



Гүйцэтгэлийн Аудит

АДБОУС-ыг хэрэгжүүлэх
гарын авлага

1-р хэвлэл, 2021 оны 8-р сар



Ерөнхий зүйл:

Гарын авлагын албан бус орчуулга болон хэвлэлийг Европын холбооны санхүүжилттэй НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн хэрэгжүүлж буй “Монгол Улсад Тогтвортой хөгжлийн зорилготой уялдсан төсвийн төлөвлөлтөөр хөдөлмөр эрхлэлтийн шинэчлэлийг дэмжих нь” төслийн хүрээнд зөвхөн дотоодын хэрэгцээнд зориулан гүйцэтгэв. Тус хэвлэлийг зөвхөн Үндэсний аудитын газрын Гүйцэтгэлийн аудитын газрын дотоодын хэрэгцээнд ашиглах бөгөөд гадагшаа түгээх, худалдах, дахин хэвлэх, эсвэл ямар нэгэн ашиг олох хэрэгсэл болгохыг хориглоно.

Тусбаримтбичгийнанглиэхийг дарааххолбоосоортатажавна уу: <https://www.idi.no/work-streams/professional-sais/work-stream-library/performance-audit-issai-implementation-handbook>

ТАЛАРХАЛ

Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандартыг гүйцэтгэлийн аудитад хэрхэн ашиглаж болох арга замуудыг танилцуулж, удирдамжаар хангахад чиглэсэн энэхүү гарын авлагыг Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Байгууллагын Хөгжлийн Санаачилгаас аудиторруудад зориулж боловсруулан юм.

Тус гарын авлагыг Төрийн аудитын байгууллагын албан хаагчдад хүртээл болгоход үнэтэй хувь нэмэр оруулсан Үндэсний аудитын газрын төрийн аудитын стандартын хорооны дарга бөгөөд Ерөнхий аудиторын орлогч /асан/ Я.Сарансүх, Санхүү, нийцлийн аудитын газрын захирал Ц.Наранчимэг, Гүйцэтгэл, нийцлийн аудитын газрын захирал Д.Энхболд, аудитын менежер Х.Баярмаа, аудитын менежер П.Цэнгүүн, Төрийн аудитын стандартын хорооны хараат бус гишүүн Х.Нямбаяр болон гарын авлагын албан бус орчуулгыг хянан тохиолдуулсан Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институтын дэд ерөнхийлөгч Д.Нацагдорж нарт талархал илэрхийлье.

Түүнчлэн, гарын авлагын албан бус орчуулга болон хэвлэлийн ажлыг санхүүжүүлэхэд дэмжлэг үзүүлж, хамтран ажилласан Европын Холбооны санхүүжилттэй НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн хэрэгжүүлж буй “Монгол Улсад Тогтвортой хөгжлийн зорилготой үялдсан төсвийн төлөвлөлтөөр хөдөлмөр эрхлэлтийн шинэчлэлийг дэмжих нь” төслийн хамт олонд талархал илэрхийлье.

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

АГУУЛГА

ТАЛАРХАЛ	3
Гүйцэтгэлийн аудитын АДБОУС-ыг хэрэгжүүлэх гарын авлагын 1-р хувилбарын чанарын мэдүүлэг (2021 оны 6-р сарын 8-ны өдөр)	9
<i>Энэхүү ГНБ-т оруулсан шинэчлэлүүд</i>	<i>10</i>
Үндсэн мэдээлэл	11
Энэхүү гарын авлагын зорилго юу вэ?	11
Энэхүү гарын авлагын тухай	11
Энэхүү гарын авлагыг хэрхэн боловсруулсан бэ?	12
Гарын авлагын агуулга	12
1-р бүлэг	14
<i>Гүйцэтгэлийн аудит гэж юу вэ?</i>	<i>14</i>
Гүйцэтгэлийн аудит гэж юу вэ?	14
Гүйцэтгэлийн аудитын зорилго юу вэ?	15
Үр ашигтай байдал: Байгаа нөөцийг дээд зэргээр ашиглах	16
Гүйцэтгэлийн аудит ямар үнэ цэн авчрах вэ?	20
Гүйцэтгэлийн аудитын дүнд ямар төрлийн тайлангууд гарах вэ?	22
Гүйцэтгэлийн аудит болон бусад төрлийн улсын секторын аудитууд хоорондоо ямар ялгаатай вэ?	24
Судлах сэдэв/ зүйл болон судлах сэдэв/ зүйлийн мэдээлэл гэж юу вэ?	28
2-р бүлэг	29
<i>Чанартай гүйцэтгэлийн аудитын гол зарчмууд гэж юу вэ?</i>	<i>29</i>
Чанарын хяналт гэж юу вэ?	30
Хараат бус байдал ба ёс зүй гэж юу вэ?	32
Мэргэжлийн үнэлэмж ба үл итгэх үзэл гэж юу вэ?	39
Аудитын багийн чадамж гэж юу вэ?	41
Материаллаг байдал гэж юу вэ?	43
Аудитын баримтжуулалт ба хянан удирдлага гэж юу вэ?	45
Аудитын эрсдэл ба баталгаатай байдал гэж юу вэ?	49
Аудитад шалгагдагч этгээд, гадаад оролцогч талууд, хэвлэл мэдээллийнхэн болон олон нийттэй харилцах харилцаа гэж юу вэ?	51
АДБОУБХС-аас дэвшүүлсэн хүртээмжтэй байдлыг хэвшүүлж, гүйцэтгэлийн аудитын нөлөөллийг хамгийн их байлгахад анхаарах зүйлс	56

3-р бүлэг	62
<i>Гүйцэтгэлийн аудитын сэдвийг хэрхэн сонгох вэ?</i>	62
Стратегийн төлөвлөлтийн үйл явц гэж юу вэ?	63
АДБ гүйцэтгэлийн аудитын боломжит сэдвүүдийг тодорхойлохын тулд аудитын орчныг хэрхэн танддаг вэ?	65
Гадаад оролцогч талуудын хүсэлт хэрхэн үүсдэг вэ?	68
АДБ яагаад дан ганц аудитад шалгагдагч этгээдийн үүрэг хариуцлага биш сэдвээр аудит хийхийг бодолцож үзэж болох вэ?	69
АДБ-ууд гүйцэтгэлийн аудитын сэдвийг сонгохдоо ямар шалгуур ашигладаг вэ?	71
4-р бүлэг	75
<i>Гүйцэтгэлийн аудитыг хэрхэн загварчлах вэ?</i>	75
Аудитын сэдвийн урьдчилсан судалгааг хэрхэн хийх вэ?	76
Гүйцэтгэлийн аудитын арга хандлагыг хэрхэн тодорхойлох вэ?	79
Аудитын зорилго(ууд)ыг хэрхэн боловсруулах вэ?	81
Аудитын асуултуудыг хэрхэн боловсруулах вэ?	84
Аудитын хамрах хүрээг хэрхэн тодорхойлох вэ?	87
Аудитын шалгуурыг хэрхэн сонгох вэ?	89
Аудитын арга зүйг хэрхэн боловсруулах вэ?	94
Аудитыг зохиомжлох үеийн эрсдэлийг хэрхэн удирдах вэ?	98
Гүйцэтгэлийн аудитад шаардлагатай хугацаа болон нөөцийг хэрхэн тодорхойлох вэ?	101
Аудитын төлөвлөгөөг хэрхэн баримтжуулах вэ?	102
Гүйцэтгэлийн аудитыг загварчлах үед дотоод, гадаад оролцогч талууд болон удирдлагыг хэрхэн оролцуулах вэ?	106
5-р бүлэг	110
<i>Гүйцэтгэлийн аудитыг хэрхэн хийх вэ?</i>	110
Нотлох зүйлсийн хангалттай бөгөөд зохистой байдлыг хэрхэн тодорхойлох вэ?	111
Гүйцэтгэлийн аудитад ашиглах мэдээллийг хэрхэн цуглуулах вэ?	116
Мэдээллийг хэрхэн шинжлэх вэ?	139
Мэдээллийг хэрхэн баримтжуулж, хамгаалах вэ?	149
6-р бүлэг	152
<i>Илрүүлэлт, дүгнэлт, зөвлөмжүүдийг хэрхэн боловсруулах вэ?</i>	152
Аудитын илрүүлэлт гэж юу вэ?	153
Аудитын шалгуурыг нөхцөлтэй хэрхэн харьцуулах вэ?	155
Шалтгаан, үр дагаврыг хэрхэн тодорхойлох вэ?	156
Нотлох зүйлсээ хэрхэн үнэлэх вэ?	158
Дүгнэлт, зөвлөмжүүдийг хэрхэн боловсруулах вэ?	162
Тайлангийн төслийг бичихэд хэрхэн бэлдэх вэ?	168
7-р бүлэг	170
<i>Гүйцэтгэлийн аудитын тайланг хэрхэн бичих вэ?</i>	170
Гүйцэтгэлийн аудитын тайланг хэрхэн боловсруулах вэ?	170
Гүйцэтгэлийн аудитын тайлангийн үндсэн шинж чанарууд юу вэ?	171
Тайлангийн логик бүтцийг хэрхэн үүсгэх вэ?	175
Тайланг хэрхэн чанартай байлгах вэ?	187
Аудитад шалгуулагч этгээд эсвэл гуравдагч талын саналыг хэрхэн авч үзэх вэ?	190
Хэрхэн эцсийн тайланг нийтэлж, аудитын үр дүнгүүдийг түгээх вэ?	191
8-р бүлэг	192
<i>Гүйцэтгэлийн аудитын мөрөөр хэрхэн хяналт тавих вэ?</i>	192
Мөрөөр хяналт тавих үйл ажиллагааг хэрхэн гүйцэтгэх вэ?	194
Мөрөөр хяналт тавих үйл ажиллагааг хэзээ гүйцэтгэх вэ?	196
Аудитын нөлөөллийг хэрхэн тодорхойлох вэ?	198
Мөрөөр хяналт тавих үйл ажиллагааны үр дүнг хэрхэн тайлагнах вэ?	199

Хавсралтууд	203
Хавсралт 1: Холбогдох стандарттай нийцэх нийцлийг баталгаажуулах АДБ-ын ЧБ-ын хүрээний жишээ	204
Хавсралт 2: Гадаад үйл ажиллагаанд оролцох зөвшөөрлийн маягтын жишээ	205
Хавсралт 3: Хараат бус байдлын мэдэгдлийн жишээ	206
Хавсралт 4: Аудитын сэдэв сонгох хүснэгтийн жишээ	207
Хавсралт 5: Зохиомжийн баримт бичгүүдийн жишээ	208
Хавсралт 6: Зохиомжийн хуудсыг шалгах хуудас	218
Хавсралт 7: Төслийн хуваарь болон ажлын задаргааны зураглал	219
Хавсралт 8: Ярилцлагын удирдамж	223
Хавсралт 9: Шинжилгээний протоколын жишээ	228
Хавсралт 10: Өгөгдлийн найдвартай байдлын үнэлгээний жишээ	230
Хавсралт 11: Аудитад шалгагдагч этгээдийн өгөгдлийн найдвартай байдлыг үнэлэх асуултуудын жишээ	233
Хавсралт 12: Өгөгдөл цуглуулах хэрэгслийн жишээ	235
Хавсралт 13: Шууд ажиглалтыг баримтжуулах маягтын жишээ	236
Хавсралт 14: Судалгааг хэрхэн хийх вэ?	237
Хавсралт 15: Агуулгын шинжилгээ	240
Хавсралт 16: Хураангуй баримт бичиг боловсруулах маягтын жишээ	242
Хавсралт 17: Регрессийн шинжилгээний жишээ	244
Хавсралт 18: ТХГ-ын тойм мэдээ (хураангуй тайлан)-ний жишээ	246
Хавсралт 19: Европын Аудиторуудын Шүүхийн гүйцэтгэлийн хураангуйн жишээ	247
Хавсралт 20: Гүйцэтгэлийн аудитын тайланд аудитын арга зүйг тайлбарлах нь	248
Хавсралт 21: Үйл ажиллагааны төлөвлөгөө болон мөрөөр хяналт тавих үйл ажиллагааны баримт бичгийн нягталгааны маягт	249

Зургийн жагсаалт

Зураг 1: Үр ашгийн гурвал хоорондын хамаарал	19
Зураг 2: Гүйцэтгэлийн аудит хэрхэн үнэ цэн нэмж болох вэ?	21
Зураг 3: Гүйцэтгэлийн аудитын явцад тохиолддог сэдвүүд	23
Зураг 4: Гүйцэтгэлийн аудитын чанарын хяналтын үндсэн элементүүд	31
Зураг 5: Гүйцэтгэлийн аудитын явцад хараат бус байдалд учрах 6 гол аюул	33
Аудитын баримтжуулалтын хавтаснууд	47
Зураг 6: Гүйцэтгэлийн аудитад тохиолддог түгээмэл эрсдэлүүд	49
Зураг 7: АДБ-ын гарц болон АДБ-ын үр дүнгийн үнэ цэнгийн гинжин хэлхээ	56
Зураг 8: АДБ-ууд аудитын сэдвээ хэрхэн сонгож болох вэ?	64
Зураг 9: Аудитын боломжит сэдвүүдийг тодорхойлох аргууд	66
Зураг 10: Замби улсын АДБ хэрхэн аудитын орчныг тандаж, аудитын боломжит сэдвүүдийг тодорхойлдог вэ?	68
Зураг 11: Аудитын сэдэв сонгох шалгуурын жагсаалт	72
Зураг 12: Аудитын сэдвийн хураангуйн жишээ	73
Зураг 13: Мэдээллийн эх сурвалжууд	78
Зураг 14: Нэгээс олон этгээдэд аудит хийх үеийн харилцаа хамаарал	81
Зураг 15: Зохимжтой болон зохимжгүй томъёолсон аудитын зорилгуудын жишээ ба аудитын арга хандлага	83
Зураг 16: Үнэлсэн шинжтэй аудитын асуултын төрөл ба аудитын арга хандлага	85
Зураг 17: Асуудлын шинжилгээний жишээ	86
Зураг 18: Асуудлын шалтгаан-үр дагаврын шинжилгээний жишээ	87
Зураг 19: Хамрах хүрээг тогтоох асуултууд	88
Зураг 20: Тохиромжтой шалгуурын шинжүүд	91
Зураг 21: Шалгуурууд болон тэдгээртэй харгалзах аудитын асуултууд	92
Зураг 22: Сонгосон мэдээлэл цуглуулах аргуудын үр өгөөж болон анхаарах зүйлс	95
Зураг 23: Сонгосон өгөгдөл шинжлэх аргуудын үр өгөөж болон анхаарах зүйлс	97
Зураг 24: Загварын хүснэгтийн маягт	104
Зураг 25: Нотлох зүйлийн хангалттай байдал	112
Зураг 26: Нотлох зүйлийн зохистой байдал	112
Зураг 27: Нотлох зүйлсийн төрлүүд	119
Зураг 28: Шууд ажиглалт болон биечилсэн үзлэгийн жишээ	132
Зураг 29: Түгээмэл төрлийн чанарын шинжилгээний жишээ	140
Зураг 30: Дүрслэх статистикийн үндсэн ухагдахуунууд	144
Зураг 31: Үйлдвэрийн ажилчдын орлого	145
Зураг 32: Өөр өөр төрлийн үзлэг хийдэг бүс нутгуудын замын осол	147
Зураг 33: Өгөгдлийг дүрслэн харуулахад ашиглаж болох бүдүүвчүүдийн жишээ	149
Зураг 34: Илрүүлэлтийн элементүүд	153
Зураг 35: Оюуны зураглал	159
Зураг 36: Загасны яс маягийн бүдүүвч	160
Зураг 37: Зохион байгуулалтын бүдүүвч	161
Зураг 38: Аудитын илрүүлэлтүүдийн хүснэгтийн маягт	166
Зураг 39: Аудитын илрүүлэлтийн хүснэгтийн илрүүлэлтийн нэг жишээ	167
Зураг 40: Гүйцэтгэлийн аудитын тайланд мэдээллийг зураглан үзүүлсэн жишээ	174
Зураг 41: Асуултад суурилсан гарчиг ашигласан агуулгын хуудас	177
Зураг 42: Тайлбарласан шинжтэй гарчиг ашигласан агуулгын хуудас	178
Зураг 43: Аудитад шалгагдагч байгууллагын хариуцлагыг дүрслэхэд энгийн график ашиглах нь	181
Зураг 44: Аудитын дүгнэлтүүдийн жишээ	185
Зураг 45: Зарим АДБ-ын гүйцэтгэлийн аудитын тайлан дахь зөвлөмжийн жишээ	186
Зураг 46: Гүйцэтгэлийн аудитын тайлангийн өгөгдлийн лавлах баримт бичгийн жишээ	187
Зураг 47: Танзани улсын ҮАГ аудитын тайлангийн чанарын хяналтын нягталгааг хэрхэн хийдэг вэ?	189
Зураг 48: Мөрөөр хяналт тавих үйл ажиллагааны тайлангийн хэсгээс	201

Товчилсон үгс

Зi Аудитын хөтөлбөр	АДБОУС-ыг Хэрэгжүүлэх Санаачилга Хөтөлбөр
ЗЕс	Үр ашгийн гурвал (арвилан хэмнэлт, үр ашиг, үр нөлөө)
АДБ	Аудитын Дээд Байгууллага
АДБОУБ	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Байгууллага
АДБОУБ-3	АДБОУБ-ын Зарчмууд
УДИР	АДБОУБ-ын Удирдамж
АДБОУБММХ	АДБОУБ-ын Мэргэжлийн Мэдэгдлийн Хүрээ
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АДБОУБХС	АДБОУБ-ын Хөгжлийн Санаачилга
АДБОУБХСТХЗАЗ	АДБОУБ-ын Хөгжлийн Санаачилгын ТХЗ-ын Аудитын Загвар
АХАДБАБ	Англи Хэлт АДБ-уудын Африкийн Байгууллага
ГАДХ	Гүйцэтгэлийн Аудитын Дэд Хороо
ГНБ	Глобал Нийтийн бүтээл
ЗГБХ	Засгийн Газрыг Бүхэлд нь Хамруулах
ТХГ	Төрийн Хариуцлагын Газар
ИБУИНХУ	Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Хаант Улс
НҮБХХ	Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөр
ТХЗ	Тогтвортой Хөгжлийн Зорилго
ТАБ	Төрийн Аудитын Байгууллага
ТНББГ	Төрийн Нягтлан Бодох Бүртгэлийн Байгууллага
ҮАГ	Үндэсний Аудитын газар
ХАШ	Холбооны Аудитын Шүүх (Бразил)
ХОБ	Хэнийг ч Орхигдуулахгүй Байх (зарчим)
ЧБ	Чанарын Баталгаажуулалт

Гүйцэтгэлийн аудитын АДБОУС-ыг хэрэгжүүлэх гарын авлагын 1-р хувилбарын чанарын мэдүүлэг (2021 оны 6-р сарын 8-ны өдөр)

АДБОУС-ын Зорилгын Хороодын Дарга нар болон АДБОУБХС-ын хамтарсан баримт бичиг болох “Нарийвчилсан хяналтаас гадуур боловсруулж, нийтэлсэн чанарын баталгаатай АДБОУБ-ын нийтийн бүтээл”-т чанарын баталгаажуулалтын дараах гурван түвшнийг тодорхойлсон байдаг:

НАРИЙВЧИЛСАН ХЯНАЛТААС ГАДУУР БОЛОВСРУУЛЖ, НИЙТЭЛСЭН ЧАНАРЫН БАТАЛГААТАЙ АДБОУБ-ЫН Нийтийн бүтээл – Чанарын баталгаажуулалтын түвшин

1-р түвшин: Уртасгасан хугацаагаар (90 хоног) олон нийтэд ил тод байлгах зэрэг АДБОУС-ын нарийвчилсан хяналттай адил чанарын баталгаажуулалтын үйл явцаар дамжсан бүтээгдэхүүнүүд.

2-р түвшин: Байгууллагаас гадуурх оролцогч талууд эсвэл бүтээгдэхүүний эхний боловсруулалтыг хариуцсан ажлын хэсгийг оролцуулсан илүү хязгаарлагдмал чанарын баталгаажуулалтын үйл явцаар дамжсан бүтээгдэхүүнүүд. Чанарын баталгаажуулалтын үйл явц нь бүтэн 90 хоног олон нийтэд нээлттэй байлгах алхмыг багтаахгүй боловч, нэвтрүүлэн турших, тестлэх, гол оролцогч талуудаас санал сэтгэгдэл хүлээн авах зэргийг багтааж болно.

3-р түвшин: Боловсруулалтыг нь хариуцсан байгууллага эсвэл ажлын хэсгийн хүрээнд чанарын нарийн хяналт хийлгэсэн бүтээгдэхүүнүүд.

Ялгаатай Глобал Нийтийн Бүтээл (ГНБ) ялгаатай Чанарын Баталгаажуулалтын түвшнүүд тохиромжтой байж болно. Энэхүү ГНБ-ийг чанарын баталгаажуулалтын 1-р түвшний дагуу боловсруулаа.

Чанарын баталгаажуулалтын протокол: Хувилбар 2.0¹

АДБОУБХС-ын Глобал Нийтийн бүтээл болох АДБОУБХС-ын Чанарын Баталгаажуулалтын (ЧБ) Протокол нь ЧБ-ын дээрх гурван түвшинд үндэслэн чанартай байлгах арга хэмжээнүүдийг тодорхойлдог. ЧБ-ын 1-р түвшний хувьд, АДБОУБХС-ын Удирдах Зөвлөлөөс ГНБ бүтээх зөвшөөрөл авах; бүтээгдэхүүн боловсруулах чадамжтай баг бүрдүүлэх; боловсруулалтын багаас гадуурх экспертүүдээр мэргэжил нэгтний нягталгаа хийлгэх; нягталгаанд үндэслэн өөрчлөн сайжруулах; баримт бичгийг чадамжтай хүмүүсээр мадаглуулж, засварлуулж, орчуулуулах; 90 хоногийн турш олон нийтэд нээлттэй байлгах / хөгжингүй болон хөгжиж буй улс орнуудын ихэнх бүс нутаг болон ихэнх аудитын загварыг төлөөлсөн, мөн глобал байгууллагуудыг төлөөлсөн холбогдох оролцогч талуудыг хамруулж санал солилцон хэлэлцэх; олон нийтэд нээлттэй байлгах үед ирсэн саналуудад үндэслэн баримт бичгийг өөрчлөн сайжруулах; ГНБ-ын 1-р хувилбарыг зохих ёсоор батлах зэрэг арга хэмжээнүүдийг хэрэгжүүлдэг.

¹ Протоколыг үзэх холбоос: <http://www.idi.no/en/idi-library/global-public-goods>.

Энэхүү ГНБ-т оруулсан шинэчлэлүүд

Энэхүү ГНБ-ыг хамааралтай хэвээр байлгахын тулд гүйцэтгэлийн аудитын АДБОУС-д өөрчлөлт орох бүрд АДБОУБХС-ын зүгээс Гүйцэтгэлийн аудитын АДБОУС-ыг хэрэгжүүлэх гарын авлагад томоохон өөрчлөлт оруулах болно. Томоохон өөрчлөлтүүдийг оруулахдаа АДБОУБХС-ын Чанарын баталгаажуулалтын протоколыг баримтална. Түүнчлэн, шаардлагатай үед багахан өөрчлөлт оруулж болно. Бага хэмжээний өөрчлөлтийг Протоколоор зохицуулаагүй байдаг.

АДБОУБХС-ын “Мэргэжлийн АДБ”-ууд гэх бүрэлдэхүүн нь энэхүү ГНБ-ыг өмчилж, бүрэн бүтэн байдлыг нь хариуцна.

Чанарын баталгаажуулалтын нягталгааны үйл явц

Энэхүү ГНБ-ыг боловсруулахад дагаж мөрдсөн үйл явцын ЧБ-ын нягталгааг Шоуржо Чаттэржий (АДБОУБХС, Стратегийн дэмжлэгийн нэгж) ЧБ-ын протоколын 2.0 хувилбарыг ашиглан гүйцэтгэсэн болно. ЧБ-ын нягтлагч нь АДБОУБХС-ын ГНБ-ын ЧБ-ын протоколыг мэдэх бөгөөд энэхүү ГНБ-ын боловсруулалтад оролцоогүй юм. Энэхүү ЧБ-ын нягталгааны үйл явц нь АДБОУБХС-ын зүгээс чанарын баталгаажуулалтын 1-р түвшинд тохирсон, дээр дурдсан чанарын хяналтын арга хэмжээнүүдийг гүйцэтгэсэн болохыг бүх оролцогч талуудад баталгаатай мэдээлэх зорилготой байлаа.

Чанарын баталгаажуулалтын нягталгааны үр дүн

Энэхүү ГНБ-ыг боловсруулахад дагаж мөрдсөн үйл явцын ЧБ-ын нягталгаагаар чанарын баталгаажуулалтын 1-р түвшинд Протоколыг зохих ёсоор бүрэн дагаж мөрдсөн гэж дүгнэлээ.

Дүгнэлт

ЧБ-ын нягталгаанд үндэслэн АДБОУБХС-ын зүгээс энэхүү ГНБ-ын хэрэглэгчдэд тус баримт бичиг нь уртасгасан хугацаагаар олон нийтэд ил тод байлгах зэрэг АДБОУБ-ын Мэргэжлийн Мэдэгдлийн Хүрээний (АДБОУБММХ) Зохих Үйл Явцтай адил чанарын баталгаажуулалтын үйл явцаар дамжсан болохыг баталгаатай мэдэгдэж байна.



Ноён Эинар Гөрришан (Mr. Einar Gørrissen)
АДБОУБ-ын Хөгжлийн Санаачилгын Ерөнхий Захирал
2021 оны 6-р сарын 8-ны өдөр

Үндсэн мэдээлэл

2014 онд АДБОУБ-ын Хөгжлийн Санаачилгаас (АДБОУБХС) **АДБОУС²**-ыг Хэрэгжүүлэх Санаачилгынхаа (*3i хөтөлбөр³*) хүрээнд анхны Гүйцэтгэлийн аудитын АДБОУС-ыг хэрэгжүүлэх гарын авлагыг боловсруулсан билээ. Уг баримт бичиг нь тухайн үеийн стандартуудад үндэслэсэн байв. Уг стандартууд нь тухайн үедээ гүйцэтгэлийн аудитын анхны гарын авлагад орсон аудитын арга зүйн үндэслэл болсон юм.

АДБОУБХС-ын Гүйцэтгэлийн аудитын АДБОУС-ыг хэрэгжүүлэх анхны гарын авлага нийтлэгдсэнээс хойш **АДБОУБ**-ын хүрээ мөн өөрчлөгдсөн билээ. АДБОУБ-ын Мэргэжлийн Мэдэгдлийн Хүрээ (АДБОУБММХ) нь одоогоор зарчмууд, стандартууд болон удирдамжууд гэсэн зохион байгуулалттай байна. Дэлгэрэнгүй мэдээллийг www.issai.org холбоосоор үзэж болно.

2016 онд АДБОУБ-аас АДБОУС-3000 гэх Гүйцэтгэлийн аудитын шинэ стандарт баталсан юм. Гүйцэтгэлийн аудитын үндсэн стандарт болохын хувьд АДБОУС-3000 нь өмнөх стандартуудын томоохон өөрчлөлтүүдийг агуулж байв. Зохион байгуулалтын хувьд шаардлагууд болон тайлбарууд гэсэн хэсгүүдээс бүрдэх бөгөөд өмнөх хувилбартайгаа харьцуулахад өөр бүтэцтэй байв. АДБОУБ-ын Гүйцэтгэлийн Аудитын Дэд Хороо (ГАДХ) нь мөн гүйцэтгэлийн аудитын удирдамж болсон УДИР-3910 (Гүйцэтгэлийн аудитын гол ухагдахуунууд) болон УДИР-3920 (Гүйцэтгэлийн аудитын үйл явц) гэсэн баримт бичгүүдийг боловсруулсан юм.

Үүний дараа АДБ-уудад ГА-ын АДБОУС-ыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх хүрээнд АДБОУБХС-аас АДБОУС-д орсон өөрчлөлтүүдийг тусгах зорилгоор ГА-ын АДБОУС-ыг хэрэгжүүлэх гарын авлагыг шинэчлэх ажлыг эхлүүлсэн билээ. Уг үйл явцын дүнд АДБ-уудын хийх гүйцэтгэлийн аудитад ашиглаж болох, одоогийн АДБОУС-3000-д суурилсан аудитын арга зүйг агуулсан энэхүү гарын авлага бий болсон юм. Түүнчлэн, АДБОУБХС нь гүйцэтгэлийн аудиторүүд АДБОУС-д нийцсэн аудит хийхэд ашиглаж болох гарын авлага АДБ-уудад хэрэгтэй байна гэсэн санал хүсэлт хүлээн аваад байсан юм.

Энэхүү гарын авлагын зорилго юу вэ?

Энэхүү гарын авлага нь АДБОУС-ын гүйцэтгэлийн аудитын үйл явцын тайлбар болон АДБОУС-ыг практикт ашиглахад туслах зориулалттай аудитын тэмдэглэлийн маягтуудыг

² Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандартууд

³ Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Байгууллагын (АДБОУБ) Стратегийн төлөвлөгөө болон АДБОУС-ыг Эрчимжүүлэн хэрэгжүүлэх загвар (2011 оны 10-р сард АДБОУБ-ын Удирдах Зөвлөлөөс баталсан) нь АДБОУБХС-д “АДБОУС-ын хэрэгжилтийг дэмжих” бүрэн эрх олгосон юм. Энэхүү бүрэн эрхээрээ АДБОУБХС-аас АДБОУС-ыг Хэрэгжүүлэх Санаачилга буюу 3i гэх чадавх бэхжүүлэх цогц аудитын хөтөлбөрийг эхлүүлсэн.

багтаасан. Тус гарын авлага нь гүйцэтгэлийн аудитын албан ёсны арга зүйгээр хангах зориулалтгүй бөгөөд Гүйцэтгэлийн аудитын АДБОУС-ыг хэрэгжүүлж болох боломжит арга замуудын нэгийг танилцуулж, удирдамжаар хангах зориулалттай болно. АДБ-ууд нь хууль, журам болон практикийн аливаа шаардлагаар нэмэлт удирдамж болон аудитын тэмдэглэлийн маягт зохиомжлон боловсруулах шаардлагатай болж болно.

Энэхүү гарын авлагыг улсын секторын бүх гүйцэтгэлийн аудиторүүд ашиглаж, нутагшуулж болно. Гарын авлагаар санал болгож буй арга зүй нь аудитын үйл ажиллагааны түвшинд гүйцэтгэж, баримтжуулах аудитын ажлуудыг өргөн хүрээнд хамруулсан.

Тус гарын авлагыг мөн гүйцэтгэлийн аудитын арга зүй боловсруулж буй АДБ-уудыг дэмжин ажиллаж буй байгууллагууд ашиглаж болно.

Энэхүү гарын авлагыг хэрхэн боловсруулсан бэ?

Энэхүү гарын авлагыг АДБОУБХС-ын Глобал Нийтийн Баялгийн Чанарын Баталгаажуулалтын Протоколын 2.0 хувилбарын шаардлагуудын дагуу боловсруулав.

Тус гарын авлагыг АНУ-ын Засгийн Газрын Эгэх Хариуцлагын Газар (ТХГ) болон ИБУИНХУ-ын Үндэсний Аудитын Газрын (ҮАГ) ГАДХ-дын гишүүд, Норвег улсын Ерөнхий Аудиторын Газрын ГАДХ-ны Дарга болон АДБОУБ-ын Хөгжлийн Санаачилгын багаас бүрдсэн АДБОУБХС/ГАДХ-ны баг бичсэн. 40 гаруй АДБ болон гол оролцогч талууд гарын авлагыг олон нийтэд нээлттэй байлгах үед нягтлан шалгаж, санал өгч, эсхүл гарын авлага дахь зарим ухагдахууныг дүрслэн харуулах жишээгээр хангаж ажилласан болно.

2021 оны 6-р сард нийтлэгдсэн энэхүү 1-р хувилбарт ГАДХ-ны оролцоо асар их байсан боловч хойшдын нягталгаа болон өөрчлөлтүүд нь ГАДХ-ны нягталгаанаас ангид байх болно. Гарын авлагын бүрэн бүтэн байдлыг АДБОУБХС дангаар хариуцаж, тогтмол нягталгаа хийж, гол оролцогч талуудтай хэлэлцэн шинэчлэх механизмыг бий болгоно.

Тус гарын авлагыг боловсруулахад нягт түншлэн ажиллаж, үнэтэй хувь нэмэр оруулсан Норвег улсын Ерөнхий Аудиторын Газрын ГАДХ-ны Дарга болон АНУ-ын ТХГ болон ИБУИНХУ-ын ҮАГ-ын ГАДХ-дын гишүүдэд АДБОУБХС-ын зүгээс гүнээ талархал илэрхийлье.

Гарын авлагын агуулга

Энэхүү гарын авлагыг гүйцэтгэлийн аудит хийхдээ АДБОУС-уудыг ашиглахыг хүсэж буй аудиторүүдэд зориулж, аудиторын харах өнцгөөс боловсруулсан болно. Гарын авлагад Аудитын Дээд Байгууллагаас (АДБ) улсын секторт хийх гүйцэтгэлийн аудитад ашигладаг гүйцэтгэлийн аудитын олон улсын стандарт болох АДБОУС-3000-ын шаардлагуудыг хангах зорилготой АДБОУС-д суурилсан аудитын арга зүй багтсан. Мөн АДБ-уудтай холбоотой мэдээллийг аудиторын ажилд хамааралтай хэмжээнд оруулсан болно.

Тус гарын авлага нь глобал сайн туршлагыг дэмждэг. Гэхдээ гүйцэтгэлийн аудитын АДБОУС-ыг ойлгоход зориулсан тайлбар удирдамж биш. Харин, АДБ-ын аудиторүүд АДБОУС-ын шаардлагуудыг хэрхэн дагаж мөрдөж, өндөр чанартай гүйцэтгэлийн аудитаар дамжуулан

үнэ цэн нэмж болох талаар практик зөвлөгөө өгнө. АДБ-ууд нь гарын авлагыг ашиглахдаа арга зүйг нь дотоод хэрэгцээндээ нийцүүлэн нутагшуулах шаардлагатай.

Энэхүү гарын авлага нь дараах агуулгыг хамруулсан 8 бүлгээс бүрдэнэ:

- Гүйцэтгэлийн аудит гэж юу вэ?
- Чанартай гүйцэтгэлийн аудитын гол зарчмууд гэж юу вэ?
- Гүйцэтгэлийн аудитын сэдвийг хэрхэн сонгох вэ?
- Гүйцэтгэлийн аудитыг хэрхэн зохиомжлох вэ?
- Гүйцэтгэлийн аудитыг хэрхэн хийх вэ?
- Илрүүлэлт, дүгнэлт, зөвлөмжүүдийг хэрхэн боловсруулах вэ?
- Гүйцэтгэлийн аудитын тайланг хэрхэн бичих вэ? мөн
- Гүйцэтгэлийн аудитын мөрөөр хэрхэн хяналт тавих вэ?

Аудит нь давтагддаг үйл явц тул тус баримт бичгийн бүлэг тус бүрийг бичиж, холбогдох ажлын маягтууд, удирдамжууд болон жишээнүүдийг боловсруулахдаа аудитын ялгаатай үе шат хоорондын уялдааг хадгалахад анхаарсан болно. Холбогдох маягтуудыг харилцан уялдуулах нь мөн хэрэглэгчдэд бодит гүйцэтгэлийн аудитын үеэр уг уялдааг хадгалах шаардлагыг ойлгоход тусална.

Энэхүү гарын авлагыг уншигчид нь тус гарын авлагын бүрэлдэхүүн болох АДБОУБХС-ын бусад глобал бүтээгдэхүүнийг мөн үзэхийг хүсэж магадгүй юм. Үүнд, АДБ-ын Гүйцэтгэлийн Хэмжилтийн Хүрээ 2016⁴, АДБОУС-ыг хэрэгжүүлэх хэрэгцээг үнэлэх хэрэгсэл (iCAT)⁵ болон АДБОУБХС-ын ТХЗ-ын Аудитын Загвар (АДБОУБХСТХЗАЗ) 2020⁶ болно.

⁴ <https://www.idi.no/elibrary/well-governed-sais/sai-pmf>

⁵ <https://www.idi.no/work-streams/professional-sais/gpgs/issai-icats>

⁶ <https://www.idi.no/work-streams/relevant-sais/auditing-sdgs>

Гүйцэтгэлийн аудит гэж юу вэ?

Гүйцэтгэлийн аудитыг эхлүүлэхийн өмнө гүйцэтгэлийн аудит гэж чухам юу болохыг ойлгож, санхүүгийн, нийцлийн зэрэг бусад төрлийн аудитаас хэрхэн ялгардгийг мэдэх нь чухал. Энэ бүлэгт улсын сектор дахь гүйцэтгэлийн аудитын тодорхойлолт болон зорилгыг танилцуулж, уг аудитаар нэмэх үнэ цэнийг тодорхойлно. Мөн, гүйцэтгэлийн үнэлгээний хэмжээснүүд буюу арвилан хэмнэлт, үр ашигтай байдал болон үр нөлөөтэй байдлын (хамтад нь “ЗЕ” гэж нэрлэдэг) тодорхойлолт болон жишээг оруулсан болно. Тус бүлэг нь дараах асуултуудад хариулах болно:

- Гүйцэтгэлийн аудит гэж юу вэ?
- Гүйцэтгэлийн аудитын зорилго юу вэ?
- Үр ашгийн гурвал хооронд ямар хамаарал байдаг вэ?
- Гүйцэтгэлийн аудит ямар үнэ цэн авчрах вэ?
- Гүйцэтгэлийн аудитын дүнд ямар төрлийн тайлангууд гарах вэ?
- Гүйцэтгэлийн аудит болон бусад төрлийн улсын секторын аудитууд хоорондоо ямар ялгаатай вэ?
- Гүйцэтгэлийн аудитын гурван тал гэж хэн бэ?
- Судлах сэдэв/зүйл болон судлах сэдэв/зүйлийн мэдээлэл гэж юу вэ?

Гүйцэтгэлийн аудит гэж юу вэ?

Гүйцэтгэлийн аудит

АДБ-аас хийдэг гүйцэтгэлийн аудит нь засгийн газрын ажил хэрэг, тогтолцоо, үйл ажиллагаа, хөтөлбөр, арга хэмжээ, зохион байгуулалт нь арвилан хэмнэлттэй, үр ашигтай, үр нөлөөтэй байх зарчмын дагуу байгаа эсэхийг, мөн сайжруулах зүйлс бий эсэхийг тогтоох хараат бус, бодитой (объектив) бөгөөд найдвартай хяналт шалгалт юм.

Эх сурвалж: АДБОУС-3000/17.

Гүйцэтгэлийн аудит бол Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт (АДБОУС) 100/22-т тодорхойлсон улсын секторын аудитын гурван үндсэн төрлийн нэг юм. Санхүүгийн болон нийцлийн аудит гэсэн бусад хоёр үндсэн төрлөөсөө хэрхэн ялгардгийг энэ бүлэгт авч үзнэ.

Гүйцэтгэлийн аудит нь ерөнхийдөө засгийн газар бодлогын зорилгуудаа үр нөлөөтэй биелүүлж, зорьсон нөлөөллөө бий болгохдоо нөөцийг хэр сайн ашиглаж байгаа вэ гэдгийг шалгадаг. Ийм аудит нь ихэвчлэн бодлого(ууд)-ын хэрэгжилтийг шалгахыг зорьдог. АДБ-ууд нь засгийн газрын гүйцэтгэлийг тохиромжтой шалгууруудаар шалгаад, аливаа хангалтгүй гүйцэтгэлийн шалтгааныг илрүүлэхийг оролддог. Нөгөөтэйгүүр, гүйцэтгэлийн аудит нь аудитад шалгуулагч этгээдийн үйл ажиллагааны сайн талыг илрүүлж, эсвэл уг байгууллагын бодлого эсвэл үйл ажиллагааны тодорхой өөрчлөлтүүдийн улмаас гүйцэтгэл хэр хэмжээнд сайжирсныг хэмжиж болно.

Гүйцэтгэлийн аудит нь зохион байгуулалт, санхүү болон захиргааны тогтолцоо зэрэг засгийн газрын бүхий л үйл ажиллагааг хамруулдаг (АДБОУБ-3-1, 4-р хэсэг). Гүйцэтгэлийн аудит нь ганц хөтөлбөр, бодлого, байгууллага эсвэл санд төвлөрч болно. Эсвэл үр дүн эсвэл тогтолцоонд хувь нэмэр оруулж буй хөтөлбөрүүд, бодлогууд болон байгууллагуудыг судлах замаар үр дүнгүүд эсвэл тогтолцоонд төвлөрч болно. Гол анхаарч төвлөрөх зүйл нь:

- Үйл ажиллагаа, тухайлбал, засгийн газрын худалдан авах ажиллагааны бодлого;
- Гарц, жишээлбэл, төрийн өмчийн байгууллагуудын бүтээмжийн түвшин;
- Үр дүн, жишээлбэл, засгийн газрын барилгуудад эрчим хүчний үр ашигтай бодлого нэвтрүүлснээр бий болох нүүрстөрөгчийн хэмжээний бууралт; мөн
- Үйлчилгээ, жишээлбэл, засгийн газрын тухайлсан үйлчилгээний хурд ба чанар.

Гүйцэтгэлийн аудитын зорилго юу вэ?

Гүйцэтгэлийн аудитын үндсэн зорилго нь арвилан хэмнэлттэй, үр нөлөөтэй бөгөөд үр ашигтай засаглалыг бүтээлчээр дэмжиж, эгэх хариуцлага болон ил тод байдалд хувь нэмэр оруулахад оршдог. Гүйцэтгэлийн аудит нь шинэ мэдээлэл, шинжилгээ эсвэл ойлголтоор хангаж, шаардлагатай үед сайжруулалт хийх зөвлөмжөөр хангахыг зорьдог (АДБОУС-300/12; АДБОУС-3000/18). Шинжилгээний шинэ ойлголтоор хангаж, мэдээллийг оролцогч талуудад илүү хүртээмжтэй болгож, аудитын нотлох зүйлсэд үндэслэсэн хараат бус, эрх нөлөөтэй үзэл эсвэл дүгнэлтэд хүргэж, аудитын илрүүлэлтүүдэд хийсэн шинжилгээнд үндэслэсэн зөвлөмжөөр хангаснаар гүйцэтгэлийн аудит нь шинэ мэдээлэл, мэдлэг болон үнэ цэнийг бий болгодог (АДБОУС-300/10).

“ЗЕ” буюу арвилан хэмнэлт, үр ашигтай байдал болон үр нөлөөтэй байдал гэж юу вэ?

Арвилан хэмнэлт, үр ашигтай байдал болон үр нөлөөтэй байдал нь гүйцэтгэлийн аудитад маш чухал. Эдгээр нь мөн гүйцэтгэлийн аудитыг нийцлийн аудитаас ялгах нэгэн чухал шинж болдог. Эдгээр зарчмуудыг АДБОУС-300/11-т тодорхойлж, УДИР-3910/35-48-д утгыг нь тайлбарласан байдаг. АДБОУС-3000/35-д, “Аудитор нь арвилан хэмнэлт, үр ашигтай байдал болон/эсвэл үр нөлөөтэй байдлын зарчимтай холбогдсон, сайтар тодорхойлсон аудитын зорилго(ууд)ыг тавих ёстой” гэсэн шаардлагыг тусгасан байдаг.

Арвилан хэмнэлт: Өртгийг бага байлгах



Стандарт

Арвилан хэмнэлт гэдэг нь үйл ажиллагаа явуулахад ашиглах нөөцийн өртгийг хамгийн бага байлгахыг хэлнэ. Ашиглаж буй нөөц нь хамгийн боломжит үнээр, зохистой чанар, тоо хэмжээгээр тогтоосон хугацаанд бэлэн байх ёстой.

Эх сурвалж: АДБОУС-300/11.

Арвилан хэмнэлтийн аудит нь аудитад шалгуулагч этгээд нөөцийн (орц) зохих чанарыг харгалзаж үзэнгээ өртгийг нь хэр амжилттай бууруулсан бэ гэдэгт төвлөрдөг. Аудитын энэ

хэсэг нь “Ашиглаж буй нөөц нь хамгийн боломжит үнээр, зохистой чанар, тоо хэмжээгээр тогтоосон хугацаанд бэлэн байна уу?” гэсэн асуултыг асууж, зөвхөн орцод төвлөрнө (УДИР-3910/38).

- Арвилан хэмнэлтийн аудит хийхдээ аудитор нь дараах асуултуудад хариулж болно⁷:
- Зөвлөх үйлчилгээг хамгийн боломжит үнээр авсан уу?
- Өвчний чөлөөний зардлыг бууруулах боломж байна уу?
- Хүнсний тусламжийн тээврийн зардлыг хамгийн бага байлгах горим байна уу?
- Гарцыг бий болгоход нөөцийн үргүй зарлага гарсан уу?

Арвилан хэмнэлтийг харгалзаж үзэх нь ихэвчлэн бараа, ажил, үйлчилгээ худалдан авахтай холбогдох үйл явц болон удирдлагын шийдвэр гаргалтыг судлахад хүргэдэг.

Үр ашигтай байдал: Байгаа нөөцийг дээд зэргээр ашиглах



Стандарт

Үр ашигтай байдал гэдэг нь байгаа нөөцөөс хамгийн их үр ашиг хүртэхийг хэлнэ. Энэ нь чанар, тоо хэмжээ, хугацааны хувьд ашиглаж буй нөөц (орц) болон бий болгосон гарц хоорондын хамаарлаас шалтгаална.

Эх сурвалж: АДБОУС-300/11.

Үр ашигтай байдал нь орц болон гарц хоорондын хамаарлыг үнэлдэг. Үр ашигтай байдлын аудит нь орцыг хамгийн сайн эсвэл хангалттай байдлаар ашигласан эсэхийг, эсвэл адил эсвэл ойролцоо гарцыг (тоо, чанар, хугацааны хувьд) илүү бага нөөцөөр бий болгож болох байсан эсэхийг судалдаг. Өөрөөр хэлбэл, “Бид орцоосоо тоо, чанарын хувьд хамгийн их гарцыг бий болгож байна уу?” гэдгийг судалдаг (УДИР-3910/39). Иймд, үр ашигтай байдал гэдэг нь өгөгдсөн хэмжээний орцоор хамгийн их гарцыг бий болгох эсвэл өгөгдсөн хэмжээний гарцыг бий болгоход шаардлагатай хамгийн бага орцыг ашиглах тухай ойлголт юм. Үр ашигтай байдал болон арвилан хэмнэлтийн хувьд орцын чанар гэдэг нь чухал ухагдахуун болдог (УДИР-3910/38).

Үр ашигтай байдал бол харьцангуй ухагдахуун. Өөрөөр хэлбэл, аливаа нэг үйл явц, хэрэгсэл эсвэл хөтөлбөр нь нөгөөгөөсөө илүү эсвэл дутуу үр ашигтай байдаг. Үр ашигтай байдлын аудит хийхэд тодорхой хэмжээний харьцуулалт хийх шаардлагатай болдог. Тухайлбал, харьцуулж болох байгууллагуудын төстэй үйл ажиллагаануудыг хооронд нь; нэг байгууллагын нэг үйл явцыг өнгөрсөн цагийн түүнтэй адил үйл явцтай; аливаа үйл явцын ямар нэгэн бодлого эсвэл горим нэвтрүүлэхийн өмнөх болон дараах байдлыг хооронд нь; мөн аливаа байгууллагын үр ашигтай байдлыг үр ашигтай байгууллагуудын хүлээн зөвшөөрөгдсөн багц шинж чанаруудтай харьцуулж болно. Үр ашигтай байдлын аудит нь мөн үйл явцуудыг орцоос гарц хүртэл нь шалгаж, тухайн үйл явцад буюу түүний хэрэгжилтэд оршин байгаа сул талуудыг илрүүлж болно. Энэ нь үйл явцууд хэрхэн үр ашигтай байдгийг, үр ашгийг нь шууд хэмжихгүй байсан ч, илүү сайн ойлгоход тусалдаг. (УДИР-3910/41)

⁷ Эш болгосон материал: Европын Аудиторуудын Шүүхийн Гүйцэтгэлийн аудитын гарын авлага, 2017.

Үр ашигтай байдлын аудит хийхдээ асууж болох жишээ асуултуудыг оруулав⁸:

- Ажилгүйчүүдэд зориулсан сургалтын хөтөлбөрөөр бий болгосон ажлын байр тутмын өртгийг ижил төстэй өөр бусад хөтөлбөрөөр бий болгосон ажлын байр тутмын өртөгтэй харьцуулахад хэр ялгаатай байна вэ?
- “А” төслийг илүү сайн чанартай бөгөөд цаг хугацаанд нь хэрэгжүүлэх өөр ямар боломж байсан бэ?
- Нөлөөллийг хамгийн их байлгахын тулд тээврийн дэд бүтцийн төслүүдийн ач холбогдлын эрэмбийг тогтоож, сонголт хийх хангалттай горим болон шалгуурууд байгаа юу?
- Сургуулиуд мэдээллийн технологийн тоног төхөөрөмжийн хэрэглээгээ хамгийн их байлгаж байна үү?

Үр ашигтай байдлын аудитын зорилго нь гарцтай илүү холбогдох үед, байгууллагуудын орцыг гарц болгон хувиргаж буй үйл явцуудад илүү анхаарах хэрэгтэй болно.

Үр нөлөөтэй байдал: Төлөвлөсөн зорилго, зорилтуудад хүрэх



Стандарт

Үр нөлөөтэй байдал гэдэг тогтоосон зорилгыг биелүүлж, зорьсон үр дүнд хүрэхийг хэлнэ.

Эх сурвалж: АДБОУС-300/11.

Үр нөлөөтэй байдал нь гарц, үр дүн болон нөлөөлөлтэй холбогдоно. Энэ нь бий болгосон гарц нь бодлогын зорилтуудтай нийцсэн эсэхийг хэмжих тухай юм. Энэ нь нэг талаас зорилго, зорилтууд нөгөө талаас үр дүн хоорондын уялдаа холбоог чухалчилж үздэг. Үр нөлөөтэй байдлын асуулт нь хоёр хэсгээс бүрдэнэ. Нэгдүгээрт, зорилгуудыг хэр хэмжээнд биелүүлсэн бэ? гэдгийг асуух бөгөөд хоёрдугаарт, зорилгын биелэлт нь хэрэгжүүлсэн бодлогын гарцтай хамааралтай эсэхийг асуудаг. (УДИР3910/42) Жишээ асуултуудыг үзүүлэв⁹:

- Дэд бүтцийн төслүүд нь аюулгүй байдлыг сайжруулж, аяллын хугацааг багасгахын зэрэгцээ замын хөдөлгөөнийг нэмэгдүүлэхэд хувь нэмэр оруулсан үү?
- “А” салбар дахь байгаль орчны нөлөөллийг хянан-шинжилж, бууруулах тохиромжтой арга хэмжээг тодорхойлж, зохих ёсоор хэрэгжүүлсэн үү?
- Яамд эсвэл байгууллагууд нь нийгмийн бүх салбарт зорилгуудаа биелүүлсэн үү?

Үр нөлөөтэй байдлын аудит хийхэд гарц, үр дүн эсвэл нөлөөлөлд төвлөрдөг. Үр нөлөөтэй байдлыг үнэлэхдээ, АДБ-ууд нь засгийн газрын бодлого, хөтөлбөр эсвэл үйл ажиллагаа нь зорилгодоо хүрсэн эсэхийг, хүрсэн бол хэрхэн хүрснийг харгалзан үздэг. АДБ-ууд нь заримдаа үр нөлөөтэй байдлыг ялгаатай хоёр хэсэгт хувааж үздэг. Тэдгээр нь:

⁸ Эш болгосон материал: Европын Аудиторуудын Шүүхийн Гүйцэтгэлийн аудитын гарын авлага, 2017.

⁹ Эш болгосон материал: Европын Аудиторуудын Шүүхийн Гүйцэтгэлийн аудитын гарын авлага, 2017.

- *Гарцуудын* хувьд тодорхой зорилгуудад хүрсэн байдал (үүнийг зарим АДБ “үр дагавар” (efficacy) гэж нэрлэдэг).
- *Үр дүнгүүдийн* хувьд зорьсон ерөнхий үр дүнд хүрсэн байдал.

Тухайлбал, ажиллах хүчин дэх үр чадварын дутагдлыг нөхөхөөр сургуулиас гарсан сурагчдын үр чадварыг сайжруулах зорилготой Боловсролын яамны хөтөлбөрт аудит хийж байна гэж үзье. Энэ үед, та зөвхөн гарцад төвлөрвөл, зорилтот мэргэжлийн шаардлагыг хангаж сургуулиас гарсан сурагчдын тоо болон эзлэх хувь хэмжээ зэрэг индикаторуудын өөрчлөлтөд дээр төвлөрөх магадлал өндөр. Харин үр дүнг чухалчилсан, илүү өндөр зорилготой аудитын хувьд дараах илүү нарийн асуултуудыг бодолцож үзэж болно:

- Уг бодлого нь хөдөлмөрийн зах зээл дэх үр чадварын дутагдлыг ямар нэгэн хэмжээгээр өөрчилсөн үү?
- Яамнаас хөдөлмөрийн зах зээл дэх үр чадварын дутагдлыг хэр сайн урьдчилан таамаглаж, хариу арга хэмжээ авч чадаж байна вэ?

Энэ тохиолдолд үр нөлөөтэй байдлыг үр дүнгээр нь хэмжвэл, байгууллагууд болон институтууд хоорондын холбоог судлах шаардлагатай болно. Илүү том орчныг судлах хэрэгтэй болно. Хүрэх үр дүн нь дан ганц хөтөлбөр эсвэл санаачилгаас хамаарахгүй. Дээрх жишээнд, хөтөлбөрийг шууд хариуцсан байгууллагаас гадна хөдөлмөр эрхлэлт, тээвэр, санхүү зэрэгтэй холбогдох байгууллагууд ч өөрийн гэсэн оролцоотой байх боломжтой. Үр нөлөөтэй байдалд ажиллаж буй АДБ нь хөтөлбөрийн үнэлгээ зэрэгт хариуцлагатай байдлыг зураглах арга хандлагаар үр өгөөж бий болгож чадна - бодлогын арга хэмжээний хэрэгжилт болон нөлөөллийг шалгах замаар түүний зорилтот болон зорилтот бус үр нөлөө болон өртгийг тодорхойлж, үнэлэх үйл ажиллагаа. Шаардлагатай үед, АДБ болон аудитын баг шалгагдагч байгууллагын гүйцэтгэлд хууль тогтоомж болон зохион байгуулалтын тогтолцооны үзүүлэх нөлөөллийг бодолцож үзэх ёстой.

Шалгагдагч байгууллагын зорилгуудын хүрсэн үр дүнд хамааралтай гүйцэтгэлийн үр нөлөөт байдалд аудит хийх үед үйл ажиллагааны төлөвлөсөн нөлөөллийг бодит нөлөөлөлтэй харьцуулахад аудит чиглэнэ. Үр нөлөөтэй байдлыг янз бүрийн аргаар хэмжиж болно. Хамгийн боловсронгуй аргууд нь аливаа бодлого эсвэл хөтөлбөрийг нэвтрүүлэхийн өмнөх болон дараах үеийн нөхцөл байдлыг харьцуулж, санамсаргүй туршилт эсвэл бүрэн бус туршилтын¹⁰ загвараар уг бодлого эсвэл хөтөлбөрт хамрагдаагүй хяналтын бүлгийн (эсрэг баримтын) зан үйлийг хэмждэг. Гэвч, энэ төрлийн арга нь байнга ашиглаж болохуйц арга биш. Зарим үед бодлого, хөтөлбөр болон үр нөлөө хоорондын учир шалтгааны хамаарлыг ойлгоход чанарын аргууд илүү тохиромжтой байдаг. Бодлого, хөтөлбөр болон үр нөлөө хоорондын учир шалтгааны хамаарлыг дүгнэх үед ашигласан аргынхаа давуу тал болон хязгаарлалтыг тодорхой тусгах нь чухал. Зөв аргыг сонгоход чиглүүлэг болох олон төрлийн баримт бичиг бий (УДИР-3910/45).

Практикт, дээрх харьцуулалтыг хийхэд хэцүү байх болно. Энэ нь харьцуулахад тохиромжтой материал ихэвчлэн дутагдалтай байдагтай холбоотой. Мөн, аудит хийж буй бодлого,

¹⁰ Бүрэн бус туршилт (quasi-experiment) нь аливаа арга хэмжээнээс зорилтот хүн амд үзүүлэх нөлөөллийг судалдаг боловч судалгаанд хүн амын аль хэсгийг хамруулах вэ гэдгийг сонгохдоо санамсаргүй хуваарилах аргаас өөр аргуудыг ашигладаг.

хөтөлбөрийн нөлөөллийг гадаад хүчин зүйлсээс тусгаарлахад туйлын хэцүү байдаг. Харин бодлогын үндэс суурь болсон таамаглалын үнэмшилтэй байдлыг үнэлж болно. Үүнийг заримдаа хөтөлбөрийн онолыг тестлэх гэж нэрлэдэг. Мөн, хөтөлбөрийн эхний алхмууд, ялангуяа эцсийн нөлөөллийг бий болгоход шаардлагатай алхмууд хэрэгжсэн эсэхийг үнэлж болно. Ихэвчлэн, байгууллагуудын зорилгууд хэр хэмжээнд биелснийг, зорилтот бүлгүүдэд хүрсэн эсэхийг, эсвэл гүйцэтгэлийн хүссэн түвшинд хүрсэн эсэхийг үнэлэх зэрэг харьцангуй амбиц багатай аудитын зорилгыг сонгох шаардлагатай болдог.

“ЗЕ” хооронд ямар хамаарал байдаг вэ?

Аливаа аудит нь ихэвчлэн “ЗЕ”-ийн аль нэг дээр нь төвлөрдөг. Гэсэн хэдий ч, үйл ажиллагааны арвилан хэмнэлт, үр ашигтай байдал эсвэл үр нөлөөтэй байдлыг бүрэн салангид авч үзэхгүй байвал зохино. Тухайлбал, аливаа бодлогын үр дүнг бодолцож үзэхгүйгээр дан ганц арвилан хэмнэлтийг чухалчилбал өртөг багатай боловч үр нөлөөгүй арга хэмжээ бий болно. Нөгөөтээгүүр, үр нөлөөтэй байдалд аудит хийх үед аудитор нь арвилан хэмнэлт болон үр ашигтай байдлыг мөн харгалзан үзэхийг хүсэж болно. Аливаа аудитад шалгуулагч этгээд, үйл ажиллагаа, хөтөлбөр эсвэл арга хэмжээний үр дүн нь хүссэн ерөнхий үр дүнд хүргэж болох ч, нөөц нь хэт өндөр өртөгтэй болж мэднэ... (УДИР-3910/47)

Гүйцэтгэлийн аудитад үр ашгийн гурвалыг ашиглахдаа бид ихэвчлэн нэгээс олон талбарыг авч үздэг бөгөөд уг талбарууд хоорондын хамаарлыг ойлгох нь чухал. Аливаа зорилго эсвэл багц зорилгод хүрэхийн тулд өгөгдсөн хугацааны турш зарцуулагдаж буй нөөцийг бид судлах нь олонтоо. Энэ үед уг арга хэмжээ болон түүний зорилго, орц, үйл явц, гарц болон үр дүн, түүнчлэн ерөнхий үр дүн болон нөлөөлөл хоорондын хамаарлыг ойлгох нь чухал. 1-р зурагт үр ашгийн гурвал хоорондын хамаарлыг орц, гарц болон үр дүнтэй уялдуулан тайлбарлав. Энэхүү загварыг гүйцэтгэлийн аудитынхаа объектыг судлахад ашиглах хэрэгтэй.

Зураг 1: Үр ашгийн гурвал хоорондын хамаарал



Эх сурвалж: Европын Аудиторуудын Шүүхийн мэдээллийг эш болгов.

Гүйцэтгэлийн аудит нь эгэх хариуцлага болон ил тод байдлыг хэрхэн дэмждэг вэ?

Гүйцэтгэлийн аудит нь засаглал болон хяналт хариуцсан этгээдүүдэд гүйцэтгэлийг сайжруулахад шаардлагатай арга хэмжээнүүдийг ойлгоход нь туслах замаар эгэх хариуцлагыг дэмждэг. Мөн, хууль тогтоох эсвэл гүйцэтгэх засаглалын шийдвэр нь арвилан хэмнэлттэй, үр ашигтай болон үр нөлөөтэйгөөр гарч, хэрэгжиж буй эсэхийг, мөн татвар төлөгчид болон иргэд мөнгөний үнэ цэнийг хүртэж буй эсэхийг шалгах замаар далд асуудлуудыг ил болгодог (УДИР-3910/9). Гүйцэтгэлийн аудит нь хууль тогтоох засаглалын эсвэл бодлогын зорилго болон шийдвэрийг судалдаггүй боловч түүний хэрэгжилтийн явцад ямар нэгэн саад тулгарч, тодорхойлсон зорилгыг биелүүлэхэд саад болсон эсэхийг судалдаг. (АДБОУС-300/12)

Гүйцэтгэлийн аудит нь засгийн газрын янз бүрийн үйл ажиллагааны удирдлага болон үр дүнг ойлгоход тусалснаар ил тод байдлыг дэмждэг. Энэхүү аудитын гарцыг дараах этгээдүүд сонирхоно

- Засгийн газрын болон хууль тогтоох байгууллагууд;
- Татвар төлөгчид болон улсын төсвийн бусад эх үүсвэрүүд;
- Засгийн газрын бодлогыг хэрэгжүүлэгчид; мөн
- Зарим тохиолдолд, хэвлэл мэдээллийн хэрэгслүүд.

Иймд, гүйцэтгэлийн аудит нь улсын секторыг судалж, сайжруулах үндэс суурь болохын зэрэгцээ иргэдийг хэрэгцээт мэдээллээр хангахад шууд хувь нэмэр оруулдаг. (АДБОУС-300/12, УДИР-3910/9)

Гүйцэтгэлийн аудит нь мөн хууль тогтоох засаглалд засгийн газрын гүйцэтгэлд эгэх хариуцлага тооцоход нь тусалдаг. Гүйцэтгэлийн аудитыг ихэвчлэн хууль тогтоох засаглалын зүгээс хийдэг боловч зарим улс орон өөр төрлийн зохицуулалттай байдаг. Улс орон бүрийн үндсэн хуулийн зохицуулалтаас хамаарч АДБ-ын тайлан нь хууль тогтоох засаглал дахь цаашдын хэлэлцүүлэг буюу хурлуудын үндэс суурь болдог. Ийнхүү, гүйцэтгэлийн аудит нь эгэх хариуцлага болон ил тод байдлыг хоёуланг нь дэмждэг.

Гүйцэтгэлийн аудит ямар үнэ цэн авчрах вэ?

Гүйцэтгэлийн аудит нь иргэдэд үнэ цэн нэмж чадах, сайжруулалт хийх хамгийн өндөр боломжтой талбаруудад төвлөрдөг бөгөөд аудитад шалгуулагч этгээдэд гүйцэтгэлээ сайжруулах тохиромжтой арга хэмжээ авахад нь туслах бүтээлч зөвлөмж өгдөг. (АДБОУС-300/12)

Гүйцэтгэлийн аудит нь ямар үнэ цэн нэмдэг вэ?

АДБ-аас гүйцэтгэж буй улсын секторын аудит нь иргэдийн амьдралд өөрчлөлт авчрах чухал хүчин зүйл юм. Засгийн газрын болон улсын секторын байгууллагуудад хийх АДБ-ын аудит нь улсын нөөцийг хамгаалагчдын оюун ухааныг уг нөөцийг сайн ашиглахад төвлөрүүлдэг учраас нийгэмд итгэх итгэлд эергээр нөлөөлдөг. Ийнхүү мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх нь хүсэмжит үнэ цэнийг дэмжиж, эгэх хариуцлагын механизмуудыг бэхжүүлснээр шийдвэр гаргалтыг сайжруулахад нөлөөлдөг.

АДБ-ын аудитын үр дүнг нийтэлсний дараа, иргэд, олон нийт улсын нөөцийг захиран зарцуулагчдад эгэх хариуцлага тооцох боломжтой болно. АДБ нь төрийн захиргааны үр ашигтай байдал, эгэх хариуцлага, үр нөлөөтэй байдал болон ил тод байдлыг ийнхүү дэмждэг.

Эх сурвалж: АДБОУБ-3-12.

Ерөнхийдөө, гүйцэтгэлийн аудит нь дараах зүйлсийг тодорхой болгох зэргээр үр өгөөж бий болгодог:

- Төрийн үйлчилгээний үргүй зарлага болон үр ашиггүй байдал;
- Төрийн үйлчилгээний хөрөнгө оруулалтын өгөөжийг хамгийн их байлгах боломжууд;
- Бодлогын зорилгуудыг биелүүлэхэд тохиолдох эрсдэлүүд; мөн
- Иргэдэд тулгамдаж буй нийгмийн болон эдийн засгийн асуудлууд.

АДБОУБ-3-12 нь АДБ-ууд иргэдийн амьдралд өөрчлөлт авчирч болох арга замуудыг тайлбарладаг. 2-р зурагт гүйцэтгэлийн аудитаар дамжуулан бий болгож болох тодорхой хувь нэмрүүдийг харуулав.

Зураг 2: Гүйцэтгэлийн аудит хэрхэн үнэ цэн нэмж болох вэ?

Гүйцэтгэлийн аудитын үнэ цэн нэмдэг үйл ажиллагаа	АДБОУБ-3-12-ын холбогдох зарчим	АДБ энэхүү үйл ажиллагааг хэрхэн гүйцэтгэж болох вэ?
Шударга байдал Засгийн газрын мэдээлж буй амжилтыг хараат бусаар баталгаажуулах	2 – Засгийн газрын болон улсын секторын байгууллагуудын улсын нөөцийн захиран зарцуулалтыг эгэх хариуцлагатай байлгахын тулд аудит хийх.	Орон сууцны зах зээл дэх засгийн газрын санхүүгийн арга хэмжээ нь зах зээлд оролцохгүй байсан худалдан авагчдыг зоригжуулсан эсэхийг шалгах. Худалдан авахад туслах: Хөрөнгийн зээлийн төлөвлөгөө – ахицын нягталгаа. ҮАГ (ИБУИНХУ), 2019.
Эгэх хариуцлага Гүйцэтгэх засаглалын гүйцэтгэлийг эгэх хариуцлагатай байлгахад туслах	2 – Засгийн газрын болон улсын секторын байгууллагуудын улсын нөөцийн захиран зарцуулалтыг эгэх хариуцлагатай байлгахын тулд аудит хийх.	Засгийн газар эмнэлгийн тоног төхөөрөмж худалдан авахдаа сайн хэлэлцээр хийдэг эсэхийг үнэлэх. Клиникийн үйлчилгээний газрын эмнэлгийн тоног төхөөрөмж, мэс заслын хэрэгслийн худалдан авалтад хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан. Ботсвана улсын Ерөнхий Аудиторын Газар, 2012.
Ил тод байдал АДБ нь шинэ мэдээлэл нийтэлснээр улсын нөөцийг хэрхэн ашиглаж буйг ил болгож чадна	4 – Аудитын үр дүнг тайлагнаснаар олон нийтийг засгийн газрын болон улсын секторын байгууллагуудад эгэх хариуцлага тооцох боломжтой болгох.	Зөвхөн дотоодод нээлттэй байсан бүс нутгийн гүйцэтгэлийн өгөгдлийг нийтлэх. ҮЭМҮ-ний (NHS) сонголтод болон хорт хавдрын эмчилгээний хүлээлгийн хугацаа. ҮАГ (ИБУИНХУ), 2019.

<p>Шинэ ойлголт Засгийн газар хараахан ашиглаж байгаагүй дүн шинжилгээний техникүүдийг ашиглах</p>	<p>7 – Улсын сектор дэх үр өгөөжтэй өөрчлөлтийг дэмжих удирдамж ба хараат бус бөгөөд бодитой ойлголт, найдвартай эх сурвалж байх.</p>	<p>Ажилтны гүйцэтгэлд ямар хүчин зүйл статистикийн ач холбогдол бүхий нөлөө үзүүлж буйг тогтооход олон хүчин зүйлст регрессийн шинжилгээ ашиглах.</p> <p>Холбооны ажиллах хүч: Ирээдүйтэй практикт нэмэлт шинжилгээ хийж, хуваалцах нь ажилтны үйл ажиллагаа болон гүйцэтгэлийг сайжруулах боломжтой, Төрийн хариуцлагын газар ТХГ, 2015.</p>
<p>Дотоод, гадаадын сайн туршлагыг хуваалцах Бусад яамдын ижил үйл ажиллагаанд аудит хийсэн туршлагад үндэслэн ойлголт санал болгох. АДБ-ууд нь өөрсдийн бие даасан аудитын тайлангуудад шинжилгээ хийж, сэдвүүд, нийтлэг илрүүлэлтүүд, чиг хандлага, уг шалтгаан болон аудитын зөвлөмжүүдийг тодорхойлж, үүнийгээ гол оролцогч талуудтай хэлэлцэж болно. АДБ-ууд нь мөн олон улсын улсын секторын аудитын салбар дахь оролцоогоо ашиглан бусад улс орнуудаас туршлага, сургамж авч болно.</p>	<p>7 – Улсын сектор дэх үр өгөөжтэй өөрчлөлтийг дэмжих удирдамж ба хараат бус бөгөөд бодитой ойлголт, найдвартай эх сурвалж байх.</p>	<p>Өөр өөр улс орнууд нэгэн ижил үйл ажиллагааг хэрхэн удирдлагыг харьцуулах.</p> <p>ИБУИНХУ-ын ЭМ-ийн тусламж, үйлчилгээ: Англи, Шотланд, Уэльс, Хойд Ирландын ҮЭМҮ-ний харьцуулалт, ҮАГ (ИБУИНХУ), 2012.</p> <p>L'accès des jeunes à l'emploi : construire des parcours, adapter les aides (Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийн хүртээмж – замнал үүсгэж, төрийн дэмжлэгийг сайжруулах нь), Cour des comptes. (Францын Аудиторуудын Шүүх), 2016.</p>
<p>Практик зөвлөмж гаргах Аудитад шалгуулагч этгээдийг гүйцэтгэлээ сайжруулах боломжоор хангах зөвлөмжүүдийг гүйцэтгэлийн аудитын тайланд оруулах.</p>	<p>3 – Улсын секторын засаглалыг хариуцдаг хүмүүсийг аудитын илрүүлэлтүүд болон зөвлөмжүүдийн дагуу тохиромжтой залруулах арга хэмжээ авах үүрэг хариуцлагаа биелүүлэх боломжоор хангах.</p>	<p>Гүйцэтгэлийн хангалтгүй байдлын уг шалтгааныг үнэлсний дараа энэхүү нотлох зүйлдээ үндэслэн хэрхэн илүү сайн гүйцэтгэлтэй болгохыг санал болгосон зөвлөмж гаргах.</p>
<p>Нарийн төвөгтэй байдлыг тодорхой болгох Нарийн төвөгтэй сэдвүүдийн талаар ойлгоход хялбар хураангуй үүсгэх</p>	<p>4 – Аудитын үр дүнг тайлагнаснаар олон нийтийг засгийн газрын болон улсын секторын байгууллагуудад эгэх хариуцлага тооцох боломжтой болгох.</p>	<p>Гүйцэтгэлийн аудитын нийтлэлийг энгийн бөгөөд ойлгомжтой байдлаар, бүх зорилтот хэрэглэгчийн ойлгодог хэлээр бичих.</p>




Аудитор таны хувьд гүйцэтгэлийн аудитаар үнэ цэн нэмж болох эсэх, нэмбэл хэрхэн нэмж болох талаар эртнээс бодох нь чухал. Энэ эргэцүүлэл нь танд ажлынхаа нөлөөллийг хамгийн их байлгах арга, шинжилгээ болон харилцааны стратегийг зохиоход тусална.

Гүйцэтгэлийн аудитын дүнд ямар төрлийн тайлангууд гарах вэ?

Гүйцэтгэлийн аудит нь “ЗЕ”-г дэмжих болон эгэх хариуцлага хийгээд ил тод байдлыг нэмэгдүүлэх зорилготой байдаг тул боломжит хамрах хүрээ нь өргөн байж болно. Гэхдээ, зарим сэдэв бусдаасаа илүү их давтамжтай тохиолддог. **3-р зурагт** гүйцэтгэлийн аудит хийх явцад тохиолдох магадлалтай түгээмэл сэдвүүдийн заримыг үзүүлэв.

Зураг 3: Гүйцэтгэлийн аудитын явцад тохиолддог сэдвүүд

Сэдэв	Аудитын зорилгын жишээ	Энэ сэдвээр аудит хийсэн АДБ-ын тайлангийн жишээ
 <p>ТХЗ-ыг хэрэгжүүлэх бэлэн байдал</p>	<p>2015 оны 9-р сард 2030 Хөтөлбөрийг баталснаас хойш Ямайка улсын засгийн газраас үндэсний хэмжээнд хэрэгжүүлсэн арга хэмжээнүүд нь ТХЗ-ыг биелүүлэх бэлэн байдлыг дэмжихэд хангалттай байсан хэр хэмжээг үнэлэх.</p>	<p>Тогтвортой Хөгжлийн Зорилгуудыг (ТХЗ) Хэрэгжүүлэх Ямайка Улсын Бэлэн Байдал. Ямайка Улсын Ерөнхий аудиторын газар, 2018.</p>
 <p>Үр нөлөөтэй худалдан авалт</p>	<p>Эрүүл Мэндийн Яам эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмжөө бусад улстай харьцуулахад илүү боломжийн чанар болон үнээр худалдан авахын тулд үр нөлөөтэй худалдан авалтын горим ашигласан эсэхийг тогтоох.</p>	<p>Эрүүл Мэндийн Яамны Клиникийн үйлчилгээний газрын эмнэлгийн тоног төхөөрөмж, мэс заслын хэрэгслийн худалдан авалтад хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан. Ботсвана Улсын Ерөнхий аудиторын газар (ЕАГ), 2012.</p>
 <p>Нийт засгийн газрын зохицуулалт</p>	<p>Уур амьсгалын өөрчлөлтийн улмаас үүссэн байгаль орчны сорилтуудыг даван туулахад төрийн байгууллагууд хэр сайн хамтран ажиллаж байгааг тогтоох.</p>	<p>Төрийн ногоон худалдан авалт – удирдлага нь уур амьсгалын зорилгыг биелүүлэхэд үр нөлөөтэй тусалж байна уу? Швед Улсын УАГ, 2012</p>
 <p>Эдийн засгийн үр дүн</p>	<p>Жижиг бизнесүүдэд зориулсан засгийн газрын дэмжлэг, сургалт нь эдийн засгийн өсөлтөд хүргэсэн эсэхийг, мөн өгөөжийг нь тэгш хуваасан эсэхийг үнэлэх.</p>	<p>Цахим худалдааны жижиг, дунд бизнесүүдийг дэмжих Европын Бүс Нутгийн Хөгжлийн Сангийн дэмжлэг үр нөлөөтэй байсан уу? Европын аудиторуудын шүүх, 2014.</p>
 <p>Зохицуулалт</p>	<p>Мөрийтэй тоглоомын зохицуулалт хүмүүсийг үр нөлөөтэй бөгөөд пропорциональ байдлаар мөрийтэй тоглоомтой холбоотой хор хохирлоос хамгаалж, үүсэх эрсдэлийг бууруулж буй хэр хэмжээг судлах.</p>	<p>Мөрийтэй тоглоомын зохицуулалт: донтолт ба эмзэг хүмүүсийг хамгаалах нь, ИБУИНХУ-ын УАГ, 2020.</p>
 <p>Нийгмийн үр дүн</p>	<p>Хариуцах яам нь дотоодын ус хангамжийн сүлжээний шүүрлийн асуудлыг хангалттай шийдвэрлэж байгаа эсэхийг үнэлэх.</p>	<p>Хот, суурин газруудын ус түгээлтийн удирдлага, Танзани Улсын УАГ, 2012.</p>
 <p>Байгаль орчны болон тогтвортой байдлын үр дүн</p>	<p>Хариуцах яам нь загасны нөөцийн тогтвортой удирдлагыг үр нөлөөтэй дэмжиж байгаа эсэхийг үнэлэх.</p>	<p>Байгалийн усан дахь загасны нөөцийн тогтвортой удирдлага, Замби Улсын Ерөнхий аудиторын газар (ЕАГ), 2015.</p>
 <p>Жендэрийн тэгш байдал</p>	<p>Одоогийн хууль эрх зүй болон бодлогын хүрээ; уг хүрээг хэрэгжүүлж буй үйл явц; мөн хүрээний хэрэгжилтийг хянан-шинжилж, тайлагнах зохицуулалтыг судлах замаар Эмэгтэйчүүдийн Үйл Ажиллагааны Хөтөлбөрийн хэрэгжилт, ялангуяа эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг таслан зогсоох арга хэмжээ үр нөлөөтэй байгаа эсэхийг, мөн сайжруулалт хийх боломж байгаа эсэхийг үнэлэх.</p>	<p>Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг таслан зогсоох нь, Фижи улсын АДБ, 2019.</p>

 <p>Дэд бүтэц</p>	<p>Хөдөөгийн ХАА-н Хөгжлийн Газраар (ХХААХГ (RADA)) дамжуулан засгийн газар нь Ямайка улсын фермийн замыг сэргээн засах ажилд зориулсан үр нөлөөтэй удирдлагын тогтолцоо бий болгосон эсэхийг үнэлэх. Түүнчлэн, ХХААХГ нь замын сэргээн засвар/арчлалтад чанарын стандарт нэвтрүүлэх замаар онц сайн гүйцэтгэлийг хамгийн ихээр чухалчилж, замын ажил чанар муутай болох эрсдэлийг хамгийн бага байлгахын төлөө ажиллаж буй эсэхийг үнэлэх.</p>	<p>ХХААХГ-ын фермийн замыг сэргээн засах ажлын удирдлага, Ямайка улсын АДБ, 2019.</p>
 <p>Боловсрол</p>	<p>Хувийн хэвшлийн сурагч, багш нарыг дэмжих засгийн газрын хөтөлбөр (ХХСБНДЗГХ) нь зорилго, зорилтууддаа хүрсэн хэр хэмжээг тодорхойлох. Мөн, Боловсролын Яам нь боловсрол хамгийн хэрэгтэй байгаа бүлгүүдийг тэргүүлэх зорилгоо болгож, хөтөлбөрийн удирдлагыг зохистой болгосон эсэхийг үнэлэх.</p>	<p>ХХСБНДЗГХ, Филиппин Улсын АДБ, 2018.</p>
 <p>Эрүүл мэнд, боловсрол болон жендерийн тэгш байдал</p>	<p>Өсвөр насныханд зориулсан жирэмслэлтээс сэргийлэх үйлчилгээ үр нөлөөтэй байсан эсэхийг тодорхойлох.</p>	<p>Өсвөр насныхны жирэмслэлтээс сэргийлэх үйлчилгээ. Эл үйлчилгээг Эмэгтэйчүүд болон Эмзэг Бүлгийнхэн, мөн Эрүүл Мэнд болон Боловсролын Яамд үзүүлжээ. Перу улсын АДБ, 2018.</p>

Эх сурвалж: АДБОУБХС/ГАДХ-ны Хөгжлийн Баг.

Гүйцэтгэлийн аудит болон бусад төрлийн улсын секторын аудитууд хоорондоо ямар ялгаатай вэ?

Гүйцэтгэлийн аудит бол өөрийн гэсэн стандарт болон тогтсон ёстой тусгай үйл ажиллагаа юм. Гүйцэтгэлийн аудит болон улсын секторын аудитын бусад хоёр үндсэн төрөл (санхүүгийн аудит болон нийцлийн аудит) хоорондын ялгааг ойлгох нь чухал.

Санхүүгийн аудитыг гүйцэтгэлийн аудитаас ихэнхдээ хялбархан ялгаж болдог. Санхүүгийн аудитын хувьд, аудитын нотлох зүйлс цуглуулах замаар аливаа байгууллагын санхүүгийн мэдээлэл холбогдох санхүүгийн тайлагнал болон зохицуулалтын хүрээний дагуу санхүүгийн мэдэгдэлд нь байгаа эсэхийг тодорхойлдог (АДБОУС-200/7). АДБ-үүд нь санхүүгийн аудитыг жил бүр хийдэг бөгөөд энэ үед аудиторүүд нь аудитад шалгуулагч этгээдийн санхүүгийн мэдэгдлүүдийг шалгаж батламжилдаг. Санхүүгийн аудит нь санхүүгийн мэдэгдлүүдийн зорилтот хэрэглэгчдэд аудитаар шалгасан мэдэгдлүүдэд тусгасан мэдээллийн найдвартай бөгөөд хамааралтай байдалд итгэх итгэл өгөх замаар үнэ цэн нэмдэг.

Нийцлийн аудит болон гүйцэтгэлийн аудит нь заримдаа давхацдаг тул хоорондын ялгааг нь ойлгоход багагүй сорилттой болж болно. Нийцлийн аудит нь үйл ажиллагаа, санхүүгийн гүйлгээ болон мэдээллийг шалгах зэргээр янз бүрийн шинж чанартай өргөн хүрээтэй аудитын үйл ажиллагааг хамруулдаг.

Нийцлийн аудит бол аливаа судлах сэдэв/ зүйлийг холбогдох эрх мэдлийн хэрэгсэл буюу шалгууртай нийцэж буй эсэхийг үнэлэх хараат бус үнэлгээ юм. Нийцлийн аудит хийхэд, үйл ажиллагаа, санхүүгийн гүйлгээ болон мэдээлэл нь аудитад шалгуулагч этгээдийг засагладаг эрх мэдлийн хэрэгслүүдтэй, материаллаг байдлын бүх талаар нийцэж буй эсэхийг үнэлдэг (АДБОУС-400/12). Эрх мэдлийн хэрэгсэл гэдэгт улсын секторын санхүүгийн сайн удирдлага болон төрийн албан хаагчийн үйл хөдлөлийг засаглах дүрэм, хууль, зохицуулалт, төсвийн шийдвэр, бодлого, тогтсон ёс, тохиролцсон нөхцөл эсвэл ерөнхий зарчмууд багтаж болно. (АДБОУС-400/29)

Зарим гүйцэтгэлийн аудит нь судлах сэдэв/ зүйлийн “ЗЕ”-г судлахад шаардлагатай бөгөөд хамааралтай хэмжээнд нийцлийн аудитын асуултуудыг ашиглаж болно.

Гүйцэтгэлийн аудит бол шууд тайлагнах ажил (АДБОУС-100/29-30). Шууд тайлагнах ажлын хувьд, аудитор нь судлах сэдэв/зүйл болон шалгуураа сонгоод эрсдэл болон материаллаг байдлыг харгалзаж үзэнгээ шалгуураараа судлах сэдэв/зүйлээ хэмжих буюу үнэлдэг. Хэмжилтийн үр дүнг аудитын тайланд илрүүлэлт, дүгнэлт, зөвлөмж эсвэл санал хэлбэрээр толилуулна. (АДБОУС-100/29)

Нөгөө төрлийн үйл ажиллагаа нь баталгаажуулах үйл ажиллагаа бөгөөд энэ үед хариуцагч тал нь судлах сэдэв/ зүйлийг шалгуураараа хэмжээд судлах сэдэв/ зүйлийн мэдээллийг толилуулдаг. Аудитор нь дүгнэлт гаргахад шаардлагатай зөв үндэслэлийг бий болгохын тулд хангалттай бөгөөд зохистой аудитын нотлох зүйлс цуглуулна. Санхүүгийн аудит бол үргэлж баталгаажуулах үйл ажиллагаа байдаг. Харин нийцлийн аудит нь баталгаажуулах эсвэл шууд тайлагнах үйл ажиллагаа, эсвэл нэгэн зэрэг баталгаажуулах болон шууд тайлагнах үйл ажиллагаа байж болно. (АДБОУС-100/29-30)

Шууд тайлагнах ажил гэсэн ангилалд байх нь гүйцэтгэлийн аудитад хэрхэн нөлөөлөх вэ?

Гүйцэтгэлийн аудит нь шууд тайлагнах үйл ажиллагаа тул тайлан болон дүгнэлтийнхээ судлах сэдэв/ зүйлийг сонгож, тодорхойлох нь аудитор таны үүргийн нэг хэсэг болно. Түүнчлэн, холбогдох шалгуурыг тодорхойлох нь таны үүргийн нэг хэсэг бөгөөд аудитын хэрэглэгчдийг хамааралтай бөгөөд найдвартай мэдээллээр хангах аудитын тайлан бичихийн тулд судлах сэдэв/ зүйлээ шалгууруудаар хэмжих буюу үнэлэх нь таны хийх ёстой ажил юм. Хамааралтай аудитын асуултуудыг асууж, судлах сэдэв/ зүйлийн аудитын нотлох зүйлсийг олоход тохирох аргуудыг сонгож, ашиглахад та тун идэвхтэй үүрэг оролцоотой байх хэрэгтэй.

Гүйцэтгэлийн аудит хийхэд аудитад шалгуулагч байгууллагын ажлын горимыг тодорхой хэмжээнд шалгах хэрэгтэй болдог ч, аудит бүхэлдээ зөвхөн “бичиг цаастай зууралдсан” үйл ажиллагаа болж хувирахаас сэргийлэх хэрэгтэй. Ажлын горимыг тестэлж, дутагдлыг илрүүлэх нь гүйцэтгэлийг үнэлэхэд шаардлагатай ойлголтыг бий болгодоггүй. Гүйцэтгэлийг хэмжинэ гэдэг нь аудитад шалгуулагч этгээд бодлогоо хэрэгжүүлэхийн тулд юу хийж байгаа вэ гэдгийг үнэлэх үйл явц юм. Ингэхдээ таны шалгаж буй ажлын горим нь амжилттай үр дүнд хэрхэн хувь нэмэр оруулж буйг сайтар тайлбарлах хэрэгтэй болно. Тухайлбал, аливаа

нэг Яам албаны хэрэгцээндээ тээврийн хэрэгсэл хэрхэн худалдан авдгийг үнэлж байгаа гүйцэтгэлийн аудит нь уг байгууллагын ажилтнууд худалдан авах ажиллагааны горимоо дагаж буй эсэхийг шалгаж болно. Гэхдээ, үр дүнгийн нотлох зүйлсийг цуглуулсаар байх болно. Тухайлбал:

- Тээврийн хэрэгслүүдийг хэр их ашиглалгүй орхидог вэ?
- Яам нь тээврийн хэрэгслүүдэд шударга үнэ төлсөн үү?
- Хувийн бизнесүүд нь Яамнаас илүү хямд үнээр тээврийн хэрэгсэл авч чадах үү?
- Яам нь тээврийн хэрэгслийн техникийн үйлчилгээний зардлыг хэрхэн бууруулж болох вэ?
- Тээврийн хэрэгслийг шаардлагатай үед нь түрээслэн авч ашигладаг байх нь илүү өртөг багатай байх үү?

Шууд тайлагнах ажлын хувьд, уншигчдад мэдээлэл өгөх нь аудитор таны үүрэх хариуцлага байдаг:

- Гүйцэтгэлийн аудитын зорилго(ууд) нь юу вэ?
- Та ямар шалгуурыг, яагаад сонгосон бэ?
- Та ямар нотлох зүйлс цуглуулсан бэ?
- Гүйцэтгэлд ямар давуу талууд болон сул талууд оршин байгаа вэ?
- Сул тал нь юунаас, яагаад үүдсэн бэ?
- Нотлох зүйлс нь хэр няцаагдашгүй вэ?
- Та ямар дүгнэлтэд, яагаад хүрсэн бэ?
- Тайлагнасан илрүүлэлтийн нөлөөлөл эсвэл үр дагавар нь юу вэ?
- Уншигч нь дүгнэлтэд хэр хэмжээнд итгэж болох вэ?

Гүйцэтгэлийн аудитын гурван тал гэж хэн бэ?



Стандарт

Аудитор нь аудитын зорилтот хэрэглэгчид болон хариуцагч талуудыг сайтар тодорхойлж, аудитыг зохих ёсоор хийхийн тулд аудитын туршид эдгээр үүргүүдийн учир холбогдлыг бодолцож үзэх хэрэгтэй.

Эх сурвалж: АДБОУС-3000/25.

Улсын секторын аудитын гурван тал гэдэг нь аудитор, хариуцагч тал болон зорилтот хэрэглэгчид юм. Эдгээр нь гүйцэтгэлийн аудитын үед ялгаатай шинж чанартай байж болно.

Аудиторын үүргийг АДБ-ын тэргүүн болон аудит хийхээр томилогдсон хүмүүс гүйцэтгэнэ (АДБОУС-100/25). Энэхүү тодорхойлолт нь АДБ-ын ялгаатай загваруудын хувьд өөр өөр байна. Вестминстерийн загварын хувьд, АДБ нь ихэвчлэн Үндэсний Аудитын Газар гэгддэг бөгөөд тайлан дээр аудитын хариуцлагыг үүрэгч болох Ерөнхий Аудитор дангаар гарын үсэг зурдаг. Шүүхийн загвар болон Зөвлөлийн (буюу Коллежийн) загварын хувьд, аудиторууд нь удирдлагын түвшний хяналтын дор аудитыг хийдэг. Иймд, дүрмүүдийг эдгээр институтийн загваруудаас хамааруулж тайлбарлах хэрэгтэй (ХАШ, 2020).

Гүйцэтгэлийн аудит хийж буй аудиторууд нь ерөнхийдөө янз бүрийн, бие биеэ нөхсөн үр чадвараараа элбэж, багаар ажилладаг (АДБОУС-300/16).

Хариуцагч тал нь судлах сэдэв/ зүйлийг хариуцсан этгээд буюу аудиторыг мэдээллээр хангаж, зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх үүрэгтэй этгээд байж болно. Гүйцэтгэлийн аудитын хувьд энэ үүргийг хувь хүмүүс эсвэл байгууллагууд хуваалцаж болдог. Хариуцагч тал нь мөн зорилтот хэрэглэгч байж болох боловч ерөнхийдөө дан ганц зорилтот хэрэглэгч нар байдаггүй (АДБОУС-100/25; АДБОУС-300/17; АДБОУС-3000/27).

Зорилтот хэрэглэгч гэдэг нь аудитор аудитын тайлангаа зориулан бэлтгэж өгдөг хувь хүмүүс, байгууллагууд эсвэл тэдгээрийн нэгжүүд байдаг. Хууль тогтоох, гүйцэтгэх засаглал, засгийн газрын агентлагууд, аудитад холбогдох гуравдагч тал болон олон нийт бол зорилтот хэрэглэгчдийн жишээ юм. (АДБОУС-100/25; АДБОУС-3000/26)

Аудитор таны хувьд зорилтот хэрэглэгчид болон хариуцагч талуудын хэрэгцээ шаардлага, хүсэл сонирхлыг харгалзан үзэх нь чухал. Ингэснээр аудитын тайланг үнэ цэн нэмдэг бөгөөд дээрх этгээдүүдэд ойлгомжтой болгодог. Гэхдээ энэ нь таны хараат бус байдал болон бодитой хандлагыг аудитын туршид үгүй хийхгүй байх ёстой. (АДБОУС-3000/28)

Судлах сэдэв/ зүйл болон судлах сэдэв/ зүйлийн мэдээлэл гэж юу вэ?



Стандарт

Аудитор нь гүйцэтгэлийн аудитын судлах сэдэв (зүйл)-ийг тодорхойлох ёстой.

Эх сурвалж: АДБОУС-3000/29.

Судлах сэдэв/ зүйл гэдэг нь тодорхой шалгуураар хэмжсэн буюу үнэлсэн мэдээлэл, нөхцөл эсвэл үйл ажиллагааг хэлнэ. Судлах сэдэв/ зүйл нь “Юунд аудит хийх вэ?” гэсэн асуулттай холбогдох бөгөөд аудитын үйл ажиллагааны хил хязгаар болох аудитын хамрах хүрээнд тодорхойлогддог. Гүйцэтгэлийн аудитын судлах сэдэв/ зүйл нь хөтөлбөр, арга хэмжээ, тогтолцоо, байгууллага эсвэл сан байж болно. Эдгээр нь үйл ажиллагааг (гарцаар, үр дүнгээр, нөлөөллөөр) эсвэл учир шалтгаан болон үр дагавар зэрэг одоогийн нөхцөл байдлыг бүрдүүлдэг. Судлах сэдэв/ зүйлийг аудитын зорилгоор тодорхойлж, аудитын асуултуудаар томъёолно. (АДБОУС-100/26; АДБОУС-300/19; АДБОУС-3000/30)

Судлах сэдэв/ зүйлийн мэдээлэл гэдэг нь судлах сэдэв/ зүйлийг шалгууруудаар үнэлэх буюу хэмжсэний үр дүнг хэлнэ (АДБОУС-100/28). Гүйцэтгэлийн аудитын хувьд, аудитор нь судлах сэдэв/ зүйлийн мэдээллийг үүсгэдэг. Харин санхүүгийн аудитын хувьд хариуцагч тал нь судлах зүйлийн мэдээллийг (санхүүгийн мэдэгдлүүд) үүсгэдэг. Дараа нь аудитор уг аудитын нотлох зүйлсийг авч, дүгнэлтийнхээ дэмжлэг болгодог. (ХАШ, 2020)

2-р бүлэг

Чанартай гүйцэтгэлийн аудитын гол зарчмууд гэж юу вэ?

Энэхүү бүлэгт гүйцэтгэлийн аудитыг чанартай хийхэд шаардлагатай 8 зарчмыг үзнэ. АДБОУС-100/36-43-ын дагуу уг зарчмууд нь:

- Чанарын хяналт;
- Хараат бус байдал ба ёс зүй;
- Мэргэжлийн үнэлэмж ба үл итгэх үзэл;
- Аудитын багийн чадамж;
- Материаллаг байдал;
- Аудитын баримтжуулалт ба хянан удирдлага;
- Аудитын эрсдэл ба баталгаа; мөн
- Аудитад шалгуулагч этгээд, гадаад оролцогч талууд, хэвлэл мэдээллийнхэн болон олон нийттэй харилцах.

Гүйцэтгэлийн аудитын онилох зүйл болон мөн чанарыг бодож үзвэл, эдгээр зарчмууд нь АДБ-үүд болон аудитор танд асар чухал болно. Эдгээр зарчмууд байхгүй бол АДБ-үүд болон аудиторүүд гүйцэтгэлийн аудитыг үр нөлөөтэй хийх бололцоогүй болж, улмаар арвилан хэмнэлт, үр ашиг болон үр нөлөөтэй байдлыг (ЗЕ) сайжруулж чадахгүйд хүрнэ. Танай АДБ эдгээр зарчим тус бүртэй холбогдох шаардлагуудыг тайлбарласан бодлого, горимуудтай байх нь чухал. Энэ бүлэгт дээрх зарчмуудыг хэрэгжүүлэхэд шаардлагатай АДБ-ын түвшний бодлогуудыг товч авч үзнэ. Гэсэн хэдий ч, дээрх зарчмуудыг хэрэгжүүлэхэд тохирох алхмуудыг аудитор та хэрхэн авч хэрэгжүүлж болох талаар голчлон өгүүлнэ.

Энэ бүлэгт мөн АДБОУБХС-аас дэвшүүлсэн хүртээмжтэй байдлыг хэвшүүлж, гүйцэтгэлийн аудитын нөлөөллийг хамгийн их байлгахад анхаарах зүйлсийг тайлбарласан хэсгийг оруулсан болно.

Чанарын хяналт гэж юу вэ?



Стандарт

АДБ-ууд нь ёс зүй болон чанарын хяналтын зохих горимыг бий болгож, мөрдүүлэх хэрэгтэй.

Эх сурвалж: АДБОУС-100/35.

Аудитыг тогтмол өндөр түвшинд хийдэг байлгахын тулд АДБ-ын чанарын хяналтын бодлого, горимууд нь мэргэжлийн стандартуудтай нийцэх ёстой. Аудиторууд нь чанарын хяналтын мэргэжлийн стандартыг баримтлан аудит хийх хэрэгтэй. (АДБОУС-100; АДБОУС-140)

АДБ нь аудит болон бусад ажлаа тогтмол өндөр чанартай байлгах хэрэгтэй. АДБ-ын ажлын чанар нь тэдний нэр хүнд болон итгэл хүлээх байдалд нөлөөлж, эцсийн дүндээ бүрэн эрхээ хэрэгжүүлэх чадварт нь нөлөөлдөг (АДБОУС-140).


Чанарын хяналт гэдэг нь аудитын тайлангуудыг зохистой, тэнцвэртэй, шударга, үнэ цэн нэмдэг бөгөөд АДБОУС-д нийцсэн байлгахын тулд АДБ-аас бий болгосон бодлого, горимуудын тогтолцоо юм. Чанарын хяналт нь аудитын үйл явцын бүхий л үе шатанд буюу төлөвлөх, гүйцэтгэх, тайлагнах болон мөрөөр хяналт тавих үе шатуудад хэрэгжсээр байх ёстой. Ийм бодлого, горимуудыг чанарын хяналтын тогтолцоог ерөнхийд нь хариуцдаг АДБ-ын тэргүүн (дарга) үүсгэх хэрэгтэй (АДБОУС-140).

Чанарын баталгаажуулалт гэдэг нь чанарын хяналтын тогтолцоотой холбогдох бодлого, горимууд нь хамааралтай, хангалттай бөгөөд практикт үр нөлөөтэй хэрэгжиж буй гэдгийг АДБ-д үндэслэлтэйгээр баталж өгөх зорилготой хяналт-шинжилгээний үйл явц бий болгохтой холбогдох ойлголт юм (АДБОУС-140/6). Чанарын баталгаажуулалт нь аудитыг АДБОУС-уудын дагуу гүйцэтгэсэн эсэхийг баталгаажуулахын тулд нягталгаа хийхийг зорилгоо болгодог.

Тайлан гарахаас өмнө хийгдэж буй нягталгаа, горимын хэрэгжилт болон шалгалтууд нь тайланг өндөр чанартай байлгах АДБ-ын чанарын хяналтын тогтолцооны нэг хэсэг юм. Эдгээр нягталгааг менежерүүд эсвэл гаднын нягтлагч нар хийж болно. Чанарын баталгаажуулалт нь, нөгөө талаас, зохистой чанарын хяналтын тогтолцоо байгаа эсэхийг, уг тогтолцоо нь зохих ёсоор хэрэгжиж буй эсэхийг шалгадаг. Чанарын баталгаажуулалтыг шууд удирдах менежерүүд хийдэггүй бөгөөд чанарын баталгаажуулалтад хэдийнээ нийтлэгдсэн тайлангуудыг хамруулдаг. (AFROSAI-E Гүйцэтгэлийн аудитын гарын авлага, 2016)

Чанарын хяналтын 6 гол элементийг 4-р зурагт үзүүлэв. Түүнчлэн, 1-р хавсралтад АДБ-ын чанарын баталгаажуулалтын хүрээний жишээг орууллаа.

Зураг 4: Гүйцэтгэлийн аудитын чанарын хяналтын үндсэн элементүүд



Эх сурвалж: АДБОУС-140.

Чанарын хяналтын тогтолцоо үр нөлөөтэй байхын тулд АДБ-ын стратеги, соёл, бодлого, горимуудын нэг хэсэг болох хэрэгтэй. Ингэснээр чанар нь тайлан гарсны дараа хийдэг нэмэлт үйл явц гэхээс илүүтэй АДБ-ын ажил болон АДБ-аас гаргадаг тайлангийн нэг хэсэг болно (АДБОУС-140). Чанарын хяналтын горимд аудитын үйл явцын чиглүүлэх, хянан удирдах, мөн бэрх эсвэл маргаантай асуудлууд дээр шийдвэрт хүрэхийн тулд зөвлөлдөх хэрэгцээ шаардлагыг тусгах хэрэгтэй. (АДБОУС-100/38)

АДБ дан ганц бодлого, горимуудыг бий болгох нь хангалттай биш. Чанарын хяналтын тогтолцооны ажиллагааг аудитын ажил болон тайлангийн тогтмол үнэлгээгээр хянан-шинжлэх шаардлагатай. Тогтолцоо нь зөв зохиомжлогдсон бөгөөд үр нөлөөтэй ажиллаж буй эсэхийг, мөн бодлого, горимууд мөрдөгдөж буй эсэхийг тогтоох нь чухал. Энэхүү хяналт-шинжилгээний ажлыг дотоод болон гадаад нягталгаагаар хоёулангаар нь хийж болно. Мөчлөгт түншийн үнэлгээ болон бусад төрлийн үнэлгээ мониторинг зэрэг хяналт-шинжилгээ хийдэг ба энэ нь ДБ-д хийгдэж буй ажлууд болон түүний дүнд гарсан тайлангууд стандартад нийцсэн, өндөр чанартай гүйцэтгэж байгаа гэдэгт баталгаа өгөхөд тусалдаг.

Танай АДБ-д танаас шаардагдах үйл хөдлөл болон зан үйлүүдийг чанарын хяналтын хүрээний элемент тус бүрийн дагуу журамласан бодлого, горимууд хэрэгтэй. АДБ нь үүнийгээ бүх аудиторт сайтар мэдээлж, ойлгуулсан байх ёстой.

Хараат бус байдал ба ёс зүй гэж юу вэ?

Хараат бус байдал болон ёс зүйн шаардлагуудыг дагаж мөрдөх нь гүйцэтгэлийн аудит хийхийн урьдач нөхцөл болдог бөгөөд үүнийг АДБОУБ-ын Мэргэжлийн Мэдэгдлийн Хүрээнд (АДБОУБММХ) онцлон чухалчилсан байдаг. Дараах хэсгүүд нь хараат бус байдал болон ёс зүйтэй холбогдох чухал ухагдахуунуудыг танилцуулах болно.

Хараат бус байдал



АДБОУБ-ын АДБОУС-130:

Ёс зүйн дүрэмд хараат бус байдал болон ёс зүйг дэлгэрэнгүй тайлбарлана. Уг дүрэм нь АДБ-ууд болон тэдгээрийн ажилтнуудыг зан үйлийнхээ үндэс болгох үнэт зүйлс болон зарчмуудын цогцоор хангадаг. Түүнчлэн, улсын секторын аудитын орчны онцлогийг (хувийн секторын аудитынхаас ихэвчлэн өөр байдаг) харгалзан үзсэн эл дүрэм нь уг үнэт зүйлсийг АДБ-ын үйл явцууд болон аудитын ажилд хэрхэн шигтгэх талаар нэмэлт чиглүүлэг өгдөг.

Эх сурвалж: АДБОУБХС/ГАДХ-ны ХБ.

Хараат бус байдал гэдэг нь аудиторын мэргэжлийн үнэлэмжийг алдагдуулах, эсвэл алдагдуулж болзошгүй гэж харагдаж байгаа орчин нөхцөл буюу нөлөөллөөс ангид байж, голч бөгөөд нэг талыг бариагүй байдлаар үйлдэл хийхийг хэлнэ.

Танай АДБ болон та, аудиторын хувиар хараат бус байдалд сөргөөр нөлөөлж, аудитын үр нөлөөтэй байдлыг алдагдуулах ямар боломжит аюулууд оршин байдгийг ойлгох нь чухал. Гүйцэтгэлийн аудитын явцад хараат бус байдалд учрах 6 гол аюул байдгийг 5-р зурагт үзүүлэв.

Зураг 5: Гүйцэтгэлийн аудитын явцад хараат бус байдалд учрах 6 гол аюул

Хувийн ашиг сонирхол	Санхүүгийн эсвэл бусад хувийн ашиг сонирхол нь аудиторын үнэлэмж эсвэл зан үйлд зохисгүй байдлаар нөлөөлөх аюул.
Алагчлал эсвэл өмгөөлөл	Улс төр, үзэл баримтлал, нийгэм эсвэл бусад төрлийн итгэл үнэмшлийн дүнд аудитор нь бодитой бус байр суурь баримтлах аюул.
Ойр дотно байдал	Аудитад шалгуулагч агентлаг дахь гэр бүл, найз нөхөд зэрэг хүмүүстэй үүсгэсэн хувийн харилцаа нь аудиторыг бодитой биш байр суурь баримтлахад хүргэх аюул.
Сүрдүүлэг буюу зүй бус нөлөөлөл	Гаднын нөлөөлөл буюу дарамт нь аудиторын хараат бус бөгөөд бодитой дүгнэлт гаргах чадварт нөлөөлөх аюул.
Хувийн үзэмж	Аудитад шалгуулагч агентлагт үйлчилгээ үзүүлж байсан аудитор эсвэл аудитын байгууллагын уг туршлага нь аудитын дүгнэлтэд нөлөөлөх аюул.
Удирдлагын оролцоо	Аудитор нь хөндлөнгийн аудитор байхын оронд аудитад шалгуулагч агентлагийн дотоод удирдлагын бүтцийн нэг хэсэг болж, дүрэм зөрчсөний улмаас үүсэх аюул.

Эх сурвалж: УДИР-3910/14.

АДБ болон аудитын багууд нь доорх шигтгээнд жагсаасан мэдээллийг ашиглах зэргээр хараат бус байдалд учрах аюулыг арилгах эсвэл зөвшөөрөгдөх түвшинд хүртэл бууруулах хяналтын механизмыг хэрэгжүүлэх хэрэгтэй.

АДБ нь мөн ажилтнуудаа бодитой дүгнэлт гаргадаг байлгахын тулд аудитад шалгуулж буй этгээдтэй хэт ойрын харилцаа үүсгэхээс сэргийлэх хэрэгтэй. АДБ-ууд нь дараах зүйлсийг хийхдээ хууль тогтоох засаглалаас тогтоосон холбогдох хуулиудыг мөрдөхийн зэрэгцээ хууль тогтоох засаглал болон засгийн газрынхаа чиглүүлэг буюу хөндлөнгийн оролцооноос ангид байх хэрэгтэй:

- Аудитын сэдэв сонгох. Зарим АДБ бүрэн эрхэд нь хамаарах тодорхой сэдвүүдээр аудит хийх үүрэгтэй байдаг. Гэсэн хэдий ч, АДБ болон аудитор нь аудит хийхдээ хараат бус байдлаа хадгалах нь чухал;
- Аудитаа төлөвлөх, хөтөлбөр гаргах, гүйцэтгэх, тайлагнах болон мөрөөр хяналт тавих;
- Оффисоо зохион байгуулж, удирдах; мөн
- Бүрэн эрхэд нь санкц тавих эрх багтсан тохиолдолд, шийдвэрээ хэрэгжүүлэх.

Аудиторын хувьд, та хараат бус байх нь чухал. Ингэснээр таны тайлан голч чанартай болох бөгөөд зорилтот хэрэглэгчдэд мөн голч чанартай харагдана. Гүйцэтгэлийн аудитын үед хараат бус байдлаа хадгалах чадвартай байх нь чухал. Учир нь олон шийдвэр таны мэргэжлийн үнэлэмж болон аудитын нотлох зүйлсэд үндэслэдэг.

Хараат бус байдал дутагдалтай үед гаргасан дараах шийдвэрүүд (үүнийг дараа дараагийн бүлгүүдэд авч үзнэ) нь гүйцэтгэлийн аудитад сөргөөр нөлөөлж болно:

- Аудитын сэдвийг тодорхойлж, шийдэх;
- Аудитын зорилго(ууд) болон асуултуудыг тодорхойлох;
- Холбогдох шалгууруудыг тодорхойлох;
- Аудитын арга зүйн арга хандлагыг тодорхойлох;
- Аудитын нотлох зүйлсийг үнэлж, дүгнэлт боловсруулах;
- Аудитын шалгуур болон илрүүлэлтүүдийг хараат бусаар үнэлж, аудитын фокус болсон этгээдүүдтэй хэлэлцсэний дараа эцэслэн шийдэх;
- Янз бүрийн оролцогч талуудын байр суурийг үнэлэх; мөн
- Шударга бөгөөд тэнцвэртэй тайлан бичих.

Хараат бус байдалд учрах аюулаас хамгаалж чадах хяналтын механизмын ямар жишээ байж болох вэ?

- ✓ Аудиторын хараат бус байдлыг алдагдуулахгүйгээр өөр нэг хүнээр хийсэн ажлыг нягтлуулах эсвэл зөвлөгөө өгүүлэх.
- ✓ Хараат бус захирлуудын хороо, мэргэжлийн зохицуулах байгууллага, мэргэжлийн ажилтнууд зэрэг гуравдагч талтай зөвлөлдөх.
- ✓ Ойр дотно байдал үүсэх аюулаас сэргийлж давтан хийж буй гүйцэтгэлийн аудитад ажиллах ажилтнуудыг сэлгэн ажиллуулах.
- ✓ Аливаа аудитын ажлыг эхлүүлэхийн өмнө түүн дээр ажиллах бүх хувь хүмүүсийн хараат бус байдлыг бататгаж, аудитын туршид тэдний хараат бус байдлыг харгалзан үзэх.
- ✓ Санхүүгийн ашиг сонирхол, харилцаа холбоо эсвэл үйл ажиллагаа нь хараат бус байдалд аюул учруулах аливаа хүнийг аудитын багаас хасах.

Эх сурвалж: УДИР-3910/19.

Ёс зүй

Ёс зүй гэдэг нь шударга байдал (integrity), мэргэжлийн чадамж, үр дүй, мэргэжлийн зан үйл болон нууцлал хадгалах чадвар зэргийг багтаасан хувь хүний ёс суртахууны зарчмуудыг хэлэх бөгөөд дэлгэрэнгүй тодорхойлбол:

- *Шударга байдал:* Шударга, найдвартай, сайн санаатайгаар нийтийн ашиг сонирхлын төлөө үйлдэл хийх.
- *Мэргэжлийн чадамж:* Үүрэгтээ тохирсон мэдлэг, үр чадваруудыг суралцан эзэмшиж, холбогдох стандартын дагуу үр дүйтэйгээр үйлдэл хийх.
- *Мэргэжлийн зан үйл:* Холбогдох хууль, журам болон тогтсон ёсыг дагаж, АДБ-ын итгэл хүлээх байдлыг алдагдуулж мэдэх аливаа үйлдлээс зайлсхийх.
- *Нууцлал хадгалах чадвар ба ил тод байдал:* Мэдээллийг зохих ёсоор хамгаалж, үүнийгээ ил тод байдал болон эгэх хариуцлагын хэрэгцээ шаардлагатай тэнцвэртэй байлгах.

Эдгээр зарчим тус бүрийг доор бүр дэлгэрүүлэн тайлбарлана. АДБОУБ-ын АДБОУС-130: Ёс зүйн дүрэмд АДБ болон аудитор хоёрт хоёуланд нь зориулсан эдгээр зарчим тус бүрийг дагаж мөрдөх дэлгэрэнгүй зааварчилгаа бий.

АДБ-ууд нь ёс зүйн шаардлагуудыг хангуулж, аудитор тус бүрд мөрдүүлэх хэрэгцээ шаардлагыг чухалчилсан бодлого, горимуудтай байх хэрэгтэй. АДБ-ын ёс зүйн шаардлагуудад АДБ-д үйлчлэх хууль болон зохицуулалтын хүрээний шаардлагууд багтах ёстой. АДБ-ууд нь дараах зүйлсийг бодолцож үзэх шаардлагатай: АДБ-ын ёс зүйн шаардлагуудтай нийцэж буйг бататгасан мэдэгдлийг ажилтнуудаасаа бичгээр авах; мөн ажилтнуудад зориулсан ёс зүйн зөрчлийг мэдээлэх горимыг бий болгох.

Шударга байдал (integrity)

АДБ нь дараах зүйлсийг хангасан бодлого, горимуудтай байх хэрэгтэй:

- Шударга байдлыг чухалчилж, харуулж, дэмжиж, сайжруулах;
- Ажилтнуудад зориулсан ёс зүйн зөрчлийг мэдээлэхийг дэмжсэн дотоод орчин; мөн
- Шударга байдлын зөрчилд шуурхай бөгөөд хангалттай байдлаар хариу арга хэмжээ авах.

Аудитор таны үйлдэл үнэнч шударга байх шаардлагатай. Мөн, таны шударга байдлыг бууруулах орчин нөхцөлөөс сэрэмжилж, зохих хэмжээнд зайлсхийх хэрэгтэй. Уг орчин нөхцөл нь дараахыг багтааж болно:

АДБ-ын ашиг сонирхлуудтай зөрчилдөх хувийн, санхүүгийн эсвэл бусад төрлийн ашиг сонирхлууд эсвэл харилцаанууд;

- Аудитад шалгуулагчаас бэлэг эсвэл талархлын зүйл санал болгох;



Аудитор нь бодитой болон таамаглагдаж буй ашиг сонирхлын зөрчлөөс ангид байж, оюуны хараат бус байдал болон харагдах байдал дээрх хараат бус байдлаа хадгалах нь чухал.

Иймд аудитор нь бодит болон харагдах байдал дээрх зөрчлөөс хоёулангаас нь зайлсхийж, аудиторын бодитой бөгөөд голч дүгнэлт гаргах чадварт гуравдагч талаас бодитой бөгөөд мэдлэгтэйгээр эргэлзэхэд хүргэх өөр бусад нөхцөл байдлаас ангид байх хэрэгтэй.

Эх сурвалж: АДБОУБХС/ГАДХ-ны ХБ.

- Хувийн ашиг хонжооны төлөө эрх мэдлээ урвуулан ашиглах боломж;
- Улс төрийн үйл ажиллагаанд оролцох эсвэл шахалтын бүлгүүд болон лобби бүлгүүдэд оролцох, г.м.;
- Эмзэг болон нууцлалтай мэдээлэлд нэвтрэх боломж; мөн
- АДБ-ын нөөцийг хувийн эсвэл бусад зорилгоор ашиглах боломж.

Мэргэжлийн чадамж

Гүйцэтгэлийн аудит болон түүнтэй холбогдох ажлуудыг зохих мэдлэг, ур чадвартай, ажлаа амжилттай хийх чадвартай ажилтнуудаар хийлгэдэг байх бодлого, горимуудыг АДБ-ууд бий болгох хэрэгтэй. Ийм бодлого горимуудад дараах зүйлс багтаж болно:

- Чадамжид суурилсан ажилд авах горим болон хүний нөөцийн практикийг бий болгох;
- Даалгавар тус бүрд шаардагдах мэргэшлийг эзэмшсэн хүмүүсээс бүрдсэн ажлын багийг томилох;
- Ажилтнуудаа зохих сургалт, дэмжлэг, хянан удирдлагаар хангах;
- Мэдлэг, мэдээлэл хуваалцах үйл явцыг сайжруулах хэрэгслээр ажилтнуудаа хангаж, уг хэрэгслүүдийг ашиглахад уриалах; мөн
- Улсын секторын орчны өөрчлөлтөөс үүсэх сорилтуудыг даван туулах.

Мэргэжлийн чадамжтай байх шаардлагуудыг үнэлж, түүнийг дагахдаа аудитор та дараах зүйлсийг хийж болно:

- Үүрэг болон гүйцэтгэх даалгавраа ойлгох;
- Дагаж мөрдөх ёстой холбогдох техникийн, мэргэжлийн болон ёс зүйн стандартуудыг мэдэх;
- Ажил эсвэл даалгаврын шаардлагаас хамаарах янз бүрийн хам нөхцөл болон нөхцөл байдалд чадамжтай ажиллах; мөн
- Шинэ мэдлэг, ур чадвар болон чадвар эзэмшиж, түүнийгээ шаардлагатай тохиолдолд шинэчилж, сайжруулж байх.



Гүйцэтгэлийн аудит хийхэд мэргэжлийн чадамж болон

зан үйлийг өөртөө хөгжүүлсэн аудиторчууд чухал. Тухайлбал, аудиторчууд нь **дараах зүйлсийг хийж ёстой:**

- Бодитой, төвийг сахисан, нам бус бөгөөд баримтад суурилдаг байх;
- Арга зүйн хувьд зөв арга хандлагыг ашиглаж аудитын зорилгуудыг биелүүлдэг; мөн
- Мэргэжлийн зан үйл болон хэмжээтэй холбогдох АДБ-ын бодлого, горимуудыг үр нөлөөтэй хэрэгжүүлэх чадвартай.

Аудиторууд нь дараах зүйлсийг хийж болохгүй:

- Аудитын ажлын хүрээнд талбарын ажил хийх газруудаа сонгохдоо хувийн шалтгаанд үндэслэн сонгох;
- Үргэлжилж буй гүйцэтгэлийн аудиттай холбогдох асуудлуудаар хувийн үзэл бодлоо социал медиагаар нийтлэх;
- Хувийн хэрэгцээнд ашиглах мэдээллийг олж авахын тулд албан тушаалаа урвуулан ашиглах; мөн
- Аудитор эсвэл АДБ-ын хувьд ашиг сонирхлын зөрчил үүсгэж болох гаднын үйл ажиллагаанд оролцох.

Эх сурвалж: АДБОУБХС/ГАДХ-ны ХБ.

Мэргэжлийн зан үйл

АДБ хууль, журам болон үйл ажиллагаа явуулж буй нийгмийнхээ тогтсон ёсоор тодорхойлогддог, дотоод болон гадаад оролцогч талуудын хүлээлтэд нийцсэн мэргэжлийн зан үйлийн стандартын талаар мэдлэг ойлголттой байж, ажил хэргээ түүний дагуу, өөрийн бүрэн эрхийн хүрээнд явуулдаг байх хэрэгтэй. Мэргэжлийн зан үйлийн хамгийн өндөр стандартыг дэмжиж, уг стандартад нийцсэн үйл ажиллагаануудыг тодорхойлохын тулд АДБ-ууд нь байвал зохих зан үйлийн талаар чиглүүлэг гаргаж, түүний зөрчлийг хянан-шинжилж, илрүүлж, шийдвэрлэх хяналтыг хэрэгжүүлэх ёстой.

Аудитор та зан үйлээ ажлын орчинд ч, ажлын бус орчинд ч мэргэжлийн хэм хэмжээнд нийцүүлэх алхмуудыг авч хэрэгжүүлэх нь чухал. Тухайлбал:

- Мэргэжлийн зан үйлтэй холбогдох АДБ-ын бодлого, горимуудыг мэдэх, тухайлбал, холбогдох мэргэжлийн стандартууд, хууль, журам, АДБ-ын үйл ажиллагаа явуулж буй нийгмийн тогтсон ёс;
- Таны үйлдэл АДБ-ын итгэл хүлээх байдалд нөлөөлөх нөлөөллийг ойлгож, таны зан үйл, ажлын болон ажлын бус орчинд хамтран ажиллагсад, гэр бүл болон найз нөхөд, аудитад шалгуулагчид, хэвлэл мэдээллийнхэн болон бусад хүмүүст хэрхэн харагдахыг бодолцож үзэх. Тухайлбал, таны АДБ-ын үйл ажиллагаанаас гадуур хийдэг ажил эсвэл сайн дурын ажил нь ашиг сонирхлын зөрчил гэж харагдаж, эсвэл таны голч байдалд нөлөөлж болно. Зарим АДБ ажлаас гадуурх үйл ажиллагааг тайлагнах механизмтай байдаг. 2-р хавсралтаас ажлаас гадуурх үйл ажиллагааны оролцоогоо баримтжуулах АДБ-ын маягтын жишээг үзнэ үү.
- Ёс зүйн үнэт зүйлсийн дагуу үйлдэл хийх; хэрэгжиж буй хууль, зохицуулалтын хүрээг дагаж мөрдөх; албан тушаалаа урвуулан ашиглахгүй байх; ажлаа хийхдээ хичээнгүй бөгөөд үр дүйтэй байх; мөн бусадтай харилцахдаа зүй зохистой байх зэрэг нь байвал зохих нийтлэг зан үйл гэдгийг мэдэж ойлгох; мөн
- Таны үйлдэл эсвэл үзэл бодол, тухайлбал сошиал медиа ашиглаж байх үед, АДБ болон түүний ажилд сөргөөр нөлөөлөх эсвэл итгэл хүлээх байдлыг нь алдагдуулахаас сэргийлж зохих хэмжээнд хянуур, болгоомжтой байх.

Нууцлал хадгалах чадвар ба ил тод байдал

АДБ-ууд нь гүйцэтгэлийн аудитын явцад олж авсан аудиттай холбоотой болон бусад мэдээллийн **нууцлалыг ил тод байдал** болон эгэх хариуцлагатай байх хэрэгцээ шаардлагатай тэнцвэртэй байлгах бодлого, горимуудтай байх хэрэгтэй. АДБ нь мөн шаардлагатай үед, ялангуяа эмзэг мэдээллийн хувьд нууцлалыг хадгалах хангалттай тогтолцоотой байх ёстой. Түүнчлэн, АДБ-ууд нь АДБ-д ажил гүйцэтгэж өгөх гэрээ байгуулсан аливаа талуудтай нууцлал хадгалах гэрээ байгуулах хэрэгтэй.

Аудиторын хувьд нууцлал болон ил тод байдалтай холбогдох аливаа хуулиар хүлээсэн үүрэг болон АДБ-ынхаа бодлого, горимуудыг мэддэг байх нь чухал. Та мөн аудитын явцад цуглуулсан мэдээллээ хамгаалж, зохих тодорхой эрх мэдэлгүй болон хуулийн эсвэл мэргэжлийн эрх эсвэл үүрэггүй гуравдагч талд задруулахгүй байх хариуцлагыг хүлээнэ.

Нууцлал болон ил тод байдлыг хангахын тулд ашиглаж болох хяналт болон хамгаалалтуудын жишээг доор өгүүлэв:

- Аудитын явцад цуглуулсан мэдээллийн нууцлалыг хүндэтгэхийн тулд мэргэжлийн үнэлэмжийг ашиглах. Ялангуяа, ажилтай холбоотой асуудлуудыг АДБ-ын бусад ажилтнуудтай хэлэлцэх үедээ мэдээллийн нууцлалыг санаж байх хэрэгтэй.
- Зохих эрх бүхий байгууллага эсвэл талуудад хууль, журмын зөрчил байж болзошгүй тохиолдлыг мэдээлэх эсэх талаар эргэлзэж байгаа үедээ хийвэл зохих үйлдлийн талаар АДБ-аасаа хуулийн зөвлөгөө авах талаар бодолцож үзэх хэрэгтэй.
- Аудиттайгаа холбоотой мэдээллийг сошиал медиа зэрэг ажлын орчноос гадуурх орчинд хэлэлцэхгүй байх.
- Зөөврийн компьютер, зөөврийн өгөгдөл хадгалах хэрэгсэл зэрэг цахим өгөгдлийн хэрэгслүүдийг хамгаалж, аудиттай холбогдох баримт бичиг болон бичиг цаас зэрэг аудитын бүх мэдээллийг зохих ёсоор хамгаалах. Ингэхийн тулд мэдээллийг ажлын шүүгээ эсвэл албан тасалгаа зэрэг цоожтой газар хадгалж болно. Мөн, албан тасалгааны орчинд нэвтрэх эрхийг хянаж, цахим болон цаасан хэлбэрээрх баримт бичиг, бичиг цаас буюу аудиттай холбогдох бүх мэдээллийг хамгаалж болно. Цахим мэдээллийн хувьд өгөгдлийг буцаан хуулах эсвэл серверээр дамжуулан алдахаас сэргийлэх шаардлагатай алхмуудыг мөн зохих үед авч хэрэгжүүлэх шаардлагатай.



АДБ-ууд нь ил тод байдлыг хангахын тулд дараах алхмуудыг авч хэрэгжүүлж болно:

- Аудитад шалгуулагч этгээдэд бодитой бөгөөд ил тод байх аудитын стандарт, үйл явц болон аргуудыг ашиглах.
- Ажлынхаа үр дүн болон ажилдаа ашигласан арга зүйг нийтэд ил болгох.
- Үйл ажиллагаа болон аудитын үр дүнгээ цаг хугацаанд нь өргөн хүрээнд сошиал медиа, вебсайт болон бусад хэрэгслээр мэдээлэх.

Эх сурвалж: АДБОУБХС/ГАДХ-ны ХБ

Хараат бус байдал болон ёс зүйн асуудлуудыг бууруулах буюу шийдвэрлэх

АДБ болон аудиторууд нь хараат бус байдал болон ёс зүйн асуудлуудыг бууруулах болон шийдвэрлэх хариуцлагыг хүлээдэг. АДБ-ууд нь ёс зүйн зөрчлийг илрүүлж, шинжилж, бууруулж, ёс зүйтэй зан үйлийг дэмжиж, ёс зүйн үнэт зүйлсийн аливаа зөрчлийг шийдвэрлэж, сэжигтэй буруу үйлдлийг мэдээлсэн хүмүүсийг хамгаалах ёс зүйн хяналтын тогтолцоотой байх хэрэгтэй. Ёс зүйн хяналтын тогтолцооны үндсэн бүрэлдэхүүн хэсгүүд нь ёс зүйн дүрэм, манлайлал болон “дээд удирдлагуудын харилцаа хандлага”, ёс зүйн удирдамж болон ёс зүйн удирдлага, хяналт-шинжилгээ байж болно (АДБ-ын үүрэг хариуцлагын талаар дэлгэрэнгүй мэдээллийг АДБОУС-130-аас үзнэ үү).

Аудитор та хараат бус байдал болон ёс зүйн асуудлуудыг бууруулах болон шийдвэрлэх бодитой арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх шаардлагатай. Тухайлбал:

- Хараат бус байдал болон ёс зүйн шаардлагууд доголдож болох нөхцөл байдлуудыг тодорхойлж, түүнээс гарч болзошгүй нөлөөллийг ойлгох;
- Хараат бус байдалд учрах аюулыг илрүүлж, бууруулахын тулд ашиг сонирхлын зөрчилгүй гэсэн мэдэгдэлд гарын үсэг зурж, өөрийн болон АДБ-ынхаа шударга байдлыг хангах. 3-р хавсралтаас хараат бус байдлын мэдэгдлийн жишээг үзнэ үү;
- Аюул учруулж болзошгүй харилцаа болон нөхцөл байдлын талаар удирдлагадаа

мэдээлэх;

- Зан үйлийн хэм хэмжээ болон хүлээлт, мэргэжлийн чадамж, мөн аудиттай холбогдох мэдээлэл, түүний нүүцлалыг хамгаалах талаар бүрэн ойлголттой болохын тулд мэдлэг, үр чадвараа хөгжүүлэх; мөн
- Мэргэжлийн чадамж болон шударга байдлыг хангахын тулд тодорхой даалгаврыг гүйцэтгэхэд таны мэргэшил хангалтгүй байгаа үед шууд удирдлагадаа мэдэгддэг байх.

Сэдвүүд болон байгууллагуудын талаарх өөрийн алаг үзэл болон үзэл бодлыг ойлгодог байх хэрэгтэй. Хараат бус байдал болон ёс зүйн шаардлагуудыг мөрдөж буйгаа ухамсарлаж, зан үйлээ хөгжүүлэх хэрэгтэй. Аудитын төлөвлөлт болон гүйцэтгэлийн туршид олон удаа хараат бус байдал болон ёс зүйд учрах аюулын талаар бодолцож үзэх нь чухал. Ёс зүй болон хараат бус байдалд аюул учирч магадгүй гэж санагдаж байвал зөн инстинктдээ итгэж, АДБ-ынхаа бодлогыг нягталж, уг асуудлыг дээд удирдлагадаа зохих ёсоор мэдээлэх хэрэгтэй. Түүнчлэн, танай АДБ-ын нэр хүнд бүх аудитор нь хараат бус байдал болон ёс зүйн шаардлагуудыг мөрдөхөөс хамаарах тул бусад аудитор болон хамтран ажиллагсдынхаа зан үйлийг мөн анзаарч байх хэрэгтэй. Олон АДБ-д ажиглагдсан зохисгүй үйлдлийг мэдээлэх горим бий. Танд эргэлзээ байвал шууд удирдлагатайгаа холбогдоорой.

Мэргэжлийн үнэлэмж ба үл итгэх үзэл гэж юу вэ?



Стандарт

Аудитор нь мэргэжлийн үнэлэмж ба үл итгэх үзлээр хандаж, асуудлыг өөр өөр төлөв байдлаас авч үзэн, олон янзын үзэл бодол, баримт нотлох зүйлд нээлттэй, бодитой хандах ёстой.

Эх сурвалж: АДБОУС-3000/68.

Мэргэжлийн үнэлэмж болон үл итгэх үзлийг хэрэгжүүлэх нь гүйцэтгэлийн аудитыг үр нөлөөтэй байлгахад амин чухал үүрэгтэй.

Мэргэжлийн үнэлэмж гэдэг нь аливаа асуудлаар дүгнэлт эсвэл шийдвэр гаргахдаа мэдлэг, үр чадвар болон туршлагаа стандарт, хууль болон ёс зүйн зарчмуудтай нийцсэн байдлаар ашиглахыг хэлнэ. Мэргэжлийн үл итгэх үзэл гэдэг нь аудитад шалгуулагч этгээд(үүд)ээс мэргэжлийн зай барьж аудитыг гүйцэтгэсэн байх ба аудитаар олж авсан аудитын нотлох зүйлсийг үнэлж байх үедээ хангалттай бөгөөд зохистой байдлыг анхаардаг бөгөөд асуудаг байх хандлагад дадсан байхыг хэлнэ. АДБ нь аудиторыг мэргэжлийн үнэлэмж болон мэргэжлийн үл итгэх үзлийг тогтмол хэрэгжүүлдэг байхад чиглүүлдэг бодлого, горимуудтай байх шаардлагатай. Тухайлбал, аливаа нөхцөл байдал дахь хараат бус байдлыг тодорхойлохын тулд ухагдахууны хүрээг ашиглахад мэргэжлийн үнэлэмж нь аудиторт чухал хэрэгтэй байдаг. Иймд, АДБ-ын бодлого, горимууд нь хараат бус байдалд учрах аюулыг, мөн харагдах байдал дээрх хараат бус байдалд учрах аюулыг илрүүлж, үнэлэх удирдамж болон илрүүлсэн аюулуудыг бууруулах холбогдох хамгаалалтыг агуулсан байх шаардлагатай.

АДБ нь мөн аудиторүүддаа мэргэжлийн үнэлэмж болон үл итгэх үзлийн чухлыг ойлгуулж, гүйцэтгэлийн аудитад зохих ёсоор ашигладаг болгох хэрэгтэй. Энэ зорилгыг биелүүлэхийн тулд АДБ нь аудиторүүддаа дараах зэргийн сэдвүүдэд төвлөрсөн мөчлөгт сургалтуудад суухыг шаардаж болно:

- Нотлох зүйлсийн төрлүүд (баримт бичгийн, мэдүүлгийн, биет болон шинжилгээний), тэдгээрийн давуу болон сул талууд;
- Нотлох зүйлсийг үнэлэхэд ашиглах стандартууд (тохиромжтой байдал болон хангалттай байдал); мөн
- Аудиторүүдын хүрсэн дүгнэлтийг үндэслэлтэй бөгөөд логиктой байлгахын тулд нотлох чадвартай нотлох зүйлстэй байхын ач тус.

Аудитор та мэргэжлийн үнэлэмж болон үл итгэх үзлийг хэрэгжүүлж, асуудлуудыг олон янзын өнцгөөс авч үзэж, янз бүрийн үзэл бодол болон аргументад нээлттэй бөгөөд бодитой хандах хэрэгтэй. Аудитын явцад цуглуулсан бусад нотлох зүйлстэй үялдүүлэн үнэлж, хэлэлцэх шаардлагатай эсрэгцсэн мэдээлэлтэй тулгарсан үед энэхүү нээлттэй сэтгэлгээ асар хэрэгтэй байдаг. Мэргэжлийн үнэлэмж болон үл итгэх үзлийг хэрэгжүүлэх нь таныг янз бүрийн үзэл бодол, аргументыг хүлээн авах чадвартай байж, ялгаатай харах өнцгүүдийг бодолцон үзэх боломжтой болгодог.

Гүйцэтгэлийн аудиттай холбогдох нотлох зүйлс нь ихэвчлэн дүгнэх чанартай бус, харин ятгах чанартай бөгөөд тогтмол дахин үнэлэхийг шаардаж байдаг тул гүйцэтгэлийн аудит хийхэд маш сайн үнэлэмж, хөрвүүлэн ойлгох чадвар болон үл итгэх үзэл шаардагддаг. Мэргэжлийн үнэлэмж болон үл итгэх үзэл нь аудитын явцад олж авсан нотлох зүйлсийг үр нөлөөтэй бөгөөд нарийн үнэлэх гол түлхүүр юм. Аудитор та аудитын ажилд “бичиг цаастай зууралдах” сэтгэлгээгээр хандахын оронд, олж авсан мэдээлэл болон нотлох зүйлсийг сорьж шалгаж ажиллах ёстой. Нэг алхам хойш зогсож, илүү том зургаар нь харж (хам нөхцөлөөр нь авч үзэж), “Энэ ер нь зөв байна уу?” гэж асуудаг байх хэрэгтэй. Гүйцэтгэлийн аудитын үед мэргэжлийн үнэлэмжийг ашиглаж болох зарим жишээнээс дурдвал:

- Судлах сэдэв/ зүйлийг ойлгох шаардлагатай түвшнийг тодорхойлох;
- Аудитын горим болон арга зүйн мөн чанар, хугацаа болон цар хүрээг тодорхойлох;
- Аль илрүүлэлтүүд нь тайлагнах хэмжээний ач холбогдолтой вэ гэдгийг тодорхойлох;
- Хангалттай бөгөөд зохистой аудитын нотлох зүйлс олж авсан эсэхийг үнэлэх; мөн
- Илрүүлсэн асуудлуудын уг шалтгааныг арилгахад зориулан боловсруулах зөвлөмжийг тодорхойлох.



Аудиторүүд нь гүйцэтгэлийн аудитын туршид, тухайлбал дараах тохиолдолд, мэргэжлийн үнэлэмж болон үл итгэх үзлийг ашиглах шаардлагатай.

- Бодитой бөгөөд төвийн сахисан аудитын асуултуудыг боловсруулах;
- Тохиромжтой хамрах хүрээ болон арга зүйг сонгох;
- Албан тушаалтнуудтай ярилцлага хийх;
- Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлсийг үнэлэх; мөн
- Бичмэл тайланд зориулсан, тэнцвэртэй мессеж боловсруулах.

Эх сурвалж: АДБОУБХС/ГАДХ-ны ХБ.

Мэргэжлийн үл итгэх үзлийг хэрхэн хэрэгжүүлж болох вэ?

- ✓ Асуултад өгсөн хариулт болон шалгуулагч этгээдээс авсан бусад мэдээллийг нягтлах.
- ✓ Нэг эх сурвалжаас авсан мэдүүлэг буюу нотлох зүйлсийг хоёрдогч эх сурвалжийн нотлох зүйлстэй тулгаж нотлох.
- ✓ Материалаг буюу ач холбогдолтой үл нийцэх мэдээлэл илрүүлсэн тохиолдолд эрсдэлийн үнэлгээгээ шинэчлэх (үүнийг хожим авч үзнэ).
- ✓ Аудитын явцад ашиглах өгөгдлийн найдвартай байдлыг үнэлэх.
- ✓ Олж авсан баримт бичгүүдийн эх сурвалжийн найдвартай байдлыг үнэлэх.
- ✓ Олж авсан бусад аудитын нотлох зүйлстэй эсрэгцэж буй аудитын нотлох зүйлсэд анхааралтай хандах.

Эх сурвалж: УДИР-3910/88-89.

Аудиторын та мэргэжлийн үл итгэх үзлийг хэрэгжүүлж (нотлох зүйлсийн үнэн зөв байдлыг шалгах асуулт асуух), юмс ойлгомжгүй үед давтан судалж, аудитад шалгуулагч этгээдийн удирдлагын хэлж буй зүйлийг баримтаар нотлохгүйгээр хүлээн зөвшөөрөхгүй байснаар аудитын нотлох зүйлсээ илүү хөдөлбөргүй болгож чадна. Мэргэжлийн үл итгэх үзэл нь аудитын асуултуудад хариулж, өндөр түвшний баталгаатай дүгнэлт гаргахад асар чухал байдаг.

Аудитын багийн чадамж гэж юу вэ?



Стандарт

Аудитын баг нь хамтдаа аудит гүйцэтгэхэд шаардах мэргэжлийн чадамжтай байгааг АДБ нягтлах ёстой.

Аудитор нь мэргэжлийн зан төлөвийг дээд зэргээр сахих ёстой.

Эх сурвалж: АДБОУС-3000/63; АДБОУС-3000/75.



Үр нөлөөтэй аудитын баг нь дараах шаардлагыг хангасан гишүүдээс бүрддэг:

- Багаар ажиллах болон хамтран ажиллах үр чадвартай;
- Шүүмжит сэтгэлгээтэй;
- Тоон болон чанарын шинжилгээний үр чадвартай;
- Ярилцлага авах үр чадвартай; мөн
- Аман болон бичгийн харилцааны үр чадвартай.

Эх сурвалж: АДБОУБХС/ГАДХ-ны ХБ.

Үр нөлөөтэй гүйцэтгэлийн аудит хийхийн тулд, аудитын явцад шаардагдах даалгавруудыг гүйцэтгэхэд шаардлагатай бүх үр чадварыг эзэмшсэн багийг байгуулах нь чухал.

Аудитын чанар нь аудитын багийн үр чадвар, чадвар болон мэдлэгээс хамаардаг. Гүйцэтгэлийн аудит бол багийн хүчин зүтгэл. Гүйцэтгэлийн аудитын асуудлууд нь ихэвчлэн нарийн төвөгтэй байдаг бөгөөд бүх шаардлагатай үр чадварыг багийн гишүүн нэг бүр эзэмшсэн байх албагүй. Харин, аудитын баг нь олон янзын үр чадвар, чадвар болон мэдлэгтэй гишүүдээс бүрдсэн бөгөөд аудитын ажлыг гүйцэтгэх чадамжтай байвал хамгийн сайн.

АДБ-ууд нь аудит хийхээсээ өмнө аудитын багуудаа бүхэлд нь шаардлагатай мэргэжлийн мэдлэг, үр чадвар болон чадваруудтай байлгах хэрэгтэй. Тухайлбал, АДБ нь шаардлагатай салбаруудын мэдлэгт суралцаж, зохих шаардлага хангасан хүмүүсийг ажилд авч болно. Ажилд авсны дараа аудиторуудаа шаардлагатай

ур чадвар болон чадвартай болгохын тулд тусгай сургалтын хөтөлбөрт хамрагдахыг шаардаж эсвэл санал болгож болно. Сургалт нь хувь хүний хэрэгцээ, АДБ-ын сургалтын хөтөлбөр болон бусад санаачилгуудаас хамаараад танхимаар, ганцаарчилсан болон ажлын байрын дээрх сургалт байж болно. Түүнчлэн, тодорхой хэмжээний тасралтгүй суралцах үйл явцыг АДБ-ын зүгээс шаардаж болно.

АДБ-уудын хувьд аудиторүүд, хянагчид болон менежерүүдийн туршлагын түвшнийг мөн аудитад тохиромжтой хэмжээнд байлгах нь чухал. Тухайлбал, аудитын багт туршлагагүй аудиторүүд орсон байвал туршлагатай хянагчид болон менежерүүдийг ажиллуулж тэнцвэржүүлэх нь чухал. Шаардлагатай ур чадвар, чадвар, мэдлэг болон туршлага дутмаг багийн гүйцэтгэсэн аудит нь үр ашиг болон үр өгөөжтэй байдлын хувьд харьцангуй муу болж, аудитын сэдвийг зохих хэмжээнд судлаагүй тайлан гаргах магадлалтай.

АДБ-ын дотоодоос томилогдох эсвэл аудитын багт туслуулах гэж гаднаас гэрээ байгуулж ажиллуулах оролцогч талууд болох судлах зүйлийн экспертүүдийг гүйцэтгэлийн аудитад их ашигладаг бөгөөд тэд аудитын багийн ур чадварын цогцыг баяжуулж, аудитын чанарыг сайжруулдаг. Тухайлбал, АДБ-ын дотоодоос томилогдох оролцогч талууд нь аливаа аудитын багийн бүтэн цагийн гишүүн биш боловч ажлын чанарыг сайжруулах үүднээс аудитын түршид шаардлагатай орц болон мэргэшлээр хангаж ажилладаг хуулийн, арга зүйн эсвэл техникийн экспертүүд байна. Эдгээр оролцогч талуудтай хамтран ажиллаж эхлэхийн өмнө АДБ болон аудитор та уг экспертүүдийг аудитад шаардлагатай зохих чадамжтай бөгөөд аудитын үйл явцтай холбогдох нөхцөлүүд болон ёс зүйн асуудлуудын талаар мэдээлэлтэй болгох хэрэгтэй. Энэ нь АДБ-ын дотоодын биш экспертүүдэд ч мөн хамаатай. Гүйцэтгэлийн аудитын багт янз бүрийн төрлийн мэргэшил шаардлагатай болж болох талбаруудын жишээг доороос үзнэ үү.

Аудитын багийн бүрдүүлж, анхны оролцогч талуудыг тодорхойлсны дараа аудитын бүх



Аудитыг эхлүүлж, аудитын багийг бүрдүүлэх үедээ АДБ-ууд нь дараах зүйлсийг хийж болно:

- Аудитыг гүйцэтгэхэд шаардлагатай мэргэшлийн талбаруудыг АДБ-ындотоодод тодорхойлж, аудитын эдгээр мэргэшлийн талбаруудыг төлөөлөх хүмүүсийн үүрэг, хариуцлагыг тодорхой болгох; мөн
- Аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхийн тулд, аудитын багийн нийт гишүүдийг шаардлагатай үр чадвар, чадвар болон мэдлэгтэй байлгах ажилтныг аудитын багт нэмж оруулах.

оролцогч нь мэргэжлийн зан үйлийн өндөр стандартыг баримтлах хэрэгтэй. Хууль, журам, зохицуулалтын болон мэргэжлийн бүх шаардлагыг мөрдөж, ажлынхаа итгэл хүлээх байдлыг алдагдуулж болох бүх үйлдлээс зайлсхийвэл зохино. Мэргэжлийн стандартууд болон холбогдох хууль, журам, зохицуулалтын өөрчлөлтүүдийг сайн мэддэг байж, дагаж мөрдсөнөөр хувийн мэргэжлийн үр чадвар болон чадамжаа өндөр түвшинд хадгалах хэрэгтэй. Энэ бүх мэргэжлийн зан үйлийг аудитын үйл явцын туршид буюу сэдэв сонгож, аудитыг төлөвлөж эхлэхээс авхуулаад өгөгдөл цуглуулж, шинжилж, тайлагнаж, мөрөөр хяналт тавих хүртэл баримтлах нь чухал. Энэхүү хүчин чармайлт нь аудитыг чанартай гүйцэтгэхэд туслах болно.

Эх сурвалж: АДБОУБХС/ГАДХ-ны ХБ.

АДБОУС-ын стандартуудад аудиторүүд нь мэргэжлийн зан үйлийн өндөр стандартыг баримтлахаас гадна, аудитын үйл явцын туршид шинэ арга эсвэл санааг санал болгох эсвэл түршихэд бэлэн байх зэргээр шинийг санаачлахад бэлэн байх ёстой гэж заасан байдаг. Бүтээлч, уян хатан, нөөц боллоцоотой байснаараа аудитор та мэдээлэл цуглуулж, хөрвүүлж, шинжлэх аудитын шинэлэг арга хандлагыг хөгжүүлэх боломжуудыг илрүүлэхэд илүү ойр байх болно.

Гүйцэтгэлийн аудитын багийн гишүүд, төслийн менежерүүд болон гаднын экспертүүдэд ямар төрлийн мэргэшил хэрэгтэй байж болох вэ?

- ✓ Судалгаа загварчлах.
- ✓ Шинжлэх ухааны үнэлгээний аргууд.
- ✓ Хууль, эрх зүйн.
- ✓ Нийгмийн шинжлэх ухааны.
- ✓ Байгууллагын менежментийн.
- ✓ Аудитын сэдвээс хамааруулан мэдээллийн технологи, кибер-орчин эсвэл инженерчлэл зэрэг тусгай мэргэшлүүд.

Материаллаг байдал гэж юу вэ?



Стандарт

Аудитор нь аудитын үйл явцын бүхий л үе шатанд аль болох их үнэ цэн нэмэх зорилгоор судлах сэдэв (зүйл)-ийн санхүүгийн, нийгмийн болон улс төрийн талууд зэрэг материаллаг байдлыг бодолцож үзэх ёстой.

Эх сурвалж: АДБОУС-3000/83.

Материаллаг байдал гэдгийг аливаа асуудлыг авч үзэж буй хам нөхцөл дэх тухайн асуудлын харьцангуй ач холбогдол (эсвэл чухал байдал) гэж тодорхойлж болно (АДБОУС-3000/84). Материаллаг байдал нь хууль тогтоох болон гүйцэтгэх засаглал зэрэг тайланг хэрэглэгчдийн шийдвэрт нөлөөлж, аль болох их үнэ цэн нэмж болно. Материаллаг байдалд мөнгөн үнэ цэнээс гадна нийгмийн болон улс төрийн ач холбогдол, нийцэл,

ил тод байдал, засаглал болон эгэх хариуцлага зэргийг оруулна. Аудиторын хувьд, материаллаг байдал нь зорилтот хэрэглэгчид болон хариуцагч талуудын харах өнцгөөс хамаарч, өөрчлөгдөж болно гэдгийг санаж байх нь чухал.

Аливаа зүйл эсвэл бүлэг зүйлсийн үгийн шинж чанар нь өөрөө аливаа материйг материаллаг байдалтай болгож болно. Матери нь өөрөө мөн оршин буй хам нөхцөлөөсөө хамаараад материаллаг байдалтай байж болно. Материаллаг байдлыг харгалзан үзэх нь аудитын үйл ажиллагааны мөн чанар, цуг хугацаа болон цар хүрээнд, мөн аудитын үр дүнгийн үнэлгээнд нөлөөлнө. Харгалзан үзэхдээ оролцогч талуудын үзэл бодол, олон нийтийн ашиг сонирхол, хууль, журам, зохицуулалтын шаардлагууд болон нийгэмд учруулах үр дагавар зэргийг харгалзан үзэж болно. Аудитын сэдвийг сонгох алхам болон аудит өөрөө материаллаг байдал гэх ухагдахууныг харгалзан үзэхийг шаарддаг.

Материаллаг байдлыг тодорхойлох үед анхаарах ёстой бас нэг зүйл бол хүртээмжтэй байдал юм. Хүртээмжтэй байдал гэдэг нь биеийн болон оюуны хувьд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, цөөнхийн бүлгийн гишүүд зэрэг ихэвчлэн орхигддог буюу захлагддаг хүмүүсийг оролцуулах практик буюу бодлогыг хэлнэ. Энэ нь нийгмийн хүртээмжтэй байдал, тэгш болон тэгшитгэсэн боломжийг хангахад засгийн газруудад асар чухал ойлголт юм. Иймд, улсын секторын аудиторүүд нь аудит хийхдээ хүртээмжтэй байдлыг нэг хэмжээс гэж үзэх шаардлагатай. Энэ бүлгийн төгсгөлөөс хүртээмжтэй байдлын талаар дэлгэрэнгүй үзнэ үү.

Материаллаг байдлын зарчмыг АДБ-ын гүйцэтгэлийн аудитын бүх талыг зохицуулах бодлого, горимуудад оруулах ёстой. Тодруулбал, аудитын сэдвүүдийг сонгох, аудитын шалгууруудыг тогтоож, тодорхойлох, аудитын нотлох зүйлсийг үнэлж, баримтжуулах, түүнчлэн зохисгүй эсвэл нөлөөлөл багатай аудитын илрүүлэлтүүд буюу тайлан гарах эрсдэлийг удирдах үед материаллаг байдлыг харгалзаж үзэх шаардлагатай.

Эцсийн дүндээ, аудиторүүд материаллаг байдлыг харгалзаж үздэг байхын тулд мэргэжлийн үнэлэмжийг хэрэгжүүлэх шаардлагатай. Тодруулбал, та болон танай аудитын баг юу материаллаг, юу материаллаг биш байгааг ялгах хариуцлагыг хүлээнэ. АДБОУС-3000-д аудитын сэдвүүдийг сонгох үед материаллаг байдалтай холбогдох шийдвэр гаргахдаа харгалзаж үзэх ёстой ухагдахуунуудыг тодорхойлсон байдаг. Тухайлбал:

- Арвилан хэмнэлт, үр ашиг болон үр нөлөөтэй байдалд үзүүлэх нөлөө эсвэл эрсдэл;
- Нийгэм болон улс төрийн түвшин дэх санхүүгийн ач холбогдол;
- Хүлээгдэж буй нөлөөллийг хамгийн их болгох;
- Аудит хийх боломж; мөн
- АДБ-ын бүрэн эрхэд хамаарах байдал.

Аудитор та аудитын асуултууд болон шалгууруудыг зохиох, аудиттай холбогдох нотлох зүйлсийг цуглуулж, үнэлэх, мөн гүйцэтгэлийг сайжруулахад ихээхэн хувь нэмэр оруулах аудитын илрүүлэлтүүд болон зөвлөмжүүдийг боловсруулах зэргээр аудитын түршид материаллаг байдлыг санаж байх хэрэгтэй. Тухайлбал, аудитад шалгуулагч этгээдийн нийт үйл ажиллагаа нь танай аудитын хувьд материаллаг биш байх магадлал өндөр. Иймд та материаллаг сэдэв болон аудитын гол онилсон асуудалд хүчин зүтгэлээ төвлөрүүлэх

хэрэгтэй. Аливаа сэдвийн талаар баримт бичиг цуглуулахад та асар их цаг зарцуулж болох ч байгаа нөөцөө хамгийн сайн ашиглахын тулд аудитын ажил хийхдээ аливаа баримт бичиг эсвэл хэлэлцүүлгийн материаллаг чанарыг үргэлж харгалзан үзэж байх хэрэгтэй. Материаллаг байдал нь аудитын үйл явцын бүх үе шаттай холбогдох тул материаллаг байдлын зарчмын талаар дараагийн бүлгүүдэд илүү дэлгэрэнгүй өгүүлнэ.

Аудитын баримтжуулалт ба хянан удирдлага гэж юу вэ?

Энэ хэсэгт аудитын баримтжуулалт болон хянан удирдлагын ач холбогдлыг тайлбарлана. Эдгээр сэдвүүдийг доор танилцуулах боловч энэхүү гарын авлагын түршид гүйцэтгэлийн аудитын янз бүрийн үе шатуудыг тайлбарлахдаа дахин авч үзсээр байх болно.

Аудитын баримтжуулалт



Стандарт

Аудитор нь аудитыг хангалттай, иж бүрэн бөгөөд дэлгэрэнгүй байдлаар баримтжуулах ёстой.

Эх сурвалж: АДБОУС-3000/86.

Аудитын баримтжуулалт нь гүйцэтгэсэн аудитын горим, олж авсан аудитын холбогдох нотлох зүйлс болон аудиторчуудын хүрсэн дүгнэлтүүдийг бүртгэдэг (“аудитын тэмдэглэл” эсвэл “аудитын үл мөр” гэсэн нэр томъёонуудыг мөн заримдаа ашигладаг).

Гүйцэтгэлийн аудитын багийн гишүүд, төслийн менежерүүд болон гаднын экспертүүдэд ямар төрлийн мэргэшил хэрэгтэй байж болох вэ?

- ✓ Хийсэн ажлын мөн чанар, хугацаа болон цар хүрээ.
- ✓ Аудитын ажлын илрүүлэлтүүд болон олж авсан нотлох зүйлс.
- ✓ Аудитын явцад үүссэн ач холбогдол бүхий асуудлууд (тухайлбал, аудитын хамрах хүрээ эсвэл арга хандлагад гарсан өөрчлөлт, аудитын явцад илэрсэн шинэ эрсдэлийн хүчин зүйлстэй холбогдох шийдвэрүүд, аудитад шалгуулагч этгээд болон аудитын баг хоорондын санал зөрөлдөөнд авсан арга хэмжээнүүд, г.м.).
- ✓ Өмнө дурдсан ач холбогдолтой асуудлуудын дүнд хүрсэн дүгнэлтүүд.
- ✓ Уг дүгнэлтүүдэд хүрэх явцад гаргасан чухал буюу гол шийдвэрүүд.

Эх сурвалж: АДБОУБХС/ГАДХ-ны Хөгжлийн Баг.

АДБ нь АДБ-аас гүйцэтгэх аудитүүдэд шаардагддаг аудитын баримтжуулалтын үндсэн стандартыг тодорхойлох бодлого, горимуудтай байх нь чухал. Эдгээр бодлого, горимууд нь аудит дүүссанаас хойш хадгалах ёстой файлуудын төрлийг тодорхойлж, хэр удаан хадгалах ёстойг тогтоох стандартыг тодорхойлдог. АДБ-ууд нь аудитын баримт бичгүүдийг хэрхэн эмхэтгэж, хадгалахтай холбогдох сургалтаар аудиторчуудыг хангах ёстой. Эдгээр бодлого, горимууд болон сургалтууд нь аудит тус бүрээр цуглуулсан аудитын баримт бичгүүдээр дамжуулан аудитын ерөнхий зорилгод хүрсэн тухай аудиторчуудын дүгнэлт

гаргах үндэслэлийг нотлох зүйлсээр хангахад тусалдаг. Бодлого, горимууд болон сургалтууд нь мөн аудитыг АДБ-ын шаардлагууд болон холбогдох хууль, журам, зохицуулалтын шаардлагуудын дагуу төлөвлөж, гүйцэтгэсэн гэдгийг батлах нотлох зүйлсийг бий болгоход туслахыг зорьдог.

Аудитор аудитын түршид аудитын зохих баримт бичгүүдийг АДБ-ын бодлогын дагуу цуглуулж, хадгалдаг байлгах алхмуудыг авч хэрэгжүүлэх хэрэгтэй. Мөн, цуглуулсан баримт бичгүүд нь аудиттай өмнө нь ямар ч холбоогүй байсан туршлагатай аудиторт аудитын шийдвэрүүд болон аудитын үр дүнгүүдийг хэрхэн бий болгосон талаар хангалттай ойлгох боломж олгодог байх ёстой. Баримтжуулалтыг гүйцэтгэлийн аудитын бүр анхнаас нь буюу аудитын багийг анх бүрдүүлэх үеэс хийж эхэлдэг. Аудитаа эхлүүлэхдээ дараах зүйлсийг баримтжуулах талаар бодолцож үзэх хэрэгтэй:

- Аудитын сэдвийг хэрхэн сонгосныг;
- Ямар нэгэн урьдчилсан төлөвлөлт хийсэн эсэхийг;
- Оролцогч талуудыг хэрхэн тодорхойлсныг;
- Аудитад шалгуулагч этгээдүүдтэй харилцсан аливаа харилцааг;
- Аудитын баг болон түүний удирдлагаас гаргасан аливаа эхний шийдвэрүүдийг; мөн
- Тодорхойлсон аливаа эрсдэлүүдийг.

Аудитыг гүйцэтгэж, тайлагнах явцад баримтжуулалт нь маш чухал зүйл хэвээр байх бөгөөд баримтжуулалтыг шүүрхай дуусгах хэрэгтэй. Дараах зүйлсийг баримтжуулах хэрэгтэй:

- Нотлох зүйлс болон түүнд хийсэн танай багийн шинжилгээ;
- Илрүүлэлтийг хэрхэн бий болгосон тухай; мөн
- Ирсэн саналуудад үндэслэсэн дотоод нягталгаа, аудитад шалгуулагч этгээдүүдтэй харилцсан харилцаа болон өөрчлөлт хийх (эсвэл хийхгүй байх) тухай хэлэлцсэн тохиолдлууд, мөн мессеж болон тайлангийн төслийг боловсруулах явцдаа гаргасан бусад гол шийдвэрүүд.

Танай аудитын баг цуглуулсан бүх мэдээлэл болон шийдвэрүүдийг зохих ёсоор баримтжуулсан байхын тулд аудитын ажлын хамгийн эхнээс аудитын баримтжуулалтын багц ажлыг эхлүүлэх нь чухал. Аудитын баг нь аудитын баримтжуулалтыг хэрхэн зохион байгуулах талаар, мөн аудитыг баримтжуулахад аудитын багийн ашиглах аливаа үйл явцууд болон арга хандлагуудын талаар нэгдсэн ойлголттой болсон



- Аудиторууд аудитын баримтжуулалтын нэг хэсэг болгож хадгалах ёстой олон төрлийн баримт бичиг бий. Эдгээрт дараах зэргийн баримт бичгүүд орно:
- Файлд орсон мэдээллийн индекс;
 - Аудитын явцад гарсан шийдвэрүүд, гүйцэтгэсэн үйл ажиллагаанууд, дотоод болон гадаад х а р и л ц а а н у у д ы г баримтжуулах бүх гол шийдвэр болон харилцааны тэмдэглэл;
 - Аудиторуудын хараат бус байдлын мэдэгдэл;
 - Аудитын хамрах хүрээ, арга зүй болон нотлох зүйл цуглуулах төлөвлөгөөг тодорхойлсон аудитын төлөвлөгөө;
 - Аудитын талаар хэлэлцэх анхны уулзалт, илрүүлэлтүүдийг хэлэлцэх аудитын төгсгөл үеийн уулзалтууд зэрэг аудитад шалгуулагч этгээдтэй хийх уулзалтуудын баримтжуулалт;
 - Албан тушаалтнуудаас авсан мэдүүлгийн нотлох зүйлийг баримтжуулах ярилцлагын протокол;
 - Аудитад шалгуулагчийн бодлого, горимууд, тэмдэглэлүүд, хөтөлбөрийн тойм болон өгөгдөл зэрэг нотлох зүйл болох баримт бичгүүд;
 - Файлын нягталгаа, ажиглалт болон шалгалтын бүртгэл;
 - Асуумжийн хариултауд;
 - Фокус бүлэг болон лавлагаа бүлгийн хэлэлцүүлгийн протокол;

Эх сурвалж: АДБОУБХС/ГАДХ-ны ХБ.

байх шаардлагатай. Тухайлбал, аудитын олон төрлийн баримт бичгийг цахим хэлбэрээр, ойлгомжтой бүтэц бүхий төслийн хавтаснуудад хадгалбал зохион байгуулж, удирдахад хялбар байдаг. Цахим баримтжуулалтыг хангалттай хамгаалж хадгалж байгаа тохиолдолд, АДБ-ын бодлого, горимоор зөвшөөрсөн хэмжээнд, цаасан баримт бичгүүдийг цахим баримт бичгээр сольж болно. Аудитын явцад цуглуулсан зарим нотлох зүйлийг цахим хэлбэрээр хадгалах боломжгүй байж болно. Гэхдээ аудитын баримтжуулалтыг зохистой байлгахын тулд хадгалж, хамгаалах хэрэгтэй. Тухайлбал, аудитын явцад компьютерт суурилсан хадгалах системд цахим хэлбэрээр хадгалах боломжгүй биет объект цуглуулсан байж болно. Эдгээр биет объектыг аудитын баримтжуулалтын багцын нэг хэсэг болгож хадгалах хэрэгтэй. Үндсэндээ, аудитын баримт бичгүүдийг хангалттай хугацаанд хадгалахад зориулсан АДБ-ынхаа удирдамжийг мөрдөж ажиллана уу.

Танай аудитын баг аудитын явцад цуглуулсан нотлох зүйлсээ багийн шинжилгээтэй тулган шалгах арга хандлагыг хэвшүүлэх талаар бодолцож үзэж болно. Баримт бичгүүдийг цуглуулж, тулган шалгахтайгаа зэрэгцүүлээд баримт бичгүүд болон аудитын тэмдэглэлийн нууцлал хийгээд аюулгүй хадгалалтыг хангахад ашиглах зохих горимыг хэрэгжүүлж болно.

Гүйцэтгэлийн аудитын цахим файлын бүтцийн жишээг доор үзүүлэв. Энэ бүтцийг багийнхаа хэрэгцээ болон АДБ-ынхаа бодлоготой уялдуулан нутагшуулж болно.

Аудитын баримтжуулалтын хавтаснууд

- Захиргааны баримт бичгүүд.
- Урьдчилсан судалгааны ерөнхий мэдээллийн материалууд.
- Төлөвлөлтийн материалууд.
- Нотлох зүйл болох материалууд (тухайлбал, ярилцлагуудын протокол, олж авсан баримт бичгүүд).
- Нотлох зүйлсэд хийсэн шинжилгээ.
- Тайлангийн төсөл.
- Мөрөөр хяналт тавих үйл ажиллагаа.

Аудитын хянан удирдлага



Стандарт

АДБ нь аудитын үйл явцын турш бүх шатны аудитын ажилтнуудын хийж буй ажил болон аудитын үе шатуудыг зохих ёсоор хянан удирдаж байгааг нягтлах ёстой.

Эх сурвалж: АДБОУС-3000/66.

Ерөнхийдөө, аудитын хянагч нь аудитын үйл явцын туршид аудитын бүх бодлого, горимуудыг мөрдүүлэх хариуцлагыг хүлээнэ.

Аудитын хянан удирдлага гэдэг нь аудитын зорилго(ууд)ыг биелүүлж, арга зүйг зөв ашиглаж, нотлох зүйлс болон шинжилгээг хангалттай баримтжуулж, тайланг өндөр чанартай байлгахын тулд аудит хийхээр томилогдсон ажилтнуудыг хангалттай дэмжлэг, удирдамж болон чиглүүлгээр хангахыг хэлнэ. Хянагчид нь аудитын явцад тулгарсан

томоохон асуудлуудын талаар мэдээлэлтэй байж, аудитын чанарыг хангахын тулд гүйцэтгэж буй ажлуудыг тогтмол нягтлах ёстой. Аудитын хянан удирдлагын нэг чухал хэсэг бол аудитын багийн гишүүдийг үр нөлөөтэй ажлын байран дээрх сургалтаар хангах юм. Ингэснээр бүх аудитор аудитыг үр нөлөөтэй хийх чадавхаа хөгжүүлсээр байх болно.

Аудитын хянан удирдлага юунаас бүрддэг вэ?

- | | |
|--|---|
| ✓ Багийн бүх гишүүдэд аудитын зорилго(ууд) болон аудитын асуултуудыг ойлгуулах. | ✓ Үйл ажиллагааны багийн гишүүн нэг бүрийн чадамж хийгээд нөөц чадавхыг харгалзан үзэх. |
| ✓ Аудитын горимуудыг хангалттай байлгаж, зохих ёсоор хэрэгжүүлэх. | ✓ Үйл ажиллагааны явцад үүсэж болох чухал асуудлуудыг шийдвэрлэж, зохицуулах. |
| ✓ Аудитын нотлох зүйлсийг хамааралтай, найдвартай, хангалттай байлгаж, баримтжуулах. | ✓ Аудитор нь сорилтыг давах шаардлагатай болсон үед дэмжлэг үзүүлэх. |
| ✓ Олон улсын болон үндэсний аудитын стандартуудыг мөрдүүлэх. | ✓ Үүсэх асуудлуудыг шийдвэрлэхэд биечлэн дэмжлэг үзүүлэх. |
| ✓ Төсөв, хуваарь болон төлөвлөгөөг гүйцэтгэхийн тулд үйл ажиллагааны ахицыг тандан судлах. | ✓ Нягтлахад илүү их туршлага шаарддаг асуудлуудыг тодорхойлох. |
| | ✓ Аудитын ажлыг нягталж, батлах. |

Эх сурвалж: УДИР-3910/82.

Аудитын бүх үе шатны турш АДБ-ууд нь удирдамжаар хангаж, хянагчид нь дэмжлэг болон нягталгаагаар хангах нь аудитыг дараах хэмжээнд байлгахад чухал:

- Мэргэжлийн стандартуудад нийцсэн;
- Аудитын зорилгуудыг хангасан байх;
- Баримтжуулалт нь бүрэн бөгөөд аудитын илрүүлэлтүүд болон зөвлөмжүүдийг дэмждэг; мөн
- Ажилтнууд нь мэргэжлийн үр чадамжаа хөгжүүлдэг.

Зарим АДБ-ууд хянан удирдлагын нягталгааны дараа бүх аудитын гарцын аудитын стандартуудтай нийцэх нийцлийг нягталдаг төв оффистой байдаг. Уг төв оффисын нягталгаа нь, тухайлбал, илрүүлэлт, дүгнэлт, зөвлөмжүүдийг нотлох зүйлсээр хангалттай бөгөөд зохистой дэмжүүлж, ойлгомжтой толилуулагдахад хүргэдэг.

Хянан удирдлага шаардлагатай байх хэр хэмжээ нь аудитын байгууллагын хэмжээ, аудиторүүдын туршлага болон ажлын ач холбогдол зэрэг олон хүчин зүйлээс хамаарна. Тухайлбал, үйл ажиллагаандаа ихээхэн хэмжээний засгийн газрын санхүүжилт шаарддаг аудитын сэдэв, эсвэл үлс төрийн болон нийгмийн өнцгөөс асар эмзэг байх асуудал зэрэг их хэмжээний материаллаг байдал бүхий асуудалтай холбогдох аудит нь аудитын баг болон АДБ-аас ихээхэн хэмжээний хянан удирдлага болон хяналтыг шаарддаг. Гэхдээ энэ бүх хүчин зүйлсээс үл хамааруулаад аудитын ажлыг аудитын үйл явцын туршид, ялангуяа аудитын тайланг эцэслэхийн өмнө аудитын багийн дээд албан тушаалтай гишүүд болон АДБ-ын удирдлага нягталж байх шаардлагатай.

Аудиторын хувьд, АДБ-ынхаа хянан удирдлагатай холбогдох шаардлагуудыг дагаж мөрдөх нь чухал. Тухайлбал, аудитын баримт бичгүүдийг хянагчдаа өгч нягтлуулж, санал шүүмж авах хэрэгтэй. Хянагчийнхаа өгсөн аливаа чиглүүлэг, зөвлөгөө, хяналт-шинжилгээ

болон саналыг хүлээн авах чадвартай байж, зохих хариу арга хэмжээг авч, мэргэжлийн чадамж болон гүйцэтгэлээ тасралтгүй сайжруулахыг зорих хэрэгтэй.

Аудитын эрсдэл ба баталгаатай байдал гэж юу вэ?



Стандарт

Аудитор алдаатай, бүрэн бус аудитын илрүүлэлт, дүгнэлт, зөвлөмж боловсруулж, тэнцвэргүй мэдээллээр хангах эсвэл үнэ цэн нэмж чадахгүй байхаас зайлсхийхийн тулд аудитын эрсдэлийг идэвхтэй удирдах ёстой.

Аудитор аудитын судлах сэдэв (зүйл)-ийг шалгуур үзүүлэлттэй харьцуулсан аудитын үр дүнгийн талаарх баталгаажуулалтыг ил тод байдлаар мэдээлэх ёстой.

Эх сурвалж: АДБОУС-3000/52; АДБОУС-3000/32.

АДБ болон аудиторүүд нь аудитын эрсдэлийг идэвхтэй удирдах хэрэгтэй. Эрсдэлийн удирдлага нь зорилтот хэрэглэгчдэд аудитаар бий болгосон мэдээллийн найдвартай бөгөөд хамааралтай байдалд итгэлтэй байж болох бөгөөд аудитын үр дүнг шийдвэр гаргах үндэслэл болгон ашиглаж болно гэсэн баталгаа гаргаж өгөх боломжийг АДБ болон аудитын багт олгодог байх хэрэгтэй.

Гүйцэтгэлийн аудиттай холбогдох олон эрсдэл байдгийг 6-р зурагт үзүүлэв. АДБ болон түүний аудиторүүд нь эдгээр эрсдэлүүдийг зохих ёсоор бууруулж, удирдсан гэсэн баталгааг хэрэглэгчдэдээ өгөх ёстой.

Зураг 6: Гүйцэтгэлийн аудитад тохиолддог түгээмэл эрсдэлүүд

<p>Буруу эсвэл бүрэн бус дүгнэлт</p>	<p>Аудиторүүд буруу эсвэл бүрэн бус аудитын дүгнэлт гаргаж, шаардлагатай эсвэл зохистой асуудалд төвлөрөөгүй зөвлөмж гаргах эрсдэл. Энэ эрсдэл нотлох зүйлсийг хангалттай үнэлээгүй, аудитын зохистой бөгөөд шаардлагатай горимуудыг баримтлаагүй зэрэг олон хүчин зүйлийн улмаас тохиолдож болно.</p>
<p>Тэнцвэргүй мэдээлэл</p>	<p>Аудиторүүд эсрэгцсэн нотлох зүйлсийг хамруулан үнэлж, аудитын аль шалгуур хангагдсаныг тодорхой илтгэж, эсвэл сайн туршлагыг тайлагнаж чадахгүй байх эрсдэл. Аудитад шалгуулагч этгээдийн хүрсэн амжилтыг хэлэлцэхгүй, илрүүлсэн дутагдлуудад хувь нэмэр оруулж буй хүчин зүйлсийг мэдээлэхгүй байх эрсдэл. Тухайлбал, дутагдлыг онцлохдоо шалгуулагч этгээдийн үйл ажиллагаа явуулж буй орчин дахь сорилт, хязгаарлалуудыг тайлбарлахгүй орхих, эсвэл гүйцэтгэлийг нь үнэлэхдээ хүлээн зөвшөөрөгдөх стандартыг дурдахгүй орхих эрсдэл.</p>
<p>Аудитын дүнд хэрэглэгчдэд нэмэгдэх үнэ цэнэ огт байхгүй эсвэл хязгаарлагдмал байх</p>	<p>Аудиторүүд аудитаараа шинэ мэдээлэл эсвэл мэдлэгийг өгч чадахгүй байх эрсдэл. Тодруулбал, аудиторүүд янз бүрийн оролцогч талуудад шинжилгээний шинэ ойлголт (илүү өргөн эсвэл илүү гүн шинжилгээ эсвэл шинэ харах өнцөг) өгч чадахгүй эсвэл мэдээллийг хүртээмжтэй болгож чадахгүй байх эрсдэл.</p>
<p>Чанартай мэдээлэл олж авахад бэрхшээл тулгарах</p>	<p>Аудиторүүд хэрэгцээт мэдээллийг олж авах боломжгүй эсвэл боломж хязгаарлагдмал байх эрсдэл. Түүнчлэн, уг мэдээлэл нь чанарын стандартуудад нийцэхгүй байх эрсдэл (өөрөөр хэлбэл, өгөгдөл нь найдвартай биш байх). Аудитын илрүүлэлтүүд болон дүгнэлтүүд нь цуглуулсан мэдээлэл болон өгөгдлийн чанараас ихээхэн хамаардаг тул аудитыг төлөвлөж, гүйцэтгэхдээ сайн чанартай мэдээлэл болон өгөгдөл олж авах боломжгүй болох эрсдэлийг үнэлэх нь чухал.</p>

<p>Хангалтгүй шинжилгээ</p>	<p>Мэргэшил, аудитын шалгуур эсвэл мэдээллийн хүртээмж дутмаг байсны улмаас аудиторчууд хангалттай шинжилгээ хийхгүй байх эрсдэл. Төлөвлөлтийн үе шатанд үр дүйг хэрэгжүүлсэн бол аудитын явцад мэргэшил болон аудитын шалгуур дутагдсаны улмаас үүсэх эрсдэлийг бууруулж болно.</p>
<p>Удирдлагын оролцоо</p> <p>Хамааралтай мэдээлэл эсвэл аргументыг орхигдуулах</p> <p>Залилан, нөөцийг урвуулан ашиглах болон/эсвэл хэвийн бус практик</p> <p>Маш нарийн төвөгтэй байдал эсвэл улс төрийн эмзэг байдал</p>	<p>Аудитор нь хөндлөнгийн аудитор байхын оронд аудитад шалгуулагч агентлагийн дотоод удирдлагын бүтцийн нэг хэсэг болж, дүрэм зөрчсөний улмаас үүсэх аюул.</p> <p>Аудиторууд аудитын явцад судлах гол асуудлуудыг төлөвлөлтийн үе шатанд бүгдийг нь тодорхойлохгүй байх, хамаарал бүхий нотлох зүйлсийг харгалзан үзэхгүй орхих, эсвэл аудитын дүгнэлт дэх чухал аргументыг няцааж чадахгүй байх эрсдэл.</p> <p>Аудитын зорилго(ууд)ын хүрээнд залилан гарах эрсдэл их байгаа эсэхийг үнэлэхгүй байх, мөн/эсвэл залилан болон хэвийн бус байдлыг шуурхай мэдээлж чадахгүй байх эрсдэл. Хэрэв залилан гарсан бол аудитор нь АДБ-ынхаа залилантай холбогдох горимыг дагах хэрэгтэй.</p> <p>Маш нарийн төвөгтэй болон улс төрийн хувьд эмзэг сэдвүүд дээр аудиторууд зохих ёсоор ажиллахгүй байх эрсдэл. Энэ эрсдэл аудитын тайлан болон АДБ-ын итгэл хүлээх байдлыг ноцтой ихээр алдагдуулж болно.</p>

Эх сурвалж: АДБОУБХС/ГАДХ-ны Хөгжлийн Баг.

Аудитын баталгаатай байдал гэх ухагдахуун нь аудитын эрсдэл гэх ухагдахуунтай салшгүй холбоотой. Гүйцэтгэлийн аудиторууд нь баталгаатай байдлыг үүсгэхдээ, санхүүгийн аудитын дүгнэлтээс ялгаатай нь, аудитад шалгуулагч этгээд арвилан хэмнэлт, үр ашигтай болон үр өгөөжтэй байдалд хүрсэн талаарх ерөнхий дүгнэлт хэлбэрээр үүсгэх албагүй байдаг (АДБОУС-300/21).

Аудитын тайланг хэрэглэгчид нь тайлангийн дүгнэлтийг найдвартай бөгөөд хүчин төгөлдөр гэдэгт итгэлтэй байх хэрэгтэй. УДИР-3910/27-д зааснаар, мэдээлэл найдвартай бөгөөд хүчин төгөлдөр байхын тулд судалсан сэдвийн талаарх дүгнэлт нь аудитын зорилго(ууд) болон шалгууруудтай логик холбоотой бөгөөд хангалттай, тохиромжтой нотлох зүйлсээр дэмжигдсэн байх шаардлагатай. Дүгнэлтийг бичихдээ судалсан сэдэв/ зүйлийг шалгуураар үнэлсэн үнэлгээнд итгэх зорилтот хэрэглэгчдийн итгэлийн түвшнийг сайжруулах байдлаар бичих хэрэгтэй.

Аудиторын хувьд, баттай нотлох зүйлсэд үндэслэн аудитын зорилгууд, шалгуурууд болон илрүүлэлтүүд хоорондын холбоог тодорхой болгох нь чухал. Ингэхдээ илрүүлэлтүүд, шалгуурууд болон дүгнэлтүүдийг хэрхэн тэнцвэртэй бөгөөд үндэслэлтэй байдлаар боловсруулсныг, мөн илрүүлэлтүүд болон шалгууруудын хослол нь яагаад тодорхой ерөнхий дүгнэлт эсвэл багц дүгнэлтүүдэд хүргэснийг тодорхой болгох



Аудитын баг болон аудиторууд нь дараах зүйлсийг хангах замаар аудитын эрсдэлийг удирдаж, баталгаатай байдлыг үүсгэх хэрэгтэй:

- Аудит нь АДБ-ын бүрэн эрхийн хамрах хүрээнд байх ба хамрах хүрээг зохих байдлаар тодорхойлох;
- Аудит хийх байгууллагад аудитыг гүйцэтгэхэд шаардлагатай бөгөөд тохиромжтой мэдлэг, үр чадвартай хүний нөөц бэлэн байх;
- Аудитын загварчлал нь эрсдэлийг үр нөлөөтэй удирдахаар тооцсон байх;
- Аудитыг гүйцэтгэхэд шаардлагатай бүртгэл болон өгөгдөлд хандах боломжтой байх;
- Бүртгэл болон өгөгдөл нь найдвартай бөгөөд бүрэн байх;
- Чанартай бүтээгдэхүүн боловсруулах хөрөнгө оруулалтын түвшин нь эрсдэлтэй тэнцүү байх; мөн
- Үйл ажиллагааны зохиомж, ажилтнуудын бүрэлдэхүүн, оролцогч талуудын оролцоо, мессеж боловсруулалт болон бүтээгдэхүүний нягталгаа зэрэг нийт үйл ажиллагааны туршид чанарыг удирдахын тулд бүх түвшний хариуцлага болон эгэх хариуцлагыг ойлгомжтой тодорхойлсон байх.

Эх сурвалж: АДБОУБХС/ГАДХ-ны ХБ.

хэрэгтэй. Хэрэв зөв хийж чадвал, зорилтот хэрэглэгчид нь дүгнэлтийн хүчин төгөлдөр байдалд итгэлтэй байж чадах бөгөөд ийнхүү аудитор нь баталгаатай байдлыг үүсгэж чадна (УДИР-3910/32). Зорилтот хэрэглэгчид өгөх баталгааг ил тод мэдээлэх хэрэгтэй.

Аудитор та аудитын эрсдэлийг үнэлж, баталгаатай байдлыг үүсгэх алхмуудыг хэрэгжүүлэх хэрэгтэй. Тодруулбал, дараах зүйлсийг хийх хэрэгтэй:

1. Эрсдэлүүдийг тодорхойлох;
2. Уг эрсдэлүүдийг үнэлэх;
3. Уг эрсдэлүүдээс сэргийлэх, бууруулах стратеги боловсруулж, хэрэгжүүлэх; мөн
4. Аудитын туршид аудитын эрсдэл болон түүнийг бууруулах стратегийг хянан-шинжилж, өөрчлөгдөж буй орчин нөхцөлийн шаардлагаар өөрчлөлт оруулж байх.

Аудитын эрсдэл болон баталгаатай байдлын түвшинд олон хүчин зүйл нөлөөлдөг боловч хамгийн чухал нь танай аудитын багийн дараах зүйлсийг хийх чадвар юм:

- Аудитын хамрах хүрээ болон нотлох зүйл цуглуулах горимын тохиромжтой байдлыг тодорхойлсон байдлаар аудитыг чанартай загварчлах;
- Аудитын эрсдэл болон загварыг идэвхтэй удирдахын тулд судлах сэдэв/ зүйлийг хангалттай ойлгох. Аудитын баг нь судлах сэдэв/ зүйлийн нөхцөл болон аудитын тайлангийн зорилтот хэрэглэгчдэд шаардлагатай итгэлтэй байдлын түвшнийг харгалзаж үзэх ёстой; мөн
- Аудитын сэдэв бүр өвөрмөц учир эрсдэлүүдийг үнэлэхдээ мэргэжлийн үнэлэмж болон мэргэжлийн үл итгэх үзлийг үр нөлөөтэй хэрэгжүүлэх. Та аудит хийж буй сэдвийнхээ талаар судалж, хичээнгүйлэн суралцаж, зөв ойлгосон гэдгээ батлан итгэл хүлээх байдлаар судлах сэдэв/ зүйлийн талаарх ойлголтоо баримтжуулах ёстой.

Аудитын эрсдэлийг үнэлж, бууруулах талаар дэлгэрэнгүй мэдээллийг 4, 5-р бүлгүүдэд оруулав.

Аудитад шалгагдагч этгээд, гадаад оролцогч талууд, хэвлэл мэдээллийнхэн болон олон нийттэй харилцах харилцаа гэж юу вэ?



Стандарт

Аудитор нь аудитын үйл явцын турш аудитын гол хэсгүүдийг үр нөлөөтэй бөгөөд зохистой байдлаар аудитад шалгуулагч этгээд болон холбогдох оролцогч талуудад мэдээлэх харилцааг төлөвлөж, хэрэгжүүлэх ёстой.

Аудитор нь оролцогч талуудтай үүсгэсэн энэхүү харилцаа АДБ-ын хараат бус байдал болон голч байдлыг алдагдуулахгүй байхад анхаарах ёстой.

АДБ нь гүйцэтгэлийн аудитыг хийхэд дагаж мөрдсөн стандартуудыг тодорхой мэдээлэх ёстой.

Аудитор нь аудитыг төлөвлөх болон/эсвэл гүйцэтгэх ажлын нэг хэсэг болгож аудитын шалгуурыг аудитад шалгуулагч этгээдтэй хэлэлцэх ёстой.

АДБ-ууд нь аудитад шалгагдагч этгээдээс аудитын илрүүлэлтүүд болон зөвлөмж дээр санал авах горим зэрэг бодитой бөгөөд ил тод стандарт, үйл явц болон аргуудыг нэвтрүүлэх ёстой.

Эх сурвалж: АДБОУС-3000/55; АДБОУС-3000/59; АДБОУС-3000/61; АДБОУС-3000/49; АДБОУБ-3-20, Зарчим 3.

Танай аудитын баг гүйцэтгэлийн аудит хийхдээ ганцаараа ажиллахгүй. Та болон танай аудитын баг шинжилгээгээ хийж, зохих дүгнэлтэд хүрэхэд шаардлагатай мэдээлэл авах зорилгоор аудитад шалгуулагчтай үр нөлөөтэй бөгөөд зохистой харилцаа үүсгэх хэрэгтэй. Аудит нь нэг эсвэл хэд хэдэн аудитад шалгуулагч этгээдэд төвлөрч болно. Холбогдох бүх этгээдтэй харилцах нь чухал. Хуульчид, арга зүйчид, техникийн экспертүүд зэрэг АДБ-ынхаа дотоод оролцогч талуудтай зөвлөлдөхөөс гадна, АДБ-аас гадуурх хүмүүсээс ч бас тусламж хүсэх нь хэрэгтэй байж болно. Тухайлбал, АДБ-ууд салбарын байгууллагууд эсвэл судалгааны компаниудын тухайн судлах сэдэв/ зүйлээр мэргэшсэн экспертүүдээр ажил гүйцэтгүүлэх гэрээ байгуулж, аудитдаа туслуулж болно. Гэхдээ, энэ төрлийн тусламж эрж байгаа үед хараат бус байдлаа хадгалж, экспертүүдийг аудитын дүгнэлтэд зүй бусаар нөлөөлүүлэхгүй байх нь чухал. Эцэст нь, хийж буй ажлынхаа талаар хэвлэл мэдээллийнхэнтэй харилцдаг АДБ-уудын хувьд, хэвлэл мэдээллийнхэн болон олон нийттэй харилцах стратегийг харгалзан үзэх шаардлагатай болж болно (ялангуяа олон нийтэд их харагддаг эсвэл маргаантай сэдвээр хийж буй аудитын хувьд).

Аудитад шалгуулагч этгээдтэй харилцах нь

Аудитад шалгуулагч этгээдийг аудитын холбогдох бүх хамаарал бүхий асуудалд оролцуулсаар байх нь чухал. Энэ нь ажлын бүтээлч харилцааг хөгжүүлж, аудитын багийг аудитын зорилго(ууд)доо хүрч, өндөр чанартай аудит хийхэд нь тусалдаг. Харилцаа гэдэгт аудиттай холбогдох мэдээлэл олж авч, удирдлагууд болон засаглал хариуцсан хүмүүст боломжит илрүүлэлтүүд болон дүгнэлтүүдийн талаарх ажиглалтыг шуурхай хүргүүлэх багтаж болно. АДБ-ууд нь аудитад шалгуулагч этгээдтэй харилцах харилцаатай холбогдох ерөнхий хамгийн доод шаардлагуудаар аудиторуудаа хангаж болно. Тухайлбал, АДБ-ын удирдамж нь аудиторуудыг хэзээ аудитад шалгуулагч этгээдтэй харилцахыг, ямар төрлийн эсвэл түвшний мэдээлэл хэлэлцэхийг зааж өгч болно. Эсвэл, тухайлбал, АДБ-ын бодлого, горимуудад аудитад шалгуулагч агентлагт өгсөн зөвлөмж нь АДБ-ыг хараат бус, голч аудиторууд биш, харин зөвлөхүүдээс бүрдсэн гэж харагдуулахуйц хэт дэлгэрэнгүй зааварчилгаатай байж болохгүй гэж шаардсан байж болно.

Танай аудитын баг аудитад шалгуулагч этгээдтэй аудитын туршид тогтмол мөчлөгтэй харилцах хэрэгтэй. Тодруулбал, танай баг дараах зүйлсийг хийж болно:

- Аудитад шалгуулагч этгээдтэй харилцах үйл явцыг аудитын төлөвлөлтийн үе шатанд эхлүүлж, аудитын туршид үргэлжлүүлэх. Аудитад шалгуулагч этгээд нь гүйцэтгэлийн аудитын талаар мэдлэггүй байж болох



Аудиторууд нь аудитад шалгуулагч этгээдтэй дараах байдлаар үр нөлөөтэй харилцаж болно:

- Аудитад шалгуулагчийн албан тушаалтнуудтай нүүр нүүрээ харсан уулзалт хийх;
- Теле хурал, уулзалт хийх; мөн
- Захидал, и-мэйл зэргээр бичгээр харилцах.
- Аудитын багууд аудитын чухал үеүдэд аудитад шалгуулагч этгээдтэй уулзах шаардлагатай. Үүнд:
- Аудитын зорилго, аудитын асуултууд, хамрах хүрээ, арга зүй, мэдээллийн шаардлага болон хугацааг хэлэлцэх анхны уулзалт;
- Аудитад шалгуулагчаас өгөгдөл, мэдээлэл авах, мөн аудитад шалгуулагчид аудитын ахицын талаар мэдээлэх ажлын уулзалтууд; мөн
- Аудитын илрүүлэлтүүдийн төслийг хэлэлцэх, аудитад шалгуулагч этгээдэд санал болон нэмэлт мэдээллээр хангах боломж олгох аудитын төгсгөл үеийн уулзалт.
- Аудитад шалгуулагч этгээдтэй харилцахдаа аудиторууд нь дараах шаардлагыг хангах нь чухал:
- Мэргэжлийн, хүндэтгэлтэй, эелдэг, хүлээн авах чадвартай байх; мөн
- Хараат бус байдал болон голч байдлаа хадгалах.

Эх сурвалж: АДБОУБХС/ГАДХ-ны ХБ.

учраас тэдэнд гүйцэтгэлийн аудитын зорилго болон үйл явцын талаар танилцуулах нь чухал;

- Аудитын судлах сэдэв/ зүйл; аудитын зорилго(ууд) болон асуултууд; аудитын шалгуурууд; аудит хийх хугацаа; болон аудитад хамрагдах засгийн газрын ажил хэрэг, зохион байгуулалт болон/эсвэл хөтөлбөрүүдийг тодорхойлох аудитын эхний үе шатуудад аудитад шалгуулагч этгээдийг оролцуулах. Баримт бичиг болон өгөгдөлд хандах эрх, мөн хуваалцах мэдээллийн нууцлал/эмзэг байдал, түүнийг хэрхэн ашиглаж, аудитын эцсийн тайланд хэрхэн нийтлэх вэ гэдэг нь аудитын үйл явцын эхэн үед, болж өгвөл аудитыг төлөвлөх үед аудитад шалгуулагчтай хэлэлцэх гол асуудлууд юм;
- Аудитын үйл явцын туршид аудитад шалгуулагч этгээдэд мэдээлэл өгөх уулзалтуудыг зохион байгуулж, уулзалтуудын мэдээллийг харгалзан үзэх. Аудит нь ихэнхдээ аудитын баг сэдвийнхээ талаар илүү ихийг мэдэж, мэдээлэл олж авч, шинжлэхтэй зэрэгцээд хувьсан өөрчлөгдөж байдаг. Та аудитын асуултууд болон шалгуурууд зэрэг аудитын гол хэсгүүдэд гарсан аливаа томоохон өөрчлөлтүүдийн талаар аудитад шалгуулагч этгээдэд мэдээлдэг байх хэрэгтэй. Үр нөлөөтэй харилцаа нь таны өгөгдөл, мэдээлэлд хандах боломжийг сайжруулж, аудитад шалгуулагч этгээдийн харах өнцгийн талаар илүү сайн ойлголттой болоход тусалж болно; мөн
- Аудитад шалгуулагч этгээдэд аудитын илрүүлэлт, дүгнэлт болон зөвлөмжүүд дээр саналаа хэлэх боломж олгох. Түүнчлэн, аудитад шалгуулагч этгээдийн саналыг ашиглан баримтын алдааг засаж, эцсийн тайланд өөр бусад өөрчлөлт оруулах хэрэгтэй эсэхийг бодолцон үзэж болно. Үзэл бодлын шийдвэрлэгдээгүй үлдсэн ялгаатай байдал болон бусад чухал саналуудыг АДБ-ын өгсөн хариултын хамт тайлангийн нэг хэсэг болгон нийтэлж болно.

Аудитын үйл явцын туршид аудитад шалгуулагч этгээдийг оролцуулсан бат бэх харилцаа нь засаглалд утга учиртай өөрчлөлтийг авчрахад чухал бөгөөд аудитын нөлөөллийг нэмэгдүүлж болно. Энэ тохиолдолд, та аудитын урьдчилсан илрүүлэлтүүдийг аудитад шалгуулагч этгээдтэй хуваалцаж, аудитын туршид харах өнцгүүдийг боловсруулагдаж, үнэлэгдэх бүрд хуваалцах замаар бүтээлч харилцаа үүсгэж болно. Гэхдээ, аудитад шалгуулагч этгээдтэй үр нөлөөтэй харилцаж, хамтран ажиллахдаа зохих хараат бус байдал болон голч байдлаа үргэлж хадгалах ёстойгоо санагтун.

Гадаад оролцогч талуудтай харилцах нь

Бид АДБ аудитыг гүйцэтгэхэд шаардлагатай мэдлэг, үр чадварыг эзэмшсэн аудитын багийг бүрдүүлж, аудитын бүх үе шатны туршид экспертүүд болон арга зүйчид зэрэг АДБ-ынхаа дотоодын оролцогч талуудтай зөвлөлдөхийн чухлыг хэлэлцсэн билээ. АДБ-аас гадуурх оролцогч талуудтай харилцах нь мөн зохистой юм. Танай байгууллагаас гадуурх боломжит оролцогч талуудад дараах багтаж болно:

- Эрдэм шинжилгээний болон бизнесийн байгууллагууд;
- Олон улсын байгууллагууд;
- Дотоодын аудиторүүд;

- Иргэд болон тэдний төлөөлөл;
- Судалгааны хүрээлэнгүүд;
- Иргэний нийгмийн байгууллагууд (ИНБ);
- Мэргэжлийн институтүүд;
- Эмзэг бүлгийнхний төлөөлөл;
- Бусад төрийн бус байгууллагууд; мөн
- Хуулийн экспертүүд (АДБ-ын дотоодод байхгүй тохиолдолд).

Оролцогч талтай харилцах харилцаа нь АДБ-ын манлайлал болон аудитын багт хоёуланд нь чухал. Тухайлбал, АДБ-ууд бүтээмжтэй хамтын ажиллагааг дэмжих зорилгоор янз бүрийн байгууллагуудтай сайн харилцаа үүсгэх шаардлагатай.

Түүнчлэн, аудитор та аудитад оролцогч бүх оролцогч талуудтай мэргэжлийн сайн харилцаатай байхыг эрмэлзэх хэрэгтэй. Ингэхдээ, нууцлал хадгалах шаардлагын зөвшөөрсөн хэмжээнд чөлөөтэй бөгөөд илэн далангүй мэдээллийн үрсгалыг дэмжиж, оролцогч талууд бие биеэ харилцан хүндэлж, тус тусын үүрэг, хариуцлагыг ойлгосон орчинд хэлэлцүүлгүүд өрнүүлэх хэрэгтэй. Оролцогч талуудтай харилцах харилцаа чухал боловч энэхүү харилцаа нь аудитын эсвэл АДБ-ын хараат бус байдал болон голч байдлыг алдагдуулахгүй байхад анхаарах нь чухал. Тухайлбал, танай АДБ-д АДБ-аасаа гадуурх оролцогч талуудтай хуваалцаж болох аудитын мэдээлэл болон баримт бичгийг тодорхой журамласан бодлого, горимүүд байж болно.

Хэвлэл мэдээллийнхэн болон олон нийттэй харилцах нь

Хэвлэл мэдээллийнхэнтэй холбоо тогтоож, харилцах стратеги нь олон нийтэд аудитын ажлын үр дүнг мэдээлэхэд чухал байж болно. Тайланг, хууль, журам эсвэл зохицуулалтаар хориглоогүй тохиолдолд, олон нийт болон бусад сонирхсон оролцогч талуудад хэвлэл мэдээллээр дамжуулан нээлттэй болгох нь сайн практик юм. Аудитын үр дүнг нийтэд тайлагнах нь, тусгайлан хязгаарлаагүй тохиолдолд, аудитын үр дүнг буруугаар ойлгогдох эрсдэлийг бууруулж, зохих залруулах арга хэмжээнүүд авагдсан эсэхийг тодорхойлох зорилготой мөрөөр хяналт тавих ажиллагааг дэмждэг. АДБ-ууд нь АДБ-ын ажлын талаар мэдээлэл авах хүсэлт гаргаж буй олон нийт болон хэвлэл мэдээллийнхний хэрэгцээ шаардлагад анхаарал хандуулах үндэслэл бүхий хүчин зүтгэл гаргах нь чухал. ч бай, цахим ч бай, орон нутгийн ч бай, үндэсний ч бай, дотоодын ч бай, олон улсын ч бай бүх хэвлэл мэдээлэлд хандах АДБ-ын хандлага нь тэнцвэртэй бөгөөд тэгшитгэсэн байх хэрэгтэй.

Аудитор таны хувьд АДБ-ынхаа хэвлэл мэдээллийнхэн болон олон нийттэй харилцахтай холбоотой дүрэм, удирдамжуудыг дагаж мөрдөх нь чухал. Тухайлбал, АДБ-ын удирдамж нь АДБ-ын ямар түвшний албан тушаалтан хэвлэл мэдээлэлд ярилцлага өгч болох талаар чиглүүлэг өгч болно.

Гүйцэтгэлийн аудитыг чанартай гүйцэтгэх зарчмууд нь таны нийт ажилд үйлчлэх ёстой тул дараах зүйлсийг үргэлж санагтун:

... АДБ-ынхаа чанарын хяналт болон баталгаажуулалтын хүрээг ойлгож, түүний дагуу ажиллах;

... хараат бус байдалд анхаарч, хараат бус байдалд учирч болох аюулуудаас сэрэмжилж, шаардлагатай үед тэдгээрийг мэдээлэх;

... АДБ-ынхаа бүх ёс зүйн стандартууд болон шаардлагуудыг дагаж мөрдөх;

... мэргэжлийн үнэлэмж болон үл итгэх үзлийг бүрэн хэрэгжүүлэх;

... аудитын багаа бүхэлд нь аудитыг гүйцэтгэхэд шаардлагатай мэргэжлийн чадамжтай байлгах;

... аудитын сэдвүүд болон илрүүлэлтүүдийн материаллаг байдлыг тодорхойлж, аудитын нотлох зүйлс болон шийдвэрүүдийг зохистой баримтжуулж, аудитыг үр нөлөөтэй хянан удирдах;

... аудитын эрсдэлийг үнэлж, аудитад баталгаатай байдал үүсгэх стратегийг бий болгох;

... аудитын гол хэсгүүдийг үр нөлөөтэй бөгөөд зохистой байдлаар аудитад шалгуулагч этгээд болон холбогдох оролцогч талуудад мэдээлэх харилцааг төлөвлөж, хэрэгжүүлэх; мөн

... гүйцэтгэлийн аудиттай холбогдох нотлох зүйлс нь ихэвчлэн дүгнэх чанартай бус, харин ятгах чанартай бөгөөд тогтмол дахин үнэлэхийг шаардаж байдаг тул гүйцэтгэлийн аудит хийхэд маш сайн үнэлэмж, хөрвүүлэн ойлгох чадвар болон үл итгэх үзэл шаардагддаг гэдгийг санах.

Эх сурвалж: АДБОУБХС/ГАДХ-ны Хөгжлийн Баг.


АДБОУБХС-аас дэвшүүлсэн хүртээмжтэй байдлыг хэвшүүлж, гүйцэтгэлийн аудитын нөлөөллийг хамгийн их байлгахад анхаарах зүйлс

Гүйцэтгэлийн аудитын АДБОУС-уудын ерөнхий зарчмуудаас гадна, гүйцэтгэлийн аудитад хамаарах, салбар дамнасан хоёр анхаарах зүйлийг энд онцолъё: Аудитын нөлөөлөл ба хүртээмжтэй байдал. Эдгээр нь гүйцэтгэлийн аудитын шаардлага биш юм. Өөрөөр хэлбэл, эдгээр арга хэмжээг аваагүй байсан ч гүйцэтгэлийн аудит нь АДБОУС-д нийцсэн байж болно. Гэхдээ, АДБОУБХС-ын зүгээс АДБ-ууд нь АДБ-ын бий болгодог үнэ цэн болон өгөөжийг нэмэгдүүлэхийн тулд гүйцэтгэлийн аудитын үйл явцын туршид аудитын нөлөөлөл болон хүртээмжтэй байдлыг хэвшүүлэхэд анхаарах хэрэгтэй гэж зөвлөдөг.

Нөлөөлөлд хөтлөгдсөн гүйцэтгэлийн аудитын үйл явц

АДБОУБХС нь “аудитын нөлөөлөл” гэдгийг хүмүүс болон гараг дэлхийд (нийгэмлэг/бүлэг/талбар) учрах үрт хугацааны эерэг үр нөлөөнд АДБ-ын аудитын ажлын оруулах хувь нэмэр гэж тодорхойлдог. Аудитын ийм нөлөөллийг АДБ-ын гарцууд болон АДБ-ын үр дүнгүүдийн үнэ цэнгийн гинжин хэлхээгээр бий болгоно. 7-р зурагт гүйцэтгэлийн аудитын хувьд уг үнэ цэнгийн гинжин хэлхээ хэрхэн харагдаж болохыг үзүүлэв.

Зураг 7: АДБ-ын гарц болон АДБ-ын үр дүнгийн үнэ цэнгийн гинжин хэлхээ



АДБ нь АДБ-ын гарцуудыг хянадаг боловч АДБ-ын үр дүн болон нөлөөлөлд оруулах хувь нэмэрт нөлөөлөх олон хүчин зүйл бий. АДБ-ууд бол экосистемийн нэг хэсэг юм. Улс орны нийгэм, эдийн засаг, улс төрийн хам нөхцөл болон хууль тогтоох, хэрэгжүүлэх байгууллагууд, иргэний нийгмийн байгууллагууд, мэргэжлийн байгууллагууд, эрдэмтэн судлаачид, хэвлэл мэдээллийнхэн зэрэг олон талт оролцогч талууд нь аудитын нөлөөллийг бий болгоход үүрэг гүйцэтгэдэг.

АДБ нь эдгээрийг хянах боломжгүй байж болох ч, нөлөөлөх бүрэн боломжтой байдаг. АДБ гүйцэтгэлийн аудитаараа дамжуулан нөлөөлөлд хувь нэмэр оруулах боломжийг хамгийн их болгохын тулд бид АДБ-ыг аудитын нөлөөллийн асуудлыг аудитын үйл явцынхаа туршид орхигдуулж болохгүй гэж зөвлөдөг. Ингэхийн тулд гүйцэтгэлийн аудитын янз бүрийн үе шатанд зарим гол асуултуудыг асууж, хариулж болно.

Гол асуултууд

- Энэхүү гүйцэтгэлийн аудитын төлөвлөсөн аудитын нөлөөлөл нь юу вэ?
- Сонгосон сэдэв нь хүсэж буй аудитын нөлөөлөлд хувь нэмэр оруулах уу?
- Аудитын загварын хүрээ нь хүсэж буй аудитын нөлөөлөлд хувь нэмэр оруулах уу?
- Аудитын үйл явцын туршид гол оролцогч талууд оролцохоор байна уу?
- Аудитын зөвлөмж нь орхигддог хүмүүс зэрэг хүн амын бүх бүлэгт зориулагдсан эерэг нөлөөлөл бий болгоход чиглэгдсэн үү?
- Гол мессежнүүдийг холбогдох бүх оролцогч талд хүргүүлсэн үү?
- Аудитын нөлөөллийн мөрөөр хяналт тавьж, дэмжих зохих үйл явцыг бий болгосон уу?

Эх сурвалж: АДБОУБХС/ГАДХ-ны Хөгжлийн Баг.

Аудитын нөлөөллийг нэмэгдүүлэх зарим зөвлөгөөг доор өгүүлэв.

Аудитын нөлөөллийг нэмэгдүүлэх зөвлөгөө

- ✓ АДБ-ын манлайлалтай (удирдлагатай) харилцах.
- ✓ Аудитад шалгуулагч этгээдтэй тогтмол харилцах.
- ✓ Оролцогч талуудын эвсэл байгуулах.
- ✓ Ажлынхаа үнэ цэнийг мэдээлэх.
- ✓ Аудитын үйл явцын туршид аудитын нөлөөллийг бодож үзэх.
- ✓ АДБОУС-уудыг дагаж мөрдөх.

Эх сурвалж: АДБОУБХС/ГАДХ-ны Хөгжлийн Баг.

Гүйцэтгэлийн аудитад хүртээмжтэй байдлыг хэвшүүлэх нь

Дэлхий даяар сая сая хүн ядуу тарчиг амьдарсаар байгаа бөгөөд үнэ хүндтэй амьдрах боломжгүй хэвээр байна. Боломж, баялаг болон эрх мэдлийн ялгаа асар их байна. Жендэрийн тэгш бус байдал гол сорилт хэвээр байна. Өнөөгийн цар тахал тэгш бус байдлыг улам хурцатгалаа. Засгийн газрын үйл явцууд болон үр дүнгүүдэд оролцож, өгөөж хүртэх сонголт хийгээд боломжоор дутагддаг хүмүүс орхигдож хоцордог хэвээр байна. Хүмүүс жендэр, яс үндэс, нас, анги давхарга, хөгжлийн бэрхшээл, бэлгийн чиг хандлага, шашин шүтлэг, үндэс угсаа, уугуул амьдралын хэв маяг, цагаачлалын статус, нийгэм-эдийн засгийн статус, газар зүйн алслагдмал байдал, зөрчилдөөн мөргөлдөөн гэх мэт олон хүчин зүйлийн үлмаас эмзэг бөгөөд орхигдсон байдалд орж болно. Улс орон бүрийн хувьд, засаглалын үүрэг хариуцлагыг хүлээсэн хүмүүс нь засгийн газрын бодлого, хөтөлбөр болон институтуудийг алслагдсан хүмүүсийн хэрэгцээ шаардлагад хариулдаг, хүртээмжтэй байлгах нь чухал юм.

Алслагдсан хүмүүсийг оролцуулах нь засгийн газрын үр дүн болон шийдвэр гаргах үйл явцад хоёуланд нь чухал байдаг. Гүйцэтгэлийн аудит нь үр нөлөөтэй засаглал болон төрийн үйлчилгээнд хувь нэмэр оруулахыг зорьдог учраас засаглалын үүрэг хариуцлагыг хүлээсэн хүмүүс улс орныхоо алслагдсан бүлгийнхнийг оролцуулж, хэрэгцээ шаардлагад нь үйлчилж буй эсэхийг шалгах нь чухал.

Гүйцэтгэлийн аудитын үед хүртээмжтэй байдлыг дараах байдлаар шалгаж болно:

- **Хүртээмжтэй байдлыг гүйцэтгэлийн аудитын сэдэв бүрийн нэг хэсэг болгон шалгах.** Тухайлбал, үндэсний нийтийн эрүүл мэндийн хүчирхэг бөгөөд уян хатан тогтолцоонд аудит хийхэд шалгах сэдвүүдийн нэг нь онцгой байдлын үед уг тогтолцооны хүн амын хөгжлийн бэрхшээлтэй иргэд, цагаачид болон дүрвэгсэд зэрэг алслагдсан секторын хэрэгцээ шаардлагад хүрч үйлчлэх бэлэн байдал байж болно.
- **Алслагдсан хүмүүст шууд нөлөөлөх сэдвүүдийг сонгох.** Үндэсний тэргүүлэх зорилгуудад үндэслэн алслагдсан хүмүүст шууд нөлөөлөх өндөр ач холбогдолтой сэдвүүдийг сонгохоор шийдэж болно. Тухайлбал, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн гаралт маш өндөр улсад байгаа бол гүйцэтгэлийн аудитын сэдвээрээ эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг таслан зогсоох үйл ажиллагааг сонгож болно.
- **Алслагдсан секторуудын оролцогч талууд болон үр шим хүртэгчидтэй харилцах.** Аудитын үйл явц нь холбогдох алслагдсан бүлгүүдийг төлөөлдөг эсвэл тэдэнд хүрч ажилладаг иргэний нийгмийн байгууллагуудтай (ИНБ) харилцах замаар өөрөө хүртээмжтэй байж болно. Ийм харилцаа нь судлах сэдэв/ зүйлийг илүү сайн ойлгоход хувь нэмэр оруулах, аудитын бүх үе шатанд эдгээр секторуудын дуу хоолойг сонсож, харгалзан үздэг болгох зэрэг олон талын өгөөжтэй. Түүнчлэн, аудитын хамааралтай зөвлөмж боловсруулах чадварт сайнаар нөлөөлдөг.
- **Алслагдсан секторуудад нөлөөлөх аудитын нөлөөллийг ойлгох.** Аудитынхаа нөлөөллийг ойлгох үедээ хүртээмжтэй байдлыг мөн харгалзан үзэж болно. Танай аудит алслагдсан секторуудад ямар өөрчлөлтийг авчрах вэ?
- **Алслагдсан секторуудад тулгарч буй асуудлуудын талаарх мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх үүднээс аудитынхаа гол мессежийг түгээх.**

Хүртээмжтэй байдлыг шалгахын тулд асууж болох асуултууд

- ✓ Алслагдсан бүлгүүдийг засгийн газар хэрхэн тодорхойлж, бодлогуудын хэрэгжилтдээ харгалзан үзэж байна вэ?
- ✓ Хэн орхигдож байна вэ? Тэдний эмзэг байдлын суурь шалтгаан юу вэ?
- ✓ Өгөгдлийн задлан ялгаагүй ямар эх сурвалжууд бэлэн байна вэ? Ямар өгөгдөл дутуу байна вэ?
- ✓ Алслагдсан хүмүүсийн хэрэгцээ шаардлагыг тодорхойлохын тулд ямар арга хэмжээ авч байна вэ?
- ✓ Засгийн газар шийдвэр гаргах үйл явцдаа алслагдсан бүлгүүдийг хэрхэн оролцуулж байна вэ?
- ✓ Засгийн газар алслагдсан бүлгүүдэд шийдвэр гаргах үйл явцынхаа талаар хэрхэн мэдээлж байна вэ?
- ✓ Алслагдсан болон эмзэг бүлгийн хүн амтай холбогдох АДБ-ын зөвлөмжийн дагуу засгийн газар ямар арга хэмжээ авсан бэ?

Эх сурвалж: АДБОУБХС/ГАДХ-ны Хөгжлийн Баг.

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ҮЙЛ ЯВЦ

Чухал алхмууд ба ухагдахуунууд



1-р алхам

Аудитын
сэдвийг сонгох

2-р алхам

Аудитыг
загварчлах

3-р алхам

Аудитыг
гүйцэтгэх

4-р алхам

Илрүүлэлт,
дүгнэлт,
зөвлөмжүүдийг
боловсруулах

5-р алхам

Тайлан бичих

6-р алхам

Аудитын
мөрөөр хяналт
тавих

Салбар дамнасан
анхаарах зүйлс

Чанарын хяналт

Хараат бус
байдал ба ёс зүй

Мэргэжлийн үнэлэмж
ба үл итгэх үзэл



Аудитын сэдвийг сонгох нь

- Яам, хууль тогтоох засаглал, засгийн газар, мөн иргэний нийгмийн байгууллага болон олон нийт зэрэг бусад оролцогч талуудын **ашиг сонирхол болон тэргүүлэх зорилгуудыг ойлгох.**
- Аудитын сэдвүүдийг ач холбогдолтой, аудит хийх боломжтой бөгөөд АДБ-ын бүрэн эрхэд нийцсэн байлгах **сэдэв сонгох шалгуурыг ашиглах.**
- Эрсдэл, санхүү болон бодлогын шинжилгээ хийж **аудитын орчныг тандах.**
- **Аудитын сэдвүүдийг эрэмбэлж,** АДБ-ын хамгийн тэргүүний зорилгыг тодорхойлох.
- Аудитын багт **сэдвийг сонгож** өгөх.



Аудитыг загварчлах нь

- Аудитын сэдвийг илүү сайн ойлгохын тулд **урьдчилсан судалгаа** хийх.
- Аудитын **арга хандлагыг** тодорхойлох.
- Аудит хийх шалтгааныг тодорхойлсон **зорилго(ууд)ыг** боловсруулах.
- Аудитын тухайлсан талбаруудыг чиглүүлэх **аудитын асуултуудыг** боловсруулах.
- Аудитад шалгуулагч этгээдийн гүйцэтгэлийг байвал зохих байдалтай тулган хэмжих аудитын тохиромжтой **шалгууруудыг** тодорхойлох.
- Мэдээлэл цуглуулж, шинжлэх ажлыг чиглүүлэх **арга зүйг** боловсруулах.
- Хүснэгт зэргээр аудитын зохиомжийг

Аудитыг гүйцэтгэх нь

- **Хангалттай** бөгөөд **зохистой** нотлох зүйлс цуглуулахын ач холбогдлыг ойлгох.
- Зөвшөөрөгдсөн **арга зүйг ашиглан** өгөгдөл, мэдээлэл цуглуулах.
- Цуглуулсан өгөгдөл, мэдээллийг чанарын болон тоон аргуудыг ашиглан

Илрүүлэлт, дүгнэлт, зөвлөмжүүдийг боловсруулах нь

- Аудитын илрүүлэлтүүдийг тодорхойлох.
- Эерэг болон сөрөг **илрүүлэлтүүдийг** зохих тэнцвэртэй агуулсан **мессеж** боловсруулах.
- Шаардлагатай бол **дүгнэлтүүд** болон

Тайлан бичих нь

- Аудитын үр дүнгүүдийг **үр нөлөөтэй мэдээлэх** тайлангийн бүтэц үүсгэх.
- АДБ-ынхаа удирдамжийн дагуу тайлангийн **төсөл бичих**.
- Тайлангийн төсөлдөө **аудитад шалгуулагч этгээдийн саналыг** авах.
- АДБ-ынхаа удирдлагуудаар батлуулсныхаа дараа тайлангаа эцэслэж, **нийтлэх**.
- Аудитын үр дүнгүүдийг холбогдох талуудад **мэдээлэх**.



Аудитын мөрөөр хяналт тавих нь

- Аудитын илрүүлэлтүүд болон зөвлөмжүүдийн **ахицыг** тодорхойлох.
- Илрүүлсэн асуудлуудыг **шийдвэрлэсэн** эсэхийг үнэлэх.
- Санхүүгийн болон санхүүгийн бүс **өгөөжүүдийг** тодорхойлох.
- **Ирээдүйд аудит хийх** талбаруудыг тодорхойлох.

Гүйцэтгэлийн аудитын үр ашгийн гурвал (3Es)



Арвилан хэмнэлт
Өртгийг бага байлгах



Үр ашигтай байдал
Байгаа нөөцийг дээд зэргээр ашиглах



Үр нөлөөтэй байдал
Зорилгыг биелүүлж, зорьсон үр дүнд хүрэх

Зөвлөмж

АДБ-ын дотоодын оролцогч талууд болон гаднын экспертүүдийн мэргэшлийг ашигла.

Аудитын турш аудагчид шалгуулагч этгээдтэй харилцаатай бай.

Аудитын үе шат бүрд мэдлэг, туршлагыг ашиглан мэргэжлийн үнэлэмж болон үл итгэх үзлийг хэрэгжүүл.

Загварчлах, гүйцэтгэх болон тайлагнах үед хүртээмжтэй байдалд анхаар.

Эерэг үр дүнг тайлагнахаас гадна дутагдлыг тайлагнаж тэнцвэртэй байлгахад анхаар.

3-р бүлэг

Гүйцэтгэлийн аудитын сэдвийг хэрхэн сонгох вэ?



1-р алхам



2-р алхам



3-р алхам



4-р алхам



5-р алхам



6-р алхам

Аудитын сэдэв сонгох нь

- ✓ Яам, хууль тогтоох засаглал, засгийн газар, мөн иргэний нийгмийн байгууллага болон олон нийт зэрэг бусад оролцогч талуудын **ашиг сонирхол болон тэргүүлэх зорилгуудыг ойлгох.**
- ✓ Аудитын сэдвүүдийг ач холбогдолтой, аудит хийх боломжтой бөгөөд АДБ-ын бүрэн эрхэд нийцсэн байлгах **сэдэв сонгох шалгуурыг** ашиглах.
- ✓ Эрсдэл, санхүү болон бодлогын шинжилгээ хийж, **аудитын орчныг тандах.**
- ✓ **Аудитын сэдвүүдийг эрэмбэлж,** АДБ-ын хамгийн тэргүүний зорилгыг тодорхойлох.
- ✓ Аудитын багт **сэдэв сонгож өгөх.**

АДБОУС-3000-ын дагуу, гүйцэтгэлийн аудитын төлөвлөлт нь хоёр хэсгээс бүрддэг: сэдэв сонгох ба аудитын загварчлах. Энэ бүлэгт бид сэдэв сонголтын тухай үзнэ. Аудитын Дээд Байгууллага (АДБ) аль сэдвээр аудит хийхээ хэрхэн сонгодгийг тайлбарлана. Аудитыг загварчлах тухай 4-р бүлэгт үзнэ.

Сэдэв сонгох үйл явц нь АДБ-ын хувьд янз бүр байж болно. Аудитор таны хувьд ажлаа хийх явцад сэдэв сонголт хэрхэн өрнөдгийг ойлгох нь чухал. Энэхүү бүлэг нь гүйцэтгэлийн аудитын Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандартын (АДБОУС) шаардлагууд болон АДБ-ын нийтлэг практик үндэслэн ерөнхий удирдамж санал болгоно.

Тус бүлэг нь дараах асуултуудад хариулах болно:

- Стратегийн төлөвлөлтийн үйл явц гэж юу вэ?
- АДБ гүйцэтгэлийн аудитын боломжит сэдвүүдийг тодорхойлохын тулд аудитын орчныг хэрхэн танддаг вэ?
- Гадаад оролцогч талуудын хүсэлт хэрхэн үүсдэг вэ?
- Дан ганц аудитад шалгуулагч этгээдийн үүрэг хариуцлага биш сэдвээр АДБ ямар үед аудит хийхийг бодолцож үзэж болох вэ?
- АДБ-ууд гүйцэтгэлийн аудитын сэдвийг сонгохдоо ямар шалгуур ашигладаг вэ?

Стратегийн төлөвлөлтийн үйл явц гэж юу вэ?



Стандарт

Аудитор боломжит сэдвүүдэд шинжилгээ хийж, холбогдох эрсдэл, хүндрэлийг тодорхойлох судалгаа хийх замаар АДБ-ын стратегийн төлөвлөлтийн үйл явцыг хэрэгжүүлэн аудитын сэдвийг сонгох ёстой.

Эх сурвалж: АДБОУС-3000/89.

Стратегийн төлөвлөлт бол АДБ-ын урт хугацааны зорилгуудыг тодорхойлж, тэдгээрийг биелүүлэх хамгийн боломжит арга хандлагыг илрүүлэх үйл явц юм.¹¹ АДБ-ын стратегийн төлөвлөлтийн үйл явц нь аудит хийх боломжит талбаруудын шинжилгээнээс бүрдэж, аудитын нөөцийн үр ашигтай хуваарилалтын үндэс болдог тул үүнийг сэдэв сонголтын эхний алхам гэж ойлгож болно (АДБОУС-3000/92). Энэхүү үйл явцын нэг хэсэг болгож, АДБ нь томоохон эрсдэлүүд болон чухал гэж үзэгдэх асуудалтай талбаруудыг илрүүлэх судалгаа хийдэг. АДБ нь эдгээр субъектүүдийг шинжилж, аль гүйцэтгэлийн аудит нь олон нийт, засгийн газар болон хууль тогтоох засаглалын ашиг сонирхолд хамгийн сайн нийцэхийг, мөн аль нь хамгийн их үнэ цэн нэмэхийг тодорхойлдог.

Стратегийн төлөвлөлтийн үйл явц нь АДБ бүрд өөр өөр байдаг. Төлөвлөлт нь ерөнхийдөө хэдэн жилийг хамруулж, АДБ-д гүйцэтгэлийн аудитын сэдэв сонгоход нь чиглүүлэг болдог. Стратегийн төлөвлөлт нь ерөнхийдөө доод түвшний үйл ажиллагааны аудитын төлөвлөгөөг бий болгож, ирэх нэг эсвэл түүнээс олон жилд аль сэдвүүдээр ажиллахыг зааж өгдөг.

¹¹ Энэ нь үйл ажиллагааны болон байгууллагын стратегийн төлөвлөлтөөс ялгаатай. Гэхдээ аудитын стратегийн төлөвлөлт нь байгууллагын стратегийн төлөвлөлтөд нөлөөлдөг.

Аудитын стратегийн төлөвлөлтийн зорилго нь ихэвчлэн ...

... АДБ-ын дээд удирдлагуудыг ирээдүйн аудитын хамралтын чиглэлийг тогтоох бат сууриар хангадаг;

... Аудитад шалгуулагч этгээдэд тулгарах эрсдэлийг ойлгож, уг эрсдэлийг аудитын сэдэв сонгоходоо бодолцож үздэг;

... Улсын секторын эгэх хариуцлага болон захиргааг сайжруулах боломжтой гүйцэтгэлийн аудитыг тодорхойлж, сонгодог;

... АДБ-ын гүйцэтгэлийн аудитын тэргүүлэх зорилгуудыг аудитад шалгуулагч этгээд болон хууль тогтоох засаглалд мэдээлдэг;

... Байгаа нөөцөөр хэрэгжүүлж болох ажлын хөтөлбөрийг бий болгодог; мөн

... АДБ-ын эгэх хариуцлагын үндэс суурийг бий болгодог.

Эх сурвалж: АДБОУБХС/ГАДХ-ны Хөгжлийн Баг.


АДБ стратегийн төлөвлөлтийн үйл явцад ашиглах мэдээллийг хэрхэн цуглуулдаг вэ?

Аудитын сэдвүүдийг хоёр үндсэн эх сурвалжаас гаргаж авдаг:

- АДБ аудитын орчныг тандах замаар илрүүлсэн ерөнхий асуудлууд.
- Оролцогч талуудын хүсэлт эсвэл санал.

Энэ хоёр эх сурвалж АДБ-д аудитын сэдвээ сонгоход хэрхэн тусалдгийн жишээг 8-р зурагт үзүүлэв.

Зураг 8: АДБ-ууд аудитын сэдвээ хэрхэн сонгож болох вэ?



Эх сурвалж: АДБОУБХС/ГАДХ-ны Хөгжлийн Баг.

АДБ гүйцэтгэлийн аудитын боломжит сэдвүүдийг тодорхойлохын тулд аудитын орчныг хэрхэн танддаг вэ?

АДБ-үүд нь ерөнхийдөө гүйцэтгэлийн аудитын шинэ сэдвийг илрүүлэх ажлыг салангид үйл ажиллагаа гэхээс илүүтэй байнга үргэлжлэх үйл явц гэж авч үздэг. Үр өгөөжтэй санаа ямар ч үед, ямар ч эх сурвалжаас гарч ирж болно. Танай АДБ болон аудитор та төрийн байгууллагуудад нөлөөлөх шинэ сорилт, эрсдэл болон үйл явдлуудад сэрэмжтэй байх ёстой.

Аудитад шалгуулагч байгууллага нь гүйцэтгэлийн аудит хийлгэх шаардлагыг үүсгэдэг дотоод болон гадаад дарамтуудтай тулгарч байдаг. Нийтлэг дарамтуудын жишээнээс дурдвал:

- Төсвийн хязгаарлагдмал байдал;
- Эдийн засаг, нийгэм болон хүн амын чиг хандлагууд;
- Шинэ бөгөөд нарийн төвөгтэй хөтөлбөр эхлэх;
- Хангалттай үр чадвартай ажилтнуудын бэлэн байдал;
- Байгууллагын үйл ажиллагааг фокусаа болгосон хэвлэл мэдээллийнхэн; мөн
- Дээд удирдлага дахь өөрчлөлтүүд.

АДБ аудитын орчны эрсдэлүүд өөрчлөгдөх болон шинэ эрсдэл гарч ирэх бүрд үнэлгээ хийж, түүнд шуурхай хариу арга хэмжээ авах нь чухал (АДБОУБ-3-12/Зарчим 5). Стратегийн төлөвлөлтийн явцад эрсдэлийн шинжилгээ эсвэл асуудлын үнэлгээ зэрэг техникүүд нь төлөвлөлтийн үйл явцыг бүтэцжүүлэхэд тусалдаг. Гэхдээ, эдгээрийг мэргэжлийн үнэлэмжээр дэмжиж, АДБ-ын бүрэн эрхийг харгалзан үзэж, ач холбогдолтой бөгөөд аудит хийх боломжтой сэдвүүдийг сонгох хэрэгтэй (АДБОУС-3000/93). Хэрэв та эрсдэлийг эрт эсвэл гүйцэтгэлийн аудитын явцад илрүүлсэн бол түүнийг бууруулах зөвлөмжийг гаргах хэрэгтэй. Ингэснээр та аудитад шалгуулагч этгээдийн үр нөлөөтэй байдалд үзүүлэх нөлөөллийг ихээр нэмэгдүүлэх боломжтой юм. 4-р бүлэгт эрсдэлийг хэрхэн илрүүлж, үнэлэх талаар дэлгэрэнгүй өгүүлсэн болно.

Олон АДБ аудитаар шалгаж буй байгууллагууддаа зориулж эрсдэлийн үнэлгээг жил бүр шинэчлэх хөтөлбөр хэрэгжүүлдэг. Энэ үйл явц нь тэдэнд эерэг нөлөөлөл үзүүлж болох сэдвүүдийг илрүүлэх нь тусалдаг. Аудитын боломжит сэдвүүдийг тодорхойлох олон янзын арга техник бий. 9-р зурагт хамгийн нийтлэг аргуудын заримыг жагсаасан бол 10-р зурагт уг үйл явцыг Замби улсын АДБ хэрхэн хэрэгжүүлдгийг тайлбарлан харууллаа.

Зураг 9: Аудитын боломжит сэдвүүдийг тодорхойлох аргууд

<p>Улсын секторын орчныг тандах</p>	<p>АДБ хожим гүйцэтгэлийн аудитаар нарийвчилсан хяналт хийхэд тусалж болох хөгжил дэвшлүүдийн талаар мэдээлэлтэй байхын тулд улсын секторын гол асуудлуудыг хянан-шинжилдэг. Тухайлбал, та дараахыг хийж болно:</p> <ul style="list-style-type: none"> • Гүйцэтгэлтэй холбогдох хамаарал бүхий нийтлэлүүд болон өмнөх тайлангуудыг унших; • Бусад аудиторуудын туршлагыг сонсох; • Парламентын мэтгэлцээний тэмдэглэлийг нягтлах; • Конференц, семинаруудад суух; • Хамтран ажиллагсад, оролцогч талууд болон мэргэжилтнүүдтэй хэлэлцүүлэг хийх; мөн • Асуудлуудыг хэвлэл мэдээллээр нийтэлж буй эсэхэд анхаарах. <p>Талбарыг ажиглах гэдэг нь таныг болон танай АДБ-ыг нийгэмд юу болж байгаа талаар, мөн ямар талбарт илүү их судалгаа шаардлагатай байгаа талаар байнгын шинэ мэдээлэлтэй байлгадаг тасралтгүй үйл явц юм.</p>
<p>Албан ёсны мэдэглүүдийг нягтлах</p>	<p>АДБ-ууд нь аудитад шалгуулагч этгээдэд нь нөлөөлж болох албан ёсны мэдэглүүд болон нийтлэлүүдийг ажиглаж байдаг. Та дараах мэдээллүүдийг шалгаж болно:</p> <ul style="list-style-type: none"> • Олон улсын нийгэмлэгийн тогтвортой хөгжлийн зорилгууд (ТХЗ). • Төсвийн байнгын Хороо эсвэл бусад байнгын хорооны тогтоолууд. • Парламентын жилийг нээж Төрийн Тэргүүний хэлсэн үг. • Хууль, журам болон хууль тогтоогчдын илтгэлүүд. • Улсын төсөв болон удирдамжууд. • Төрийн бодлогын бусад баримт бичгүүд (тухайлбал, яамны стратегийн баримт бичиг, тайлангууд). • Аудитад шалгуулагч этгээдийн жилийн тайлангууд. • АДБОУБ-аас тодорхойлсон сэдвүүд зэрэг глобал хөгжил, дэвшил.
<p>Санхүүгийн шинжилгээ</p>	<p>Санхүүгийн суурь шинжилгээ хийхэд аудитад шалгуулагч этгээдийн орох, гарах мөнгөн урсгалыг судалдаг. Дараах материаллаг байдал бүхий онцлогуудыг илүү нарийвчлан судлахаар сонгож болно:</p> <ul style="list-style-type: none"> • Санхүүгийн нарийн төвөгтэй зохицуулалтууд; • Орлого болон зарлагын шинэ эх үүсвэрүүд; мөн • Зарлага өндөр эсвэл хурдтай өөрчлөгдөж буй талбарууд.
<p>Хэвлэл мэдээллийн хяналт-шинжилгээ</p>	<p>АДБ-ууд нь олон нийт эсвэл тоймч нарын зүгээс төрийн үйлчилгээний талаар дэвшүүлж буй асуудлуудыг илрүүлэхийн тулд хэвлэл мэдээллийнхний үйл ажиллагааг (тухайлбал, сонин нийтлэл, телевизийн мэдээ, сошиал медиа) хянан-шинжилдэг. Хүн амын тодорхой сегментэд л нөлөөлж болох асуудлуудыг илрүүлэхийн тулд хэвлэл мэдээллийг өргөн хүрээнд анхаарах нь чухал. Тухайлбал:</p> <ul style="list-style-type: none"> • Ахмад настнуудад чиглэсэн нийтлэлүүд нь тэтгэвэр, ахмад настнуудын дунд илүү түгээмэл байдаг эрүүл мэндийн асуудлын эмчилгээ зэрэг талбаруудад үүсэж буй асуудлуудын шижмийг бариулж болно. • Бүс нутгийн нийтлэлүүд нь засгийн газраас нийтийн тээвэр, ус хангамж болон ариутгах татуурга, харилцаа холбоо зэрэг үйл ажиллагаануудад хуваарилж буй төсвийн хуваарилалтыг түлхүү харуулж болно. • Тодорхой жендер, ясны бүлэг эсвэл бусад хүн амын ижил төстэй сегментэд чиглэсэн нийтлэлүүд нь уншигчдад харилцан адилгүй нөлөөлөх төрийн үйлчилгээний асуудлуудыг (эрүүл мэндийн үр дүн зэрэг) илрүүлж болно.

Ерөнхий тойм

Ерөнхий тойм (мөн ерөнхий судалгаа гэдэг) нь ерөнхийдөө аудитад шалгуулагчийн зорилго, үндсэн үйл ажиллагаа болон үүргээ гүйцэтгэхдээ ашигладаг нөөцийн түвшин болон мөн чанарын талаарх ойлголтыг танд өгдөг. Та авч үзэж буй байгууллага эсвэл талбарын суурь мэдээлэл, зорилго, үйл ажиллагаа, төлөвлөгөө, нөөц, горим болон хяналтын талаарх мэдээллийг эмхэлж, үнэлж болно.

Ерөнхий тойм нь дараах зорилготой:

- Ихээхэн хэмжээний нөөц зарцуулагддаг талбаруудыг илрүүлж, нягтлах;
- Нөөцийн хамгийн сайн ашиглалтад хүрэхэд тулгарах боломжит эрсдэлүүдийг илрүүлэх;
- Аудитын анхааралд үргэлж байх шаардлагатай талбаруудыг онцлох; мөн
- Аудит хийх талбар эсвэл субъектийг санал болгох.

Та дараах зүйлсийг хамруулсан ерөнхий тойм бэлдэж болно:

- Аудитад шалгуулагч этгээдийг бүхэлд нь;
- Хоорондоо холбоотой бүлэг үйл ажиллагаа; мөн
- Зарлага гаргах эсвэл хүлээн авах томоохон төсөл, хөтөлбөрүүд.

Ерөнхий тойм нь аудитын стратегийн төлөвлөлтөд оруулах зүйлсийн саналыг гаргах үед үнэтэй лавлах эх сурвалж болж болно. Ерөнхий судалгаанд мэдээлэл цуглуулах үедээ холбогдох бүх баримт болон үнэлгээг хандахад хялбар ажлын хавтсанд бүртгэн хадгалж, шинэчилж байх нь чухал.

Ерөнхий тойм нь ерөнхийдөө дараах зүйлсийг хамруулдаг:

- Аудитад шалгуулагч этгээдийн талаарх суурь мэдээлэл.
- Ач холбогдол өндөртэй хууль хэрэгжүүлэгч байгууллага
- Шалгагдагч байгууллагын зорилго.
- Зохион байгуулалтын шийдэл.
- Эгэх хариуцлагын харилцаа.
- Гүйцэтгэсэн үйл ажиллагаанууд.
- Ашигласан нөөцийн түвшин болон мөн чанар.
- Хэрэгжиж буй горимууд болон хяналтын тогтолцоонууд.

Иргэдийн үзэл бодлыг харгалзан үзэх

АДБ аудитад шалгагдагч этгээдийн гүйцэтгэлийг иргэд хэрхэн үзэж буйг, мөн уг гүйцэтгэл нь иргэдийн ашиг сонирхолд хэрхэн нөлөөлж буйг мэдэхийг зорьдог.

Иргэд нь гүйцэтгэлийн аудитын санааны эх сурвалж, гүйцэтгэлийн аудит хийх эрэлтийг үүсгэгч, мөн эргээд гүйцэтгэлийн аудитын тайлангийн хэрэглэгчид болж болно. АДБ засгийн газрын байгууллагуудын үйл ажиллагаа болон хөтөлбөрүүдийн талаарх олон нийтийн үзэл бодлыг тоймлосон хамсааралтай мэдээлэлтэй байхыг зорьдог.

Та шинжилгээндээ хүртээмжтэй байдлыг харгалзан үзэх хэрэгтэй. Өөрөөр хэлбэл, аудитад шалгуулагч этгээдийн гүйцэтгэл нийгмийн өөр өөр секторуудад хэрхэн нөлөөлж буйг харгалзаж үзэх хэрэгтэй. Тухайлбал, бизнесийн үр чадварыг дэмжих хөтөлбөрийг судлахдаа, уг хөтөлбөр эрэгтэйчүүд болон эмэгтэйчүүдэд адил хүртээмжтэй байгаа эсэхийг, мөн эрэгтэй болон эмэгтэй оролцогч нарын уг хөтөлбөрт хамрагдсан туршлага хэр хэмжээнд байгааг харгалзан үзэж болно. Нийгмийн ялгаатай бүлгүүдэд очих туршлага болон үр дүн нь материаллаг байдлын хувьд ялгаатай байгаа илрүүлсэн тохиолдолд, та уг үйлчилгээг илүү хүртээмжтэй болгох ямар нэгэн өөрчлөлтийг хийж болох эсэхийг судлах хэрэгтэй.

Судалгааны сэдэв нь материаллаг байдалтай байгаа эсэхийг харгалзан үзэхдээ, та оролцогч талуудын бодол, олон нийтийн ашиг сонирхол, хууль, журам, зохицуулалтын шаардлага болон нийгэмд үүсэх үр дагаврыг харгалзан үзэж болно.

Бусад гадаад оролцогч талуудтай нягт харилцах

АДБ-ын дотоод хэлэлцүүлэг, үнэлгээнүүд

АДБ гадаад оролцогч талуудтай харилцаа үүсгэж, аудитын боломжит сэдвийг илрүүлэх болон хэлэлцэхийн тулд тэдэнтэй тогтмол харилцаж байж болно.

Та тухайн асуудлаар мэргэшсэн экспертүүд, засгийн газар дахь холбогдох талууд болон аудитад шалгуулагч этгээдийн дотоод аудиторуудаас аудитын сэдвийн талаар санал авч болно.

Эрдэм шинжилгээний салбарынхан гэдэгт аудитын тухайлсан талбарт экспертийн мэдлэгтэй хүмүүс багтана. Ийм эрдэмтэд нь хувийн ашиг сонирхлоор харьцангуй бага хязгаарлагдсан илүү бодитой үзэл бодол хэлэх боломжтой. Иймд эрдэмтэн судлаачид нь аудитын бүх үе шатанд тохиромжтой хэлэлцүүлгийн оролцогч, заримдаа зөвлөх ч болдог.

Төрийн бус байгууллагууд нь санааны хэрэгтэй эх сурвалж байж чадна. Тэд судалгаа болон кэйс судалгаагаар өөрийн гэсэн судалгааг хийж, олон төрлийн хэрэгтэй харилцааг үүсгэсэн байх талтай.

АДБ бусад гүйцэтгэл, санхүү болон нийцлийн аудиторуудтай харилцаж, аудитын боломжит сэдвүүдийг илрүүлж болно. Тухайлбал, санхүүгийн аудиторууд нь аливаа хөтөлбөрийг үр нөлөөтэй хэрэгжүүлж чадаагүй гэдгийг илтгэх санхүүгийн сул талуудыг илрүүлсэн байж болно.

Эх сурвалж: АДБОУБХС/ГАДХ-ны Хөгжлийн Баг.

Зураг 10: Замби улсын АДБ хэрхэн аудитын орчныг тандаж, аудитын боломжит сэдвүүдийг тодорхойлдог вэ?

Замби улсын АДБ – Эрсдэлийн үнэлгээг жилийн төлөвлөлтөд ашиглах нь

Замби улсын АДБ нь талбар ажиглах ажлыг гүйцэтгэлийн аудитыг хийх үндсэн суурь болгож ашигладаг. Талбар ажиглахын зорилго нь төрийн байгууллагын бүтээгдэхүүн, үйлчилгээнд олон нийт сэтгэл дундуур байдаг гэсэн тайлан гардаг эсвэл байгууллагуудад гүйцэтгэлтэй холбогдох асуудлууд байдаг янз бүрийн салбарууд дахь талбаруудыг үнэлэхэд оршдог. Тус АДБ гүйцэтгэлийн аудитаар шалгах боломжит талбаруудыг илрүүлэхийн тулд нийцлийн болон санхүүгийн аудитын тайлангуудыг мөн ашигладаг.

Тэд тодорхой салбаруудын талбар ажиглах үүрэг хариуцлагыг хамгийн ихдээ 3 аудитораас бүрдсэн багт хуваарилдаг. Уг аудиторууд нь жилийн турш тухайн салбарт гарсан хөгжил дэвшил хийгээд асуудлуудыг мэдэж байх даалгаврыг гүйцэтгэдэг. Талбар ажиглах ажил бол аудиторууд стратегийн

болон жилийн аудитын төлөвлөгөө, парламентын мэтгэлцээн, гүйцэтгэх засаглалын шийдвэрүүд, төсвийн хуваарилалт, хэвлэл мэдээллийнхэн болон тухайн асуудлаар мэргэшсэн экспертүүд хийгээд бусад оролцогч талуудтай хийх олон нийтийн хэлэлцүүлэг зэргээр дамжуулан мэдээлэл цуглуулдаг тасралтгүй үйл явц юм.

Салбарын үнэлгээг хожим эрсдэлийн ерөнхий үнэлгээнд нэгтгэж, өөр өөр салбаруудаас сонгосон гүйцэтгэлийн аудитын боломжит сэдвүүдийг толилуулж, ач холбогдлоор нь эрэмбэлдэг.

Үнэлгээний үр дүнгээс хамаарч, тэд материаллаг байдал, мэдээллийн бэлэн байдал, өөрчлөлт авчрах боломж, олон нийтийн ашиг сонирхол бүхий асуудал зэргийг харгалзаж үзэнгээ талбаруудад аудит хийх боломжтой эсэхийг тогтоодог.

Эх сурвалж: АХАДБАБ-ын Гүйцэтгэлийн Аудитын Гарын Авлага, 2016.

Гадаад оролцогч талуудын хүсэлт хэрхэн үүсдэг вэ?

Аливаа яам шинэ хөтөлбөр нь хэр хэрэгжиж буйг эхний байдлаар судалж өгөхийг АДБ-аас хүсэж болно. АДБ мөн хууль тогтоох засаглалаас хяналт шалгалт эсвэл аудит хийх тухайлсан хүсэлт хүлээн авч болно. Хөндлөнгийн оролцогч талуудад хариулт өгөхдөө, АДБ нь ихэвчлэн санал хүлээн авахад нээлттэй байдаг. Гэхдээ, АДБ хууль тогтоох засаглалаас баталсан өөрсдөд нь үйлчлэх хуулийг хүндэтгэнгээ, хараат бус байдлаа хадгалах ёстой.

Үндэсний хэмжээний хуульд өөрөөр заагаагүй тохиолдолд, аудит хийх эсэх, мөн аудитын судалгааны гол зорилгыг хэрхэн тодорхойлох вэ гэдгийг шийдэх эцсийн сонголт нь хөндлөнгийн оролцогч талд бус, үргэлж АДБ-д хадгалагдах ёстой. (АДБОУБ-3-10/Зарчим 3)

Аудитор таны хувьд хөндлөнгийн хүсэлтийг харгалзан үзэхдээ аудитын тайлангийнхаа хэрэглэгчдийн хэрэгцээ шаардлага болон ашиг сонирхлыг харгалзан үзэх нь чухал. Эдгээр шаардлагыг харгалзан үзсэнээр та аудитын тайланг хэрэгцээтэй бөгөөд ойлгогдохуйц болгож чадна. Тухайлбал, та аль асуудал болон илрүүлэлт нь тайлангийн уншигчдын хувьд материаллаг байдалтай байх вэ гэдгийг бодолцож үзэх ёстой. Өмнө дурдсанчлан, материаллаг байдал гэдгийг аливаа асуудлыг авч үзэж буй хам нөхцөл дэх тухайн асуудлын харьцангуй ач холбогдол буюу чухал байдал гэж тодорхойлж болно. Материаллаг байдалд мөнгөн үнэ цэнээс гадна нийгмийн болон улс төрийн ач холбогдол, нийцэл, ил тод байдал, засаглал болон эгэх хариуцлага зэргийг оруулна. (АДБОУС-3000/84)

Аль болох их үнэ цэн бий болгохын тулд аудитор нь аудитын үйл явцын бүхий л үе шатанд судлах сэдэв/ зүйлийн санхүүгийн, нийгмийн болон улс төрийн талууд зэрэг материаллаг байдлыг бодолцож үзэх ёстой (АДБОУС-3000/83). Аливаа асуудлын талаарх мэдлэг нь зорилтот хэрэглэгчдийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол тухайн асуудлыг материаллаг байдалтай гэж үзэж болно. Материаллаг байдлыг тодорхойлох нь мэргэжлийн үнэлэмжийн асуудал бөгөөд хэрэглэгчдийн хэрэгцээ шаардлагыг хөрвүүлэн ойлгох аудиторын ойлголтоос хамаарна. Таны үнэлэмж дан ганц зүйл эсвэл хамтад нь авч үзсэн бүлэг зүйлстэй холбогдож болно.

АДБ яагаад дан ганц аудитад шалгагдагч этгээдийн үүрэг хариуцлага биш сэдвээр аудит хийхийг бодолцож үзэж болох вэ?

Аудитын стратегийн төлөвлөлт нь дан ганц аудитад шалгагдагч этгээдэд хялбархан оноож болохооргүй сэдвүүдийг агуулж болно. Гүйцэтгэлийн аудит нь дан ганц хөтөлбөр, бодлого, байгууллага эсвэл сан дээр төвлөрч болно. Эсвэл үр дүн эсвэл тогтолцоонд төвлөрч, үг үр дүн болон тогтолцоонд хувь нэмэр оруулдаг хөтөлбөр, бодлого, байгууллагуудыг судалж болно. Судлах сэдэв/ зүйлийн нарийн төвөгтэй байдлын үнэлгээ хийж, хариуцах байгууллагуудын (мөн тэдгээрийн хоорондын харилцааны) зураглалыг гаргасны дараа АДБ нь аудитын зорилго болон хамрах хүрээг тогтоох ёстой. Энэ үйл ажиллагаа нь стратегийн төлөвлөлтийн явцад хэдийнээ хийгдсэн эсвэл хийгдээгүй байж болно.

Зарим тохиолдолд аудитын сэдвийг хариуцсан нэгээс олон этгээд байдаг. Тухайлбал, хөдөө аж ахуйн бүтээмжийг сайжруулах шинэ технологи ашиглах хөтөлбөр нь газар тариалан, байгаль орчин, санхүү, сургалт болон олон улсын худалдааг хариуцсан олон яамдыг хамруулж болох тул зорьсон үр дүнд хүрэхийн тулд уг яамдыг холбон зохицуулах шаардлагатай болно.

Нэг бодлого эсвэл үйл ажиллагааны хэрэгжилтэд бага зэрэг ч болтугай өөр өөр зорилготой өөр өөр байгууллагууд хувь нэмэр оруулж байгаа үед гүйцэтгэлийн асуудлын эрсдэл илүү өндөр байна. ЗЕ-г (арвилан хэмнэлт, үр ашигтай байдал болон үр нөлөөтэй байдал)

бодолцож үзвэл, энэ нь гүйцэтгэлийг муутгах маш өндөр эрсдэлтэй гэсэн үг. Тухайлбал, хүн амын уургийн хэрэглээг өсгөх замаар нийтийн эрүүл мэндийг сайжруулахыг хүсэж буй засгийн газрын тохиолдлыг авч үзье. Хөдөө аж ахуйн яам нь махан бүтээгдэхүүнийг гадаад руу худалдаалж фермерүүдийн орлогыг нэмэгдүүлэхийг хүсэх магадлал маш өндөр. Харин Эрүүл Мэндийн Яам нь махыг дотооддоо хэрэглүүлэхийг хүснэ. Энэхүү эсрэгцэл нь засгийн газрын бодлогын үр ашигтай байдал болон үр нөлөөтэй байдлыг ерөнхийд нь муутгаж болно.

Хөтөлбөр, бодлого эсвэл байгууллага дамнасан аудитын сэдвийг авч үзэх үед, түүнтэй уялдуулан, аудитад шалгуулагч этгээдүүд болон тэдгээрийн үүрэг хариуцлагыг тодорхойлохоос авхуулаад аудитын хамрах хүрээ, шалгуур болон арга зүйг тодорхойлох хүртэлх аудитын үйл явцыг тохируулах нь чухал.

Эдгээр үйл ажиллагааг аудитын боломжит сэдэв гэж тодорхойлохыг эрмэлзэхдээ АДБ дараах зүйлсийг хийж болно:

- Гүйцэтгэлийн аудит нь олон нийтийн мөнгө болон бусад нийтийн нөөцийг захиран зарцуулах хариуцлагыг хүлээсэн улсын секторын бүх байгууллагыг хамруулна гэсэн хүлээлтэд нийцэх;
- Улсын секторын байгууллагууд хоорондын нягт хамтын ажиллагааг дэмжих; мөн
- Хэн ч хариуцлагатайгаар авч үзэхгүй байгаа сэдвүүдийг илрүүлэх. Энэхүү дутагдлыг илрүүлэхэд аливаа үйл ажиллагаа эсвэл сэдвийн хүрээнд оршин буй үүрэг хариуцлагуудыг ангилан зураглах дасгал ажил тусалж болно. Үүний тулд та RACI шинжилгээг ашиглаж болно¹².

АДБ мөн аудитын сэдвүүдийн сонголт нь засгийн газрыг бүхэлд нь тэнцвэртэй хамруулах зэрэг АДБ-д нь байж болох аливаа үрт хугацааны стратегитай тохирч буй эсэхийг бодолцож үзэхийг хүсэж болно. АДБ нь мөн нэг том сэдвийг хэд хэдэн тайланд оруулахыг зорьж болно. Тухайлбал, улс орнууд ТХЗ-ыг хэрэгжүүлж эхлэх үед Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Байгууллага (АДБОУБ) болон Нэгдсэн Үндэстний Байгууллага хоёр хоёулаа АДБ-ыг ТХЗ-ыг хэрэгжүүлэх бэлэн байдалд аудит хийж, ахицыг тандан судлах замаар ТХЗ-2030 Хөтөлбөрийн амжилтад хувь нэмэр оруулж болно гэж онцлон чухалчилсан билээ. Үр нөлөөтэй ингэхийн тулд АДБ-ууд нь, тухайлбал, цагаа олсон зөвлөмж бүхий цуврал гүйцэтгэлийн аудитын тайлангуудыг гаргаж болно.

¹² ХЭЗМ (RACI=Responsible, Accountable, Consulted, Informed) шинжилгээ гэдэг нь аливаа багц үйл ажиллагааны хувьд хэн Хариуцах вэ, хэн Эгэх хариуцлага хүлээх вэ, хэнтэй Зөвлөлдөх вэ, мөн хэнд Мэдээлэх вэ гэдгийг тодорхойлох хэрэгсэл юм.

АДБ-үүд гүйцэтгэлийн аудитын сэдвийг сонгохдоо ямар шалгуур ашигладаг вэ?



Стандарт

Аудитор нь ач холбогдолтой бөгөөд аудит хийх боломжтой, мөн АДБ-ын бүрэн эрхэд нийцсэн аудитын сэдвүүдийг сонгох ёстой.

Аудитор нь аудитын чадавхыг бодолцож үзэнгээ аудитын хүлээгдэж буй нөлөөллийг хамгийн их байлгах зорилгоор аудитын сэдэв сонгох үйл явцыг хэрэгжүүлэх ёстой.

Эх сурвалж: АДБОУС-3000/90-91.

Аудитын боломжит сэдвүүдийг тодорхойлсны дараа, АДБ нь цаг хугацаа болон нөөцөө үр ашигтай бөгөөд үр нөлөөтэйгөөр хуваарилахын тулд тэдгээрийг ач холбогдлоор нь эрэмбэлдэг. Гүйцэтгэлийн аудитын сэдвийг сонгохын тухайд АДБОУС-3000-д АДБ нь дараах зүйлсийг харгалзаж үзэх ёстой гэж заасан байдаг:

- Судлах сэдэв/ зүйлийн ач холбогдол (санхүү, нийгэм болон улс төрийн гэх мэт);
- Сонгосон сэдвээр аудит хийх боломж;
- АДБ-д аудит хийх нөөц болон үр чадвар байгаа эсэх;
- Аудитын сэдэв нь АДБ-ын бүрэн эрхтэй нийцэх эсэх; мөн
- Аудитын нөлөөллийг (санхүүгийн болон бусад) хэрхэн хамгийн их байлгах арга замууд.

АДБ сэдэв сонгох шалгуур болон горимоо АДБОУС-үүдын шаардлагын дагуу боловсруулж болно. Ингэх хоёр арга буюу оноо өгөх хүснэгт болон товч хураангуйг харьцуулах аргуудыг доор тайлбарлав.

Аудитын сэдэв сонгоход оноо өгөх хүснэгт ашиглах нь

Оноо өгөх хүснэгт нь мэргэжлийн үнэлэмжид тулгуурлан өгөх оноог аудитын боломжит сэдвүүдийн нэг индикатор гэж үздэг. АДБ нь сэдэв сонгох шалгуураа сонгосны дараа уг шалгуураараа аудитын боломжит сэдэв тус бүрд оноо өгдөг.

11-р зурагт үзүүлсэн сэдэв сонгох шалгуурууд нь аудитын хамгийн боломжит сэдвүүдийг эрэмбэлж, сонгоход харгалзан үзэж болох жишээнүүд юм. Энд авч үзсэн шалгуурууд нь бүрэн жагсаалт биш бөгөөд бүх АДБ-д тохиромжтой байх албагүй гэдгийг анхаарна уу. Шалгуур тус бүрийн харьцангуй ач холбогдол нь АДБ тус бүрийн үйл ажиллагаа явуулж буй өвөрмөц орчин нөхцөл болон хам нөхцөлөөс шалтгаална.

Зураг 11: Аудитын сэдэв сонгох шалгуурын жагсаалт

Материаллаг байдал	Аливаа асуудлыг авч үзэж буй хам нөхцөл дэх тухайн асуудлын харьцангуй ач холбогдол. Материаллаг байдалд мөнгөн үнэ цэнээс гадна нийгмийн болон улс төрийн ач холбогдол, нийцэл, ил тод байдал, засаглал болон эгэх хариуцлага зэргийг оруулна.
Аудит хийх боломж	Энэ сэдвээр аудит хийж болох уу? Аудит нь практикт бодитоор хийгдэх үү? АДБ-ын хууль ёсны бүрэн эрхэд хамаарах үү? АДБ-д энэ сэдвээр аудит хийх нөөц чадавч байгаа юу (тухайлбал, энэ аудитын сэдвийг ойлгодог экспертүүдийг олж чадах уу)?
Боломжит нөлөөлөл	Энэ сэдэв нь засгийн газрын ажил хэргийн арвилан хэмнэлт, үр ашигтай байдал болон/эсвэл үр нөлөөтэй байдлыг сайжруулахад ихээхэн нөлөөлөх үү?
АДБ-д учрах эрсдэл	Энэ аудитын сэдвийг судлахгүй бол стратегийн эсвэл нэр хүндийн эрсдэл үүсэх үү?
Хууль тогтоох засаглал эсвэл олон нийтийн ашиг сонирхол	Энэ сэдвээр аудит хийх нь хууль, эрх зүйн асуудлыг шийдвэрлэх эсвэл олон нийтэд давуу талтай байдал үүсгэх үү? Тухайлбал, энэ аудит нь хүртээмжтэй байдлыг дэмжих үү?
Хамаарал	Энэ сэдэв нь бодит ертөнцийн асуудлууд, өдөр тутмын үйл явдлууд эсвэл нийгмийн өнөөгийн байдалд тодорхой хэмжээгээр нөлөөлөх эсвэл ач холбогдолтой байх үү?
Цаг үетэйгээ тохирох байдал	Энэ сэдвээр аудит хийх зөв эсвэл тохиромжтой цаг мөн үү? Тухайлбал, шинэ үйл ажиллагааны ахицыг судлахад хэт эртдэх үү?
Өмнөх аудитын ажил	Энэ сэдвээр өнгөрсөн үед аудит хийж байсан үү? Дахин аудит хийх хэрэгцээ байна үү? Ашиглаж болон аудитын шинэ арга хандлага байна үү?
Төлөвлөгдсөн эсвэл хэрэгжиж буй бусад томоохон ажил	Энэ сэдвээр өөр ажил төлөвлөгдсөн эсвэл хэрэгжиж байгаа юу?
Гүйцэтгэлийн аудит хийлгэх хүсэлт	Гүйцэтгэлийн аудит хийлгэх ямар нэгэн тусгай хүсэлт ирсэн үү? Хүсэлт илгээсэн эх сурвалжийг харгалзан үзэж, ач холбогдлыг нь тодорхойлох хэрэгтэй. Тухайлбал, парламент, үр шим хүртэгчид эсвэл бусад гадаад оролцогч талуудаас ирүүлсэн хүсэлт гэх мэт.

Эх сурвалж: АДБОУБХС/ГАДХ-ны Хөгжлийн Баг.

Дээр авч үзсэн шалгууруудад үндэслэн аудитын боломжит сэдвүүдийг ач холбогдлоор нь эрэмбэлж болно. Сэдэв сонгох явцад мэргэжлийн үнэлэмжээ ашиглах шаардлагатай гэдгийг онцгойлон чухалчлах хэрэгтэй. 4-р хавсралтад аудитын сэдэв сонгох хүснэгтийг ашигласан аудитын сэдэв сонголтын жишээг үзүүлэв. Уг жишээнд харуулсан тоон оноонууд нь аудит хийх чухал сэдвүүдийг илрүүлэхэд туслах хэрэгсэл болох боловч таны мэргэжлийн үнэлэмжийг орлохгүй гэдгийг мартаж болохгүй.

Аудитын боломжит сэдэв тус бүрийн товч хураангуйг харьцуулах нь

Энэ арга хандлага нь оноо өгөх системийг ашигладаггүй. Харин, аудитын баг нь стандарт маягт ашиглан аудитын боломжит сэдвүүдийн энгийн, товч хураангуйг бэлддэг. Дараа нь дээд удирдлагууд хувилбар тус бүрийг хялбархан нягталж, аль нь стратегийн тэргүүлэх зорилгуудтай нь тохирч буйг судалдаг. Хураангуйг хэрхэн ашиглаж болохыг 12-р зурагт үзүүлэв.

Зураг 12: Аудитын сэдвийн хураангуйн жишээ

Нэр	Хог хаягдлын менежмент
Хам нөхцөл (хам сэдэв)	Хатуу хог хаягдлын менежмент бол иргэдийн хувьд амьдралын чанар хийгээд эрүүл мэндийн амин чухал сэдэв юм. Засгийн газар энэ асуудалд улам бүр их хөрөнгө зарцуулж, ихэвчлэн хувийн хэвшлийн үйлчилгээ үзүүлэгчидтэй хамтран ажиллаж байна.
Үндэслэл	АДБ энэ сэдвийг сүүлийн 8 жил судлаагүй. Засгийн газар саяхан улсын секторын бусад гэрээт үйлчилгээгээ муу гүйцэтгэсэн, санхүүгийн хувьд сул байгаа компаниас ирэх 5 жилийн хугацаанд өндөр дүнтэй гэрээт үйлчилгээ авахаар болсон.
Аудитаар юунд хүрч болох вэ?	Яам хувийн секторын нийлүүлэгчидтэй байгуулсан гэрээнээсээ сайн үнэ цэн авч чадаж буй эсэхийг аудитаар судалж, ирээдүйд хэрэгтэй чухал сургамжийг тодорхойлно. Тухайлбал, худалдан авах ажиллагааны үйл явцын үр ашигтай байдлыг судална. Эрт арга хэмжээ авах нь иргэдэд ирэх эрүүл мэндийн үр дүнг мөн сайжруулахад хүргэж магадгүй.
Гол эрсдэлүүд	<ul style="list-style-type: none">Манай аудит шинэ гэрээний мөчлөгийн хэт эрт үед тохиож байна гэж харагдаж магадгүй.Манай арилжааны гэрээний мэргэжилтнүүд нэг жилийн гэрээтэй ажиллаад ажлаас гардаг тул аудитад туслах боломжгүй болдог.Бид яаман дээр хэдийнээ хоёр аудит төлөвлөсөн байгаа. Иймд тэд аудитын ачаалал хэт их байна гэж бодож магадгүй.Бид гүйцэтгэлээ жишиж болох олон улсын итгэлтэй харьцуулах зүйлийг олох шаардлагатай.Гүйцэтгэлийг үнэлэх үед үйлчилгээний "шударга" үнэ ямар байхыг тооцоолох нь бэрхшээлтэй байж магадгүй. Учир нь яам энэ үйлчилгээг дотооддоо үзүүлж байгаагүй. Өмнө дурдсанчлан, бид тохиромжтой олон улсын харьцуулах зүйлийг олох шаардлагатай.Үйлчилгээний доголдоос үүсэх нийтийн эрүүл мэндийн өртгийг тооцоолох үед бид хог хаягдлын муу менежмент болон үндэсний хэмжээний өвчлөлийн түвшин хоорондын учир шалтгааны шууд холбоог нотлох баттай нотлох зүйлсээр хангах шаардлагатай болно. Бид өвчлөл нэмэгдэхэд хувь нэмэр оруулсан бусад хүчин зүйлсийн талаар маш сэрэмжтэй байх хэрэгтэй.
Нийтийн Дансны Хороо/ Парламентын ашиг сонирхол	Парламент энэ сэдвийг маш их сонирхож байгаа. Парламентын хэд хэдэн гишүүд өнөөгийн тогтолцоо муу байгаа бөгөөд сонгогчдоос хог хаягдлын үйлчилгээ муу байна, амин чухал засваруудыг хийж чадахгүй гэсэн гомдол үе үе ирж байгаа талаар сүүлийн үед хэлэх болсон.
Гарцын төрөл	Гүйцэтгэлийн аудит
Ойролцоо төсөв	300,000 ам.доллар
Ойролцоо хугацаа	Аудит нь 9 сар үргэлжилж, 2020 оны 9-р сард тайлангаа гаргана.

Эх сурвалж: АДБОУБХС/ГАДХ-ны Хөгжлийн Баг.

Замби улсын АДБ – Эрсдэлийн үнэлгээг жилийн төлөвлөлтөд ашиглах нь

- ✓ Боломжит сэдвүүдийг шинжилж, судалгаа хийж, АДБ-ын стратегийн төлөвлөлтийн үйл явцаар дамжуулан аудитын сэдвийг сонгох;
- ✓ Аудитын сэдвүүдийг ач холбогдолтой, аудит хийх боломжтой, АДБ-ын бүрэн эрхэд нийцсэн байлгах;
- ✓ АДБ-ын аудит хийх чадавхыг харгалзаж үзэнгээ нөлөөллийг хамгийн их байлгах аудитын сэдвийг сонгох;
- ✓ Аудитын хамгийн тохиромжтой сэдвийг сонгохын тулд аудитын орчныг тандахдаа олон эх сурвалжийн мэдээллийг ашиглах; мөн
- ✓ Аудитын сэдвүүдийг үнэлж, сонгоход тань туслах тохиромжтой шалгууруудыг ашиглах.

Эх сурвалж: АДБОУБХС/ГАДХ-ны Хөгжлийн Баг.

4-р бүлэг

Гүйцэтгэлийн аудитыг хэрхэн загварчлах вэ?



Аудитыг загварчлах нь

- Аудитын сэдвийг илүү сайн ойлгохын тулд **урьдчилсан судалгаа** хийх.
- Аудит хийх шалтгааныг тодорхойлсон зорилго(ууд)ыг боловсруулах.
- Аудитын **арга хандлагыг** тодорхойлох.
- Аудитын тухайлсан талбаруудыг чиглүүлэх **аудитын асуултуудыг** боловсруулах.
- Аудитад шалгагдагч этгээдийн гүйцэтгэлийг байвал зохих байдалтай тулган хэмжих аудитын тохиромжтой **шалгууруудыг** тодорхойлох.
- Мэдээлэл цуглуулж, шинжлэх ажлыг чиглүүлэх **арга зүйг** боловсруулах.
- Хүснэгт зэргээр аудитын загварыг **баримтжуулж**, төслийн хуваарь гаргах.

Аудитын сэдвийг сонгосны дараа хийх аудитын төлөвлөлтийн хоёр дахь алхам бол аудитыг загварчлах алхам юм. Аудитын загварчлал нь гүйцэтгэлийн аудитыг бүрэн болгоход чухал алхам бөгөөд АДБ-ын чанарын хяналтын хүрээг хэрэгжүүлэхийн амин чухал бүрэлдэхүүн хэсэг нь болдог. Мөн, аудитын загварчлал нь аудитын ажлаа бүрэн болгоход шаардлагатай мэдлэгийг олж авахад тусалдаг тул гүйцэтгэлийн аудитын хамгийн чухал хэсгүүдийн нэг юм.



Стандарт

Аудитор нь аудитыг төлөвлөхдөө арвилан хэмнэлтэй, үр ашигтай, үр өгөөжтэй, цаг хугацаандаа хийгддэг өндөр чанартай аудитад хувь нэмэр оруулах байдлаар, төслийн сайн удирдлагын зарчмуудын дагуу төлөвлөх ёстой.

Эх сурвалж: АДБОУС-3000/96.

Үр нөлөөтэй загварчлал нь аудитын төрөл, цаг хугацааны хуваарь, нөөцийн шаардлагууд (хүн ба санхүү), аудитын сэдвийн тойм, хамрах хүрээ (болон хязгаарлалтууд), зорилго(ууд), асуултууд, шалгуурууд, эрсдэлүүд болон арга зүйг агуулсан аудитын дэлгэрэнгүй төлөвлөгөө бичиж, аудитыг бүрэн болгох стратегийг боловсруулахаас бүрдэнэ. Аудитын сайн төлөвлөгөө боловсруулах нь гүйцэтгэлийн аудитын арвилан хэмнэлт, үр ашигтай байдал болон үр нөлөөтэй байдлыг үнэлэх үндэс суурийг тавихад асар чухал үүрэгтэй.

Энэ бүлэгт тайлбарласанчлан, аудитын загварчлалд дэс дараалсан олон алхам багтана. Гэвч, аудитын түршид өөрчлөгдөж буй мэдээлэл, нөөц болон цаг хугацааны хуваарьтай уялдуулж загварчлалын хэсгүүдийг эргэн харж байх хэрэгтэй.

Тус бүлэг нь дараах асуултуудад хариулах болно:

- Аудитын сэдвийн урьдчилсан судалгааг хэрхэн хийх вэ?
- Гүйцэтгэлийн аудитын арга хандлагыг хэрхэн тодорхойлох вэ?
- Аудитын зорилго(ууд)ыг хэрхэн боловсруулах вэ?
- Аудитын асуултуудыг хэрхэн боловсруулах вэ?
- Аудитын хамрах хүрээг хэрхэн тодорхойлох вэ?
- Аудитын шалгуурыг хэрхэн сонгох вэ?
- Аудитын арга зүйг хэрхэн боловсруулах вэ?
- Аудитыг загварчлах үеийн эрсдэлийг хэрхэн удирдах вэ?
- Гүйцэтгэлийн аудитад шаардлагатай хугацаа болон нөөцийг хэрхэн тодорхойлох вэ?
- Аудитын төлөвлөгөөг хэрхэн баримтжуулах вэ?
- Гүйцэтгэлийн аудитыг загварчлах үед дотоод болон гадаад оролцогч талууд болон удирдлагыг хэрхэн оролцуулах вэ?

Аудитын сэдвийн урьдчилсан судалгааг хэрхэн хийх вэ?



Стандарт

Аудит нь зохистойгоор төлөвлөсөн гэдгийг нягтлахын тулд, аудитор нь шалгах хөтөлбөр эсхүл шалгагдагч байгууллагын үйл ажиллагааны талаар хангалттай мэдлэгийг аудит хийж эхлэхээс өмнө олж авах ёстой. Тиймээс, аудит эхлэхээс өмнө мэдлэгтэй болохын тулд олон төрлийн аудитын загварыг туршиж болон шаардлагатай мэдээлэл байгаа эсэхийг шалгаж судалгааны ажил явуулах шаардлагатай байдаг. Энэхүү бэлтгэл ажлыг урьдчилсан судалгаа гэж нэрлэж болно.

Эх сурвалж: АДБОУС-3000/99.

Аудиторын хувьд, та аудитаа зохистой зохиомжлоход шаардлагатай алхмуудыг авч хэрэгжүүлэх хэрэгтэй. Ингэхийн тулд, та аудитын сэдэв болон аудитад шалгуулагч этгээдийн бизнесийн талаар мэдээлэл цуглуулах шаардлагатай. Мэдлэг хуримтлуулж, аудитын боломжит зохиомжуудын талаар бодож, тухайн сэдвээр аудит хийх боломжтой эсэхийг үнэлэх замаар аудитын бэлтгэл ажлыг эхлүүлж болно. Танай АДБ аудитын сэдвийг сонгохдоо (3-р бүлэгт хэлэлцсэнчлэн) уг сэдвээр аудит хийх боломжтой эсэхийг хэдийнээ харгалзан үзсэн ч гэсэн, орчин нөхцөл өөрчлөгдсөн байж болно. Эсвэл, та бэлтгэл ажлынхаа эцэст өөр дүгнэлтэд хүрсэн байж болно. Энэхүү бэлтгэл ажлыг урьдчилсан судалгаа гэж нэрлэж болно. Урьдчилсан судалгааны үеэр амжилттай аудит хийх нөхцөл оршин байгаа эсэхийг тогтоохыг зорьдог.



Дотоод хяналт бол аливаа байгууллагад үйл ажиллагаагаа үр ашигтай бөгөөд үр нөлөөтэй явуулж, үйл ажиллагааныхаа талаар найдвартай мэдээлэл тайлагнаж, холбогдох хууль, журам, зохицуулалтуудад нийцэхэд тусалдаг үйл явц юм.

Эх сурвалж: АДБОУБХС/ГАДХ-ны ХБ.

Тодруулбал, аудитын сэдэв сонгох үе шатны үед үнэлсэнчлэн, та тухайн аудитыг АДБ-ын стратегийн зорилгуудад үнэ цэн нэмэхүйц; дотоод хяналтыг бэхжүүлснээр аудитын сэдвийн арвилан хэмнэлт, үр ашигтай байдал болон үр нөлөөтэй байдлыг сайжруулахүйц; мөн залилан, үргүй зарлага болон урвуулан ашиглалтыг илрүүлэхүйц хэвээр байгаа эсэхийг тогтоох шаардлагатай болно. Түүнчлэн, аудитаар шалгах гүйцэтгэлийн сул тал буюу асуудлын талаар ойлголттой болох нь чухал. АДБ-ууд урьдчилсан судалгааг өөр өөрөөр хийдэг. Зарим нь аудитыг зохиомжлохын өмнө хийх бүрэн

хэмжээний судалгаа болгож хийдэг байхад бусад нь аудитыг загварчлах үе шатны нэг хэсэг болгож үздэг. Та урьдчилсан судалгаа хийхдээ АДБ-ын арга хандлагыг дагах хэрэгтэй.

Чухал ач холбогдолтой аудитын асуудлыг илрүүлэхэд дөхөм болгохын тулд болон аудитын үүрэг хариуцлагыг биелүүлэхийн тулд шалгах хөтөлбөр болон шалгагдагч байгууллагын үйл ажиллагаа, мөн түүний нөхцөл байдал ба болзошгүй нөлөөллийн талаар зөв ойлголттой болох нь чухал. Гүйцэтгэлийн аудит гэдэг нь арга зүйн дасан зохицлыг хамардаг сурах үйл явц бөгөөд аудитын нэг хэсэг юм. (АДБОУС-3000/100).

Энэхүү урьдчилсан судалгааг АДБ-ын үйл явцуудад нийцсэн бөгөөд зохих ёсоор баримтжуулагдсан байдлаар гүйцэтгэх ёстой.

Аудитыг амжилттай хийх нөхцөл оршин буй эсэхийг тогтоохын тулд та аудитын сэдэв сонгох үедээ гүйцэтгэсэн ажилдаа тулгуурлах хэрэгтэй. Өөрөөр хэлбэл, танд дараах зүйлсийг ойлгох боломж олгох нэмэлт мэдээлэл цуглуулах хэрэгтэй:

- Байгууллагын бүтэц, үүрэг, функц, оролцогч талууд, үйл ажиллагаа болон үйл явцууд, нөөц болон чиг хандлагууд;
- Байгууллагын зорилгууд;
- Хэрэгжиж буй дотоод хяналтууд;
- Нягтлагдаж буй байгууллага болон хөтөлбөрт нөлөөлөх дотоод болон гадаад орчны хүчин зүйлс;
- Гарц болон үр дүнг бий болгоход нөлөөлж буй гадаад хязгаарлалтууд;
- Нягтлагдаж буй байгууллага болон хөтөлбөрийн сайн ажиллаж байгаа болон сайн ажиллахгүй байгаа зүйлс;
- Гүйцэтгэлийг үнэлэх бэлэн байгаа эсвэл боловсруулж болох шалгуурууд; мөн
- Үйл ажиллагаанууд нөлөөлөлд өртөгч бүх талуудыг хамруулж буй хэр хэмжээ.

Эдгээр мэдээллийг аудитын үйл явцын туршид цуглуулах шаардлагатай боловч энэ бүх суурь мэдээллийн ихэнхийг нь аудитыг зохиомжлох болон гүйцэтгэх үе шатанд цуглуулсан байх ёстой байдаг. Та болон танай аудитын баг эдгээр мэдээллийг олж авахын тулд ашиглах мэдээлэл цуглуулах аргаа уян хатан бөгөөд прагматик байлгах шаардлагатай. Урьдчилсан судалгааг гүйцэтгэхэд та олон янзын эх сурвалжаас мэдээлэл цуглуулах магадлал өндөр. Тэдгээрийн жишээг 13-р зурагт үзүүлэв.


Зураг 13: Мэдээллийн эх сурвалжууд



Эх сурвалж: АДБОУБХС/ГАДХ-ны Хөгжлийн Баг.

Урьдчилсан судалгааны үеэр танай баг хараат бус байдлаа баримтжуулж, АДБ-ын дотоод болон гадаад оролцогч талуудтай зохих хэмжээнд шүүд хамтран ажиллаж эхлэх нь мөн чухал. Үр нөлөөтэй ингэхийн тулд, оролцогч талуудын шинжилгээгээ гүйцээх шаардлагатай болж болно. Тэгснээр дотоод оролцогч талууд (тухайлбал, хуулийн экспертүүд, арга зүйчид болон техникийн экспертүүд), тэдгээрийн үүрэг болон ашиг сонирхол, тэдний аудитад оролцох хэмжээний таамаг, мөн тэд өгөх мэдээллээрээ хэр чухал байх вэ гэдгийг тодорхойлж чадна. Үүнийг танай байгууллагаас гадуурх, салбарын бүлэг, холбоод болон экспертүүд зэрэг гадаад оролцогч талуудын хувь ч хийх шаардлагатай болж болно. Эдгээр шинжилгээний жишээг 5-р хавсралтаас үзнэ үү.

Дотоод оролцогч талуудыг тодорхойлсны дараа, зарим АДБ тэдгээрийг цуглуулж анхны уулзалтад оролцуулдаг. Энэ уулзалтын үеэр аудитдаа ашиглах боломжит арга хандлагууд, аудитын зорилго(ууд), аудитын асуултууд, зохиомжийн хувилбарууд болон аудитын сэдвийн талаар мэдэх боломжит хүмүүстэй холбоо барих мэдээллийг оролцогч талуудтайгаа хэлэлцэнэ. Энэ уулзалтыг хийсэн тохиолдолд, уулзалтын хэлэлцүүлгийг дэмжих үүднээс оролцогч талуудыг баримт бичгээр урьдчилан хангах эсэхийг бодолцож үзэж болно. Тухайлбал, аудит нь нарийн төвөгтэй эсвэл шинэ асуудал буюу судлах сэдэв/ зүйлтэй холбогдох бол, аудитын баг нь уулзалтын оролцогчдод туслах үүднээс нэмэлт материал эсвэл суурь мэдээллээр хангах хэрэгтэй гэж шийдэж болно. Энэ уулзалтыг урьдчилсан судалгааны үеэр зохион байгуулснаар оролцогч талууд нь танай аудитын хамрах хүрээ болон арга зүйг боловсруулахад илүү сайн хувь нэмэр оруулж чадна гэсэн үр дүн гарч магадгүй. Уулзалтын үеэр гаргасан гол шийдвэрүүдээ баримтжуулж, аудитын файлдаа хадгалах нь маш чухал.

 Хуулийн экспертүүд, эдийн засагчид болон техникийн мэргэшилтэй хувь хүмүүс зэрэг дотоод оролцогч талуудыг аудитын эхэн үед оролцуулснаар та өгөгдөл, мэдээллийн эх сурвалж, холбоо барих хүмүүс болон аудитаа төлөвлөхөд тань туслах арга зүйнүүдийг шуурхай тодорхойлох боломжтой болж чадна. Танай баг эдгээр оролцогч талуудтай уулзах үед гаргасан гол шийдвэрүүдээ баримтжуулж, аудитын файлдаа хадгалах нь маш чухал.

Эх сурвалж: АДБОУБХС/ГАДХ-ны ХБ.



Аудитад шалгуулагч этгээдтэй хийх анхны уулзалтууд нь танд тэдний албан тушаалтнуудын мэргэшилд тулгуурлан холбогдох мэдээллийг шуурхай олж авч, аудитынхаа зорилго(ууд), хамрах хүрээ болон арга зүйг нарийвчлан сайжруулах боломж олгодог. Уулзалтын үеэр хүрсэн гол шийдвэрүүдээ танай аудитын баг баримтжуулан авч, аудитын файлдаа хадгалах нь маш чухал.

Эх сурвалж: АДБОУБХС/ГАДХ-ны ХБ.

Аудитын баг нь өгөгдөл, мэдээлэл цуглуулж эхлэхээсээ өмнө аудитад шалгуулагч этгээдтэй уулзах нь чухал. Аудитад шалгуулагч этгээдтэй уулзах анхны уулзалтын үеэр танай баг ажлынхаа шалтгааныг хэлэлцэж, шалгуулагч талын албан тушаалтнуудад багаа танилцуулж, аудитын мэдээллийн хэрэгцээ шаардлагаа мэдүүлж, ажлаа гүйцэтгэх оффис болон талбаруудын байршлын таамгаа мэдээлэх зэрэг олон зүйлийг хэлэлцэж болно. Урьдчилсан судалгааны үеэр аудитад шалгуулагч этгээд албан тушаалтнуудтай уулзах нь аудитын сэдвээр аудит хийж болох эсэхийг, мөн аудитыг амжилттай хийх нөхцөл оршин буй эсэхийг тодорхойлоход шаардлагатай мэдээллийг олж авах чадварыг тань нэмэгдүүлнэ. Эдгээр

уулзалтууд нь мөн танай аудитын багт албан тушаалтнуудын харах өнцөг болон саналыг аудитын эхэн үед сонсож, харгалзан үзэх боломжийг олгодог. Анхны уулзалтын нэгэн адил, энэ уулзалтын үр дүн болон хэлэлцүүлгийн үеэр танай аудитын багийн хүрсэн гол шийдвэрүүдийг баримтжуулах нь чухал. 5-р хавсралтаас энэ төрлийн уулзалтыг чиглүүлэхэд ашиглах хөтөлбөрийн жишээг үзнэ үү.

Урьдчилсан судалгаа хийх үедээ хэрэгжүүлж болох алхмууд

- ✓ Танай АДБ-аас уг сэдвээр хийсэн өмнөх ажлуудыг нягталж, аудитад шалгуулагч этгээдийн гаргаж өгсөн бодлого, гүйцэтгэлийн тайлан зэрэг баримт бичгүүдийг нягтлах замаар суурь мэдээллийн судалгаа хийх.
- ✓ Аудитын сэдвээр туршлагатай зөвлөхүүд болон гаднын байгууллагуудтай зөвлөлдөх. Үүнд, Нэгдсэн Үндэстний Байгууллага, хандивлагч байгууллагууд, иргэний нийгмийн байгууллагууд, төрийн бус байгууллагууд болон тусгай мэргэшил бүхий бусад этгээдүүд багтаж болно.
- ✓ Аудитын сэдэвтэй холбогдох асуудлуудаар гаргасан хэвлэл мэдээллийн тайлангуудыг шинжлэх.
- ✓ Засгийн газрын холбогдох санаачилгуудыг нягталж, тэдгээрийн зорилго, арга хандлага болон санхүүжилтийг ойлгох.
- ✓ Хариуцах агентлагуудаас нь бэлтгэсэн хөтөлбөрийн гүйцэтгэл болон эгэх хариуцлагын тайлангуудыг нягтлах. Энэ нь аудитын багт уг агентлагуудын чиг үүргийн болон санхүүгийн дэлгэрэнгүй мэдээллийг ойлгож, гол анхаарах ёстой талбаруудыг илрүүлэхэд тусална.
- ✓ Гол дотоод оролцогч талуудтай анхны уулзалт хийж, боломжит арга хандлагууд, судалгааны асуултууд, загварын хувилбарууд болон аудитын сэдвийн талаар мэдлэгтэй хүмүүстэй холбоо барих мэдээллийг хэлэлцэх.
- ✓ Аудитад шалгуулагч этгээдтэй уулзалт хийж, мэдээллийн хэрэгцээгээ хэлэлцэж, тухайн сэдвээр аудит хийх боломжтой эсэх, мөн амжилттай аудит хийх нөхцөл оршин буй эсэх талаарх ойлголтоо сайжруулах.

Гүйцэтгэлийн аудитын арга хандлагыг хэрхэн тодорхойлох вэ?



Стандарт

Аудитор нь үр дүнд, асуудалд эсвэл тогтолцоонд чиглэсэн арга хандлага, эсвэл тэдгээрийн хослолыг сонгох ёстой.

Эх сурвалж: АДБОУС-3000/40.

Аудитын арга хандлага нь ерөнхийдөө ямар ч аудитын төв бүрэлдэхүүн болдог бөгөөд аудитын зорилго(ууд) болон аудитын асуултууд хоорондын чухал холбоос юм. Гүйцэтгэлийн аудитыг гүйцэтгэх гурван нийтлэг арга хандлага бий. Тэдгээр нь, үр дүнд, асуудалд, мөн тогтолцоонд чиглэсэн арга хандлагууд юм. Аудитын зорилго(ууд) болон аудитын асуултуудаа боловсруулах үедээ эдгээр арга хандлагуудаас нэгийг эсвэл хослуулж ашиглах эсэхээ бодолцон үзэх нь чухал.

Үр дүнд чиглэсэн аудитын арга хандлага нь үр дүн эсвэл гарцын зорилгууд биелсэн эсэхийг, эсвэл үйлчилгээ анх зохиомжилсон шигээ ажиллаж буй эсэхийг үнэлдэг. Энэ арга хандлагын хувьд, илрүүлэлтүүдийг гүйцэтгэлийн шалгуураас зөрсөн хазайлт хэлбэрээр илэрхийлдэг. Таны зөвлөмж эдгээр хазайлтуудыг шалтгаан(ууд)ыг нь арилгах замаар залруулахад чиглэх болно. Үр дүнд чиглэсэн арга хандлагын хувьд, та арвилан хэмнэлт, үр ашигтай байдал болон үр нөлөөтэй байдлын гүйцэтгэлийг судалж, ажиглалтуудаа ерөнхий зорилго, зорилго, зохицуулалт эсвэл аудитын шалгууртай холбоно. Шалгуурыг тодорхойлоход хэцүү байвал, найдвартай шалгуур боловсруулахын тулд экспертүүдтэй хамтран ажиллах шаардлагатай болж болно.



Үр дүнд чиглэсэн арга хандлага нь дараахтай адил асуултуудад хариулт эрдэг:

- Ямар үр дүнд хүрсэн бэ?
- Аудитад шалгуулагч этгээд зорилгодоо хүрсэн үү?

Эх сурвалж: АДБОУБХС/ГАДХ-ны ХБ.



Асуудалд чиглэсэн арга хандлага нь дараахтай адил асуултуудад хариулт эрдэг:

- Асуудлын шалтгаанууд юу вэ?
- Засгийн газар энэ асуудлыг хэр хэмжээнд шийдвэрлэж чадах вэ?

Эх сурвалж: АДБОУБХС/ГАДХ-ны ХБ.

Асуудалд чиглэсэн аудитын арга хандлага нь ерөнхийдөө аудитын явцад нарийвчлан тулган баталгаажуулах шаардлагатай эсвэл шаардлагагүй анхан шатны асуудлаас эхэлдэг. Иймд энэ арга хандлага нь гүйцэтгэлийн асуудлуудын шалтгааныг тулган баталгаажуулах болон шинжлэхийг онцгойлон чухалчилдаг. Аливаа асуудлаар тодорхой нэгдсэн ойлголт байгаа үед, хүсэж буй үр дүн эсвэл гарцын талаар тодорхой мэдэгдэл байхгүй байсан ч, энэ арга хандлагыг

ашиглаж болно. Хэрэв та энэ арга хандлагыг ашиглавал, илрүүлсэн асуудалд тодорхой хүчин зүйлс хэрхэн хувь нэмэр оруулж буйг үнэлэх боломжоор таныг хангах шалгууруудыг ашиглаж шинжлэн, баталгаажуулах үйл явцад суурилж дүгнэлтүүд болон зөвлөмжүүдээ гаргана. Асуудалд чиглэсэн аудитын арга хандлагыг ашиглах үед хийх ёстой гол ажил нь асуудлын учир шалтгааныг олон өнцгөөс шинжлэх юм.

Тогтолцоонд чиглэсэн аудитын арга хандлага нь удирдлагын тогтолцоонуудын зүй зохистой ажиллагааг шалгадаг. Энэ арга хандлагыг ашигласан тохиолдолд, аливаа асуудлаар тодорхой нэгдмэл санаа дутагдалтай эсвэл үр дүн болон гарцыг сайн тодорхойлоогүй үед ч, гүйцэтгэлийн жишгүүд болон сайн удирдлагын зарчмууд нь арвилан хэмнэлт, үр ашигтай байдал болон үр нөлөөтэй байдлын нөхцөлийг үнэлэх сайн шалгуур болж болно. Тайлангийн хэрэглэгчдэд удирдлагын тогтолцооны гүйцэтгэлийн сул талуудыг сайтар ойлгуулахын тулд уг сул талуудын шалтгааныг тогтоож, үйл ажиллагаанд хэрхэн нөлөөлж буйг



Тогтолцоонд чиглэсэн арга хандлага нь дараахтай адил асуултуудад хариулт эрдэг:

- Хувь хүмүүсийн үүрэг, хариуцлагууд юу вэ?
- Хамааралтай ямар мэдээлэл байна вэ?
- Сайн чанартай хяналт-шинжилгээний тогтолцоо байна уу?
- Үйл явцуудыг мөчлөгтэй бөгөөд зохистойгоор үнэлж байна уу?

Эх сурвалж: АДБОУБХС/ГАДХ-ны ХБ.

нь үндэслэлтэйгээр нотлон харуулах нь чухал. Сайн ашигласан тохиолдолд энэ төрлийн аудит нь үйл ажиллагаа хэр хэрэгжиж буйг, аливаа сул талын учир шалтгааныг, мөн юмсыг сайжруулж болох хэр хэмжээг тодорхойлох олон төрлийн асуултад хариулахыг зорьдог.

АДБОУС-3000/40-д заасанчлан аудитын арга хандлагуудыг хослуулан ашиглах нь мөн боломжтой юм. Тухайлбал, ТХЗ-ын хэрэгжилтэд хийх аудитад үр дүн болон тогтолцоонд чиглэсэн аудитын арга хандлагыг хослуулан ашиглаж болно. Иймд аудит нь Засгийн Газрыг Бүхэлд нь Хамруулах (ЗГБХ) арга хандлагыг ашигладаг.

ЗГБХ арга хандлага нь засгийн газрын гүйцэтгэлийн фокусыг засгийн газрын буюу аливаа ганц хөтөлбөр, агентлаг эсвэл байгууллагын үйл ажиллагаа бус, харин нийгмийн асуудал, сорилтыг даван туулж хүрэхийг зорьж буй үр дүнд чиглүүлдэг. Энэ тохиолдолд нөхцөл байдал 14-р зурагт үзүүлсэн шиг болно.¹³

Зураг 14: Нэгээс олон этгээдэд аудит хийх үеийн харилцаа хамаарал



Эх сурвалж: ТХЗ-ын хэрэгжилтэд хөндлөнгийн аудит хийхэд анхаарах зарим зүйлс (Le Blanc, David ба Montero, мөн Aránzazu Guillán, 2020).

Аудитын зорилго(ууд)ыг хэрхэн боловсруулах вэ?



Стандарт

Аудитор нь арвилан хэмнэлт, үр ашигтай байдал болон/эсвэл үр нөлөөтэй байдлын зарчмуудтай холбогдсон, ойлгомжтой тодорхойлогдсон аудитын зорилго(ууд)ыг тогтоох ёстой.

Эх сурвалж: АДБОУС-3000/35.

Аудитын зорилго(ууд) нь аудит хийх шалтгаан(ууд)ыг тодорхойлдог. Зорилго(ууд) нь таны ажлыг чиглүүлэх аудитын асуултуудыг боловсруулах эхлэлийн цэг болдог. Ийм учраас зорилго(ууд)ыг тодорхойлоход ашигласан үгс нь маш чухал бөгөөд аудитын үр дүнд нөлөөлж байдаг. Аудитын зорилго(ууд)ыг загварчлахдаа аудитын үр өгөөж болон нөлөөллийн хэмжээг хамгаалах, материаллаг байдлын үндэсний үйл ажиллагааг хамгаалах, нөхцөл байдал 14-р зурагт үзүүлсэн шиг болно. www.effectiveservices.org/assets/CES_Whole_of_Government_Approaches.pdf - ц үзэж болно.

аудитын сэдвийн **арвилан хэмнэлт, үр ашигтай байдал** болон **үр нөлөөтэй байдлыг** үнэлэхийг зорих хэрэгтэй (УДИР-3910/35-42 болон УДИР-3920/24-30-ыг үзнэ үү). Аудитын зорилго(ууд)ыг тогтоохдоо АДБ-ынхаа бүрэн эрх болон аудит хийх шалтгаануудыг харгалзаж үзэх хэрэгтэй.

Та аудитын зорилго(ууд)ыг аудитын ерөнхий зорилго(ууд)ын төвийг сахисан мэдэгдэл гэж үзэж болно. Аудитын зорилго(ууд) нь аудитын асуултуудыг боловсруулахын үндэс болдог (мөн энэ бүлэгт авч үзнэ). Аудитын хэрэгцээнээс хамааруулаад та зорилго(ууд)оо холбоо үгээр эсвэл асуулт хэлбэрээр бичиж болно. Аль ч хэлбэрээр бичсэн бай, зорилгуудаа боловсруулахдаа дараах хүчин зүйлсийг харгалзаж үзэх шаардлагатай:

- Аудитын зорилгуудыг ойлгомжтой бөгөөд энгийн үгээр илэрхийлсэн үү?
- Зорилгууд нь тодорхой, хэрэгжих боломжтой, шударга бөгөөд бодитой, бодлогын хувьд төвийг сахисан, мөн хэмжиж болохуйц байна үү?
- Зорилгууд нь таныг хоёрдмол утгагүй дүгнэлтэд хүргэх боломжтой байдлаар бичигдсэн үү?
- Зорилгууд нь та яагаад аудит хийх болсныг, аудитын фокус болон ерөнхий зорилго нь юу болохыг аудитад шалгуулагч этгээд болон оролцогч талуудад хялбархан ойлгуулах хангалттай мэдээллээр хангаж байна үү?

Зураг 15: Зохимжтой болон зохимжгүй томьёолсон аудитын зорилгуудын жишээ ба аудитын арга хандлага

Аудитын арга хандлага	Жишээ
Асуудалд чиглэсэн арга хандлага	<p>Загасны амьдралын орчныг хамгаалах</p> <ul style="list-style-type: none"> • Зохимжтой: Загасны аж ахуй болон байгаль орчны газраас загасны аж ахуй болон түүний амьдралын орчны гол бодлогуудыг яагаад хэрэгжүүлээгүйг тогтоох. • Зохимжгүй: Загасны аж ахуй болон байгаль орчны газар хэрхэн бүтэлгүйтсэнийг тогтоох. <p>Энэ зорилго нь та яагаад аудит хийх болсныг, аудитын фокус болон ерөнхий зорилго нь юу болохыг аудитад шалгуулагч этгээд болон оролцогч талуудад ойлгуулах хангалттай мэдээллээр хангахгүй байна.</p> <p>K-12 боловсрол: Ядуу бүлгийн олон сурагчтай улсын ахлах сургуулиуд болон жижиг сургуулиуд коллежид бэлдэхэд зориулсан хичээл цөөнтэй байдаг</p> <ul style="list-style-type: none"> • Зохимжтой: Ядуу бүлгийн олон сурагчтай улсын ахлах сургуулиуд болон жижиг сургуулиуд яагаад цөөн хичээлтэй байдгийг судлах. • Зохимжгүй: Ядуу газрын сургуулиуд яагаад сурагчдаа коллежид бэлдэхийн оронд техник, мэргэжлийн сургалтад хамруулдгийг судлах. <p>Энэ зорилго техник, мэргэжлийн сургалт нь ядуу сурагчдад боловсрол олгох асуудлын ядмагхан шийдэл юм гэсэн утга агуулж байгаагаас гадна тодорхой бөгөөд хоёрдмол утгагүй дүгнэлтэд хүргэх үндэс суурийг олгохгүй байна.</p>
Үр дүнд чиглэсэн арга хандлага	<p>Энтертайнментын салбар дахь ажилтнуудын үнэлгээ</p> <ul style="list-style-type: none"> • Зохимжтой: Ажилтнууд орлогын албан татварын гол заалтуудыг хэрэгжүүлсэн хэр хэмжээг үнэлэх. • Зохимжгүй: Энтертайнментын салбарын орлогын албан татварын дүрмийн заалтуудтай нийцэх нийцлийг үнэлэх. <p>Энэ зорилго нь хэн аудитад шалгуулж буйг эсвэл аудит хийх үндэслэлийг тодорхой илтгэхгүй байна. Мөн, хамрах хүрээ нь өргөн бөгөөд аудитыг тодорхой бөгөөд хоёрдмол утгагүй дүгнэлтэд хүргэхээргүй байна. Түүнчлэн, гүйцэтгэлийн аудитын зорилгоос илүүтэй нийцлийн аудитын зорилгод ойр байна. Эцэст нь, энэ зорилго аудиторт нийгмийн асуудал болон засгийн газрын гүйцэтгэлийн асуудал хооронд ялгах боломж олгохгүй байна.</p> <p>Фермерүүдийн орлогыг тогтворжуулах нь: Цогц хэрэгслүүд, гэхдээ хэрэгслүүдийг бага ашиглаж, хэт өндөр нөхөн төлбөр үүсгэж байгааг зохицуулах шаардлагатай</p> <ul style="list-style-type: none"> • Зохимжтой: Эрсдэл болон хямралын удирдлагын хэрэгслүүдийг ашиглаж буй, мөн зорилтот үр дүнг бий болгож буй хэр хэмжээг үнэлэх. • Зохимжгүй: Эрсдэл болон хямралын удирдлагын аль хэрэгслүүд нь үр дүнг хамгийн сайн бий болгож чадахыг үнэлэх. <p>Энэ зорилго нь “үр дүнг хамгийн сайн бий болгох” гэдгийг тоон үзүүлэлтээр илтгэх хангалттай шалгуургүйгээр үр дүнд чиглэсэн шинжилгээ хийхийг зорьж байна. Хамрах хүрээ нь хэт өргөн бөгөөд зорилгод хүрэх боломжгүй байж магадгүй.</p>
Тогтолцоонд чиглэсэн арга хандлага	<p>Засгийн газрын боловсролын тэтгэлгийн ашиглалт болон тэтгэлэг хүртэгчдийн үйл ажиллагааны хяналт-шинжилгээ</p> <ul style="list-style-type: none"> • Зохимжтой: Агентлагуудын тогтолцоо нь тэтгэлэг хүртэгчид санхүүжилтээ хэрхэн ашиглаж буйг хянан-шинжлэхэд шаардлагатай хяналтыг агуулсан хэр хэмжээг үнэлэх. • Зохимжгүй: Санхүүжилтийг зохистой ашиглуулахын тулд агентлагууд тэтгэлэг хүртэгчдийг хянан-шинжилж буй эсэхийг үнэлэх. <p>Энэ зорилго нь нягталгааны хамрах хүрээг тодорхой тогтоогоогүй бөгөөд объектив шалгуур ашиглахад төвөг учруулж мэдэх субъектив нэр томьёонуудыг ашигласан байна.</p> <p>Удирдлагын тогтолцооны цунамигийн гамшгийн хариу арга хэмжээний үнэлгээ</p> <ul style="list-style-type: none"> • Зохимжтой: Удирдлагын тогтолцоо болон горимууд нь цунамигийн гамшигт хангалттай шуурхай бөгөөд тохиромжтой хариу арга хэмжээ авахыг зөвшөөрч буй хэр хэмжээг үнэлэх. • Зохимжгүй: Цунамигийн гамшигт илүү үр нөлөөтэй хариу арга хэмжээ авах нэмэлт алхмуудыг хэрэгжүүлж болох байсан эсэхийг үнэлэх. <p>Энэ зорилго нь хариу арга хэмжээ мүү байсан гэж урьдчилан таамаглаад аудитын зорилтыг тодорхойлохгүй, хэрэгжүүлэхэд хэтэрхий өргөн хамрах хүрээтэй болгосон байна.</p>

Эх сурвалж: Канад Улсын Ерөнхий аудиторов газрын мэдээллийг эш болгов; Энэтхэг Улсын Ерөнхий хянагч бөгөөд ерөнхий аудитор; мөн АНУ-ын ТХГ.

Аудитын асуултуудыг хэрхэн боловсруулах вэ?

Аудитын зорилго(ууд) болон арга хандлагаа боловсруулсны дараа аудитын ажлыг тань чиглүүлэх аудитын тодорхой асуултуудыг боловсруулах хэрэгтэй. Аудитын асуултууд нь аудитын нийт зорилго(ууд)аас урган гарах бөгөөд аудитын үеэр таны тайлбарлах буюу үнэлэх сэдвүүдтэй голчлон холбогдоно. Таны аудитын асуултуудын зорилго нь аудитын зорилго(ууд)ын бүх хэсгийг хамрахад оршино. Дээр тайлбарласан арга хандлага тус бүр таныг аудитын асуултаа өөрөөр томъёолоход хүргэж болно. Аудитын зорилго(ууд)аа боловсруулахын нэгэн адил, танай баг аудитын асуултуудаа боловсруулахдаа ашиглах үгсээ нухацтай бодож үзэх нь чухал. Учир нь үгс нь та бүхний шийдвэр, цуглуулах мэдээллийн төрлүүд, өгөгдөл, мэдээлэл цуглуулах аргууд, шинжилгээний арга хандлага болон олох илрүүлэлт болон гаргах дүгнэлтүүдэд нөлөөлдөг. Аудитын асуултуудаа дэд асуултуудад задлах тохиолдолд бие биеэ нөхсөн, давхцаагүй бөгөөд хамтдаа аудитын ерөнхий асуултуудыг бүрэн орлож чадахуйц байлгах хэрэгтэй (УДИР-3000/37).

Аудитын асуултууд нь нэг бол тайлбарласан (аливаа нөхцөлийг тайлбарласан) эсвэл үнэлсэн (аливаа нөхцөлийг шалгууртай тулган үнэлсэн; хэм хэмжээ заасан эсвэл шинжилсэн) шинжтэй байдаг (УДИР-3920/31-37). Тайлбарласан шинжтэй аудитын асуулт нь олон хэлбэртэй байж болно. Заримд нь хялбархан хариулж болдог бол бусад нь хэцүү байдаг. Тухайлбал:

- Хөдөөгийн сургуулийн хөтөлбөрийн хүлээн авагчдын онцлог юу вэ?
- Засгийн газарт шууд ажилд орж, мөн засгийн газартай гэрээ байгуулсан компанид ажилд орж, “А” үйл ажиллагаанд оролцсон ажилтнуудын тооны талаар юу мэдэгдэж байгаа вэ?
- Төрийн тогтвортой худалдан авалттай холбогдох үйл ажиллагаануудын босоо болон хэвтээ уялдааг хэрэгжүүлэхийн тулд засгийн газраас ямар ямар институтийн зохион байгуулалтуудыг бий болгосон бэ?
- Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг таслан зогсоохтой холбоотой санаачилгуудыг хэрэгжүүлэхийн тулд засгийн газар төрийн бус оролцогч талуудтай хэрхэн харилцаж байна вэ?

Үнэлсэн шинжтэй аудитын асуулт нь аливаа хөтөлбөрийн одоогийн арвилан хэмнэлтээс авхуулаад ирээдүйн үйл явдлуудыг таамагласан шинжилгээ хүртэл маш олон янз байж болно. Үнэлсэн шинжтэй аудитын асуултын таван төрөл байдгийг 16-р зурагт үзүүлэв. Аудитын ийм асуултуудыг ашиглах үед асуулт хооронд харилцан зөрчил үүсэхгүй. Тухайлбал, үр нөлөөтэй байдлыг үнэлэх асуулттай гүйцэтгэлийн аудит нь дотоод хяналтыг мөн үнэлж болно.

Зураг 16: Үнэлсэн шинжтэй аудитын асуултын төрөл ба аудитын арга хандлага


Аудитын арга хандлага		Жишээ
<p>1 Хөтөлбөрийн арвилан хэмнэлт ба үр ашигтай байдал</p>	<p>Арвилан хэмнэлт болон үр ашигтай байдалд төвлөрсөн асуултууд нь хөтөлбөрийн үр дүнд хүрэхийн тулд ашигласан нөөц болон өртгийг асуудаг.</p>	<p>Асуудалд чиглэсэн арга хандлага:</p> <ul style="list-style-type: none"> Улсын эмнэлгүүдийн өвчтөний асаргааны зардлын хэлбэлзлийг ямар хүчин зүйлээр тайлбарлах вэ?
<p>2 Ирээдүйг таамагласан шинжилгээ</p>	<p>Ирээдүйг таамагласан шинжилгээний асуултууд нь тохиолдож болох үйл явдлуудын талаарх таамаглалд, мөн арвилан хэмнэлт, үр ашигтай байдал болон үр нөлөөтэй байдалд нөлөөлж болох ирээдүйн явдлуудад хариу арга хэмжээ болгох аудитад шалгуулагч этгээдийн боломжит үйлдлүүдэд үндэслэсэн мэдээлэлд шинжилгээ хийдэг эсвэл дүгнэлт гаргадаг.</p>	<p>Асуудалд чиглэсэн арга хандлага:</p> <ul style="list-style-type: none"> Коллежид элсэхээр бэлдэж буй нэн ядуу бүсийн сурагчдад ирэх 20 жилд ямар сорилт тулгарах вэ? <p>Үр дүнд чиглэсэн арга хандлага:</p> <ul style="list-style-type: none"> Залуучуудын зуслангийн аюулгүй байдлын талаар санал болгож буй холбооны стандарт нь хүүхдийн гэмтэл бэртэл болон өвчлөлийн түвшинд хэр нөлөөлж болох вэ?
<p>3 Хөтөлбөрийн үр нөлөөтэй байдал ба үр дүн</p>	<p>Хөтөлбөрийн үр нөлөөтэй байдал болон үр дүнд төвлөрсөн асуултууд нь ихэвчлэн аливаа хөтөлбөр ерөнхий болон бусад зорилгуудаа хүрч буй байдал болон хэр хэмжээг хэмждэг. Иймд хөтөлбөрийн хэрэгжилтийн чанарыг мөн шалгаж болно.</p>	<p>Үр дүнд чиглэсэн арга хандлага:</p> <ul style="list-style-type: none"> Олон улсын сургуулийн хүнсний дэмжлэгийн хөтөлбөрүүд нь НҮБ-аас тогтоосон эдгээр хөтөлбөрийн сайн туршлагуудыг хэр хэмжээнд дагаж байна вэ? <p>Тогтолцоонд чиглэсэн арга хандлага:</p> <ul style="list-style-type: none"> Удирдлагын тогтолцоо болон горимууд нь гамшигт хангалттай шуурхай бөгөөд тохиромжтой хариу арга хэмжээ авахыг хэр хэмжээнд зөвшөөрч байна вэ?
<p>4 Дотоод хяналт</p>	<p>Дотоод хяналтын асуултууд нь үр нөлөөтэй бөгөөд үр ашигтай үйл ажиллагааг бий болгож, санхүүгийн болон гүйцэтгэлийн найдвартай тайлан гаргасныг үндэслэлтэйгээр баталгаажуулах зорилготой байгууллагын дотоод хяналтын тогтолцоонд хийх үнэлгээтэй холбогдоно.</p>	<p>Үр дүнд чиглэсэн арга хандлага:</p> <ul style="list-style-type: none"> Тогтоосон дотоод хяналт нь хүсэж буй үр дүнгүүдэд хүрэхэд хэр хэмжээнд тусалж байна вэ? <p>Тогтолцоонд чиглэсэн арга хандлага:</p> <ul style="list-style-type: none"> Хөдөлмөрийн яам хөдөлмөр эрхлэлтийн сургалтын хөтөлбөрийн гүйцэтгэлийн хэмжүүрүүдээ хэр хэмжээнд хүчин төгөлдөр, найдвартай бөгөөд бүрэн байлгаж байна вэ?
<p>5 Нийцэл</p>	<p>Нийцлийн асуултууд нь аудитад шалгуулагч этгээдийн нөөц олж авах, хамгаалах, ашиглах болон зохицуулах ажиллагаанд, мөн аудитад шалгуулагч этгээдийн үйлдвэрлэж, үзүүлж буй үйлчилгээний тоо хэмжээ, чанар, цаг хугацаатай байдал болон өртөгт нөлөөлж болох хууль, журам, зохицуулалт, гэрээний заалт, тэтгэлгийн гэрээ болон бусад шаардлагаар тогтоосон шалгууруудтай нийцэх нийцэлтэй холбогдоно.</p>	<p>Тогтолцоонд чиглэсэн арга хандлага:</p> <ul style="list-style-type: none"> Хурдны замын түргэн тусламжийн хөтөлбөрөөр санхүүжүүлсэн төслүүд нь холбооны хөтөлбөрийн шаардлагуудад хэр хэмжээнд нийцэж байна вэ?

Эх сурвалж: Канад Улсын Ерөнхий аудиторын газар; Энэтхэг Улсын Ерөнхий хянагч бөгөөд ерөнхий аудитор; мөн АНУ-ын ТХГ.

Аудитын асуулт зохиоход ашиглаж болох олон арга техник бий. Тэдгээрийн нэг нь 17-р зурагт загварчлан үзүүлсэн шиг асуудлын шинжилгээний пирамид бэлдэх арга юм. Энэ хэрэгслийн зорилго нь аудитын зорилгыг хэд хэдэн нарийвчилсан асуултад хувааж, пирамид бүтэц үүсгэхэд оршдог. 1-р түвшинд харагдаж буй аудитын зорилго нь эрүүл мэндийн яам хүн амын ядуу бүлэгт жирэмсний үеийн тусламж үйлчилгээ үзүүлэх одоогийн болон ирээдүйн өртгийг тодорхойлсон хэр хэмжээг үнэлэхийг зорьж байна. 2-р түвшин нь

аудитын зорилгыг биелүүлэхийн тулд аудитын баг аудитын явцад хариулах шаардлагатай аудитын асуултуудыг тодорхойлж байна.

Зураг 17: Асуудлын шинжилгээний жишээ



Эх сурвалж: АДБОУБХС/ГАДХ-ны Хөгжлийн Баг.

Энэ арга техник нь танд аудитын асуултуудад хариулах боломжтой эсэхийг үнэлэх болон аудитын үйл ажиллагааны суурь болох логикийг боловсруулах боломж олгож чадна.

Хоёр дахь арга техник нь 18-р зурагт загварчлан үзүүлсэн шиг асуудлын шалтгаан-үр дагаврын шинжилгээг гүйцэтгэх арга юм. Таны аудитаас хамаараад энэ арга нь хоёр салангид алхамд хуваагдаж болно. Нэгдүгээр алхам нь, хүлээгдэж буй үр дүнгүүдэд хүрсэн эсэхийг эсвэл аливаа тогтолцоо хүлээлт ёсоор ажиллаж буй эсэхийг тогтоох юм. Хэрэв ийм биш байвал, гүйцэтгэлийн асуудал оршин байх магадлалтай бөгөөд та шинжилгээгээ нэг шат гүнзгийрүүлж асуудлын шалтгааныг таамаглаж, шинжилж болох эсэхэд анхаарах шаардлагатай болно. Асуудалд чиглэсэн арга хандлагын хувьд, гүйцэтгэлийн үндсэн асуудал болон урьдчилсан байдлаар илрүүлсэн асуудал үүсгэгч гол хүчин зүйлс нь аудитын анхны зохиомжийн нэг хэсэг болж болно.

1-р түвшинд харуулсан үр нөлөө нь 2-р түвшинд харуулсан таамагласан шалтгаануудыг үнэлэх эхлэлийн цэг болно. Боломжит шалтгаанууд нь 3-р түвшинд үзүүлсэн аудитын асуултуудыг боловсруулах үндэс суурь болно.

Зураг 18: Асуудлын шалтгаан-үр дагаврын шинжилгээний жишээ



Эх сурвалж: АХАДБАБ-ын Гүйцэтгэлийн Аудитын Гарын Авлага, 2016.

Аудитын асуултуудыг томъёолох нь давтагддаг үйл явц бөгөөд судлах сэдэв/ зүйлийн талаар мэдэгдсэн болон шинэ мэдээллүүд, мөн хариулт олох боломжийг харгалзан үзэж асуултуудыг дахин дахин тодотгож, сайжруулж байдаг. Дэд асуудлууд болон дэд шалтгаануудын талаар нэмэлт мэдээлэл олж авч, ойлголтоо гүнзгийрүүлэхийн тулд аудитаа хувьсан өөрчлөгдөхийг зөвшөөрөх нь чухал. Ингэхдээ аудитын асуултуудаа хэзээ, хэрхэн, яагаад өөрчлөн сайжруулснаа баримтжуулж, аудитынхаа бүртгэлийг бүрэн байлгах нь мөн асар чухал. Томоохон өөрчлөлт хийсэн бол уг өөрчлөлтийнхөө талаар аудитад шалгуулагч этгээдэд мэдээлэх шаардлагатай.

Аудитын хамрах хүрээг хэрхэн тодорхойлох вэ?

Хамрах хүрээ нь таны аудитын хил хязгаарыг тогтоож, таны асуухаар зорьж буй тухайлсан асуултууд, таны гүйцэтгэх судалгааны төрөл зэрэг зүйлсийг тодорхой болгодог. Тухайлбал, аудитын хамрах хүрээ нь аудиторын үнэлж тайлагнах судлах зүйлийн шалгах баримт бичиг болон тайлан бүртгэл, шалгах хугацаа, мөн хамруулах байршлуудыг тодорхойлж өгдөг.

Хамрах хүрээг тодорхойлоход аудитын зорилго(ууд) болон асуултууд шууд нөлөөлдөг. Ийм учраас та мэдээлэл цуглуулж, аудитын судлах сэдэв/ зүйлийн талаар илүү их мэдлэгтэй болсон үед хамрах хүрээгээ шинэчлэх шаардлагатай болж болно. Та мөн аудитын зорилго(ууд) эсвэл асуултуудад гарсан аливаа өөрчлөлтийн зүгээс аудитын хамрах хүрээнд нөлөөлөх нөлөөллийг харгалзан үзэх шаардлагатай болно. Аудитын хамрах хүрээг тогтоох нь аудитыг зохиомжлохын салшгүй чухал хэсэг юм. Нэмэлт мэдээлэл хэрэгтэй бол УДИР-3910/24-26 болон УДИР-3920/21-23-ыг үзнэ үү.

Та 19-р зурагт жагсаасан асуултуудад хариулах замаар аудитынхаа хамрах хүрээг тогтоож болно.

Зураг 19: Хамрах хүрээг тогтоох асуултууд

Юу/Ямар?	<ul style="list-style-type: none"> • Тухайлсан ямар асуултууд эсвэл таамаглалуудыг судалж байгаа вэ? • Таны аудитад хамаарах гол үйл явцууд юу вэ? • Үнэлгээ хийж, тайлагнах судлах сэдэв/ зүйл нь юу вэ? • Аудитыг гүйцэтгэхэд ямар нөөцүүд бэлэн байгаа вэ? • Ямар асуулт, үйл явц болон нөөцийг хамруулахгүй вэ?
Хэн/Аль?	<ul style="list-style-type: none"> • Аль агентлаг болон байгууллагууд аудиттай холбогдох хариуцлага эсвэл харах өнцгийг хадгалж байгаа вэ? • Холбогдох агентлаг болон байгууллагаас хэн нь аудитын асуултуудад хариулах зохистой бөгөөд хангалттай нотлох зүйлсээр хангах хамгийн боломжтой байгаа вэ? • Таны аудиттай холбогдох өгөгдөл, мэдээллийн найдвартай байдлыг баталгаажуулах хариуцлагыг хэн хүлээж байгаа вэ? • Аль байгууллага эсвэл хүнийг хасах вэ?
Хаана?	<ul style="list-style-type: none"> • Ямар байршлуудыг хамруулах вэ? • Судлах шаардлагатай баримт бичгүүд болон бүртгэлүүд хаана байна вэ? • Ямар байршлуудыг хасах вэ?
Хэзээ?	<ul style="list-style-type: none"> • Ямар хугацааг хамруулах вэ?

Эх сурвалж: АДБОУБХС/ГАДХ-ны Хөгжлийн Баг.

Аудитынхаа хамрах хүрээг тогтоохдоо та олон нэмэлт хүчин зүйлсийг мөн харгалзаж үзэх хэрэгтэй. Тухайлбал, найдвартай нөөц болон өгөгдлийн олдцод үндэслэн хамрах хүрээгээ хязгаарлах шаардлагатай болж болно. Мөн, дараах зүйлсэд үндэслэн хамрах хүрээгээ тодотгон сайжруулж болно:

- Нарийн төвөгтэй арга зүйг хэрэгжүүлэхэд шаардлагатай үр чадвар бүхий арга зүйн экспертүүд гэх мэт аудиторруудтай хамтран ажиллах боломж зэрэг аудитыг гүйцэтгэх бэлэн байгаа нөөц;
- Судлах сэдэв/ зүйлээр мэргэшсэн экспертүүдтэй хамтран ажиллах боломж;
- Замын зардалтай холбогдох зардал; мөн
- Аудитын цаг хугацааны хязгаарлалт.

Өмнөх аудитын тайлан дахь зөвлөмжүүдийг бий болгосон асуудлууд одоо ч хамааралтай хэвээр байгаа бол таны аудитын хамрах хүрээнд мөн багтаж болно. Доор жагсаасан хамрах хүрээний жишээнүүдийг олон янзын гүйцэтгэлийн аудитын нийтлэгдсэн тайлангуудаас авав.

Аудитын хамрах хүрээний жишээ

1. Байгаль орчин, тогтвортой хөгжлийн комиссарын Загасны амьдралын орчныг хамгаалах ажлын 2009 оны хаврын тайлан. Канад улсын Ерөнхий Аудиторын Газрын тайлан, 2009.

Тус аудит нь Загасны амьдралын орчныг хамгаалах газрын захиргаа, Загасны аж ахуйн тухай хуулийн бохирдлоос сэргийлэх тухай заалтууд, мөн эдгээр заалтуудтай холбогдох засгийн газрын хандлагыг тодорхойлсон хоёр бодлогыг (Амьдралын орчны бодлого, мөн Нийцлийн болон хэрэгжүүлэлтийн бодлого) хамруулсан юм. Ингэхдээ загасны аж ахуйн бодлого, хөтөлбөр, үйл ажиллагаанууд, далайн амьдралын хөтөлбөр, дээрх заалтуудын хэрэгжилт болон захиргааг дэмжих бусад зохицуулалтууд зэргийг хамруулжээ. Тус аудит нь Загасны аж ахуйн тухай хуулийн заалтын дагуу яамны зөвшөөрөлтэйгөөр эхлүүлж болох, Байгаль орчны үнэлгээний тухай хуулиар шаарддаг байгаль орчны үнэлгээнд төвлөрөөгүй байна.

2. Өргөжүүлсэн сургалтын хөтөлбөрийг удирдах нь. ИБУИНХУ-ын Үндэсний Аудитын Газрын тайлан, 2012.

Тус аудитаар 2010 оны 5-р сараас хойш Боловсролын яамнаас өргөжүүлсэн сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлсэн байдал, түүний санхүүжилт болон хяналтын хүрээний хангалттай байдлыг боловсролын салбарыг бүхэлд нь хамруулж (2010 оны 5-р сараас өмнө байгуулагдсан байгууллагуудыг мөн хамруулж) үнэлсэн юм. Уг хөтөлбөр нь эхэн үедээ явж байсан бөгөөд сургуулиуд өргөжүүлсэн хөтөлбөрт хамрагдсанаас хойш сургалтын гүйцэтгэл нь хэр байсныг тодорхойлох чиг хандлагын өгөгдөл хязгаарлагдмал байв. Аудитаар сургалтын байгууллагуудын гүйцэтгэлийн энэ хэсгийг ирээдүйн мөнгөний үнэ цэнгийн хөтөлбөрийн нэг хэсэг болгож судалсан байна. Тайланд хөрөнгийн санхүүжилтийг хамруулаагүй. Мөн, орон нутгийн санхүү болон үйлчилгээний өргөжилтийн нөлөөллийг нарийвчлан үнэлээгүй байна.

3. Хэрэглэгчдийн гомдлыг удирдах нь. Ботсвана улсын Ерөнхий Аудиторын Газрын тайлан, 2008.

Тус аудит нь 2003-2006 оны санхүүгийн жилд хэрэглэгчдийн санал, гомдлыг удирдахын тулд Хэрэглэгчдийг Хамгаалах Газраас хэрэгжүүлсэн үйл ажиллагаануудад төвлөрсөн юм. Аудитын хамрах хүрээ нь үндэсний хэмжээнд байв. 2003-2004 оны санхүүгийн жилийн хэрэглэгчдийн гомдлын өгөгдөл бэлэн байгаагүй.

Эх сурвалж: АДБОУС-3000/45.

Аудитын шалгуурыг хэрхэн сонгох вэ?



Стандарт

Аудитор нь аудитын зорилго(ууд) болон аудитын асуултуудтай уялдсан, арвилан хэмнэлт, үр ашиг болон/эсвэл үр нөлөөтэй байдлын зарчмуудтай холбогдсон аудитын тохиромжтой шалгууруудыг тогтоох ёстой.

Эх сурвалж: АДБОУС-3000/45.

Хамрах хүрээгээ тодорхойлсны дараа аудитад шалгуулагчийн гүйцэтгэлийг байвал зохих байдалтай тулгаж хэмжих боломж олгох шалгууруудын талаар бодолцож үзэх хэрэгтэй.

Аудитын шалгуур гэж юу вэ?

Аудитын шалгуур нь аудитын сэдэвтэй холбогдох шаардагдаж буй эсвэл хүсэж буй төлөв байдал буюу хүлээлтийг тодорхойлж, үйл ажиллагааныхаа арвилан хэмнэлт, үр ашигтай байдал болон үр нөлөөтэй байдлыг тулган үнэлж болох үндэслэлтэй бөгөөд хүрч болохуйц гүйцэтгэлийн стандартыг илтгэдэг. Товчхондоо, аудитын шалгуур гэдэг нь аудитын нотлох зүйлсээ тулган шалгаж болох стандарт юм. Энэ утгаараа, шалгуур нь нотлох зүйлсийг үнэлж, аудитын тайлан дахь илрүүлэлт, дүгнэлт, зөвлөмжүүдийг ойлгох хам нөхцөлийг бий болгодог (УДИР-3910/55-60 болон УДИР-3920/38-43-ыг үзнэ үү).

Гүйцэтгэлийг үнэлж буй бүх аудитад шалгуур хэрэгтэй. Өмнө дурдсанчлан, ийм үнэлгээнд аудитад шалгуулагч этгээдийн гүйцэтгэлтэй холбогдох нийцлийн асуудлуудыг мөн хамруулж болно. Аудитын шалгуур нь хууль, журам, зохицуулалтын дагуу “юу байх ёстой”, сайн туршлагын дагуу “юу хүлээгдэж байгаа”, эсвэл илүү сайн нөхцөлд “юу байж болох” талаарх хүлээлтийг илтгэж болно. Түүнчлэн, шалгуур нь чанарын эсвэл тоон, ерөнхий эсвэл тусгай, эсвэл нягтлагдаж буй судлах сэдэв/ зүйлийн хэм хэмжээний загвар (өөрөөр хэлбэл гүйцэтгэл эсвэл арвилан хэмнэлт/үр ашигтай байдалтай холбогдож буй нийцлийн асуудлуудын хэм хэмжээ) үзүүлэлттэй байж болно. Шалгуурын жишээнээс дурдвал:

- Аудитад шалгуулагч этгээдийн үйл ажиллагаанд үйлчлэх хууль, журам, зохицуулалтууд;
- Аудитад шалгуулагч этгээдийн тогтоосон зорилго, бодлого, горимууд;
- Боловсруулсан техникийн стандарт, норм дүрмүүд;
- Экспертийн санал дүгнэлт;
- Үүрэг эсвэл үйл ажиллагааны горим;
- Тодорхойлсон бизнесийн практик;
- Гэрээ эсвэл тэтгэлгийн гэрээ;
- АДБ, аудитад шалгуулагч этгээд эсвэл бусад холбогдох байгууллага, салбаруудаас тогтоосон жишгүүд буюу гүйцэтгэлийн индикаторууд;
- Өмнөх үеүдийн гүйцэтгэл; мөн
- Ижил төстэй аудитад ашигласан эсвэл бусад АДБ-ын ашигласан шалгуурууд. (Жич: Эдгээр шалгуурууд хүчин төгөлдөр хэвээр байгаа эсэхийг шалгах хэрэгтэй.)

Аудитын шалгуурыг хэрхэн сонгох вэ?

Гүйцэтгэлийн аудитын шалгуурыг сонгохдоо бодитой (объектив) хандлагаар сонгох нь чухал. Энэ үйл явц нь рационал сэтгэлгээ болон сайн мэргэжлийн үнэлэмж шаарддаг. Заримдаа, тухайлбал, хууль тогтоох засаглал эсвэл засгийн газраас тогтоосон ерөнхий зорилго тодорхой, нарийвчлалтай бөгөөд хамааралтай үед аудитын шалгуурыг тодорхойлоход хялбар байдаг. Гэхдээ үргэлж ийм байна гэж үгүй. Тухайлбал, хамааралтай шалгуур нь аудитын эхэн үед тодорхой харагдахгүй байж болно. Мөн холбогдох гүйцэтгэлийн зорилгууд нь бүдэг, зөрчилдөөнтэй эсвэл бодитой бус байж болно. Түүнчлэн, аудитад шалгуулагч этгээдээс тогтоосон шалгуур эсвэл стандарт нь сайн гүйцэтгэлд хувь нэмэр оруулахгүй байгаагийн улмаас та гүйцэтгэлийн илүү тохиромжтой жишгээр хангах шинэ шалгуур сонгох, тохируулах, эсвэл бүр нэмэлтээр боловсруулах шаардлагатай болж болно. Олон тохиолдолд, аудитад шалгуулагч этгээд болон бусад эх сурвалжаас авсан

олон төрлийн шалгуурын хослол нь гүйцэтгэлийг үнэлэх зөв хүрээгээр хангадаг болохыг та мэдэх болно. Гэхдээ, бүх тийм тохиолдолд, материаллаг байдлыг хангаж, асуудал болон түүнтэй холбогдох сайн туршлагауудын талаар илүү мэдлэгтэй болохын тулд шалгууруудаа сонгохын өмнө багахан аудитын ажил хийвэл түстэй байдаг.

Аудитын шалгуурыг бодитой (объектив) хандлагаар сонгоход дараах зүйлс хэрэгтэй:

- Аудитад шалгагдах талбарын талаарх ерөнхий ойлголттой болж, холбогдох хуулийн болон бусад баримт бичигтэй, мөн аудитад шалгагдах талбарт хийсэн сүүлийн үеийн судалгаанууд болон аудитуудтай танилцах;
- Хууль тогтоох засаглал эсвэл засгийн газраас тогтоосон аудитын сэдэв болон зорилгын сэдэл болон эрх зүйн үндсийн талаар сайн мэдлэгтэй болох; мөн
- Хамааралтай эсвэл ижил төстэй бусад засгийн газрын хөтөлбөрийн практик болон туршлагын талаар сайн мэдлэгтэй болох.

Таны сонгосон шалгуур нь аудитын сэдэв болон зорилго(ууд)д тохиромжтой байх нь маш чухал. Тохиромжтой шалгуур нь хамааралтай, найдвартай, бодитой, ойлгомжтой, тестэлж болдог бөгөөд бүрэн байдаг. Шалгуур сонгох явцад эдгээр шинжүүдийн харьцангуй ач холбогдлыг бодолцож үзэх нь мэргэжлийн үнэлэмжийн асуудал юм. Тус шинжүүдийг 20-р зурагт тайлбарлав.

Зураг 20: Тохиромжтой шалгуурын шинжүүд



Эх сурвалж: ТХГ болон УДИР-3910: Гүйцэтгэлийн аудитын гол ухагдахуунууд, 2019.

АДБОУС-3000/49-ийн дагуу, аудитор нь аудитыг зохиомжилж, гүйцэтгэх үедээ сонгосон аудитын шалгууруудыг аудитад шалгуулагч этгээдтэй хэлэлцэх ёстой. Ингэх нь судлах сэдэв/ зүйлийг үнэлэх үед ямар шалгууруудыг жишиг болгон ашиглах талаар хамтын, нийтлэг ойлголт үүсгэхэд тусална. Мөн, шалгуурын тохиромжтой бөгөөд хэрэглэх боломжтой байдалтай холбоотой асуултуудад хариулахад тусалдаг. Ийм хэлэлцүүлэг нь аудитад шалгуулагчийн гүйцэтгэлээ хэмжихдээ ашигладаг шалгуураас өөр шалгуурыг аудитдаа сонгосон тохиолдолд нэн тустай байдаг. Гэхдээ, ил тод байдал болон аудитад шалгуулагч этгээдээс холбогдох орцыг авах нь чухал хэдий ч, аудит болон аудитын асуултуудын мөн чанарт үндэслэн аудитад тохиромжтой шалгуур сонгох нь угтаа аудитад шалгуулагч этгээдийн бус, аудиторын үүрэг хариуцлага юм.

21-р зурагт аудитын шалгууруудын жишээг харгалзах аудитын асуултуудынх нь хамт үзүүлэв.

Зураг 21: Шалгуурууд болон тэдгээртэй харгалзах аудитын асуултууд

Аудитын асуулт	Шалгуур
Байгаль орчны удирдлагын агентлаг Усны тухай хуулийн шаардлагуудтай хэр хэмжээнд нийцэн ажиллаж байна вэ?	Усны тухай хуулийн дагуу, тус агентлаг нь Хуулийн хэрэгжилтийн талаар Парламентад жил бүр тайлан бэлдэж өгөх ёстой.
Боловсролын агентлаг гэрээ байгуулах хугацаагаа хэр хэмжээнд баримталж байна вэ?	Тус агентлаг өөр өөр төрлийн гэрээ байгуулах хугацаагаа дотооддоо тогтоосон.
Хөдөө аж ахуйн удирдлагын агентлаг тусламжийн төлбөрийг зохих ёсоор олгох үйл явцаа хэр хэмжээнд тодорхойлсон бэ?	Тус агентлагийн бодлого нь төлбөр авах боломжит хүлээн авагчдыг шаардлага хангаж буй эсэхийг тогтоож, буруу олгосон аливаа мөнгийг буцаан авах үйл явцыг тогтоосон байхыг шаарддаг.
Эрүүл мэндийн агентлаг хэр хэмжээнд ундны усаар хангагчдад шаардлага тавьж, усны чанарын тест хийлгэж байна вэ?	Усны тест хийх зохицуулалтад хүний хэрэглээний усанд ямар төрлийн тест хийж, ямар үр дүн гаргах ёстой талаар заасан байдаг.
Батлан хамгаалахын агентлагийн мэдээллийн технологийн газар нь ажилтнуудынхаа эмзэг мэдээллийг хамгаалахын тулд хэр хэмжээний арга хэмжээ авч хэрэгжүүлж байна вэ?	Боловсруулсан техникийн стандарт нь агентлагууд ажилтнуудынхаа эмзэг мэдээллийг хамгаалахын тулд дагаж мөрдөх ёстой алхмуудыг заадаг.
Хууль зүйн яамны тэтгэлэгт хөтөлбөр зорилтот хүн амд хүсэж буй үр дүнг бий болгоход хэр хэмжээний хувь нэмэр оруулсан бэ?	Хөтөлбөрийн зорилгууд нь хүсэж буй үр дүн болон түүнтэй холбогдох зорилгуудад хүрэх ахицыг үнэлэх арга хэмжээг тодорхойлдог.
Байгаль орчны агентлагийн нүүрстөрөгчийн ялгаруулалтыг бууруулах хөтөлбөр зорилтот үр дүндээ хэр хэмжээнд хүрсэн бэ?	Нүүрстөрөгчийн ялгаруулалтыг бууруулах зорилт нь 5 жилийн хугацаанд хүрэхийг хүсэж буй бууруулалтын түвшнийг тодорхойлдог.
Үндэсний хэмжээнд ТХЗ болон 2030 Хөтөлбөрийн талаарх оролцогч талуудын мэдлэг ойлголт хийгээд эзний сэтгэлийг нэмэгдүүлэх тогтсон механизм байна уу?	2030 Хөтөлбөрийн лавлагаа удирдамжийн дагуу улс орнууд нийгмийн янз бүрийн сегментүүд төдийгүй олон нийтийг нэгтгэн оролцуулж, мэдээлэл өгөх харилцааны янз бүрийн стратегитай болох ёстой.

Эх сурвалж: АДБОУБХС/ГАДХ-ны Хөгжлийн Баг.

Өмнө дурдсанчлан, зарим үед бэлэн шалгуур оршин байдаггүй, эсвэл шалгуур нь тохиромжгүй эсвэл шууд хэмжих боломжгүй байдаг. Иймд тохиолдолд, шинэ шалгуур нэвтрүүлж эсвэл боловсруулж болно. Шинэ шалгуурыг ихэвчлэн бүр анхнаас нь зохиодоггүй. Харин, байгаа шалгуур, нийгмийн шинжлэх ухааны зарчмууд эсвэл мэргэжлийн практикийн стандартад тулгуурлан зохиодог. Тухайлбал дараахыг хийж болно:



Хэрэв та шалгуур боловсруулахыг сонгосон бол, дотоод болон гадаад оролцогч талуудтай зохих хэмжээнд зөвлөлдөх хэрэгтэй. Мөн, шинэ шалгуурыг боловсруулж, хүчин төгөлдөр болгоход шаардагдах хугацаа болон ажилтны нөөцийг харгалзан үзэж, аудитын нийт өртөг болон ач холбогдолд нийцэж буй эсэхэд нь анхаарах хэрэгтэй.

Тухайлбал, экспертийн санал дүгнэлтэд үндэслэн шалгуур боловсруулж байгаа бол, тэдгээрийг сонгох үйл явц нь ил тод бөгөөд зөвтгөх боломжтой байх нь маш чухал. Энэ үйл явцын нэг хэсэг болгож харгалзан үзэх ёстой хүчин зүйлсээс дурдвал:

Аудитын баг экспертүүдийг тодорхойлж, тэднээс мэдээлэл цуглуулах арга (зөвлөлүүд, судалгаанууд, фокус бүлгүүд, г.м.);

Хүсэж буй харах өнцөг, байгууллага болон секторуудын бүрэлдэхүүн бий болгохын тулд экспертүүдийн тохиромжтой бүрэлдэхүүн үүсгэх;

Экспертүүдийн сертификат, нэр хүнд болон туршлага;

Албан тушаал, холбоо, хөрөнгө, орлогын эх үүсвэр болон бусад холбогдох орчин нөхцөлөөс үүсэж болох ашиг сонирхлын зөрчлөөс хамаарсан экспертүүдийн бодит болон харагдах байдал дээрх хараат бус байдлын түвшин;

Экспертүүд дүгнэлтээ гаргахдаа харгалзан үзэх хүчин зүйлс.

Эх сурвалж: АДБОУБХС/ГАДХ-ны ХБ.

ижил төстэй аудитын сэдэв эсвэл үйл ажиллагаанд ашиглаж байсан шалгуурыг эрж, тохируулан нэвтрүүлэх; бэлэн байгаа судалгааны материалуудыг нягталж, салбарын экспертүүдийн ашигладаг хэмжилтийн шалгууруудыг илрүүлэх; эсвэл олон улсын орчин гэх мэт орчин нөхцөлүүд болон харьцуулж болох практикуудад үндэслэн гүйцэтгэлийн жишгийг тодорхойлохын тулд албан тушаалтнууд, экспертүүд, зөвлөхүүд эсвэл фокус бүлгийнхэнтэй уулзах. Таны боловсруулсан шалгуур уншигчдад хүчин төгөлдөр бөгөөд үнэмшилтэй байх шаардлагатай. Боловсруулсан шалгуураа хүчин төгөлдөр болгохын тулд ихэвчлэн тухайн салбарыг өргөн хүрээнд төлөөлж чадах хараат бус экспертүүдийн санал дүгнэлтийг авдаг.

Түүнчлэн, шалгууруудыг аудитад шалгуулагч этгээдтэй хэлэлцэж, яагаад нэмэлт шалгуур хэрэгтэй болсныг, мөн тэднийг хэрхэн хүчин төгөлдөр болгохыг тайлбарлах нь чухал. Аудитад шалгуулагч этгээдэд уг шалгууруудыг ашиглах боломжтой эсэх талаар үзэл бодол байж мэднэ. Эсвэл таны анзаараагүй байж болох уг шалгуурын тохиромжтой байдалтай холбогдох бусад мэдээллийг танд илрүүлж өгч болох юм. Шалгуурын ашиглалтын тухайд аудитад шалгуулагчийн санал, хүсэлтийг мөн авах нь тустай. Учир нь ингэснээр аудитад шалгуулагч этгээд тайлангийн илрүүлэлтүүд болон зөвлөмжүүдтэй санал нийлж, түүний дагуу арга хэмжээ авах магадлал өснө. Аудитад шалгуулагч этгээд таны сонгосон шалгууртай санал нийлэхгүй тохиолдолд, та ялгаатай харах өнцгүүдийг нэгтгэхийн тулд гуравдагч талын экспертүүдийг оролцуулж болно. Гэхдээ, аудитад шалгуулагч этгээдийн оролцоо болон санал, хүсэлт нь чухал боловч, тохиромжтой шалгуурыг боловсруулах ажил нь угтаа аудитын багийн үүрэг хариуцлага гэдгийг санах хэрэгтэй. Түүнчлэн, удаан үргэлжилсэн санал зөрөлдөөний хувьд, аудитын баг шалгуураа хадгалан үлдэж, аудитын тайланд түүнийхээ үндэслэлийг тодорхойлон бичихийг сонгож болно.

Аудитын арга зүйг хэрхэн боловсруулах вэ?



Стандарт

Төлөвлөлтийн үеэр аудитор нь аудитын зорилго(ууд) болон асуулт(ууд)ад хариулж чадах хангалттай бөгөөд зохистой аудитын нотлох зүйлсийг цуглуулахад ашиглах аудитын горимыг зохиомжлох ёстой.

Эх сурвалж: АДБОУС-3000/101.

Аудитын зорилго(ууд), асуултууд, шалгуур болон хамрах хүрээг тодорхойлсны дараа аудитад ямар арга зүй тохирохыг, мөн бэлэн байгаа цаг хугацаа болон нөөцийг харгалзан үзэх шаардлагатай болно. Аудитын арга зүй нь аудитын асуултуудад хариулахын тулд мэдээлэл цуглуулж, шинжлэх арга замыг тодорхойлдог. Олон төрлийн аргыг ашиглаж болох бөгөөд тэдгээрээс хамгийн түгээмлүүдийг нь 22-р зурагт үзүүлэв.

Зураг 22: Сонгосон мэдээлэл цуглуулах аргуудын үр өгөөж болон анхаарах зүйлс

Арга	Үр өгөөж	Анхаарах зүйлс
<p>Ярилцлага Нэг эсвэл түүнээс олон хүнтэй утас, интернэтээр эсвэл биечлэн уулзаж, аливаа хөтөлбөр эсвэл үйл ажиллагааны талаарх тэдний харах өнцгийг мэдэхийн тулд хэлэлцэх.</p>	<ul style="list-style-type: none"> • Ярилцлага өгөгчийн харах өнцгийг гүнзгий ойлгох боломж олгодог. • Ихэвчлэн харьцангуй богино хугацаанд төлөвлөж, гүйцэтгэж болдог. • Эмзэг сэдвүүдээр мэдээлэл цуглуулах боломж олгодог. • Ярилцлагын үеэр хэлэгдсэн мэдэгдлийн дагуу мэдээллийг шуурхай сурвалжлах боломж олгодог. 	<ul style="list-style-type: none"> • Жигд зохион байгуулж, харьцуулалт үүсгэх боломжтой болгохын тулд сайтар бодож хэрэгжүүлэх шаардлагатай. • Статистик шинжилгээг дэмждэггүй. • Хэд хэдэн ярилцлагын нийтлэг шинж буй чиг хандлагыг тодорхойлж, шинжлэхэд багагүй хугацаа шаарддаг.
<p>Баримт бичиг цуглуулах Аудитад шалгуулагч болон бусад эх сурвалжаас цуглуулсан баримт бичгүүдийг нягтлах.</p>	<ul style="list-style-type: none"> • Ярилцлагын үеэр цуглуулсан мэдүүлэг хэлбэртэй нотлох зүйлээс ерөнхийдөө илүү найдвартай гэж үздэг. • Ихэвчлэн илүү өргөн хүрээтэй, нарийн мэдээллээр хангадаг. 	<ul style="list-style-type: none"> • Эх сурвалжийн шударга байдал, үнэн байдал, эрх мэдэл болон найдвартай байдлыг сайтар харгалзан үзэх ёстой (5-р бүлгээс дэлгэрэнгүй үзнэ үү) • Аудитад шалгуулагчаас баримтын бэлэн нотлох зүйлс гаргаж өгөхгүй байгаа үед мэдээлэлд хандахад бэрхшээл тулгарч болно.
<p>Шууд ажиглалт болон үзлэг Чанарын мэдээлэл цуглуулахын тулд аудиттай холбогдох хөтөлбөр, хүмүүс, хөрөнгө болон үйл явдлуудыг биечлэн ажиглах.</p>	<ul style="list-style-type: none"> • Аудиттай холбогдох хөтөлбөр, хүмүүс, хөрөнгө болон үйл явдлыг шууд ажиглах боломж олгодог. • Аудиттай холбогдох асуудлуудын хам нөхцөлийн (хам сэдвийн) талаарх мэдээллээр хангаж болно. 	<ul style="list-style-type: none"> • Аудитын асуулт(ууд)ад шууд эсвэл хэсэгчлэн хариулах зорилготой ажиглалт нь нарийн төвөгтэй байж болно. • Нарийвчилсан төлөвлөгөө болон сайн хуваарь гаргахыг шаарддаг. • Ажиглалт нь ажиглагдаж буй хүний зан үйл эсвэл нөхцөл байдалд нөлөөлж болно. • Зам туулах болон ажилтнуудыг оролцуулахад ихээхэн нөөц шаардаж болно.
<p>Судалгаа Стандарт асуултууд ашиглаж хүн амаас (эх олонлогоос) нотлох зүйлс цуглуулахад ашигладаг өгөгдөл, мэдээлэл цуглуулах арга хандлага.</p>	<ul style="list-style-type: none"> • Олон хүнээс мэдээлэл цуглуулах арга. • Өгөгдлийг олон төрлийн шинжилгээнд ашиглаж болно. • Сонгосон хувьсагчийн өгөгдлийг ерөнхийлж эсвэл нарийвчилж болдог. 	<ul style="list-style-type: none"> • Нөөц болон хугацаа шаарддаг. • Сайн төлөвлөгөө болон тест шаарддаг. • Цаг хугацаа их шаарддаг шинжилгээ хийх шаардлагатай болж болно.
<p>Талбарын ажил Аудитын аргыг ашиглахын тулд газар зүйн тухайлсан байршилд очиж ажиллах.</p>	<ul style="list-style-type: none"> • Ярилцлага, баримт бичгийн нягталгаа, шууд ажиглалт болон биечилсэн үзлэг зэрэг олон янзын аргуудыг хослуулан ашиглаж болно. • Нэг талбарын ажлын үеэр олон аргыг хослуулан ашигласнаар өртгийн үр ашигтай байдлыг сайжруулж болно. 	<ul style="list-style-type: none"> • Нарийвчилсан дэвшилтэт төлөвлөгөө болон сайн хуваарь гаргахыг шаарддаг. • Зам туулах болон ажилтнуудыг оролцуулахад ихээхэн нөөц шаардаж болно. • Аудитад шалгуулагч этгээд буюу талбарын ажлын судлах сэдэв/ зүйл нь ямар зохион байгуулалттай байгааг сайтар ойлгохыг шаарддаг.
<p>Файлын нягталгаа ба бүтэцлэгдсэн ажиглалт Бүртгэлүүдээс авсан мэдээлэл болон ажиглалтыг системтэй бүртгэхэд ашигладаг өгөгдөл, мэдээлэл цуглуулах хэрэгсэл.</p>	<ul style="list-style-type: none"> • Тоон болон чанарын шинжилгээг дэмжихэд ашиглаж болох бүтэцлэгдсэн бөгөөд найдвартай өгөгдлийн багц үүсгэдэг. • Хуулийн эсвэл зохицуулалтын шаардлагад нийцэх нийцлийг үнэлэхэд шаардлагатай өгөгдлийг цуглуулах үр нөлөөтэй хэрэгсэл. • Хөтөлбөр эсвэл хүн амаар ерөнхийлөх боломжтой өгөгдлөөр хангадаг. 	<ul style="list-style-type: none"> • Энэ арга хандлагыг хэрэгжүүлэхэд ихээхэн цаг хугацаа болон нөөц шаардагддаг. • Нарийвчилсан дэвшилтэт төлөвлөгөө гаргаж, өгөгдөл цуглуулах хүчин төгөлдөр хэрэгсэл боловсруулахыг шаарддаг. • Илрүүлсэн дутагдлуудын шалтгааныг тодорхойлох боломж олгохгүй байж болно.

Арга

Үр өгөөж

Анхаарах зүйлс

Жижиг бүлгийн арга

Фокус бүлэг болон экспертүүдийн зөвлөл зэрэг хэрэгслийг ашиглан бүлэг хүмүүсээс мэдээлэл цуглуулах.

- Хэлэлцүүлэг нь ганцаарчилсан ярилцлагын үеэр дурдагдаагүй асуудлуудыг илрүүлж болно.
- Олон төрлийн аудитын хэрэгцээнд тохируулан ашиглах боломжтой.
- Асуудлууд эсвэл үйл ажиллагаануудад экспертүүд нэгдсэн харах өнцөг өгч болно.

- Зам туулах эсвэл экспертүүдийн зөвлөлийг хуралдуулахад өртөг өндөртэй байж болно.
- Мэдээллийн хэмжээ болон олон янз байдлын улмаас шинжилгээ хийхэд бэрх бөгөөд их хугацаа шаардсан болж болно.

Хоёрдогч эх сурвалжийн өгөгдөл

Засгийн газрын агентлагууд, их сургуулиуд болон судалгааны байгууллагууд зэрэг өөр этгээдийн цуглуулсан өгөгдөл.

- Өгөгдөл цуглуулах бусад аргуудаас илүү хурдан байж болно.
- Өгөгдөл нь та өөрөө цуглуулах байснаас илүү бүрэн байж болно.
- Чанарын шалгалтыг хэдийнээ хийчихсэн байж болно.

- Өгөгдөл нь аудитын зорилгод тохирохгүй байж болно.
- Өгөгдлийг үнэлэхэд хэцүү байж болно.
- Өгөгдлийн найдвартай байдлыг үнэлэхэд ихээхэн хугацаа шаардаж болно.

Кэйс судалгаа

"Яагаад" эсвэл "хэрхэн" гэсэн нарийн төвөгтэй асуултуудад хариулахыг зорьсон нэг эсвэл түүнээс олон нарийн төвөгтэй үйл явдал, тохиолдол эсвэл байршлын талаар дэлгэрэнгүй өгөгдөл цуглуулах.

- Тодорхой "бодит ертөнцийн" жишээнүүдийг ашиглан үйл ажиллагааны нарийвчилсан үнэлгээ хийх боломж олгож, өөр өөр байршил дахь үйл ажиллагаа хоорондын ижил төстэй болон ялгаатай талуудыг шинжлэхэд тусалж, хөтөлбөрүүдийн үйл явц болон доголлын үр дагаврыг зураглан харуулдаг.
- Аливаа сэдэв эсвэл нарийн төвөгтэй үйл явдлуудын талаар маш дэлгэрэнгүй мэдээлэл цуглуулах боломж олгодог.
- Энэ арга хандлага нь нотлох зүйлсийн нотлох чадварыг баталгаажуулж, илрүүлэлтүүдийн найдвартай бөгөөд хүчин төгөлдөр байдлыг нэмэгдүүлдэг.

- Ихээхэн хэмжээний цаг хугацаа болон нөөц шаардагдаж болно.
- Шинжилгээ хийхэд их хугацаа орж болно.
- Кэйс судалгааг сонгох нь мэдээлэл цуглуулалт болон илрүүлэлтүүдэд ихээхэн нөлөөлдөг.

Эх сурвалж: АДБОУБХС/ГАДХ-ны Хөгжлийн Баг.


Өгөгдөл, мэдээллийг тодорхойлсны дараа түүнийг хэрхэн шинжлэх гэж байгаа талаараа төлөвлөлтийн үе шатанд сайтар бодох шаардлагатай болно. Арга зүй боловсруулахдаа харгалзан үзэж болох хэд хэдэн шинжилгээний арга байдгаас 23-р зурагт заримыг нь үзүүлэв.

Зураг 23: Сонгосон өгөгдөл шинжлэх аргуудын үр өгөөж болон анхаарах зүйлс

Арга	Үр өгөөж	Анхаарах зүйлс
<p>Агуулгын шинжилгээ Ярилцлага, ихээхэн хэмжээний баримт бичиг зэрэг олон эх сурвалжаас авсан нарийн төвөгтэй чанарын мэдээллийг бүтэцжүүлж, шинжлэх арга.</p>	<ul style="list-style-type: none"> • Аудитын асуултууд болон зорилгод хэрэгтэй өгөгдлийн нийтлэг шинж буюу чиг хандлагыг тодорхойлох боломж олгодог. • Шинжилгээний ангиллыг боловсруулахад өгөгдөлд хөтлөгдөхийг зөвшөөрдөг. • Бусад аргуудыг ашиглахад хэрэгтэй мэдээллээр хангахад хэрэглэж болно. • Бүтэцлэгдээгүй өгөгдлийг хураангуйлж, шинжилж, тайлагнах боломж олгодог. 	<ul style="list-style-type: none"> • Хөдөлмөр, цаг хугаа их шаарддаг. • Буруу хэрэгжүүлбэл ашиглах боломжгүй үр дүнд хүргэж болно. • Төлөвлөлт болон ажилтнуудын сургалтыг шаарддаг.
<p>Статистикийн шинжилгээ ба загварчлал Томоохон өгөгдлийн багцууд дахь чиг хандлага, нийтлэг шинж болон харилцан хамаарлыг илрүүлэхийн тулд программ хангамж болон компьютерын загваруудыг ашиглах.</p>	<ul style="list-style-type: none"> • Ихээхэн хэмжээний өгөгдөл дэх нийтлэг шинжүүд болон харилцан хамаарлыг илрүүлэх боломж олгодог. • Ихээхэн хэмжээний тоон өгөгдлийг шинжлэх үр ашигтай бөгөөд бүтэцлэгдсэн аргаар хангадаг. 	<ul style="list-style-type: none"> • Өгөгдлийн шинжилгээний программ хангамжаар сайн мэргэшсэн байхыг шаарддаг. • Өгөгдлийн өгөгдөл шинжлэх программаар шинжлэх боломжтой болгохын тулд бүтэцжүүлэхэд ихээхэн цаг хугацаа болон нөөц шаардагдаж болно. • Ерөнхийдөө нийтлэг шинж болон харилцан хамаарлын шалтгааныг тодорхойлдоггүй.

Эх сурвалж: АДБОУБХС/ГАДХ-ны Хөгжлийн Баг.

Өгөгдөл цуглуулах ба дүн шинжилгээ хийх аргыг загварчилж байхдаа аудитын зорилго (ууд)-д чиглэсэн ба аудитын асуултуудад хариулсан байхаар нотлох зүйлийг аудитын баг олж авсан байхаар арга хандлагыг боловсруулсан байхыг хангахуйцаар та гэдэгт та итгэлтэй байхаар боловсруулах шаардлагатай. Түүнчлэн, танай багийн мэргэшил, өртөг болон хугацааны хязгаарлалт, мөн өгөгдлийн олдоц болон найдвартай байдлын улмаас үүсэх эрсдэлүүд болон хязгаарлалтуудыг та харгалзан үзэх шаардлагатай болно (доор буй эрсдэлийг удирдах тухай хэсгээс дэлгэрэнгүй үзнэ үү). Ихэнх тохиолдолд, олон эх сурвалжаас авах мэдээллийн үнэн зөвийг нотлохын тулд өгөгдөл цуглуулж, шинжлэх олон аргыг хамтатган ашиглах нь үр өгөөжтэй байх болно.



Та аудитынхаа арга зүйн талаарх анхны шийдвэрийг төлөвлөлтийн үе шатанд гаргах боловч, аудитаа гүйцэтгэх явцдаа арга зүйгээ нарийвчлан сайжруулах эсвэл тохируулан өөрчлөх шаардлагатай болж болно гэдгийг санагтун. Энэ тухай 5-р бүлэгт бүр дэлгэрэнгүй авч үзнэ.

Эх сурвалж: АДБОУБХС/ГАДХ-ны ХБ.

Аудитын аргыг ашигласан жишээ

Сав, баглаа, боодлыг дахин ашиглах үүрэг; 2018.

Энэ аудитыг гүйцэтгэхдээ аудитын баг өгөгдөл цуглуулж, шинжлэх олон тооны арга ашигласнаас дурдвал:

1. Ярилцлага. Хөтөлбөрийн зорилго, гүйцэтгэл, залилан болон алдаа гарах эрсдэлийн түвшин, мөн засгийн газраас түүнийг хянаж буй байдлын талаарх оролцогч талуудыг үзэл бодлыг ойлгох ярилцлага.

2. Шууд ажиглалт. Хөтөлбөр хэрхэн хэрэгжиж, хянан-шинжлэгдэж буйг ойлгохын тулд Байгаль орчны агентлагийн сав, баглаа, боодлын нийцлийн багийг шууд ажигласан.

3. Агуулгын шинжилгээ. Хууль, журам, бодлогын баримт бичгүүд, яамны тойм мэдээ, аудитын тайлан, салбарын тайлан болон холбогдох аудитын нийтлэгдсэн тайлангуудыг судалсан.

4. Статистикийн шинжилгээ. Хөтөлбөрт бүртгүүлж, итгэмжлэгдсэн компанийн тоо, системээр дамжуулан олсон гэж тайлагнасан орлогын хэмжээ болон дахин боловсруулсан сав, баглаа, боодлын тайлагнасан жингийн чиг хандлагыг тодорхойлохын тулд Үндэсний сав, баглаа, боодлын хог хаягдлын өгөгдлийн санд статистикийн шинжилгээ хийсэн.

Холбооны хяналт-шинжилгээ, үнэлгээний удирдамж нь бүх биш ч, ихэнх тэргүүлэх практикийг ашиглаж байна; 2019.

Энэ аудитыг гүйцэтгэхдээ аудитын баг өгөгдөл цуглуулж, шинжлэх олон тооны арга ашигласнаас дурдвал:

1. Агуулгын шинжилгээ. Агентлагийн удирдамж, баримтжуулалт болон ярилцлагуудыг 28 тэргүүлэх практиктай тулгаж судалсан агуулгын шинжилгээ.

2. Агуулгын шинжилгээ болон баримт бичгийн нягталгаа. Агентлагийн бодлого, удирдамж болон үйл ажиллагааны горимуудыг засгийн газрын удирдамжид тусгасан шаардлагуудтай тулгаж судалсан.

3. Ярилцлага. Агентлагийн албан тушаалтнуудтай хийсэн ярилцлага.

Эх сурвалж: АДБОУБХС/ГАДХ-ны Хөгжлийн Баг.

Эцсийн дүндээ, та дан гагц хэрхэн нотлох зүйл цуглуулж, аудитын асуултууддаа хариулахын тулд түүнийг хэрхэн шинжлэхийг харгалзан үзэх шаардлагатай бус, харин хэрхэн нотлох зүйлсийг үнэлж, найдвартай байлгах талаар ч мөн харгалзан үзэх шаардлагатай болно. Энэ бүх алхмууд хамтдаа таны аудитын арга зүйг бүрдүүлдэг. Арга зүйн талаар бид 5-р бүлэгт бүр дэлгэрэнгүй авч үзнэ.

Аудитыг зохиомжлох үеийн эрсдэлийг хэрхэн удирдах вэ?



Стандарт

Аудитор алдаатай, бүрэн бус аудитын тогтоосон зүйлс, дүгнэлт болон зөвлөмж боловсруулах, тэнцвэргүй мэдээллээр хангах эсхүл үнэ цэнийг нэмэгдүүлж чадахгүй байхаас зайлсхийхийн тулд аудитын эрсдэлийг үр дүнтэй удирдах ёстой.

Эх сурвалж: АДБОУС-3000/52.

Аудитыг загварчлах хүйл явцын туршид эрсдэлийг удирдах нь чухал. Аудитыг загварчлахын гол зорилго нь гол эрсдэлүүдийг илрүүлж, бууруулж, төлөвлөгөөнд оруулахад оршдог тул загварчлалтай холбогдох бүх шийдвэр нь эрсдэлд суурилсан байх ёстой.

Аудитын эрсдэл гэж нотлох зүйлийн хангалтгүй, эсхүл зохисгүй байдал, аудитын хангалтгүй үйл явц эсхүл алдаатай толилуулга эсхүл залилангийн үлмаас санаатай орхигдуулах эсхүл төөрөгдүүлсэн мэдээлэл зэрэг хүчин зүйлүүдээс болж аудитын илрүүлэлт, дүгнэлт болон зөвлөмжүүд нь зохисгүй эсхүл бүрэн бус байх боломжтой байхыг хэлнэ. (УДИР-3910/61). Үүнд, аудиторүүд алдаа, үл нийцэл буюу томоохон алдаа, эсвэл аудитыг дэмжих нотлох зүйлсэд агуулагдсан залилан зэргийг илрүүлэхгүй байх эрсдэл багтана. Эрсдэл нь тохиолдвол ноцтой үр дагавар үүсгэх үйл явдлын тохиолдох магадлалыг агуулж байдаг.

Эрсдэлийг хэрхэн илрүүлж, үнэлэх вэ?


Аудитыг загварчлах үед эрсдэлийг илрүүлж, үнэлэхийн тулд аудитын сэдвийн зорилгууд, бодлого болон үйл явцыг гол оролцогч талууд болон хяналтын хамтаар сайтар ойлгох зэргээр аудитын талбарын талаар баталгаатай, сүүлийн үеийн мэдлэгтэй байх шаардлагатай. Аудитын эрсдэлийг илрүүлэхдээ ажлын хугацаа, нарийн төвөгтэй байдал болон эмзэг байдал; санхүүгийн үнэ цэн болон үйлчилсэн иргэдийн тоо зэргээр хэмжигдэх үйл ажиллагааны хэмжээ; үл нийцэл, томоохон алдаа эсвэл залилангаас сэргийлэх, илрүүлэх аудитад шалгуулагчийн тогтолцоо болон үйл явцын хангалттай байдал; мөн аудиторүүдийн бүртгэлд хандаж нэвтрэх боломж зэрэг чанарын болон тоон хүчин зүйлсийг хамтад нь авч үздэг.

Аудитын ерөнхий эрсдэл болон аудитын боломжит арга хандлага тус бүрийн эрсдэлийг тодорхойлж, үнэлэх хэрэгтэй. Тэгснээр боломжит арга зүйнүүдийн өртөг, үр өгөөж болон хязгаарлалтуудыг тодорхой ойлгоно. Эрсдэлийг тодорхойлж, үнэлэх ажил нь олон хэлбэртэй байж болох ч ерөнхийдөө дараах асуултуудад анхаарах замаар хийгддэг (УДИР-3920/61):

- Аудитын багт аудит хийх хангалттай үр чадвар болон мэдлэг (мөн тухайлсан даалгавруудыг гүйцэтгэх тусгай мэдлэг) байна уу?
- Аудитыг гүйцэтгэхэд шаардлагатай цаг хугацаа болон нөөц нь бэлэн бөгөөд ашиглах боломжтой байна уу (тухайлбал, замын зардал, алдагдсан боломжийн өртгийн бусад аудитад үзүүлэх нөлөөлөл)?
- Аудитын сэдэв нь эмзэг, олон нийтэд ил эсвэл маргаантай юу (тухайлбал, улс төрийн хувьд эмзэг, хэвлэл мэдээллийнхний хувьд эмзэг)?
- Аудит болон судлах сэдэв/зүйл нь маш нарийн төвөгтэй, эсвэл угаас эрсдэлд өртөмтгий талбаруудыг хамруулсан уу (тухайлбал, ИТ-ийн системүүд, худалдан авах ажиллагаа, эрүүл мэнд болон байгаль орчны асуудлууд)?
- Аудитыг гүйцэтгэхээр томилогдсон аудиторүүдийн хараат бус байдалд бодит эсвэл харагдах байдал дээрх аюул учирч байна уу?
- Аудитад шалгуулагч этгээдийн удирдлагын шударга байдал эсвэл харилцаатай холбоотой эрсдэл байна уу?
- Хангалттай өгөгдөл бэлэн бөгөөд сайн чанартай байна уу (тухайлбал, өгөгдөлд хандах боломж болон найдвартай байдал)?

Эрсдэлийг тодорхойлж, үнэлэхдээ аудитад шалгагдагч этгээд одоогийн аудитын хам нөхцөлд хамааралтай өмнөх аудитуудын илрүүлэлтүүд болон зөвлөмжүүдийн дагуу зохих залруулах арга хэмжээ авсан эсэхийг үнэлэх нь тустай байж болно. Энэ мэдээллийг одоогийн аудитын ажлын мөн чанар, хугацаа болон цар хүрээг тодорхойлоход, мөн одоогийн аудитын хувьд залруулах арга хэмжээний хэрэгжилтийг хэрхэн шалгахыг тодорхойлоход ашиглаж болно. Нэгэнт эрсдэлүүдийг мэддэг болсон бол, эрсдэлийг хүлцэх түвшнээ сайтар бодолцож үзэх хэрэгтэй. Өөрөөр хэлбэл, аудитын зорилгуудыг биелүүлэхэд саад болохгүй хэмжээний аудитын гүйцэтгэлийн хэлбэлзлийн зөвшөөрөгдөх түвшнийг бодож үзэх хэрэгтэй. Эрсдэлийг хүлцэх түвшнийг мөн даалгаврыг гүйцэтгэхийн үр өгөөжтэй жишиж тэнцвэржүүлж байх хэрэгтэй. Тухайлбал, судалгаа хийх болсон тохиолдолд, оролцогчдын хариултын үзүүлэлт доогуур байх эсвэл судалгааг зохих ёсоор зохиомжилж, явуулахад шаардлагатай ажилтнууд хязгаарлагдмал байх зэрэг эрсдэлүүдийг хүлцэх түвшнийг уг судалгааны боломжит үр өгөөжтэй жишин тэнцвэржүүлэх хэрэгтэй.

Эрсдэлийг хүлцэх түвшнийг тодорхойлохдоо, хүлээлт ёсоор, хугацаанд нь гүйцэтгэхгүй бол төслийн гүйцэтгэлийг хойшлуулах даалгавруудаас бүрдэх аудитын “зонхилох хэсэг” (critical path) нөлөөлөх магадлал хамгийн өндөр эрсдэлүүд дээр төвлөрнө.

 Аудитын явцад эрсдэлийг илүү сайн үнэлэхийн тулд гол эрсдэлүүдийг зохиомжийн хүснэгтэд оруулж, эрсдэлтэй даалгавруудад хангалттай хугацаа хуваарилж, төслийн хуваарь эсвэл ажлын задаргааны зураглалд тусгаж болно. Төслийн хуваарь нь мөн аль даалгавар нь маш чухал бөгөөд эрсдэлийг нь бууруулах хамгийн шаардлагатай вэ гэдгийг тодорхойлоход тусалдаг. “Аудитын төлөвлөгөөг хэрхэн баримтжуулах вэ?” гэсэн хэсгээс аудитыг зохиомжлоход ашигладаг эдгээр чухал хэрэгслүүдийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл авна уу.

Эх сурвалж: АДБОУБХС/ГАДХ-ны ХБ.

Аудитыг зохиомжлох үед эрсдэлийг үнэлэх арга хандлага нь аудитын орчин нөхцөл болон арга хандлагаас хамаараад янз бүр байж болох бөгөөд мэргэжлийн үнэлэмжийн асуудал юм. Судлах сэдэв/ зүйлийн талаарх мэдлэгийг дээшлүүлж, аудитын эрсдэлийн шинжилгээнд туслах хэрэгслүүдийг 5-р хавсралтаас үзнэ үү.


Аудитын эрсдэлийг хэрхэн бууруулах вэ?

Аудитын эрсдэл болон хүлцэх түвшнийг тодорхойлж, үнэлсний дараа аливаа томоохон эрсдэлийг бууруулах эсвэл үр нөлөөг нь бууруулах алхмуудыг төлөвлөх зэргээр удирдах нь чухал (УДИР-3920/62). Үүнийг олон янзын арга хэмжээгээр дамжуулан хийж болно. Тухайлбал:

- Ажлын хамрах хүрээг өргөсгөх эсвэл хумих;
- Мэргэжилтнүүд (жишээ нь арга зүйчид), нягтлагчид эсвэл нэмэлт ахлах ажилтан нэмэх;
- Нөөцийг нэмэгдүүлэх;
- Аудитын төлөвлөгөөг шинэчилж, ахицыг явцын зорилтуудтай тогтмол тулгаж хянан-шинжлэх эсвэл тандан судлах;
- Боломжтой бол, өндөр эрсдэлтэй даалгавруудад илүү их цаг хуваарилж өгөх;
- Нэмэлт нотлох зүйлс, өндөр чанартай нотлох зүйлс болон нотлох чадвартай нотлох зүйлсийн хувилбаруудыг олж авах аргаа өөрчлөх;
- Илрүүлэлтүүд болон дүгнэлтүүдийг эгнүүлж, олж авсан нотлох зүйлсээ тодотгон харуулах; мөн
- Хянан удирдлагын болон удирдлагын нягталгааг нэмэгдүүлэх.

Танай аудитын баг өгөгдлийн чанарт санаа зовж байгаа тохиолдолд, өгөгдлийн ашиглалттай холбогдох эрсдэлийг бууруулах төлөвлөгөөг дараах байдлаар гаргаж болно: өгөгдлийг баяжуулах эсвэл нотолгоотой болгохын тулд бусад эх сурвалжуудаас нэмэлт нотлох зүйлс цуглуулах; мөн тайланд өгөгдлийн эх сурвалж болон чанарын тухай мэдээллийг, түүнийг ашиглах эсвэл хөрвүүлэн ойлгоход тулгарах аливаа холбогдох хязгаарлалтуудын тухай тайлбарын хамт оруулах. Аудитаа гүйцэтгэхэд зориулж зөвхөн хангалттай найдвартай гэж тогтоосон өгөгдлөө ашиглах хэрэгтэй гэдгийг санагтун.

Эрсдэлийг бууруулах арга замуудыг бодолцож үзэхдээ, аудитын арга хандлагуудын үнэ цэнийг сайтар ойлгож, хөрөнгө оруулсан нөөцийн өгөөжийг хамгийн сайн байлгахын тулд аудитын арга хандлагуудтай холбогдох эрсдэл болон түүнийг бууруулах алхмуудыг уг арга хандлагуудын үр өгөөжтэй үргэлж жишиж тэнцвэржүүлж байх хэрэгтэйг санагтун. Нийт аудитын туршид эрсдэлийг удирдах үйл явцын талаар 2-р бүлэгт ерөнхийлөн оруулсан болно.

 Гол эрсдэлүүдийг бууруулах төлөвлөгөөг аудитын зохиомжийн хүснэгтэд оруулж болно. Аудитын зохиомжийн хүснэгтийн тухай "Аудитын төлөвлөгөөг хэрхэн баримтжуулах вэ?" гэсэн хэсэгт оруулав.

Эх сурвалж: АДБОУБХС/ГАДХ-ны ХБ.

Гүйцэтгэлийн аудитад шаардлагатай хугацаа болон нөөцийг хэрхэн тодорхойлох вэ?

Аудитаа зохиомжлох үедээ, хэрэгжих боломжтой хугацаа болон нөөцийг тогтоох нь маш чухал. Ингэснээр ажлыг төслийн сайн удирдлагын зарчмуудын дагуу, арвилан хэмнэлттэй, үр ашигтай, үр нөлөөтэй бөгөөд цаг хугацаандаа багтсан байдлаар гүйцэтгэж чадна. Хязгаарлагдмал хугацаанд сайн чанартай аудит хийхийн тулд аудитыг төсөл гэж бодох нь тустай байж болно. Учир нь аудит бол тодорхой зорилгуудад хүрэхийн тулд нөөцийг төлөвлөж, зохион байгуулж, хамгаалж, удирдаж, манлайлж, хянадаг үйл ажиллагаа юм. Хугацаа болон нөөцийг тодорхойлохдоо дараах зүйлсийг онцгойлон анхаарна уу:

- Аудит болон түүний хүрээнд гүйцэтгэх даалгавруудад хэрэгжүүлэх боломжтой хугацааг нь тодорхойлж өгөх. Энэ нь төлөвлөсөн арга зүй болон бусад холбогдох хүчин зүйлсэд, тухайлбал дотоод аудитын үйл явцууд, өнгөрсөн үеийн аудитууд, оролцогч талуудын харах өнцөг, мэдээлэлд хандах боломжийн тухай таамаг, мөн нөөцийн бэлэн байдалд үндэслэх ёстой;

- Ажлыг зохих хугацаанд нь гүйцэтгэхийн тулд хангалттай тооны аудиторрууд, хянагчид болон дотоод хийгээд гадаад оролцогч талуудыг тодорхойлж, уялдаа холбоо үүсгэж, үүрэг даалгаврыг нь тодорхой болгож өгөх. Энэ үйл явцыг хэрэгжүүлэхдээ тэдгээрийн хамтын мэдлэг, үр чадвар, чадвар, хараат бус байдал болон хөгжлийн хэрэгцээг харгалзаж үзэх ёстой. Аудитын багийг чадамжтай байлгах талаар нэмэлт мэдээллийг 2-р бүлгээс үзнэ үү; мөн
- Замын зардал, сургалт, тоног төхөөрөмжийн зардал болон судлах сэдэв/ зүйлээр мэргэшсэн гаднын экспертүүдтэй холбогдон гарах зардал, мөн бусад туслах зардлуудыг тодорхойлох. Дотоод ажилтнуудын нөөцийг ерөнхийдөө ажлын өдрөөр төсөвлөж, дотоод бүртгэлийн системд бүртгэн хадгалдаг бол гаднын оролцогч талуудын хувьд тусдаа зардал үүсгэж болно.

Аудитын төлөвлөгөөг хэрхэн баримтжуулах вэ?

Аудитын төлөвлөгөө гэж юу вэ?

Аудиторрууд нь ажлаа чиглүүлж, аудитаа зохих ёсоор загварчлахын тулд аудитын төлөвлөгөө бичиж бэлдэх нь чухал (УДИР-3920/56-58). Аудитын төлөвлөгөөний зорилго нь өмнө авч үзсэн загварчлах хүчин зүтгэлийг уялдаатай болгож, баримтжуулж, зохиомжийн бүх анхаарах асуудлууд болон бүрэлдэхүүн хэсгүүдийг нэгтгэхэд оршдог. Аудитын төлөвлөгөөний хэлбэр болон агуулга нь аудитуудын хувьд өөр өөр байж болох ч, ихэвчлэн зохиомжийн хүснэгт, төслийн хуваарь болон өөр бусад тохиромжтой аудитын баримтжуулалтыг агуулдаг. Үүнд, аудитын зорилгууд, хамрах хүрээ болон арга зүйн талаарх гол шийдвэрүүд болон уг шийдвэрүүдийг гаргасан аудиторруудын үндэслэл зэрэг багтана. Тодруулбал, СВOT шинжилгээ (давуу тал, сул тал, боломж болон аюулын шинжилгээ) болон Эрсдэлийг тулган баталгаажуулах диаграмм (RVD диаграмм), аудитын урьдчилсан судалгааны үр дүн, өгөгдөл цуглуулах төлөвлөгөө болон хэрэгслүүд зэрэг олон зүйлс багтаж болно (5-р хавсралтыг үзнэ үү). Эдгээр зүйлс нь хамтдаа дараах зүйлсийг хамруулах ёстой:

- Судлах сэдэв/ зүйл болон аудитад шалгуулж буй этгээдийг ойлгоход шаардлагатай суурь мэдлэг хийгээд мэдээлэл;
- Аудитын зорилго(ууд), асуултууд, шалгуур болон хамрах хүрээ, мөн аудитад хамруулах хугацаа;
- Эрсдэлийн үнэлгээний үр дүн;
- Нотлох зүйл цуглуулж, аудитын шинжилгээ хийх аргууд;
- Гол даалгаврууд, цаг хугацааны хуваарь, явцын зорилтууд, нөөцүүд (багийн гишүүд болон гаднын экспертүүдийг ажиллуулах хэрэгцээ) болон хяналтын цэгүүд зэргийг агуулсан аудитын ажлыг гүйцэтгэх төлөвлөгөө; мөн
- Аудитын тооцоолсон өртөг, АДБ-ын төлөвлөлтийн тогтолцооноос хамаараад ажилтны зардлыг багтаасан болон багтаагаагүй өртөг.

Аудитын бичмэл төлөвлөгөө нь АДБ-ын удирдлагад аудитын загварчлалыг хянан удирдаж, олон зүйлийг тодорхойлох боломж олгодог. Тухайлбал, санал болгосон аудитын зорилгууд болон асуултууд нь хэрэгцээт чанар сайтай тайланд хүргэх эсэх; аудит

нь эрсдэлийг хангалттай үнэлэх эсэх; санал болгосон хамрах хүрээ болон арга зүй нь аудитын зорилго(ууд)ыг хангалттай биелүүлэх эсэх; мөн бэлэн байгаа нотлох зүйлс нь аудитад хангалттай бөгөөд зохистой байж чадах эсэхийг тодорхойлох боломж олгодог.

Төлөвлөгөө нь мөн хамтдаа хангалттай мэргэжлийн чадамж болон бусад нөөцтэй хангалттай тооны ажилтнууд, хянагчид болон мэргэжилтнүүд аудитыг төлөвлөсөн хугацаанд гүйцэтгэж чадах эсэхийг тогтооход удирдлагад туслах хэрэгсэл юм. Ийм учраас аудитын төлөвлөгөөг доор буй Гүйцэтгэлийн аудитыг загварчлах үед дотоод, гадаад оролцогч талууд болон удирдлагыг хэрхэн оролцуулах вэ? гэсэн хэсэгт хэлэлцсэнчлэн АДБ-ын удирдлагад батлуулахаар илгээх нь чухал юм. Ийнхүү батлагдсан төлөвлөгөө нь танай багийн аудитын ажлыг чиглүүлж, ахицыг нь тогтмол хянан-шинжлэх үндэс сууриар удирдлагуудыг хангадаг. Үр нөлөөтэй ингэхийн тулд, аудитын төлөвлөгөө нь аудитын явцад орчин нөхцөл өөрчлөгдөж, мэдлэг гүнзгийрэхтэй уялдан өөрчлөгдөх боломжтой, уян хатан байх ёстой.

Загварын хүснэгтийг хэрхэн боловсруулах вэ?

Аудитын загварын хүснэгт бол аудитын загварыг тоймлон харуулж, баримтжуулах гол хэрэгсэл юм. Тус хүснэгт нь таны аудитын загварын элементүүдийг уялдуулан нэгтгэх бүтцээр хангаж, загварчлах үйл явцыг илүү системтэй, чиглэлтэй болгохоос гадна танай АДБ-ын дотоод оролцогч талуудтай аудитын арга хандлагын талаар харилцах боломж олгодог. Загварын хүснэгт нь аудитын хамрах хүрээ, зорилго(ууд), шалгуур болон аргуудыг баримтжуулж, уялдуулахад тусалдаг бөгөөд аудитын арга хандлага болон хүрэх магадлалтай үр дүнгүүд хооронд учир шалтгааны логик гинжин холбоо үүсгэдэг. Түүнчлэн, оролцогч талуудад аудитын загварын талаар нэгдмэл ойлголттой болж, эцэстээ төлөвлөсөн арга хандлага дээр санал нэгдэх үндэс суурийг тавьдаг. Загварын хүснэгтийг аудитыг загварчлах үед анх бэлтгэдэг боловч тус хүснэгт бол аудитын ажил урагшлах тусам шаардлагатай үеүдэд нягтлагдаж, шинэчлэгдэж байдаг амьд баримт бичиг юм.

Загварын хүснэгт нь дараах үндсэн зорилгуудтай:

- Аудитын арга хандлагыг баримтжуулж, албажуулах;
- Аудитын загварыг хураангуйлан тоймлож харуулах;
- Аудитын хамрах хүрээ, зорилгууд болон арга зүй хооронд тодорхой холбоо үүсгэх замаар аудитын ажлын “яагаад, юуг, хэн” гэсэн асуултуудыг тодорхойлж, баримтжуулах;
- Гүйцэтгэсэн ажлыг хүрэх ёстой үр дүнтэй нь уялдуулах; мөн
- Оролцогч талуудтай харилцах, аудитыг хянан удирдах болон нягтлахад туслах.

Хүснэгтийг бэлтгэх үедээ, хэрэгцээ болон ашиг сонирхлыг нь харгалзан үзэх боломжтой болгохын тулд аудитын тайлангийн зорилтот хэрэглэгчдийг сайтар тодорхойлох хэрэгтэй. Ингэх нь тайланг зорилтот хэрэглэгчдэд нь хэрэгцээтэй бөгөөд ойлгомжтой болгоход тусална. Гэхдээ, зорилтот хэрэглэгчдэд анхаарах нь тэнцвэртэй бөгөөд хараат бус гүйцэтгэлийн аудит хийх үүрэг хариуцлагыг хүлээсэн аудитын багийн хараат бус байдал болон бодитой хандлагыг ямар ч үед алдагдуулахгүй байх ёстой.

24-р зурагт загварын хүснэгтийн маягтын жишээг хэсэг бүрийг нь бөглөх зааварчилгааны хамт харууллаа. Монгол Улсын Төрийн аудитын байгууллага Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан заавар, аргачлалын дагуу “Аудитын загварын матриц”-ыг ашигладаг. Агуулгын хувьд “Загварын хүснэгт”-тэй ижил юм.

Зураг 24: Загварын хүснэгтийн маягт

- Асуудлыг хам нөхцөлөөр нь авч үзэж, яагаад чухал вэ гэдгийг бичнэ үү.
- Аудитыг яагаад хийж буйг бичнэ үү.
- Аудитын баг болон аудитын тайлангийн зорилтот хэрэглэгчдийг тодорхойлно үү.
- Аудитын ерөнхий зорилго(ууд)ыг танилцуулна үү.

Аудитын асуулт(ууд)	Шалгуур болон шаардлагатай мэдээлэл, түүний эх сурвалж(ууд)	Хамрах хүрээ ба арга зүй, мөн өгөгдлийн найдвартай байдал	Хязгаарлалтууд	Ажлын хүлээгдэж буй үр дүн
<p>Аудитын гол асуултуудыг тодорхойлно.</p> <p>Аудитын асуултууд нь тайлбарласан эсвэл үнэлсэн шинжтэй байж болно.</p> <p>Асуулт бүрийг тодорхой, бодитой, төвийн сахисан, хэмжиж болохуйц, хийж болохуйц байлгана. Гол нэр томъёонуудыг тодорхойлно.</p> <p>Ерөнхий асуултыг дагуулж нарийвчилсан дэд асуултууд оруулах нь заримдаа хамрах хүрээг тодруулж, илүү үл суурьтай илрүүлэлт бий болгоход тусалдаг. Дэд асуултын тоог гурваас илүүгүйд хязгаарлана.</p> <p>Аудитын дүгнэлт гарах дөхөх үед аудитын асуултуудыг тодотгон сайжруулж илрүүлэлтүүдээ илүү оновчтой болгоно.</p>	<p>Шалгуур: Шалгуурыг тодорхойлно эсвэл ашиглах шалгуурыг тогтоох баримт бичгүүдийг цуглуулах төлөвлөгөө гаргана.</p> <p>Өмнө хэлэлцсэнчлэн, шалгуур тогтооходоо хууль, журам, бодлого, сайн туршлага болон юмс хэрхэн байх ёстойг заасан бусад найдвартай стандартуудыг ашиглаж болно.</p> <p>Шаардлагатай мэдээлэл ба эх сурвалж: Аудитын асуултуудад хариулахад шаардагдах мэдээлэл болон баримт бичгүүд, хөтөлбөрийн ажилтнууд, өгөгдлийн сангууд, судлах сэдэв/ зүйлийн экспертүүд зэрэг үг мэдээллийн эх сурвалжийг тодорхойлох.</p> <p>Эхний баганад дэд асуултуудыг оруулсан бол, заавал нэг нэгээр нь уялдуулан харгалзуулах албагүй. Асуултад хариулахад юу хэрэгтэйг бодолцож үзээд давталтаас зайлсхийнэ.</p>	<p>Хамрах хүрээ: Судалгааны зорилготой холбогдох ажлын төлөвлөсөн хамрах хүрээг тодорхойлно. Хамрах хүрээ нь таны зорилгот ажлын хил хязгаар болон цаг хугацааг тодорхойлно.</p> <p>Арга зүй: Шаардлагатай өгөгдөл, мэдээллийг цуглуулах баримт бичгийн нягталгаа, өгөгдөл цуглуулах хэрэгслүүд, асуумжууд, фокус бүлгүүд болон кэйс судалгаа зэрэг стратегиудаа тайлбарлана. Стратеги тус бүрийн төлөвлөсөн хамрах хүрээ буюу цаг хугацаа, байршил болон түүврийн хэмжээ зэргийг тодорхойлно.</p> <p>Цуглуулсан мэдээллийг шинжлэхэд ашиглах агуулгын шинжилгээ, кэйс судалгааны хураангуй, регрессийн шинжилгээ зэрэг шинжилгээний техникүүдийг тодорхойлно.</p> <p>Өгөгдлийн эх сурвалжийн найдвартай байдлыг үнэлэхийн тулд хийх алхмуудыг тодорхойлно.</p>	<p>Шаардлагатай мэдээлэл, төлөвлөсөн арга зүй эсвэл аудитын асуултад хариулах таны ерөнхий чадвартай холбогдох аливаа хязгаарлалтуудыг тодорхойлно. Хязгаарлалт гэдэгт өгөгдлийн чанар болон найдвартай байдлын асуудал, зарим мэдээлэлд хандах боломжгүй байдал, ажилтны болон замын зардлын хязгаарлалт, илрүүлэлтүүдийг ерөнхийлөх эсвэл экстраполяц хийх боломжгүй байдал зэрэг орж болно.</p> <p>Хязгаарлалт тус бүр бүтээгдэхүүнд хэрхэн нөлөөлж болохыг хэлэлцэж, холбогдох сорилтуудыг бууруулахын тулд хийх алхмуудыг тодорхойлно.</p> <p>Хязгаарлалт нь таны аудитын асуултад хариулах чадварт материаллаг байдлаар нөлөөлөхүйц ноцтой байвал үг эрсдэлийг бууруулахын тулд асуултаа дахин томъёолох, мөн/эсвэл хамрах хүрээгээ өөрчлөх талаар бодолцож үзнэ.</p>	<p>Гүйцэтгэсэн ажлын дунд аудитын баг юу хэлж чадах магадлалтайг хураангуйлж, ажлын хүлээгдэж буй үр дүнг тодорхойлно.</p> <p>Хүлээгдэж буй үр дүн нь эхний баганад буй аудитын асуултуудад хариулах ёстой.</p>

Эх сурвалж: АНУ-ын ТХГ.

Энэхүү загварын хүснэгтийг өөр бусад хэлбэрээр мөн баримтжуулж болно. Жишээ нь, дээрхтэй адил мэдээллийг бүтэцлэгдсэн хүснэгтэд оруулахгүйгээр хүүрнэсэн хэлбэрээр толилуулдаг загварын хуудас байж болно. Загварын хуудас нь өөрөө аудитын орчин нөхцөл болон ажилтнуудын/үдирдлагуудын үзэмжээс хамаараад хэд хэдэн хэлбэртэй байж болно. Хэрэв загварын хуудас ашиглах бол, 6-р хавсралтад буй шалгах хуудсыг ашиглаж загварын хуудсанд аа шаардлагатай мэдээллүүдийг бүрэн оруулсан эсэхийг шалгана уу.

Төслийн хуваарь болон ажлын задаргааны зураглалыг хэрхэн боловсруулах вэ?

Төслийн хуваарь болон ажлын задаргааны зураглал нь ажлыг гүйцэтгэх замын зураглал болж, ажлыг “хэрхэн”, “хэзээ”, “хэн” хийх вэ гэсэн нарийвчилсан асуултуудад хариулдаг. Загварын хүснэгтийн нэгэн адил, төслийн хуваарь болон ажлын задаргааны зураглал (ажлын задаргааны зураглал байнгын шаардлагатай биш) ашиглах тохиолдолд, аудитыг загварчлах үе шатанд анх боловсруулж бэлтгэх хэрэгтэй. Гэвч, аудит хийх үйл явц нь хөдөлгөөнгүй үйл явц биш тул та хийгдэж буй бүх ажлыг төлөвлөгөөнд оруулж, аудитыг үр ашигтай байдлаар үргэлжлүүлэхийн тулд хуваарь болон ажлын задаргааны зураглалаа тасралтгүй хянан-шинжилж, шаардлагатай тохиолдолд залруулах арга хэмжээг авах ёстой.

Төслийн хуваарь болон ажлын задаргааны зураглал нь хамтдаа танд дараах зүйлсийг тодорхойлж, баримтжуулахад тусална:

- Багийн гүйцэтгэх тухайлсан даалгаврууд;
- Даалгаврыг хэзээ гүйцэтгэх (хугацаа болон дараалал), мөн хэр удаан үргэлжлэх;
- Даалгаврууд өөр хоорондоо хэрхэн холбогдох;
- Хэн шаардлагатай бөгөөд бэлэн байгаа, мөн хэр хугацаанд;
- Бусад шаардлагатай нөөцүүд (тухайлбал, замын зардал, сургалтын зардал);
- Зорилтот огноонууд (өөрөөр хэлбэл, гол шийдвэрүүдийг гаргах, ахицыг үнэлэх огноонууд); мөн
- Гол даалгавар бүртэй холбогдох үйл ажиллагаануудын дэлгэрэнгүй.

Төслийн хуваарь болон ажлын задаргааны зураглал нь ижил төстэй хэрэгслүүд боловч өөр өөр төрлийн мэдээллээр, өөр өөр хэмжээний нарийвчлалтай хангадаг. Тодруулбал, ерөнхийдөө бүх аудитад зориулан боловсруулдаг төслийн хуваарь нь аудитын гол үйл ажиллагаанууд, үргэлжлэх хугацаа болон холбогдох ажилтнуудад төвлөрч, аудитын даалгавруудыг тодорхойлж, дэс дараалалд оруулж, нөөцийг хуваарилж, ашиглалтыг нь ойроос хянан-шинжлэх боломж олгодог. Харин, ажлын задаргааны зураглал нь танд ажлыг ялгаатай хэсгүүдээр нь задалж, ажлын хамрах хүрээг тодорхойлж, хяналтаар хангахын тулд гүйцэтгэх даалгавруудыг шаардлагатай хэмжээний нарийвчлалтайгаар тодорхойлдог. Ажлын задаргааны зураглал нь ерөнхийдөө ажилтай холбогдох хугацааг онцолдоггүйгээрээ төслийн хуваариас ялгардаг. Ерөнхий цаг хугацааны хуваарийг бус, тодорхой нарийвчилсан алхмуудыг гүйцэтгэхэд зориулсан судалгаа болон хяналтын фокусыг боловсруулах зэрэг томоохон хэмжээний хүчин зүтгэлтэй холбогдох ажлыг

нарийвчлан тодорхойлох шаардлагатай үед ажлын задаргааны зураглал хэрэгтэй байж болно. Та ажлын задаргааны зураглалыг ч, эсвэл зөвхөн төслийн хуваарийг ч ашиглахаар сонгосон бай, аудитын үйл явцыг ажилтнуудын цагийн зардал болон төсөвлөсөн нөөцийн хамтаар сайтар хянан-шинжлэх нь чухал.


7-р хавсралтаас төслийн хуваарь (ерөнхий болон нарийвчилсан хувилбарууд) болон ажлын задаргааны зураглалын маягтууд, жишээнүүд болон дэлгэрэнгүй тайлбаруудыг үзнэ үү.

Гүйцэтгэлийн аудитыг загварчлах үед дотоод, гадаад оролцогч талууд болон удирдлагыг хэрхэн оролцуулах вэ?

Дотоод оролцогч талууд (техникийн экспертүүд, хуулийн экспертүүд, арга зүйчид) болон удирдлагатайгаа, мөн аудитад шалгуулагч этгээд, хууль тогтоох засаглал, хэвлэл мэдээллийнхэн болон бусад сонирхогч талууд зэрэг гадаад оролцогч талуудтай үр нөлөөтэй харилцаа үүсгэх нь аудитаа зөв төлөвлөж, гүйцэтгэхэд нэн чухал.

Дотоод оролцогч талууд болон удирдлагатай хэрхэн харилцах вэ?

Аудитын сайн төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэх таны чадвар нь аудитыг загварчлах үйл явцын эхэн үе болон үйл явцын туршид дотоод оролцогч талууд болон АДБ-ын удирдлагатай харилцах хэр хэмжээнээс тань ихээхэн хамаардаг. Өмнө хэлэлцсэнчлэн, аудитын төлөвлөгөөг дотоод оролцогч талуудтай хамтран боловсруулж, АДБ-ын удирдлагуудад хүргүүлж батлуулах хэрэгтэй. Энэ үйл явцын нэг хэсэг болгож аудитын баг, хянагч, дотоод оролцогч талууд болон удирдлагууд хамтдаа загварын хүснэгт, төслийн хуваарь болон сонгосон бусад хэрэгслээр баримтжуулсан аудитын төлөвлөгөөг хэлэлцэж, санал нэгтэй болох нь тустай байх болно. Ингэх нь бүх талуудыг аудитын арга хандлага дээр нэгдсэн саналтай болгож, аудитын төлөвлөгөөг хараахан туршаагүй байгаагийн улмаас оршин байж болох аудитын аливаа эрсдэлийг хүлээн зөвшөөрүүлэхэд хэрэгтэй. Үүнийг ихэвчлэн АДБ-ын бодлогоор шаарддаг албан уулзалтаар дамжуулан хэрэгжүүлдэг.



Эх сурвалж: АДБОУБХС/ГАДХ-ны ХБ.

Энэ бүлгийн туршид хэлэлцсэнчлэн, аудитыг загварчлах бол тасралтгүй үйл явц юм. Иймд та удирдлагуудтайгаа тогтмол уулзалт төлөвлөж, аудитын ахиц болон хуваарилагдсан нөөцийн ашиглалтын талаар тэдэнд мэдээлдэг байх нь чухал. Энэ нь удирдлагуудад аудитын төлөвлөгөөнд оруулах шаардлагатай аливаа өөрчлөлтийг чиглүүлж, аудитыг амжилттай хийхэд хуваарилагдсан нөөцийг үргэлж хангалттай байлгах боломж олгоно. Түүнчлэн, та дотоод оролцогч талуудтай үе үе зөвлөлдөж, тэдний мэргэшлийг ашигладаг байхаар төлөвлөх нь мөн адил чухал юм. Ингэхдээ мөчлөгт уулзалтууд, аудитын чухал

цэгүүдэд товлосон хэлэлцүүлгүүд, статусын шалгалт болон шуурхай зөвлөгөөн зэргийг зохион байгуулж болно.

Аудитын ажил өрнөж эхлэх үед оролцогч талууд (арга зүйчид, хуулийн экспертүүд гэх мэт) болон удирдлагатай хоёулантай нь харилцах тасралтгүй харилцаа нь аудитын төлөвлөгөөг гүйцэтгэх болон урьдчилсан илрүүлэлтүүд дээр төвлөрөх ёстой. Түүнчлэн, төслийн хуваарь, загварын хүснэгт болон ажлын задаргааны зураглал зэрэг хэрэгслүүд нь оролцогч талууд болон удирдлагуудыг тогтмол оролцуулах механизмаар хангадаг.

Гадаад оролцогч талууд болон удирдлагатай хэрхэн харилцах вэ?



Стандарт

Аудитор нь аудитын үйл явцын турш аудитад шалгуулагч этгээд болон холбогдох оролцогч талуудтай аудитын гол хэсгүүдийн талаар харилцах үр нөлөөтэй бөгөөд зохистой харилцааг төлөвлөж, хэрэгжүүлэх ёстой.

Аудитор нь оролцогч талуудтай харилцах харилцааг АДБ-ын хараат бус байдал болон голч байдлыг алдагдуулдаггүй байлгахад санаа тавих ёстой.

Эх сурвалж: АДБОУС-3000/55; АДБОУС-3000/59.

Аудитаа загварчлах үед, аудитад шалгуулагч этгээд, хууль тогтоох засаглал болон засгийн газрын бусад холбогдох газрууд, мөн шаардлагатай тохиолдолд хэвлэл мэдээллийнхэн зэрэг төрийн бус оролцогч талууд гэх мэт гадаад оролцогч талуудтай харилцах нь чухал.

Аудитад шалгуулагч этгээдтэй харилцах харилцаа нь аудитыг төлөвлөх үе шатанд эхэлж, аудитын үйл явцын туршид үргэлжлэх хэрэгтэй (УДИР-3910/64). Аудитад шалгуулагч этгээдтэй эртнээс харилцаж, аудитын судлах сэдэв/ зүйл, зорилго(ууд), шалгуур, аудитын асуултууд болон шаардлагатай мэдээлэл зэргийг аудитын үргэлжлэх хугацаа, аудитад хамрагдах засгийн газрын үйл ажиллагаа, байгууллага болон/эсвэл хөтөлбөрийн хамт хэлэлцэх нь чухал (УДИР-3910/65). Эдгээр гол зүйлсийг хэлэлцсэнээр чухам ямар аудитыг ямар шалтгаанаар хийж, ямар үр дүнд хүрч, аудитад шалгуулагч этгээдэд хэрхэн нөлөөлөх гэж байгаа талаар тодорхой зураглал үүснэ. Түүнчлэн, харилцаа нь үзэл бодлоо солилцож, үл ойлголцлоос зайлсхийж, аудитын үйл явцыг дэмжих үндэс суурийг тавьдаг. Гэхдээ энэ нь аудитад шалгуулагч этгээд аудитын нөхцөлийг тогтооно эсвэл аудитын үйл явцыг ямар нэгэн байдлаар удирдана гэсэн үг биш. Харин, үр нөлөөтэй аудитыг гүйцэтгэхэд нэн чухал хүчин зүйл болох аудитад шалгуулагч этгээдтэй харилцах бүтээлч үйл явцыг бий болгоход тусалдаг. (УДИР-3910/66)

Харилцааны хэлбэр, агуулга болон хугацаа/давтамжийг аудитад шалгагдагч этгээдийн удирдлагатай эсвэл засаглалыг нь хариуцсан хүмүүстэй хэлэлцэн тогтох нь мэргэжлийн үнэлэмжийн асуудал юм. Гэхдээ, ерөнхийдөө бичгийн харилцаа болон биечилсэн уулзалтуудыг хослуулан ашиглавал сайн. Тухайлбал, аудит эхлэх үед гол мэдээллүүдийг аудитад шалгуулагч этгээдэд хүргүүлэхдээ захидал ашиглаж, аудитын гол хэсгүүдийг хэлэлцэхдээ уулзалт товлон болно. Түүнчлэн, зарим АДБ аудитад шалгуулагч этгээдэд аудитын судалгааны загварын талаар дэлгэрэнгүй мэдээллийг аль болох эрт өгч, аудитын

мөн чанар болон хамрах хүрээг ойлгоход нь туслахыг илүүд үздэг бол бусад АДБ-ууд зөвхөн аудитын төлөвлөгөө батлагдсаны уг мэдээллийг хуваалцахыг илүүд үздэг. АДБ-уудтай хамтран ажиллаж, аудитын үйл явцад оролцож сурсан байгууллагуудад танай байгууллагатай хамтран ажиллах үед та бүхэнд мөрдүүлэхийг хүсэх тогтсон протокол байж магадгүй. Тухайлбал, аудитад шалгуулагч этгээд нь тодорхой холбоо барих хүнээрээ дамжуулан танай байгууллагад мэдээлэл авах хүсэлт илгээж магадгүй. Үүний нэгэн адил, олон АДБ-д аудитад шалгагдагч этгээдтэй хэрхэн харилцахыг нарийн тодорхойлсон бодлого, практикийг тусгасан тогтсон протокол байдаг. Ийм харилцаа үүсгэх хугацааг тодорхой болгох нь мэргэжлийн үнэлэмж болон танай АДБ-ын шаардлагуудаас хамаарах асуудал юм. Гэхдээ, аудитын зорилго болон хамрах хүрээний талаар нэгдсэн ойлголттой болохын тулд аудитад шалгагдагч этгээдэд аль болох эртнээс аль болох их мэдээлэл өгөх талаар бодолцож үзэх нь тустай байх болно.

Аудитын загварчлах үе шатанд бусад гадаад оролцогч талуудтай харилцах харилцааны хэлбэр байдлыг тал тус бүрийн үүрэг, хэрэгцээ болон ашиг сонирхол, мөн АДБ-ын дотоод протокол шийднэ. Тухайлбал, аудитыг хууль тогтоох засаглалын хүсэлтээр хийх гэж байгаа бол, аудитыг эхлүүлэхдээ тодруулга мэдээлэл авах зорилгоор хүсэлт гаргагчидтай холбогдож, аудитын загвар болон хуваарийг эргэн мэдээлж, аудитын явцын төлөв байдал болон урьдчилсан илрүүлэлтүүдийн талаар тодорхой мөчлөгтэйгөөр тойм мэдээ илгээж байх нь тустай. Түүнчлэн, аудитын туршид хамтын ажиллагааг сайн байлгахын тулд аудитад шалгуулагч этгээдийн итгэлийг олох нь чухал. УДИР-3910/70-73-ыг үзнэ үү.

Хэвлэл мэдээллийнхэнтэй харилцах харилцаа нь ерөнхийдөө аудитын тайлан гарсны дараа эхэлдэг боловч, АДБ эсвэл аудитын багийн хувьд аудитыг загварчлах үе шатанд, хэвлэл мэдээллийнхний асуултад хариулахад бэлэн байх, эсвэл бүр шаардлагатай үед, тухайлбал аудитын сэдэв нь маргаан дагуулсан эсвэл олон нийтэд ил байдаг сэдэв байгаа тохиолдолд хэвлэл мэдээллийнхэнтэй харилцах стратеги боловсруулах шаардлагатай болж болно. Дуусаагүй үргэлжилж буй ажлын хувьд, аудитын зорилго(ууд), хамрах хүрээ ба арга зүй; ажлын эх сурвалж; болон ажлыг дуусгах хугацааны төлөвлөгөө зэрэг хязгаарлагдмал хэмжээний мэдээллийг л хэвлэл мэдээллийнхэнтэй хуваалцах нь ерөнхийдөө зохимжтой байдаг. Аудитын дэлгэрэнгүй мэдээлэл эсвэл боломжит илрүүлэлтүүдийг ихэвчлэн ажлыг дуусгаж, аудитын тайланг гаргах хүртэл хэвлэл мэдээллийнхэнтэй хуваалцдаггүй.

Гүйцэтгэлийн аудитыг загварчлах үед, дараахыг санагтун:

- ✓ Аудитад шалгуулагч этгээд болон бусад мэдлэгтэй талуудтай харилцаж, аудитын сайн төлөвлөгөө боловсруулахад шаардлагатай мэдээлэл олж авах;
- ✓ Аудитын талбар, сул тал болон сорилт бэрхшээл, аудитын үед ямар өгөгдөл бэлэн байх, аудитын асуултуудын материаллаг байдал, мөн гүйцэтгэлийг үнэлэхэд ямар шалгууруудыг харгалзан үзэх талаар хангалттай ойлголттой болох;
- ✓ Ажлыг хэн, хэзээ, хэрхэн хийхийг шийдэхдээ нөөцийн бэлэн байдал болон аудитын багийн чадамжийг харгалзан үзэх;
- ✓ Аудитын төлөвлөгөөнд хуулийн, судлах сэдэв/ зүйлийн болон арга зүйн мэргэшлийг тусгахын тулд дотоод оролцогч талуудтай (мөн шаардлагатай үед гадаад оролцогч талуудтай) тасралтгүй харилцах;
- ✓ Ажлын төлөвлөгөөг бодитой хандлагаар бүтээж, найдвартай хэрэгжүүлэхийн тулд аудитын багийн гишүүдийн хараат бус байдалд анхаарах;
- ✓ Үнэн зөв, бүрэн гүйцэд, үнэ цэн нэмдэг илрүүлэлт, дүгнэлт, зөвлөмжүүдийг бий болгохын тулд аудитын өөр өөр асуултууд болон арга зүйнүүдтэй (тухайлбал, цаг хугацаа, өгөгдлийн чанар) холбогдох эрсдэлийг үнэлж, эрсдэл бууруулах зохих алхмуудыг хэрэгжүүлэх (тухайлбал, нягтлагч нарыг нэмэх, нотлох мэдээлэл олж авах). Загварчилсан бүх шийдвэр нь эрсдэлд суурилсан шийдвэр байдгийг санах;
- ✓ Хамааралтай хүчин зүйлсэд үндэслэсэн сайн шийдвэр гаргалтыг бий болгохын тулд төлөвлөлтийн бүх шийдвэрт мэргэжлийн үнэлэмжийг хэрэгжүүлэх; мөн
- ✓ Төлөвлөлтийн гол анхаарах зүйлс болон шийдвэрүүдийг зохиомжийн хүснэгт, төслийн хуваарь, ажлын задаргааны зураглал зэрэг хэрэгслүүдээр баримтжуулах.

Эх сурвалж: АДБОУБХС/ГАДХ-ны Хөгжлийн Баг.

5-р бүлэг

Гүйцэтгэлийн аудитыг хэрхэн хийх вэ?



Гүйцэтгэлийн аудит хийхийн зорилго нь хангалттай бөгөөд зохистой нотлох зүйлс цуглуулж, аудитын зорилго(ууд) болон асуултуудад хариулах илрүүлэлтүүдийг бий болгоход оршдог. 4-р бүлэгт авч үзсэнчлэн, аудитын асуултууд нь таны аудитын ажлыг чиглүүлэх учиртай. Иймд, таны цуглуулж, шинжлэх мэдээлэл нь аудитын асуултуудтай шууд холбогдох ёстой.

Тус бүлэг нь дараах асуултуудад хариулах болно:

- Нотлох зүйлсийн хангалттай бөгөөд зохистой байдлыг хэрхэн тодорхойлох вэ?
- Гүйцэтгэлийн аудитад ашиглах мэдээллийг хэрхэн цуглуулах вэ?
- Мэдээллийг хэрхэн шинжлэх вэ?
- Мэдээллийг хэрхэн баримтжуулж, хамгаалах вэ?

Эдгээр үйл ажиллагаа нь тухайн аудит болон танай багийнхны ашиглахаар шийдсэн арга зүйгээс хамаараад дэс дараатай эсвэл нэгэн зэрэг өрнөж болно. Практикт, ихэвчлэн мэдээллийг цуглуулж, шинжилж, үнэлэхдээ хангалттай болон зохистой байдлыг нь нэгэн зэрэг авч үздэг. Энэ нь өгөгдөл цуглуулж дуусаагүй байхдаа боломжит илрүүлэлтүүдийн элементүүдийг тодорхойлж эхлэхэд мөн тустай байж болно. Ингэх нь танд нотлох зүйлсдээ байгаа аливаа дутагдал болон нэмэлт өгөгдөл цуглуулах хэрэгцээг тодорхойлоход тусалж чадна. Энэ үйл ажиллагаа нь ихэнхдээ давтагддаг үйл явц байдаг.

Өгөгдөл цуглуулах үед, танай аудитын баг аудитын төлөвлөлтийн үе шатанд гаргасан зарим шийдвэрээ эргэн харах хэрэгтэй болж бас болно. Тухайлбал, та нотлох зүйл болгон ашиглаж болох мэдээллийн шинэ боломжит эх сурвалж илрүүлсэн бол, эсвэл цуглуулсан мэдээллийн зарим нь аудитын асуултуудад хариулт өгөхөд найдвартай эсвэл тустай биш байгааг тогтоосон тохиолдолд, аудитын хамрах хүрээ, асуултууд, шалгуурын хэрэглээ болон мэдээлэл цуглуулж, шинжлэх аргуудаа өөрчлөн тохируулах шаардлагатай болж болно. Аудитын төлөвлөгөөндөө аливаа материаллаг өөрчлөлт оруулахдаа удирдлагынхаа

зөвшөөрлийг авч, дотоод оролцогч талууд болон аудит шалгуулагч этгээдэд мэдээлэхээ мартаж болохгүй. (УДИР-3920/44-47, 72)

Нотлох зүйлсийн хангалттай бөгөөд зохистой байдлыг хэрхэн тодорхойлох вэ?



Стандарт

Аудитор хүлээн зөвшөөрөгдсөн АДБ-ын бүрэн эрхийн хүрээнд аудитын дүнг боловсруулж, аудитын зорилго, аудитын асуулттай уялдсан дүгнэлт гаргаж, зөвлөмж өгөхийн тулд аудитын хангалттай ба зохистой нотлох зүйлийг олж авах ёстой.

Эх сурвалж: АДБОУС-3000/106.

Аудитын илрүүлэлтүүд нь нотлох зүйлсээр дэмжигдэх ёстой. Иймд таны олж авах нотлох зүйлсийн тоо хэмжээ болон чанар чухал. Өөрөөр хэлбэл та: (1) олж авахаар төлөвлөж буй; (2) олж авч буй; (3) хэдийнээ олж авсан нотлох зүйлсийнхээ хангалттай бөгөөд зохистой байдалд тасралтгүй анхаарч, үнэлж байх шаардлагатай (УДИР-3920/69-77). Өгөгдөл, мэдээлэл цуглуулж, шинжлэх янз бүрийн аргуудтай танилцахаасаа өмнө мэдээлэл ба нотлох зүйл хоорондын ялгааг ойлгох нь чухал. Аудитын асуултуудтай холбогдуулан таны нотлохыг хүсэж буй санааг дэмжихэд ашиглагдаж болох чанарын болон тоон мэдээллийг цуглуулсан бол тэдгээр нь нотлох зүйл болно. Гэхдээ аудитын явцад цуглуулсан бүх мэдээлэл нь танд аудитын сэдвийн талаарх ойлголтоо хөгжүүлэхэд тусалж чадна. Илрүүлэлтээ дэмжихэд ашиглах нотлох зүйлс нь ихэвчлэн цуглуулсан мэдээлэлд хийх шинжилгээний дүнд бий болдог.

Хангалттай байдал гэдэг нь цуглуулсан нотлох зүйлсийн тоо хэмжээтэй холбогдоно (25-р зургийг үзнэ үү). Илрүүлэлтээ учир зүйтэй гэдгийг мэдлэгтэй хүнд үнэмшүүлэх хэмжээний хангалттай нотлох зүйлс танд байна үү? Тухайлбал, ярилцлага эсвэл ганц баримт бичиг зэрэг ганц л эх сурвалжаас авсан мэдээлэл нь илрүүлэлтийг дэмжихэд хангалтгүй байж болох ч, ерөнхий зураглал үүсгэхэд хэрэгтэй хэвээр байж болно. Илрүүлэлтүүдийг олон эх сурвалжаас авсан олон төрлийн нотлох зүйлсээр дэмжиж, нотлох нь чухал.

Зураг 25: Нотлох зүйлийн хангалттай байдал



Хангалттай байдал гэдэг нь таны аудитын зорилго(ууд) болон асуултуудтай холбогдох илрүүлэлтүүд болон дүгнэлтүүдээ дэмжихэд ашиглаж буй нотлох зүйлийн тоо хэмжээг хэмжсэн үзүүлэлт юм.

Илрүүлэлт нь учир зүйтэй гэдгийг мэдлэгтэй хүнд үнэмшүүлэхэд хангалттай нотлох зүйлсийг та олж авсан уу?

Эх сурвалж: АДБОУБХС/ГАДХ-ны Хөгжлийн Баг.

Хэр их нотлох зүйл байвал хангалттай болох вэ гэдэг нь зарим талаараа нотлох зүйлсийн зохистой байдлаас хамаарна. Зохистой байдал гэдэг нь нотлох зүйлийн чанартай холбогддог. Нотлох зүйл нь хамааралтай, хүчин төгөлдөр бөгөөд найдвартай байна уу? Эдгээрийг тодорхойлохдоо нотлох зүйлийнхээ эх сурвалж, агуулга болон хугацааг харгалзаж үзэх нь чухал. 26-р зурагт эдгээр чухал ухагдахуунуудын талаар дэлгэрэнгүй мэдээлэл оруулав.

Зураг 26: Нотлох зүйлийн зохистой байдал



Зохистой байдал

Хамааралтай нотлох зүйл нь шийдвэрлэх гэж буй асуудалтай логик холбоотой бөгөөд ач холбогдолтой байдаг. Тухайлбал, та нисэх буудлын гаалийн үзлэгийн горимд аудит хийж байгаа бол, нисэх буудлын зогсоолын горимын талаарх мэдээлэл таны аудитад хамааралгүй болно.

Хүчин төгөлдөр нотлох зүйл нь сайн эргэцүүлэл эсвэл үнэн зөв мэдээлэлд үндэслэдэг. Тухайлбал, улс төрийн намын цахим хуудаснаас авсан мэдээлэл нь хүчин төгөлдөр эх сурвалжийн нотлох зүйл биш байх магадлалтай. Учир нь уг мэдээллийн эх сурвалж нь нэг талыг барьсан хандлагатай байж болно.

Найдвартай нотлох зүйл гэдэг нь мэдээллийг хэмжих буюу тестлэх үед үр дүн нь тогтмол нэг янзаараа байдаг бөгөөд тулган баталгаажуулж болдог буюу дэмжигддэг нотлох зүйлийг хэлнэ. Тухайлбал, аливаа мэдээллийн системийн хэрэглэгчид нь системд өгөгдөл оруулахдаа нэг байдлаараа тогтмол оруулдаггүй эсвэл алдааг нь шалгадаггүй гэдгийг та мэдсэн бол тухайн системээс авсан тоон өгөгдөл найдвартай биш байх магадлалтай.

Эх сурвалж: АДБОУБХС/ГАДХ-ны Хөгжлийн Баг.

Та хүлээн зөвшөөрөгдсөн аргуудыг ашиглан, мэдлэгтэй бөгөөд найдвартай эх сурвалжуудаас өгөгдлөө авдаг байх хэрэгтэй.

Гүйцэтгэлийн аудитын хувьд нотлох зүйл нь ерөнхийдөө, дүгнэсэн шинжтэй бус (өөрөөр хэлбэл, “тийм/үгүй” эсвэл “зөв/буруу” гэж эцэслэн тодорхойлсон), харин ятгасан шинжтэй (өөрөөр хэлбэл, дүгнэлт рүү чиглүүлсэн) байдаг (УДИР-3920/71). Эцсийн дүндээ, илрүүлэлтүүддээ хангалттай бөгөөд зохистой нотлох зүйлс олсон эсэхээ тогтооход тань **мэргэжлийн үнэлэмж** шаардлагатай. Нотлох зүйлсийн хангалттай бөгөөд зохистой байдлыг тогтоохдоо та нотлох зүйлсийнхээ боломжит давуу тал болон сул талуудыг анзаарч, эх сурвалжийг нь харгалзан үзэх хэрэгтэй. Учир нь зарим эх сурвалж бусдаасаа илүү итгэлтэй буюу найдвартай байх нь бий. Нотлох зүйлсийнхээ хангалттай бөгөөд зохистой байдлыг үнэлэх үед анхаарвал зохих зөвлөмжүүдийг доороос үзнэ үү.

Нотлох зүйлсийн хангалттай бөгөөд зохистой байдал

Хангалттай байдал

- ✓ Аудитын эрсдэл өндөр байх тусам, шаардлагатай нотлох зүйлсийн тоо хэмжээ арвин, чанар өндөр байх шаардлагатай.
- ✓ Илрүүлэлтийн ач холбогдол өндөр байх тусам, шаардлагатай нотлох зүйлсийн тоо хэмжээ арвин, чанар өндөр байх шаардлагатай.
- ✓ Нотлох зүйлс баттай байх тусам, ашиглах нотлох зүйлсийн тоо цөөн байж болно.
- ✓ Их хэмжээний нотлох зүйлстэй байх нь хамааралтай, хүчин төгөлдөр бөгөөд найдвартай байдлын дутагдлыг нөхөхгүй.
- ✓ Аудитад шалгуулагч этгээд болон бусад оролцогч талууд судлах сэдэв/ зүйлийн талаар өөр өөр үзэл бодолтой байгаа үед ерөнхийдөө илүү их нотлох зүйлс шаардлагатай болдог.

Зохистой байдал байдал

- ✓ Нотлох зүйлсээ хамааралтай байлгах хэрэгтэй. Өөрөөр хэлбэл, аудитын сэдэвт ач холбогдолтой байлгах хэрэгтэй.
- ✓ Нотлох зүйлсээ хүчин төгөлдөр байлгах хэрэгтэй. Өөрөөр хэлбэл, үнэн зөв мэдээлэл болон логик шинжилгээнд үндэслэсэн байлгах хэрэгтэй.
- ✓ Нотлох зүйлсээ найдвартай байлгах хэрэгтэй. Өөрөөр хэлбэл, үр дүн нь нэгэн жигд бөгөөд тулган баталгаажуулах боломжтой байх ёстой.
- ✓ Баримт бичгийн нотлох зүйл нь ихэвчлэн мэдүүлгийн нотлох зүйлээс илүү найдвартай байдаг ч, найдвартай байдал нь тухайн баримт бичгийн эх сурвалж болон зорилгоос хамаараад янз бүр байж болно.
- ✓ Бичгээр үйлдсэн мэдүүлгийн нотлох зүйл нь дан ганц амаар ярьсан нотлох зүйлээс илүү найдвартай байдаг.
- ✓ Олон ярилцлагад суурилсан нотлох зүйл нь нэг эсвэл цөөн хэдэн ярилцлагад суурилсан нотлох зүйлээс илүү найдвартай байдаг.
- ✓ Хүмүүс чөлөөтэй ярьж болох нөхцөлд авсан мэдүүлгийн нотлох зүйл нь айлган сүрдүүлсэн гэх мэдрэмж авч болох нөхцөлд авсан нотлох зүйлтэй харьцуулахад илүү хүчин төгөлдөр бөгөөд найдвартай байдаг.
- ✓ Мэдлэгтэй, итгэл хүлээсэн, нэг талыг бариагүй гуравдагч талаас авсан нотлох зүйл нь аудитад шалгуулагчийн удирдлага эсвэл аудитад шалгуулагчтай шууд ашиг сонирхлын холбоотой бусад этгээдээс авсан нотлох зүйлээс илүү хүчин төгөлдөр бөгөөд найдвартай байдаг.
- ✓ Сул дотоод хяналт нь байгууллага даяар нотлох зүйлсийн найдвартай бөгөөд нэгэн жигд байдалд нөлөөлж байдаг. Иймд, дотоод хяналт үр нөлөөтэй үед олж авсан нотлох зүйлс нь дотоод хяналт сул эсвэл байхгүй үед олж авсан нотлох зүйлсээс илүү найдвартай байдаг.
- ✓ Аудиторын шууд ажиглалт, тооцоо болон үзлэгээр олж авсан нотлох зүйл нь шууд бусаар олж авсан нотлох зүйлээс илүү найдвартай байдаг.
- ✓ Баримт бичгүүдийн эх хувь нь хуулбаруудаасаа илүү найдвартай байдаг.

Эх сурвалж: УДИР-3920/75-76 болон Засгийн Газрын Аудитын Стандартыг (АНУ-ын ТХГ) эш болгов.

Аудитын түршид нотлох зүйлсийнхээ хангалттай бөгөөд зохистой байдлыг сайтар үнэлж, хангах нь танай аудитын багийн маш чухал үүрэг юм. Ингэхийн тулд та бүхэн **мэргэжлийн үнэлэмж** болон шүүмжит сэтгэлгээгээ ашиглах шаардлагатай. (УДИР-3920/77)

Нотлох зүйлсэд тань хязгаарлалт эсвэл тодорхой бус байдал илэрвэл, **аудитын эрсдэлийг** бууруулах алхмуудыг авч хэрэгжүүлж болно. Тухайлбал:

- Хараат бус бөгөөд нотлох чадвартай нотлох зүйлсийг бусад эх сурвалжуудаас эрэх;
- Илрүүлэлтүүд болон дүгнэлтүүдийг толилуулах. Тэгснээр дэмжих нотлох зүйлс нь ашигласан зорилгодоо хангалттай бөгөөд зохистой болно. Мөн, тайлангийн хэрэглэгчдийг илрүүлэлтүүд болон дүгнэлтүүдийн талаар төөрөгдүүлсэн мэдээлэлтэй болгохоос зайлсхийхийн тулд, шаардлагатай тохиолдолд, нотлох зүйлсийн хүчин төгөлдөр болон найдвартай байдалд тулгарсан аливаа хязгаарлалт эсвэл тодорхой бус байдлын талаар тайландаа тусгах хэрэгтэй;
- Аудитын асуултууд эсвэл хамрах хүрээг дахин тодорхойлж, асуудал үүсгэж буй тодорхой нотлох зүйлсийг ашиглах шаардлагыг арилгах. Аливаа томоохон өөрчлөлтийн талаар аудитад шалгуулагч этгээдэд мэдээлэхээ мартаж болохгүй; мөн
- Хязгаарлалтууд болон тодорхой бус байдлыг, мөн дотоод хяналтын томоохон дутагдлуудыг илрүүлэлт гэж тайлагнах эсэхээ шийдэх.

Нотлох зүйлсийн хангалттай бөгөөд зохистой байдалд хийсэн үнэлгээ үр дүн болон эрсдэл бууруулах арга хэмжээ нь нарийн тодорхой харагдахгүй байж болох бөгөөд энэ үед танай аудитын баг удирдлагатайгаа хамтран ажиллаж бэрхшээлтэй шийдвэрүүдийг гаргах шаардлагатай болж болно. Ийм шийдвэрүүдийг гаргахдаа, дараах тохиолдолд нотлох зүйлс нь хангалттай бөгөөд зохистой биш байдаг гэдгийг санах нь чухал:

- Нотлох зүйлийг ашигласан тохиолдолд буруу эсвэл зохимжгүй дүгнэлтэд хөтлөх хүлцэх боломжгүй өндөр эрсдэл дагуулахуйц байвал;
- Аудитын асуултууд болон нотлох зүйлийн ашиглалтад ихээхэн хязгаарлалт үүсэж байвал; мөн
- Нотлох зүйл нь аудитын зорилго(ууд) болон асуултуудад хариулт өгөх, эсвэл илрүүлэлтүүд болон дүгнэлтүүдийг дэмжих хангалттай үндэс болж чадахгүй байвал.

Мэдээлэл цуглуулах ажлаа үргэлжлүүлэхдээ, хүмүүс танд хэлж буй зүйлс болон баримт бичгүүдээс олж авч буй мэдээллээ шууд харагдаж буй утгаар нь хүлээн авахгүйгээр, эрүүл үл **итгэх үзлийг** хэрэгжүүлэх нь чанартай ажил гүйцэтгэхэд туйлын чухал гэдгийг санагтун. Үүнийг мэргэжлийн үл итгэх үзэл гэдэг бөгөөд 2-р бүлэгт авч үзсэн **хараат бус байдал** болон **мэргэжлийн үнэлэмж** гэсэн аудитын хоёр ухагдахууны гол бүрэлдэхүүн хэсэг болдог.

Тухайлбал, мэдүүлгийн нотлох зүйл цуглуулахдаа ярилцлага өгч буй хүмүүсийн итгэл хүлээх байдлыг харгалзан үзэх буюу албан тушаал, мэдлэг, мэргэшил болон илэн далангүй байдлыг нь бодолцож үзэх хэрэгтэй. Хүний үйлдэл болон бусад хүмүүсийн үйлдлийн тухай тайлбар нь найдвартай ч байж болно, найдваргүй ч байж болно. Ийм учраас түүнийг бүх өнцгөөс авч үзэх хэрэгтэй. Тухайлбал, аливаа байгууллага дотор, түүний хэлтсүүдийн хооронд эсвэл менежерүүд болон ажилтнуудын хооронд үргэлж санал зөрөлдөөн болон

ялгаатай ашиг сонирхлууд оршиж байдаг. Энэ нь ярилцлага өгөгч хүмүүст аудитортай мэдээлэл хуваалцах сэдэл болж болох ч, аудиторууд уг санал зөрөлдөөнийг анхааралтай ажиглаж, мэдээллийн найдвартай байдлыг үнэлдэг байх хэрэгтэй. Учир нь ярилцлага өгөгчийн мэдүүлэг нь бодит баримтаас илүүтэй ашиг сонирхлынх нь илэрхийлэл байх магадлалтай байдаг.

Ярилцлага өгөгч хүн нөхцөл байдлыг шулуун шударгаар тайлбарлаж байсан ч, эсвэл тэдний тантай хуваалцсан баримт бичиг нь аудитын сэдэвтэй холбоотой байсан ч, ялгаатай хүмүүс болон байгууллагууд ялгаатай харах өнцөг болон хүсэл сонирхолтой байдаг бөгөөд түүнийхээ улмаас бодит байдлыг ялгаатай хөрвүүлэн ойлгодог тул, уг мэдээлэл нь бодит нөхцөл байдлыг бүрэн бөгөөд зөв дүрслээгүй байх магадлалтай. Бүх хувь хүн өөрийн үүрэг, харах өнцөг, мэдлэг болон үзэл бодлынхоо хувьд эксперт болсон байдаг ч, бүтэн “түүх”-ийг мэдэхгүй, эсвэл асуудлуудыг бүх өнцгөөс адил тэгш харж чадахгүй байх нь бий. Нэг ярилцлага эсвэл нэг баримт бичгээс хангалттай бөгөөд зохистой нотлох зүйл олж авах нь туйлын ховор байдаг. Ярилцлага өгч буй хувь хүн эсвэл ашиглаж буй баримт бичиг нь аудитад шалгагдаж буй үйл ажиллагааны бүх хэсэгтэй холбоотой байх өвөрмөц тохиолдол байж болох ч, тийм тохиолдлыг үнэлэхдээ маш болгоомжтой байж, мэргэжлийн үнэлэмжээ ашиглах нь чухал. Өөр өөр албан тушаал болон үүрэгтэй ажилтнуудаас ярилцлага авах нь, нөгөөтээгүүр, аудиторуудад тухайн байгууллагын хүмүүсийн анзаараагүй асуудлуудыг ойлгож, шинжлэх боломж олгодог.

Аудитын ажлыг гүйцэтгэх явцдаа нотлох зүйлсийн хангалттай бөгөөд зохистой байдлыг үргэлж санаж байх нь аудитын нөлөө бүхий илрүүлэлтийг бий болгох хангалттай чанартай нотлох зүйлс олж авахад тань тусална.

Гүйцэтгэлийн аудитад ашиглах мэдээллийг хэрхэн цуглуулах вэ?

Аудитад шалгуулагч этгээдтэй хэрхэн хамтран ажиллах вэ?

Төлөвлөлтийн нэгэн адил, мэдээлэл цуглуулахад мөн мэдээллийг нь авах шаардлагатай аудитад шалгуулагч этгээд болон бусад байгууллагуудтай нягт хамтран ажиллах шаардлага ерөнхийдөө тулгардаг (УДИР-3910/63-69).

Аудитын ажлаа гүйцэтгэхдээ мэдээлэл цуглуулалтыг саадгүй бөгөөд үр ашигтай байлгахын тулд аудитад шалгуулагч этгээдтэй харилцах ерөнхий зөвлөмжүүдийн заримыг доор оруулав.

Аудитад шалгуулагч этгээдтэй харилцах нь

- ✓ Харилцаа хангалтгүй болж, ажил саатахаас зайлсхийхийн тулд ярилцлага төлөвлөх, талбарын ажил хийх болон мэдээлэл авах хүсэлт гаргахдаа баримтлах горимоо аудитад шалгуулагчид танилцуулж, зөвшөөрүүлэх хэрэгтэй. “Ямар ч гэнэтийн зүйлгүй байх” арга хандлага нь ерөнхийдөө мэргэн сонголт болно.
- ✓ Урьдчилан төлөвлө! Аудитад шалгуулагч этгээд үндсэн ажлаа гүйцэтгээд завгүй байгааг хүлээн зөвшөөрөх хэрэгтэй. Аудитад шалгуулагч этгээдэд аудиттай холбогдох шаардлагуудыг аль болох эртнээс мэдэгдэх тусам, таны шаардлагатай мэдээллээ хүссэн хугацаандаа багтааж авах магадлал ихэснэ.
- ✓ Шууд бөгөөд шуурхай харилцааг дэмжихийн тулд аудитад шалгуулагч этгээдийн янз бүрийн оффис дахь аудитын багтай холбогдож ажиллах хүмүүсийг харилцан тохиролцож, тодорхойлох.
- ✓ Аудитын ахицын талаарх мэдээллийг хэнд өгөхийг аудитад шалгуулагч этгээдийн дээд удирдлагуудтай тохиролцож, үг мэдээллийг байгууллагадаа түгээх үүргийг аудитад шалгуулагчийн үүрэг болгох хэрэгтэй.
- ✓ Хийхээр төлөвлөж буй ярилцлага болон талбарын ажлаа, ерөнхий хугацааны хуваарийн хамт аудитад шалгуулагч этгээд аль болох эртнээс мэдэгдэх хэрэгтэй.
- ✓ Мэдээлэл авах хүсэлтэд тань хариу өгөх хангалттай хугацааг аудитад шалгуулагч этгээдэд өгөх хэрэгтэй. Нарийн цагийн хуваарь нь хүсэлтийн нарийн төвөгтэй байдлаас хамаарах боловч, нэгэн зэрэг их хэмжээний мэдээлэл авах хүсэлт нь аудитад шалгуулагч этгээдийг мэдээллээ бүрдүүлж эхлэх хүртлээ илүү их саатахад хүргэж болно.
- ✓ Аудитынхаа ахиц болон аудитын төлөвлөгөө хийгээд хугацаанд оруулсан аливаа томоохон өөрчлөлтийг аудитад шалгуулагч этгээдэд мэдээлдэг байх хэрэгтэй.
- ✓ Аудитад шалгуулагч этгээдээс мэдээлэл авахад тулгарч буй аливаа бэрхшээлээ дээд удирдлагадаа эртнээс мэдэгдэх хэрэгтэй. Тэгснээр уг асуудал шуурхай шийдвэрлэгдэх боломжтой болно.
- ✓ Эдгээр асуудлуудыг аудитад шалгуулагч этгээдэд мэдэгдэж, хамтран шийдвэрлэх хэрэгтэй.
- ✓ Аудитад шалгуулагч этгээдтэй харилцах бүх тохиолдолд мэргэжлийн, зөлдөг бөгөөд шударга байх хэрэгтэй.
- ✓ Аудитын явцад гарч ирсэн урьдчилсан илрүүлэлтүүдийг аудитад шалгуулагч этгээдтэй хэлэлцэж, санал хүсэлт болон орцыг нь авах.
- ✓ Сорилт бэрхшээл эсвэл сааталтай тулгарсан тохиолдолд аудитад шалгуулагч этгээдтэй хамт аудитын протоколоо эргэн харж, шаардлагатай өөрчлөлтүүдийг оруулах хэрэгтэй.

Эх сурвалж: АДБОУБХС/ГАДХ-ны Хөгжлийн Баг.

4-р бүлэгт аудитын эхэнд аудитад шалгуулагч этгээдтэй үулзах тухай авч үзсэн. Аудитын төлөвлөлтийн үе шатанд хийсэн анхны үулзалтаас хойш, аудитад шалгуулагч этгээдийн албан тушаалтнуудад аудитынхаа хамрах хүрээ, төлөвлөгөө болон ахицыг ойлгуулахын тулд төлөвлөсөн ажил болон гүйцэтгэх хугацааны талаар аудитад шалгуулагч этгээдтэй аудитын үйл явцын түршид тогтмол үулзсаар байх нь чухал. Аудитад шалгуулагч этгээдтэй тогтмол хэлэлцдэг байх нь нотлох зүйлсийн нэмэлт эх сурвалжуудыг тодорхойлоход, мөн илрүүлэлтүүдийг боловсруулахад мэдээллээр хангах харах өнцгүүдийг олж авахад түстай байх болно. Түүнчлэн, аудитын багийнхаа мэдээлэл цуглуулахад ашиглах аргуудаа аудитад шалгуулагч этгээдтэй хэлэлцэж, таны хүчин зүтгэлийг дэмжихэд бэлэн болгох нь чухал.

Ихэнх аудитын үйл ажиллагаа нь шалгагдагч этгээдтэй аудитын эцэст үулзах үулзалтыг мөн агуулдаг. Танай аудитын баг гол баримтууд нь танай илрүүлэлтийг дэмжиж буйг батлан харуулж, илрүүлэлтүүд болон аливаа боломжит зөвлөмжүүдээ аудитад шалгуулагч этгээдтэй хэлэлцэж болно. Энэ үулзалтыг заримдаа хаалтын үулзалт гэж нэрлэдэг.

Хаалтын уулзалт бол аудитын тайлангийнхаа урьдчилсан төслийг хуваалцаж, урьдчилсан илрүүлэлтүүд болон зөвлөмжүүдийн талаарх аудитад шалгуулагч этгээдийн харах өнцгийг хэлэлцэх боломж юм. Энэ үеэр та болон танай баг аудитад шалгуулагч этгээдэд албан ёсоор нягтлуулж, санал авахаар албан ёсны тайлангаа хүргүүлэхийн өмнө аливаа шаардлагатай өөрчлөлтүүдийг хийх боломжтой болдог. Эдгээр алхмуудыг 7-р бүлэгт илүү дэлгэрэнгүй авч үзсэн байгаа.

Аудитын үйл явцын туршид аудитад шалгуулагч этгээдтэй сайн харилцан ярилцдаг байх нь засаглалыг бодитоор сайжруулахын гол түлхүүр бөгөөд аудитын нөлөөллийг ч өсгөх боломжтой юм. Энэ утгаараа, аудитор нь аудитын урьдчилсан илрүүлэлтүүд, аргументууд болон харах өнцгүүдийг аудитын явцад боловсруулж, үнэлэх бүрдээ аудитад шалгуулагч этгээдтэй хуваалцах замаар бүтээлч харилцаа үүсгэж болно (АДБОУС-3000/58). Ерөнхийдөө АДБ-ын илрүүлэлтүүдийг аудитад шалгуулагч этгээдэд аудитын төгсгөл хэсгээс өмнө толилуулдаггүй. Эхлээд хаалтын уулзалт дээр, дараа эцсийн тайлангаа нийтлэх үедээ толилуулдаг. Гэвч, ажлаа гүйцэтгэх үедээ залиланг нотлох зүйл, эсвэл залиланд хүргэж болзошгүй дотоод хяналтын томоохон дутагдал (доороос үзнэ үү) зэрэг нэн яаралтай залруулах арга хэмжээ авах шаардлагатай асуудлуудыг илрүүлсэн бол удирдлагадаа нэн даруй мэдэгдэх нь чухал (УДИР-3910/91-93). Түүнчлэн, эдгээр асуудлуудыг аудитад шалгуулагч этгээд хэзээ, хэрхэн мэдээлэх талаар удирдлагатайгаа хэлэлцэх хэрэгтэй.

Аудитад шалгуулагч этгээдтэй харилцах нь

Залилан гэдэг нь хувь хүн эсвэл хуулийн этгээд санаатай төөрөгдүүлсэн мэдээллээр дамжуулан үнэ цэнтэй зүйл олж авах эсвэл олж авахыг оролдохыг хэлнэ.

Тухайлбал, засгийн газраас санхүүжилт авахын тулд хөтөлбөрийн мэдээлэл эсвэл үр дүнг буруу мэдэгдэх буюу буруу мэдээлж байгаа этгээд нь залилан үйлдэж байж болно.

Аудиторын хувьд залиланг илрүүлэх эсвэл аливаа үйлдлийг залилан гэж тодорхойлох үүргийг хүлээхгүй. Энэ үүрэг нь шүүх засаглал эсвэл бусад хөндлөнгийн шүүхийн тогтолцооны үүрэг юм.

Гэхдээ та аудитын зорилго(ууд)тойгоо холбогдох залилангийн эрсдэлийг, тухайлбал дараах хүчин зүйлсийг байнга үнэлж байх хэрэгтэй:

- ✓ Хувь хүмүүсийн залилан үйлдэх сэдэл эсвэл дарамт;
- ✓ Залилан үүсэх боломж; мөн
- ✓ Залилангийн эрсдэлийг нэмэгдүүлэх хандлагууд.

Аудитын явцад аудитын зорилго(ууд)ын хүрээнд залилан үүссэн байж болзошгүй гэсэн мэдээлэл таны анхааралд өртвөл хуулийн эксперт зэрэг дотоод оролцогч талууд болон АДБ-ын удирдлагатай зөвлөлдөж, (1) түүнээс аудитын илрүүлэлтүүдэд үзүүлэх нөлөөллийг, мөн (2) АДБ-ынхаа горимуудад үндэслэн авах дараагийн зохих арга хэмжээг тодорхойлох хэрэгтэй.

Эх сурвалж: АДБОУБХС/ГАДХ-ны Хөгжлийн Баг.

Хэрхэн янз бүрийн арга зүйг ашиглан мэдээлэл цуглуулах вэ?

Аудитын баг мэдээлэл цуглуулахдаа ашиглаж болох маш олон арга бий. Гэхдээ, аудитын бүх ажил аудитын илрүүлэлтүүдийг дэмжих хангалттай бөгөөд зохистой нотлох зүйлс олох зорилгоор хийгдэх ёстой. Иймд, таны гүйцэтгэж буй аудит нь илрүүлэлт бий болгохыг дэмжих нотлох зүйл олж, шинэ мэдээлэл эсвэл шинжилгээгээр хангаж, зөвлөмжүүдийг дэмжих боломжтой байх нь чухал. 27-р зурагт үзүүлсэнчлэн олон төрлийн нотлох зүйл бий.

Зураг 27: Нотлох зүйлсийн төрлүүд



Эх сурвалж: Засгийн Газрын Аудитын Стандартыг (АНУ-ын ТХГ) эш болгов.

Аудитын баг мэдээлэл цуглуулж, эцэстээ, нотлох зүйл бий болгохдоо ашиглаж болох олон өөр арга бий. Энэ бүлэгт мэдээлэл цуглуулахад нийтлэг ашигладаг 4 аргыг дэлгэрэнгүй тайлбарлах болно:

- Ярилцлага;
- Баримт бичиг цуглуулах;
- Шууд ажиглалт ба үзлэг; мөн
- Судалгаа (санал асуулга).

Хамгийн зохистой төрлийн нотлох зүйл нь аудитын асуултууд болон уг нотлох зүйлийг тайланд хэрхэн ашиглахаас хамаарч янз бүр байна (УДИР 3920/44-50-ыг үзнэ үү). Илрүүлэлтүүд болон дүгнэлтүүдээ дэмжихэд олон төрлийн нотлох зүйлийг хамтатган ашиглах нь ихэвчлэн өгөөжтэй байдаг. Хамгийн гол нь, таны нотлох зүйлийн баттай байдал нь нийт цуглуулсан өгөгдлийн найдвартай байдлаас хамаарах учраас өгөгдөл цуглуулж, шинжлэхдээ мэргэжлийн үл итгэх үзлийг хэрэгжүүлэх нь чухал.

Мэдээлэл цуглуулахдаа, танай аудитын ажил аудитад шалгуулагч этгээдийн арвилан хэмнэлт, үр ашигтай байдал болон/эсвэл үр нөлөөтэй байдалтай холбогдох ойлголтоор хангаж чадах эсэхэд анхаарах хэрэгтэй. Өөрөөр хэлбэл, танай аудитын ажил дан ганц аудитад шалгуулагч этгээдийн хийсэн зүйлд төвлөрч болохгүй. Харин түүнийгээ хийхдээ ямар нөөцөөр, хэр үр ашигтай бөгөөд үр нөлөөтэй хийснийг судлах ёстой. Түүнчлэн, ямар мэдээллийг хэрхэн илүү сайн цуглуулж, эцсийн илрүүлэлтүүдээ үнэ цэнтэй болгох вэ гэдгийг шийдэхдээ **материаллаг байдал** гэх ухагдахууныг санаж байх нь чухал. 4-р бүлэгт авч үзсэнчлэн, аудитын баг нотлох зүйл цуглуулахдаа ашиглах аргууд болон мэдээллийн эх сурвалжуудыг аудитын төлөвлөгөөндөө тайлбарлан оруулах хэрэгтэй.

Тухайн аргын нарийн төвөгтэй байдлаас хамааруулж, арга зүйч, судлах сэдэв/ зүйлийн экспертүүд эсвэл зөвлөхүүдийг АДБ-ын дотоодоос болон гадаадаас оролцуулж, сонгосон аудитын төлөвлөгөөгөө хэрэгжүүлэхэд туслуулах, эсвэл аудитын ажил гүйцэтгэхдээ зөвлөгөө авах шаардлагатай болж болно гэдгийг санах хэрэгтэй (УДИР-3910/81). Нарийн

төвөгтэй аргууд дээр дэмжлэг үзүүлэх эксперт олох боломжгүй бол, танай аудитын баг сургалтад хамрагдаж, чадамжтай болж, гүйцэтгэх нөөцтэй болсон өгөгдөл цуглуулах аргуудаа сонгож ажиллах нь чухал (УДИР-3910/79-80). Эцэст нь хэлэхэд, өгөгдөл цуглуулж эхлэхээсээ өмнө аливаа арга нь ямар төрлийн өгөгдөл цуглуулах вэ, ямар хязгаарлалттай байх вэ гэдгийг сайтар бодолцож үзэх нь зүйтэй.

Ярилцлага

Ярилцлага бол гүйцэтгэлийн аудитын нотлох зүйл цуглуулах чухал хэрэгсэл бөгөөд ерөнхийдөө мэдүүлгийн нотлох зүйл цуглуулах үндсэн арга болдог. Ярилцлага гэдэг нь тухайлсан мэдээллийг, гүйцэтгэлийн аудитын хувьд зохистой нотлох зүйлийг гаргаж авах зориулалттай асуулт, хариултаар өрнөх үүлзалт юм. Ярилцлага нь мөн танд баримтын нотлох зүйлсийн боломжит эх сурвалжуудын талаар ойлголттой болох сайн боломж олгодог. Аудиторын үр нөлөөтэй ярилцах чадвар болон ярилцлагын үеэр гарч ирсэн мэдээллийг үнэн зөв баримтжуулах чадвар нь цуглуулсан нотлох зүйлсийн тоо хэмжээ болон чанарт нөлөөлдөг. Сайн зохиомжилж, гүйцэтгэсэн ярилцлагаар дараах зүйлсийг олж авч болно:

- Ярилцлага өгч буй хүний/хүмүүсийн харах өнцөг болон ажиглалтууд;
- Ярилцлага өгөгч хүний зүгээс өгөх баримт бичгүүд болон мэдээлэл буюу өгөгдөл; мөн
- Нэмэлт мэдээлэл олж авахын тулд холбогдож болох бусад хүмүүс болон байгууллагуудын талаарх мэдээлэл.

Ярилцлагын хоёр ерөнхий төрөл бий: бүтэцлэгдээгүй болон бүтэцлэгдсэн.

- Бүтэцлэгдээгүй ярилцлага нь ярилцлагын сэдвийн талаарх ярилцлага өгөгчийн ажиглалт болон мэдлэгийг бүрэн авч хэлэлцдэг. Асуултуудыг урьдчилан боловсруулаагүй байдаг бөгөөд хэрхэн асуулт асуух нь ярилцлагаас хамаарсан, уян хатан байдаг. Хариултаудыг мөн тодорхойлоогүй байдаг. Өөрөөр хэлбэл ярилцлага өгөгч нь асуултуудад хариулахдаа боломжит хариултаудаас сонгохын оронд хүссэн хэлбэрээрээ хариулж болно. Бүтэцлэгдээгүй ярилцлагын үеэр аудиторын асууж болох нээлттэй хариулттай асуултуудаас дурдвал:
 - Эмэгтэйчүүдийн эсрэг гэр бүлийн хүчирхийллээс сэргийлэхтэй холбогдуулан улсаас авч буй арга хэмжээг товч тодорхойлно уу.
 - Эмэгтэйчүүдийг гэр бүлийн хүчирхийллээс хамгаалах хуулийг зөв хэрэгжүүлэхэд, хэрэв саад тулгарч байгаа бол, ямар гол саадүүд тулгарч байна вэ?
 - Туршлага дээрээ үндэслэн хэлбэл, гэр бүлийн хүчирхийллийн эмэгтэй хохирогчдод зориулсан үйлчилгээг сайжруулахын тулд юу хийж болох вэ?
- Бүтэцлэгдсэн ярилцлагын үеэр аудитор урьдчилан бэлдсэн багц асуултуудыг нэгэн жигд асууж, ихэвчлэн урьдчилан тодорхойлсон боломжит хариултаудаас сонгож хариулахыг санал болгодог. Бүтэцлэгдсэн ярилцлагын хувьд, аудитын асуултууд болон хэдийнээ цуглуулсан нотлох зүйлдээ үндэслэн учир зүйтэй бөгөөд магадлал өндөртэй хариултын сонголтуудыг боловсруулах хэрэгтэй. Энэ арга хандлага нь хариултын тоо хэмжээг хязгаартай байлгахыг хүсэж буй үед, өөрөөр хэлбэл, “Бидний ярилцсан [тоо] хүнээс, [ийм тооны хүн] ... гэж хэллээ.” гэж хэлэхийг хүссэн үед хэрэгтэй байдаг. Энэ арга хандлагыг телефон утсаар хийх судалгаа зэрэг ярилцлага авагч өөрөө

хөтлөн явуулдаг судалгааны үед ихэвчлэн ашигладаг. Бүтэцлэгдсэн ярилцлагын үеэр аудиторын асууж болох сонголтод хариулттай асуултуудаас дурдвал:

- Жишээ: Хүчирхийллийн эмэгтэй хохирогчдод үйлчилгээ үзүүлэхэд цагдаа нарт, хэрэв асуудал тулгардаг бол, ямар асуудал тулгардаг вэ?
 - () Ажилтнуудын тоо хангалтгүй
 - () Хүндэтгэлтэй бөгөөд ялгаварлалгүй сонсох чадавх дутмаг
 - () Зохио ёсоор хүлээн авах чадвар дутмаг
 - () Жендерийн асуудлаар үр чадвар эзэмшсэн цагдаагийн албан хаагч цөөн
 - () Барилга, байгууламж, тоног төхөөрөмж хангалтгүй
 - () Стандарт дутмаг
 - () Эмэгтэйчүүдийн эрхийн тухай мэдээлэл дутмаг
 - () Бусад. Тодруулна уу: _____

Тухайлбал, Европын Аудиторуудын Шүүхээс ХАА-н салбарт эрсдэлийг бууруулах Европын Холбооны (ЕХ) хүчин зүтгэл үр нөлөөтэй хэрэгжиж, үр дүнгээ үр нөлөөтэй бий болгож байгаа хэр хэмжээг судлах зорилгоор үр дүн болон тогтолцоонд чиглэсэн арга хандлагуудыг ашиглаж аудит хийжээ. Энэхүү нягталгааны нэг хэсэг болгож, уг аудитын багаас ЕХ-ны 17 гишүүн орны нийт 105 фермертэй ярилцлага хийж, фермерүүдийн үйлдвэрлэлийн алдагдлын шалтгаан (тухайлбал, үүр амьсгалын үзэгдэл, хортон шавж), фермийн хэмжээнд авч хэрэгжүүлсэн урьдчилан сэргийлэх арга хэмжээ (тухайлбал, сэлгэн тариалалт, ариун цэвэр, эрүүл ахуй, ариутгах татуурга гэх мэт), фермерүүдийн эрсдэлийн эсрэг даатгуулсан хэмжээ болон бусад зүйлсийг хэлэлцсэн байна. Ярилцлагуудад бүтэцлэгдсэн асуултууд ашиглаж, аудитын багт хариултуудыг үр нөлөөтэй хязгаарлах боломж олгожээ. Аудитын багийн илрүүлэлтүүдийг дэмжихэд энэ аргыг хэрхэн ашигласан талаарх дэлгэрэнгүй мэдээллийг дараах холбоосоор үзнэ үү: [Тусгай тайлан №23/2019: Фермерүүдийн орлогыг тогтворжуулах нь: хэрэгслийн цогц багц байгаа ч, тоног төхөөрөмжийн ашиглалт бага бөгөөд хэт өндөр нөхөн олговор олгодог байдлыг шийдвэрлэх шаардлагатай байна.](#)

Ярилцлагыг мөн хагас бүтэцлэгдсэн байдалтай хийж болно. Өөрөөр хэлбэл, асуултуудын багцад урьдчилан боловсруулсан болон уян хатан асуултуудыг аль алийг нь оруулж болно. Таны сонгох арга хандлага нь та хариултуудыг хэрхэн ашиглахыг хүсэж байгаагаас хамаарна. Ердийн ярилцлага нь ихэвчлэн нээлттэй хариулттай болон сонголтод хариулттай асуултуудыг аль алийг нь агуулсан байдаг.

Үр нөлөөтэй ярилцлагын асуултын зөвлөмж

- ✓ Нэг талыг барьсан шинжгүй, бодитой бөгөөд төвийг сахисан асуулт асуух хэрэгтэй.
- ✓ Нээлттэй хариулт авахыг зорьж байгаа бол "тийм" эсвэл "үгүй" гэж хариулж болох асуултаас зайлсхийх хэрэгтэй.
- ✓ Сонголтод хариулт авахыг зорьж байгаа бол "тийм", "үгүй" эсвэл бусад тодорхой хариултаар хязгаарлагдах асуулт асуух хэрэгтэй.
- ✓ Асуултуудаа энгийн, тодорхой, товч байлгах хэрэгтэй.
- ✓ Нэг асуултаар хоёр асуудал хөндөх гэж оролдох хэрэггүй.
- ✓ Хариултаа алагчлан үзэхгүйгээр чухал сэдвүүдийн талаар дэлгэрүүлэн хэлэлцэхийг дэмжсэн тандах асуултууд ашиглах хэрэгтэй. Тухайлбал, "Та ... тухай дэлгэрэнгүй ярьж өгөөч?" эсвэл "Би энэ үйл явцыг бүрэн ойлгоогүй байж магадгүй. Тийм учраас дэлгэрэнгүй тайлбарлаж өгч болох уу?" гэх мэт асуулт асуух хэрэгтэй.

Эх сурвалж: АДБОУБХС/ГАДХ-ны Хөгжлийн Баг.

Ярилцлагыг үр нөлөөтэй байлгахын тулд сайтар төлөвлөж, үр дүй болон үр чадвартайгаар гүйцэтгэж, бүрэн бөгөөд үнэн зөв баримтжуулах ёстой. Мөн, аудитын талаар хамааралтай бөгөөд хүчин төгөлдөр мэдлэгтэй хүмүүс (тухайлбал, үйлчлүүлэгч, иргэний нийгмийн байгууллагууд, экспертүүд болон засгийн газрын бусад байгууллагууд) аудитад шалгуулагч байгууллагаас гадуур байж болно гэдгийг бодолцож үзэх хэрэгтэй. Ярилцлагыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд ерөнхийдөө гурван үе шатыг дамжих хэрэгтэй: төлөвлөлт, гүйцэтгэл, үр дүнгийн баримтжуулалт:

1. **Ярилцлагыг төлөвлөхдөө** албан тушаалтнаас үр нөлөөтэй ярилцлага авахын өмнө хийх шаардлагатай судалгаа шинжилгээ, болон захиргааны болон логистикийн арга хэмжээг гүйцэтгэх хэрэгтэй:

- Ярилцлага авах оффис болон хувь хүмүүсийг тодорхойлох. Итгэлтэй биш байвал аудитад шалгуулагч этгээдтэй холбоо барих үндсэн шугамаараа холбогдож, уг хувь хүмүүсийг тодорхойлно.
- Ярилцлагын логистикийн асуудлуудыг төлөвлөх. Аудитад шалгуулагч этгээдтэй хамтран ажиллаж ярилцлагын цаг болон байршлыг товлон. Ярилцлагын үеэр яригдсан зүйлсийн талаарх ярилцлага авагчийн ойлголтыг зөв байлгахын тулд бие биеийнхээ ойлголтыг нотлох хоёр хүн аудитын багаас бүх ярилцлагад оролцох нь сайн практик юм.
- Ярилцлагын сэдэв болон ярилцлага өгөх хувь хүний/хүмүүсийн талаар мэдлэгтэй болохын тулд ярилцлагын өмнөх судалгаа шинжилгээний ажлыг хийх.
- Олж авахыг хүссэн мэдээлэлдээ үндэслэн ярилцлагын асуултуудыг боловсруулах. Хэрэв аудитад шалгуулагч этгээдийн ажилтнаас ярилцлага авах бол, шалгуулагч этгээдийн зорилгууддаа хүрч буй хэр хэмжээг (үр нөлөөтэй байдал), эрхэм зорилгоо хэрэгжүүлэхэд шаардагддаг нөөцийг (арвилан хэмнэлт), мөн ашигласан нөөц болон бий болгосон гарц хоорондын хамаарлыг (үр ашигтай байдал) судалсан асуултуудыг ярилцлагадаа оруулах хэрэгтэй. Ярилцлагын сэдвүүдтэй хамаарал бүхий сайн тодорхойлсон шалгууруудтай үед, уг шалгууруудтайгаа уялдсан асуултуудыг зохиож, ярилцлагын мэдээллийг хожим шинжлэхэд хялбар болгож болно. Нөхцөл байдлаас хамааруулаад, уг асуултуудаа аудитад шалгуулагч этгээд рүү ярилцлагын өмнө илгээж, асуултуудад хариулбал зохих хувь хүмүүсийг

бэлэн байлгах нөхцөлийг бүрдүүлж болно. Мөн, ярилцлагын үеэр ярилцлага өгөгчийн хариултыг дэлгэрүүлэн тандаж асуух асуултуудыг боловсруулж бэлдсэн байх хэрэгтэй.

2. **Ярилцлагыг гүйцэтгэхдээ** холбогдох аудитын баримт бичгүүд болон өгөгдлийг цуглуулах зэрэг шаардлагатай мэдээлээ олж авахын тулд төлөвлөсөн ярилцлагаа гүйцэтгэх хэрэгтэй:

- Ярилцлагыг хэн удирдахыг тодорхойлох. Аудитын багийн нэг хүн ярилцлагыг удирдаж, бусад нь тэмдэглэл хөтлөх практик түгээмэл байдаг.
- Ярилцлагын эхэнд, аудитын багийнхан болон ярилцлага өгөгч хүмүүс, мөн ярилцлагын зорилго болон аудитын дэвсгэр мэдээллийг танилцуулах.
- Албан тушаалтнуудаас ярилцлага авахдаа хамааралтай асуулт асууж, хариултыг нь сайтар тэмдэглэж авах. Нотлох зүйлийнхээ чанар болон жинтэй байдлыг сайжруулахын тулд нэхэн судлах асуулт болон тандах асуултуудыг асуух нь чухал. Тухайлбал, “Үүнийхээ жишээг хэлж өгч болох уу?” гэж асуувал сайн тандан судлах асуулт болно. Мөн, танд асуудлыг цогцоор нь ойлгуулж, буруу дүгнэлт гаргахаас зайлсхийхэд туслах ямар нэгэн эсрэгцсэн нотлох зүйл байгаа эсэхийг тандаж, үнэлэх нь чухал. Ярилцлагын явцад аудитын зорилго(ууд)той холбогдох өөр бусад асуудал илэрсэн тохиолдолд төлөвлөсөн асуултын жагсаалтаа өөрчлөх буюу нэмэн дэлгэрүүлэхэд бэлэн байх хэрэгтэй.
- Харилцан яриаг ярилцлагын сэдвүүдэд төвлөрүүлэхийн тулд ярилцлагыг ерөнхийд нь хяналтдаа байлгах.
- Албан тушаалтнуудын өгсөн мэдүүлгийн мэдээллийг нотлох эсвэл өргөжүүлэх зорилготой холбогдох баримт бичгүүд болон мэдээлэл авахыг хүсэх. Ярилцлага өгөгчдөд таны цуглуулж буй мэдээлэл нь аудитад ямар хамааралтай бөгөөд хэрэгцээтэй вэ гэдгийг тайлбарлаж өгөх хэрэгтэй.
- Ярилцлагыг дуусгах үед, цуглуулсан гол мэдээллүүд болон хувь хүмүүсийн зүгээс танай аудитын багт гаргаж өгөхөөр тохирсон баримт бичгүүд болон өгөгдлүүдийг хураангуйлж үзэх. Ярилцлага өгөгчдийн зүгээс ямар нэгэн сүүлчийн асуулт эсвэл санал байгаа бол түүнд хариулж, аудитад дэмжлэг үзүүлж буйд нь талархал илэрхийлэх хэрэгтэй. Түүнчлэн, аудитын явцад ярилцлага өгөгчидтэй дахин уулзах шаардлага үүсэж болно гэдгийг мэдэгдэх хэрэгтэй.

Үр нөлөөтэй ярилцлагын асуултын зөвлөмж

- ✓ Бэлтгэлтэй байх хэрэгтэй. Ярилцлагын судлах сэдэв/ зүйлийг судалж, ярилцлага өгч буй хувь хүний/хүмүүсийн үүргийг ойлгох хэрэгтэй.
- ✓ Ярилцлагын үеэр асуух асуултуудын жагсаалтыг урьдчилан бэлтгэх хэрэгтэй.
- ✓ Ярилцлагын огноо, цаг, үргэлжлэх хугацаа болон байршлыг урьдчилан товлох хэрэгтэй.
- ✓ Аудитын багаасаа нэгээс олон хүнийг ярилцлагад авч ирэх хэрэгтэй.
- ✓ Ярилцлагын өмнө хэн асуулт асуух, хэн тэмдэглэл бичих зэргээр хүн бүрийн үүргийг хуваарилж өгөх хэрэгтэй. Боломжтой бол, ярилцлагыг ганцаараа хийхээс зайлсхийх хэрэгтэй.
- ✓ Ярилцлагаа цагтаа эхлүүлж, цагтаа дуусгах хэрэгтэй.
- ✓ Анхаарал хандуулсан, ажиглангүй, бодитой, хүндэтгэлтэй, голч, мэдрэмжтэй бөгөөд итгэлтэй байх хэрэгтэй.
- ✓ Ярилцлага өгөгчтэй таатай харилцаа үүсгэх хэрэгтэй. Ярилцлага бол тулган шалгалт биш.
- ✓ Хэт их ярихгүйгээр, сонсож, ажиглах хэрэгтэй.
- ✓ Уян хатан байх хэрэгтэй. Гэхдээ ярилцлагын зорилгоо санаж байх хэрэгтэй.
- ✓ Аудитад хамааралтай бол хэцүү бэрх асуулыг ч асуух хэмжээний зоригтой байх хэрэгтэй. Илэн далангүй, шулуун шударга байх хэрэгтэй.
- ✓ Эгогоо харуулсан, эсвэл өөрийгөө их мэдлэгтэй эсвэл албан тушаал өндөр гэсэн хандлага гаргасан нарийн төвөгтэй асуулт асуухаас зайлсхийх хэрэгтэй.
- ✓ Зайлсхийсэн шинжтэй хариулт ирсэн тохиолдолд, бүрэн мэдээлэл хүлээж буйгаа илтгэж түр азнах буюу чимээгүй байх хэрэгтэй.
- ✓ Үнэн зөв бөгөөд цогц тэмдэглэл хөтлөх хэрэгтэй.
- ✓ Боломжтой бол, дуу хураагуур авчрах талаар бодолцож үзэх хэрэгтэй.
- ✓ Ярилцлагыг гүйцэтгэснийхээ дараа аль болох богино хугацаанд баримтжуулах хэрэгтэй.

Эх сурвалж: АХАДБАБ-ын Гүйцэтгэлийн Аудитын Маягтын Гарын авлага, 2013; мөн Бразил улсын АДБ – Аудитын ярилцлагуудыг эш болгов.

3. Ярилцлагын үр дүнг баримтжуулахдаа ярилцлагын явцад олж авсан мэдээллийн үнэн зөв бичмэл протоколыг шинжилгээ хийх, чанарын хяналт хэрэгжүүлэх боломжтой байдлаар үүсгэх (УДИР-3920/100). Ярилцлагыг баримтжуулах маягыг 8-р хавсралтаас үзнэ үү:

- Аль болох нарийвчлалтай, үнэн зөв байх. Ярилцлагын протоколыг боловсруулахдаа та мэдээллийг засварлаж, хураангуйлж, нэгтгэх болно. Гэсэн хэдий ч, ярилцлагаар олж авсан мэдээллийг боловсруулж, үгэнд буулгахдаа үнэн зөв байдлыг нь алдагдуулахгүй байх нь чухал.
- Бичмэл протоколыг үйлдэхдээ мэдээлэлд шинжилгээ хийхийг дэмждэг байдлаар эмхэтгэх. Тухайлбал, протоколыг аудитын асуулт эсвэл сэдвийн талбараар ангилал үүсгэн эмхэтгэж, ялгаатай талбаруудад тохирох гарчгийг нь өгөх хэрэгтэй.
- Ярилцлага өгсөн хүмүүсийн нэрсийг, албан тушаал болон холбоо барих мэдээлэлтэй нь хамт баримтжуулах. Энэ нь ярилцлагын үнэн зөв протокол үүсгэхэд маш чухал.
- Ярилцлага өгөгчийн ярьсан аудитад шалгуулагч этгээдийн албан ёсны байр суурь болон ярилцлага өгөгчийн аливаа асуудлаарх үзэл бодлыг тус тусад нь байлгах. Энэ нь мэдээллийн зохистой байдлыг тодорхойлоход маш чухал анхаарах зүйл юм.
- Ярилцлага өгөгчөөс өгсөн баримт бичгүүдийн цахим холбоосыг ярилцлагын протоколын зохих хэсэгт эш татан оруулах. Энэ нь баримт бичгүүдийг ярилцлага өгөгчийн мэдэгдлийн хүрээнд тодорхой тайлбарлахад тусална.
- Ярилцлагын протоколын үнэн зөв байдлыг тулган баталгаажуулж, бататгах

алхмуудыг хэрэгжүүлэх. Зарим аудитын баг нийт ярилцлагын тэмдэглэлээ ярилцлагын протоколыг үүсгэж буй хүнтэй хуваалцаж, уулзалтын цогц тэмдэглэлтэй болгодог. Бусад аудитын багийн хувьд, нэг хүнээр тэмдэглэлд нь үндэслэсэн протокол бичүүлж, багийн бусад гишүүд өөр өөрсдийн тэмдэглэлийг ашиглан уг протоколыг нягталдаг. Та багтаа хамгийн сайн тохирох арга хандлагыг ашиглаж болно. Гэвч, ярилцлагын үеэр байлцсан багийн гишүүдээр ярилцлагын протоколыг нягтлуулж, үнэн зөв байдлыг нь тулган баталгаажуулах нь чухал. Өгсөн мэдээллийнх нь аль нэг хэсгийг ойлгохгүй эсвэл итгэхгүй байгаа тохиолдолд ярилцлага өгөгчтэй дахин холбогдох хэрэгтэй. Зарим тохиолдолд, та ярилцлагын дуу бичлэгийг хийж, түүнийгээ бичигт буулгах боломжтой байж болно. Боломжтой үед, ярилцлагын дуу бичлэгийг хийснээр та тэмдэглэл хөтлөхдөө төвлөрөх шаардлагагүй болж, хувь хүмүүсийн ярьж байгаа зүйлийг анхааралтай сонсох боломжтой болно. Хэрэв та ярилцлагын дуу бичлэгийг хийхээр шийдвэл, ярилцлага өгөгчийн зөвшөөрлийг авах хэрэгтэй. Мөн, яриаг нь бичсэнээр эмзэг асуудлуудаар чөлөөтэй ярихаас цааргалахад хүргэж болзошгүй гэдгийг санах хэрэгтэй. Дуу бичлэг хийх практик нь АДБ-уудын хувьд харилцан адилгүй байдаг тул байгууллагынхаа ярилцлагын дуу бичлэг хийх бодлого, горимуудыг судлах хэрэгтэй.

Аудитын сэдвийн талаар цогц ойлголттой болохын тулд өөр өөр албан тушаал, харах өнцөг болон ойлголттой хүмүүсээс ярилцлага авах нь чухал. Таны ярилцлагын үр дүн нь мэдүүлгийн нотлох зүйл байх тул, өөр өөр хүмүүс болон оффисуудтай олон удаагийн ярилцлага хийснээр нотлох зүйлийнхээ баттай байдлыг нэмэгдүүлж чадна. Ярилцлага хийх нь асар их нөөц шаарддаг. Иймд зөвхөн шаардлагатай тохиолдолд ярилцлага зохион байгуулах хэрэгтэй. Шаардлагатай эсэхийг тогтоох нэг арга бол баримт бичиг зэрэг бусад эх сурвалжаас олж авах боломжгүй, хамааралтай, шинэ эсвэл сонирхолтой мэдээллийг ярилцлагаар олж авах боломжтой эсэхийг харгалзан үзэх арга юм. Ярилцлагаар олж авсан мэдүүлгийн нотлох зүйлийн найдвартай байдал нь мэдүүлэг өгсөн хүн, түүний мэдлэгийн түвшин болон нэг талыг барих хандлагын хэмжээнээс хамаардаг гэдгийг санах хэрэгтэй. 4-р бүлэгт авч үзсэнчлэн, аудитын эрсдэлийг бууруулахын тулд олж авсан мэдээллээ боломжтой үе бүрд баримт бичигтэй эсвэл өөр хэлбэрийн нотлох зүйлтэй тулган нотолдог байх хэрэгтэй. Ярилцлагыг хэрхэн төлөвлөж, гүйцэтгэж, баримтжуулах талаар дэлгэрэнгүй мэдээлэл агуулсан ярилцлагын удирдамжийг 8-р хавсралтаас үзнэ үү.

Баримт бичиг цуглуулах

Аудит нь ерөнхийдөө илрүүлэлтүүд болон дүгнэлтүүдээ дэмжихийн тулд олон төрлийн баримт бичигт түшиглэдэг. Иймд, баримт бичиг цуглуулах нь нотлох зүйл олж авах маш чухал арга юм.

Баримт бичгийн нотлох зүйлийг ерөнхийдөө мэдүүлгийн нотлох зүйлээс илүү найдвартай гэж үздэг. Олж авсан мэдүүлгийн нотлох зүйлээ баримт бичгийн нотлох зүйлээр нотлох нь чухал (27-р зураг болон УДИР-3920/74-77-г үзнэ үү). Та олон өөр эх сурвалжаас баримт бичиг цуглуулж болно. Гэхдээ, цуглуулсан баримт бичгээ нотлох зүйл болгон ашиглаж чадах эсэх нь уг баримт бичгийн хүчин төгөлдөр байдал болон мэдээллийг үүсгэсэн эх сурвалжууд болон тогтолцоонуудын шударга байдлаас хамаарна (хажуугийн шигтгээг үзнэ үү). Үүнийг доор илүү дэлгэрүүлэн тайлбарлана.

Аудитад шалгуулагч этгээд

Ихэнх аудитын хувьд, аудитад шалгуулагч этгээд нь хамааралтай баримт бичгийн нотлох зүйлийн гол эх сурвалж болдог. Аудитын асуултууддаа хариулахын тулд аудитад шалгуулагч этгээдээс нотлох зүйлээр хангах баримт бичгүүдийг хүсэх хэрэгтэй. Баримт бичиг нь чанарын эсвэл тоон шинжтэй байж болно. Тухайлбал:

- Бодлого, удирдамж, байгууллагын зураглал;
- Гэрээ, нэхэмжлэл, нягтлан бодох бүртгэлийн мэдээлэл, төсвийн өгөгдөл;
- Аудитад шалгагдаж буй сэдвийн гүйцэтгэлийн талаарх тоон өгөгдөл; мөн
- Аудитын сэдэвтэй холбогдох эрдэм шинжилгээний болон судалгааны ажлууд.

Аудитын эхэнд, аудитад шалгуулагч этгээдээс аудитын сэдвийн талбаруудтай холбогдох зохион байгуулалт, үйл ажиллагаа болон удирдамжийнх нь талаарх мэдээллээр таныг хангах баримт бичгүүдийг хүсэх хэрэгтэй. Аудитын эхэн үед энэ мэдээллийг цуглуулж, нягталснаар та ярилцлага, судалгаа, нэмэлт баримт бичиг цуглуулалт болон үзлэгийг аудитын явцад үр нөлөөтэй гүйцэтгэх бэлтгэлтэй болно.

Албан тушаалтнуудын мэдэгдлийг нотолж, холбогдох баримтуудыг үүсгэж, аудитад шалгуулагч этгээд аудитын зорилго(ууд) болон асуултуудтай холбогдох үүргээ хэр үр нөлөөтэй бөгөөд үр ашигтай гүйцэтгэж байгаа талаар ойлголт өгөх баримт бичгүүдийг асуухаа мартаж болохгүй.

Аудитад шалгуулагч этгээдээс баримт бичиг цуглуулахдаа, өгсөн мэдээлэл нь тохиромжтой эсэхийг үнэлэх нь таны хариуцлага юм. Аудитад шалгуулагч этгээдийн гаргаж өгсөн баримт бичиг эсвэл өгөгдлийг хамааралтай, хүчин төгөлдөр бөгөөд найдвартай гэж шууд хүлээж авч болохгүй. Тухайлбал, аудитад шалгуулагч этгээдэд байгаа мэдээлэл нь үнэн зөв биш, эсвэл аудитад шалгуулагчийн хийсэн шинжилгээ үнэн зөв хийгдээгүй, эсвэл танд гаргаж өгсөн мэдээлэл нь нөхцөл байдлыг нэг талыг барьсан эсвэл бүрэн бус дүгнэсэн мэдээлэл байж болно. Өгөгдөл, мэдээллийг хэрхэн боловсруулсныг ойлгох хэрэгтэй. Мөн баримт бичигт орсон мэдээлэл нь аудитад шалгуулагч этгээдийн танд хэлсэн зүйлстэй нийцэж байгаа эсэхийг шалгах хэрэгтэй. Тухайлбал, та мэдээллийн эх сурвалжийн талаарх нэгэн

ижил асуултыг олон хүнээс асууж болно. Мөн, аудитад шалгуулагч этгээдийн гаргаж өгсөн мэдээллийг нотолж, нөхцөл байдлыг бүрэн ойлгохын тулд тухайн төрлийн мэдээллийг олон өөр эх сурвалжаас цуглуулан судалж болно. Түүнчлэн, аудитад шалгуулагч этгээдийн шинжилгээ болон дүгнэлтүүдийн үндэс болсон эх сурвалжийн өгөгдөл, кэйсүүд эсвэл файлуудыг нягтлах хүсэлт тавьж болно. Тэгснээр, та үр дүнгүүдийг өөрөө тулган баталгаажуулах боломжтой болох юм. Мөн, нягталж буй баримт бичгүүдийнхээ хугацааг анхаарах хэрэгтэй. Тодруулбал, тодорхой нэг үйл явдалтай холбогдох баримт бичгүүдийг судалж байгаа тохиолдолд, уг баримт бичгийг үйлдсэн хугацаа нь тухайн үйл явдлын өрнөсөн хугацаатай ойр эсвэл давхцаж буй эсэхийг шалгах хэрэгтэй. Тухайлбал, аливаа нэг хурлын тэмдэглэлийг хурал болсон өдөр бичсэн үү, эсвэл 6 сарын дараа бичсэн үү гэдгийг асууж болно. Хурлын тэмдэглэлийг бичсэн хугацаа нь уг аудитын нотлох зүйлийн хүчин төгөлдөр бөгөөд зохистой байдалд нөлөөлж болно.

Аудитын явцад цуглуулсан бүх баримт бичгээ бүртгэж, хянах зориулалттай бүртгэл үүсгэх хэрэгтэй. Энэ нь аудитад шалгуулагчаас гаргаж өгөхийг хүссэн баримт бичгүүдийг тодорхой тэмдэглэж, алийг нь гаргаж өгсөн, алийг нь хараахан гаргаж өгөөгүй байгааг тодорхой болгодог.

Аудитад шалгуулагч болон сэдвийн эмзэг байдлаас хамааруулаад та аудитад шалгуулагчаас баримт бичиг эсвэл мэдээлэл олж авахад сорилттой тулгарч болно. Хэрэв аудитад шалгуулагч нь таныг аудитын асуултуудтай холбоотой мэдээллийг олж авахад саад хийх гэж оролдож байвал, та нэн даруй хянагчдаа мэдэгдэх хэрэгтэй. Тэгснээр уг асуудал дээд удирдлагад шүүрхай хүрч, АДБ-ын бодлого болон хууль ёсны эрхийн дагуу шийдвэрлэгдэх болно.

Аудитад шалгуулагч этгээдээс мэдээлэл авахад тулгарах сорилтууд ба тэдгээрийг давах арга

Тухайн улсынхаа хуулийн дагуу, Аудитын Дээд Байгууллага (АДБ) бүр гүйцэтгэж буй аудитынхаа хүрээнд засгийн газрын холбогдох баримт бичгүүд болон мэдээлэлд хандах хууль ёсны эрхтэй байх ёстой. Аудитад ямар мэдээлэл яагаад шаардлагатай байгаа талаар тогтмол харилцах зэргээр аудитад шалгуулагч этгээдтэй эерэг харилцаа үүсгэх нь танд мэдээллийг илүү хялбар олж авахад тусална.

Гэвч зарим аудитад шалгуулагч этгээд таны хүссэн мэдээлэлд хандах эрхийг сайн дураар өгөхгүй байж мэднэ. Та АДБ-ынхаа хууль ёсоор танилцах эрхтэй гэж үзэж буй мэдээллийг олж авахад бэрхшээлтэй буюу ихээхэн саатал эсвэл татгалзалтай тулгарсан үед дараахыг хийх хэрэгтэй:

- ✓ Асуудлыг нэн даруй хянагчдаа мэдэгдэж, шаардлагатай үед АДБ-ын дээд удирдлагад хүргүүлэх нөхцөлийг бүрдүүлэх;
- ✓ АДБ-ынхаа хуулийн эксперттэй зөвлөлдөж, таны авахыг хүсэж буй мэдээлэл нь танай АДБ-ын хууль ёсоор авах эрхтэй мэдээлэл мөн эсэхийг мэдэж, хүсэлтээ ямар хэлбэрээр уламжлах талаар зөвлөгөө авах;

- ✓ Мэдээлэл авах хүсэлтээ аудитын тодорхой асуулттай шууд хамааралтай байлгах;
- ✓ Хүсэлтийнхээ мөн чанарыг аудитад шалгуулагч этгээдэд аль болох нарийн тодорхой тайлбарлан өгч, аудитынхаа тодорхой асуулт(ууд)тай уялдуулж өгөх;
- ✓ Хүссэн мэдээллээ хүлээн авах эсвэл уулзалт хийх хугацаагаа тодорхой тогтоож өгөх;
- ✓ Хүсэж буй мэдээлэл нь хууль ёсоор эмзэг мэдээлэл байвал, АДБ-ынхаа удирдлага болон аудитад шалгуулагч этгээдтэй хамтран ажиллаж, аудитын хэрэгцээнд тохирох мэдээллийн өөр эх сурвалж байгаа эсэхийг, эсвэл мэдээллийг газар дээр нь нягтлах зэрэг хүлээн зөвшөөрч болохуйц зохицуулалт хийж болох эсэхийг тодорхойлох; мөн
- ✓ Уг мэдээллийг олж авахын тулд хийсэн оролдлогуудаа баримтжуулж, гаргасан хүсэлтүүдийнхээ бүртгэлийг хөтлөх.

Танай аудитын баг энэ асуудлыг хэрхэн шийдвэрлэх талаар АДБ-ынхаа дээд удирдлагатай нягт хамтран ажиллах шаардлагатай.

Эх сурвалж: АДБОУБХС/ГАДХ-ны Хөгжлийн Баг.

Гуравдагч талын эх сурвалж

Аудитын үндсэн судлах сэдэв/ зүйл болоогүй харилцагчид, экспертүүд, иргэний нийгмийн байгууллагууд, гэрээлэгчид, мэргэжлийн байгууллагууд, судалгааны байгууллагууд болон засгийн газрын бусад байгууллагууд зэрэг холбогдох гуравдагч талын байгууллагууд нь мөн баримт бичгийн нотлох зүйлийн хэрэгтэй эх сурвалж байж чадна. Тухайлбал, гэрээлэгч нь танд гэрээтэй холбогдох гүйцэтгэлийнхээ талаар мэдээлэл өгч чадна. Эсвэл судалгааны байгууллага нь аудитын сэдвийн талаар холбогдох судалгаа хийсэн байж болно. 4-р бүлэгт тайлбарласанчлан, мэдээллийн холбогдох эх сурвалжуудыг тодорхойлохын тулд аудитын талбартай холбогдох ерөнхий судалгааны тайлангууд, ном болон өгүүллүүдийг аудитын эхэнд судлах нь үргэлж тустай байдаг.

Гуравдагч талын эх сурвалжийг нотлох зүйл болгон ашиглах нь зохистой эсэхийг харгалзаж үзэхдээ та аудитын хам нөхцөл, аудитын сэдэвтэй холбогдох гуравдагч талын үүрэг болон гуравдагч талд байж болох аливаа сэдэл эсвэл нэг талыг барьсан хандлагыг ойлгосон байх хэрэгтэй.

Мэдлэгтэй бөгөөд хамааралтай гуравдагч талаас мэдээлэл цуглуулах нь аудитад шалгуулагч этгээдийн итгэл даах чадвар эсвэл нээлттэй байдалд эргэлзэж буй үед ялангуяа

чухал байдаг. Ийм орчин нөхцөлд, гуравдагч талаас авсан мэдээлэл нь аудитад шалгуулагч этгээдээс өгсөн мэдээллийг нотлоход, эсвэл аудитад шалгагдагч үйл ажиллагааны талаар цогц зураглалтай болоход тусалдаг.



Файлын нягталгаа амжилттай хийхэд сайтар тодорхойлсон өгөгдөл цуглуулах хэрэгсэл чухал. Иймд дараах алхмуудыг хэрэгжүүлнэ үү:

- Өгөгдөл цуглуулах хэрэгсэлээ боловсруулж эхлэхийн өмнө файлуудын агуулгыг ойлгох;
- Файлуудаас хүссэн мэдээллээ хялбархан олж авахын тулд асуултуудаа сайтар боловсруулах;
- Өгөгдөл цуглуулах хэрэгсэлээ шаардлагатай мэдээллийг олж авч чаддаг болгохын тулд эхлээд цөөн тооны файл дээр туршиж үзэх.

Эх сурвалж: АДБОУБХС/ГАДХ-ны ХБ.

Файлын нягталгаа

Файлын нягталгаа хийхэд ажилтнуудын файл эсвэл гэрээ зэрэг ижил төрлийн баримт бичгийн олон бүртгэлийг нягталж, мэдээлэл гаргаж авдаг. Асуудал эсвэл асуултыг файлуудаас илрүүлэхийн тулд файлын нягталгаа нь бүтэцлэгдсэн бөгөөд системтэй байх шаардлагатай. Шууд ажиглалтын нэгэн адил, та мэдээлэл цуглуулж эхлэхийн өмнө цуглуулах шаардлагатай байгаа мэдээллээ тодорхойлж, өгөгдөл цуглуулах хэрэгсэлээ боловсруулах хэрэгтэй. 9-р хавсралтаас хоёр файлын харьцуулалтын жишээг үзнэ үү.

Вебд суурилсан эх сурвалжууд

Аудитын баг нь мэдээлэл олж авахдаа вебд суурилсан эх сурвалжуудыг их ашигладаг. Вебд суурилсан эх сурвалжид засгийн газрын агентлагууд, хууль тогтоох байгууллагууд, үйлдвэрчний эвлэлүүд болон хэвлэл мэдээллийн байгууллагуудын вебсайтууд багтаж болно. Тодорхой вебсайтын мэдээллийг ашиглахад уг мэдээлэл нь тохиромжгүй байх өндөр эрсдэл агуулагдаж байдаг. Тухайлбал, блог, вики сайтууд болон хувийн вебсайтуудыг нотлох зүйл болгож ашиглах нь зохимжгүй. Учир нь эдгээр эх сурвалжид тодорхойлж, хүлээн зөвшөөрч болохуйц нэр нөлөө байдаггүй, эсвэл үнэн бодитой эсэхийг нь тулган баталгаажуулах боломжгүй юм. Салбарын сэтгүүл эсвэл сонинтой холбогдох бусад вебсайтууд нь үнэн бодитой байж болох ч, нэр нөлөөтэй эсвэл найдвартай гэж үзэх нь өрөөсгөл болно. Эдгээр сайтуудаас мэдээлэл авч ашиглахдаа мэргэжлийн үнэлэмжээ хэрэгжүүлнэ үү.

Таны ашиглаж буй вебсайт нь танд хэрэгтэй мэдээллийн найдвартай эх сурвалж байж чадах эсэхийг сайтар бодолцож үзэх хэрэгтэй. Вебд суурилсан эх сурвалжуудын хувьд, дараах асуултуудыг өөрөөсөө асууна уу:

- Энэ эх сурвалж үнэн бодитой юу?
- Энэ эх сурвалж энэ сэдвээр нэр нөлөөтэй юу?
- Энэ эх сурвалж найдвартай юу?
- Энэ эх сурвалж алагчлалгүй (нэг талыг барьдаггүй) юу?

Вебд суурилсан эх сурвалжаас мэдээлэл авч ашиглах тохиолдолд, вебд суурилсан мэдээлэл өөрчлөгдөж болдог тул та уг мэдээллийг авсан огноогоо тайлагнах нь мөн чухал. Эцсийн дүндээ, вебд суурилсан эх сурвалж болон түүнээс авсан мэдээллийг ашиглах эсэхээ шийдэхэд тань таны мэргэжлийн үнэлэмж болон мэргэжлийн үл итгэл үзэл асар чухал үүрэгтэй байх болно.

Компьютероор боловсруулсан өгөгдөл

Аудитын багууд өгөгдлийн сан эсвэл программ хангамжаас гаргаж авсан өгөгдөл, программ хангамжаар хүснэгтэлсэн өгөгдөл, веб портал дээрх маягт эсвэл судалгаагаар цуглуулсан өгөгдөл зэрэг компьютероор боловсруулсан өгөгдлийг үе үе баримт бичгийн нотлох зүйлийн эх сурвалж болгож ашигладаг.

Өөр бусад өгөгдлийн эх сурвалжийн нэгэн адил, та тус өгөгдлийг шууд найдвартай гэж үзэж болохгүй. Өгөгдөл нь найдваргүй байвал, та мэдээллийг хүчин төгөлдөр гэж итгэх аргагүй болно. Таны олж авсан өгөгдөл нь илрүүлэлт, дүгнэлт, зөвлөмжүүдэд материаллаг байдлаар нөлөөлөхүйц байвал, та өгөгдлөө бүрэн бөгөөд үнэн зөв байлгахын тулд цөөн хэдэн нэмэлт алхмуудыг авч хэрэгжүүлэх шаардлагатай болно. Бүрэн бүтэн байна гэдэг нь танд хэрэгтэй өгөгдлийн бүртгэл олдоц сайтай бөгөөд уг бүртгэл дэх өгөгдлийн талбар зохих хэмжээнд суурьшсан байна гэсэн үг. Үнэн зөв байна гэдэг нь бүртгэгдсэн өгөгдөл нь эх сурвалжийн мэдээлэлтэйгээ тохирсон байна гэсэн үг.

Өгөгдлийн эх сурвалжийнхаа найдвартай байдлыг үнэлэхийн тулд хийж болох хэд хэдэн боломжит алхмууд бий. Таны хийх үнэлгээний цар хэмжээ нь тухайн өгөгдөл таны илрүүлэлтүүдэд хэр чухал вэ гэдгээс хамаарна. Боломжит алхмуудад дараах орно:

- Өгөгдлийн эх сурвалж болон өгөгдлийн хэрхэн цуглуулж, боловсруулж, үнэн зөвийг нь бататгасан талаар мэдлэгтэй албан тушаалтнуудтай ярилцлага хийх;
- Дутуу өгөгдөл, алслагдсан утгууд болон илэрхий алдааг илрүүлэх өгөгдлийн тестийг цахим технологиор эсвэл гараар хийх;
- Өгөгдөл оруулж, үнэн зөвийг нь бататгахтай холбогдох үйл явцууд болон горимууд зэрэг холбогдох дотоод хяналтад нягталгаа хийх; мөн
- Бусад эх сурвалжийн баримт бичгүүдээс сонголтод эсвэл санамсаргүй түүвэр авч шалгах.

Эдгээр алхмуудын зарим нь хэрэгжүүлэхэд нарийн төвөгтэй байж болно. Иймд өгөгдлийн найдвартай байдлыг үнэлэх чиглэлээр мэргэшсэн бөгөөд сэдвийн талаар мэдлэгтэй аудитор, арга зүйч зэрэг оролцогч талыг оролцуулж, ямар алхмыг хэрэгжүүлэх болон үнэлгээг хэрхэн хийх талаар шийдвэр гаргахад зөвлөгөө эсвэл тусламж авч болно.

Өгөгдлийг материаллаг нотлох зүйл болгон ашиглах боломжтой гэдгийг тодорхойлсныхоо дараа аль болох богино хугацаанд компьютероор боловсруулсан өгөгдлийн найдвартай байдлыг үнэлж эхлэх хэрэгтэй. Өгөгдлийн найдвартай байдлыг үнэлэх маягт болон аудитад шалгуулагч этгээдийн өгөгдлийн найдвартай байдлыг шалгах асуултуудын жишээг 10 болон 11-р хавсралтуудаас үзнэ үү. Аудитын багууд шинжилгээний нотлох зүйл бий болгохдоо ихэвчлэн компьютероор боловсруулсан өгөгдлийг шинжилдэг. Шинжилгээний нотлох зүйлийн найдвартай байдал нь шинжлэгдсэн өгөгдлийн найдвартай байдлаас шууд хамаардаг тул өгөгдлийн өргөтгөсөн шинжилгээ хийхийн өмнө өгөгдлийнхөө найдвартай байдлыг үнэлэх нь зүйтэй.

Компьютероор боловсруулсан өгөгдөл нь ховорхон тохиолдолд төгс байдаг. Гэхдээ, та тухайн өгөгдөл нь таны ашиглахаар төлөвлөж буй тодорхой аргуудад хангалттай эсэхийг тодорхойлох хэрэгтэй. Өгөгдлийн эмзэг эсвэл маргаантай мөн чанар, өгөгдлийг

ашигласнаар таны аудитын тайланг унших хүмүүсийн шийдвэрт ихээхэн сөргөөр нөлөөлөх боломж зэрэг өгөгдлийг ашиглахын эрсдэлийг бодолцож үзэх нь чухал. Түүнчлэн, нотлох чадвартай нотлох зүйлийнхээ баттай байдлыг бодолцож үзэх нь чухал. Учир нь баттай нотлох чадвартай нотлох зүйл нь төгс бус өгөгдлийн зарим эрсдэлийг бууруулахад түсэлж болно. Эсрэгээрээ, нотлох чадвартай нотлох зүйл тань хязгаарлагдмал бөгөөд та компьютероор боловсруулсан өгөгдлийг илрүүлэлтийнхээ цор ганц суурь болгож ашиглаж байгаа үед, уг өгөгдлийн хүчин төгөлдөр байдал болон найдвартай байдлын ач холбогдол асар ихэснэ. Компьютероор боловсруулсан өгөгдлийн найдвартай байдлын талаар шийдвэр гаргахад танай аудитын баг, танай байгууллагын удирдлага болон өгөгдлийн экспертүүдийн бүгдийнх нь мэргэжлийн үнэлэмж сайн байх шаардлагатай.

Компьютероор боловсруулсан өгөгдөл таны ашиглаж буй зорилгод хангалттай найдвартай гэдгийг тодорхойлсон үедээ л ашиглах хэрэгтэй гэдгийг санагтун. Мөн, аудитын эцсийн тайландаа компьютероор боловсруулсан өгөгдлийг тайлагнахдаа, эрсдэлийн баталгаажуулалтын алхам болгож, олж авсан өгөгдлийнхөө тухай, түүнийг хэрхэн олж авсан тухай, мөн тухайн өгөгдлийн хязгаарлалтуудын тухай арга зүйн зарим мэдээллийг тайлагнах хэрэгтэй.

Шууд ажиглалт ба биечилсэн үзлэг

Аудитын үед ажлын ширээнээсээ холдож, аудиттайгаа холбоотой хүмүүс, үйл ажиллагаанууд, горимууд, хөрөнгө эсвэл үйл явдлуудыг ажигладаг байх нь чухал. Мэдээлэл цуглуулах эдгээр аргуудыг шууд ажиглалт болон биечилсэн үзлэг гэж нэрлэдэг. Шууд ажиглалт болон биечилсэн үзлэгээр цуглуулсан нотлох зүйлсийг биет нотлох зүйл гэнэ. Биет нотлох зүйл нь ерөнхийдөө хамгийн нөлөө бүхий нотлох зүйлийн хэлбэр бөгөөд шууд бус нотлох зүйл буюу аудитад шалгуулагч этгээд эсвэл гуравдагч талаас гаргаж өгсөн нотлох зүйлээс илүү найдвартай байдаг.

Хэрэв танай аудитын асуултууд нь эд зүйл эсвэл хөрөнгийн нөхцөл, бараа материалын бүртгэл тооллого эсвэл аливаа үйл ажиллагааг зохих ёсоор гүйцэтгэж буй эсэхтэй холбогдож байвал эдгээр аргууд маш тустай байж чадна. Эдгээр аргуудыг ашигласнаар аудиттай холбогдох асуудлуудын хам нөхцөлийг (хам сэдвийг) ойлгож, холбогдох талбарууд нь хэр гүйцэтгэлтэй байгааг мэдэхэд дөхөм болно.

Тухайлбал, Европын Аудиторуудын Шүүхээс ЕХ-ны мал, амьтны эрүүл мэндийн асуудалд үр дүнд чиглэсэн аудит хийсэн байдаг. Уг аудитын баг нь ЕХ-ны 5 гишүүн орныг МАА-н салбарынх нь хэмжээ болон мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн хэрэгжилт сул гэдэг нь хэдийнээ тогтоогдсон эсэхэд нь үндэслэж түүвэртээ сонгожээ. Ийнхүү аудитын баг гишүүн орон бүрд, фермүүд болон мал, амьтны тээвэр болон нядалгааны үйл ажиллагаанд мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн хэрэгжилт хэр байгааг шууд ажигласан байна. Түүнчлэн, аудитын багаас мал, амьтдад хуулиар шаардагдсан бэлчээрийн талбай болон зохих хэмжээний хоол, тэжээл өгч буй эсэх гэх мэтээс хамааруулан олгодог төлбөр, дэмжлэгийг хүлээн авах тухай хуулийн шаардлагад фермерүүд хэр үр нөлөөтэй нийцэн ажиллаж буйг газар дээр нь очиж шалгажээ. Илүү дэлгэрэнгүй мэдээллийг дараах

холбоосоор үзнэ үү: *Тусгай тайлан №31/2018: ЕХ-ны мал, амьтны эрүүл мэнд: том зорилго болон практик хэрэгжилт хоорондын зөрүүг арилгах нь.*

28-р зурагт шууд ажиглалт болон биечилсэн үзлэгийн өгөөжийг хүртэж болох аудитын сэдвүүдийн зарим жишээг харуулж, түүнтэй холбогдуулан бодолцож үзэж болох ажиглалт, үзлэгүүдийн талаар өгүүллээ.

Зураг 28: Шууд ажиглалт болон биечилсэн үзлэгийн жишээ

<p>Төрийн өмчийн байгууламжуудын гэрээлэгчээр гүйцэтгүүлэх техникийн үйлчилгээ</p>	<p>Барилгуудад гэрээнд заасан шалгууруудын дагуу биечилсэн үзлэг хийхийн тулд холбогдох өмчүүд дээр талбарын ажил хийх. Гэрэл зураг дарж, ажигласан нөхцөлөө баримтжуулах.</p>
<p>Нисэх буудлын гаалийн үзлэгийн горим</p>	<p>Холбогдох нисэх буудлуудад зочилж, гаалийн үзлэгийг хэрхэн хийж буйг ажиглах. Ажиглалтаа баримтжуулаад аудитад шалгуулагч этгээдийн үзлэг хийх горимтой харьцуулах. Энэ нь үзлэгийг тогтоосон горимын дагуу хийж буй эсэхийг, мөн горимын дагуу үзлэг хийхэд шаардагдах нөөцийн түвшнийг тодорхойлоход хэрэгтэй. Түүнчлэн, ажиглалтынхаа явцад аудитад шалгуулагч этгээд үзлэг хийх аргаа илүү үр ашигтай болгох боломж байгаа эсэхэд анхаарч болно.</p>
<p>Тоног төхөөрөмжийн томоохон худалдан авалтын зөвшөөрөл</p>	<p>Хуулийн шаардлагын дагуу зөвшөөрөл олгодог албан тушаалтнуудын гарын үсэг болон итгэмжлэлийг шалгахын тулд холбогдох файлуудад үзлэг хийх. Энэ төрлийн мэдээллийг мөн өргөтгөсөн нягталгааны нэг хэсэг болгон ашиглаж, зөвшөөрөл олгодог албан тушаалтнуудад зориулсан удирдамж, сургалтууд нь тэднийг хуулийн шаардлагуудад нийцүүлэх хэмжээний хангалттай байгаа эсэхийг, эсвэл аудитад шалгуулагч этгээд нь хуулийг мөрдүүлэх хангалттай дотоод хяналттай байгаа эсэхийг тодорхойлж болно.</p>
<p>Хүнсэнд агуулагдах химийн аюул</p>	<p>Мужууд амьтны гаралтай болон бусад импортын хүнсний бүтээгдэхүүнд зохих ёсны биечилсэн шалгалт хийх замаар хүнсний аюулгүй байдлын бодлогыг үр нөлөөтэй дагаж буй эсэхийг, мөн ямар нөөцөөр шалгаж буйг тогтоох зорилгоор хилийн хүнсний шалган нэвтрүүлэх цэгүүдийн хяналтыг ажиглах.</p>

Эх сурвалж: АНУ-ын ТХГ; Европын Аудиторчуудын Шүүхийн Тусгай тайлан №02/2019: Бидний хүнсэнд агуулагдах химийн аюул: ЕХ-ны хүнсний аюулгүй байдлын бодлого биднийг хамгаалдаг ч, сорилтуудтай тулгарч байна, 2019.

Зарим шууд ажиглалт нь энгийн байдаг бөгөөд агуулах эсвэл талбарт зочилж хэдэн гэрэл зураг дарж, дүрс бичлэг хийхэд хангалттай байдаг. Тухайлбал, үерийн үлмаас засгийн газрын өмчийн байгууламжид учирсан хохирлын талаар холбогдох албан тушаалтнаас ярилцлага авч болно. Дараа нь уг албан тушаалтны өгсөн мэдэгдлийг нотлохоор хохирлын гэрэл зургийг дарж болно.

Гэхдээ, аудитын асуултуудад шууд эсвэл хэсэгчлэн хариулахад чиглэсэн шууд ажиглалт болон биечилсэн үзлэгийг системтэйгээр хийх хэрэгтэй. Уг талбарт мэргэшсэн арга зүйч зэрэг оролцогч талтай ярилцаж, эдгээр аргуудыг хэрэгжүүлэх талаар тусламж, чиглүүлэг авч болно.

Ажиглалт болон үзлэгээр цуглуулсан мэдээллийнхээ хамааралтай, хүчин төгөлдөр бөгөөд найдвартай байдлыг хангахын тулд доорх ерөнхий алхмуудыг авч хэрэгжүүлнэ үү:

1. **Юуг ажиглах эсвэл юунд үзлэг хийхээ тодорхойлох.** Ямар талбар, хүмүүс, үйл явдал эсвэл файлыг ажиглах эсвэл үзлэг хийхээ шийдэх. Орчин нь жижиг байвал, бүх эсвэл ихэнх талбар болон үйл явдлуудыг ажиглаж, үзлэг хийж чадна. Гэхдээ, авч үзэх боломжит эх олонлог нь том байвал, талбаруудыг түүвэрлэн сонгох шаардлагатай болно. Энэ тохиолдолд, аль талбар эсвэл үйл явдлыг ажиглаж, үзлэг хийвэл аудитдаа

хамгийн зохистой нотлох зүйл олж болохыг, мөн хэрхэн ажиглалт, үзлэгийн үр дүнг хэрхэн ашиглахыг тодорхойлохын тулд арга зүйчтэй ярилцах хэрэгтэй.

2. **Ямар нөхцөл оршин байх ёстойг тодорхойлох.** Ажиглалт, үзлэгээ эхлүүлэхийн өмнө оршин байх “ёстой” нөхцөл буюу шалгуураа тодорхойлох. Энэ шалгуурын эх сурвалж нь танай аудитын зорилго(ууд) болон асуултуудаас хамаарна. Гэсэн хэдий ч, аудитад шалгуулагчийн гэрээ, бараа материалын бүртгэл эсвэл шаардлагатай горимыг нягтлах замаар тодорхойлж болно. 4-р бүлэгт аудитын шалгуурын талаар дэлгэрэнгүй авч үзсэн болно.
3. **Ямар нотлох зүйлийг хэрхэн цуглуулахаа тодорхойлох.** Та болон танай аудитын баг тодорхойлсон шалгууртаа үндэслэн, ажиглалт болон үзлэг хийх явцдаа хариулах ёстой бүтэцлэгдсэн багц асуултуудыг боловсруулах. Үүнийг өгөгдөл цуглуулах хэрэгсэл гэж үзэж болно. 12-р хавсралтаас өгөгдөл цуглуулах хэрэгслийн жишээг үзнэ үү. Энэхүү багц асуулт нь та болон танай аудитын багт ажиглалт эсвэл үзлэг хийх бүрдээ нэгэн жигд байдлаар хариулж болох хэмжээний энгийн байх ёстой. Таны цуглуулахыг зорьж буй мэдээлэл нь тоон (тухайлбал, зүйлсийн тоо ширхэг) эсвэл чанарын (тухайлбал, үйл явдал эсвэл нөхцөлийн тайлбар) байж болно. Аудитын сэдвийн арвилан хэмнэлт, үр ашигтай байдал болон үр нөлөөтэй байдлыг үнэлэхэд тань туслах нотлох зүйлийг эрэх хэрэгтэй. Тухайлбал, хэрэв та гаалийн үзлэгийг хэрхэн гүйцэтгэж буйг ажиглаж байгаа бол, дан ганц гаалийн үзлэг хийгдэж байгаа эсэхийг тогтоох нь хангалтай биш. Та гаалийн үзлэгийг ямар нөөцөөр (арвилан хэмнэлт), хэр шуурхай (үр ашигтай байдал) бөгөөд бүрэн гүйцэд (үр нөлөөтэй байдал) хийж байгааг үнэлэх шаардлагатай болно. Түүнчлэн, ил эсвэл далд ажиглалт, эсвэл үйл явцыг оролцогчийн хувиар ажиглах ажиглалт зэргээр ажиглалтаа хэрхэн хийх талаарх таны шийдвэр нотлох зүйлсийн чанарт нөлөөлж болно. Тодруулбал, үзлэгийг нь ажиглаж байгаа гэдгийг мэдэж байгаа гаалийн албан тушаалтнууд мэдэхгүй байгаа албан тушаалтнуудаас илүү горимуудаа мөрдөх магадлалтай юм.
4. **Үр дүнгүүдээ баримтжуулах.** Ажиглалт болон үзлэгийнхээ үр дүнгүүдийг нарийн тодорхой, үнэн зөв баримтжуулах. Өөрөөр хэлбэл, үзлэг, ажиглалт хийх явцдаа, боловсруулсан асуултууддаа хариулах замаар юу оршин байгааг тодорхойлж баримтжуулах (УДИР-3920/100). Үзлэг, ажиглалтыг хэзээ, хаана, хэрхэн хийснийг санаж, бодит баримтуудыг шударгаар толилуулсан байдлаар бүртгэх буюу баримтжуулах хэрэгтэй. Тухайлбал, таны ажиглалтын үеэр онцгой үйл явдал өрнөсөн бол, уг үйл явдлын хариуд аудитад шалгуулагч этгээд авсан арга хэмжээ нь түүний ердийн үйл ажиллагааны илэрхийлэл болохгүй. Мөн, та ажигласан зүйлээ хөрвүүлэн ойлгосон байдлаа бус, харин ажигласан зүйлээ бүртгэж баримтжуулах нь чухал. Энэ мэдээллийг хожим шинжилнэ. 13-р хавсралтаас шууд ажиглалт болон биечилсэн үзлэгийг баримтжуулах маягтын жишээг үзнэ үү.

Талбарын ажил хийх нь

Ердийн аудит нь олон төрлийн нотлох зүйл болон мэдээлэл цуглуулах аргуудыг шаарддаг. Аудит хийх үед, цаг хугацаа, ажилтан болон мөнгөний нөөц хүссэн хэмжээнээс бага байх нь бий. Үүний улмаас, мөн АДБ-ын нөөцийг ухаалаг зарцуулах хэрэгцээ шаардлагын улмаас, мэдээллийг хамгийн үр ашигтай байдлаар цуглуулах шаардлага тулгардаг. Энэ шаардлагын дагуу ихэнх аудиторын ашигладаг нэг арга техник бол аливаа нэг газар эсвэл газар зүйн байрлалд зочилж, олон тооны ярилцлага, баримт бичиг цуглуулалт болон шууд ажиглалт эсвэл биечилсэн үзлэгийг хамтатган гүйцэтгэдэг талбарын ажил юм. Гаалийн байцаагчдад зориулсан сургалтын удирдлагатай холбогдох аудитыг дэмжихэд талбарын ажлыг хэрхэн ашиглаж болох тухай нэг жишээг доор өгүүлэв.

Гаалийн байцаагчдад зориулсан сургалтын хангалттай байдлыг үнэлэх талбарын ажлын жишээ. Гаалийн байцаагчдад зориулсан сургалтын удирдлагатай холбогдох тогтолцоонд чиглэсэн аудитын асуултын хувьд, аудитын баг нь сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлж буй хотод олон өдрөөр зочилж, дараах байдлаар мэдээлэл цуглуулах боломжтой:



1-р өдөр

Шинэ байцаагчдад гаалийн үзлэгийн сургалт явуулдаг академид зочилж, сургалтын хөтөлбөрийн удирдагч нар, хөтөлбөрийг боловсруулдаг ажилтнууд болон сургалт явуулдаг багш нараас ярилцлага авах.



2-р өдөр

Академид дахин зочилж, сургалтыг ажиглаж, сургалт болон холбогдох сургалтын хэрэглэгдэхүүнүүдийн гэрэл зураг болон дүрс бичлэгийг авах.



3-р өдөр

Орон нутгийн нисэх буудалд зочилж, гаалийн үзлэг хийж буй байцаагчдыг ажиглаж, байцаагчид болон хянагчдаас ярилцлага авах.

Эх сурвалж: АДБОУБХС/ГАДХ-ны Хөгжлийн Баг.

Талбарын цогц ажлын хуваарь гаргахад аудитад шалгуулагч этгээд буюу талбарын ажлын судлах сэдэв/ зүйл нь ямар зохион байгуулалттай байгааг ойлгож, сайтар төлөвлөж, хуваарь гаргах шаардлагатай. Ингэхдээ илүү их хүчин зүтгэл гаргах тусам тухайн байршилд олон дахин, салангид байдлаар очиж ярилцлага авч, биечилсэн ажиглалт хийснээс хол илүү их нотлох зүйлийг богино хугацаанд цуглуулах боломж олгоно.

Судалгаа (санал асуулга)

Судалгаа бол аудитын баг нотлох зүйлс олж авахдаа ашигладаг мэдээлэл цуглуулах бас нэгэн арга юм. Судалгаа нь оршин буй нөхцөл эсвэл хөтөлбөрийн талаарх мэдээллийг хүн амын тодорхой хэсгээс системтэйгээр цуглуулан авах арга юм. Судалгааг оролцогчоор өөрөөр нь гүйцэтгүүлж (тухайлбал, шуудан, цахим шуудан эсвэл веб судалгаа), эсвэл ярилцагчаар гүйцэтгүүлж (тухайлбал, биечлэн эсвэл утсаар ярилцах судалгаа) болно. Үзүүлсэн төрийн үйлчилгээтэй холбоотой зорилтот хэрэглэгч хүн амын сэтгэл ханамжийн түвшнийг хэмжих зэрэг зорилгоор цогц бүлэг хүмүүс, байгууллага доторх газар, хэлтсүүд эсвэл байгууллагуудаас тодорхой бөгөөд дэлгэрэнгүй мэдээлэл цуглуулах шаардлагатай аудитын тохиолдолд, судалгаа нь хэрэгтэй арга байж чадна.



Хэрэв та олон нийтийн гишүүдийг судлахаар төлөвлөж байгаа бол, уламжлалт хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон сошиал медиа таныг зорилтот хүмүүстээ хүрэх үр нөлөөтэй аргуудаар хангаж чадна. Тухайлбал, АНУ-ын ТХГ-аас саяхан сошиал медиаг ашиглаж, хувьчилсан цэргийн орон сууцанд амьдарч байсан АНУ-ын иргэдийг судалсан байна.

Хэрэв та судалгааны хүн амтайгаа хэвлэл мэдээллийн хэрэгслээр холбогдох бол, хүртээмжтэй буюу таны зорилтот хүмүүсийн дэд бүлгүүдэд бүгдэд нь хүрч чадах аргуудыг ашиглах хэрэгтэй. Ингэснээр та судалгааныхаа үр дүнг санамсаргүй нэг талыг барьсан болгохгүй.

Эх сурвалж: АДБОУБХС/ГАДХ-ны ХБ.

Жишээ нь, Америкийн Нэгдсэн Улсын (АНУ) Засгийн Газрын Эгэх Хариуцлагын Газар (ТХГ) АНУ-ын 50 муж тус бүрээс хэрэгжүүлсэн бага насны хүүхдийн боловсролын хөтөлбөрт нягталгаа хийсэн байна. Уг аудитын баг тогтолцоонд чиглэсэн арга хандлагыг ашиглаж, эдгээр хөтөлбөрүүдийн тоо болон шинж чанар, санхүүжилтийн хэлбэр болон холбооны болон бусад мужийн хөтөлбөртэй хэр хэмжээнд давхцаж байгааг нь тогтоохыг зорьжээ. Нягталгааныхаа хүрээнд хоёр судалгаа хийсэн байна. Судалгаа тус бүрийг харгалзах мужуудынх нь бага насны боловсролын хөтөлбөрийн ажилтнуудад илгээжээ. Эхний судалгаагаар 0-5 насны хүүхдүүдэд бага насны боловсрол болон хүүхдийн халамжийн үйлчилгээ үзүүлсэн мужуудын хөтөлбөрийг судалсан байна. Хоёр дахь судалгааны хувьд, эхний судалгаагаар тодорхойлсон хөтөлбөрүүдийн талаар, шинж чанар болон санхүүжилтийн эх үүсвэр зэрэг илүү их мэдээлэл цуглуулжээ. Тийнхүү аудитын баг мужуудын хөтөлбөрүүд ямар шинжээрээ холбооны болон бусад мужийн хөтөлбөрүүдтэй адил байгааг, мөн санхүүжилтийн олон эх

үүсвэр ашиглахын үр өгөөж болон сорилт бэрхшээлийг тодорхойлохын тулд судалгааны өгөгдлийг шинжилсэн байна. Эдгээр судалгаа болон үр дүнгийнх нь талаарх дэлгэрэнгүй мэдээллийг дараах холбоосоор үзнэ үү: *Хүүхдийн халамж ба бага насны боловсрол: Ихэнх муж сургуулийн өмнөх боловсролын хөтөлбөр хэрэгжүүлж, санхүүжилтийн олон эх үүсвэрт түшиглэж байна (ТХГ-19-375).*

Бодитой, итгэл хүлээхүйц, найдвартай мэдээллийг бий болгох судалгааг зохиомжилж, гүйцэтгэх нь нарийн төвөгтэй бөгөөд их хугацаа зарцуулдаг ажил гэдгийг санах нь чухал. Судалгааг боловсруулж, тестлэхэд асар их хэмжээний бэлтгэл ажил шаардагддаг. Энэ ажил, мөн түүнд зарцуулагдах хугацааг аудитын багууд судалгааны аргыг сонгох үедээ ихэвчлэн дутуу үнэлдэг. Судалгаа эхлүүлэхийн өмнө, судалгаа хийхийн оронд үр нөлөөтэй ашиглаж болох бэлэн байгаа мэдээллийн өөр эх сурвалж байгаа эсэхийг, эсвэл судалгаагаар цуглуулсан мэдүүлгийн мэдээллийг нотлох чадвартай нотлох зүйл болгон ашиглаж болох эсэхийг өөрөөсөө асууна уу.

Судалгааны хүрээнд хийгддэг гол алхмуудын заримыг доор товч цохон тайлбарласан бөгөөд 14-р хавсралтад илүү дэлгэрүүлэн тайлбарласан болно. Хэрэв танай аудитын баг судалгаа хийх талаар бодолцож үзэж байгаа бол, судалгаа зохиомжилж, гүйцэтгэх чиглэлээр мэргэшсэн оролцогч талуудыг чиглүүлэг болон дэмжлэг авах зорилгоор АДБ-ынхаа дотоодоос болон гадаадаас эрэх хэрэгтэй.

1. **Судалгааны эх олонлогийг тодорхойлох.** Судалгаанд хамруулах эх олонлогоо тодорхойлж, эх олонлогийг бүхэлд нь эсвэл түүвэрлэн хамруулах эсэхээ шийдэх хэрэгтэй. Ингэхдээ, таны эрж буй мэдээллийн хамгийн сайн эх сурвалж болж чадах хувь хүмүүс болон байгууллагуудыг судалгаандаа хамруулах хэрэгтэй. Доорх шигтгээнд түүвэрлэлт гэх ухагдахууныг товчхон тайлбарласан бөгөөд түүвэрлэлтийг

сайтар ойлгож, ашиглахын тулд нэмж сурах зүйл маш их бий. Түүвэрлэлт ашиглах талаар бодолцож үзэхдээ экспертийн зөвлөгөө авах болон эрдэм шинжилгээний нийтлэлүүдийг судлах нь зүйтэй.

Түүвэрлэлт

лага (АДБ) бүр гүйцэтгэж буй аудитынхаа хү

Магадлалт түүврийн арга

Магадлалт түүвэр нь санамсаргүй түүврийн аргаар түүвэр үүсгэдэг. Ийм түүвэрт эх олонлогийн гишүүд мэдэгдэж буй, адил сонгогдох магадлалтай байдаг.

Сайн зохиомжилсон магадлалт түүвэрлэлт нь шинжээчдэд нийт олонлогийн талаар мэдэгдэл хийж, тооцооллынхоо үнэн зөв байдлыг хэмжих боломж олгодог.

Магадлалт бус түүврийн арга

Магадлалт бус түүвэр нь харьцангуй энгийн боловч таны дүгнэлт гаргах боломжийг илүү их хязгаарладаг. Ийм түүвэр нь аудиторын дүгнэлт эсвэл тохитой байдлын түүвэрлэлт шиг санамсаргүй эсвэл санамсаргүй биш үйл явцыг ашиглаж болно. Энэ төрлийн түүвэрлэлтийн хувьд, эх олонлогийн туршид үр дүнгээ ерөнхийлөх боломж олгодоггүй боловч, санамсаргүй үйл явц нь аль болох илүү хэрэгтэй байдаг.

Магадлалт бус түүвэр нь танд түүврийн талаар тайлбарласан шинжтэй мэдээлэл хэрэгтэй үед, эсвэл та тархалтын талаар бус хандлага эсвэл алдаа байгаа эсэхийг тогтоохоор оролдож байгаа үед хэрэгтэй байж чадна. Энэ аргыг хувьсагчийн тооцоолол агуулсан илрүүлэлтийг дэмжих цор ганц арга болгон ашиглах нь зохисгүй.

Эх сурвалж: АНУ-ын ТХГ.

- 2. Судалгааг явуулах арга зүйг сонгох.** Биечлэн уулзах, утсаар ярилцах, вебд суурилж явуулах, шуудангаар өгч, авалцах, и-мэйлээр өгч, авалцах, эсвэл биечлэн уулзаж, өөрөөр нь бөглүүлж авах гэх мэт судалгаа явуулах олон арга бий. Зорилтот хүн ам судалгаанд хялбархан хариулж чадахгүй, эсвэл судалгааг төлөвлөсний дагуу явуулахад ажилтны нөөц хүрэлцэх бол таны сонгох арга нь танай судалгааны хариултын хувь хэмжээнд нөлөөлөх болно.

Судалгааны хариултын хувь хэмжээ

Судалгааны хариултын хувь хэмжээ нь судалгаагаар олж авсан мэдээллээ ашиглах байдалд нөлөөлж болно. Тухайлбал, судалгааны хариултыг нийт хүн амд ерөнхийлөн ашиглаж болох уу, эсвэл зөвхөн илүү хязгаарлагдмал хүрээнд ашиглаж болох уу гэдэгт нөлөөлнө.

Тодорхой дэд олонлогоос судалгааны хариулт авч чадахгүй бол таны судалгааны үр дүн нэг талыг барьсан болох магадлалтай.

Газар зүйн ялгаатай байршлууд, оффисууд эсвэл хүн ам зүйн байршлуудын өөр өөр хариултын хувь хэмжээ нь судалгааны үр дүнд алдаа эсвэл нэг талыг барьсан байдал үүсгэж болно гэдгийг санагтун.

Хүлээн зөвшөөрч болох хариултын хувь хэмжээний хамгийн доод босго гэж байхгүй. Судалгааныхаа үр дүнгийн зорилтот ашиглалтад хангалттай хувь хэмжээний хариултыг нийт эх олонлог болон дэд олонлогоос авахын тулд, эсвэл хариулт өгөөгүй тохиолдлуудыг үнэлж, зохицуулалт хийхийн тулд судлах сэдэв/ зүйлийн эксперттэй хамтран ажиллах шаардлагатай болж магадгүй.

Эх сурвалж: АНУ-ын ТХГ.

- 3. Судалгааны хариултуудыг шинжлэх.** Судалгаагаар олж авсан мэдээллээ нотлох зүйл болгон ашиглахын тулд шинжлэх хэрэгтэй. Ямар төрлийн шинжилгээ хийх шаардлагатай вэ гэдэг нь таны асуусан асуултуудын төрөл болон мэдээллээ хэрхэн ашиглахыг хүсэж буйгаас тань хамаарна. Нотлох зүйлсийг шинжлэх боломжит арга техникүүдийг энэ бүлгийн хожуу хэсэгт дэлгэрэнгүй авч үзнэ.
- 4. Судалгааны үр дүнг баримтжуулах.** Судалгааг хэрхэн хийснийг, судалгааны хариултуудыг, мөн судалгааны үр дүнгүүдэд хийсэн аливаа шинжилгээг нарийн тодорхой баримтжуулах хэрэгтэй.

Үр нөлөөтэй судалгаа хийхэд энэхүү гарын авлагад орсноос илүү хэмжээний удирдамж чиглүүлэг шаардлагатай. Судалгаа хийхийн өмнө АДБ-ынхаа дотоод болон гадаад арга зүйн экспертүүдээс дэмжлэг авах хэрэгтэйг санагтун.

Үр нөлөөтэй судалгаа хийх зөвлөмж

- ✓ Тодорхой, товч, оновчтой, төвийг сахисан асуулт бичих.
- ✓ Нэг асуултаар хоёр асуудал хөндөж болохгүй.
- ✓ Хоёрдмол утгатай эсвэл утга балархай асуултаас зайлсхийх.
- ✓ Зөвхөн шинжилгээнд ашиглагдах асуулт асуух.
- ✓ Асуумжийг хялбар асуултаудаар эхлүүлэх.
- ✓ Хэт олон нээлттэй хариулттай асуултаас зайлсхийх.
- ✓ Зорилтот хүн амын гишүүд дээр судалгааны асуултаудыг урьдчилан турших.

Эх сурвалж: АДБОУБХС/ГАДХ-ны Хөгжлийн Баг.

Мэдээлэл цуглуулах бусад боломжит аргууд

Энэ бүлэгт авч үзсэнээс гадна мэдээлэл цуглуулахад ашиглаж болох олон арга бий. Харьцангуй түгээмэл ашиглагддаг аргуудын хоёрыг доор нэмэлтээр оруулав.

Кэйс судалгаа

Кэйс судалгаа бол нэг эсвэл түүнээс олон нарийн төвөгтэй үйл явдал, тохиолдол эсвэл байршлыг гүн гүнзгий, нарийвчлан судлах судалгаа юм. Та энэ арга хандлагыг ашиглан урт хугацаанд үргэлжлэх үйл явцыг, мөн үйл явцууд болон үр дүнгүүд хоорондын хамаарлыг судалж болно. Кэйс судалгааны зорилго нь ихэвчлэн “яагаад” эсвэл “хэрхэн” гэсэн нарийн төвөгтэй асуултуудад хариулахад оршдог. Кэйс судалгаа нь их цаг шаарддаг бөгөөд ихэвчлэн өгөгдөл цуглуулах арга болон мэдээллийн эх сурвалж олныг шаарддаг. Кэйс судалгаа нь нэг эсвэл хязгаарлагдмал үйл явдалд төвлөрдөг учраас олж авсан мэдээлэл нь бүх үйл явдлыг төлөөлөхгүй. Үнэндээ, кэйс судалгааны судлах сэдэв/ зүйл нь ихэвчлэн зорилготойгоор сонгогдсон байдаг. Учир нь кэйс судалгаагаар тухайлсан буюу өвөрмөц харах өнцгийг гаргаж ирдэг. Ийм тохиолдолд, олон талт харах өнцгийг бий болгож, ялгаатай байдлыг бодитой хандлагаар тайлбарлах судлах сэдэв/ зүйлийг хамруулснаар нэг талыг барьсан хандлагаас зайлсхийж болно. Кэйс судалгаагаар олж авсан мэдээлэл нь өгөгдөл цуглуулах бусад аргуудтай сайн хосолж, тэднийг баяжуулж байдаг.

Фокус бүлгүүд

Фокус бүлэг гэдэг нь аудитын сэдэвтэй холбогдох ухагдахуунуудыг судлах эсвэл оролцогчдын туршлагын талаарх мэдээллийг (тухайлбал, гаалийн байцаагчдын сургалтын чанарыг харах өнцөг) олж авах зорилгоор хэсэг бүлэг оролцогчдыг хамруулж хийдэг чиглүүлэгчтэй ярилцлага юм. Фокус бүлэг нь оролцогчид хоорондын харилцааг мөн ажиглаж, судалдаг тул бүлгийн ярилцлагаас ялгаатай. Өгөгдөл цуглуулах олон аргын нэгэн адил, фокус бүлэгт оролцуулахаар сонгосон хувь хүмүүс нь таны олж авах мэдээллийн тохиромжтой байдалд нөлөөлж болох тул ярилцлагын үр дүнг нэг талыг барьсан болгохоос сэргийлж, оролцогчдоо болгоомжтой сонгох хэрэгтэй.



Фокус бүлгийн зорилго нь оролцогчдын дунд идэвхтэй хэлэлцүүлэг өрнүүлэхэд оршдог. Үүнийг дэмжихийн тулд дараахыг хийнэ үү:

- Бүлгийг жижиг байлгах. 8-10 орчим оролцогчтой байлгах;
- Оролцогчдын нэрийг нууцлах; мөн
- Нэг төрлийн бүлэг үүсгэх. Тэгснээр оролцогчид харах өнцгөө шулуун шударга, чөлөөтэй илэрхийлнэ (жишээ нь, менежерүүдийг менежерүүдтэй, ажилтнуудыг ажилтнуудтай хамт бүлэг болгох).

Эх сурвалж: АДБОУБХС/ГАДХ-ны ХБ.

Мэдээлэл цуглуулахдаа санах ёстой чухал хүчин зүйлс

- ✓ Аудитын ихэнх сэдвийн хувьд, таны цуглуулж, шинжилж чадах хэмжээнээс хол илүү хэмжээний мэдээлэл оршин байдаг. Аудитын үргэлжлэх хугацаанд цуглуулж болох шаардлагатай мэдээллийн талаар хэрэгжих боломжтой хүлээлт тавих нь чухал.
- ✓ Өгөгдөл цуглуулах үед, янз бүрийн эх сурвалжаас авсан мэдээлэл хооронд логик зөрчилдөөн болон зөрүүтэй байдал илэрч болно. Та илрүүлэлтээ боловсруулахад ашиглах нотлох зүйлсээ хамааралтай, хүчин төгөлдөр бөгөөд найдвартай байлгахын тулд уг логик зөрчилдөөнийг шийдвэрлэх ёстой.
- ✓ Мэргэжлийн үнэлэмж болон үл итгэх үзлийг хэрэгжүүлж, асуудлыг олон өнцгөөс авч үзэх нь таны үүрэг гэдгийг санагтун. Ингэхийн тулд та ялгаатай үзлүүд болон аргуудад нээлттэй бөгөөд бодитой хандлагаар хандах шаардлагатай.

Эх сурвалж: АДБОУБХС/ГАДХ-ны Хөгжлийн Баг.

Мэдээллийг хэрхэн шинжлэх вэ?



Стандарт

Аудитор цуглуулсан мэдээлэлдээ дүн шинжилгээ хийх ёстой ба аудитын тогтоосон зүйлсэд бодитой хандаж, аудитын зорилго болон аудитын асуултад хариулж, төлөв хандлагыг тодорхойлж байгааг нягтлах ёстой. Шаардлагатай гэж үзвэл аудитын зорилго болон аудитын асуулыг шинэчлэн боловсруулна.

Эх сурвалж: АДБОУС-3000/112.

Юу олсноо ойлгож, тайлбарлаж, эцэстээ нотлох зүйлс үүсгэхийн тулд цуглуулсан мэдээллээ шинжлэх шаардлагатай болно. Шинжилгээний зорилго нь цуглуулсан мэдээллээ ашиглаж, арвилан хэмнэлт, үр ашигтай байдал болон/эсвэл үр нөлөөтэй байдлыг үнэлж, аудитын асуултуудад хариулахад оршдог. Аудитын асуултуудад төвлөрөх нь танд мэдээллээ зохион байгуулж, шинжилгээгээрээ хэрэгтэй хариултуудаа олж авахад туслах болно.

Энэ бүлгийн эхэнд авч үзсэнчлэн, мэдээлэл цуглуулж, шинжлэх ажлыг ихэвчлэн аудитын явцад зэрэгцүүлэн хийдэг. Аудитын түршид мэдээллээ тасралтгүй шинжлэх нь танд аудитын асуултууддаа хариулах зөв мэдээллийг хангалттай хэмжээнд цуглуулж буй эсэхээ мэдэхэд туслах болно. Энэ нь таны хариуцлагын нэг хэсэг бөгөөд танд аудитын эрсдэлийг идэвхтэй удирдаж, буруу эсвэл бүрэн бус аудитын илрүүлэлт, дүгнэлт, зөвлөмжүүд бий болгох, эсвэл тэнцвэргүй мэдээлэл үүсгэхээс зайлсхийх боломж олгоно.

Цуглуулсан мэдээллээ шинжлэхэд ашиглаж болох олон төрлийн шинжилгээний арга бий. Таны сонгох арга нь таны аудитын асуултууд болон цуглуулсан мэдээллийн мөн чанараас хамаарна (УДИР-3920/86). Өгөгдөл, мэдээлэл шинжлэх чанарын болон тоон аргуудын түгээмлээс нь доор товч авч үзлээ.

Мэдээлэл шинжлэх гол чанарын аргууд юу вэ?

Чанарын шинжилгээ хийхэд нотлох зүйлстэй холбогдох логик учир зүй болон аргументыг дэмжих мэдээллийг бүтэцжүүлэх, харьцуулах, эмхэтгэх болон тайлбарлах олон төрлийн аргыг ашигладаг. Чанарын шинжилгээг ихэвчлэн ярилцлага, баримт бичиг болон судалгаанаас олж авсан нотлох зүйлс дээр хийдэг.

Тодруулбал, та аудитынхаа түршид аудитынхаа асуултуудад хариулахад тань туслах нотлох зүйлсийг илрүүлсэн олон ярилцлага хийж, олон баримт бичиг цуглуулсан байх болно. Таны аудитын асуултууд нь гол нотлох зүйлсийг илрүүлэхийн тулд таны цуглуулсан чанарын мэдээллүүдэд хийх шинжилгээний үндсэн бүтцийг гаргаж өгч болно. Үүнээс цааш, энгийн аргаас авхуулаад төлөвлөлт шаардсан нарийн төвөгтэй аргууд хүртэлх олон өөр төрлийн чанарын арга хандлагуудыг та ашиглан баримт бичгүүдийг шинжилж болно. 29-р зурагт ярилцлага болон баримт бичгүүдээс авсан мэдээллийг шинжлэхэд ашиглаж болох чанарын шинжилгээний түгээмэл аргуудын зарим жишээг орууллаа.

Зураг 29: Түгээмэл төрлийн чанарын шинжилгээний жишээ

Шууд	Энэ төрлийн шинжилгээ хийхэд аудитад шалгуулагч этгээдийн албан ёсны төлөвлөгөө болон арга хэмжээнүүд, аудитлагдаж буй сэдвийн гүйцэтгэлтэй холбогдох мэдээлэл зэрэг мэдээллийг баримт бичгүүд эсвэл ярилцлагуудаас шууд авдаг. Энэ нь хамгийн энгийн төрлийн чанарын шинжилгээ бөгөөд та шууд авсан мэдээллээ олж авсан бусад нотлох зүйлсээрээ дэмжих нь чухал.
Гарчигт төвлөрсөн	Энэ төрлийн шинжилгээ хийхэд аудитын янз бүрийн асуултуудтайгаа холбогдох гарчигт төвлөрсөн мэдээллийг фокусаа болгож, баримт бичгүүд болон ярилцлагуудыг нягталдаг. Энэ үед нийтлэг сэдэв, ижил төстэй эсвэл ялгаатай байдлыг эрэх нь аудитын илрүүлэлтүүдийг боловсруулахад хэрэгтэй байдаг.
Цаг хугацааны	Энэ төрлийн шинжилгээ хийхэд олон дараалсан үйл явдлуудын өрнөсөн дэс дарааллыг тогтоох, эсвэл үйл явцын алхмуудыг тодорхойлох зорилгоор баримт бичгүүд болон ярилцлагуудыг нягталдаг.
Сэдэвчилсэн	Энэ төрлийн шинжилгээ хийхэд баримт бичгүүд болон ярилцлагуудад тодорхой илэрхийлэмж буюу сэдэв хөндөгдсөн давтамжийг тоолж тодорхойлдог. Тухайлбал, удирдлагуудын хурлын тоймд ажилтнуудын хөгжих боломжийг нэмэгдүүлэх тухай хэлэлцүүлэг хэр их орсон байгааг судална. Энэ төрлийн шинжилгээ нь танаас шинжилгээгээ эхлүүлэхийн өмнө, юуг, хэрхэн тоолохоо сайтар тодорхойлох зэргээр тодорхой арга зүй боловсруулсан байхыг шаарддаг.
Агуулгын	Энэ төрлийн шинжилгээ хийхэд тоон мэдээлэл гаргаж авах зорилгоор чанарын нарийн төвөгтэй өгөгдлийг бүтэцжүүлж, шинжилдэг. Энэ нь хамгийн нарийн төвөгтэй төрлийн чанарын шинжилгээ бөгөөд танаас шинжилгээгээ эхлүүлэхийн өмнө тодорхой арга зүй боловсруулсан байхыг шаарддаг. Энэ төрлийн шинжилгээг хэрхэн үр нөлөөтэй гүйцэтгэх талаар дэлгэрэнгүй мэдээллийг доороос үзнэ үү.

Эх сурвалж: АНУ-ын ТХГ.

Баримт бичгийг шинжлэх нь

Цуглуулсан баримт бичгүүдээ шинжлэх үед, таны ашиглах чанарын арга(ууд) болон шаардагдах шинжилгээний нарийн төвөгтэй байдал нь таны аудитын зорилго(ууд), асуултууд болон баримт бичгүүдийн төрөл эсвэл танд буй мэдээллийн бусад эх сурвалжаас хамаарна. Тухайлбал, аудитын асуултууд нь аудитад шалгуулагч этгээд агентлагийнхаа удирдамжаар тогтоосон гаалийн үзлэгийн шаардлагуудтай холбогдож байгаа тохиолдолд, аудитад шалгуулагч этгээдэд ганцхан холбогдох удирдамж баримт бичиг байна. Та уг ганц баримт бичгээс шууд мэдээлэл авч болно. Энэ аргыг шууд шинжилгээ гэдэг. Гэхдээ, аудитад шалгуулагчийн гаалийн үзлэгийн шаардлагуудыг 10 өөр удирдамж баримт бичигт оруулсан байвал, таны шинжилгээ тэдгээр бүх баримт бичигт орсон удирдамжийг системтэйгээр хамруулж, илүү нарийн төвөгтэй болох шаардлагатай болно. Дээр 29-р зурагт авч үзсэн агуулгын шинжилгээ гэх мэт чанарын шинжилгээний илүү нарийн төвөгтэй аргуудыг үр нөлөөтэй хэрэгжүүлэхэд ихэвчлэн сайн төлөвлөлт хийгээд тодорхой арга зүй шаардагддаг. Агуулгын шинжилгээний талаар нэмэлт мэдээлэл болон жишээг 15-р хавсралтаас үзнэ үү.

Ярилцлагыг шинжлэх нь

Таны хийсэн ярилцлагууд нь мөн нотлох зүйлсийн тань багагүй хэсгийг бүрдүүлдэг. Иймд, нийтлэг мэдээлэл эсвэл сэдэв, авцалдаатай мэдээлэл, эсвэл нэгэн ижил суурь асуудал эсвэл ухагдахууны жишээг илрүүлэх зорилгоор ярилцлагуудаа шинжлэх арга хандлагыг сонгох шаардлагатай болно. Тухайлбал, таны аудитын асуултуудын нэг нь гаалийн байцаагч нарт зориулсан сургалтын үр нөлөөтэй байдалтай холбогдож байвал, ярилцлагын бүртгэл бүрээ нягтлах замаар гарчигт төвлөрсөн шинжилгээ хийж, сургалтын үр нөлөөтэй байдалтай холбогдох бүх мэдээллийг гарган авч шинжилж болно. Доорх шигтгээнд аудитын асуултууддаа үндэслэсэн ийм гарчигт төвлөрсөн шинжилгээг хэрхэн хийх талаар хэдэн энгийн алхмыг тайлбарлав.

Аудитын асуултуудад үндэслэн ярилцлагыг хэрхэн шинжлэх вэ?

1. Ярилцлагын мэдээллийг бүтэцжүүлэх аргыг сонгоно. Ингэхдээ аудитын асуултуудыг нэгдүгээр сонголт болгож ашиглана. Хэрэв зөвхөн аудитын асуултуудын дагуу мэдээллийг бүтэцжүүлэх боломжгүй болдэд асуултууд, оролцогчид, бүс нутгууд зэргийг дараагийн сонголт болгож ашиглана.
2. Ярилцлагын тэмдэглэлүүдийг дахин уншаад бүтцэдээ төвлөрнө. Хэрэв ярилцлагуудыг аудитын асуултын дагуу зохион байгуулахаар бол, тэмдэглэлд орсон мэдээлүүд аудитын хэддүгээр асуулттай холбогдож байгааг захад нь тэмдэглэнэ.
3. Аудитын 1-р асуулттай холбогдох бүх тэмдэглэлийг уншина. Хамаарал бүхий олон тэмдэглэл байвал хураангуйлан бичнэ. Шаардлагатай бол, тэмдэглэлүүдийг бүтэцжүүлэх шинэ хүчин зүйл сонгоно. Гол тоглогчдыг бүтэц үүсгэх хүчин зүйл болгон ашиглаж болно.
4. Нэг нэгээр нь, гол тоглогчдын төрөл тус бүрийн хариултуудыг эмхэтгэж, шинжилнэ.
5. Бүх төрлийн гол тоглогчдын хариултуудыг нэгэн зэрэг эмхэтгэж, шинжилнэ.
6. Гол тоглогчдын ялгаатай ангилуудын хариултуудын ижил төстэй талууд болон ялгаатай талуудыг судална.
7. Мэдээллийг хураангуйлж, ярилцлагууд нь аудитын асуултуудад хариулах болон зөвлөмжүүдийг боловсруулахад хэрхэн хувь нэмэр оруулж болохыг үнэлнэ.
8. Аудитын дараагийн асуултаар шинжилгээгээ үргэлжлүүлнэ.

Эх сурвалж: АХАДБАБ-ын Гүйцэтгэлийн Аудитын Гарын Авлага, 2016.

Ярилцлагуудыг шинжлэхдээ илрүүлсэн зүйлсээ баримтжуулах нь чухал. Үүнд ашиглагддаг нэг нийтлэг арга хандлага бол ярилцлагуудаас аудитын асуулт эсвэл хүчин зүйл тус бүртэй холбогдох мэдээллийг авч хураангуйлан эмхэтгэсэн баримт бичиг боловсруулах арга хандлага юм. 16-р хавсралтаас хураангуй баримт бичиг боловсруулах маягтын жишээг үзнэ үү. Энгийнээр тайлбарлавал, энэ нь ойлгож, үнэлэхэд хялбар байдлаар ижил төстэй нотлох зүйлсийг бүлэглэж, шошголох ажил юм. Бүх мэдээллийг нэг газарт зохион байгуулж, баримтжуулах нь сэдэвтэй холбогдох нотлох зүйлсийг бүхэлд нь ойлгоход тусалдаг. Хураангуй баримт бичиг боловсруулах тохиолдолд, анхны ярилцлагын баримт бичгийг үзэх холбоос гэх мэт нотлох зүйл тус бүрийн эх сурвалжийн мэдээллийг оруулж, нотлох зүйлийн эх сурвалжийг тодорхой болгох хэрэгтэй. Танай АДБ энэ төрлийн өгөгдлийн шинжилгээнд ашиглаж болох программ хангамжтай байж магадгүй. Энэ талаар доор дэлгэрэнгүй авч үзнэ.

Танд олон өөр эх сурвалжийн өгөгдлийг эмхэтгэж, аудитад шалгуулагч этгээд болон гуравдагч талын олон өөр түвшний олон өөр ажилтны мэдлэг, үзэл бодлыг сонсох өвөрмөц боломж бий. Өмнө онцолсончлон, ярилцлагуудыг шинжлэхдээ, таны ярилцлага авч буй хүмүүс аливаа асуудлууд дээр өөр өөр харах өнцөгтэй байж болох бөгөөд баримт факт эсвэл асуудлын шалтгааны зөвхөн нэг талыг нь мэдэж байх магадлалтай гэдгийг санагтун. Ярилцлагын үеэр танд ирсэн бүх мэдээллийг үнэлж, аудитад шалгуулагч этгээдийн гүйцэтгэлийн талаар илүү бодитой бөгөөд цогц зураглалыг үүсгэх нь аудитор таны ажил юм.

Өгөгдөл шинжлэх гол тоон аргууд юу вэ?

Тоон шинжилгээний аргууд нь энгийнээс (тухайлбал, дунджийг тооцоолох) нарийн төвөгтэй (тухайлбал, статистик загварчлал) аргууд хүртэл олон төрөл бий. Гүйцэтгэлийн аудитын хувьд, тоон шинжилгээ танд өгөгдлийнхөө чухал нийтлэг хэв шинж болон хамаарлыг илрүүлж, анхаарал эсвэл сайжруулалт шаардлагатай талбаруудыг илрүүлэхэд тусалж чадна. Энэ хэсэгт гүйцэтгэлийн аудит хийхдээ харгалзан үзвэл зохих тоон шинжилгээний төрлүүдийг товч тайлбарлана.

Статистик шинжилгээ

Статистик шинжилгээ бол өгөгдөл дэх нийтлэг хэв шинж болон чиг хандлагыг илрүүлэх шинжлэх ухаан юм. Статистик шинжилгээ нь энгийн дүрслэх статистикаас авхуулаад регрессийн шинжилгээ шиг (доороос үзнэ үү) боловсронгуй арга техник болон программ хангамж шаарддаг нарийн төвөгтэй шинжилгээ хүртэл олон төрөл бий.

Дүрслэх статистик (descriptive statistics)

Гүйцэтгэлийн аудитад ихэвчлэн дүрслэх статистикийг ашиглаж цуглуулсан өгөгдлөө утга учиртай байдлаар ойлгож, хураангуйлж, тархалтыг нь тайлбарладаг. Тухайлбал, аудитад шалгуулагч этгээдийн гүйцэтгэлийн зорилтууддаа хүрсэн байдлыг талбараар нь эсвэл хүн амын орлогын хуваарилалтаар нь шинжилдэг. 30-р зурагт дүрслэх статистикийн үндсэн ухагдахуунуудын заримыг нь танилцуулж, хэзээ ашиглах хэрэгтэйг нь тайлбарлалаа.

Зураг 30: Дүрслэх статистикийн үндсэн ухагдахуунууд

Ухагдахуун	Тодорхойлолт	Хэзээ ашиглах вэ
Дундаж	Утгуудын нийлбэрийг тоо ширхэгт нь хуваасан үзүүлэлт.	Өгөгдлийн цэгүүд тэгш хэмтэй тархсан үед хэрэгтэй. Өгөгдлийн цэгүүдэд хэт алслагдсан утгууд буюу бусад өгөгдөлтэй харьцуулахад хэт ялгаатай утга байгаа бол болгоомжтой ашиглана уу.
Медиан (голч)	Утгуудыг хэмжээгээр нь эрэмбэлэн жагсаахад тэг дунд нь байх утга. 50-р процентиль.	Хэт өндөр оноо буюу алслагдсан утга нь дундаж утгад ихээхэн нөлөөлж байгаа үед хэрэгтэй.
Моод	Багц утгууд дахь хамгийн их давтагдаж буй утга.	Хамгийн түгээмэл ангилал, хамгийн нийтлэг сонголт эсвэл хамгийн ердийн утгыг эрж байгаа үед хэрэгтэй.
Завсар (муж/ далайц)	Хамгийн их болон хамгийн бага ажиглалт хоорондын зөрүү.	Дундаж болон голч утгын тооцооллыг дэмжиж, өгөгдлийн цэгүүд хэрхэн тархсаныг хэлэлцэхэд хэрэгтэй.
Варианц	Эх олонлогийн элементүүд бие биеэсээ алслагдсан хэмжээг илэрхийлсэн тоо. Ганц ажиглалт болон дундаж утга хоорондын зайг квадрат зэрэгт дэвшүүлсний дундаж утга.	Онооны тархалт хэр байгааг хэмжих хэмжилт болж, дундаж утгын тооцооллыг дэмждэг.
Стандарт хазайлт	Өгөгдлийн тархалтын хэмжүүр. Вариацийн квадрат язгуур.	Өгөгдлийн цэгүүд хэрхэн тархсаныг хэмжих хэмжилт болж, дундаж утгын тооцооллыг дэмждэг. Өгөгдөлд хэт алслагдсан утгууд байгаа үед болгоомжтой ашиглана уу.
Хувь	Хэсэг буюу хувийн бүхэлтэй харьцангуй хэмжээ бөгөөд зуу хуваасантай харьцуулсан нэгжээр илэрхийлнэ.	Эх олонлогийн аливаа хэсгийн хэмжээг бүхэлтэй харьцангуй байдлаар ойлгоход хэрэгтэй. Тухайлбал, судалгааны нийт хариултын тоотой харьцангуй "тийм" гэсэн хариултын тоо.
Индекс	Бие даасан өгөгдлийн цэгүүдийг төлөөлөх бүлэг дэх өөрчлөлтийн хэмжүүр. Олон индикаторыг нэгтгэдэг нийлмэл хэмжүүр.	Хувьсагчуудын хөгжлийг олон жилээр харьцуулахад хэрэгтэй. Эсвэл инфляцын индекс шиг, ялгаатай жилүүдийг харьцуулахад хэрэгтэй.

Эх сурвалж: АХАДБАБ-ын Гүйцэтгэлийн Аудитын Гарын Авлага, 2016:119-ийг эш болгов.

Өгөгдлийн багцад алслагдсан утгууд байгаа бол дундаж гэх мэт ганц үзүүлэлт нь төөрөгдүүлсэн үр дүнд хүргэх тул, өгөгдлийн багцынхаа бүрэн зураглалыг бий болгохын тулд дүрслэх статистикийн олон үзүүлэлтийг хамтатган ашиглах шаардлагатай болж болно. 31-р зурагт үйлдвэрийн ажилчдын орлогыг тайлбарлахад дүрслэх статистикийн эдгээр үзүүлэлтүүдийн заримыг нь хэрхэн ашиглаж болохыг харууллаа.

Зураг 31: Үйлдвэрийн ажилчдын орлого

Ажилчин	1	2	3	4	5	6	7	8	9	10	11
Цалин	\$12k	\$14k	\$15k	\$15k	\$15k	\$16k	\$18k	\$20k	\$22k	\$70k	\$95k

Дундаж: 28 мян.ам.д

Медиан: 16 мян.ам.д

Мод: 15 мян.ам.д

Жич: мян.ам.д = мянган америк доллар; k = мянга

Эх сурвалж: АДБОУБХС/ГАДХ-ны Хөгжлийн Баг.

Та энэ үйлдвэрийн ердийн цалингийн талаар тайлан бичих шаардлагатай болсон бол, зөвхөн дундаж утгыг ашиглах нь хэлбийсэн дүгнэлтэд хүргэнэ. Учир нь хоёр ажилчин маш өндөр цалинтай байна. Энэ тохиолдолд, голч утга болон моод утга нь энэ үйлдвэрийн ажилчдын ердийн цалингийн илүү сайн хэмжүүр болж чадна. Энэ өгөгдлийн багцыг тайлбарлахад тодорхой утгаас бага хэмжээний цалин авдаг ажилчдын хувь хэмжээг тодорхойлох нь мөн хэрэгтэй байж болно. Тухайлбал, ажилчдын бараг 82% нь 25 мянган ам.доллараас бага цалин авч байна.

Варианц болон стандарт хазайлт зэрэг зарим ухагдахууныг тооцоолж, хөрвүүлэн ойлгоход заримдаа хэцүү байдаг. Энэ тооцоололд хүснэгтэлсэн өгөгдөл боловсруулдаг программ хангамж тусалж чадна. Эдгээр ухагдахууныг гүйцэтгэлийн аудитад ашигласан туршлага танд байхгүй байж болох ч, энэ төрлийн шинжилгээ нь танд аудитын асуултууддаа хариулахад тусалж чадна гэж бодож байвал судлах сэдэв/ зүйлээр мэргэшсэн хэн нэгэн дотоод оролцогч талтай зөвлөлдөх нь зүйтэй.

Регрессийн шинжилгээ

Регрессийн шинжилгээ бол хувьсагчуудын өөр хоорондоо холбогдсон (тухайлбал, харилцан хамааралтай) байгаа хэр хэмжээг үнэлэх статистик арга техник юм.

Та дараах зүйлсийг хийх гэж оролдож байгаа бол регрессийн шинжилгээ нь гүйцэтгэлийн аудитад хэрэгтэй байж чадна:

- Үнэн гэдэг нь батлагдах учиртай хамаарлыг тестлэх;
- Үр дүнг тайлбарлахад тусалж чадах, хувьсагчуудын хооронд байж болох учир шалтгаан-үр нөлөөний хамаарал;
- Хүлээгдэж буй утгуудын дунд сондгойрч байгаа ердийн бус тохиолдлыг тодорхойлох; эсвэл
- Утгуудын талаар таамаглал дэвшүүлэх.

Тухайлбал, АНУ-ын ТХГ-аас 2018 онд АНУ-ын ахлах сургуулиуд дээрх их сургуульд бэлтгэх сургалтад нөлөөлсөн хүчин зүйлсийг судалсан аудит гүйцэтгэжээ. Аудитын баг сургалт болон бусад үр дүнд ядуурал олон замаар сөргөөр нөлөөлж болно гэсэн урьдач нөхцөл бүхий асуудалд чиглэсэн арга хандлагыг ашигласан байна. Аудитын баг ядуурлын түвшнээрээ ялгаатай газруудын ахлах сургуулийн сурагчид коллежид бэлдэх хичээлд хэр хамрагдаж буйг судалжээ. Ингэхийн тулд ТХГ-аас их сургуульд бэлдэх хичээл болон

сургуулийн шинж чанар (сурагчдын ядуурлын түвшин, сургуулийн хэмжээ, хүн амын нягтаршил (хот, хөдөө), сурагчдын яс үндэсний холимог байдал гэх мэт) хоорондын хамаарлыг тестлэх регрессийн загвар боловсруулжээ. ТХГ-ын регрессийн шинжилгээгээр сурагчдын дунд ядуурлын түвшин өндөр ахлах сургуулиуд дөрвөн жилийн сургалттай ихэнх улсын их сургуулиудаас сурагчдыг ахлах сургуульдаа хамрагдсан байхыг шаарддаг математик болон шинжлэх ухааны хичээлүүдийг бага заадаг нь тогтоогджээ. Энэ жишээ болон аудитын багийн ашигласан арга зүйн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг дараах холбоосоор үзнэ үү: [K-12 БОЛОВСРОЛ: Ядуу сурагч олонтой улсын ахлах сургуулиуд болон жижиг сургуулиуд коллежид бэлдэх хичээлүүдийг бага зааж байна \(ТХГ\)](#).

17-р хавсралтад регрессийн шинжилгээг ашиглах боломжийг харуулсан маш энгийн жишээг орууллаа. Загварчлалын бусад бүх төрлийн нэгэн адил, регрессийн шинжилгээ нь нарийн төвөгтэй байж болох бөгөөд зарим өгөгдлийн багц эсвэл олон хувьсагчтай нарийн төвөгтэй шинжилгээний хувьд тусгай программ хангамж шаардаж магадгүй. Хэрэв та энэ төрлийн шинжилгээ хийх туршлагагүй бол, сургалтад суух, эрдэм шинжилгээний материал унших, эсвэл арга зүйч, судлах сэдэв/ зүйлийн эксперт зэрэг хүмүүсээс чиглүүлэг авах нь регрессийн шинжилгээ хийж, үр дүнг нь зөв хөрвүүлэн тайлбарлахад туслах болно.

Чиг хандлагын шинжилгээ

Тоон өгөгдлийнхөө нийтлэг хэв шинж эсвэл өөрчлөлтийг судалж байгаа тохиолдолд чиг хандлагын шинжилгээ тустай байдаг. Хамгийн энгийн утгаараа, чиг хандлагын шинжилгээ бол цаг хугацааны олон мөчлөгөөс өгөгдөл цуглуулж, өөрчлөлтийг нь харахын тулд графикаар дүрсэлж, өөрчлөлтөд нь нөлөөлсөн хүчин зүйлсийг тодорхойлох ажил юм.

Гүйцэтгэлийн аудитын хувьд, төсөв, өртөг болон хөтөлбөрийн гүйцэтгэл дэх өөрчлөлтийг харахын тулд чиг хандлагын шинжилгээг үе үе ашигладаг. Энэ шинжилгээ нь мөн шинэ хууль, хөтөлбөр эсвэл нөөц зэрэг орчинд гарсан өөрчлөлт нь аливаа нэг хувьсагчид ямар үр нөлөө үзүүлж буйг судлахад тусалж болно.

Тухайлбал, нэг АДБ ялгаатай бүс нутгуудын замын ослын тоог судалж байв. Замын осол гэх урьдчилсан асуудал нь мэдэгдэж байгаа боловч түүний шалтгаан болон бууруулах арга нь мэдэгдэхгүй байгаа үед энэ шалгалтыг асуудалд чиглэсэн арга хандлагаар хийжээ. Судалгааны нэг бүс нутаг (Б бүс нутаг) эрсдэлд суурилсан замын хөдөлгөөний үзлэг хийх хөтөлбөр хэрэгжүүлсэн байхад, А бүс нутагт тийм хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна. 32-р зурагт үзүүлсэнчлэн, аудиторүүд 2007 онд хэрэгжиж эхэлсэн уг хөтөлбөрийн өмнөх болон дараах замын ослын тоог шинжилсэн байна.

Зураг 32: Өөр өөр төрлийн үзлэг хийдэг бүс нутгуудын замын осол



Эх сурвалж: АДБОУБХС/ГАДХ-ны Хөгжлийн Баг.

Энэ шинжилгээнээс харагдаж байгаачлан, үзлэгийн хөтөлбөрийг хэрэгжүүлсний дараахнаас Б бүс нутгийн замын ослын тоо өөрчлөгдөж эхэлжээ. Хэдэн жилийн дараагаас Б бүс нутаг дахь ослын тоо бүр буурч эхэлсэн байна. Эрсдэлд суурилсан үзлэгийн хөтөлбөр хэрэгжүүлээгүй боловч, А бүс нутаг дахь ослын өсөлт удааширсан байна.

Хэдий сонирхолтой чиг хандлагыг харуулсан ч, энэ өгөгдлийн шинжилгээ дангаараа бүтэн “түүх”-ийг өгүүлж чадахгүй. Аудиторууд чиг хандлагын шинжилгээг бүрэн болгохын тулд А болон Б бүс нутгийн замын ослын ялгаатай байдал болон Б бүс нутагт замын ослын тоо буурсныг тайлбарлаж чадах өөр бусад хүчин зүйлс байгаа эсэхийг тодорхойлохын тулд нэмэлт судалгаа, шинжилгээ хийх шаардлагатай болсон юм. Тухайлбал, тэд судалгааныхаа явцад Б бүс нутагт үзлэгийн хөтөлбөр хэрэгжиж эхлэхтэй бараг зэрэгцээд үндэсний хэмжээний замын аюулгүй байдлын аян эхэлснийг олж мэджээ. Иймд, энэ аян нь аудитын баг үзлэгийн хөтөлбөрөөс замын осолд үзүүлсэн үр нөлөөг тодорхойлохдоо харгалзаж үзэх ёстой хувь нэмэр оруулагч хүчин зүйл болсон байна. Энэ нь мөн, аудитын баг чиг хандлагын шинжилгээг ашиглаж, хэрхэн хүссэн үр дүнд хүрэхийн тулд ямар орц шаардлагатайг тодорхойлох буюу үр ашигтай байдал болон үр нөлөөтэй байдалд төвлөрдгийг харуулсан сайн жишээ болсон юм.

Энэ жишээгээр харуулсанчлан, «“А” зүйл хэрхэн өөрчлөгдсөн бэ?»-г тодорхойлох нь ихэнхдээ «“А” зүйл яагаад өөрчлөгдсөн бэ?»-г илүү сайн судалж, тодорхойлоход зориулсан чиг хандлагын шинжилгээний зөвхөн эхлэлийн цэг болдог. Ийм учраас, чиг хандлагын шинжилгээнд үндэслэн аливаа илрүүлэлтүүд болон дүгнэлтүүдийг боловсруулахдаа өгөгдөлд ажиглагдсан чиг хандлагад хувь нэмэр оруулсан байж болох өөр олон хүчин зүйлсийг харгалзаж үзэх хэрэгтэй.

Энэ бүлэг болон бусад бүлэгт авч үзсэн өгөгдөл цуглуулж, шинжлэх аргуудын талаар илүү дэлгэрэнгүй мэдэхийг хүсвэл эрдэм шинжилгээний эсвэл үнэлгээний баримт бичгүүдийг судалж, нягталж болно.

Өгөгдлийн шинжилгээнд программ хангамж ашиглах нь

Өгөгдлийн чанарын болон тоон шинжилгээ хийхэд тань тусалж чадах асар олон төрлийн арилжааны программ хангамж бий. Тэдгээр нь түгээмэл ашиглагддаг үг боловсруулах эсвэл хүснэгтэлсэн өгөгдөл боловсруулах программуудаас авхуулаад илүү үнэтэй, нарийн төвөгтэй системүүд хүртэл олон төрөл бий. Тухайлбал, та агуулгын шинжилгээ хийх зэргээр ихээхэн хэмжээний чанарын өгөгдлийг удирдаж, зохион байгуулж, шинжлэхдээ программ хангамж ашиглаж болно. Түүнчлэн, томоохон хэмжээний тоон өгөгдлийн багцын шинжилгээ, ахисан шатны статистик болон загварчлалыг дэмждэг олон төрлийн программ хангамж бий.

Эдгээр боловсронгуй хэрэгслүүдийг ашигласнаар аудитын үйл ажиллагаагаа сайжруулж, гар аргаар удирдаж, боловсруулдгаасаа бүр том хэмжээний өгөгдлийн багцыг шинжилж чадна. Ийм программ хангамжуудыг ашиглах үед өгөгдлийн чанар нь асар чухал анхаарах зүйл болдог гэдгийг санагтун. Сүүр өгөгдөл нь найдвартай үед л программ хангамж найдвартай үр дүнг бий болгож чадна.

Танай АДБ-д таны ажлыг дэмжиж болох ямар программ хангамж байгааг дотоод арга зүйч нар болон судлах сэдэв/ зүйлийн экспертүүдээсээ лавлана уу. Мөн, олон компани программ хангамжийнхаа лицензгүй хувилбар эсвэл түршилтын хувилбарыг үнэгүй санал болгодог- үүнийг, танай АДБ-д таны хүссэн программын лицензтэй хувилбар байхгүй бол аудитын багаараа бодолцож үзэх хэрэгтэй.

Өгөгдлийг шинжилж, дүрслэхэд график ашиглах нь

Өгөгдлийг шинжлэх эсвэл дүрслэн харуулахад график ашиглахыг өгөгдлийн дүрслэл гэж нэрлэх нь олонтоо. Энгийнээр тодорхойлбол, өгөгдлийн дүрслэл гэдэг нь шинжилгээг дэмжих зорилгоор өгөгдлийг зураг эсвэл график хэлбэрээр толилуулж, тоон мессежийг үзүүлэн таниулахыг хэлнэ. Гол зорилго нь аудиторүүдэд, мөн шийдвэр гаргагчдад, ойлгоход хэцүү ухагдахуунуудыг ойлгуулж, шинэ нийтлэг хэв шинжийг таниулахад оршдог.


Өгөгдлийн дүрслэл нь хамгийн энгийн хэлбэртээ дээр үзүүлсэн чиг хандлагын шинжилгээ, тархай диаграмм зэрэг үндсэн графикууд болон бүдүүвчүүдийг агуулдаг. Хамгийн нарийн төвөгтэй хэлбэртээ, боловсронгуй программ хангамж ашиглан үүсгэсэн сая сая өгөгдлийн шугам бүхий дүрслэл агуулдаг.

Хэрэв танд тоон өгөгдөл байгаа бол, шинжилгээний арга болгож өгөгдлийн дүрслэл ашиглахыг бодолцож үзнэ үү. Уг өгөгдлөө бүдүүвчлэх нь танд, олон хуудас бичвэр болон тоо бүртгэл уншсанаас илүү хурдан бөгөөд хялбар байдлаар өгөгдлийн цэг хоорондын холбоог харж, харьцуулалт хийж, учир шалтгаан-үр нөлөөний хамаарлыг нь ойлгох боломж олгоно.

33-р зурагт шинжилгээ хийхдээ нэгэн ижил мэдээллийг дүрслэн харуулахад ашиглаж болох бүдүүвчүүдийн жишээг үзүүлэв.

Зураг 33: Өгөгдлийг дүрслэн харуулахад ашиглаж болох бүдүүвчүүдийн жишээ

2016-2019 оны санхүүгийн жилийн нийт төсөв



Эх сурвалж: АДБОУБХС/ГАДХ-ны Хөгжлийн Баг.

Арилжааны түгээмэл программ хангамжуудад янз бүрийн дүрслэл үүсгэхэд туслах функцүүд бий. Гэсэн хэдий ч, танай АДБ томоохон өгөгдлийн багцыг дүрслэхэд тань туслах тусгай программ хангамжтай байж магадгүй. Судлах сэдвээр мэргэшсэн дотоод оролцогч талтайгаа ярилцаж, бэлэн байгаа нөөцөө тодорхойлно уу.

Өгөгдлийн дүрслэл нь үр нөлөөтэй байхын тулд уншигчдад хялбархан ойлгогддог байх ёстойг санах нь чухал. Хамгийн сайн график нь шууд ойлгогддог график байдаг боловч зарим тохиолдолд, мэдээллийн зохих хам сэдвийг (хам нөхцөлийг) уншигчдад ойлгуулж, суурь мэдээлэлтэй болгохын тулд товчхон зүүлт тайлбар оруулах шаардлагатай болдог. График нь мөн тайланд орсон бичмэл мэдээллийг давтан өгүүлэх бус, бүрэн гүйцэд болгоход чиглэх ёстой. Өөрөөр хэлбэл, графикаар харуулсан мэдээллийг бичмэл байдлаар давтан өгүүлэх шаардлагагүй.

Шинжилгээгээ дуусгаж, илрүүлэлтүүдээ боловсруулсны дараа, аудитын үр дүнгүүдээ танилцуулахад өгөгдлийн дүрслэл нь асар үнэ цэнтэй хэрэгсэл болдог. ИБУИНВУ-ын УАГ болон АНУ-ын ТХГ-аас саяхан боловсруулсан интерактив өгөгдлийн багцуудаа олон нийтэд нээлттэй хуваалцсан байна. Аудитын тайландаа өгөгдлийн дүрслэлийг хэрхэн ашиглаж болох талаарх зарим жишээг дараах холбооснуудаас үзнэ үү.

www.nao.org.uk/search/publication_type/data-visualisations/

www.flickr.com/photos/usgao/

Дүрслэн харуулахын ач тусыг дараах блогод уншина уу:

www.nao.org.uk/naoblog/visualising-data/

Мэдээллийг хэрхэн баримтжуулж, хамгаалах вэ?

Мэдээлэл цуглуулж, шинжлэхдээ ажлаа тухай бүрд нь баримтжуулах буюу илтгэн харуулж, баримтжуулсан мэдээллээ хамгаалах нь чухал. 2-р бүлэгт авч үзсэнчлэн, танай аудитын баг аудитын явцад олж авсан баримт бичгүүдийнхээ хооронд ойлгомжтой бөгөөд ил тод үялдаа үүсгэх тулган шалгах тогтолцоо бий болгож, ашигладаг байх нь чухал. Баримтжуулалтын тогтолцоо нь дараах шаардлагыг хангах ёстой: танд мэдээлэлд хялбархан хандах боломж олгох; аудитын туршид чанарын хяналтын горимынхоо нэг хэсэг болгож аудитын ажлыг нягтлах (мөн нягталсныхаа дараа түүнийгээ баримтад тусгах)

боломжийг хянагчдад олгох; мөн дотоод болон гадаад чанарын баталгаажуулалтын нягталгааг дэмжих.

Өмнөх хэсгүүдэд дурдсанчлан, мэдээлэл цуглуулахын тулд хийж буй зүйлсээ, мэдээллийг хэрхэн шинжилж буйгаа, мөн шинжилгээнийхээ үр дүнгүүдийг баримтжуулах хэрэгтэй. Баримтжуулалтыг баримтжуулж буй алхмуудтайгаа хамтатган хийвэл тустай байдаг. Үйл явцыг сайн санаж байхдаа баримтжуулснаар нарийн чухал хэсгүүдийг нь орхигдуулахгүй байж чадна. Та гүйцэтгэсэн аудитын ажлынхаа талаар тодорхой ойлголт өгөх хэмжээний хангалттай баримтжуулалтыг хийх ёстой. Энэ нь, практикт, таны хийсэн аудитын талаар ямар ч мэдлэггүй боловч туршлагатай аудитор таны баримтжуулалтыг үзээд таны гүйцэтгэсэн аудит болон аудитын илрүүлэлт, дүгнэлт, зөвлөмжүүдээ дэмжсэн нотлох зүйлсийн мөн чанар, хугацаа, хамрах хүрээ болон үр дүнг, түүнчлэн танаас мэргэжлийн үнэлэмжээ ашиглахыг шаардсан бүх чухал үйл явдлуудын цаад шалтгааныг сайн ойлгож авах боломжтой байх учиртай гэсэн үг юм (АДБОУС-3000/87). Таны аудитын баримтжуулалтад хянагчийн шуурхай нягталгаа хийснээр мөн баримт бичгүүдийг бүрэн, үнэн зөв, тодорхой бөгөөд ойлгомжтой байлгадаг. Энэ нь хянагчдад аудиттай холбоотой аливаа асуудлыг (хангалтгүй нотлох зүйл эсвэл нотлох зүйлийн хэрэгцээт чанарыг цуглуулж мэдэх цуглуулсан мэдээллийн хангалтгүй баримтжуулалт) эртнээс сэрэмжлүүлж чаддаг учраас эрсдэлийн баталгаажуулалтын чухал алхам болдог. (УДИР-3910/82-84)

Цуглуулсан мэдээлэл болон шинжилгээгээ цахимаар эсвэл цаасан хэлбэрээр бүлэглэж, ойлгомжтой хавтаст систем үүсгэх хэрэгтэй.

Хувийн эсвэл эмзэг мэдээллийг хамгаалах нь

Аудитын туршид, та шалгагдагч этгээдээс хувийн (бие хүнийг тодорхойлох боломжтой мэдээлэл) эсвэл эмзэг мэдээлэл цуглуулж болно. Хэрэв ийм төрлийн мэдээлэл цугларсан бол, та түүнийг хангалттай хамгаалах ёстой. Энэ төрлийн мэдээлэл цуглуулж эхэлж магадгүй гэж бодох үедээ, эсвэл цуглуулж эхэлсэн үедээ, аудитад шалгуулагч этгээдтэй холбогдож, уг мэдээллийг тайлагнах эсэх, тайлагнавал хэрхэн тайлагнах вэ гэдгээ хэлэлцэж, уг мэдээллийг аудитад шалгуулагч этгээд болон АДБ-ын стандартад нийцсэн байдлаар хамгаалж байгаа гэдгээ баталгаатай ойлгуулах хэрэгтэй. Тухайлбал, эмзэг мэдээлэл гэдэгт аливаа хүний улсын бүртгэлийн дугаар, төрсөн өдөр зэрэг бие хүнийг тодорхойлох боломжтой мэдээлэл багтаж болно. Бас нэгэн жишээ татвал, тодорхой зарим мэдээллийг хууль эсвэл зохицуулалтын шаардлага ёсоор нууцалж, эсвэл нийтлэхийг хориглож болно. Ийм тохиолдолд, та уг мэдээллийг агуулсан тусдаа, нууцлалтай буюу хязгаарлагдмал хэрэглээний тайлан гаргаж, түүнийгээ зөвхөн хууль тогтоомж эсвэл зохицуулалтаар зөвшөөрсөн хүмүүст хүргүүлэх шаардлагатай болж болно.

Гүйцэтгэлийн аудитыг гүйцэтгэх үед, дараахыг санагтун:

- ✓ Нотлох зүйлсийн хангалттай бөгөөд зохистой байдлыг шинжилж; дотоод болон гадаад оролцогч талуудтай харилцаж; аудитын дэлгэрэнгүй баримтжуулалт үүсгэж; аудитын ажлаа хянан удирдах замаар эрсдэлийг тасралтгүй үнэлж, удирдаж, аудитын ажлын чанарыг хангах;
- ✓ Бусдыг аудитын багийн голч байдалд эргэлзэхэд хүргэж мэдэх нэг талыг барих, эсвэл нэг талыг барьсан гэж харагдах байдлаас зайлсхийхийн тулд аудитын багийнхаа хараат бус байдлыг тасралтгүй үнэлэх;
- ✓ Аудитад шалгуулагч этгээдтэй тогтмол харилцаж, өгөгдөл цуглуулж, шинжилгээгээ цогц болгож, илрүүлэлтүүдийн баримтын үндэслэлийг үнэн зөв бөгөөд шударга байгаа эсэхийг тулган баталгаажуулах;
- ✓ Ажлын чанарыг дээшлүүлэхийн тулд мэдээлэл цуглуулж, шинжлэхдээ судлах сэдвээр мэргэшсэн дотоод, мөн шаардлагатай үед гадаад экспертүүд болон оролцогч талуудтай холбогдож, зөвлөгөө, дэмжлэг болон нэмэлт харах өнцөг авах;
- ✓ Ярилцлага хийж буй хувь хүмүүс болон цуглуулж буй өгөгдлийнхөө итгэлтэй байдлыг харгалзан үзэж, эсрэгцэх нотлох зүйлсийг эрж, үнэлж, юмсыг шууд харагдаж байгаа утгаар нь хүлээн авахгүй байх замаар мэдээлэл цуглуулахдаа мэргэжлийн үл итгэх үзлийг тасралтгүй хэрэгжүүлэх;
- ✓ Мэдээлэл цуглуулж, шинжлэх ажлаа аудитад шалгуулагч этгээдийн аудитын зорилго(ууд) болон асуултуудтай харьцангуй арвилан хэмнэлт, үр ашигтай байдал болон/эсвэл үр нөлөөтэй байдалд төвлөрүүлэх;
- ✓ Гүйцэтгэсэн ажил болон олж авсан нотлох зүйл нь чухал дүгнэлтийг дэмждэг байлгахын тулд нотлох зүйлс болон аудитын бусад баримтжуулалтыг хангалттай бүрэн бөгөөд дэлгэрэнгүй байлгах;
- ✓ Цуглуулж буй мэдээллийнхээ материаллаг байдал болон гүйцэтгэж буй шинжилгээнийхээ боломжит үр дүнгүүдийг харгалзан үзэж, аудитын ажлаа аудитад шалгуулагч этгээдийн чухал үйл ажиллагаанд төвлөрүүлэхийн тулд мэргэжлийн үнэлэмжийг хэрэгжүүлэх; мөн
- ✓ Мэдээлэл цуглуулахдаа эмзэг бүлгийн хүн амыг тусгайлан чухалчилж, өгөгдлөө нөлөөлөлд өртөгч бүх талуудыг тэгш хамруулсан болгох.

Эх сурвалж: АХАДБАБ-ын Гүйцэтгэлийн Аудитын Гарын Авлага, 2016.

6-р бүлэг

Илрүүлэлт, дүгнэлт, зөвлөмжүүдийг хэрхэн боловсруулах вэ?



Аудитын илрүүлэлтүүдийг боловсруулахын зорилго нь аудитын шалгуурыг нөхцөлтэйгөө харьцуулж, шалтгаан болон үр дагаврыг тодорхойлж (хэрэв хамааралтай бол), нотлох зүйлсээ үнэлж, илрүүлэлтүүдээ хангалттай бөгөөд зохистой нотлох зүйлд суурилсан болгож, дүгнэлтүүд болон зөвлөмжүүдийг (шаардлагатай бол) боловсруулахад оршино.

Тус бүлэг нь дараах асуултуудад хариулах болно:

- Аудитын илрүүлэлт гэж юу вэ?
- Аудитын шалгуурыг нөхцөлтэй хэрхэн харьцуулах вэ?
- Шалтгаан, үр дагаврыг хэрхэн тодорхойлох вэ?
- Нотлох зүйлсээ хэрхэн үнэлэх вэ?
- Дүгнэлт, зөвлөмжүүдийг хэрхэн боловсруулах вэ?
- Тайлангийн төслөө бичихэд хэрхэн бэлдэх вэ?

Аудитын илрүүлэлтүүдээ боловсруулах ажил нь нотлох зүйлс цуглуулах ажилтай зэрэг, эсвэл цуглуулж дууссаны дараа эхэлж болно. Аудитын ажлаа гүйцэтгэж дуусаагүй байх үедээ боломжит илрүүлэлтүүдийнхээ бүрэлдэхүүнүүдийг тодорхойлж эхлэх нь тустай байж болно. Учир нь ингэснээр та нотлох зүйлсдээ оршин буй аливаа дутагдлыг илрүүлж, аудитын нэмэлт ажил хийх хэрэгцээ байгаа эсэхийг тогтоож чадна.

Аудитын илрүүлэлт гэж юу вэ?



Стандарт

Аудитор цуглуулсан мэдээлэлдээ дүн шинжилгээ хийх ёстой ба аудитын тогтоосон зүйлсэд бодитой хандаж, аудитын зорилго болон аудитын асуултад хариулж, төлөв хандлагыг тодорхойлж байгааг нягтлах ёстой. Шаардлагатай гэж үзвэл аудитын зорилго болон аудитын асуулыг шинэчлэн боловсруулна.

Эх сурвалж: АДБОУС-3000/112.

Нотлох зүйлсээ цуглуулж, шинжилсний дараа, уг нотлох зүйлсээ үнэлж, аудитын илрүүлэлтүүдийг боловсруулахад анхаарлаа хандуулах нь чухал. УДИР-3920/79-ийн дагуу, аудитын илрүүлэлт нь “юу байна”-ыг “юу байх ёстой”-той харьцуулдаг.

Аудитын туршид шинжилгээний үйл явц нь нотлох зүйлс болон түүний аудитын асуултуудтай холбогдох байдлыг тасралтгүй шинжилж, үнэлдэг. Энэхүү бүтээлч, давтагддаг бөгөөд хамтын ажиллагаатай шинжилгээний үйл явц нь танай багт чанартай аудитын илрүүлэлт боловсруулахад туслах болно. Зарим аудит нь сэдвийн хувьд холбоотой, өөр өөр асуудлуудыг судалдаг бөгөөд уг асуудлуудын бүтэн “түүх”-ийг нэг илрүүлэлт болгон толилуулж болдог. Энэ тохиолдолд, 34-р зурагт үзүүлсэнчлэн, аудитын илрүүлэлт нь дөрвөн элемент агуулсан гэж тайлбарлаж болно.

Зураг 34: Илрүүлэлтийн элементүүд



Эх сурвалж: УДИР-3920/84

Гэхдээ, өөр өөр илрүүлэлтүүд харилцан уялдаатай байгаа үед, бүтэн “түүх”-ийг аудитын тайланд бие даасан илрүүлэлтүүдээр бус, бүхлээр нь толилуулж болно. Ийм тохиолдолд, тайлан бүхэлдээ дээрх дөрвөн элементийг хамруулах шаардлагатай болно.

Аудитынхаа туршид энэ дөрвөн элементийг харгалзаж үзэх нь чухал. Эдгээр элементүүд нь хэр их нотлох зүйл цуглуулах шаардлагатайг, мөн түүнийгээ хэрхэн шинжилж болохыг тогтооход тусалдаг хүрээг үүсгэдэг. Мөн, нотлох зүйлсээ үнэлж эхлэхдээ, аль мэдээлэл нь танай аудитын асуултуудтай хамгийн их холбоотой байгааг, мөн салангид мэдээллүүд өөр хоорондоо ямар хамааралтай байгааг тодорхойлох шаардлагатай. Энэхүү нотлох зүйлсийн үнэлгээ нь нотлох зүйлс нь чухамдаа ямар ач холбогдолтой вэ гэдгийг тодорхойлоход тусална. Энэ үйл явцын туршид аудитын баг боломжит илрүүлэлтүүдээ анхаарч, улам бүр сайжруулсаар байх нь чухал.

Хянагчид, удирдлагууд болон оролцогч талуудад аудитад ашигласан аудитын шалгуурууд, нөхцөлүүд, мөн илрүүлсэн нөхцөл байдлын мөн чанар, ач холбогдол хийгээд учир шалтгааны шинжилгээг хялбархан ойлгох боломж олгох байдлаар тодорхой бөгөөд логик хүрээтэйгээр аудитын илрүүлэлтүүдийг үүсгэх ёстой. Илрүүлэлтүүдээ арвилан хэмнэлт, үр ашигтай байдал болон/эсвэл үр нөлөөтэй байдлын үүднээс авч үзэх нь залруулах арга хэмжээ авах шаардлагатай байгаа гэдгийг илтгэдэг учраас үүнийг мартаж болохгүй. Таны илрүүлэлтүүд мөн бодитой бөгөөд шударга байх ёстой.

Аудитын тайланг бүрэн болгохын тулд, сайн болон муу талуудыг хоёуланг нь тайлагнаж, зохих тохиолдолд сайшаадаг байх нь чухал. Учир нь илрүүлэлтүүдийг хам нөхцөлтэй нь толилуулах хэрэгтэй. Аудитад шалгуулагч этгээдийн үйл ажиллагаа эсвэл хөтөлбөрийг үнэлж байгаа тохиолдолд зарим зүйлс сайн хэрэгжиж буйг илрүүлэх нь олонтоо. Бодитой бөгөөд шударга үнэлгээ нь дан ганц дутагдалд төвлөрөх бус, харин нөхцөл байдлыг бүтнээр нь тусгадаг.

Түүнчлэн, энэ үйл явцын туршид материаллаг байдалд анхаарч, мэргэжлийн үнэлэмжийг хэрэгжүүлэх нь чухал (эдгээр элементүүдийг 2-р бүлэгт дэлгэрэнгүй тайлбарласан). АДБОУС-3910/112-т заасанчлан, илрүүлэлтүүд нь, дангаараа эсвэл хамтдаа, зорилтот хэрэглэгчдийн аудиторын тайланд үндэслэн гаргах холбогдох шийдвэрүүдэд үндэслэлтэйгээр нөлөөлөхүйц байгаа тохиолдолд материаллаг байдалтай гэж үзнэ. Аудитор нь материаллаг байдлыг авч үзэхдээ мэргэжлийн үнэлэмжээ ашигладаг бөгөөд энэ үед аудиторын зорилтот хэрэглэгчдийн мэдээллийн нийтлэг хэрэгцээг харж байгаа өнцөг нөлөөлдөг.



А у д и т ы н
илрүүлэлтүүдийг
боловсруулахад
тэнцвэртэй байдал чухал.
Шударга бөгөөд тэнцвэртэй
зураглал үүсгэхийн тулд
дараах асуултуудыг өөрсөө
асууна уу:

- Ухамсартай хүн аудитад шалгуулагчийг юунд хүрч чаддаг байх ёстой гэж хүлээх вэ?
- Аудитад шалгуулагч этгээд аудитын асуултуудтай холбогдуулан юуг сайн хийж байна вэ?
- Аудитаар илрүүлсэн аливаа сөрөг орчин нөхцөлийг сайжруулахын тулд аудитад шалгуулагч этгээд ямар эерэг арга хэмжээнүүдийг авсан бэ?

Эх сурвалж: АДБОУБХС/ГАДХ-ны ХБ.

Аудитын илрүүлэлтийн жишээ

Илрүүлэлтийн мэдэгдэл. “А” улсын ихэнх бүс нутагт сэтгэцийн хэвтэн эмчлүүлэх орны хомсдолтой байна.

Шалгуур. Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллагаас тогтоосон сэтгэцийн хэвтэн эмчлүүлэх орны шаардлагатай тоо 1000 хүн тутамд 0.43 байдаг.

Нөхцөл:

- ✓ Тус улсад 1000 хүн тутамд дунджаар 0.37 сэтгэцийн хэвтэн эмчлүүлэх ор оногдож байна.
- ✓ Газар зүйн бүсүүдэд орны хуваарилалт тэгш бус байгаагаас үзвэл (зүүн өмнөд бүсэд 1000 хүн тутамд 0.53 ор оногдож байхад хойд бүсэд энэ үзүүлэлт 0.04 байна) орны тоо Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллагын хүн амын шалгуурт нийцэхгүй байна.

Шалтгаан. “А” улс хотын болон мужийн хэмжээний сэтгэцийн эрүүл мэндийн төлөвлөгөөгүй байсны улмаас газар зүйн бүс тус бүрд хуваарилагдаж буй орны тоонд анхаараагүй байна.

Үр дагавар:

- ✓ Орны үзүүлэлт бага газруудад үйлчилгээ дутмаг байна.
- ✓ Сэтгэцийн эмгэгтэй хүмүүс хотууд болон мужууд руу шилжин ирэх болсноор эрүүл мэндийн тусламж үйлчилгээний төлөвлөлтийг нарийн төвөгтэй болгож байна.

Эх сурвалж: АДБОУБХС/ГАДХ-ны Хөгжлийн Баг.

Аудитын шалгуурыг нөхцөлтэй хэрхэн харьцуулах вэ?



Стандарт

Аудитор нь аудитын шалгуур үзүүлэлтүүд, тэдгээрийн эх сурвалжийг аудитын тайланд тодорхойлох ёстой.

Эх сурвалж: АДБОУС-3000/122.

Аудитын илрүүлэлтүүдийн гол нуруу буюу цөм нь шалгуур болон нөхцөл юм. Нөхцөл гэдэг нь илэрсэн нөхцөл байдал бөгөөд аудитын гүйцэтгэлийн явцад илэрсэн хамгийн хамаарал бүхий үйл явдлууд болон тохиолдлууд юм. Илрүүлэлтүүдийг боловсруулахын тулд дараах зүйлсийг хийх хэрэгтэй:

1. Аудитынхаа явцад цуглуулсан нийт мэдээллээ нягтлах;
2. Аудитын асуултуудад хариулахад аль хэсэг нь хамгийн чухал байгааг шийдэх; мөн
3. Мэдээллийн хэсгүүд хоорондоо логикийн хувьд хэрхэн холбогдож байгааг тогтоох.

Энэхүү нотлох зүйлсийг үнэлэх үйл явц нь өгөгдлийн өөр өөр эх сурвалжуудаас авсан мэдээллийг нэгтгэж, бодит нөхцөлийн талаар мэдлэг, мэдээлэлтэй болох ажлаас бүрдэнэ. Өөрөөр хэлбэл: ярилцлагын мэдээллийг статистик бүртгэлийн шинжилгээтэй нэгтгэх; кэйс судалгааны мэдээллийг асуумж судалгааны мэдээлэлтэй нэгтгэх; мөн нэг аймагт хийсэн талбарын ажлын мэдээллийг өөр аймагт хийсэн талбарын ажилтай нэгтгэх зэрэг ажлуудаас бүрдэнэ. Энэхүү мэдээлэл нэгтгэх ажил нь эвлүүлдэг зураг эвлүүлэхтэй төстэй бөгөөд ширхэг бүр нь мэдээлэл, шинжилгээний бие даасан элементүүд болно. Нотлох зүйлсээ үнэлснээр шалгууруудаа бодит нөхцөл байдал буюу нөхцөлтэй харьцуулах боломжтой болно.

Шалгуур болон нөхцөл хооронд хазайлт байгаа бол, зөвлөмж үүсгэж чадах аудитын илрүүлэлт бий болно. Тухайлбал, нотлох зүйлсийн үнэлгээгээр аудитад шалгагдагч этгээд

нь шалгуурт нийцэхгүй байна гэж харагдаж байвал, энэ нь сайжруулалт хийх шаардлагатай талбар оршин байгааг илтгэж болно. Шалгуурыг нөхцөлтэй харьцуулахдаа ухамсартай хүн аудитад шалгуулагч этгээдийн орчин нөхцөлийг хараад ямар хүлээлт тавьж болох вэ гэдэгт үндэслүүлэх хэрэгтэй.

Нөхцөл болон шалгуурын хооронд ямар ч зөрүү байхгүй бол, аудитад шалгуулагч этгээд нь шалгуурын дагуу хүлээгдэж байсан зүйлсийг хэрэгжүүлж дууссан гэсэн үг. Шалгуур болон нөхцөлийн үнэлгээгээр аудитад шалгуулагч этгээд нь шалгуурт нийцсэн эсвэл шалгуураас давсан гэж харагдаж байвал, эерэг илрүүлэлт бий болох боломжтой. Нотлох зүйлсээр тань дэмжигдэж байгаа бол эерэг илрүүлэлтүүдийг тайландаа тусгах нь чухал.

Гэвч, шалгуур болон нөхцөл хооронд зөрүү илэрсэн бол, аудитад шалгуулагч этгээд нь үйл ажиллагаагаа аудитын шалгуурт нийцсэн байдлаар явуулахгүй байна гэсэн үг. Энэ үнэлгээний дараа хийх алхам бол шалтгаанууд буюу яагаад шалгуураас хазайсан бэ гэдгийг шинжилж, батлах алхам юм. Энэ нь зөвлөмж үүсгэхэд хөтлөх боломжтой. Тухайлбал, гаалийн байцаагчдад зориулсан сургалтын хангалттай байдалтай холбогдох аудитын асуултын хувьд, шинэ байцаагчдад ордог гаалийн үзлэгийн сургалт нь сургалтын хөтөлбөрийн удирдамжтай нийцэхгүй байвал, энэ нь аудитад шалгуулагч этгээдийн сайжруулалт хийх шаардлагатай байгаа талбарыг илтгэх боломжтой юм.

Заримдаа, аудитын зорилго(ууд) эсвэл асуултуудын талаар хангалттай мэдээлэлгүй байх нь өөрөө илрүүлэлт болж болно. Мөнөөх гаалийн байцаагчдад зориулсан хангалттай сургалттай холбогдох аудитын асуултын хувьд, аудитад шалгуулагч нь сургалтад суусан гаалийн байцаагчид сургалтад сууснаар ажилдаа бэлтгэгдсэн гэж үзэж байгаа эсэх талаар мэдээлэл цуглуулдаггүй гэдгийг та илрүүлж болно. Энэ нь аудитад шалгуулагч этгээд сургалтын талаарх шийдвэрээ илүү мэдээлэл сайтай гаргахын тулд дээрх мэдээллийг цуглуулах шаардлагатай байж магадгүй гэдгийг илтгэж болно.

Шалтгаан, үр дагаврыг хэрхэн тодорхойлох вэ?

Туйлын утгаараа, та шалтгаан хийгээд үр дагаврыг тодорхойлох хангалттай бөгөөд зохистой нотлох зүйлстэй байх болно. Мөн тодорхой хэмжээнд, та гүйцэтгэлийн асуудлыг нотлох зүйлсийг шалтгаан болон үр нөлөөг тодорхойлох хөшүүрэг болгон ашиглаж болно. Шалтгаан гэдэг нь нөхцөл болон шалгуур хоорондын зөрүүг бий болгогч хүчин зүйл(с)ийг хэлэх бөгөөд залруулах арга хэмжээний зөвлөмжийн сүүрж болж болно. Түгээмэл хүчин зүйлсээс дурдвал, муу зохиомжилсон бодлого, горим болон шалгуур; нийцэлгүй, бүрэн бус эсвэл буруу хэрэгжүүлэлт; хөтөлбөрийн удирдлагын хяналтаас гадуурх хүчин зүйлс зэрэг болно. Шалтгаан, үр дагаврыг тогтоосноор учир шалтгааны хамаарлыг тогтоосон гэж үзэж болохгүй. Шалтгаан, үр дагаврын тухай асуултуудад хариулахад сайжруулсан шинжилгээний арга техникүүдийг ашиглах шаардлагатай болдог. Учир нь арга зүйн талаас, шалтгаан, үр дагаврыг тодорхойлох нь маш бэрхшээлтэй байдаг. Энэ үйл явцын үеэр арга зүйн эксперт эсвэл статистикчтай зөвлөлдөх нь чухал.

Шалтгааныг зөв тогтоохын тулд заримдаа шалтгааны “гинж” үүсгэх буюу хамгийн их засах шаардлагатай тодорхой нэг зүйлд түлж очих хүртлээ шалтгааныг нь хөөн шинжлэх

шаардлагатай болдог. Тухайлбал, нотлох зүйл муу байгаа нь хангалтгүй төлөвлөлтийн улмаас боллоо гэж дүгнэх нь хангалтгүй. Хангалтгүй төлөвлөлтийн шалтгаан юу байсан бэ? Буруу тогтоосон тэргүүлэх зорилго байсан уу? Эсвэл өөр зүйл байсан уу? Хэрэв та аливаа шалтгааныг үндэслэлтэй буюу итгэж болохуйц гэж үзэхгүй байвал, энэ тухайгаа аудитад шалгуулагчид тайлбарлаж, цаашид хэлэлцүүлэг зохиох хэрэгтэй. Өгөгдөл цуглуулах явцад “Яагаад?” гэдэг асуултыг байн байн асуух нь илрүүлсэн гүйцэтгэлийн асуудлын шалтгааныг тодорхойлж, шинжлэх боломж олгоно.

Бодит нөхцөлийг идеал нөхцөл байдал буюу шалгуурыг хангасан үеийн нөхцөл байдалтай харьцуулах замаар үр нөлөөг тодорхойлж болно. Үр дагаврыг илрүүлэхдээ “хэдийнээ тохиолдсон үр дагавар ” эсвэл “логик сэтгэлгээнд үндэслэн тооцсон ирээдүйд үүсэх дагавар ” гэж илрүүлж болно. Мөн, эерэг үр дагавар (энэ арга хэмжээг хэрэгжүүлснээр, аудитад шалгуулагч этгээд арвилан хэмнэлт, үр ашигтай байдал болон нөлөөтэй байдлын тодорхой үр дүнд хүрч чадна) болон сөрөг үр нөлөөг (энэ арга хэмжээг хэрэгжүүлэхгүй байснаар, аудитад шалгуулагч этгээд арвилан хэмнэлт, үр ашигтай байдал болон нөлөөтэй байдлын тодорхой үр дүнд хүрч чадахгүй) илрүүлж болно. Бусад гадаад хүчин зүйлс мөн ажиглагдсан үр дагаварт нөлөөлж болно гэдгийг бүү мартагтун.

Шалтгаан болон үр дагавар хооронд оршин байж болох аливаа харилцаа хамаарлын мөн чанарыг ойлгох нь бас чухал. Тухайлбал, хангалтгүй санхүүжилт нь нөхцөлийг муутгана гэж байнга үзэж болохгүй. Тусламж үйлчилгээний чанар муу байсны улмаас аливаа байгууллага санхүүжилтээ багасгасан байх боломжтой.

Шалтгаан, үр дагаврын хамаарлын төрлүүд

- ✓ **Шалтгаан-үр дагаврын шууд хамаарал:** Тухайлбал, их сургууль жил бүр элсүүлэх оюутны тогтсон тоотой бөгөөд эцнээ ангийн элсэлтээ нэмэгдүүлбэл, ердийн ангийн элсэлтээ багасгах ёстой болно.
- ✓ **Шалтгаан-үр дагаврын урвуу хамаарал:** Тухайлбал, шалгалтад муу дүн авах нь ирц муу байснаас шалтгаалсан байж болох ч, нөгөөтээгүүр, шалгалтад муу дүн авсны улмаас ирц муу байсан байж болно.
- ✓ **Санамсаргүй давхцал:** Тухайлбал, нэг орон нутгийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар болон үзлэгийн үр дүн хооронд хамаарал байж болох ч, аль нь алийнхаа шалтгаан болсныг мэдэхэд хэцүү юм.
- ✓ **Тодорхойгүй үр дагавар:** Тухайлбал, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар болон үзлэгийн үр дүн хоорондын хамаарал нь орон нутгийн удирдлагын нөөцийн үр нөлөөтэй хуваарилалтаас үүдсэн байж болно. Үүнийг талбарын ажлын үед анхаараагүй байж болно.

Эх сурвалж: УДИР-3920-ын 7-р шигтгээг эш болгов.

Нотлох зүйлсээ хэрхэн үнэлэх вэ?

Нотлох зүйлсээ үнэлэхэд ашиглаж болох хэд хэдэн арга техник бий. Таны аудитын мөн чанар болон цуглуулсан мэдээлэл нь нотлох зүйлсээ үнэлэх хамгийн тохиромжтой аргыг тодорхойлоход тусална. Танай аудитын баг цуглуулсан нотлох зүйлс болон өгөгдлөө хөрвүүлэн ойлгохдоо системтэй бөгөөд няхуур ажиллах ёстой. 5-р бүлэгт онцолсончлон, нотлох зүйлсийн хангалттай бөгөөд зохистой байдлыг хангах нь аудитын түршид асар чухал байдаг. Энэ нь нотлох зүйлсээ үнэлж, илрүүлэлтүүдээ тодорхойлохын өмнөх маш чухал алхам юм. Түүнчлэн, олон төрлийн эх сурвалж, арга болон шинжилгээний өгөгдлийг нэгтгэснээр (нотлох чадвартай өгөгдөл) мэдээллийн ганц эх сурвалж ашигласны улмаас үүсэж болох аливаа нэг талыг барьсан хандлагаас таныг хамгаалж чадна. Энэ хэсэгт нотлох зүйлсийг үнэлэх түгээмэл аргуудыг заримыг тайлбарлах болно.

Нотлох зүйлсийг бүлэглэж, шошголох

Нотлох зүйлсийг үнэлэх нэг арга техник бол мэдээллийг бүлэглэн шошголож логикийн ангилал үүсгэх юм. Мэдээллийг бүлэглэхийн тулд, мэдээллийг логикийн хувьд холбоотой мэдээллийн бүлгүүдэд хувааж, ойр холбоотой мэдээллүүдийг бүлэг бүлэг болгодог. Бүлэглэх нь ялгаатай эх сурвалжуудаас цуглуулсан мэдээллүүд доторх өөр хоорондоо холбоотой байсан мэдээллүүдийг илрүүлэхэд тусалдаг.

Бүлгүүдэд орсон мэдээлэл хоорондын холбоо хамаарлыг шинжилсний дараа бүлэг тус бүрд гарчиг өгнө. Уг холбоо хамаарлыг нь гол сэдвээ болгон илэрхийлсэн холбоо үг эсвэл өгүүлбэрээр гарчиглана. Эсвэл, тухайн бүлгийн мэдээлэл чухам юун тухай вэ гэдгийг нь илэрхийлсэн энгийн гарчиг байж болно.


Энэхүү мэдээллийг суурьшуулахад аудитын баримт бичгүүдээ ашиглаж болно. Тухайлбал, гаалийн байцаагчдад зориулсан сургалтын хангалттай байдалтай холбогдох аудитын асуултад хариулахын тулд цуглуулсан мэдээллийн хувьд, “нөөц”, “үр өгөөж”, “сорилт” зэрэг ангиллуудад бүлэглэж болно. Мэдээллийг шошголохын тулд, та “Гаалийн үзлэгийн

сургалтын академийн сургалтын ирц муу байна” гэж хэлж чадах хэмжээнд тухайн бүлэгт орсон мэдээллийг нягталж болно.

Үзүүлэн танилцуулга буюу үялдуулсан зураглал ашиглах

Бас нэгэн арга техник бол аудитын асуулт тус бүрийн дотор, мөн аудитын асуулт хооронд холбоо үүсгэхийн тулд үзүүлэн танилцуулга ашиглах арга юм. Ингэхдээ, оюуны зураглал, загасны яс маягийн бүдүүвч, зохион байгуулалтын бүдүүвч зэргийг ашиглаж болно. Нотлох зүйлсдээ үндэслэн хэрхэн өгөгдөл суурьшуулж болох талаар ойлголт өгөх, хагас гүйцээсэн зураглал, бүдүүвчүүдийн жишээг 35, 36 болон 37-р зургуудаас үзнэ үү. Эдгээр бүдүүвчүүдийг аудитыг зохиомжлох үе шат зэрэг аудитын бусад үе шатуудын үеэр мөн ашиглаж болно.


Зураг 35: Оюуны зураглал



Эх сурвалж: АНУ-ын ТХГ-ын мэдээллийг эш болгов.

Оюуны зураглал нь тухайлсан сэдэв эсвэл асуулттай холбогдох бүх мэдээллийг дүрслэн үзүүлэхэд тусалдаг. Тухайлбал, гаалийн байцаагчдад зориулсан сургалтын хангалттай байдалтай холбогдох аудитын асуултын хувьд, сургалтын хөтөлбөр гэсэн гарчгийг төв цэг буюу гол санаа болгон ашиглаад хөтөлбөрт хамрагдах дэд гарчгуудыг ойр орчимд нь холбон дүрсэлнэ.


Зураг 36: Загасны яс маягийн бүдүүвч



Эх сурвалж: АНУ-ын ТХГ-ын мэдээллийг эш болгов.

Загасны яс маягийн бүдүүвч нь аливаа асуудлын боломжит шалтгаануудыг дүрслэн тодорхойлж, зохион байгуулалтад оруулснаар уг шалтгаан рүү нь чиглэсэн зөвлөмж боловсруулахад тусалдаг. Гаалийн байцаагчдад зориулсан сургалтын хангалттай байдлын тухай өмнөх жишээг авч үзвэл, шинэ байцаагчдад ордог гаалийн үзлэгийн сургалт нь сургалтын хөтөлбөрийн удирдамжтай нийцэхгүй байна гэсэн асуудлын мэдэгдлийг ашиглаж болно. Дараа нь хүний нөөц, тоног төхөөрөмж эсвэл бодлоготой холбогдох бэрхшээл зэрэг боломжит шалтгаануудыг бүдүүвчид оруулна.

Зураг 37: Зохион байгуулалтын бүдүүвч



Эх сурвалж: АНУ-ын ТХГ-ын мэдээллийг эш болгов.

Зохион байгуулалтын бүдүүвч нь нотлох зүйл тус бүр бусадтайгаа ямар хамааралтайг үзүүлэхэд тусалдаг. Өмнөх жишээг авч үзвэл, шинэ байцаагчдад ордог гаалийн үзлэгийн сургалт нь сургалтын хөтөлбөрийн удирдамжтай нийцэхгүй байна гэсэн асуудлын мэдэгдлийг зохион байгуулалтын бүдүүвчийн оройд тавьж болно. Дараа нь сургалт удирдамжтай яагаад нийцэхгүй байгаа шалтгаануудыг задлан эрэмбэлж байрлуулна.

Ханан дээр бичих

Нотлох зүйлийг багаараа үнэлэх бас нэгэн арга бол “ханан дээр бичих” гэж заримдаа нэрлэдэг арга техник юм. Энэ арга техникийг ашиглах үед аудитын баг бүхэлдээ, дотоод оролцогч талууд болон хянагчидтайгаа нэг өрөөнд цугладаг (эсвэл виртуалаар цуглана). Сургагдсан чиглүүлэгчийн тусламжтайгаар, багаараа аудитын асуултуудыг дэлгэрүүлэн хэлэлцэж, шийдвэрлэх ямар нотлох зүйлс цуглуулснаа ярилцана. Дараа нь бүх нотлох зүйлээ наадаг цаасан дээр бичиж ханан дээр наана. Үүнийг компьютер дээр хийж болно. Ийнхүү багийн бүх гишүүд нотлох зүйлсийн хэмжээ болон асуудлын ерөнхий зураглалыг харна. Хэдэн өдрийн турш багаараа янз бүрийн нотлох зүйлсийг хэлэлцэж, наадаг цаасан дээрх тэмдэглэлүүдийнхээ байрлалыг сольж, аудитын илрүүлэлтүүдийг зураглал байдлаар үүсгэнэ. Чиглүүлэгч нь багийн гишүүд болон оролцогч талуудаас нотлох зүйлсийг дэмжих мэдээлэл, дутагдлуудын шалтгаан болон үр нөлөөг асуух байдлаар чухал үүрэг гүйцэтгэдэг.

Дүгнэлт, зөвлөмжүүдийг хэрхэн боловсруулах вэ?

Нотлох зүйлийг үнэлснээр аудитын илрүүлэлт рүү хөтөлж хүргэх боломжтой болох ба эдгээр илрүүлэлтэд суурилан дүгнэлт, зөвлөмжийг боловсруулж гаргаж чадах байдалд хүргэнэ. Илрүүлэлтүүд болон дүгнэлтүүд нь хангалттай бөгөөд зохистой нотлох зүйлсээр дэмжигдсэн байх ёстой.

Дүгнэлтийг хэрхэн боловсруулах вэ?



Стандарт

Аудитор хүлээн зөвшөөрөгдсөн АДБ-ын бүрэн эрхийн хүрээнд аудитын дүнг боловсруулж, аудитын зорилго, аудитын асуулыг ашиглан дүгнэлт гаргаж, зөвлөмж өгөхийн тулд аудитын хангалттай ба зохистой нотлох зүйлийг олж авах ёстой.

Эх сурвалж: АДБОУС-3000/106.

Дүгнэлт нь дутагдлыг арилгах эсвэл ашиг түс бий болгох шаардлагатай арга хэмжээнд чиглэсэн сайжруулах болон засах асуудлын үндэс суурь болох аливаа нэг зөвлөмж өгөх боломж олгох товч тодорхой, үнэмшилтэй бөгөөд үндсэн санааг гаргах боломжийг танд олгодог. Дүгнэлт нь мөн дараах боломжийг олгоно: нотлох зүйлдээ суурилж санал дүгнэлтээ толилуулах; илрүүлэлтүүдийг тодорхой болгож, утгыг нь нэмэх; мөн аудитын тайлангаар толилуулах илрүүлэлтүүдийг улам боловсронгуй болгох. Түүнчлэн, дүгнэлт нь илрүүлэлтүүдэд үндэслэсэн аудиторын тайлбар болон санал дүгнэлтийн тусгал болдог. Тухайлбал, дүгнэлт нь илрүүлэлтүүд дэх ерөнхий сэдэв эсвэл тодорхой нийтлэг шинжийг агуулж болно. Эсвэл илрүүлэлтүүдийг тайлбарлах суурь асуудлыг агуулж болно (УДИР-3920/93-ыг эш болгов). Дүгнэлтийн төсөл бичихэд, аудитын баг дүгнэлтүүдийг аудитын илрүүлэлтүүд, нотлох зүйлс болон шалгууруудтай холбож авч үзэх нь маш чухал. Түүнчлэн, дүгнэлтүүдийг аудитын зорилготой холбож авч үзэх нь чухал.

Аудитын дүгнэлтүүдээ боловсруулахад харилцаа холбоо нэн чухал. Учир нь аудитор дүгнэлт гаргахын өмнө хам нөхцөл, холбогдох аргументууд болон ялгаатай харах өнцгүүдийг харгалзаж үзэх нь чухал. Ийм учраас аудитор нь АДБ-ын холбогдох оролцогч талууд болон аудитад шалгуулагч этгээдтэй үр нөлөөтэй бөгөөд зохистой харилцаатай байх шаардлагатай (УДИР-3920/100-124-ийг эш болгов). Энэ харилцааг энэ бүлгийн сүүл хэсэг болон 7-р бүлэгт авч үзнэ.

Дүгнэлтүүд

Дүгнэлт нь дараах шаардлагыг хангах ёстой:

- ✓ ЗЕ -г ерөнхийд нь нягтлах эсвэл ЗЕ-тэй холбогдох тодорхой мэдээллээр хангах замаар арвилан хэмнэлт, үр ашигтай байдал болон/эсвэл үр нөлөөтэй байдлын хэмжээг мэдэгддэг;
- ✓ Ойлгомжтой бөгөөд товч. Дүгнэлтийн хэсэг бүх илрүүлэлтийг давтан бичих шаардлагагүй;
- ✓ Аудитын шалгуурыг тусгасан;
- ✓ Боломжтой бол тоо хэмжээгээр илэрхийлсэн (тухайлбал, хүлээгдсэн буюу идеал стандартаас гүйцэтгэл хэр их зөрж байгааг мэдэгддэг);
- ✓ Цаг хугацааны явцад гарсан өөрчлөлтүүдийг тусгасан (тухайлбал, шинэ өөрчлөлтийн улмаас гүйцэтгэлд учрах эрсдэл өсөх эсэхийг мэдэгддэг);
- ✓ Утга илэрхийлэмжийн хувьд тэнцвэртэй, аудитын илрүүлэлтэд тулгуурласан бөгөөд аудитын илрүүлэлтийг шударгаар тусгасан; мөн
- ✓ Тайлангийн зөвлөмжүүдтэй тодорхой уялдсан. Зарим АДБ дүгнэлт бүр нь зөвлөмжтэй шууд уялдсан байх ёстой гэж шаарддаггүй.

Эх сурвалж: АДБОУБХС/ГАДХ-ны Хөгжлийн Баг.

Үр нөлөөтэй дүгнэлт боловсруулах зөвлөмж

- ✓ Дүгнэлтийг аудитын зорилготой уялдуулж, уг аудит яагаад чухлыг тайлбарлах.
- ✓ Дүгнэлт нь тэнцвэртэй, аудитын илрүүлэлтүүдийн (эерэг болон сөрөг) ач холбогдлыг онцолсон бөгөөд хөндсөн асуудлыг аудитад шалгуулагч этгээд хэр ахицтай (хэрэв байгаа бол) шийдвэрлэж буйг илтгэсэн байх хэрэгтэй.
- ✓ Дүгнэлт нь аудитын илрүүлэлтүүдээс логиктойгоор урган гарах ёстой.
- ✓ Ердөө илрүүлэлтүүдийг хураангуйлсан эсвэл дахин давтсан байдлаар бус, харин илрүүлэлтүүдийн ач холбогдлыг тайлбарлаж, зөвлөмжүүд яагаад хэрэгтэйг илтгэсэн байдлаар дүгнэлт боловсруулах хэрэгтэй.

Эх сурвалж: АНУ-ын ТХГ-ын мэдээллийг эш болгов.

Зөвлөмжийг хэрхэн боловсруулах вэ?



Стандарт

Аудитор нь АДБ-ын бүрэн эрхэд хамаарах болон хүлээн зөвшөөрөгдсөн хүрээнд аудитаар олж тогтоосон дутагдлыг арилгах, асуудлуудыг шийдвэрлэхэд чиглэсэн чухал хувь нэмэр оруулах боломжтой бүтээлч зөвлөмж өгөх ёстой.

Эх сурвалж: АДБОУС-3000/126.

АДБОУС-3000-д аудитын тайлагналын үе шатанд боловсруулах зөвлөмжийн тухай заасан байдаг. Гэсэн хэдий ч, аудиторуудад илрүүлэлт, дүгнэлт болон зөвлөмж хоорондын холбоог ойлгоход нь туслах зорилгоор бид энэ хэсэгт зөвлөмж боловсруулах тухай мэдээлэл орууллаа.

Аудитын үед илрүүлсэн дутагдлуудыг залруулах болон бусад илрүүлэлтүүдийг шийдвэрлэх зөвлөмжүүдийг шаардлагатай тохиолдолд боловсруулдаг. Аудитын илрүүлэлтүүд болон зөвлөмжүүд хоорондын үялдааг нэгэн ижил түлхүүр үгс болон холбоо үгс ашиглаж илэрхийлдэг байх нь тустай байдаг. Сайн зөвлөмжийн шинжүүдийг SMART (Specific – Тодорхой, Measurable – Хэмжиж болохуйц, Attributable – Хариуцах эзэнтэй, Relevant – Хамааралтай, мөн Time-bound – Цаг хугацаатай) гэх товчилсон үгээр илэрхийлж болно. Зарим орчин нөхцөлд, аудитад шалгуулагч этгээдтэй хэлэлцэх нь аудитын багт “Цаг хугацаатай” байдал буюу зөвлөмжийг хэрэгжүүлэх цаг хугацааны хуваарийг тодорхой болгоход тусалж чадна.

Боловсруулсан аливаа зөвлөмж нь аудитад шалгуулагч этгээдийн удирдлагын хариуцлагуудад халдахгүйгээр, илрүүлсэн дутагдлуудын шалтгаануудыг шийдвэрлэж, аудитад шалгуулагчийн хөтөлбөр, үйл ажиллагаа болон гүйцэтгэлийг сайжруулахад тусалдаг байх ёстой. Энэ бүлэг болон 7-р бүлэгт дэлгэрэнгүй авч үзсэнчлэн, тайлангийн төсөл бичихийн өмнө боломжит зөвлөмжүүдээ аудитад шалгуулагч этгээдтэй мөн хэлэлцэж болно.

Зөвлөмж нь ихэвчлэн нотлох зүйл болон аудитын шалгуур хоорондын зөрүүг арилгахад чиглэдэг. Хэрэгжүүлэхэд тустай, үндэслэлтэй, өртөг бага шаарддаг гэдэг нь тодорхой харагдаж байгаа зөвлөмж хамгийн үр нөлөөтэй байдаг. Ийм бүтээлч зөвлөмж нь дараах шинжтэй байдаг (УДИР-3920/127-г эш болгов):

- Илрүүлсэн дутагдлууд болон асуудлуудын шалтгааныг шийдвэрлэхэд чиглэсэн;
- Практикт амжилттай хэрэгжих боломжтой;
- Үнэ цэн нэмдэг;
- Үндэслэл сайтай бөгөөд илрүүлэлтүүд болон дүгнэлтүүдийн логиктойгоор урган гарсан;
- Трюизм (илэрхий үнэн бөгөөд шинэ эсвэл сонирхолтой зүйл илэрхийлэхгүй мэдэгдэл) болон аудитын шалгуур, дүгнэлтүүдийг ердөө өөр үгээр илэрхийлсэн мэдэгдлээс зайлсхийсэн байдлаар бичигдсэн;
- Хэт ерөнхий ч биш, хэт нарийвчилсан ч биш. Хэт ерөнхий зөвлөмж нь үнэ цэн нэмэхгүй байх эрсдэлтэй бол хэт нарийвчилсан зөвлөмж нь аудитад шалгуулагч этгээдийг зохих хэмжээнд уян хатан байхыг нь хориглодог. Түүнчлэн, АДБ-ын бодлого, горимуудад

аудитад шалгагдагч этгээдэд өгсөн зөвлөмж нь АДБ-ыг хараат бус, голч аудиторууд биш, харин зөвлөхүүдээс бүрдсэн гэж харагдуулахуйц хэт дэлгэрэнгүй нарийвчилсан зааварчилгаатай байж болохгүй гэж шаардсан байж болно; мөн

- Арга хэмжээ авах хариуцлагыг хүлээн хүмүүст хаяглагдсан бөгөөд шаардлагатай арга хэмжээнүүдийг тодорхой мэдэгдсэн.

Боломжтой бол, дараах зүйлсэд анхаарна уу:

- Зөвлөмжүүдийн аль нэг нь бусдаасаа илүү тэргүүлэх ач холбогдолтой (эхэлж хэрэгжүүлэх шаардлагатай) эсэх;
- Зөвлөмжүүдийг хэрэгжүүлэхэд ямар нөөц шаардлагатай байж болох;
- Зөвлөмжийг хэрэгжүүлснээр бий болох үр өгөөж нь зөвлөмжийг хэрэгжүүлэх зардлаас их байгаа эсэх; мөн
- Зөвлөмжүүдийн мөрөөр хяналт тавих арга. Мөрөөр хяналт тавих үйл ажиллагааны тухай 8-р бүлгээс дэлгэрэнгүй үзнэ үү.

Зөвлөмж

- ✓ Аудитын үйл явцын эхэн хэсэгт боломжит зөвлөмжүүдийн талаар бодож, оролцогч талуудаас гүйцэтгэлийг сайжруулахын тулд юу хийж болох талаар үе үе асуух.
- ✓ Зөвлөмжүүд хэрэгжсэн эсэхийг АДБ-аас үнэлж болохуйц байдлаар зөвлөмжүүдийг бичих.

- ✓ Зөвлөмжүүдийг аудитад шалгуулагч этгээдтэй хэлэлцэж, шаардлагатай өөрчлөлтүүд болон зөвлөмжийг практикт амжилттай хэрэгжүүлэх аргуудыг илрүүлэх. Энэ нь зөвлөмжийг бодитоор хэрэгжүүлэхэд хөтөлнө.

Эх сурвалж: АДБОУБХС/ГАДХ-ны Хөгжлийн Баг.

Аудитын илрүүлэлтийн хүснэгт

Нотлох зүйлсээ үнэлж, дүгнэлт, зөвлөмжүүдийг боловсруулахад ашиглаж болох нэг хэрэгсэл бол 38-р зурагт үзүүлсэн аудитын илрүүлэлтийн хүснэгт юм. Энэ хэрэгсэл нь таны илрүүлэлт болон зөвлөмж хангалттай бөгөөд зохистой нотлох зүйлсэд суурилсан эсэхийг тодорхойлох боломж олгоно. Сайн боловсруулсан аудитын илрүүлэлтүүдийн хүснэгт нь мөн тайлангаа бичихэд тань тусалдаг.

Зураг 38: Аудитын илрүүлэлтүүдийн хүснэгтийн маягт

Аудитын зорилго: Аудит чухам юуны төлөө вэ гэдгийг тодорхой бөгөөд бодитой хандлагаар илэрхийлэх.

Аудитын асуулт (аудитын зохиомжийн хүснэгтэд оруулсантай адил): Аудитын асуулт (эсвэл дэд асуулт) тус бүрд, хүснэгтэд дурдсан зүйлсийг давтан ашиглана.

Илрүүлэлт	Илэрсэн нөхцөл байдал (Нөхцөл)	Аудитын гүйцэтгэлийн явцад илэрсэн хамгийн хамаарал бүхий үйл явдлууд болон тохиолдлууд.
	Шалгуур	Аудитаар шалгасан объектын хүлээгдэж буй гүйцэтгэл хангалттай байгаа, хүлээлтээс давсан байгаа, эсвэл хангалтгүй байгаа эсэхийг тодорхойлоход ашигласан мэдээлэл.
	Нотлох зүйл ба шинжилгээ	Өгөгдлийн шинжилгээний аргуудыг ашигласны эсвэл нотлох зүйлсээ үнэлсний үр дүн. Гүйцэтгэлийн үе шатанд цуглуулсан мэдээлэлтэй харьцахад ашигласан арга техникүүд болон хүрсэн үр дүнгүүдийг илтгэж болно.
	Шалтгаан	Илэрсэн нөхцөл байдлын шалтгаан. Аудитын объектын үйл ажиллагаа эсвэл зохиомжтой холбогдож болно. Удирдлагын хяналтаас гадуурх зүйл байж болно. Аливаа зөвлөмж нь шалтгаантай холбоотой байх ёстой.
	Үр дагавар	Шалтгаантай холбогдох үр дагавар болон харгалзах нотлох зүйлс. Илрүүлэлтийн хамарлын хэмжээс байж болно.
Нотлох зүйл нь хангалттай бөгөөд зохистой юу? Хэрэв тийм биш бол, аливаа зөрүүг арилгахад ямар ажил нэмж хийх шаардлагатай байна вэ?		Илрүүлэлтийн элемент тус бүрийн нотлох зүйлсийг харгалзан үзэж, хангалттай бөгөөд зохистой эсэхэд нь анхаарна. Одоо байгаа нотлох зүйл тань элемент тус бүрд хангалттай бөгөөд зохистой биш байвал, нотлох зүйлд буй аливаа зөрүүг арилгахын тулд ямар ажил нэмж хийх шаардлагатай байна вэ?
Сайн туршлагауд		Сайн гүйцэтгэлд хөтлөх илрүүлсэн арга хэмжээнүүд. Зөвлөмжүүдийг дэмжиж болно.
Зөвлөмжүүд		Илрүүлсэн шалтгаануудыг (эсвэл дутагдлуудыг) шийдвэрлэх саналууд.

Эх сурвалж: АНУ-ын ТХГ болон Бразил улсын АДБ-ын мэдээллийг эш болгов.

39-р зурагт гүйцэтгэлийн аудитын илрүүлэлтийн хүснэгтийн илрүүлэлтийн нэг жишээг үзүүлэв.

Зураг 39: Аудитын илрүүлэлтийн хүснэгтийн илрүүлэлтийн нэг жишээ

Аудитын зорилго: Америкийн Нэгдсэн Улсад хүсээгүй бэлгийн харилцаа буюу бэлгийн хүчирхийлэл өндөр, тэр дундаа их сургуулийн оюутнууд, засан хүмүүжүүлэх газрын хүмүүжигчид болон цэргийн албан хаагчдын дунд өндөр байгаа асуудлыг шалгах.

Аудитын асуулт: Бэлгийн хүчирхийллийн талаарх өгөгдөл цуглуулах одоогийн хүчин зүтгэл харилцан адилгүй байгаагийн улмаас үүссэн аливаа сорилтыг засгийн газрын агентлагууд хэр хэмжээнд шийдвэрлэж байна вэ?

Илрүүлэлт	Илэрсэн нөхцөл байдал (Нөхцөл)	Бэлгийн хүчирхийллийн талаарх өгөгдөл цуглуулах ажлын харилцан адилгүй байдлыг бууруулах агентлагуудын хүчин зүтгэл нэгдмэл биш бөгөөд хамрах хүрээний хувьд хязгаарлагдмал байна.
	Шалгуур	Үндэсний Статистикийн Хорооны Холбооны Статистикийн Агентлагийн Зарчмууд болон Практикууд-д ялгаатай эрхэм зорилгоор нэгэн ижил холбооны хэмжээний статистик гаргадаг холбооны агентлагуудад дараах шаардлагуудыг тавьсан байдаг: (1) Одоогийн мэдээллийн хэрэгцээг хангахын тулд уялдаатай, хамтран ажиллах; мөн (2) Ганц тогтолцоогоор бий болгож чадах өгөгдлөөс илүү шинэ эсвэл илүү хэрэгтэй өгөгдөл бий болгох.
	Нотлох зүйл ба шинжилгээ	Өгөгдөл цуглуулах хүчин зүтгэлүүдийн уялдааг нэмэгдүүлэхэд чиглэсэн таван агентлагийн хүчин зүтгэл байна. Эдгээр хүчин зүтгэлүүдийн зохицуулалт нь хоёр талт (ерөнхийдөө өгөгдөл цуглуулах арван хүчин зүтгэлээс нэг удаад хоёрыг хамруулж байдаг) бөгөөд хамрах хүрээ нь хязгаарлагдмал байна.
	Шалтгаан	Удирдлага болон Төсвийн Газраас бэлгийн хүчирхийллийн талаарх өгөгдлийг уялдуулах агентлаг дундын бүлгийг байгуулахаар төлөвлөдөггүй. Тэд оронд нь Үндэсний Гэмт Хэргийн Хохирогчдын Судалгааг дахин зохиомжлох зэрэг өөр бусад тэргүүлэх зорилгуудад төвлөрөхөөр төлөвлөдөг гэж мэдэгдсэн.
	Үр дагавар	Бэлгийн хүчирхийллийн талаарх өгөгдөл нэгэн жигд бус, тохиромжгүй байгаа бөгөөд өгөгдлийн талаар буруу ойлголт байна. Америкийн Нэгдсэн Улсад бэлгийн хүчирхийллийн цар хүрээний талаарх ойлголт дутмаг байна.
	Нотлох зүйл нь хангалттай бөгөөд зохистой юу? Хэрэв тийм биш бол, аливаа зөрүүг арилгахад ямар ажил нэмж хийх шаардлагатай байна вэ?	Тийм.
Сайн туршлагууд	Байхгүй.	
Зөвлөмжүүд	Өгөгдөл цуглуулах хүчин зүтгэлүүд харилцан адилгүй байгаад анхаарч, Америкийн Нэгдсэн Улс дахь бэлгийн хүчирхийллийн талаарх ерөнхий ойлголтод аль хүчин зүтгэл нь сайнаар эсвэл муугаар нөлөөлж байгааг үнэлдэг бэлгийн хүчирхийллийн статистикийн агентлаг дундын бүлгийг байгуулах нь зүйтэй гэсэн зөвлөмжийг Удирдлага болон Төсвийн Газрын Захиралд хүргүүлэв.	

Эх сурвалж: АНУ-ын ТХГ-ын мэдээллийг эш болгов.

Тайлангийн төслийг бичихэд хэрхэн бэлдэх вэ?

АДБ-ын дотоодод хэлэлцэх

Илрүүлэлт, дүгнэлт, зөвлөмжүүдээ боловсруулсны дараа, илрүүлэлтүүдээ тайлбарлаж, онцлохыг хүссэн гол мессежнүүд болон сэдвүүдээ сайжруулж, тайлангийн төсөл бичихэд бэлдэх талаар АДБ-ын дотоодод нэгдсэн ойлголттой болох хэрэгтэй. Гүйцэтгэлийн аудит дээр ажилласан бүх аудитор, дотоод оролцогч талууд болон менежерүүдийг хамруулсан уулзалт хийж, аудитын илрүүлэлтүүдийн талаар нэгдсэн ойлголттой болоход анхаарах хэрэгтэй. Эсвэл, аудитын ажлаа үргэлжлүүлэх явцдаа шинээр гарч ирсэн илрүүлэлтүүдийг аудитын багийн гишүүд, дотоод оролцогч талууд болон менежерүүдтэйгээ хэлэлцдэг байж болно.

Аудитын илрүүлэлтүүдийнхээ талаар нэгдсэн ойлголтод хүрч, тайлангийн төслөө бичихэд бэлдэхийн тулд, аудитын баг нь аудитын бүх асуултынхаа илрүүлэлтүүдийг хэлэлцэж, хариулт бүрийн нотлох зүйлийн баттай байдал болон найдвартай байдалд анхаарч, нотлох зүйлд агуулагдаж буй аливаа хоёрдмол утга болон тодорхойгүй байдлыг илрүүлж, шийдвэрлэх хэрэгтэй. Аливаа тодорхойгүй байдлын хувьд, нэмэлт нотлох зүйл цуглуулах шаардлагатай болж магадгүй.

Шалгагдагч этгээдтэй хэлэлцэх

Тайлангийн төсөл бичиж эхлэхийн өмнө сүүлийн алхам болгож, аудитад шалгагдагч этгээдтэй харилцаж, аудитын илрүүлэлтүүдээ хэлэлцэх нь чухал. Энэ нь аудитад шалгагдагч этгээдийн харах өнцөг болон таныг нотлох зүйлсээ цуглуулснаас хойш өрнөсөн аливаа арга хэмжээнд үндэслэн ямар нэгэн сайжруулалт хийх шаардлагатай эсэхийг тогтооход тусална. Та судалгааныхаа явцад аудитад шалгагдагч этгээдтэй ойр харилцаатай байсан бол, гэнэтийн үйл явдал болох магадлал бага байх тул, энэ алхам харьцангуй хялбар байх болно.

Аудитад шалгагдагчийн анхны хариу үйлдлийг ашиглаж дараах зүйлсийг хийж болно:

- Таны дүгнэлтүүд үндэслэлтэй эсэхийг хэмжих;
- Шаардлагатай бол нэмэлт нотлох зүйл хүсэх;
- Аудитын илрүүлэлтүүдийн төсөлд байж болох аливаа баримтын алдааг илрүүлж, залруулах;
- Аудитад шалгагдагчийн үзэл бодлыг тусгахын тулд аудитын илрүүлэлтүүдийн төсөлд шинэ материал нэмэх; мөн
- Аливаа зөвлөмжийг сайжруулах (илүү тодорхой, хэрэгжих боломжтой болгосноор аудитад шалгуулагч этгээдийн зөвлөмжийг хэрэгжүүлэх магадлалыг нэмэгдүүлэх).

Аудитад шалгуулагч этгээдтэй дээрх хэлэлцүүлгүүдийг хийж, нэмэлт нотлох зүйлс хүлээн авсныхаа дараа хараат бус байдал болон мэргэжлийн үнэлэмжийг баримтлангаа, тайлангийн төсөлдөө зохих өөрчлөлтүүдийг оруулах хэрэгтэй. Өөрчлөлт оруулах нь муу зүйл биш бөгөөд өндөр чанартай тайлан гаргах үйл явцын нэг хэсэг юм. Харин уг өөрчлөлтүүд нь бүгд сайн чанартай нотлох зүйлсэд тулгуурласан байх нь нэн чухал.

Аудитын илрүүлэлт, дүгнэлт, зөвлөмжүүдийг боловсруулах үед, дараахыг санагтун:

- ✓ Анхны эрсдэлийн үнэлгээгээ цуглуулсан нотлох зүйлстэйгээ уялдуулан үзэж, аудитын ажил нэмж хийх шаардлага байгаа эсэхийг тогтоох;
- ✓ Нотлох зүйлс болон цуглуулсан өгөгдлөө системтэйгээр, сайтар шинжилж, аудитын илрүүлэлтүүдээ аудитын зорилго(ууд) болон аудитын асуултуудтай холбогдож, хариулт өгч чаддаг болгох;
- ✓ Аудитын илрүүлэлтүүдээ бодитой, шударга бөгөөд тэнцвэртэй болгож, хараат бус байдлаа хадгалангаа сайн болон муу талуудыг хоёуланг нь дурдаж, зохих тохиолдолд аудитад шалгуулагч этгээдийг сайншаах;
- ✓ Илрүүлэлтүүдийнхээ материаллаг байдалд анхаарч, уг илрүүлэлтүүд нь аудитад шалгуулагчийн гүйцэтгэлд хэрхэн нөлөөлөхийг тооцохдоо мэргэжлийн үнэлэмжээ ашиглах;
- ✓ Шалгуур болон нотлох зүйл хооронд үл тохирол илэрсэн бол, шалтгаан буюу яагаад шалгуураас хазайх болов гэдгийг шинжилж, батлах;
- ✓ Шалгуур болон нотлох зүйл хооронд үл тохирол илэрсэн бол, эерэг болон сөрөг үр нөлөөг нь тодорхойлох;
- ✓ Боловсруулсан аливаа дүгнэлт, зөвлөмжүүдээ аудитын илрүүлэлтүүдээс логиктойгоор урган гарсан, тэнцвэртэй бөгөөд үндэслэлтэй байлгах; мөн
- ✓ Урьдчилсан илрүүлэлтүүд, мөн дүгнэлтүүд болон зөвлөмжүүдээ аудитад шалгуулагч этгээдэд мэдэгдэж, хэлэлцэх.

Эх сурвалж: АДБОУБХС/ГАДХ-ны Хөгжлийн Баг.

7-р бүлэг

Гүйцэтгэлийн аудитын тайланг хэрхэн бичих вэ?



Энэхүү бүлэгт гүйцэтгэлийн аудитын тайланг хэрхэн бэлтгэж, тайлангийн төсөл бичихийг тайлбарлах болно. Гүйцэтгэлийн аудитын тайлангийн зорилго нь аудитын үр дүнгүүдийг хууль тогтоох засаглал, аудитад шалгагдагч этгээд болон олон нийтэд мэдээлэхэд оршдог. Хэвлэмэл тайлан гаргасан ч, эсвэл зөвхөн цахим хэлбэрээр тайлан гаргасан ч, нэгэн адил дээд түвшний зарчмуудыг дагаж мөрдөх ёстой.

- Тус бүлэг нь дараах асуултуудад хариулах болно:
- Гүйцэтгэлийн аудитын тайланг хэрхэн боловсруулах вэ?
- Гүйцэтгэлийн аудитын тайлангийн үндсэн шинж чанарууд юу вэ?
- Тайлангийн логик бүтцийг хэрхэн үүсгэх вэ?
- Тайланг хэрхэн чанартай байлгах вэ?
- Аудитад шалгуулагч этгээд эсвэл гуравдагч талын саналыг хэрхэн авч үзэх вэ?
- Хэрхэн эцсийн тайланг нийтэлж, аудитын үр дүнгүүдийг түгээх вэ?

Гүйцэтгэлийн аудитын тайланг хэрхэн боловсруулах вэ?

Аудитын сайн тайлан нь аудитын асуултуудын материаллаг илрүүлэлтүүд болон дүгнэлтүүдийг тодорхой бөгөөд бодитой байдлаар танилцуулж, шаардлагатай тохиолдолд практикт амжилттай хэрэгжих боломжтой зөвлөмжүүдээр хангадаг. Тайлан нь зорилтот уншигчдад хялбархан ойлгогдохуйц буюу аудитыг гүйцэтгэхийн тулд юу хийсэн, яагаад хийсэн, хэрхэн хийсэн гэдгийг хялбархан ойлгуулахуйц байх ёстой. Зорилтот уншигчид нь мөн аудитын сэдвийн хам нөхцөлийг ойлгох боломжтой байх хэрэгтэй.

АДБ аудитын тайлангийн төсөл бичих даалгаврыг хуваарилахад өөр өөр арга хандлага ашигладаг. Заримд АДБ энэ ажлыг аудитын багийн гишүүдэд хувааж өгдөг байхад бусад нь тайлангийн төслөөр мэргэшсэн багийн гишүүдтэй байдаг. Тайлангийн төсөл бичих хүн нь аудитын нотлох зүйл цуглуулсан хүн биш байх нь бий. Аудитын илрүүлэлт тус бүрийг хаана нь оруулахыг харуулсан тайлангийн тодорхой бүтэц үүсгэсэн тохиолдолд төсөл бичих үйл явц саадгүй бөгөөд алдаа гарах эрсдэл багатай болно.

Хэрэв нэгээс олон хүн төслийг бичих бол, нийт тайланг хэлбэр загвар болон утга илэрхийлэмжийн хувьд нэгэн жигд болгохын тулд хангалттай мадаглуулах хэрэгтэй. Хянагчаараа тайлангийн төслийг нягтлуулж, нотлох зүйл эсвэл логик нь сул газар байгаа эсэхийг шалгуулах хэрэгтэй. Түүнчлэн, нотлох зүйлс болон логик нь дүгнэлтүүдийг илэрхий сайн дэмжиж байгаа эсэхийг багийн гишүүн биш хүнээр нягтлуулах талаар бодолцож үзэж болно. Багийн гишүүн биш хүний нягталгаа нь мөн тодорхой байдал болон хараат бус байдлыг хангахад тусалж болно.

Гүйцэтгэлийн аудитын тайлангийн үндсэн шинж чанарууд юу вэ?



Стандарт

Аудитор нь бүрэн цогц, үнэмшилтэй, цаг үеэ олсон, уншигчдад ээлтэй, тэнцвэртэй аудитын тайлан гаргахыг зорих хэрэгтэй.

Эх сурвалж: АДБОУС-300/32.

Тайлан бичихдээ гүйцэтгэлийн аудитын тайлангийн таван шинж чанарыг санах хэрэгтэй. Эдгээр шинж чанарууд нь гүйцэтгэлийн аудитын тайлан ямар ч бүтэцтэй байсан, агуулагдах ёстой. Дэлгэрэнгүй удирдамжийг УДИР-3920/108-124-өөс үзэж болно.

Бүрэн цогц

Тайланд аудитын зорилго болон аудитын асуултуудыг шийдвэрлэх шаардлагатай бүх мэдээлэл болон аргументыг оруулж, бүрэн цогц болгох нь чухал. Ингэхдээ, судлах сэдэв/зүйл болон аудитын илрүүлэлт, дүгнэлтүүдийг ойлгогдохуйц хэмжээнд тайланг хангалттай нарийн дэлгэрэнгүй бичих ёстой (АДБОУС-3000/117). Хамгийн чухал нь, аудитын зорилго(ууд)тай холбогдох илрүүлэлт, дүгнэлт, зөвлөмжүүдийг дэмжих хангалттай бөгөөд зохистой нотлох зүйлсийг тайландаа оруулах хэрэгтэй (УДИР-3920/114). Эдгээр элементүүдийг энэ бүлэгт илүү дэлгэрүүлэн авч үзнэ.

Үнэмшилтэй

Тайланд орсон дүгнэлт, зөвлөмжүүдэд хөтлөх таны аргумент уншигчийг үнэмшүүлэх ёстой. Үнэмшилтэй байхын тулд, гүйцэтгэлийн аудитын тайлан нь логик бүтэцтэй бөгөөд аудитын зорилго(ууд) болон асуултууд, аудитын шалгуурууд, мөн аудитын илрүүлэлт, дүгнэлт, зөвлөмжүүд хоорондын хамаарлыг тодорхой толилуулсан байх шаардлагатай. 6-р бүлэгт хангалттай бөгөөд зохистой нотлох зүйлсэд үндэслэн илрүүлэлтүүдээ боловсруулах талаар дэлгэрэнгүй тайлбарласан байгаа. Аудитын тайлан нь мөн аудитын илрүүлэлтүүдийг ятган

үнэмшүүлэх байдлаар толилуулсан, хэлэлцүүлэгт хамаарах бүх аргументад хариулсан бөгөөд үнэн зөв байх хэрэгтэй. Үнэн зөв байхын тулд аудитын нотлох зүйлс, илрүүлэлтүүд болон дүгнэлтүүдийг төвийг сахисан бөгөөд баримтад суурилсан байдлаар толилуулах шаардлагатай. (АДБОУС-3000/118)

АДБ нь гүйцэтгэлийн аудитын үнэмшилтэй тайлан гаргахыг зорихдоо хоёр үндсэн зорилгыг тавьдаг:

- **Логиктой байх.** Дүгнэлтүүд болон зөвлөмжүүдэд хөтлөх аргументын логикийг зураглах ёстой. Аудитын шалгуур – илрүүлэлтүүд – дүгнэлтүүд болон зөвлөмжүүд хооронд тодорхой уялдаа холбоо байх хэрэгтэй.
- **Үнэн зөв байх.** Үнэн зөв бус тайлан нь АДБ-ын итгэл хүлээх байдалд хохирол учруулж болно. Тайланд орсон үнэн зөв бус ганц мэдээлэл нь нийт тайлангийн (эсвэл бүр АДБ-ын) хүчин төгөлдөр байдалд эргэлзэх эргэлзээ үүсгэж, анхаарлыг тайлангийн уг чанараас холдуулж болно.

Цаг үеэ олсон

Удирдлагууд, засгийн газар, хууль тогтоох засаглал болон бусад сонирхогч талуудад хэрэгтэй мэдээллийг бэлэн байлгахын тулд гүйцэтгэлийн аудитын тайлан цаг хугацаандаа гарах шаардлагатай (АДБОУС-3000/119). Зарим тохиолдолд, АДБ аливаа шинэ хөтөлбөрийн эхэн үед тайлан гаргахаар шийдэж болно. Ингэхдээ хөтөлбөрийн ахицыг хожим дахин үнэлэхээр төлөвлөдөг.

Аудитын тайлан нь аудитад шалгагдагч этгээдэд сайжруулалт бий болгохыг зорьдог. Уг сайжруулалт нь шалгагдагч этгээдийг зорилгууддаа илүү үр ашигтай эсвэл үр нөлөөтэй байдлаар хүрэх боломж олгох учиртай.

Уншигчдад ээлтэй

АДБ нь бодитой, баримтад суурилсан мэдээллийг энгийн, тодорхой байдлаар, бүх оролцогч талууддаа ойлгогдох үг хэллэг ашиглан тайлагнах хэрэгтэй (АДБОУБ-3-12/Зарчим 4). Ялгаатай улс орнууд болон соёлуудад харилцааны хэв маяг болон зохист байдал өөр өөр байж болох ч, тайлангийн утга илэрхийлэмжийг үргэлж мэргэжлийн бөгөөд төвийг сахисан байлгахыг зорино уу.

Тайлан нь товч байх хэрэгтэй ч, хангалттай нотлох зүйлсийг агуулах шаардлагатай (энэ бүлгийн эхэн хэсэгт авч үзсэн бүрэн цогц байдлыг үзнэ үү). Товч байлгаснаар тайлангийн хэмжээг шаардлагатай хэмжээнээс ихгүй байлгаж, тодорхой байдлыг нэмэгдүүлж, тайлангийн мессежийг илүү үр нөлөөтэй хүргэхэд тусалдаг (АДБОУС-3000/120). Хэдий сайн бичигдсэн байсан ч, урт тайлан нь уншигчдыг айлгаж эсвэл урмыг нь мохоож болох талтай. Урт тайлан бичихээс өөр аргагүй тохиолдолд, та хавсралтууд ашиглах эсвэл үндсэн санаануудыг нь агуулсан хураангуйг тусад нь нийтлэх талаар бодолцож үзэж болох юм.

Уншигчдад ээлтэй тайлан гаргахын тулд, уншигчдаа танин мэдэж, хэрэгцээ шаардлагыг нь ойлгож, тэр ёсоор тайлангаа бичих хэрэгтэй (УДИР-3920/120). Өмнө авч үзсэнчлэн, аудитын багаас гадуурх уншигчдыг ашиглаж тайланг ойлгоход хялбар байгаа эсэхийг

шалгаж болно. Мөн бичвэрийнхээ нарийн төвөгтэй байдалд суурь үнэлгээ хийлгэхийн тулд энгийн автоматжуулсан уншигдах байдлын шинжлэгчийг ашиглаж болно. Ийм хэрэгсэл нь өгүүлбэрийн дундаж урт болон үгийн сангийн нарийн төвөгтэй байдал зэрэг үзүүлэлтийг ашиглаж, тайланг ойлгоход шаардлагатай уншигчийн түвшнийг санал болгодог. Энэ төрлийн хэрэгслийг нээлттэй эх сурвалжаас эсвэл бичвэр боловсруулах программ хангамж дээрээс ашиглаж болно.

Уншигчдад ээлтэй

- ✓ Урт өгүүлбэрийн оронд богино өгүүлбэр ашиглах.
- ✓ Энгийн бүтэцтэй өгүүлбэр ашиглах (хамгийн энгийн нь өгүүлэгдэхүүн-тусагдахуун-өгүүлэхүүн).
- ✓ Үйл үгийн өөрөө үйлдэх хэвийг ашиглах.
- ✓ Бичвэрээ гарчиг, дэд гарчгуудаар зааглах.
- ✓ Бичвэр агуулаагүй зураглал, дүрслэлүүдийг ашиглах (зураг, үзүүлэн, бүүдүүвч, график, зураглал гэх мэт).
- ✓ Нарийн мэргэжлийн үг болон нарийн төвөгтэй, ховор ашиглагддаг үгнээс зайлсхийх.
- ✓ Эш татан холбох болон товчилсон үгсийг хэт их ашиглахаас зайлсхийх.

Эх сурвалж: АДБОУБХС/ГАДХ-ны Хөгжлийн Баг.

Уншигчдад ээлтэй байх бас нэгэн арга бол тайлангийн туршид график буюу дүрслэл ашиглах арга юм. Мэдээллийг дүрслэн үзүүлэх нь уншигчдад нарийн төвөгтэй ухагдахуунуудыг, эсвэл санаанууд өөр хоорондоо хэрхэн холбогдож байгааг хурдан ойлгоход тусалдаг. Түүнчлэн, үйл явцууд болон үйл явдлуудыг олон үгээр тайлбарлах шаардлагыг арилгадаг. Судлах сэдэв/ зүйлтэй холбоотой байвал, гэрэл зургийг мөн ашиглахад тустай байдаг. Завгүй уншигчийн хувьд дүрслэл их агуулсан тайланг унших нь хялбар санагдах болно. 40-р зурагт гүйцэтгэлийн аудитын тайланд дүрслэл ашиглах жишээг үзүүлэв.

Зураг 40: Гүйцэтгэлийн аудитын тайланд мэдээллийг зураглан үзүүлсэн жишээ


АНУ-ын зорчигчдын нислэгт үндэслэсэн АНУ-ын нисэх буудлуудын арилжааны нисэх буудлын ангилал (2017)

Арилжааны нисэх буудлын ангилал	Жилийн нийт зорчигчдын шаардлагатай доод хувь хэмжээ	Жилийн зорчигчдын нислэг, нисэх буудлын ангиллаар		Нисэх буудлуудын тоо
		Хувь	Тоо	
Том "hub"-ын	1% ба түүнээс их	72.0%	617,598,283	30
Дунд "hub"-ын	Багадаа 0.25%, гэхдээ 1%-аас ихгүй	16.2%	138,949,064	31
Жижиг "hub"-ын	Багадаа 0.05%, гэхдээ 0.25%-аас ихгүй	8.3%	71,157,137	70
"Hub"-ын бус	10,000-аас их, гэхдээ 0.05%-аас бага	3.4%	28,881,284	255
Үндсэн бус арилжааны үйлчилгээ	Багадаа 2,500, гэхдээ 10,000-аас ихгүй	0.1%	627,545	125

Эх сурвалж: Холбооны Нисэхийн Захиргааны 2017 оны нислэгийн өгөгдөлд хийсэн ТХГ-ын шинжилгээ, НИСЭХ БУУДЛЫН ДЭД БҮТЭЦ:

Жич: "Hub" (хаб) гэдэг нэр томъёог холбооны хуульд арилжааны нисэх буудлуудыг зорчигчдын хувь хэмжээгээр нь ангилахад ашигладаг бөгөөд нисэх буудлуудыг дөрвөн "hub"-ын ангилалд оруулдаг. (49 US Code Sections 40102 (29), (31), (34) and (42).)

Хүүхдийн хүчирхийллийн мэдэгдсэн тохиолдол (биеийн, бэлгийн эсвэл сэтгэл зүйн эсвэл үл хайхрах), Батлан Хамгаалахын Яамны (БХЯ) хүчирхийллийн шалгуураар, 2014-2018 оны санхүүгийн жилүүд



Эх сурвалж: Гэр бүлийн өмгөөллийн хөтөлбөрийн өгөгдөлд хийсэн ТХГ-ын шинжилгээ, ХҮҮХДИЙН САЙН САЙХАН БАЙДАЛ: Хүүхдийн хүчирхийллийг тандан судалж, хариу арга хэмжээ авах БХЯ-ны үйл ажиллагааг сайжруулахад илүү их чиглүүлэг болон хамтын ажиллагаа шаардлагатай байна, 2020, ТХГ-20-110.

Уншигчдад ээлтэй байхын бас нэгэн чухал бүрэлдэхүүн бол хүртээмжтэй байдал юм. Уншигчид өөрсдөд нь хамааралтай тодорхой асуудлыг хөндсөн гэж үзсэн үедээ тайланд илүү их итгэдэг. Тухайлбал, улсын ялгаатай хэсгүүдэд ялгаатай нөлөөлөл үзүүлж буй хөтөлбөрт аудит хийсэн бол газрын зураг болон бусад графикийг ашиглаж, уг ялгаатай бүс нутгуудад эсвэл нийгмийн ялгаатай хэсгүүдэд нөлөөлөх ялгаатай нөлөөллийг харуулж болно.

Тэнцвэртэй

Тэнцвэртэй байна гэдэг нь гүйцэтгэлийн аудитын тайлан агуулга болон утга илэрхийлэмжийн хувьд голч чанартай байхыг хэлнэ. Аудитын бүх нотлох зүйлийг нэг талыг бариагүй байдлаар толилуулж, эерэг болон сөрөг илрүүлэлтүүдийг хоёуланг нь тайлагнах хэрэгтэй. Аудиторууд ихэнхдээ сайжруулалт хийх зөвлөмжид хөтлөх асуудлуудад төвлөрөх хандлагатай байдаг. Ийм асуудлуудын нөлөөллийг тайлбарлах нь уншигчдад асуудлуудын ач холбогдлыг сайн ойлгоход тусалж, залруулах арга хэмжээг эрчимжүүлдэг (УДИР-3920/123). Энэ үйл явц хэдий чухал боловч, аудитын сэдэв эсвэл үйл ажиллагааны цогц зураглалыг ойлгуулах нь мөн адил чухал юм. Хэрэв аудитад шалгуулагч этгээд ямар нэгэн зүйлийг сайн хийж байвал, түүнийг нь сайжруулалт шаардлагатай байгаа талбаруудын хамт тайлагнах хэрэгтэй. Аудитад шалгуулагч этгээдийн дутагдалтай гүйцэтгэлийг хэт дэвэргэж, хэт онцлох эрсдэлээс болгоомжилно үү. (АДБОУС-3000/121)

Тэнцвэр

- ✓ Илрүүлэлтүүдийг бодитой бөгөөд шударгаар, төвийг сахисан нэр томъёо ашиглан толилуулах ба аудитад шалгуулагч этгээдийн зүгээс өөрийгөө хамгаалах эсвэл аудитыг эсэргүүцэх байдал үүсгэхэд хүргэж болох нэг талыг барьсан мэдээлэл болон үг хэллэгээс зайлсхийх хэрэгтэй.
- ✓ Сэдвийн талаарх ялгаатай харах өнцгүүд болон үзэл бодлуудыг толилуулах хэрэгтэй.
- ✓ Бүрэн гүйцэд байх хэрэгтэй. Эерэг зүйлс болон сайжруулалт шаардлагатай зүйлсийг хоёуланг нь оруулах хэрэгтэй. Зохих тохиолдолд сайшаадаг байх хэрэгтэй. Эерэг талуудыг оруулснаар тайланг ашигласан бусад төрийн байгууллагын гүйцэтгэл сайжрахад хүргэж болно.
- ✓ Баримт фактыг дарагдуулах ёсгүй. Багахан дутагдлыг дэвэргэх хэрэггүй.

Эх сурвалж: УДИР-3920/124.

Тайлангийн логик бүтцийг хэрхэн үүсгэх вэ?

Үндсэн таван шинж чанарыг харгалзаж үзэнгээ, аудитын илрүүлэлт, дүгнэлт, зөвлөмжүүдээ уншигчдад мэдээлэх логиктой тайлангийн бүтцийг үүсгэх хэрэгтэй. Зарим тохиолдолд, аудитын асуултууд нь аудитын тайлангийн нэг нэг бүлэг болж чадахуйц эмх цэгцтэй байдаг. Гэхдээ, бүх тохиолдол ийм байхгүй. Тухайлбал, хоёр тусдаа аудитын асуултын илрүүлэлтүүд харилцан хамааралтай байвал, тэдгээрийг нэг бүлэгт хамтатган толилуулах нь зүйтэй. Бусад тохиолдолд, ялгаатай илрүүлэлтүүдийн материаллаг байдалд эсвэл үйл явдлуудын цаг хугацааны дараалалд үндэслэн тайлангийн бүтцийн логик дэс дарааллыг сонгож болно.

Ямар бүтцийг сонгосноос үл хамааруулан, тайланг бичиж эхлэхийн өмнө эхлээд ерөнхий логик бүтцийг нь зураглаж үзэх нь тустай байдаг. Энэ арга хандлага нь тайлангийн логик уялдааг сайжруулж, агуулгыг шаардлагагүй давхардуулах эрсдэлийг бууруулна. Үр нөлөөтэй бүтэц нь уншигчийн анхаарлыг татаж, нарийн төвөгтэй асуудлуудыг тодорхой мэдээлж, үр дүнгүүдийг тодорхой ойлгуулдаг (УДИР-3920/121). Мөн, уншигчдад аудитын судлах сэдэв/ зүйлийг ойлгоход хэрэг болох хам нөхцөл (хам сэдэв) болон суурь мэдээллийг тайланд хангалттай оруулах хэрэгтэй. Тухайлбал, уншигч аудитын сэдэвт

оролцдог талуудын үүрэг, хариуцлага, зарцуулсан мөнгөний хэмжээ болон аудит хийж буй талбар дахь засгийн газрын зорилгуудыг ойлгох шаардлагатай байж болно.

АДБ болон аудитын ажлаас хамаараад тайлан нь олон төрлийн хэлбэр, форматтай байж болно. Тайлангийн зохистой бүтцийг боловсруулахдаа уншигчдаа санаж байх хэрэгтэй. Зарим АДБ уншигчдад ээлтэй тайлангийн бүтэц үүсгэхдээ “Үдшийн цайллага” гэдэг арга хандлагыг ашигладаг. Үдшийн цайллага гэдэг арга хандлагын хувьд, та зочдодоо зориулж үг хэлж байгаа бөгөөд анхаарлыг нь өөр дээрээ төвлөрүүлэх богинохон хугацаа оногдсон гэж төсөөлдөг. Аудитынхаа явцад илрүүлсэн зүйлсээс зочдодоо хэлэх хамгийн гол зүйлс нь юу байх вэ? Энэхүү сонирхолтой дүгнэлтийг гаргасныхаа дараа, уг дүгнэлтүүдээ дэмжих нарийн мэдээллүүдийг өрж эхэлж болно. (УДИР-3920/121)

Доор тайлангийн нийтлэг сегментүүдийг авч хэлэлцэв.

Гарчиг

Сайн гарчиг нь тайлангийн сэдвийг (эсвэл мессежийг) ойлгуулдаг. Мессежинд чиглэсэн зарим гарчгийн хувьд, гарчиг нь өөрөө зөвлөмжүүдийг хөндөж байдаг:

- **Тайлбарласан шинжтэй гарчгийн жишээ:** *Арилжаанд суурилсан мөнгө угаалттай тэмцэх АНУ-ын хүчин зүтгэл* (ТХГ-20-314R).
- **Мессежинд чиглэсэн гарчгийн жишээ:** *Кибер аюулгүй байдлын удирдлага болон хяналтын сул талыг шийдвэрлэх шаардлагатай байна* (ТХГ-20-199)

Та мөн гарчиг дотор аудитад шалгуулагч этгээдийн нэрийг дурдах эсэхээ шийдэж болно. Тухайлбал, танай тайлан олон өөр яамдын ажлыг хамруулж байгаа бол, тайлангийн гарчгаа товч байлгах үүднээс нэрсийг нь дурдахгүй орхиж болно.

Аудитын тайлангийн гарчиг

Хариуцагч этгээдийн нэргүй

Канад улсын кибер аюулын эсрэг гол дэд бүтцийг хамгаалах нь (Канад Улсын Ерөнхий Аудиторын 2012 оны тайлан)

Хариуцагч этгээдийн нэртэй

Дотоодын Орлогын Яам: Хүүхдийн халамжийн өрийг удирдах нь (Шинэ Зеланд Улсын Ерөнхий Аудиторын 2010 оны тайлан)

Эх сурвалж: УДИР-3920/124.

Агуулгын хүснэгт

Агуулгын хүснэгтийг сайн боловсруулснаар тайлангийн бүтцийг тодорхой харуулж, уншигчдад сонирхсон хэсгээ хялбар олох боломж олгодог. Үүнд зориулсан арга хандлагуудын нэгийг 41-р зурагт үзүүлэв.

Зураг 41: Асуултад суурилсан гарчиг ашигласан агуулгын хуудас

Гарчиг	Хуудас
Хураангуй ба зөвлөмжүүд	7
Үндсэн мэдээлэл	7
Дүгнэлт	8
Дэмжих илрүүлэлтүүд	8
Зөвлөмжүүд	10
Шалгуулагч этгээдийн хариултын хураангуй	10
Австрали Улсын засгийн газрын бүх байгууллагад зориулсан аудитын гол мессежнүүд	11
Аудитын илрүүлэлтүүд	13
1. Үндсэн мэдээлэл	
Австрали Улсын Татварын Газрын (АУТГ) жижиг бизнесүүдэд зориулсан нийцэл, зөрчил болон өр цуглуулах үйл ажиллагаанууд	14
Аудит хийх үндэслэл	14
Аудитын арга хандлага	19
2. Жижиг бизнесүүдийн татварын өрийг удирдах зохион байгуулалтын зохицуулалт	
АУТГ-т жижиг бизнесүүдийн өрийн үр нөлөөтэй удирдлагыг дэмжих стратегиуд болон үйл явцууд байдаг уу?	19
АУТГ-т жижиг бизнесүүдийн нийцэл, зөрчил, өрийн үйл ажиллагааг зохицуулах үр нөлөөтэй үйл явцууд байдаг уу?	21
АУТГ жижиг бизнесүүдэд зориулсан өрийн стратегиуд болон үйл явцуудад өөрчлөлт оруулахдаа олон улсын сайн туршлага, оролцогч талуудын үзэл бодол болон тасралтгүй сайжруулалтыг ашигладаг уу?	21
3. Жижиг бизнесийн өрийн тууштай удирдлага	
АУТГ-т өрийн асуудалд илүү хатуу чанд, хүчтэй арга хэмжээг тууштай авахыг дэмждэг үйл явцууд байдаг уу?	28
АУТГ-т жижиг бизнесүүдийн татварын өрийн асуудалд авах тууштай арга хэмжээг илүү хатуу чанд, хүчтэй байлгах үр нөлөөтэй хяналт байдаг уу?	36
4. Гүйцэтгэлийн хяналт-шинжилгээ ба тайлагнал	
Нийцлийн үйл ажиллагааны улмаас үүссэн татварын өр зэрэг жижиг бизнесүүдийн татварын өрийг үр нөлөөтэй хянан-шинжилж, тайлагнадаг уу?	39
АУТГ-т нийцлийн үйл ажиллагааны улмаас үүссэн татварын өр зэрэг жижиг бизнесүүдийн татварын өрийг үр нөлөөтэй, үр ашигтай бөгөөд нийцтэй байдлаар барагдуулах гүйцэтгэлийн сайн хүрээ байгаа юу?	44
Хавсралтууд	
1-р хавсралт: Австрали Улсын Татварын Газрын хариу	54
2-р хавсралт: АУТГ-ын илүү чанга, илүү хүчтэй арга хэмжээнүүд	58
3-р хавсралт: Эй Би Си телевизийн "Four Corners" сурвалжилгаар хөндсөн асуудлууд	69
4-р хавсралт: АУТГ-ын чанарын арга хэмжээнүүд ба индикатор	70

Эх сурвалж: Жижиг бизнесийн татварын өрийн удирдлага, Австрали улсын УАГ, 2019.

41-р зурагт, АДБ нь аудитын илрүүлэлтүүдийг толилуулсан хэсэгт асуулт хэлбэрийн гарчиг ашигласан байна. Зарим АДБ агуулгын хуудсыг илрүүлэлтүүдийн хураангуй байдлаар ашиглахыг илүүд үздэг. Ингэхийн тулд, тэд аудитын илрүүлэлтүүдээ нэг өгүүлбэрээр хураангуйлж, гарчиг болгон ашигладаг. 42-р зурагт энэ арга хандлагын жишээг үзүүлэв.

Зураг 42: Тайлбарласан шинжтэй гарчиг ашигласан агуулгын хуудас

Гарчиг	Хуудас
Хураангуй	5
Зөвлөмжүүд	11
1-р хэсэг	
Уэльсийн Засгийн Газар хог хаягдлаас сэргийлэх төлөвлөгөөтэй боловч дахин боловсруулалтад илүү их анхаарал, нөөцийг төвлөрүүлж байна	13
Уэльсийн Засгийн Газар хотын хог хаягдлын дахин боловсруулалтыг нэмэгдүүлэхэд амжилттай төвлөрсөн боловч, хог хаягдлаас сэргийлэх ажил хэдэн чухал санаачилгыг эс тооцвол ерөнхийдөө гүйцэтгэл муутай байна	14
Хог Хаягдлаас Сэргийлэх Хөтөлбөрт нийтлэг практикийг тусгасан боловч, бусад газрын арга хандлагаас суралцаж, хууль тогтоомж болон санхүүгийн урамшуулыг сайн ашиглах боломж оршсоор байна	17
Уэльсийн Засгийн Газар зөвлөлүүддээ хотын хог хаягдлын менежментийн үйлчилгээндээ зарцуулах ихээхэн хэмжээний санхүүжилт олгосон боловч, уг санхүүжилт ихэвчлэн дахин боловсруулалтад зарцуулагдаж, багахан хэсэг нь урьдчилан сэргийлэх ажилд зарцуулагджээ	23
2015 оны 10-р сар болон 2018 оны 9-р сар хооронд Уэльсийн Засгийн Газар хог хаягдлаас сэргийлэх болон бусад зорилгоор гурван ашгийн бус байгууллагад 13 сая евро олгосон байна	26
2-р хэсэг	
Хог хаягдлаас сэргийлэх том зорилготойгоо гүйцэтгэлийг тулган хэмжихэд ашигласан Уэльсийн Засгийн Газрын өгөгдөл нь чанарын хувьд харилцан адилгүй байгаа бөгөөд янз бүрийн ахицыг илтгэж байна	30
Уэльсийн Засгийн Газар хотын хог хаягдлын талаар сайн өгөгдөлтэй боловч, бусад төрлийн хог хаягдлын талаарх ихэнх өгөгдөл нь хязгаарлагдмал байна	31
Үүсэж буй хог хаягдлын хэмжээний талаарх одоогийн өгөгдөл нь Уэльсийн Засгийн Газрын хог хаягдлаас сэргийлэх том зорилгыг биелүүлэх ахиц янз бүр байгааг илтгэж байна	35
Хавсралтууд	43
Хавсралт 1 – Аудитын аргууд	44
Хавсралт 2 – Уэльсийн Засгийн Газрын Хог Хаягдлаас Сэргийлэх Хөтөлбөрийн гол бүрэлдэхүүн хэсгүүд ба хог хаягдлын салбарын төлөвлөгөө	45

Эх сурвалж: Уэльс улсын Хог Хаягдлын Менежмент – Хог Хаягдлаас Сэргийлэх нь, Уэльс улсын Аудитын Газар, 2019.

Тайлангийн хураангуй

Тайлангийн хураангуй гэдэг нь тайлангийн үндсэн санаанууд болон гол мессежнүүдийг товчлон илэрхийлэх зориулалттай богино бүлэг юм. Олон хүн тайлангийн зөвхөн энэ хэсгийг уншдаг. Иймд, тайлангийн хураангуйг тодорхой бичих нь чухал. Мөн, энэ хэсэгт тайлангийн хамгийн чухал хэсгүүдийг товч хураангуйлах нь чухал. Ерөнхийдөө, тайлангийн хураангуйд аудитыг яагаад хийх болсныг тайлбарлаж, аудитын судлах сэдэв/ зүйл болон аудитад шалгуулагч этгээдийн талаар товч мэдээлэл оруулж, аудитын зорилго болон асуултууд, хамрах хүрээ, арга зүй, гол илрүүлэлтүүд, дүгнэлтүүд болон зөвлөмжүүдийг товч мэдээлдэг.

Зарим АДБ тайлангийн хураангуйг ашигладаггүй бөгөөд аудитын тайлангаа өөр аргаар хураангуйлдаг. Тухайлбал, АНУ-ын ТХГ гүйцэтгэлийн хураангуйн оронд нэг хуудас абстракт ашигладаг (18-р хавсралтыг үзнэ үү). Зөв зохистой ашигласан гүйцэтгэлийн хураангуй нь:

- Тайлангийн үлдсэн хэсэгт юу байгааг үнэн зөв тусгана;
- Аудитын чухал илрүүлэлтүүдийг орхигдуулахгүйгээр товч байна;
- Аудитын асуултуудын ач холбогдол болон тэдгээрийн хариултуудыг уншигчид ойлгуулна;
- Үндсэн тайлангийн аль хэсэг нь аль гол илрүүлэлтийг дэмжих вэ гэдгийг уншигчдад харуулна;
- Бие даасан баримт бичиг болж чадна;
- Зөвхөн үндсэн тайланд орсон материалыг агуулна; мөн
- Өмнөх аудитүүд эсвэл үг сэдвээр гүйцэтгэх засаглал хэр ажиллаж байгаа зэрэг хам нөхцөлийн чухал мэдээллүүдийг дурдана.

Гүйцэтгэлийн хураангуй нь мессежийг дамжуулахдаа график, дүрслэл ашиглаж бас болно.

Үр нөлөөтэй гүйцэтгэлийн хураангуй нь аудитын сэдэв АДБ-ын гүйцэтгэлийн үнэлгээтэй холбоотойгоор уншигчдад төрөх чухал асуултуудад хариулдаг. Тухайлбал, ИБУИНХУ-ын УАГ-ын аудитын хураангуй бичих удирдамжид аудиторүүдыг дараах асуултуудад хариулах хэрэгтэй гэж заасан байдаг:

- **Гүйцэтгэлийг үнэлэх.** Энэ судалгааны хам нөхцөлд сайн үнэ цэн ямар харагдах вэ? Ямар харьцуулах зүйл эсвэл баримт ашигласан бэ?
- **Үйл ажиллагааны сайн туршлагыг харьцуулах зүйл болгох.** Сайн туршлагыг хэрхэн тодорхойлсон бэ?
- **Тоо хэмжээгээр илэрхийлэх.** Зарцуулсан нийт нөөц болон хүрсэн амжилтуудыг тоо хэмжээгээр илэрхийлсэн үү? Өртөг болон үр өгөөжийг гүйцэтгэлийн талаарх дүгнэлтүүдийг дэмжих байдлаар толилуулсан үү?
- **Учир шалтгааны холбоо.** Тогтолцооны үнэ цэн эсвэл үр өгөөжийг шалгагдаж буй аливаа зарцуулалтаас үүдсэн гэж үзэж болох үү? Өгөгдлийг хөрвүүлэн ойлгох үед, гарцууд болон үр дүнгүүдэд өөр ямар хүчин зүйлс нөлөөлсөн байж болох вэ?
- **Тодорхой бус байдал.** Тайланд ашигласан өгөгдөлтэй холбогдох ямар эрсдэлүүд болон тодорхой бус байдал байна вэ? Бүх өгөгдөлд тодорхой хэмжээний тодорхой бус байдал оршин байдаг. Иймд тодорхой бус байдлынх нь түвшнийг тодорхой мэдэгдэх нь зүйтэй.

Тайлангийн хураангуйн урт нь ихэвчлэн үндсэн тайлангийн урт болон нарийн төвөгтэй байдалтай пропорциональ хамааралтай байдаг. Гэхдээ, ердийн гүйцэтгэлийн хураангуй гурван нүүрээс хэтрэхгүй урттай байх нь элбэг. 19-р хавсралтад гүйцэтгэлийн хураангуйн жишээг үзүүлэв.

Тайлангийн хураангуй

- ✓ Үндсэн тайлан дахь хураангуйлсан догол мөрүүд болон өгүүлбэрүүдийг ашиглан гүйцэтгэлийн хураангуйг үүсгэнэ. Энэ нь гүйцэтгэлийн хураангуйг үндсэн тайлантай нийцэлтэй болгодог.
- ✓ Гүйцэтгэлийн хураангуйг Нийтийн Дансны Хороо эсвэл хууль тогтоох засаглалын хяналтын хороонд зориулж; тайланг аудитад шалгуулагч этгээдэд зориулж; харин хавсралтуудыг нь тухайн салбар болон дэлгэрэнгүй арга зүйг сонирхсон эрдэмтэн судлаачид эсвэл мэргэжилтнүүдэд зориулж бичиж байна гэж бодох нь заримдаа тустай байдаг.

Эх сурвалж: АДБОУБХС/ГАДХ-ны Хөгжлийн Баг.

Оршил

Тайлангийн оршил нь гүйцэтгэлийн аудитын хам нөхцөлийг танилцуулж, уншигчдад аудитыг ойлгоход нь тусалдаг. Ерөнхийдөө, АДБ-ууд тайлангийн оршил хэсгийг ашиглаж аудитын илрүүлэлтүүдийг бус, аудитын сэдвийг танилцуулдаг.

Оршил хэсэг нь хэт урт болон нарийн дэлгэрэнгүй байх шаардлагагүй. Тухайлбал, 43-р зурагт, энгийн графикайг тайлангийн оршил хэсэгт ашиглаж, аудитад шалгуулагч янз бүрийн байгууллагын хариуцлагуудыг шүүрхай тайлбарлаж болохыг харуулав. Уншигчид дэлгэрэнгүй мэдээлэл хэрэгтэй бол, хавсралтаар эсвэл үндсэн мэдээлэл гэсэн хэсгээр тусад нь өгч болно. Эсвэл, дэлгэрэнгүй мэдээллийг хаанаас авч болохыг зааж өгч болно.

Тайлангийн хураангуй

- ✓ Аудитад шалгагдагч үйл ажиллагааг хэрхэн удирдаж, явуулдгийг уншигчдад мэдүүлэхэд зориулж хангалттай хам нөхцөлийн мэдээлэл оруулах хэрэгтэй. Гэхдээ оршил хэсгийг алгасах сэдэл төрүүлэхүйц хэт их мэдээлэл оруулж болохгүй.
- ✓ Аудитад шалгагдагч аль үйл ажиллагаанд хэн хариуцлага хүлээхийг энгийн диаграмм ашиглан харуулах талаар бодолцож үзэх хэрэгтэй.
- ✓ Энэ үйл ажиллагааны талаар яагаад одоо тайлан бичих болсноо уншигчдад хэлэх хэрэгтэй.
- ✓ Уншигчийг дэлгэрэнгүй мэдээлэлд хөтлөхөд хавсралт, эш татсан эх сурвалж эсвэл ном зүйн хэсгийг ашиглах хэрэгтэй.

Эх сурвалж: АДБОУБХС/ГАДХ-ны Хөгжлийн Баг.

Зураг 43: Аудитад шалгагдагч байгууллагын хариуцлагыг дүрслэхэд энгийн график ашиглах нь



Эх сурвалж: ИБУИНХУ-ын ҮАГ – Яамдын баримт бичигт хийсэн шинжилгээ

Аудитын зорилго(ууд) болон асуултууд

Гүйцэтгэлийн аудитын тайланд аудитын зорилго(ууд) болон асуултуудыг тайлбарлах ёстой. Уншигчдад аудитын ерөнхий зорилго, гүйцэтгэсэн ажлын мөн чанар болон цар хэмжээ, мөн аудитын зорилго, хамрах хүрээ болон арга зүйн аливаа томоохон хязгаарлалтуудыг ойлгуулахын тулд энэ мэдээллийг тайланд оруулах хэрэгтэй. Аудитын зорилгууд болон асуултуудын жишээг 4-р бүлгээс үзнэ үү.

Аудитын хамрах хүрээ болон арга зүй

Ялгаатай уншигчид аудитаас ялгаатай зүйлийг хүсэж, хүлээж байдаг. Аудитын хамрах хүрээ нь уншигчдад дараах зүйлсийг ойлгоход тусална:

- Тайлангаас юу хүлээж болохыг;
- Илрүүлэлтүүд болон дүгнэлтүүдийг юунд ашиглаж болохыг; мөн
- Илрүүлэлтүүд болон дүгнэлтүүдэд хэр хэмжээнд найдаж болохыг.

Аудитын арга хандлага нь юуг хамруулсан, юуг хамруулаагүйг, ямар цаг хугацааг эсвэл газар зүйн талбарыг хамруулсныг, мөн аудитын субъект нь хэн болохыг уншигчдаа хэлэх хэрэгтэй. Тайлан нь гарчигтаа хамаарах хүрээнд бус, харин аудитад шалгагдагч үйл ажиллагааны тухайлсан багц хэсэг дээр төвлөрч буй эсэхийг уншигчдаа хэлэх нь чухал. Тухайлбал, Намгархаг газрыг хамгаалах нь гэсэн гарчигтай тайлан нь улсын хэмжээнд буй бүх намгархаг газрыг хамгаалах асуудлыг хөндөөгүй байж болно. Иймд тайлангийнхаа тухайлсан фокусыг тайлбарлах хэрэгтэй.

Түүнчлэн, аудитын зорилго(ууд)ыг биелүүлэхэд ашигласан аудитын арга зүйгээ тайлбарлах хэрэгтэй.

Гүйцэтгэлийн аудитын арга зүйг тайлбарласан хэсгээс

"Холбооны Нисэхийн Захиргаанаас (ХНЗ) батламжилсан механик болон засварчдын шинж чанарыг судлахын тулд, бид 2018 оны 12-р сарын байдлаарх ХНЗ-ны нийт мэдээлэлд нас, хүйс зэрэг хүн ам зүйн шинж чанараар шинжилгээ хийсэн юм. Нисэхийн техникийн үйлчилгээний ажилтнуудын цалин хөлс болон ажилгүйдэл зэрэг хөдөлмөр эрхлэлтийн шинж чанарыг судлахын тулд бид 2013-2018 оны хөдөлмөрийн зах зээлийн сонгосон индикаторуудаар Хөдөлмөрийн Статистикийн Товчооны Өнөөгийн Хүн Амын Судалгааны өгөгдлийг шинжиллээ. Мөн, бүх 50 мужийн хамгийн сүүлийн үеийн Ажиллах Хүчний Шинэчлэл болон Боломжийн Актыг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд нягталгаа хийсэн юм."

Эх сурвалж: АНУ-ын ТХГ-ын тайлан, Нисэхийн техникийн үйлчилгээ: Чадамжтай, төрөлжсөн ажиллах хүчнийг дэмжих ХНЗ-ны хүчин чармайлтыг нэмэлт зохицуулалт болон өгөгдлөөр ахиулж болно, 2020, ТХГ-20-206.

Арга зүйг тайлангийн үндсэн хэсэгт товч тайлбарлаж, хавсралтаар илүү дэлгэрүүлэн тайлбарлаж болно. 20-р хавсралтаас дээр дурдсан тайлангийн хамрах хүрээ болон арга зүйн тайлбарыг үзнэ үү.

Тайлангийн үндсэн хэсэг нь хамгийн багадаа дараах зүйлсийг товч агуулах ёстой.

- Аудитын арга зүй болон арга хандлага;
- Өгөгдлийн эх сурвалжууд;
- Өгөгдөл цуглуулж, шинжлэх аргууд; мөн
- Өгөгдлийн ашиглалтын аливаа хязгаарлалтууд.

Тайланд орсон арга зүй болон ашигласан аливаа өгөгдлийн талаар илүү дэлгэрэнгүй мэдээллийг уншигчид өгөх нь ихэвчлэн чухал байдаг. Иймд, илүү дэлгэрэнгүй мэдээллийг, голчлон хавсралтаар оруулж өгөх нь зохимжтой. Тухайлбал, дараах зүйлсийн талаар мэдээлэл оруулж болно:

- Өгөгдлийн найдвартай байдлыг тодорхойлохын тулд хийсэн зүйлс;
- Уншигч мэдэх ёстой өгөгдөл болон шинжилгээний, мөн өгөгдлийг хөрвүүлэн ойлгох аргын хязгаарлалтууд зэрэг арга зүйн хязгаарлалтууд байгаа эсэх;
- Таны хандсан өгөгдөл болон бусад нотлох зүйлсэд хязгаарлалтууд байсан эсэх; мөн
- Таны тоон шинжилгээний үеэр илрүүлсэн чиг хандлагууд статистикийн ач холбогдолтой байсан эсэх.

Аудитын шалгуур болон эх сурвалж

Аудитад ямар шалгууруудыг хэрхэн боловсруулж ашигласнаа, мөн ямар эх сурвалжуудыг ашигласнаа мэдэгдэх нь чухал. Аудитын шалгуурыг онцлон өгүүлснээрээ, гүйцэтгэлийг тулган хэмжиж буй стандартаа тодорхой болгох юм. Эх сурвалжууд, аудитын шалгуурууд, аргууд болон таамаглалуудаа тодорхой болгосноор, уншигчдад тайланд орсон нотлох зүйлс болон дүгнэлтүүдийг хэр чухалчлан үзэх вэ гэдгээ шийдэхэд нь тусална. (УДИР-3920/115)

Зарим гүйцэтгэлийн аудитын хувьд, аудитын шалгуурууд нь анхнаасаа бэлэн байдаггүй. Ийм тохиолдолд, аудитын баг шалгууруудаа боловсруулж, аудитад шалгуулагч этгээдтэй хэлэлцэх шаардлагатай болно. Аудитад шалгагдагч этгээд нь шалгууруудтай санал нийлэхгүй байвал, АДБ-аас уг шалгууруудыг ашиглах эсэх талаар эцсийн шийдвэрийг гаргана. АДБ-ын боловсруулсан шалгуурууд дээр ихээхэн санал зөрөлдөөн үүссэн тохиолдолд, шалгууруудын эх сурвалж нь гагц аудиторүүд өөрсдөө болж, улмаар аудитад шалгагдагч этгээд илрүүлэлтүүдийг хүлээн зөвшөөрөхгүй байх эрсдэл үүснэ гэдгийг бодолцож үзэх шаардлагатай. Энэ сэдвийг 4-р бүлэгт дэлгэрэнгүй авч үзсэн болно.

Аудитын илрүүлэлт



Стандарт

Аудитын тогтоосон зүйлс нь аудитын зорилго(ууд) болон/ аудитын асуултуудаас урган гарч тодорхой дүгнэлтэд хүрснийг, эсхүл яагаад ингэх боломжгүйг тайлбарласан байхыг аудитор нягтлах хэрэгтэй.

Эх сурвалж: АДБОУС-3000/124.

6-р бүлэгт хэлэлцсэнчлэн, тайлангийн төсөл бичих үедээ, аудитын илрүүлэлтүүд нь аудитын шалгуурууд болон нотлох зүйлстэй хэрхэн уялдаж байгааг уншигчдад ойлгомжтой байлгах нь чухал. Олон тайланд илрүүлэлтүүдийг аудитын асуултуудын дагуу зохион байгуулах замаар энэхүү уялдааг тодорхой болгодог. Аудитын асуулт тус бүр нь аудитын тайлангийн хэсэг эсвэл бүлэг болж, холбогдох илрүүлэлтүүдээ дотроо багтаана. Өөр өөр илрүүлэлтүүд харилцан уялдаатай байвал дүгнэлтүүдийг уг бүлэгт нь оруулах нь зүйтэй. Харин харилцан уялдаагүй байвал, дүгнэлтүүдийг нь тусад бүлэг болгож оруулах хэрэгтэй. Илрүүлэлтүүдийг зохион байгуулах ямар арга сонгосноос үл хамаарч, 6-р бүлэгт авч үзсэнчлэн, аливаа илрүүлэлтийн нөхцөл, шалгуур, шалтгаан болон үр нөлөө нь уншигчдад тодорхой ойлгогддог байх нь чухал.

Гүйцэтгэлийн аудитын тайлан дахь илрүүлэлтийн тайлбарын жишээ

Бид Хар Тамхитай Тэмцэх Газрын (ХТТГ) сэтгэцэд нөлөөт эм бэлдмэлийг гар дамжуулахаас сэргийлэх хүчин зүтгэлтэй холбогдох дутагдлуудыг илрүүллээ. Тухайлбал:

✓ **Салбарын тайлангийн өгөгдөлд бүтээлч бөгөөд нарийвчилсан шинжилгээ хязгаарлагдмал.** ХТТГ-ын одоогийн өгөгдлийн системүүд нь бодит цагийн (real-time) шинжилгээ хийх зориулалтгүй бөгөөд салбар байгууллагуудынхаа хүсэлт зэргийн дагуу салбарын тайланд зарим шинжилгээг хийдэг боловч, ХТТГ өгөгдлийн нийтлэг хэв шинж дэх сэжигтэй тохиолдлуудыг илрүүлэхийн тулд компьютерын автоматжуулсан алгоритм ашиглаж илүү их шинжилгээ хийх боломжтой. Тухайлбал, ХТТГ-аас хэвийн бус хэмжээгээр устгагдсан арилжаа эсвэл хэвийн бус хэмжээгээр устгалд оруулсан эм бэлдмэл зэргийг илрүүлэхийн тулд өгөгдлийг шинжилж болно. Мөн, тодорхой газар зүйн талбарт дахь эм бэлдмэлийн түгээлтийн чиг хандлага эсвэл худалдан авалтыг тодорхойлохын тулд өгөгдлийг шинжилж болно. Үүнээс гадна, газар зүйн нэг талбар дахь эм бэлдмэлийн захиалгыг ойролцоо талбаруудынхтай нь харьцуулж, хэвийн бус хэв шинжийг эрж болно. Эдгээр шинжилгээ нь ХТТГ-т сэжигтэй үйл ажиллагаа эсвэл мөрдөн шалгах шаардлагатай хэргүүдийг бүтээлчээр илрүүлэхэд туслах боломжтой.

✓ **Сэтгэц нөлөөт эм бэлдмэлийн арилжааны бүх өгөгдлийг удирдах өгөгдлийн засаглалын бүтэц байхгүй.** ХТТГ-т зарим мэдээллийн системийг ашиглах удирдамж, бодлого, горимууд байдаг боловч, сэтгэцэд нөлөөт эм бэлдмэлийг гар дамжуулахаас сэргийлэх хүчин зүтгэлд нь асар чухал, цуглуулж хадгалсан бүх өгөгдлөө удирдах өгөгдлийн засаглалын албан ёсны бүтэц үүсгээгүй байна. Өгөгдлийн засаглалын бүтэц гэдэг нь өгөгдлийн стандартыг боловсруулж, хэрэгжүүлэх бүхий л мөчлөгийн турш өгөгдлийн засаглалаар хангах бодлого, горимуудын зохион байгуулалтад оруулсан багц юм. Салбарын болон технологийн зөвлөлүүд, дотоодын болон олон улсын стандарт тогтоодог байгууллагууд, мөн холбооны байгууллагууд нь өгөгдлийн стандартууд, дижитал контент болон өгөгдлийн бусад хөрөнгүүдийг боловсруулах, удирдах, хэрэгжүүлэх үйл явцыг хянахад засаглалын бүтэц ашиглахыг сайшаан дэмждэг. ХТТГ-аас засаглалын бүтэц үүсгэх хүчин зүтгэлийг эхлүүлсэн боловч, хөгжүүлэлтийн эхний үе шатууддаа явж байгаа бөгөөд хүчин зүтгэлийнхээ талаар нэмэлт мэдээлэл буюу баримтжуулалтгүй байна. Үр нөлөөтэй өгөгдлийн засаглалын бүтэц нь ХТТГ-т чухал өгөгдлийн хөрөнгүүдээ нийцтэй бөгөөд бүрэн ашиглахад нь тусалж болно.

Эх сурвалж: АНУ-ын ТХГ-ын тайлан, ЭМИЙН ХЯНАЛТ: Өвчин намдаах төрлийн эмийн сэжигтэй захиалгуудын талаарх өгөгдлийн хэрэгцээт чанарыг хангахад арга хэмжээ шаардлагатай байна, 2020, ТХГ-20-118.

Түүнчлэн, өмнө хэлэлцсэнчлэн, график болон хүснэгт ашиглах нь тайлангийн уншууштай байдлыг ихээхэн нэмэгдүүлж чадна.

Дүгнэлт

6-р бүлэгт хэлэлцсэнчлэн, тайланд орсон илрүүлэлтүүд болон мэдээллүүдийг хураангуйлсан дүгнэлтийн хэсэг олон тайланд бий. АДБ-ын тайлангийн загвар болон уншигчдын хэрэгцээнээс хамааруулаад энэ хэсгийг бичих олон арга байдаг. 44-р зурагт гурван өөр АДБ-ын аудитын тайлангийн дүгнэлтийн хэсгийг үзүүлэв.

Зураг 44: Аудитын дүгнэлтүүдийн жишээ

<p>Европын Холбооны боловсролд зориулсан хүмүүнлэгийн тусламжид 2021 онд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан. Европын Аудиторуудын Шүүх, 2021.</p>	<p>Аудитын зорилго. ЕХ-ны боловсролд зориулсан хүмүүнлэгийн тусламж хүүхдүүдэд үр нөлөөтэй тусалж, үр ашигтай хэрэгжсэн эсэхийг үнэлэх.</p> <p>Аудитын дүгнэлт. Ерөнхийдөө, ЕХ-ны тусламж хэрэгцээт бүлгийн хүүхдүүдэд тусалж, төслүүд хүлээгдэж буй үр дүндээ хүрсэн байна. Гэвч, хангалттай олон охидод хүрсэнгүй. Түүнчлэн, манай түүвэрт багтсан ихэнх төсөл хүүхдүүдийн боловсролын хэрэгцээтэй харьцуулахад хэт богино хугацаатай байсан тул үр ашигтай байдлыг бууруулж байлаа. 11 төсөлд хийсэн шалгалтын илрүүлэлтүүдийг 2-р хавсралтад хураангуйлан оруулав. 68 төсөл нь хамааралтай бөгөөд зохицуулалт сайтай байв. Комисс нь хяналт-шинжилгээ хийх талбарын ажлын үеэр илрүүлсэн асуудлуудаа шийдвэрлэсэн байна. Төслүүд төлөвлөсөн үр дүнгүүдийнхээ ихэнхийг биелүүлжээ. Гэвч, комисс нь Сайжруулсан Хариу Арга Хэмжээний Чадавхын төслүүдийнхээ үр дүнгүүдийг хязгаарлагдмал байдлаар ашигласан байна. Мөн, комисс нь илүү их сул талтайг нь мэдэж байсан ч, хангалттай олон тооны охидыг зорилтот бүлэгт оруулаагүй байна. Түүнчлэн, хэд хэдэн төсөл охидын зорилтот хувь хэмжээг хангаж ажиллаагүй байна.</p>
<p>Маврики улсад уламжлалт загасны аж ахуйн тогтвортой байдлыг нэмэгдүүлэх нь – Гүйцэтгэлийн аудитын тайлан. Маврики улсын АДБ, 2018.</p>	<p>Аудитын зорилго. Яамнаас хэрэгжүүлсэн арга хэмжээнүүд нь уламжлалт загасны аж ахуйн тогтвортой байдлыг үр нөлөөтэй дэмжсэн эсэхийг үнэлэх.</p> <p>Аудитын дүгнэлт. Яамнаас уламжлалт олон төрлийн арга хэмжээг санаачлан хэрэгжүүлэх замаар загасны аж ахуйд тусгайлан чиглэсэн, мөн далай тэнгисээс тасарсан экосистемийн хамгааллаар дамжуулан нийгэм болон үндэсний хэмжээнд ерөнхийдөө чиглэсэн олон сайн санаачилгыг хэрэгжүүлсэн байна. Энэ бүх арга хэмжээг ТХЗ-14Б болон ХХААБ-ын Хариуцлагатай Загасны Аж Ахуйн Ёс Зүйн Дүрэмтэй уялдуулсан нь уламжлалт загасны аж ахуйн тогтвортой байдлыг дэмжиж байна.</p>
<p>Мах үйлдвэрлэлийн үйл явцын эрүүл ахуйн хяналтын гүйцэтгэлийн аудит. Танзани улсын АДБ, 2016.</p>	<p>Аудитын зорилго. Газар Тариалан, Мал Аж Ахуй болон Загасны Аж Ахуйн Яам (ГТМААЗААЯ), Бүсийн Захиргаа болон Орон Нутгийн Удирдлага хариуцсан Ерөнхийлөгчийн Алба (БЗОНУХЕА) болон Эрүүл Мэнд, Нийгмийн Хөгжил, Жендер, Ахмадууд болон Хүүхдүүдийн Яам (ЭМНХЖАХЯ) нь олон нийтийг эрүүл, аюулгүй махаар хангахын тулд мах үйлдвэрлэлийн үйл явцад үр ашигтай бөгөөд үр нөлөөтэй эрүүл ахуйн практик болон хяналтын механизм бий болгосон эсэхийг үнэлэх.</p> <p>Аудитын дүгнэлт. Олон мах бэлтгэлийн газарт махны үзлэг болон ариутгах татуургын хяналт хангалтгүй хэмжээнд байдаг тул бидний талбарын ажил хийсэн зарим мах бэлтгэлийн газарт хүргэгдэж буй мах нь хүний хэрэглээнд аюулгүй гэдгийг батлах ямар ч баталгаажуулалт байсангүй. Үүний шалтгаан нь ГТМААЗААЯ, БЗОНУХЕА болон ЭМНХЖАХЯ-наас эрүүл ахуйн хяналтын механизмыг үр нөлөөтэй бөгөөд үр ашигтай удирдахгүй байгаагийнх юм.</p>

Эх сурвалж: Европын Аудиторуудын Шүүх; Маврики улсын АДБ; мөн Танзани улсын АДБ.

Зөвлөмж

Олон тайланд аудитад шалгуулагч этгээдэд зориулсан зөвлөмж агуулагддаг. Зөвлөмж бичихдээ тэнцвэртэй байлгах хэрэгтэй. Хоёрдмол утга илэрхийлэхээс сэргийлж, нарийн тодорхой байлгах хэрэгтэй. Гэхдээ удирдлагын хариуцлагад халдах хэмжээний хэт нарийвчилсан байлгаж болохгүй. Зөвлөмж боловсруулах талаар 6-р бүлэгт дэлгэрэнгүй авч үзсэн байгаа. Зөвлөмжийн талаар илүү дэлгэрэнгүйг АДБОУС-3000/127-128 болон УДИР-3920/125-128-аас үзэж болно. 45-р зурагт АДБ-ын зөвлөмжүүдийн жишээг үзүүлээ.

Зураг 45: Зарим АДБ-ын гүйцэтгэлийн аудитын тайлан дахь зөвлөмжийн жишээ

<p>Сэтгэцийн гэмтлийн сүлжээний сайжруулалт</p>	<p>Яамнаас эрүүл мэндийн стратегийн байгууллагуудыг сэтгэцийн гэмтлийн сүлжээ үүсгэхэд дэмжиж байгаа билээ. Гэвч, сүүлийн 20 жилийн хугацаанд сэтгэцийн гэмтлийн голлох үйлчилгээнүүдийг сайжруулахад ахиц муутай байсныг харгалзан үзэж, бид дараах арга хэмжээнүүдийг зөвлөмж болгож байна:</p> <p>а. Анхан шатны тусламж үйлчилгээний трастууд болон түргэн тусламжийн трастууд ноцтой гэмтсэн өвчтөнүүдийг аль түргэн тусламжийн тасагт хүргүүлж эмчлэхийг тодорхойлох эмчилгээний эрэмбийн (триаж) протокол боловсруулж, хэрэгжүүлэх хэрэгтэй.</p> <p>б. Анхан шатны тусламж үйлчилгээний трастууд нь хуулиар олгогдсон эрх мэдлээрээ сэтгэцийн гэмтэлтэй өвчтөн хүлээн авах түргэн тусламжийн тасагтай бүх байгууллагыг TARN-д (Сэтгэцийн гэмтлийн аудит болон судалгааны сүлжээ) өгөгдөл оруулдаг байхыг шаардах хэрэгтэй. Гол зорилго нь цуглуулсан мэдээллийг ашиглаж сэтгэцийн гэмтлийн сүлжээний хөгжлийг мэдээллээр хангахад оршино.</p> <p>в. Эрүүл мэндийн стратегийн байгууллагууд нь эмнэлгийн трастуудтай хамтран тусгай мэргэжлийн тусламж үйлчилгээ эсвэл тухайн эмнэлэгт байхгүй эмчилгээ шаардлагатай өвчтөнүүдийг шилжүүлэх протокол боловсруулах хэрэгтэй.</p>
<p>Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг таслан зогсоох арга хэмжээний зохицуулалт</p>	<p>Бид Эмэгтэйчүүдийн Яаманд дараах зөвлөмжийг хүргүүлж байна:</p> <p>а. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг таслан зогсоох арга хэмжээг удирддаг хуулийн хүрээгээ шинэчилж, ТББ-ууд болон засгийн газрын холбогдох байгууллагуудын уялдаатай ажиллагааг сайжруулж, олон улсын гэрээ хэлэлцээрээр хүлээсэн үүргээ биелүүлэх засгийн газрын хүчин чармайлтыг нэмэгдүүлэх замаар засаглалын тогтолцоогоо бэхжүүлэх.</p> <p>б. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн хуулийн хүрээний хэрэгжилтийг сайжруулахын тулд холбогдох гол оролцогч талуудтай үр нөлөөтэй уялдаж ажиллах.</p> <p>в. Хяналт-шинжилгээ болон тайлагналын зохицуулалтаа сайжруулж, бэхжүүлэх.</p>
<p>Гэр бүлийн хүчирхийллийн хэрэгтэй холбогдох шийдвэр гаргалт</p>	<p>Гэр бүлийн хүчирхийллийн хэрэгт хариу арга хэмжээ авангаа шийдвэр гаргалтыг мэдээлэл сайтай болгохын тулд бид Эмэгтэйчүүдийн Яаманд дараах зөвлөмжийг хүргүүлж байна:</p> <p>1. Эрсдэлийг газар дээр нь зөв үнэлж, хохирогчийг зохих ёсоор хамгаалахын тулд цагдаагийн албан хаагчдад гэр бүлийн хүчирхийллийн хэргийн суурь мэдээлэл (хүчирхийлэл үйлдэгч өмнө нь ял эдэлж байсан эсэх, хар тамхи хэрэглэж байсан эсэх, галт зэвсэг эзэмшдэг эсэх гэх мэт) хандах эрх өгөх.</p> <p>2. Хамгаалах болон хориглох захирамжийг нэг өгөгдлийн санд нэгтгэж, хүчирхийлэлд шуурхай, үр нөлөөтэй хариу арга хэмжээ авах.</p> <p>3. Гэр бүлийн хүчирхийллийг эрт илрүүлэхийн тулд, хариуцагч талуудтай хамтран ажиллаж, хүүхдийн эрүүл мэндийн үзлэг, эмэгтэйчүүдийн үзлэг гэх мэт үйл ажиллагааны хүрээнд гэр бүлийн хүчирхийллийг эрт илрүүлэх тогтолцоо үүсгэж, хэрэгжүүлэх.</p>
<p>Хувийн сургуулийн багш, сурагчдад зориулсан засгийн газрын дэмжлэг (ХСБСЗЗГД)</p>	<p>АДБ-аас Боловсролын Яаманд дараах зөвлөмжийг хүргүүлж байна:</p> <p>а. Хөтөлбөрөөр чанартай боловсролын хүртээмжийг сайжруулж, улсын сургуулиудын ачааллыг бууруулсан хэр хэмжээг тодорхойлоход тохиромжтой гүйцэтгэлийн индикаторуудыг бий болгох;</p> <p>б. Эмзэг бүлгийнхнийг Хөтөлбөрийн тэргүүлэх зорилтот бүлэгт болгох;</p> <p>в. ХСБСЗЗГД-ын Төрөлжсөн баг байгуулсны дараа Хөтөлбөрийг удирдахад тусгайлан зориулсан, сайн ажиллагаатай оффис байгуулах; мөн</p> <p>г. Хувийн Сургуулийг Дэмжих Хорооны өмч гэгддэг системүүд болон холбогдох бүх Мэдээллийн Технологийн системүүдийг нэгтгэхийн тулд Мэдээллийн Системийн Стратегийн Төлөвлөгөөгөө боловсруулах.</p>

Эх сурвалж: ИБУИНХУ-ын УАГ; Фижи улсын АДБ; Гүрж улсын ТАБ; мөн Филиппин улсын АДБ.

Товчилсон үгс

Зарим сэдвийн хувьд танил бус товчилсон үгс болон нарийн мэргэжлийн нэр томьёо ашиглахгүй байхад хэцүү байж болно. Тайлангийн эхэн хэсэгт эсвэл хавсралтад товчилсон үгсийн жагсаалт болон нэр томьёоны тайлбар толь оруулах замаар уншигчид тусалж болно.

Тайланг хэрхэн чанартай байлгах вэ?

Алдаа гарах эрсдэлийг хамгийн бага байлгаж, аудитын үйл ажиллагааг нийцтэй болгохын тулд чанарын хяналтын горим нь гүйцэтгэлийн аудит бүрийн салшгүй хэсэг байх шаардлагатай (УДИР-3910/102). АДБ-үүд нь тайлангуудаа өндөр чанартай байлгахын тулд хэрэгжүүлж болох цөөнгүй арга зам бий. Үүнд, тайлангийн нотлох зүйлсийг эх сурвалжуудтай холбон зураглах үйл явц; эцсийн тайланг нийтлэхийн өмнө тайлангийн нягталгаа хийлгэж, аудитад шалгуулагч этгээдийн саналыг авах зэрэг орно. АДБОУС-140 нь чанарын хяналтын талаарх нэмэлт удирдамжаар хангадаг.

Хэрхэн нотлох зүйлсийг эх сурвалжуудтай холбон зураглах вэ?

Аудитын тайланг нийтлэхийн өмнө тайланд орсон бүх тоо, баримт болон дүгнэлтийн эх сурвалжийг харуулсан өгөгдлийн лавлах эсвэл түүнтэй төстэй аудитын тэмдэглэл үүсгэх нь сайн практик байдаг. Ингэснээр тайланд алдаа гарах эрсдэл буурч, баримт фактуудын талаар нягтлагч нар, аудитад шалгуулагч этгээд эсвэл гуравдагч талаас асуух үед хариулт өгөхөд хялбар болдог. Энэхүү лавлахыг аудитын тэмдэглэлийн нэг хэсэг болгож хадгалах хэрэгтэй. 46-р зурагт тайлангийнхаа өгөгдлийн лавлахыг хэрхэн үүсгэх талаар жишээ орууллаа.

Зураг 46: Гүйцэтгэлийн аудитын тайлангийн өгөгдлийн лавлах баримт бичгийн жишээ

Хэсэг	Лавлах өгөгдөл	Тайлбар/эх сурвалж
2.3	2019 оны 6-р сард, Боловсролын Сайд шинэ коллеж барих бусад төлөвлөсөн хөтөлбөрүүдийг түр зогсооно гэж мэдэгдсэн.	2019 оны 6-р сарын 3-ны өдөр Боловсролын Сайд Парламентад хандаж хэлсэн үгэндээ, "Оюутнуудад хамгийн сайн коллеж барьж өгөх нь энэ Засгийн Газрын тэргүүлэх зорилго мөн. Бидний эхлүүлсэн ажлын эхний давлагааны үеэр зарим алдаа дутагдлууд илэрлээ. Иймд бид эхэн үед тулгарсан уг асуудлуудыг судалж, суралцсаны дараа үлдсэн байгууламжуудаа барьж байгуулахаар боллоо." гэсэн юм. [Парламентын хурлын тэмдэглэл, 2019 оны 6-р сар]
2.4	Ийн хойшилсноор Яам 15 сая ам.долларын зардал нэмж гаргах юм.	Энэхүү 15 сая ам.долларын задаргааг 8-р зурагт үзүүлэв. Эх сурвалж: 2019 оны 5-р сарын Яамны Төслийн Төлөвлөгөө, хувилбар 3.7. Уг 15 сая ам.доллар нь дараахаас бүрдэнэ: ...

Эх сурвалж: ИБУИНХУ-ын УАГ; Фижи улсын АДБ; Гүрж улсын ТАБ; мөн Филиппин улсын АДБ.

Тайланг нягтлах үйл явц гэж юу вэ?

2-р бүлэгт, бид АДБ-ууд чанарын хяналт болон баталгаажуулалтын хүрээнийхээ нэг хэсэг болгож чанарын шалгалтуудыг хийх шаардлагатай талаар авч үзсэн. Тайланг нийтлэхийн өмнө, АДБ-ууд тайлангийн төслөө дотоод чанарын хяналтад оруулах хэрэгтэй. АДБ-ууд өөр өөрийн чанарын нягталгааны горимтой байдаг боловч нягталгаа нь ерөнхийдөө дараах хүмүүсээр хийгддэг:

- АДБ-ын дотоодын янз бүрийн түвшний менежерүүд;
- Харилцаа холбооны экспертүүд;
- Аудитын багаас хараат бус АДБ-ын дотоод оффис; мөн
- Магадгүй, хөндлөнгийн эксперт. Тухайлбал, аудит хийгдэж буй үйл ажиллагааны талаар гүн гүнзгий мэдлэгтэй эрдэм шинжилгээний мэргэжилтэн, арга зүйч эсвэл өөр бусад экспертүүд.

Ийм нягталгаа нь тайланг шударга бөгөөд тэнцвэртэй гэдгийг хараат бусаар баталгаажуулж өгдөг. Шударга бөгөөд тэнцвэртэй тайлан нь дараах шинжтэй байдаг:

- Цуглуулсан нотлох зүйлсэд бодитой хандаж, нэг талыг барьсан хандлага болон ялгаварлалаас зайлсхийдэг;
- Аудитын зорилго(ууд) болон асуултуудад хамааралтай эерэг болон сөрөг нотлох зүйлсэд хоёуланд нь ач холбогдол өгдөг; мөн
- Нотлох зүйлсийг толилуулахдаа уншигчдыг төөрөгдүүлэхгүй буюу ташаа ойлголт төрүүлэхгүй байдлаар толилуулдаг.

Нягтлагч нар нь хараат бус мэргэжлийн үнэлэмжээр нягтлахад шаардлагатай ур чадвартай байх нь чухал. Мэргэжлийн үнэлэмж болон мэргэжлийн үл итгэх үзлийг хэрэгжүүлэх талаар 2-р бүлэгт дэлгэрэнгүй мэдээлэл оруулсан болно.

Өмнө хэлэлцсэнчлэн, АДБ-ууд эцсийн төслөө дээд удирдлагууд, техникийн редакторууд болон харилцаа холбооны мэргэжилтнүүдээр мөн нягтлуулдаг. 47-р зурагт нэг АДБ хэрхэн тайлангийн төслийнхөө чанарын хяналтыг зохион байгуулдгийг харууллаа.

Зураг 47: Танзани улсын УАГ аудитын тайлангийн чанарын хяналтын нягталгааг хэрхэн хийдэг вэ?

Гүйцэтгэлийн аудитын тайлан дахь илрүүлэлтийн тайлбарын жишээ

Чанар бол нягтлагч нарт даатгаж орхих зүйл биш, харин гүйцэтгэлийн аудитын бүхий л үйл явцад шигтгэх учиртай ухагдахуун билээ. Гэхдээ, энэ үйл явцын нэг чухал хэсэг нь чанарын хяналтын нягталгаа юм. Танзани улсын АДБ-д, бусад бүх АДБ-ын нэгэн адил, гүйцэтгэлийн аудитын тайланд чанарыг хамгийн чухалд тооцдог. Итгэлцэл үүсгэхэд их хугацаа шаарддаг ч, ганцхан тайланд орсон хангалтгүй мэдээлэл эсвэл муу шинжилгээгээр итгэлцэл үгүй болж болно. Чанарын хяналтын нягталгааны гол зорилго нь тайлангийн чанарыг сайжруулж, хангалтгүй чанартай болохоос хамгаалахад оршдог.

Тус АДБ нь бүх гүйцэтгэлийн аудитаа гурван төрлийн чанарын хяналтын нягталгаа ашигладаг: мэргэжил нэгтний нягталгаа, судлах сэдэв/ зүйлийн экспертийн нягталгаа, мөн гурван түвшний удирдлагын нягталгаа.

Мэргэжил нэгтний нягталгааны хувьд, бусад багийн хамтран ажиллагсад аудитын төлөвлөгөө болон тайлангийн төслийг нягталдаг. Урьдчилсан судалгааны төсөл болон аудитын тайлангийн төслийг бүх гүйцэтгэлийн аудиторчуудын хурлаар хэлэлцдэг. Тус АДБ-аас гүйцэтгэлийн аудитын практикаа өргөжүүлж, энэхүү нягталгааны хурлыг өөр хэсгүүдээр хязгаарлахаар төлөвлөж байна. Мэргэжил нэгтний нягталгаа нь аудитын багт өөрсдийн дүгнэлтийг хамтран ажиллагсдынхаа хамтын туршлага болон үр ухаантай тулган шалгах боломж олгодог. Бас нэгэн үр өгөөж гэвэл, нягтлагч нар болон бусад ажлын хамт олон нь бусад багуудаа юу хийж байгааг мэдэж, шинэлэг арга хандлагууд (ж.нь: тодорхой орон нутгаас соёлын зан үйлд нийцсэн байдлаар өгөгдөл цуглуулахад тохиромжтой арга техник) болон амжилттай туршлагаа хуваалцдаг. Энэ нь гүйцэтгэлийн аудитын практикийг нэгэн жигд болгож, сайжруулахад хувь нэмэр оруулдаг.

Тус АДБ нь бүх тайлангийн төслөө нийтлэхийн өмнө **экспертүүдээр** мөн нягтлуулахыг хүсдэг. Экспертүүдийг аудитад шалгагдаж буй судлах сэдэв/ зүйлээр тухайн салбартаа онол, практикийн арвин туршлага хуримтлуулсан, нэр хүндтэй экспертүүдээс сонгож авдаг. Тухайлбал, дээд боловсролын байгууллагуудын профессор, тэтгэвэрт гарсан төрийн албан хаагч, аудитад шалгуулагч этгээдтэй ашиг сонирхлын ямар ч холбоогүй өөр бусад эксперт зэрэг хүмүүсээс сонгодог. Экспертүүд нь тайлангийн төсөлд тусгагдсан илрүүлэлт, дүгнэлт, зөвлөмжүүд дээр зөвлөгөө өгч, бэрх, хоёрдмол угтатой эсвэл маргаантай асуудлууд болон тайлагнах стратегийн хувилбаруудын талаарх хэлэлцүүлэгт оролцдог. Энэ нь манай тайлангийн чанарыг сайжруулахад тусалдаг. Ерөнхий Хянагч бөгөөд Ерөнхий Аудитор (ЕХЕА) өөрийн биеэр экспертүүдтэй хийх нягталгааны хурлуудад оролцдог. Энэхүү хянан удирдлагын нягталгааг дэмжих энэхүү зохицуулалт нь ЕХЕА-т тайлангийн төслийн чанарын талаар баталгаа өгдөг.

Удирдлагуудын нягталгаа нь аудитын багийн гаргасан томоохон шийдвэрүүд болон тайлангийн төслийг аудитын багт чухал даалгавруудыг өгөх эрхтэй дээд шатны албан тушаалтнуудаар нягтлуулах зорилготой юм. Багийн ахлагч нарыг гүйцэтгэлийн аудит хариуцсан дээд шатны албан тушаалтнууд буюу Ерөнхий Аудиторын Туслах (ЕАТ) болон Ерөнхий Аудиторын Орлогч (ЕАО) нар хянан удирддаг. Менежерүүдийн үүрэг нь хяналтдаа буй аудитчуудыг тогтсон горимуудын дагуу зохих ёсоор гүйцэтгүүлэхэд оршдог. Тус АДБ-аас саяхан одоогийн удирдлагын бүтцээ үүсгэсэн юм. Энэхүү бүтцийн хувьд, бүх тайлангийн төслийг харгалзах ЕАТ, мөн ЕАО болон нягтлах ёстой.

Эх сурвалж: АХАДБАБ-ын Гүйцэтгэлийн Аудитын Гарын Авлага, 2016.

Энэ үйл явцын үеэр, нягтлагч нар нь түүхий илрүүлэлтээс шинжилгээнд хөтлөх, улмаар аудитын дүгнэлтүүдэд хөтлөх логикийн гинжин холбоог анхааралтай шалгах нь чухал. Дүгнэлт гаргахаасаа өмнө ялгаатай харах өнцгүүд болон холбогдох бүх аргументыг харгалзаж үзэх хэрэгтэй. Ухамсартай уншигчид нэгэн адил нотлох зүйлсийг ашиглан мөн адил дүгнэлтэд хүрдэг байх нь чухал. Энэ төрлийн нягталгааг бүртгэн баримтжуулж, аудитын файлд оруулах хэрэгтэй. Аудитын баг санал зөрөлдөөн үүсэх үед хэрхэн хариу арга хэмжээ авч, шийдвэрлэснээ баримтжуулах нь чухал.

Аудитад шалгуулагч этгээд эсвэл гуравдагч талын саналыг хэрхэн авч үзэх вэ?

6-р бүлэгт тайлбарласанчлан, аудитын баг илрүүлэлтүүдээ аудитад шалгуулагч этгээдтэй хэлэлцэх нь маш чухал (УДИР-3920/129-136). Түүнчлэн, тайланг эцэслэхийн өмнө аудитад шалгуулагч этгээд болон гуравдагч талын үзэл бодлыг сонсож, тайланг нийтлэхээс өмнө зохих өөрчлөлтүүдийг оруулах нь чухал (УДИР-3920/136). Зарим АДБ аудитад шалгуулагч этгээдийн албан ёсны санал болон түүнд хийсэн шинжилгээгээ эцсийн тайланд ил тод нийтэлдэг.



Стандарт

АДБ-аас аудитын тайланг нийтлэхээс өмнө, аудитор нь аудитад шалгуулагч этгээдэд аудитын илрүүлэлт, дүгнэлт, зөвлөмжүүдэд саналаа хэлэх боломж олгох ёстой.

Эх сурвалж: АДБОУС-3000/129.

Тайлангийнхаа нэг хувийн аудитад шалгуулагчид албан ёсоор хүргүүлэх үед, тэд дараах зүйлс дээр санал хэлж магадгүй:

- Тайлангийн баримтын үнэн зөв байдал;
- Баримтуудыг хөрвүүлэн ойлгож, дүгнэлт гаргасан байдал; мөн
- Таны боловсруулсан зөвлөмжүүдийн дагавар утгууд.

Аудитад шалгуулагчийн хариултыг сайтар шинжилж, нотлох зүйлсийн стандартад үндэслэн тайлангийн төсөлдөө зохих өөрчлөлт оруулах талаар бодолцож үзэх нь чухал. Дээр дурдсанчлан, та шинээр гарч ирсэн илрүүлэлтүүдээ аудитад шалгуулагч этгээдтэй хэдийнээ хэлэлцсэн байх болно. Гэсэн хэдий ч, заримдаа аудитад шалгуулагч этгээд илрүүлэлтүүдийг тайлангийн хэлбэрт орсон байдлаар харах үедээ өөр санал хэлдэг.

Аудитын тэмдэглэлийнхээ нэг хэсэг болгож, аудитад шалгуулагч этгээдийн санал болгосон аливаа өөрчлөлтийг яагаад, мөн хэрхэн тайланд тусгаснаа албан ёсоор хураангуйлан тэмдэглэж, аудитын шалгуулагч этгээдийн саналын хамт хадгалах хэрэгтэй.



Стандарт

Аудитор нь аудитад шалгуулагч этгээдийн өгсөн саналд хийсэн шинжилгээгээ, аудитын тайланд өөрчлөлт оруулсан шалтгаан эсвэл саналыг хүлээн авахаас татгалзсан шалтгааны хамт аудитын тэмдэглэлд бүртгэж оруулах ёстой.

Эх сурвалж: АДБОУС-3000/130.

Түүнчлэн, аудитын тайланд ихэвчлэн гуравдагч талуудыг (аудитын хамрах хүрээнд багтаагүй байгууллагууд, бүлгүүд болон хувь хүмүүс) шууд эсвэл шууд бусаар эш татан оруулдаг. Тухайлбал, танай тайлан төрийн үйлчилгээ авдаг хүмүүсийг төлөөлдөг хүмүүнлэгийн тусламжийн байгууллага эсвэл бусад нийгмийн бүлгүүдийг эш татаж болно.

Уг гуравдагч талуудтай холбогдох мэдэгдэл үнэн зөв бөгөөд бүрэн бүтэн байгаа эсэхийг өөрсөдтэй нь холбогдож, тулган баталгаажуулах нь зүйтэй. Энэ үйл явц нь АДБ-д гуравдагч талыг эш татсан үед үнэн зөв бөгөөд шударга мэдээлэл оруулах боломж олгодог.

Хэрхэн эцсийн тайланг нийтэлж, аудитын үр дүнгүүдийг түгээх вэ?



Стандарт

АДБ нь мэдээллийн нууцлалтай холбогдох хууль, журмуудыг харгалзаж үзэнгээ аудитын тайлангаа өргөн хүрээнд хүртээмжтэй болгох ёстой.

Эх сурвалж: АДБОУС-3000/133.

Аудитын тайланг өргөн хүрээнд түгээх нь аудитын үйл ажиллагааны итгэл хүлээх байдлыг нэмэгдүүлдэг. Ийм учраас аудитын тайланг аудитад шалгуулагч этгээд, хууль тогтоох болон гүйцэтгэх засаглал, мөн бусад хариуцагч талуудад хүргүүлэх шаардлагатай. Мөн, эмзэг эсвэл нууцлалтай мэдээлэл агуулсан тайлангаас бусад тайланг бусад оролцогч талууд болон олон нийт шүүд болон хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан хандах боломжтой байлгах хэрэгтэй (АДБОУС-3000/134). Тайланг нийтлэхдээ эмзэг эсвэл нууцлалтай мэдээллийг хассан бол, тодорхой мэдээллийг орхигдуулсан тухайгаа шалтгааных нь хамт бичих хэрэгтэй. (УДИР-3920/138)

АДБ-ууд нь тайлангаа өөрийн бүрэн эрхэд нийцүүлэн нийтэлж, түгээх хэрэгтэй (УДИР-3920/137). Энэ практик АДБ-уудын хувьд янз бүр байж болно. Гүйцэтгэлийн аудитын тайлангийн үндсэн уншигчид нь хууль тогтоох болон гүйцэтгэх засаглал, засгийн газрын агентлагууд, мөн олон нийт байдаг. Сайн гүйцэтгэлийн аудит нь хууль тогтоох засаглалд засгийн газар болон агентлагуудын гүйцэтгэлийг үр нөлөөтэй хянаж, гүйцэтгэлийн сайн үр дүнд хөтлөх өөрчлөлтүүдийг бий болгохын тулд засгийн газар болон төрийн үйлчилгээний шийдвэр гаргагчдад нөлөөлөх боломж олгодог. Гэвч, олон нийт, мөн хувийн хэвшил болон хэвлэл мэдээллийн байгууллага зэрэг бусад оролцогч талуудад, хэдий өөр фокустай байж болох ч, гүйцэтгэлийн аудитын үр дүнтэй тодорхой хэмжээний ашиг сонирхлын холбоотой байдаг (АДБОУС-3000/135). Иймд, холбогдох бүх талуудтай харилцах нь чухал бөгөөд энэ үед та нэмэлт бүтээгдэхүүн бий болгох талаар бодолцож үзвэл зохино. (УДИР-3920/141)

Гүйцэтгэлийн аудитын тайланг бичих үед, дараахыг санагтун:

- ✓ Логиктой бөгөөд ойлгомжтой тайлангийн бүтэц үүсгэх;
- ✓ Зөвлөмж бичихдээ SMART (Specific - Тодорхой, Measurable – Хэмжиж болохуйц, Attributable – Хариуцах эзэнтэй, Relevant – Хамааралтай, мөн Time-bound – Цаг хугацаатай) хүрээг ашиглах;
- ✓ Тайлангаа бүрэн цогц, үнэмшилтэй, цаг үеэ олсон, уншигчдад ээлтэй, тэнцвэртэй байлгах;
- ✓ АДБ-ын стандартуудыг хангуулж, илрүүлэлтүүд болон дүгнэлтүүдийг нотлох зүйлсээр дэмжигдсэн байлгахын тулд тайланг хараат бусаар нягтлуулах; мөн
- ✓ Аудитад шалгуулагч этгээд болон холбогдох гуравдагч талуудын саналыг авч, харгалзан үзэх хангалттай цаг гаргах.

Эх сурвалж: АДБОУБХС/ГАДХ-ны Хөгжлийн Баг.

8-р бүлэг

Гүйцэтгэлийн аудитын мөрөөр хэрхэн хяналт тавих вэ?



Энэ бүлэгт гүйцэтгэлийн аудитын илрүүлэлтүүд болон зөвлөмжүүдийн мөрөөр хяналт тавихын ач холбогдол хийгээд хэзээ хяналт тавивал зохихыг авч үзнэ.

Тус бүлэг нь дараах асуултуудад хариулах болно:

1. Гүйцэтгэлийн аудитын мөрөөр хяналт тавих үйл ажиллагаа гэж юу вэ?
2. Мөрөөр хяналт тавих үйл ажиллагааг хэрхэн гүйцэтгэх вэ?
3. Мөрөөр хяналт тавих үйл ажиллагааг хэзээ гүйцэтгэх вэ?
4. Аудитын нөлөөллийг хэрхэн тодорхойлох вэ?
5. Мөрөөр хяналт тавих үйл ажиллагааны үр дүнг хэрхэн тайлагнах вэ?

Гүйцэтгэлийн аудитын мөрөөр хяналт тавих үйл ажиллагаа гэж юу вэ?



Стандарт

Аудитор нь өмнөх аудитын илрүүлэлтүүд болон зөвлөмжүүдийн мөрөөр зохих ёсоор хяналт тавих ёстой бөгөөд боломжтой тохиолдолд, холбогдох бүх залруулах арга хэмжээ авах шийдвэр болон түүний нөлөөллийн талаар Аудитын Дээд Байгууллага нь хууль тогтоох засаглалд тайлагнах ёстой.

Аудитор нь мөрөөр хяналт тавихдаа аудитад шалгуулагч этгээд үндэслэл бүхий хугацаа өнгөрөхөд асуудлуудаа хангалттай шийдвэрлэж, асуудал үүсгэгч нөхцөл байдлыг арилгасан эсэхэд төвлөрөх ёстой.

Эх сурвалж: АДБОУС-3000/136 болон АДБОУС.

Мөрөөр хяналт тавих үйл ажиллагаа гэдэг нь гүйцэтгэлийн аудитын илрүүлэлтүүд болон зөвлөмжүүдийн мөрөөр аудитад шалгуулагч этгээд эсвэл өөр бусад хариуцагч талын авч хэрэгжүүлсэн залруулах арга хэмжээг шалгах шалгалтыг хэлнэ. Мөрөөр хяналт тавих үйл ажиллагаа нь аудитын мөчлөгийн хамгийн сүүлийн үе шат бөгөөд ерөнхийдөө илрүүлэлтүүдийг шийдвэрлэж, зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх хангалттай хугацаа өнгөрсний дараа эхэлдэг. Энэхүү үйл ажиллагаа нь аудитын нөлөөллийг бэхжүүлэх замаар аудитын үйл явцын үнэ цэнийг нэмэгдүүлдэг хараат бус үйл ажиллагаа юм.

Гүйцэтгэлийн аудитын үндсэн зорилго нь аудитын зөвлөмжүүдийн хэрэгжүүлэлтээр дамжуулан улсын секторын гүйцэтгэл болон ил тод байдлыг сайжруулахад оршдог (1-р бүлгийг үзнэ үү). Илрүүлэлтүүдийг шийдвэрлэж, аудитын зөвлөмжүүдийг шуурхай хэрэгжүүлэх нь аудитад шалгуулагч этгээдийн хариуцлага мөн. Мөрөөр хяналт тавих үйл явцаар дамжуулж, та аудитад шалгуулагч этгээд асуудлууд буюу илрүүлэлтүүдийг шийдвэрлэсэн эсэхийг, шийдвэрлэсэн бол хэрхэн шийдвэрлэснийг, асуудал үүсгэгч нөхцөл байдлыг арилгасан эсэхийг, мөн аудитын зөвлөмжүүдийг хэрэгжүүлсэн эсэхийг хянан-шинжилж чадна. Аудитад шалгуулагч этгээд нь таны өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэхгүйгээр, өөр бусад арга хэмжээг авч хэрэгжүүлэх замаар илрүүлэлтүүдийг шийдвэрлэсэн байх боломжтойг санагтун. Уг арга хэмжээнүүд нь зөвлөмжийн зорилгыг амжилттай биелүүлсэн бол, асуудал шийдвэрлэгдсэн гэж үзэх хэрэгтэй.

АДБОУБ-3-12-ын дагуу, аудитын илрүүлэлтүүд болон зөвлөмжүүдийн мөрөөр хяналт тавих арга хэмжээг тайлагнах нь улсын секторын засаглалыг хариуцсан этгээдүүдэд хариуцлагаа бүрэн хэрэгжүүлж, зохих залруулах арга хэмжээг авахад түслэх арга зам юм. АДБ-ын бүрэн эрх болон үндсэн хуулийн ерөнхий зохицуулалтаас хамаарч, оролцогч талууд гэдэгт хууль тогтоох засаглал, түүний Байнгын Хороод болон аудитад шалгагдагч этгээдийн удирдлагууд хийгээд удирдах зөвлөл багтаж болно.

ИхэнхүлсoronдаудитадшалгагдагчэтгээдньАДБ-аасгаргасанзөвлөмжүүдийгхэрэгжүүлэх хуулиар хүлээсэн үүрэггүй байдаг. Аудитад шалгуулагч этгээдтэй сайн харилцаа үүсгэх нь олон талын үр өгөөжтэй гэж энэхүү гарын авлагын түршид хэлэлцсэнчлэн, уг сайн харилцаа нь аудитад шалгуулагч этгээдийн аудитын явцад илэрсэн дутагдлуудыг залруулж, аудитын зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх магадлалыг мөн өсгөж чадна. Илрүүлэлтүүдийг шийдвэрлэж, зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх нь аудитад шалгуулагч этгээд, төрийн/нийтийн байгууллагууд болон иргэдэд асар их үр өгөөж авчрах болно гэдгийг нотлон үнэмшүүлэх зүйлсийг аудитын үйл явц болон тайланд оруулж өгөх нь чухал. Түүнчлэн, уг илрүүлэлтүүд болон зөвлөмжүүдийнхээ мөрөөр хяналт тавьж, хэрэгжсэн эсэхийг нь, мөн ямар үр нөлөө бий болгосныг нь судлах нь чухал. Мөрөөр хяналт тавих үйл ажиллагаа нь аудитад шалгуулагч этгээд илрүүлсэн дутагдлуудыг үндэслэл бүхий хугацаа өнгөрөхөд хангалттай шийдвэрлэсэн байгаа эсэхийг тогтооход төвлөрөх ёстой (АДБОУС-3000/140). Аудитын дараа үр дүнгүүдийг хэт эрт хэмжвэл бодит байдлыг тогтоож чадахгүй учраас зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх үндэслэл бүхий хугацааг аудитор та тухайн аудит тус бүрд үнэлж тогтоох ёстой.

Аудитын илрүүлэлтүүд болон зөвлөмжүүдийн мөрөөр хяналт тавих үйл ажиллагаа нь хэд хэдэн зорилгыг биелүүлдэг (УДИР-3920/146-147):

Аудитад шалгуулагч этгээд аудитын илрүүлэлтүүд болон зөвлөмжүүдийн дагуу өөрчлөлтүүдийг хэрэгжүүлсэн хэр хэмжээг тодорхойлох. Мөрөөр хяналт тавих нь аудитад шалгуулагч этгээд аудитын үр дүнд илэрсэн сул талуудыг залруулах ямар арга хэмжээ авсныг тодорхойлоход тань тусалж чадна.

- **Аудитад хамааруулж болох нөлөөллийг тодорхойлох.** Мөрөөр хяналт тавих нь аудитад хамааруулж болох өртгийн хэмнэлт болон санхүүгийн бус сайжруулалтуудыг илрүүлж чадна.
- **Ирээдүйд аудит хийвэл зохих талбаруудыг тодорхойлох.** Өмнөх аудитуудын илрүүлэлтүүд болон зөвлөмжүүдийн мөрөөр хяналт тавих нь АДБ-д гүйцэтгэл хэрхэн өөрчлөгдсөнийг тодорхойлох зорилгоор шинэ аудит хийвэл зохих талбаруудыг тодорхойлоход тусалж чадна.
- **АДБ-ын гүйцэтгэлийг үнэлэх.** Мөрөөр хяналт тавих нь АДБ-ын гүйцэтгэлийг үнэлэх суурь болдог бөгөөд АДБ-ын мэдлэгийг дээшлүүлж, практикийг сайжруулахад хувь нэмэр оруулж болно. Энэ утгаараа аудитын үр дүнгийн мөрөөр хяналт тавих үйл ажиллагаа нь чанарын баталгаажуулалтын хэрэгсэл болдог.
- **Хууль тогтоох засаглал болон засгийн газрыг аудитын нөлөөллийн талаарх эгэх мэдээллээр хангах.** Мөрөөр хяналт тавих нь аудитын нөлөөгөөр аудитад шалгуулагч этгээдийн гүйцэтгэл хэрхэн өөрчлөгдөж, ямар сайжруулалтуудыг хийсэн талаарх мэдээллээр хангаж чадна.

Мөрөөр хяналт тавих үйл ажиллагааг хэрхэн гүйцэтгэх вэ?

АДБ-ууд нь өнгөрсөн үеийн гүйцэтгэлийн аудитуудын илрүүлэлтүүд болон зөвлөмжүүдийн мөрөөр хяналт тавих үйл явцыг боловсруулах нь чухал. Аудитын баримт бичиг нь мөрөөр хяналт тавих үйл ажиллагаа маш чухал үүрэг гүйцэтгэдэг бөгөөд, олон тохиолдолд, аудитыг гүйцэтгэсэн аудиторуудаас өөр аудиторууд мөрөөр хяналт тавих үйл ажиллагааг гүйцэтгэх болдог.

Мөрөөр хяналт тавих үед, аудитор та аудитад шалгуулагч этгээд илрүүлэлтүүд болон зөвлөмжүүдийн дагуу зохих арга хэмжээ авсан эсэхийг тогтооходоо нэг талыг бариагүй бөгөөд хараат бус арга хандлагыг ашиглах нь чухал. Зохих арга хэмжээ авсан эсэхийг тогтооходоо гүйцэтгэлийн аудитыг хийсэн багийнхны ашигласантай адил стандартууд болон аргуудыг ашиглах хэрэгтэй.

УДИР-3920/152-т илрүүлэлтүүд болон зөвлөмжүүдийн мөрөөр хяналт тавихад тусгайлан зориулагдсан олон аргыг тайлбарласан байдаг. Ямар арга ашиглах нь танай АДБ-аас тогтоосон горимууд болон тэргүүлэх зорилгуудаас хамаарна. Уг аргуудаас жишээ татвал:

- Тодорхой хугацаа өнгөрсний дараа аудитын илрүүлэлтүүд болон зөвлөмжүүдийн хариуд ямар арга хэмжээ авсныг нь олж мэдэх зорилгоор аудитад шалгуулагч этгээдтэй уулзалт зохион байгуулах. Уулзалтын үеэр цугларах мэдээллээс гадна, аудитад шалгуулагч этгээдийн төлөөлөгч нар авч хэрэгжүүлсэн залруулах арга хэмжээ болон түүнийхээ үр нөлөөг дэмжих баримт бичгүүдийг гаргаж өгөх ёстой.
- Аудитын тайлангаар толилуулсан илрүүлэлтүүд болон зөвлөмжүүдийн дагуу авч хэрэгжүүлсэн эсвэл авч хэрэгжүүлэх гэж буй арга хэмжээнүүдийнхээ талаар АДБ-д бичгээр мэдэгдэхийг аудитад шалгуулагч этгээдээс хүсэх (арга хэмжээнүүдийн талаар бичгээр мэдээлэл хүлээн авсан жишээг 21-р хавсралтаас үзнэ үү).
- Аудитад шалгуулагчийн авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар мэдээлэл цуглуулахын тулд утсаар ярих эсвэл талбар дээр хязгаартай очиж танилцах. Аль алийг нь баримтжуулах хэрэгтэй.
- Илрүүлсэн асуудлуудыг зохих ёсоор шийдвэрлэсэн эсэхийг тогтоохын тулд аудитад шалгуулагч этгээд, бусад хариуцагч талууд, хууль тогтоох засаглал болон хэвлэл мэдээллийн байгууллагуудын хариу үйлдлийн талаар сүүлийн үеийн мэдээлэлтэй байх.
- АДБ-ынхаа санхүүгийн болон нийцлийн аудитын багуудаас аудитын горимынхоо хүрээнд танай багийн илрүүлэлтүүд болон зөвлөмжүүдийн дагуу аудитад шалгуулагч этгээдийн авч хэрэгжүүлсэн арга хэмжээнүүдийн талаар мэдээлэл цуглуулж өгөхийг хүсэж, хүлээн авсан мэдээлэл, баримт бичгүүддээ шинжилгээ хийх.
- Шаардлагатай тохиолдолд шинэ гүйцэтгэлийн аудит хийх. АДБ нь сэдвийн хамааралтай байдал болон шинэ аудитаар бий болгох боломжтой нөлөөллийг харгалзан үзэж, мөрөөр хяналт тавих аудит хийх шаардлагатай эсэхийг шийдэх хэрэгтэй. Мөрөөр хяналт тавих аудит нь мөн зөвлөмжүүдийг хэрэгжүүлсэн ч гэсэн асуудал үргэлжилсээр байгаа тохиолдолд нөхцөл байдлыг үнэлэх арга зам болж болно.



Мөрөөр хяналт тавих зөвлөмж
Аудитын

Дээд Байгууллагын (АДБ) тэргүүн (дарга) аудитын тайланг баталсны дараа, аудитын багийн удирдагч нь аудитад шалгуулагч этгээдэд үйл ажиллагааны төлөвлөгөөний маягт илгээж, бөглүүлэн авч болно. Уг үйл ажиллагааны төлөвлөгөөнд илрүүлэлтүүд болон зөвлөмжүүдийн мөрөөр хэрэгжүүлсэн эсвэл хэрэгжүүлэхээр зорьж буй арга хэмжээнүүдийн төрлүүд, мөн цаг хугацааны хуваарь болон холбоо барих хүний мэдээлэл орох ёстой. Шаардлагатай тохиолдолд, аудитын баг аудитад шалгуулагч этгээдийн төлөөлөлтэй уулзаж, үйл ажиллагааны төлөвлөгөөнд оруулбал зохих мэдээллийн талаар хэлэлцэж, тодорхой болгож болно. Үйл ажиллагааны төлөвлөгөөг бөглөж, буцаан илгээх эцсийн хугацааг тодорхой зааж өгөх нь зүйтэй.

Эх сурвалж: АДБОУБХС/ГАДХ-ны ХБ.

Аудитын тэмдэглэл боловсруулахдаа ашиглаж буй горимоо мөрөөр хяналт тавих үйл ажиллагааны явцад цуглуулсан нотлох зүйлсийг баримтжуулахад мөн ашиглах хэрэгтэй (аудитын тэмдэглэлийг зохион байгуулах талаар дэлгэрэнгүй мэдээллийг 2-р бүлгээс үзнэ үү). Нотлох зүйлсийг үнэлж, илрүүлэлтүүдийг шийдвэрлэж, зөвлөмжүүдийг хэрэгжүүлсэн эсэхийг тогтоох хүрээтэй байх нь мөн тустай байдаг. Энэ үнэлгээг хийхэд ашиглаж болох хүрээг 21-р хавсралтаас үзнэ үү. Ийм хүрээтэй үед, та илрүүлэлтүүд болон зөвлөмжүүдийг тань хэрэгжүүлсэн хэр хэмжээ болон төлөв байдлыг үнэлж, баримтжуулж чадна. Аудитад шалгуулагч этгээд нь аудитын зөвлөмжийг хэрэгжүүлсэн эсэхтэй холбогдох нотлох зүйлсийг нягтлахдаа, хэрэгжүүлэлтийн хэр хэмжээг ангилах тогтолцоотой байх нь мөн тустай байж болно.

Тухайлбал, дараах ангиллыг ашиглаж болно:

- **Бүрэн хэрэгжүүлсэн.** Аудитад шалгуулагч этгээд нь зөвлөмжийн зорилгыг хангах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн. Аудитад шалгуулагч этгээд нь асуудлыг зөвлөмжид тусгаснаас өөр арга хэмжээгээр шийдвэрлэсэн байх боломжтой.
- **Хагас хэрэгжүүлсэн.** Аудитад шалгуулагч этгээд тодорхой хэмжээний арга хэмжээ авч хэрэгжүүлсэн боловч зөвлөмжийг хараахан бүрэн хэрэгжүүлээгүй.
- **Хэрэгжүүлээгүй.** Аудитад шалгуулагч этгээд хангалттай хугацаа өнгөрөхөд зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч хэрэгжүүлээгүй. Тухайлбал, аудитад шалгуулагчийн зөвлөмжийг хэрэгжүүлэх эцсийн хугацаа өнгөрсөн бөгөөд аудитад шалгуулагч этгээд зөвлөмжийг хэрэгжүүлээгүй.
- **Хамааралгүй болсон.** Зөвлөмжид бусад үйл явдлууд эсвэл орчин нөхцөл нөлөөлж, хэрэгжүүлэхэд тохиромжгүй болгосон.
- **Тулган баталгаажуулж чадаагүй.** Зөвлөмжийн хэрэгжилтийн төлөв байдлыг тодорхойлж чадаагүй. Өмнө дурдсанчлан, зарим үед мөрөөр хяналт тавих үйл явцын дүнд нэмэлт нягталгаа хийх шаардлагатай чухал асуудлууд илэрч болно. Хэрэв нэмэлт нягталгаа шаардлагатай бол, шинэ гүйцэтгэлийн аудит хийх нь тохиромжтой болж магадгүй. Танай АДБ тухайн сэдвээр шинэ гүйцэтгэлийн аудит хийхээр шийдсэн тохиолдолд, өмнөх илрүүлэлтүүд болон зөвлөмжүүдийг яагаад шийдвэрлээгүй гэдгийг тодорхойлох нь чухал. Зарим тохиолдолд, бусад хүчин зүйлийн улмаас асуудал үүсгэгч нөхцөл байдал өөрчлөгдөж, улмаар зөвлөмжүүдийг хамааралгүй болгосон, эсвэл аудиттай хамааралгүй шалтгаануудын улмаас асуудал оршихоо больсон байдаг. Энэ бүх асуудлыг аудитын мөрөөр хяналт тавих үйл ажиллагааг гүйцэтгэх хугацааны хамт бодолцож үзэх хэрэгтэй.



А У Д И Т Ы Н зөвлөмжүүдийн дагуу хэрэгжүүлсэн эерэг арга хэмжээгээ тайлагнах нь чухал. Учир нь ингэснээр аудитад шалгуулагч этгээд болон АДБ-ын итгэл хүлээх байдал нэмэгдэнэ. Түүнчлэн, энэ нь аудиторүүд болон АДБ-д мөрөөр хяналт тавих үйл ажиллагааг гүйцэтгэж, АДБ-ынхаа дүр төрх, нэр хүнд болон итгэл хүлээх байдалд эерэг нөлөөлөл үзүүлэх нэмэлт сэдэлжүүлэлт болох юм.

Эх сурвалж: АДБОУБХС/ГАДХ-ны ХБ.

Мөрөөр хяналт тавих үйл ажиллагааг хэзээ гүйцэтгэх вэ?

Мөрөөр хяналт тавих үйл ажиллагааг ерөнхийдөө АДБ-аас зохистой гэж үзсэн мөчлөгтэйгөөр хийдэг. Мөрөөр хяналт тавих үйл ажиллагааны даалгавруудын ач холбогдлын эрэмбийг ихэвчлэн АДБ-ын аудитын ерөнхий стратегийн хүрээнд үнэлж тогтоодог. Аудитад шалгуулагч этгээдэд зохих арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх хангалттай хугацаа өгөх ёстой. (УДИР-3920/148)

Танай аудитын баг аудитын явцад, ялангуяа илрүүлэлтүүд болон зөвлөмжүүдийн төслийг боловсруулж байхдаа мөрөөр хяналт тавих үйл ажиллагааны талаар бодож эхлэх хэрэгтэй. Зөвлөмжүүдийн төслийг боловсруулахдаа, 6-р бүлэгт авч үзсэнчлэн, танай баг зөвлөмжүүдийг аудитад шалгуулагч этгээд зохих ёсоор хэрэгжүүлж чадахуйц байлгаж, үр өгөөж нь хэрэгжүүлэх өртгөөс нь илүү байхад анхаарах ёстой. Түүнчлэн, аудитын төгсгөл үед, танай аудитын баг аудитад шалгуулагч этгээдийн дээд удирдлагатай дээд түвшний ярилцлагуудыг хийж, илрүүлэлтүүд болон зөвлөмжүүдийн мөрөөр хяналт тавих үйл

ажиллагаа явуулахаар аудитад шалгуулагчтай холбоо барихад дагаж мөрдөх горимыг тодорхойлох хэрэгтэй.

Тухайлбал, АДБ нь аудитад шалгуулагч этгээдтэй харилцаж, үйл явцаа тодорхойлохоор болсон гэж үзье. Зөвлөмжүүдийг аудитад шалгуулагч этгээдтэй хэлэлцэх үед, тэднээс зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх цаг хугацааны хуваариа гаргаж өгөхийг хүсэж болно. Ингэснээр мөрөөр хяналт тавих хуваарь болон зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх арга хэмжээнүүдийг төлөвлөхөд дөхөм болох тул энэ нь аудитад шалгуулагч этгээдэд ч, АДБ-д ч үнэ цэн нэмж чадна. Аудитад шалгуулагч этгээд нь мөн үйл ажиллагааны төлөвлөгөө санал болгож болно.

АДБОУС-3000/139-ийн дагуу, аудитор нь мөрөөр хяналт тавихдаа аудитад шалгуулагч этгээд үндэслэл бүхий хугацаа өнгөрөхөд асуудлуудаа хангалттай шийдвэрлэж, асуудал үүсгэгч нөхцөл байдлыг арилгасан эсэхэд төвлөрөх ёстой. Энэхүү үндэслэл бүхий хугацаа нь тухайн аудитын зөвлөмжүүдийн хам сэдэв (хам нөхцөл) болон мөн чанараас хамаарна. Мэдээж, зарим зөвлөмжийг хэрэгжүүлэхэд илүү урт хугацаа шаардагддаг байхад бусдынх нь хувьд илүү богино хугацаа шаардагддаг байх боломжтой. Түүнчлэн, та ямар үед ямар төрлийн өгөгдөл үүсэх боломжтой вэ гэдгийг харгалзан үзэх ёстой. Тухайлбал, зөвлөмжийн хэрэгжилтийн үр нөлөөг зөвхөн хангалттай хугацаа өнгөрсний дараа хэмжих боломжтой байж болно.

Зарим илрүүлэлт болон зөвлөмж нь хамааралгүй болсон байж болно. Иймд, мөрөөр хяналт тавих үедээ хамааралтай хэвээр байгаа илрүүлэлт, зөвлөмжүүдэд төвлөрөх хэрэгтэй. (УДИР-3920/151)

Мөрөөр хяналт тавих үйл ажиллагааг гүйцэтгэх цагийг товлох нь АДБ тус бүр өөрийн бодлого эсвэл бүрэн эрхийн дагуу гаргах удирдлагын гол шийдвэр юм. Тухайлбал, АДБ нь аудитын зөвлөмжийн хэрэгжилттэй холбогдуулан жил бүр мөрөөр хяналт тавих ажил хийх бодлоготой байж болно. Энэ практик нь үр дүнгүүдийг системтэйгээр тайлбарлахад түстэй байж болох ч, аудитын тайланг нийтэлснээс хойших эхний жилд аудитын нөлөөллийг нотлох зүйл маш бага байж болно. АДБ тайлагналын ямар ч мөчлөгийг сонгосон бай, түүнтэйгээ үялдсан шинжилгээ болон тайлангийн хязгаарлалтуудыг маш тодорхой мэддэг байх шаардлагатай.

Тухайлбал:

- **Бразил улсын АДБ**-ын хувьд, аудитад шалгуулагч этгээдээс гаргасан үйл ажиллагааны төлөвлөгөөг шинжилсний дараа мөрөөр хяналт тавих хуваарь гаргадаг. Мөрөөр хяналт тавих хугацааг аудитад шалгуулагч этгээдийн тодорхойлсон зөвлөмжийг хэрэгжүүлэх эцсийн хугацааны дагуу шийддэг.
- **Америкийн Нэгдсэн Улсын ТХГ**-ын хувьд, гүйцэтгэлийн аудитыг хийж, үр дүнг нь тайлагнасны дараа, мөрөөр хяналт тавих үйл ажиллагааг дөрвөн жилийн турш, жилд багадаа нэг удаа явуулдаг. Тэд мөн дөрвөн жилийн хугацаанд хэрэгжсэн зөвлөмжүүдийн хувь хэмжээг тандан судлах замаар засгийн газрын эгэх хариуцлага, үйл ажиллагаа болон үйлчилгээг сайжруулахад үзүүлсэн нөлөөллийг хэмждэг.
- **Гүрж улсын АДБ**-ын хувьд, аудиторүүд аудитад шалгуулагчаас ирүүлсэн үйл

ажиллагааны төлөвлөгөөнд үндэслэн жилд хоёр удаа зөвлөмжийн мөрөөр хяналт тавихыг хичээдэг. Тэд мөн эл үйл явцаа хялбаршуулахын тулд зөвлөмж хянан-шинжлэх цахим систем хөгжүүлж байна. Чухал аудитүүдын хувьд, тэд олон жилийн дараа мөрөөр хяналт тавих тухай бодолцож үздэг.

- **Филиппин улсын АДБ**-ын хувьд, аудиторууд гүйцэтгэлийн аудитын тайланг аудитад шалгуулагч этгээдэд илгээхдээ тайланд орсон зөвлөмжүүдэд үндэслэн гүйцэтгэх үйл ажиллагааны төлөвлөгөөгөө хариу илгээх хүсэлтийг хавсаргадаг. Аудитад шалгуулагч этгээд нь тайланг хүлээн авснаас хойш 60 хоногийн дотор стандартад нийцсэн үйл ажиллагааны төлөвлөгөө гаргаж, АДБ-д ирүүлдэг. Зөвлөмжийн хэрэгжилтийн төлөв байдлын мөрөөр хяналт тавих үйл ажиллагааг жилийн төгсгөлд гүйцэтгэдэг.
- **Европын Аудиторуудын Шүүх** болон **Норвег улсын АДБ**-ын хувьд, мөрөөр хяналт тавих үйл ажиллагааг ерөнхийдөө гүйцэтгэлийн аудитын тайланг нийтэлснээс хойш гурван жилийн дараа гүйцэтгэдэг. Энэ нь аудитад шалгуулагч этгээдэд аудитын зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх хангалттай хугацаа олгодог.

Аудитын нөлөөллийг хэрхэн тодорхойлох вэ?

Мөрөөр хяналт тавихын нэг шалтгаан нь төрийн бодлого болон үйлчилгээг сайжруулахад аудитын үзүүлсэн нөлөөллийг тодорхойлох явдал юм. Аудитын зөвлөмжийн хэрэгжилтийн нөлөөллийг хэмжих олон арга бий. Дараах жишээнүүдийг Бразил улсын АДБ болон АНУ-ын ТХГ-ын мэдээллээс авав.

- **Санхүүгийн нөлөөлөл.** Зардал буурах эсвэл орлого өсөхтэй холбогдох үр өгөөж. Тухайлбал, ажлын ачаалал багатай техникийн үйлчилгээний байгууламжуудыг хаах зөвлөмж хэрэгжсэнээр 50 сая ам.доллар хэмнэгджээ.
- **Чанарын бөгөөд тоологддог нөлөөлөл.** Гүйцэтгэлийн сайжруулалттай холбогдох, тоон утгаар илэрхийлж болохуйц үр өгөөж. Тухайлбал, зөвлөмжийн хэрэгжилт нь уушгины хорт хавдрын эмчилгээний хүлээлгийн хугацааг 15 хоногоор багасгажээ.
- **Чанарын бөгөөд тоологддоггүй нөлөөлөл.** Гүйцэтгэлийн сайжруулалттай холбогдох, тоон утгаар илэрхийлж болохооргүй үр өгөөж. Тухайлбал, зөвлөмжийн хэрэгжилт нь аюултай материалтай харьдаг албан хаагчдад зориулсан аюулгүй ажиллагааны горимыг сайжруулжээ.

Аудитын нөлөөллийг аудитын түршид буюу аудитын сэдвийг сонгохоос авхуулаад аудитын мөрөөр хяналт тавих хүртэл харгалзаж үзэх ёстой. Мөрөөр хяналт тавих үйл явцын үеэр аудитад шалгуулагч этгээдийн зөвлөмжийг хэрэгжүүлсний нөлөөллийг үнэлж, янз бүрийн аргаар хэмжиж болно. Тухайлбал, мөрөөр хяналт тавих үед илэрсэн нөхцөл байдлыг аудитын явцад илэрсэн нөхцөл байдалтай харьцуулж, ямар нэгэн өөрчлөлт байгаа эсэхийг тогтоож болно. Зөвлөмжийн хэрэгжилтийн улмаас үүссэн үр нөлөөг өөр бусад хүчин зүйлсийн улмаас үүссэн өөрчлөлтөөс ялгаж салгах нь чухал.

Аудитад шалгуулагч этгээд нь мөн авч хэрэгжүүлсэн арга хэмжээнийхээ нөлөөллийг тооцоолж болно. Эсвэл гэрээлэгчээр тооцоолуулж болно. Танай илрүүлэлтүүд болон зөвлөмжүүдийн нөлөөллийг хөндлөнгийн байгууллага хараат бусаар үнэлсэн байх боломжтой.

Тухайлбал, ИБУИНХУ-ын Үндэсний Аудитын Газарт, аудитын баг нь сэтгэцийн гэмтлийн гол төвүүдэд хийсэн аудитынхаа илрүүлэлтүүд болон зөвлөмжүүдийн мөрөөр хяналт тавих үйл ажиллагааныхаа явцад аудитын тайлангийнх нь үр дүнд бий болсон өөрчлөлтүүдийн нөлөөллийг нэгэн эрдэм шинжилгээний судалгаагаар хэмжсэн байсныг олж мэджээ. Ийм судалгаа хийгдсэн байвал, та уг судалгааг шинжилж, үр дүнг нь зөвлөмжийн нөлөөллийн нотлох зүйл болгон ашиглах боломжтой эсэхэд үнэлгээ хийх хэрэгтэй.



Аудитын мөрөөр
хяналт тавих үйл
ажиллагааны үр

дүнгийн жишээ
2019 онд мөрөөр хяналт тавих үйл ажиллагаагаараа Төрийн хариуцлагын газар (ТХГТХГ) 214.7 тэрбум ам.долларын санхүүгийн үр өгөөж буюу хөрөнгө оруулсан ам.доллар тутамд ойролцоогоор 338 ам.долларын үр өгөөжтэй ажилласан байна. Үүнээс гадна, ам.доллароор хэмжих боломжгүй боловч, засгийн газрын хөтөлбөрүүд болон үйл ажиллагааг сайжруулахад хүргэсэн 1,418 үр өгөөжийг илрүүлжээ.

Эх сурвалж: АДБОУБХС/ГАДХ-ны ХБ.

АДБЕБ-аас хийсэн судалгаагаар аудитын нөлөөлөлд нөлөөлдөг 6 хүчин зүйлийг илрүүлжээ (EUROSAI, 2021). Тэдгээр нь:

- Аудитын тайлангийн чанар.
- Аудитор болон аудитад шалгуулагч этгээд хоорондын бүтээлч харилцаа.
- Мөрөөр хяналт тавих тогтолцооны буй байдал.
- Парламентын оролцоо.
- Мөрөөр хяналт тавих тогтолцооны үр дүнг тайлагнах байдал.
- Мөрөөр хяналт тавих үйл ажиллагааны үр дүнгүүдийг гүйцэтгэлийн хяналт-шинжилгээний тогтолцоо болон эрсдэлийн үнэлгээнд ашиглах байдал.

Мөрөөр хяналт тавих үйл ажиллагааны үр дүнг хэрхэн тайлагнах вэ?

АДБ-уудад мөрөөр хяналт тавих үйл ажиллагааны үр дүнг тайлагнах тогтолцоо үр өгөөжтэй байж болно. АДБ-ын гүйцэтгэлийн аудитаас бий болсон үр өгөөжийг олон нийтэд тайлагнах нь АДБ-ын бий болгосон үнэ цэнийг нийтэд ойлгуулахад чухал үүрэг гүйцэтгэдэг. Энэ нь АДБ-д төсөв буюу нөөцийн хүсэлтээ зөвтгөж, нэр хүнд болон итгэл хүлээх байдлаа эергээр нэмэгдүүлэхэд тустай байж чадна.

Мөрөөр хяналт тавих хүчин зүтгэлийнхээ үр дүнг дангаар нь, эсвэл АДБ-ынхаа мөрөөр хяналт тавих үйл ажиллагааны нийт эсвэл хэсэгчилсэн үр дүнтэй нэгтгэсэн байдлаар тайлагнаж болно. Мөрөөр хяналт тавих үйл ажиллагааны нэгтгэсэн тайланд тайлагналын хэд хэдэн талбар дахь нийтлэг чиг хандлагууд болон сэдвүүдийн шинжилгээ багтаж болно. Ямар ч хэлбэрээр тайлагнасан бай, мөрөөр хяналт тавих үйл ажиллагааны тайлан нь тэнцвэртэй, толилуулсан илрүүлэлтүүд нь бодитой бөгөөд шударга байх ёстой. (УДИР-3920/155)

Мөрөөр хяналт тавих үйл ажиллагааны тайлан дараах бүтэцтэй байж болно:

1. **Оршил.** Яагаад аудит хийсэн тухай тайлбар, мөн өмнө нь мөрөөр хяналт тавих үйл ажиллагаа гүйцэтгэсэн бол түүний тухай мэдээлэл оруулна.
2. **Тойм.** Аудитын сэдвийг товч тайлбарлана.
3. **Арга зүй.** Мөрөөр хяналт тавих үйл ажиллагааг хэрхэн гүйцэтгэсэн тухай бичнэ.
4. **Аудитын илрүүлэлтүүд.** Энэ нь уг тайлангийн үндсэн хэсэг болно. Энэ хэсэгт илрүүлэлтүүд, тэдгээртэй холбогдох зөвлөмжүүд, мөн зөвлөмжүүдийн хэрэгжилтийн мөрөөр хяналт тавих явцад илэрсэн нөхцөл байдлын талаарх дүгнэлт багтаж болно.
5. **Аудитад шалгагдагч этгээдийн санал.** Мөрөөр хяналт тавих үйл ажиллагааны тайлангийн төсөлд өгсөн саналын хураангуй.
6. **Дүгнэлт.** Зөвлөмжийн нөхцөл байдлын тойм.

48-р зурагт Бразил улсын АДБ-аас гаргасан “Бразил улсын өндөр гүйцэтгэлтэй спортууд” гэх хөтөлбөрт хийсэн гүйцэтгэлийн аудитын мөрөөр хяналт тавих үйл ажиллагааны тайлангийн хэсгээс харууллаа.

Зураг 48: Мөрөөр хяналт тавих үйл ажиллагааны тайлангийн хэсгээс

Мөрөөр хяналт тавих үйл ажиллагааны тайлангийн хэсгээс

... III.4 Замналаа дуусгасан (зодог тайлсан) тамирчдын нийгэм-боловсролын дэмжлэг

Аливаа тамирчин бэлтгэл сургуулилтаа бүрмөсөн зогсоож, тэмцээнд орохоо болихоор бэлдэж эхлэх мөчийг "замналын шилжилт" гэдэг үгээр илэрхийлэх нь олонтоо. Замналаа дуусгахад нас ахисны улмаас гүйцэтгэл буурсан, гэмтэл бэртэл авсан, эсвэл бүр өөр ажил хийж амьдрахыг хүссэн зэрэг олон шалтгаан нөлөөлж болно. Иймд, энэ үйл явц нь төлөвлөгдсөнөөр эсвэл өөрийн эрхгүй өрнөдөг.

Бразил улсад, Өндөр Гүйцэтгэлтэй Спортын Салбарын бодлогын нэг зорилго нь тамирчид болон пара-спортын тамирчдыг спортын замналынхаа турш оюуны болон мэргэжлийн хөгжлийн сургалтад хамрагдах боломжоор хангахад оршдог.

III.4.1 Аудитын тайланд юу тусгагдсан бэ?

Аудитаар засгийн газраас хэрэгжүүлдэг арга хэмжээний хөтөлбөрт тамирчдын замналаа дуусгасны (зодог тайлсны) дараах хугацааг хамруулаагүй нь илэрсэн байна.

АДБ-аас Өндөр Гүйцэтгэлтэй Спортын Нарийн Бичгийн Даргад тамирчид болон зодог тайлсан тамирчдыг дэмжих тогтолцоог шинэчилж, тамирчны замналаа дуусгасан хойноо спортын салбартаа үлдэх нөхцөлөөр хангах стратегийн төлөвлөлт хийхийг зөвлөсөн билээ.

III.4.2 Мөрөөр хяналт тавих үед илэрсэн нөхцөл байдал – зөвлөмж хэрэгжээгүй

Үйл ажиллагааны төлөвлөгөөнд уг зөвлөмжийг хэрэгжүүлэх бодитой санал тусгагдаагүй байна. Энэ асуудлын талаар тодруулахад, аудитад шалгагдагч этгээд нэг төсөл боловсруулж байгаа гэж хариулсан юм. Зорилго нь мэргэжилтнүүдийг спортын удирдлагатай холбогдох үүрэг гүйцэтгэх онлайн сургалтад хамруулах явдал гэв. Зөвлөмжтэй холбоотой дурдагдсан цор ганц арга хэмжээ энэ байлаа.

Мөрөөр хяналт тавих үед, АДБ-аас судалгаа явуулсан юм. Судалгаагаар аудитын сэдвийг спортын холбоод болон нэгдсэн холбоодын төлөвлөлтөд маш бага тусгасан бөгөөд тамирчдын нийгэм-боловсролын дэмжлэгт чиглэсэн ямар ч нэгдсэн стратеги байхгүй байна гэсэн дүгнэлт гарчээ.

Тамирчдыг өөр замналаар боловсрол, мэргэжил эзэмшихийг дэмжихэд чиглэсэн санаачилгуудын хувьд, асуумжид хариулсан нэгдсэн холбоод болон холбоодын ихэнх удирдлагууд (тус тус 67%, 57%) байгууллагынхаа төлөвлөгөөнд энэ төрлийн санаачилгыг оруулаагүй эсвэл оруулахаар боловсруулж байгаа гэж хариулсан байна. Одоогоор бэлэн байгаа сургалтын хөтөлбөрийн хувьд, холбоодын 76%, нэгдсэн холбоодын 67% нь энэ зорилгоор хийсэн төлөвлөлт байхгүй гэжээ.

Ойрын хугацаанд замналаа орхих хүслийг нь нэмэгдүүлж болох хүчин зүйлсийн талаар асуухад, асуумжид хариулсан тамирчдын 42% нь "тамирчны хувиар цаашид мэргэшиж ажиллахтай холбоотой ойлголт дутагдаж байгаа" гэсэн сонголтыг сонгожээ. Энэ нөхцөл байдал нь тамирчдын заримынх нь сэтгэл ханамж болон урам зоригийн түвшинд нөлөөлж байна.

Илэрсэн нөхцөл байдлын улмаас, тус зөвлөмжийг хэрэгжээгүй гэж үзлээ.

...

Эх сурвалж: Бразил улсын АДБ-ын мөрөөр хяналт тавих үйл ажиллагааны тайлангийн хэсгээс.

АДБ мөрөөр хяналт тавих үйл ажиллагааныхаа үр дүнг өөр арга замуудаар мөн тайлагнаж болно. Тухайлбал, АНУ-ын ТХГ-т зөвлөмжүүд болон тэдгээрийн хэрэгжилтийн төлөв байдлыг (статусыг) олон нийтэд нээлттэй байлгах өгөгдлийн сан бий. Тэд жил тутмын Гүйцэтгэл болон Эгэх Хариуцлагын Тайлан зэрэг бусад механизмынхаа хамт, энэхүү өгөгдлийн сангаа ашиглаж, мөрөөр хяналт тавих үйл ажиллагааныхаа төлөв байдал болон хийсэн ажлынхаа нөлөөллийг нийтэд мэдээлдэг. ТХГ-аас мөн сүүлийн дөрвөн жилд гаргасан нийт зөвлөмжүүдийнхээ хэрэгжилтийн хувь хэмжээг олон нийтэд тайлагнадаг.

Мөрөөр хяналт тавих үйл ажиллагааг АДБ-ын тогтсон горимын дагуу тайлагнах ёстой. Хууль тогтоох засаглалд мөрөөр хяналт тавих аудитын тайлан гаргаж өгвөл зохих эсэх нь

АДБ аудитын илрүүлэлтүүд, дүгнэлтүүд болон хэрэгжсэн залруулах арга хэмжээнүүдийн нөлөөллийг хэр ач холбогдолтой гэж үнэлснээс хамаарна.

Гүйцэтгэлийн аудитын мөрөөр хяналт тавих үед, дараахыг санагтун:

- ✓ Танай илрүүлэлтүүд болон зөвлөмжүүдийн мөрөөр арга хэмжээ авсан эсэхийг хянан-шинжлэх;
- ✓ Аудитын зөвлөмжүүдийн хариуд авсан эерэг арга хэмжээнүүдийг тайлагнах. Учир нь энэ нь аудитад шалгуулагч этгээд болон Аудитын Дээд Байгууллагын (АДБ) хоёулангийнх нь итгэл хүлээх байдлыг нэмэгдүүлнэ. Мөн, АДБ-ын дүр төрх, нэр хүнд, төсөв болон итгэл хүлээх байдалд эергээр нөлөөлж болно;
- ✓ Аудитад шалгуулагч этгээд нь илрүүлэлтүүд болон зөвлөмжүүдийн мөрөөр зохих арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн эсэхийг тодорхойлоход нэг талыг бариагүй бөгөөд хараат бус арга хандлагыг ашиглах;
- ✓ Аудитын явцад, ялангуяа илрүүлэлтүүд болон зөвлөмжүүдийн төслийг бичих үед мөрөөр хяналт тавих талаар бодох;
- ✓ Илрүүлэлтүүд болон зөвлөмжүүдийн хариуд аудитад шалгуулагч этгээдийн авч хэрэгжүүлсэн арга хэмжээ нь таны аудитын явцад цуглуулсан нотлох зүйлсээ үнэлэхдээ баримталсантай нэгэн ижил стандартууд болон горимуудыг баримталсан эсэхийг үнэлэх; мөн
- ✓ Аудитад шалгагдагч этгээдийн авч хэрэгжүүлсэн арга хэмжээг аудитын тэмдэглэлдээ баримтжуулж, хянагчийн нягталгаа хийлгэх.

Эх сурвалж: АДБ ОУБХС/ГАДХ-ны Хөгжлийн Баг.

Хавсралтууд

Хавсралт 1: Холбогдох стандарттай нийцэх нийцлийг баталгаажуулах АДБ-ын ЧБ-ын хүрээний жишээ



Эх сурвалж: АНУ-ын ТХГ-ын мэдээллийг эш болгов.

Хавсралт 2: Гадаад үйл ажиллагаанд оролцох зөвшөөрлийн маягтын жишээ

Маягтын жишээ: Гадаад үйл ажиллагаанд оролцох зөвшөөрөл¹⁴

1. Нэр:	2. АДБ-ын нэгж/оффис:	3. Албан тушаал:
4. Гаднын ажил олгогч, нийтлэгч эсвэл байгууллага:		5. Бизнес эсвэл үйл ажиллагаа:
6. Таны үүрэг, ажил эсвэл нийлүүлэх бүтээгдэхүүн/үйлчилгээ:		7. АДБ энэ талбарт ажилладаг уу? Та энэ талбарт ажилладаг уу?
8. Ажиллах эсвэл сайн дурын ажил хийх цаг?		9. Нөхөн олговор?
10. АДБ болон гадаад үйл ажиллагаа хооронд бизнесийн харилцаа, хэрэв байгаа бол, тайлбарлана уу?		
11. Хэрэв нийтлэл эсвэл яриа бол, сэдвийг нь тодорхойлж, холбогдох АДБ-ын бүтээгдэхүүнүүдийг жагсаана уу: Жич: Аливаа гадаад нийтлэл эсвэл бэлдсэн ярианы бичвэрийг нийтлэх буюу ярихын өмнө зохих нэгж эсвэл оффисоор нягтлуулах ёстой.		
12. АДБ-ын 123-р тушаалд заасны дагуу, миний бие дээр дурдсан гадаад үйл ажиллагаанд оролцох АДБ-ын зөвшөөрөл хүсэж байна. Миний бие албан үүрэгт ажлын цагаараа уг үйл ажиллагаанд оролцохгүй болно.		
Аудиторын гарын үсэг ба огноо:		
13. Хянагчийн зөвлөмж ___ Зөвшөөрөх ___ Болзолтой зөвшөөрөх (болзлуудын хураангуйг хавсаргах) ___ Үл зөвшөөрөх (шалтгааны хураангуйг хавсаргах) Хянагчийн гарын үсэг:		
14. Зөвшөөрөл олгосон албан тушаалтны гарын үсэг		
Илүү богино хугацааг энд бичээгүй бол, зөвшөөрлийн хүчинтэй хугацаа 3 жилийн дараа дуусна:		

Эх сурвалж: АНУ-ын ТХГ.

¹⁴ АДБ-ын ажилтнууд нь энэхүү маягтыг ашиглан дараах төрлийн гадаад үйл ажиллагаанд оролцох зөвшөөрөл хүсэж болно: (1) хувь хүн өөрийн цаг хугацаа, хүчин зүтгэл эсвэл авьяас чадварын хариуд нөхөн олговор, цалин эсвэл төлбөр хүлээн авах үйл ажиллагаанд оролцох (уг үйл ажиллагаа эсвэл хөдөлмөр эрхлэлтийг гүйцэтгэхэд бодитоор гарсан замын болон бусад зардлын нөхөн олговрыг хасна); (2) ажилтан уг үйл ажиллагааг үнэ төлбөргүй гүйцэтгэсэн байсан ч, нөхөн төлбөр, цалин эсвэл төлбөртэй хийгдэж заншсан үйл ажиллагаанд оролцох; (3) ерөнхийдөө үнэ төлбөргүй хийгдэж заншсан байсан ч, илтгэл тавих эсвэл бичих үйл ажиллагаанд оролцох; (4) холбоо эсвэл байгууллагад ажилтан, захирал, удирдах зөвлөлийн гишүүн эсвэл төлөөлөгчийн ажил хийх; (5) АДБ-ын тушаалаар зөвшөөрсөн сонгуульт ажилд өрсөлдөх.

Хавсралт 3: Хараат бус байдлын мэдэгдлийн жишээ

Маягтын жишээ: Аудиторын хараат бус байдлын мэдэгдэл

АДБ-ын аудиттай холбогдох бүх асуудалд, АДБ, түүний ажилтнууд болон бусад оролцогч нар өөрсдийнх нь шударга байдал, бодитой хандлага эсвэл мэргэжлийн үл итгэх үзэлд учир ойлгодог бөгөөд мэдээлэлтэй гуравдагч тал эргэлзэхэд хүргэх орчин нөхцөлөөс ангид байж, бодит болон харагдах байдал дээрх хараат бус байдлаа хадгалах ёстой.

- a. Хараат бус байдалд учрах аюулд дараах багтана (гэхдээ дараахаар хязгаарлагдахгүй):
- b. Хувийн ашиг сонирхол – Санхүүгийн эсвэл бусад хувийн ашиг сонирхол нь аудиторын/шалгагчийн үнэлэмж эсвэл зан үйлд зохисгүй байдлаар нөлөөлөх аюул.
- c. Хувийн үзэмж – Аудитын бүс үйлчилгээ үзүүлж байсан аудитор эсвэл аудитын байгууллага нь аудитад чухал ач холбогдолтой дүгнэлт гаргах үедээ өмнө нь гаргаж байсан дүгнэлтийнхээ үр дүнг эсвэл аудитын бүс үйлчилгээний хүрээнд гүйцэтгэсэн үйлчилгээгээ зохистой үнэлэхгүй байх аюул.
- d. Нэг талыг барих (алагчлал) аюул – Улс төр, үзэл баримтлал, нийгэм эсвэл бусад төрлийн итгэл үнэмшлийн дүнд аудитор нь бодитой (объектив) бус байр суурь баримтлах аюул.
- e. Ойр дотно байдал – Аудитад шалгуулагч агентлагийн удирдлагууд эсвэл ажилтнуудтай ойрын эсвэл урт хугацааны харилцаатай, эсвэл гэр бүл эсвэл төрөл садны харилцаатай байх нь аудиторыг бодитой бус байр суурь баримтлахад хүргэх аюул.
- f. Зүй бус нөлөөлөл – Гаднын нөлөөлөл буюу дарамт нь аудиторын хараат бус бөгөөд бодитой дүгнэлт гаргах чадварт нөлөөлөх аюул.
- g. Удирдлагын оролцоо – Аудитор нь аудитад шалгуулагч этгээдийн удирдлагын удирдлагын үүргийг хүлээх эсвэл төлөөлөн гүйцэтгэх болсны улмаас үүсэх аюул.
- h. Бүтцийн аюул – Аудитын байгууллагын засгийн газрын этгээд доторх байр суурь нь аудитад шалгуулагч этгээдийн бүтцийн хамтаар аудитын байгууллагын ажлаа бодитой хандлагаар гүйцэтгэж, үр дүнгээ тайлагнах чадварт нөлөөлөх аюул.

Энэ маягыг бөглөх нь хараат бус байдал болон бодитой хандлагын стандартуудыг дагаж мөрдөхөө батламжилж буй хэрэг бөгөөд АДБ-ын аудитад оролцогч бүх ажилтан жил бүр батламжлах ёстой. Энэ батламжийг гаргах боломжгүй эсвэл хараат бус байдалд нь учирч болзошгүй, хамгаалалт шаардах аюул байгаа гэж үзэж байгаа хувь хүмүүс шууд удирдлагадаа мэдэгдэж, нөхцөл байдлаа хэлэлцэх ёстой.

Миний бие хараат бус байдал маань огт алдагдаагүй гэдгийг, мөн хараат бус байдалд маань, хамгаалалт шаардах аюул үүссэн тохиолдолд шууд удирдлагадаа мэдэгдэнэ гэдгийг үүгээр батламжилж байна.

Гарын үсэг: _____ Огноо: _____

Эх сурвалж: АНУ-ын ТХГ-ын мэдээллийг эш болгов.

Хавсралт 4: Аудитын сэдэв сонгох хүснэгтийн жишээ

Аудитын сэдэв сонгох хүснэгт

АДБ нь стратегийн төлөвлөлтийн үйл явцаараа аудитын дөрвөн боломжит сэдэв илрүүлжээ:

1. Хатуу хог хаягдлын менежмент
2. Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох арга хэмжээ
3. Тогтвортой загасны аж ахуй
4. Улсын эмнэлгүүдийн эхийн эрүүл мэндийн үйлчилгээ

Дараах хүснэгтэд хэрхэн оноо өгч, аудитын сэдвүүдийг сонгосон шалгууруудад үндэслэн ач холбогдлоор нь эрэмбэлдгийг үзүүлээ. (Сэдэв сонгох шалгуурууд болон тэдгээрийн жинг АДБОУС-ын дагуу, АДБ-д хэр хамааралтай бөгөөд ач холбогдолтой гэдэгт нь үндэслэн сонгоно).

ШАЛГУУР	ЖИН	Аудитын хувилбар сэдвүүд							
		Сэдэв 1		Сэдэв 2		Сэдэв 3		Сэдэв 4	
		Оноо	Жинлэсэн оноо	Оноо	Жинлэсэн оноо	Оноо	Жинлэсэн оноо	Оноо	Жинлэсэн оноо
1. Материаллаг байдал	15	3	45	3	45	2	30	2	30
2. Аудит хийх боломж	15	3	45	1	15	2	30	2	30
3. Боломжит нөлөөлөл	15	3	45	2	30	2	30	2	30
4. АДБ-д учрах эрсдэл	10	3	30	1	10	3	30	3	30
5. Хууль тогтоох засаглал эсвэл олон нийтийн ашиг сонирхол	10	3	30	3	30	0	0	3	30
6. Хамаарал	10	3	30	3	30	2	20	3	30
7. Цаг үетэйгээ тохирох байдал	5	3	15	3	15	1	5	2	10
8. Өмнөх аудитын ажил	5	2	10	3	15	2	10	2	10
9. Төлөвлөгдсөн эсвэл хэрэгжиж буй бусад ажил	5	2	10	1	5	1	5	1	5
10. Гүйцэтгэлийн аудит хийлгэх хүсэлт	10	3	30	0	0	3	30	2	20
Нийт жинлэсэн оноо	100		290		195		190		225
Эрэмбэ			1		3		4		2

Жич: Хамааралгүй = 0, Бага = 1, Дунд = 2, Өндөр = 3

Тайлбар:

1. Материаллаг байдал: (сэдэв тус бүрд өгсөн оноогоо үндэслэлтэй тайлбарлаж бичнэ)
2. Боломжит нөлөөлөл:
3. Хамаарал:
4.

Дээрх үнэлгээнд ач холбогдлын эрэмбээр нь 1-р сэдвийг (Хатуу хог хаягдлын менежмент) нэгдүгээрт, 4-р сэдвийг (Улсын эмнэлгүүдийн эхийн эрүүл мэндийн үйлчилгээ) хоёрдугаарт, 2-р сэдвийг (Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох арга хэмжээ) гуравдугаарт, 3-р сэдвийг (Тогтвортой загасны аж ахуй) дөрөвдүгээр эрэмбэлсэн байна.

- ✓ Жинг шалгууруудад хувааж оноох бөгөөд нийлбэр нь 100% байна. Хувааж оноохдоо шалгуурууд нь АДБ-ын удирдлага, хууль тогтоох засаглал, засгийн газар болон олон нийтэд хэр ач холбогдолтойг харгалзан үзнэ.
- ✓ Аудитор нь "хамааралгүй", "бага", "дунд", "өндөр" гэсэн оноо өгөхдөө мэргэжлийн үнэлэмжээ хэрэгжүүлэх хэрэгтэй. Гэхдээ, үнэлэмж нь зохих үндэслэл болон баримт бичгээр дэмжигдэх ёстой.
- ✓ "Жин" болон "оноо"-ны үржвэрээс "жинлэсэн оноо" гарна. Жинлэсэн онооны нийлбэр нь сэдэв тус бүрийн "нийт жинлэсэн оноо"-г үүсгэнэ.
- ✓ Хамгийн өндөр "нийт жинлэсэн оноо"-той сэдвийг нэгдүгээрт эрэмбэлж болно. Иймд, аудитын нөөцийн хувьд, уг сэдэвт хамгийн их ач холбогдол өгөх бөгөөд улмаар аудит хийх эрэмбийн жагсаалтад оруулна. Өгөгдсөн хугацаанд аудит хийхээр сонгох аудитын сэдвүүдийн тоо нь аудитын нөөцийн бэлэн байдлаас хамаардаг. Аудитын сэдвийг сонгохдоо уг сэдвийн эрэмбэ болон мэргэжлийн үнэлэмжид үндэслэнэ.

Жич: Энэ жишээнд жинлэсэн оноо ашигласан боловч, АДБ-үүд нь бүх шалгуурыг адил ач холбогдолтой гэж үзсэн тохиолдолд жинлэхгүй байхыг сонгож болно.

Эх сурвалж: АДБОУБХС/ГАДХ-ны Хөгжлийн Баг.

Хавсралт 5: Зохиомжийн баримт бичгүүдийн жишээ

Оролцогч талуудын шинжилгээ

Урьдчилсан судалгааны үеэр АДБ-ынхаа дотоод болон гадаад оролцогч талуудтай хамтран ажиллах нь асар чухал юм. Дотоод оролцогч талуудаас жишээлбэл арга зүйчид, хуулийн экспертүүд зэрэг болно. Гадаад экспертүүдээс жишээлбэл аудитын судлах сэдвээр мэргэшсэн экспертүүд болно. Үүнийг үр нөлөөтэй хийхийн тулд оролцогч талуудын шинжилгээ хийж болно. Зураг 5.1-д гэр бүлийн хүчирхийлэл болон эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн асуудлыг судалж буй аудитын нэг хэсэг болгон гүйцэтгэсэн оролцогч талуудын шинжилгээний жишээг үзүүлээ.

Зураг 5.1: Гүйцэтгэлийн аудитын оролцогч талуудын шинжилгээний жишээ

Оролцогч тал	Үүрэг	Ашиг сонирхол	Аудит хийхийн ач холбогдол
Хохирогч/даван туулагч	<ul style="list-style-type: none"> • Биеийн, сэтгэл зүйн, бэлгийн, өвийн болон ёс суртахууны хүчирхийллийг мэдээлэх. • Дэмжлэг болон хоргодох байр хүсэх (шаардлагатай тохиолдолд). • Хүчирхийлэл үйлдэгчтэй холбогдох хуулийн арга хэмжээг ажиглах. 	<ul style="list-style-type: none"> • Зохих тусламж үйлчилгээ болон эмчилгээ авах. • Аюулгүй байдал мэдрэх. • Хэвийн үйл ажиллагаа руугаа буцах. • Хүчирхийлэлд өртөхгүй байх. • Хүчирхийлэл үйлдэгчийг шийтгэсэн гэдгийг мэдэх. 	Өндөр
Хүчирхийлэл үйлдэгч	<ul style="list-style-type: none"> • Хүчирхийлэл үйлдэхээ болихын тулд тусламж эрэх. 	<ul style="list-style-type: none"> • Зохих тусламж үйлчилгээ болон эмчилгээ авах. • Зан үйл болон хандлагаа өөрчлөх. 	Өндөр
Хүүхэд / гэр бүл / тэжээлгэгч	<ul style="list-style-type: none"> • Биеийн, сэтгэл зүйн, бэлгийн, өвийн болон/эсвэл ёс суртахууны хүчирхийллийг мэдээлэх. 	<ul style="list-style-type: none"> • Зохих тусламж үйлчилгээ болон эмчилгээ авах. • Аюулгүй байдал мэдрэх. • Хэвийн үйл ажиллагаа руугаа буцах. 	Дунд
Засгийн газар	<ul style="list-style-type: none"> • Олон яам/газар, хэлтсүүдийн бодлогуудыг үялдүүлж, нэгтгэх. • ТХЗ-ын хэрэгжилтийг хангах төлөвлөгөө гаргах. • ТХЗ-той үялдсан бодлогуудаа нягталж, хэрэгжилтийг нь сайжруулах. • Бодлогууд хэр сайн хэрэгжиж буйг үнэлэх. • Мэдээллээр хангах. • “Хэнийг ч орхигдуулахгүй байх”-ын тулд хэрэгжүүлэлтийн төлөвлөгөөнд хүртээмжтэй байдлыг хангах. 	<ul style="list-style-type: none"> • ТХЗ-той үялдсан үндэсний хэмжээний зорилтуудаа хэрэгжүүлэх. 	Өндөр
Эмэгтэйчүүдийн яам	<ul style="list-style-type: none"> • Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллээс сэргийлж, хүчирхийллийн эмэгтэй хохирогчдыг хамгаалах бодлогуудыг боловсруулж, үялдуулах. • Жендерийн тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөр боловсруулах. • Жендерийн тэгш байдлыг дэмжих. • Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн талаарх олон нийтийн мэдлэг, ойлголтыг дээшлүүлэх аян зохиож, хэрэгжүүлэх. • Эмэгтэйчүүдэд зориулсан бодлогын хэрэгжилтийг дэмжихийн тулд үндэсний болон олон улсын төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтран ажиллах санаачилгуудыг боловсруулж, дэмжиж, хэрэгжүүлэх. 	<ul style="list-style-type: none"> • Тойрогтоо эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг бүүруулах. 	Өндөр
ОХЗҮХТЗ арга хэмжээг хариуцсан бүсийн / орон нутгийн төрийн байгууллагууд	<ul style="list-style-type: none"> • Жендерийн тэгш байдлын төлөвлөгөөг хэрэгжүүлэх. • Жендерийн тэгш байдлыг дэмжих. • Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн талаарх олон нийтийн мэдлэг, ойлголтыг дээшлүүлэх аян зохиож, хэрэгжүүлэх. 	<ul style="list-style-type: none"> • Хариуцсан газартаа эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг бүүруулах. 	Өндөр

Эрүүл мэндийн яам	<ul style="list-style-type: none"> ОХЗҮХ-ийн хохирогчдод тусламж үйлчилгээ үзүүлэх дүрэм, удирдамж, протоколуудыг бий болгох. ОХЗҮХ-ийн хохирогчдод тусламж үйлчилгээ үзүүлэх төрөлжсөн баг ажиллуулах (сувилагч, эмч, сэтгэл зүйч, нийгмийн ажилт). ОХЗҮХ-ийн хохирогчдыг БЗХӨ-өөс сэргийлэх ОХЗҮХ-ийн тохиолдолд үр хөндөлтийг хуулиар зөвшөөрөх. ОХЗҮХТЗ-ийн чиглэлээр ажилладаг байгууллагуудад техникийн болон санхүүгийн дэмжлэг үзүүлэх. 	<ul style="list-style-type: none"> ОХЗҮХ-ийн хохирогчдод эрүүл мэндээ сэргээхэд нь шаардлагатай бүх дэмжлэгийг үзүүлэх. 	Өндөр
Хууль зүйн яам	<ul style="list-style-type: none"> ОХЗҮХ-ийн нөлөөлөлд өртөгчдөд (хохирогчид, хүчирхийлэл үйлдэгчид, гэр бүлийнхэн) шаардлагатай үйлчилгээг үзүүлэх бодлого, төлөвлөгөөнүүдийг бий болгох. ОХЗҮХТЗ хариуцлагыг хүлээсэн байгууллагуудын (цагдаагийн газар, хуулийн тогтолцоо, шүүгч, улсын прокурор, орон нутгийн прокурор) бодлого, төлөвлөгөөний хэрэгжилтийг уялдуулах. 	ОХЗҮХ-ийн нөлөөлөлд өртөгчдөд сайн үйлчилгээ үзүүлэх.	Өндөр
Боловсролын яам	<ul style="list-style-type: none"> ОХЗҮХ-ийн талаарх мэдлэг, ойлголтыг дээшлүүлэх боловсролын аяныг дэмжих. Сургуулиудын хичээлийн хөтөлбөрийг нягталж, жендерийн хэвшмэл ойлголтгүй болгох. Багш нар болон боловсрол хариуцсан бусад мэргэжилтнүүдэд зориулж жендерийн тэгш байдал болон ОХЗҮХТЗ-д төвлөрсөн чадавх бэхжүүлэх хөтөлбөрүүдийг боловсруулах. 	<ul style="list-style-type: none"> ОХЗҮХ-ийг бууруулах боловсролын амжилттай үйл ажиллагаанууд. 	Өндөр
Нийгмийн халамжийн яам	<ul style="list-style-type: none"> ОХЗҮХ-ийн нөлөөлөлд өртөгчдөд (хохирогчид, хүчирхийлэл үйлдэгчид, гэр бүлийнхэн) шаардлагатай үйлчилгээг үзүүлэх бодлого, төлөвлөгөөнүүдийг бий болгох. ОХЗҮХТЗ хариуцлагыг хүлээсэн байгууллагуудад техникийн болон санхүүгийн дэмжлэг үзүүлэх. ОХЗҮХ-ийн нөлөөлөлд өртөгчдөд үйлчилгээ үзүүлэх хариуцлагыг хүлээсэн байгууллагуудын бодлого, төлөвлөгөөний хэрэгжилтийг уялдуулах 	<ul style="list-style-type: none"> Хохирогчид болон тэдний гэр бүлийнхний сайн сайхан байдлыг хангах. 	Өндөр
Цагдаагийн газар	<ul style="list-style-type: none"> Шаардлагатай тохиолдолд, хохирогчийг цагдаагийн хамгаалалтад авах. Шаардлагатай тохиолдолд, хохирогчийг эмнэлэгт зуучлах. Хүчирхийлэл үйлдэгчийн эсрэг хэрэг үүсгэхийг хүсэж байгаа хохирогчийг прокурорт зуучлах. Шаардлагатай тохиолдолд, шүүгчээс хамгаалах арга хэмжээ хүсэх. 	<ul style="list-style-type: none"> Хохирогчдод сайн үйлчилгээ үзүүлэх. ОХЗҮХТЗ-д хувь нэмэр оруулах. 	Өндөр
Үндэсний статистикийн газар	<ul style="list-style-type: none"> ОХЗҮХ-ийн өгөгдлийг цуглуулж, эмхэтгэж, шинжлэх өгөгдлийн систем бий болгож, ажиллуулах. Мужууд болон хотуудаас ирүүлсэн ОХЗҮХ-ийн талаарх өгөгдлийг хүлээн авч, эмхэтгэх. Хүлээн авсан өгөгдлийнхөө шударга байдлыг үнэлэх. ОХЗҮХ-ийн талаарх статистик мэдээлэл агуулсан тайлан боловсруулж, түгээх. 	<ul style="list-style-type: none"> ОХЗҮХ-ийн талаарх найдвартай бөгөөд сайн чанартай статистик мэдээллээр хангах. 	Өндөр

ОХЗҮХТЗ чиглэлээр ажилладаг ИНБ-ууд	<ul style="list-style-type: none"> • ОХЗҮХ-ийн асуудал дээр нийгмийг хөдөлгөх. • ОХЗҮХ-ийн хохирогчид болон тэдний хүүхдүүдэд зориулсан тусламж үйлчилгээг сайжруулах арга хэмжээг шаардах. • Хохирогчдод эрхийг нь мэдүүлж, боловсрол олгох. • ОХЗҮХ-ийн хохирогчид болон тэдний хүүхдүүдэд боловсрол, биеийн болон сэтгэцийн эрүүл мэнд, хөдөлмөр эрхлэлт, орон байр болон эрх зүйн үйлчилгээ авахад нь туслах. 	<ul style="list-style-type: none"> • ОХЗҮХ-ийн хохирогчдын сайн сайхан байдлыг хангах. 	Дунд
НҮБ-ын агентлагууд	<ul style="list-style-type: none"> • ОХЗҮХ-ийн асуудал дээр засгийн газрууд болон нийгмийг хөдөлгөх. • ОХЗҮХ-ийн хохирогчид болон тэдний хүүхдүүдэд зориулсан тусламж үйлчилгээг сайжруулах арга хэмжээг шаардах. • Хохирогчдод эрхийг нь мэдүүлж, боловсрол олгох. 	<ul style="list-style-type: none"> • Эмэгтэйчүүдийн эрхийг хангах. • Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг бууруулах. 	Дунд
Экспертүүд	<ul style="list-style-type: none"> • ОХЗҮХТЗ чиглэлээр судалгаа, эрдэм шинжилгээний ажил хийх. • Засгийн газрууд болон ИНБ-уудыг ОХЗҮХ-ийн талаарх баталгаатай мэдээллээр хангах • Засгийн газрын агентлагуудад ОХЗҮХТЗ бодлого боловсруулж, хэрэгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх. 	<ul style="list-style-type: none"> • Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг бууруулах. 	Өндөр
Эмэгтэйчүүдийн холбоо (үндэсний, орон нутгийн, хотын, тосгоны)	<ul style="list-style-type: none"> • ОХЗҮХ-ийн асуудал дээр нийгмийг хөдөлгөх. • ОХЗҮХ-ийн хохирогчид болон тэдний хүүхдүүдэд зориулсан тусламж үйлчилгээг сайжруулах арга хэмжээг шаардах. • Хохирогчдод эрхийг нь мэдүүлж, боловсрол олгох. • ОХЗҮХ-ийн хохирогчид болон тэдний хүүхдүүдэд боловсрол, биеийн болон сэтгэцийн эрүүл мэнд, хөдөлмөр эрхлэлт, орон байр болон эрх зүйн үйлчилгээ авахад нь туслах. 	<ul style="list-style-type: none"> • ОХЗҮХ-ийн хохирогчдын сайн сайхан байдал болон аюулгүй байдлыг хангах. 	Дунд
Шүүгчид	<ul style="list-style-type: none"> • Хамгаалах арга хэмжээгээр хангах. • Прокурорт хамгаалах арга хэмжээ авах шаардлагын талаар мэдэгдэх. • Шаардлагатай тохиолдолд хүчирхийлэл үйлдэгчийг түр саатуулах шийдвэр гаргах. • Шаардлагатай тохиолдолд түр саатуулах шийдвэрийг цуцлах. 	<ul style="list-style-type: none"> • ОХЗҮХ-ийн хохирогчдын сайн сайхан байдал болон аюулгүй байдлыг хангах. 	Өндөр
Улсын прокурорууд	<ul style="list-style-type: none"> • ОХЗҮХ-ийн хохирогчдод цагдаагийн хамгаалалт гаргаж өгөхийг хүсэх. • ОХЗҮХ-ийн хохирогчдод эрүүл мэнд, боловсрол, нийгмийн халамж болон бусад үйлчилгээ үзүүлэхийг хүсэх. • ОХЗҮХ-ийн нөлөөлөлд өртөгчдөд (хохирогчид, хүчирхийлэл үйлдэгчид, гэр бүлийнхэн) шаардлагатай үйлчилгээг үзүүлдэг төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудыг хянах. 	<ul style="list-style-type: none"> • ОХЗҮХ-ийн хохирогчдын сайн сайхан байдал болон аюулгүй байдлыг хангах. 	Дунд
Орон нутгийн прокурорууд	<ul style="list-style-type: none"> • ОХЗҮХ-ийн хохирогчдод тусгайлан зориулсан, хүмүүнлэг эрх зүйн үйлчилгээ үзүүлэх. 	<ul style="list-style-type: none"> • ОХЗҮХ-ийн хохирогчдод эрх зүйн үйлчилгээ авах боломж олгох. 	Дунд

Жич: ЭЭОХЗҮХТЗ – Эмэгтэйчүүдийн эсрэг ойрын хамтрагчийн зүгээс үйлдэгддэг хүчирхийллийг таслан зогсоох.

Эх сурвалж: АДБОУБХС-ын ТХЗ-ын Аудитын Загвар (АДБОУБХСТХЗАЗ).

Анхны уулзалтын хөтөлбөр

Зарим АДБ гүйцэтгэлийн аудитын эхэнд, анхны уулзалтад оролцох дотоод оролцогч талуудыг (тухайлбал, хуулийн экспертүүд, эдийн засагчид, техникийн мэргэшилтэй хувь хүмүүс) эхлээд цуглуулж уулзах нь тустай гэж үздэг. Энэ уулзалтын үеэр та оролцогч талуудтайгаа боломжит арга хандлагууд, аудитын асуултууд, зохиомжийн сонголтууд болон аудитын сэдвийн талаар мэдлэгтэй холбоо барих боломжит хүмүүсийн талаар хэлэлцэнэ. Энэ төрлийн уулзалтыг чиглүүлж болох ТХГын уулзалтын хөтөлбөрийн жишээг доор орууллаа.

Анхны уулзалтын хөтөлбөрийн жишээ

<u>АДБ-ын удирдлага</u>	<u>Аудитын баг</u>	<u>Оролцогч талууд</u>
<u>1-р групп</u> Сара Пек, Удирдах захирал Маита Сабраманиан, Захирал Линг Лиу, Аудитын менежер	Хуан Балдез, Хариуцах аудитор Алессандра Энгле, Аудитор	<u>Ерөнхий зөвлөх</u> Ребека Санчез, Хуулийн эксперт <u>Арга зүйч болон Өгөгдлийн шинжилгээний дэмжлэг</u> Мелисса Нгумо (арга зүйч) Такано Ватанабэ (өгөгдлийн шинжээч)
<u>Аудитын хэлэлцүүлэг (5 минут)</u> Аудитын үндэслэл (хууль, хүсэлт эсвэл бусад). Нөөцийн шаардлагын тооцоо. Гүйцэтгэлийн сүл талын эрсдэл. Арвилан хэмнэлт, үр ашигтай байдал болон үр нөлөөтэй байдлын зарчмуудад нийцэхэд тулгарч буй сорилтууд, мөн хууль, журам, зохицуулалттай нийцэх боломжтой байдал. Дотоод хяналтууд.		
<u>Дотоод/гадаад зохицуулалт (10 минут)</u> Холбогдох сэдвүүд дээр ажиллаж буй, эсвэл аудитад шалгуулагч этгээдтэй ажиллаж буй дотоод оролцогч талууд болон аудитын багийнхантай хийсэн уулзалтуудын хураангуй. Бусад аудитын байгууллага, судалгааны бүлгүүд, аудитын сэдвийг судалсан хүмүүс зэрэг гадаад оролцогч талуудтай хийсэн уулзалтуудын хураангуй. Аудитад шалгуулагч этгээд дээр өрнөж буй, аудитын мөн чанартай холбогдох, мэдэгдэж буй үйл ажиллагаанууд. Судлах сэдэв/ зүйлтэй холбогдох экспертүүдтэй уулзалт товлох төлөвлөгөө.		
<u>Аудитын санал болгож буй зорилгууд (15 минут)</u> ...-н чиг хандлага ямар байгаа вэ? Энэ хэлтэс ...-г хэр хэмжээнд хэрэгжүүлдэг вэ? Энэ хэлтэс ...-г хэр тогтмол бөгөөд хангалттай хэрэгжүүлдэг вэ?		
<u>Боломжит арга зүй (15 минут)</u> Өгөгдлийн шинжилгээ: ... оны санхүүгийн жилийн өгөгдлийг шинжлэх. ... газруудын мэдлэг бүхий албан тушаалтнуудтай ярилцлага хийх. ... байршлуудад талбарын ажил хийх.		
<u>Оролцогч талуудыг үүргийг хэлэлцэх (10 минут)</u>		
<u>Уулзалтаар гаргасан гол шийдвэрүүдийн тойм болон уулзалтын дараа хийх зүйлс (5 минут)</u> Шийдвэрүүдийг баримтжуулах. Аудитад шалгуулагч этгээдтэй хийх анхны уулзалтыг хийх.		

Эх сурвалж: АНУ-ын ТХГ.

Аудитад шалгуулагч этгээдтэй хийх анхны уулзалтын хөтөлбөр

Аудитын баг нь ерөнхийдөө өгөгдөл, мэдээлэл цуглуулж эхлэхийн өмнө аудитад шалгуулагч этгээдтэй уулздаг. Энэ уулзалтын үеэр аудитад шалгуулагчийн албан тушаалтнуудтай уулзаж, ажлаа танилцуулж, аудитын мэдээллийн хэрэгцээ шаардлага болон бусад зүйлсийг тодорхой болгодог. ТХГ-ын анхны уулзалтын хөтөлбөрийн жишээг доор оруулав.

Аудитад шалгуулагч этгээдтэй хийх анхны уулзалтын хөтөлбөрийн жишээ

Огноо/цаг:

Байршил:

Холбоо барих мэдээлэл:

Оролцогчид

Нэр	Албан тушаал	И-мэйл	Утас
Жоан Смит	Захирал		
Линг Лиү	Аудитын менежер		
Хуан Балдез	Хариуцах аудитор		
Алессандра Энгле	Аудитор		

Ажлын эх сурвалж: (тухайлбал, хяналтын хорооны хүсэлт, АДБ-ын үргэлжилж буй аудитын сэдвийн нэг хэсэг, г.м.)

Ажлын хамрах хүрээ: Энэ ажил нь засгийн газрын удирдлагын [аудитын зорилго болон асуултуудыг оруулна]-г үнэлэх хүчин зүтгэлүүдийг агуулна. Энэ аудит үргэлжлэх явцад, бидний мэдээллийн хэрэгцээ ихсэж магадгүй бөгөөд нэмэлт мэдээлэл шаардлагатай болж магадгүй. Ийм тохиолдол үүссэн үед бид та бүхэнд мэдэгдэх болно.

АДБ-аас анх ажлыг гүйцэтгэхээр тодорхойлсон оффисүүд болон байршлууд:

Цаг хугацаа

- Бид ажлаа нэн даруй эхэлж, тайлангийн төслөө 20XX он гэхэд бэлэн болгохоор төлөвлөж байна.

Эх сурвалж: АНУ-ын ТХГ.

Судлах сэдэв/ зүйлийн мэдлэгийг нэмэгдүүлж, эрсдэлийг шинжлэх хэрэгслүүд

СВОТ (давуу тал, сул тал, боломж, аюул) шинжилгээ

СВОТ шинжилгээний зорилго нь аудитад шалгуулагч этгээдийн дотоод болон гадаад орчинтой холбогдох давуу тал, сул тал, боломж болон аюулыг тодорхойлж, ангилахад оршдог. Зураг 5.2-т СВОТ шинжилгээний маягтыг, Зураг 5.3-т СВОТ шинжилгээний жишээг үзүүлэв.

Зураг 5.2: SWOT шинжилгээний маягт

	Дотоод орчин	Гадаад орчин
Эерэг	Давуу тал Аудитад шалгуулагч этгээдийн дотоод орчинтой холбогдох давуу талуудыг тодорхойлж, жагсаана.	Боломж Аудитад шалгуулагч этгээдийн гадаад орчинд орших боломжуудыг тодорхойлж, жагсаана.
Сөрөг	Сул тал Аудитад шалгуулагч этгээдийн дотоод орчинтой холбогдох сул талуудыг тодорхойлж, жагсаана.	Аюул Аудитад шалгуулагч этгээдийн гадаад орчинд орших аюулуудыг тодорхойлж, жагсаана.

Эх сурвалж: АДБОУБХС/ГАДХ-ны Хөгжлийн Баг.

Зураг 5.3: Хөдөөгийн ундны усны хангамжийн хөтөлбөрийн гүйцэтгэлийн аудитын СВOT шинжилгээний жишээ

	Дотоод орчин	Гадаад орчин
Эерэг	<p>Давуу тал</p> <ol style="list-style-type: none"> 1. Тогтвортой Хөгжлийн Зорилгуудтай холбогдсон тодорхой, тогтсон зорилго 2. Хөдөөгийн ундны усны хангамжийн хөтөлбөр 2001 оноос хойш хэрэгжиж байгаа 3. Засгийн газрын 3 түвшинд усны хангамжийг хариуцдаг байгууллагууд 4. Засгийн газрын 3 түвшинд сайтар тодорхойлсон үүрэг, хариуцлагууд 5. Жилийн төлөвлөгөө тодорхойлогдсон 6. Хяналт-шинжилгээний нэгж 7. Тосгоны ус болон ариутгах татуургын хороотой 8. Ус хангамжийн хөтөлбөрийг бий болгох гэрээний үйл явц ил тод 	<p>Боломж</p> <ol style="list-style-type: none"> 1. Тойргийн нутаг дэвсгэрийн дундуур гол урсдаг 2. Дэлхийн Эрүүл Мэндийн байгууллагаас тогтоосон усны чанарын тест хийх шалгуур бий 3. Аялал, жуулчлал нэмэгдсэнээр тойрогт илүү их санхүүгийн нөөц авчирна
Сөрөг	<p>Сул тал</p> <ol style="list-style-type: none"> 1. Тогтоосон зорилгод хүрээгүй байгаа (26% нь аюулгүй ундны устай болоогүй хэвээр байна) 2. Зарим тосгонд ундны ус хэзээд хүртээмжгүй байна 3. Тест хийх лаборатори дутмаг (дүүрэг тутамд нэг байх ёстой) 4. Тест хийх багцын материал хомс 5. Тестийн багцыг ашиглах сургалтыг явуулж буй хүн цөөн (тосгон бүрд 5 байх ёстой) 6. Усны шүүрэлтээс сэргийлж, ус түгээлтийг хариуцах хүмүүс дутмаг 7. Усны тогтолцоонд тогтмол үзлэг хийж, ус хангамжийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүмүүс дүүргүүд болон тосгодоод дутмаг 8. Тогтмол техникийн үйлчилгээ хийх тосгоны санхүүгийн нөөц дутмаг 9. Зарим дүүрэгт усны хүрэлцээ бага 10. Тосгоны ус болон ариутгах татуургын хороонд жендерийн тэгш байдал байхгүй 11. Ус хадгалалт дутагдалтай 12. Ус хураах ажиллагаа (борооны ус хуримтлуулах) дутмаг 13. Мэдээллийн систем болон гүйцэтгэлийн индикаторууд дутагдалтай 	<p>Аюул</p> <ol style="list-style-type: none"> 1. Гадаргын усны биологийн бохирдол 2. Гүний усны химийн бохирдол 3. Ус хангамжийн хөтөлбөр, ариутгах татуургын үйлчилгээ болон эрүүл мэндийн тогтолцоо хооронд уялдаа маш бага 4. Дүүргүүд болон тосгодын дунд усаа хуваалцах зохицуулалт бага 5. Цаг агаарын нөхцөлөөс хамааралтай 6. Аялал, жуулчлал нэмэгдсэнээр усны эрэлт өсөхөд хүргэж мэднэ

Эх сурвалж: АДБОУБХС/ГАДХ-ны Хөгжлийн Баг.

Эрсдэлийг тулган баталгаажуулах диаграмм (RVD диаграмм / ЭТБД)

ЭТБД-ыг боловсруулахдаа, SWOT шинжилгээгээр илрүүлсэн сул талууд (w) болон аюулуудтай (t) холбогдох эрсдэлүүдийн жагсаалтыг гаргаж, магадлал болон нөлөөллийг нь үнэлж, диаграммд зохих ёсоор байрлуулна. Зураг 5.4-д дээр өгүүлсэн хөдөөгийн ундны усны хангамжийн хөтөлбөрийн SWOT шинжилгээнд үндэслэсэн ЭТБД-ын жишээг үзүүлэв.

Зураг 5.4: Хөдөөгийн ундны усны хангамжийн хөтөлбөрт хийсэн аудитын ЭТБД-ын жишээ



Хавсралт 6: Зохиомжийн хуудсыг шалгах хуудас

Зохиомжийн хуудсыг зохиомжийн хүснэгтийн оронд ашиглаж болно. Энэ хуудас нь аудитын багт аудитын зохиомжоо бүтэцлэгдсэн хүснэгтийн оронд хүүрнэсэн хэлбэрээр баримтжуулах боломж олгодог. Зохиомжийн хуудас нь аудитын орчин нөхцөл болон баг эсвэл удирдлагын шийдвэрээс хамаарч янз бүрийн хэлбэртэй байж болно. Зураг 6.1 нь танд загварын хуудсаа шаардлагатай мэдээллүүдийг агуулсан байлгахад тусалж чадна.

Зураг 6.1: Хөдөөгийн ундны усны хангамжийн хөтөлбөрт хийсэн аудитын ЭТБД-ын жишээ

Загварын хуудсыг шалгах хуудас	
(a) Загварын хуудас нь дараах зүйлсийг тодорхойлж байна уу? i) аудит хийж буй асуудлуудаа үнэлэхэд ашиглах шалгуурууд; эсвэл ii) аудит хийж буй асуудлуудаа үнэлэхэд шаардлагатай шалгууруудыг тодорхойлохын тулд хэрэгжүүлж буй төлөвлөгөө. Боломжит шалгууруудын жишээ: хууль, журам, зохицуулалтын эсвэл удирдлагаас тогтоосон ерөнхий зорилго, зорилго, бодлого эсвэл горимууд; техникийн дэмжлэг үзүүлэхээр боловсруулсан стандарт, норм, дүрмүүд; экспертүүдийн санал дүгнэлтүүд; өмнөх жилүүдийн гүйцэтгэл; ижил төстэй байгууллагуудын гүйцэтгэл; хувийн хэвшлийн гүйцэтгэл; эсвэл тэргүүлэх байгууллагуудын сайн туршлагауд.	
(b) Загварын хуудсанд аудитын хам сэдэв буюу хам нөхцөлийн талаарх хангалттай мэдээлэл орсон уу (тухайлбал, асуудлын мөн чанар, хөтөлбөрийн ач холбогдол, боломжит асуудал эсвэл анхаарах асуудал болон түүний цар хэмжээ, улс төрийн орчин, гол тоглогчид болон аудитын бүтээгдэхүүний боломжит хэрэглэгчид)?	
(c) Загварын хуудас нь аудитын асуултуудыг тодорхойлж байна уу?	
(d) Загварын хуудас нь аудитын асуултуудад хариулахад шаардлагатай мэдээллийн эх сурвалжууд болон уг мэдээллийг хаанаас олж авахыг, эсвэл аудитын нотлох зүйл болгон ашиглаж болох өгөгдлийн боломжит эх сурвалжуудыг хэрхэн илрүүлэхийг төлөвлөж буйг тодорхойлсон уу?	
(e) Загварын хуудас нь өмнөх аудитын тайлангуудад орсон одоогийн аудитын зорилгуудтай холбоотой мэдэгдэж буй чухал илрүүлэлтүүд болон нээлтэй зөвлөмжүүдийн мөрөөр хэрхэн хяналт тавихыг тодорхойлсон уу?	
(f) Загварын хуудас нь аудитыг загварчлах ерөнхий стратеги, аудитын асуултуудад хариулах арга зүй, мөн ашиглах шинжилгээний төрлийг агуулсан уу? Арга зүй нь кэйс судалгаа, бүтэцлэгдсэн ярилцлага, фокус бүлэг, файлын нягталгаа, нүдэн үзлэг, түүвэрлэлт, компьютерт суурилсан өгөгдлийн ашиглалт зэрэг байж болно.	
(g) Загварын хуудас нь ажлын хязгаарлалтууд (тухайлбал, бүртгэлд хандахад бэрхшээл тулгарах, ажилтан бүрдүүлэх болон зам туулахад тулгарах бэрхшээлүүд, эсвэл өгөгдлийн чанар эсвэл найдвартай байдлын асуудлууд) болон түүнээс бүтээгдэхүүнд үзүүлэх үр нөлөөг баримтжуулсан уу?	
(h) Загварын хуудсанд шинжилгээгээр илэрхийлэхийг хүсэж байгаа зүйл тань агуулагдсан уу?	

Эх сурвалж: АНУ-ын ТХГ.

Хавсралт 7: Төслийн хуваарь болон ажлын задаргааны зураглал

Төслийн ерөнхий хуваарь

Төслийн ерөнхий хуваарийг гаргахдаа даалгаврууд болон явцын зорилтуудыг ерөнхий өрнөх дарааллаар нь жагсаана. Даалгавруудыг нэгэн зэрэг хийж болно. Даалгавар тус бүрд, эхлэх болон дуусах огноог нь, аудитын багийн хариуцах ажилтан эсвэл ажилтнуудын хамт тодорхойлж өгнө. Төслийн хуваарь нь үе шатаар нь хуваасан бүлэг даалгавруудыг АДБ-ын аудитын үйл явцтай уялдуулсан бүтэцтэй байна. Зураг 7.1-д төслийн ерөнхий хуваарийн жишээг үзүүлэв. Ойлгомжтой байлгах үүднээс жишээг товчлон хураангуйлсан бөгөөд аудитын төлөвлөгөөндөө тохируулж даалгавруудын тоог нэмж, явцын зорилтуудыг баяжуулах хэрэгтэй.

Зураг 7.1: Төслийн ерөнхий хуваарийн жишээ

Параграф	ЭХЛЭХ	ДУУСАХ	ХАРИУЦАХ АЖИЛТНУУД
	ОГНОО	ОГНОО	
2-р үе шат – Аудитыг зохиомжлох (АДБ-ын дотоод аудитын үйл явцын дагуу даалгавруудыг бүтэцжүүлнэ)			
Даалгавар 1 (ж.нь: аудитын сэдвийн урьдчилсан судалгаа хийх)			
Даалгавар 2 (ж.нь: аудитын зорилго(ууд), хамрах хүрээ болон арга зүйг боловсруулж, шалгууруудыг тодорхойлох)			
Даалгавар 3 (ж.нь: аудитын зохиомжийн эрсдэлийг үнэлэх)			
Даалгавар 4 (ж.нь: аудитын төлөвлөгөөг бэлтгэх)			
2-р үе шатны явцын зорилт (ж.нь: аудитын төлөвлөгөөнд санал нэгдэх)			
3-р үе шат – Аудитыг гүйцэтгэх (АДБ-ын дотоод аудитын үйл явцын дагуу даалгавруудыг бүтэцжүүлнэ)			
Даалгавар 1 (ж.нь: нотлох зүйлсийг цуглуулах)			
Даалгавар 2 (ж.нь: нотлох зүйлсийг шинжлэх)			
Даалгавар 3 (ж.нь: нотлох зүйлсийн хангалттай бөгөөд зохистой байдлыг үнэлэх)			
Даалгавар 4 (ж.нь: аудитын илрүүлэлтүүдийг боловсруулах)			
3-р үе шатны явцын зорилт (ж.нь: тайлангийн мессеж дээр санал нэгдэх)			
4-р үе шат – Тайлагнах (АДБ-ын дотоод аудитын үйл явцын дагуу даалгавруудыг бүтэцжүүлнэ)			
Даалгавар 1 (ж.нь: тайлангийн төсөл гаргах)			
Даалгавар 2 (ж.нь: баримтуудыг тулган баталгаажуулаад аудитад шалгуулагч этгээдийн саналыг авах)			
Даалгавар 3 (ж.нь: тайланг эцэслэж, АДБ-ын удирдлагаар батлуулах)			
4-р үе шатны явцын зорилт (ж.нь: тайланг түгээх)			

Эх сурвалж: АНУ-ын ТХГТХГ.

Төслийн хуваарь гаргахдаа төлөвлөгөө нь аудитын үйл явцыг үр нөлөөтэй чиглүүлэх хэмжээний бодитой байх ёстойг санагтун. Үйл ажиллагаануудын дэс дараалал болон үргэлжлэх хугацааг төлөвлөх нь бэрх байж болно. Ялангуяа, аудитын ажил өрнөж эхлэх үед шинэ мэдээлэл болон хүчин зүйлс гарч ирдэг. Түүнчлэн, аудиторүүд нь АДБ-ын бусад үүрэг хариуцлага, сургалт болон амралт зэрэг аудитын бус үйл ажиллагаанд үе үе цагаа зарцуулдаг. Үүний дүнд, аудиторүүд мэдээлэл цуглуулах, шинжлэх, тайлан бичих болон нягтлах зэрэг аудитын гол үйл ажиллагаануудын үргэлжлэх хугацааг тооцоолохдоо нэлээн үүжүү хугацаа тавьж өгөх нь элбэг. Холбогдох даалгавруудынхаа хугацааг тогтоох үед таны өмнө тодорхойлсон аудитын эрсдэлүүд нь (4-р бүлгийг үзнэ үү) тодорхой бус байдал үүсгэх тул эрсдэлүүдийг харгалзан үзэх ёстой. Ийм учраас хуваариа гаргахдаа хэт нарийвчлахгүй байх хэрэгтэй. Энэ нь аудитын ажил ид өрнөх үед төлөвлөгөөгөө засаж сайжруулахад зарцуулах цагийг хэмнэх болно.

Төслийн нарийвчилсан хуваарь

Төслийн нарийвчилсан хуваарь нь ажил, түүнтэй холбогдох даалгаврууд, үргэлжлэх хугацаа болон нөөцийг нарийн тодорхойлж, уялдуулах боломж олгодог. Төслийн ерөнхий хуваарийг цаасан дээр эсвэл программ хангамж ашиглан үүсгэж, ашиглаж болдог. Харин, төслийн нарийвчилсан хуваарийг арилжааны эсвэл үнэгүй төслийн удирдлагын программ хангамж ашиглан үүсгэж, ашиглавал илүү хялбар байдаг.

Төслийн ерөнхий хуваарийн нэгэн адил, даалгаврууд болон явцын зорилтуудыг өрнөх ерөнхий дарааллаар нь жагсааж нарийвчилсан хуваарийг гаргадаг. Даалгавар тус бүрд, үргэлжлэх хугацаа, нөөц болон хамааралтай даалгавруудыг нь тодорхойлж, дэс дараалалтайгаар уялдуулж өгдөг. Тухайлбал, ямар нэгэн шинжилгээг гүйцэтгэхийн өмнө ярилцлага хийх ёстой бол уг ярилцлагыг шинжилгээний өмнөх даалгавар гэж уялдуулна. Гэхдээ, даалгаврууд ихэвчлэн зэрэг эсвэл янз бүрийн хэмжээгээр давхацсан байдлаар хийгддэг.

Аливаа нэг үйл ажиллагааны өрнөх ёстой огноог тодорхой зааж өгч болох ч, аудитын үргэлжлэх хугацаа болон үйл ажиллагааны огноог ерөнхийдөө үйл ажиллагаа тус бүрийн үргэлжлэх хугацаа болон харилцан хамаарал буюу өмнөх болон залгамжилсан үйл ажиллагаатай нь уялдуулж тогтоодог. Нарийвчилсан хуваарь нь нөөцийг тооцохдоо мөн тодорхой тооны цаг хуваарилах боломж олгодог. Энэ нь тухайн даалгавартай холбогдох ажлын ачааллыг нарийвчлан тооцоход тусалдаг.

Зураг 7.2-т буй жишээнд үйл ажиллагаануудыг дэлгэрэнгүй жагсааж, дэс дараалалд оруулах боломжийг харуулах үүднээс зөвхөн төлөвлөлтийн үе шатаар хязгаарлав. Энэ загварыг ашиглан аудитын бусад бүх шатыг хамруулсан төслийн цогц хуваарь үүсгэж болно.

Зураг 7.2: Төслийн нарийвчилсан хуваарийн төлөвлөлтийн үе шатны жишээ

	Нэр	Хугацаа (өдрөөр)	Эхлэх	Дуусах	Өмнөх даалгавар	Нөөц
1	Аудитын нэр					
2	2-р үе шат - Төлөвлөлт	29	1/2/2020	2/12/2020		
3	Урьдчилсан судалгаа хийж, аудитын арга хандлагыг харгалзан үзэх	11	1/2/2020	2/17/2020		
4	Аудитын сэдвээр хийсэн өмнөх ажлыг нягталж, дэвсгэр судалгаа хийх	5	1/2/2020	1/9/2020		A 1; A 2
5	Сэдвийг аудитад шалгуулагчтай хэлэлцэх	3	1/9/2020	1/14/2020	4	A 1; A 2; Аудитын мжр.
6	Дотоод оролцогч талуудыг тодорхойлж, харилцах	8	1/2/2020	1/14/2020	4 зэрэг эхэлнэ (зэ)	A 1; A 2; Аудитын мжр.
7	Аудитын арга хандлагыг тодорхойлох	3	1/14/2020	1/17/2020	5	A 1; A 2; Аудитын мжр.
8	Зорилго, хамрах хүрээ, арга зүйг боловсруулах	13	1/17/2020	2/5/2020		
9	Аудитын хамрах хүрээ болон зорилгуудыг тодорхойлох	1	1/17/2020	1/18/2020	3	A 1; A 2; Аудитын мжр.
10	Аудитын асуултуудыг боловсруулах	2	1/20/2020	1/22/2020	9	A 1; A 2; Аудитын мжр.
11	Аудитын шалгуурыг тодорхойлох	3	1/22/2020	1/27/2020	10	A 1; A 2; Аудитын мжр.
12	Хугацаа болон шаардлагатай нөөцийг тодорхойлох	5	1/17/2020	1/24/2020	9 зэ	A 1; A 2; Аудитын мжр.
13	Аудитын арга зүйг тодорхойлох	7	1/27/2020	2/5/2020	10; 11	A 1; A 2; Аудитын мжр.
14	Зохиомжийн эрсдэлийг үнэлэх	5	1/22/2020	1/29/2020		
15	СВОТ шинжилгээ болон ЭТБД-ыг бэлтгэх	2	1/23/2020	1/27/2020	13 зэ - 2 өдөр	A 1; A 2
16	Эрсдэлийг хүлцэх түвшин тодорхойлох	2	1/22/2020	1/24/2020	15 зэ - 1 өдөр	A 1; A 2; Аудитын мжр.
17	Загварын эрсдэлийг бүүруулах алхмуудыг тодорхойлох	2	1/27/2020	1/29/2020	15; 16	A 1; A 2; Аудитын мжр.
18	Аудитын төлөвлөгөөг бэлтгэх	11	1/28/2020	2/12/2020		
19	Загварын хүснэгтийг бэлтгэх	10	1/28/2020	2/11/2020	10; 13 зэ + 1 өдөр	A 1; A 2
20	Төслийн ерөнхий эсвэл нарийвчилсан хуваарийг гаргах	5	1/28/2020	2/4/2020	19 зэ	A 1; A 2
21	Ажлын задаргааны зураглал гаргах (сонголтоор)	5	1/28/2020	2/4/2020	19 зэ	A 1; A 2
22	Аудитын төлөвлөгөөг удирдлагаар батлуулах	1	2/11/2020	2/12/2020	3; 8; 14; 19; 20; 21	A 1; A 2; Аудитын мжр.; АДБ-ын удрлг.

Эх сурвалж: АДБОУБХС/ГАДХ-ны Хөгжлийн Баг.

Хэдийгээр шаардлагагүй боловч, төслийн нарийвчилсан хуваарь нь танд аудитын зонхилох хэсгийг (critical path) илүү хялбар тодорхойлох боломж олгодог. 4-р бүлэгт авч үзсэнчлэн, зонхилох хэсэг гэдэг нь таны хуваарь дахь дэс дараалсан үйл ажиллагаануудын хамгийн удаан үргэлжлэх хэсэг юм. Зонхилох хэсгийг тодорхойлсноор аудитыг дуусгах боломжтой хамгийн ойрын огноог тодорхойлж, аудитын баг болон удирдлагуудад аудитын цаг хугацааны хуваарийг хөдөлгөж болзошгүй үйл ажиллагаануудад анхаарлаа төвлөрүүлэх боломж олгодог. Түүнчлэн, зонхилох хэсэгт аудитын хамгийн чухал үйл ажиллагаануудыг оруулах нь ерөнхийдөө зохимжтой байдаг.


Ажлын задаргааны зураглал

Ажлын задаргааны зураглал нь ихэвчлэн судалгаа зэрэг тодорхой аргатай холбогдох янз бүрийн тухайлсан даалгавруудыг тодорхойлохоор оролдож байгаа үед хамгийн тустай байдаг. Энэ зураглалыг энгийн бичвэр боловсруулах программ эсвэл төслийн

менежментийн программ хангамжаар боловсруулж болно. Ажлын задаргааны зураглалыг боловсруулахдаа, үндсэн даалгавраас эхлүүлэн шатлан захирах эрэмбийн модны бүтэц үүсгэдэг. Дараа нь хамтдаа үндсэн буюу “эцэг” даалгаврын биелэлтийг бий болгох дэд даалгавруудад үндсэн даалгавраа хуваана. Даалгавруудыг шаардлагатай бөгөөд үндэслэлтэй хэмжээнд жижиглэн хувааж, эцсийн даалгавар буюу цаашид хуваах боломжгүй даалгавар хүртэл хуваадаг. Хариуцагч талыг мөн даалгавар тус бүртэй холбож, ажлыг хэн гүйцэтгэхийг нарийн тодорхойлж болно.

Зураг 7.3-т судалгаа хийх ажлын задаргааны хялбаршуулсан зураглалыг үзүүлэв. Хүссэн түвшний нарийвчлалаа үүсгэхийн тулд энэ зураглалын түвшин бүрд нэмэлт даалгаврууд болон дэд даалгавруудыг нэмж болно. Түүнчлэн, хэрэв хүсвэл, аудитыг зохиомжлох үе шатыг эсвэл аудитыг бүхэлд нь хамруулсан том зураглал дотор ажлын задаргааны жижиг зураглалуудыг оруулан зураглаж болно.

Зураг 7.3: Ажлын задаргааны зураглалын жишээ



Эх сурвалж: АДБОУБХС/ГАДХ-ны Хөгжлийн Баг.

Хэдийгээр заавал ашиглах албагүй боловч, ажлын задаргааны зураглал нь томоохон аргыг ашиглах хүчин зүтгэлийн хамрах хүрээг илүү сайн тодорхойлж, ажлаа илүү жижиг, илүү удирдах боломжтой хэсгүүдэд хуваахад тусалж чаддаг. Ингэснээр, та аудитын багаа уг аргатай холбогдох зардлууд болон хөдөлмөрийн цагийг илүү сайн нарийвчлалтай тооцох боломжтой болгоно.

Хавсралт 8: Ярилцлагын удирдамж

Ярилцлагыг төлөвлөх нь

1-р алхам: Ярилцлагын өмнөх судалгаагаа гүйцээх:

1. Ерөнхий болон дэд зорилгуудыг тодорхойлох.
2. Хангалттай суурь мэдээлэлтэй болох.
3. Хэнээс ярилцлага авахыг тодорхойлох.
4. Шаардлагатай мэдээллийн бусад эх сурвалжийг тодорхойлох.

2-р алхам: Асуултуудаа бэлдэх:

1. Юу мэдэхийг хүсэж буйгаа тодорхойлох.
2. Асуултуудаа эхний байдлаар бичих.
3. Бичсэн асуултуудаа хянагчаараа нягтлуулах.

3-р алхам: Логистикийн асуудлыг шийдэх:

1. Ярилцлагын цаг, газар болон байршлыг товлох.
2. Ярилцлага өгөх хүнд ярилцлагын зорилгыг мэдэгдэх.
3. Хэдэн ажилтан оролцохыг шийдэх. Нэгээс олон ярилцлага авагчтай байхыг хичээх.

Ярилцлагыг гүйцэтгэх нь

4-р алхам: Ярилцлагыг нээх:

1. Цагаа баримталж, зохистой хувцаслах.
2. Албан тушаалтнуудыг тухтай байлгахын тулд шаардлагатай тохиолдолд багахан яриа өрнүүлэх талаар бодолцож үзэх.
3. Оршил хэлж, ярилцлагын зорилго болон аудитын дэвсгэр мэдээллийг танилцуулах.
4. Хүсэж буй үр дүнгээ тайлбарлах.

5-р алхам: Ярилцлагыг гүйцэтгэх:

1. Бэлдсэн асуултуудаа асуух.
2. Идэвхтэй сонсох.
3. Тандах асуулт асуух:
 - Хэлсэн мэдэгдлүүдийг шууд утгаар нь бүү хүлээж ав. Дэлгэрүүлж ярихыг хүсэж, дэмжих баримт бичгүүдийг асуух.
 - Ямар асуудлууд байгааг, яагаад оршин байгааг, ярилцлага өгөгч хүмүүс аудитын сэдвийг хэрхэн өөрчлөхийг хүсэж буйг асуух; хэн, юуг, хаана, хэзээ, хэрхэн, яагаад гэдгийг асуух.
4. Өгсөн мэдээллийг дэмжих жишээ болон шалтгааныг асуух
5. Таны урьдчилан боловсруулсан асуултын жагсаалтад байхгүй байж болох нэхэн судалсан асуултуудыг асуухад бэлэн байх.
6. Таны төсөөлж байгаагүй сэдэв эсвэл хариултыг хөндсөн тохиолдолд түүнийг лавшруулан судлах асуултуудыг дэс дараатай асуух.
7. Хоёрдмол утгатай эсвэл тодорхой бус хариултыг тодруулах асуух.

8. Ярилцлага өгөгч таны мэдэхгүй товчилсон үг ашигласан бол утгыг нь асуух.
9. Гол нэр томъёонууд болон нарийн мэргэжлийн үгсийн тодорхойлолтыг асуух.
10. Асуултуудынхаа хариултыг дэлгэрэнгүй тэмдэглэж авах.
11. Олж авах баримт бичгүүдийн жагсаалт үүсгэх.
12. Ярилцлагыг хяналтдаа байлгах.
13. Ярилцлагыг хамаарал бүхий мэдээлэлд төвлөрүүлэх.
14. Албан тушаалтнуудын зайлсхийхийг оролдож буй сэдвүүдийг ажиглах.
15. Цаг хугацааны хязгаарыг хүндэтгэх.
16. Холбогдох баримт бичиг болон холбоо барих хүмүүсийг асуух.

6-р алхам: Ярилцлагыг хаах:

1. Олж авсан гол мэдээллүүдээ хураангуйлах.
2. Мэдээллийг хэрхэн ашиглахаа тайлбарлах.
3. Ярилцлага өгсөн хүний асуулт болон саналд хариу өгөх.
4. Ярилцлага өгсөн хүнтэй дараа дахин уулзаж, нэмэлт асуулт асууж болох эсэхийг асуух.
5. Ярилцлага өгсөн хүмүүст цаг заваа зориулж, мэдээлэл өгсөнд нь талархал илэрхийлэх.

Ярилцлагыг тоймлох нь

7-р алхам: Ярилцлагыг тоймлох:

1. Зорьсон зүйлдээ хүрсэн үү? Хэрэв үгүй бол, яагаад?
2. Өөрөөр хэрхэн хийж болох байсан бэ?
3. Аудитын баг одооноос хэрхэн ажиллах шаардлагатай вэ?
4. Аудитын багийн хүн бүр нэгэн адил мэдээлэл сонссон үү?

8-р алхам: Ярилцлагын дараах үйл ажиллагаануудыг гүйцээх:

1. Уулзалтын дараа аль болох хурдан ярилцлагын протоколыг бичих (доор буй нэмэлт удирдамжийг үзнэ үү).
2. Ярилцлагын протоколын төслөө хянагчдаа нягтлуулахаар илгээх.
3. Ярилцлага өгсөн хүмүүсээс холбогдох баримт бичгүүдийг авах.
4. Шаардлагатай тохиолдолд, давтан ярилцлага товлох.

Ярилцлагыг баримтжуулах нь

Ярилцлагыг баримтжуулахын зорилго нь: ярилцлагын үеэр хэн, юу гэж ярьсан бэ гэдэг фактуудыг (баримтуудыг) баримтжуулах; мөн илрүүлэлт бий болгохын тулд уг баримтуудаа зохион байгуулахад оршино.

1. Олж авсан мэдүүлгийн нотлох зүйлсээ аль болох бүрэн бөгөөд үнэн зөв баримтжуулахын тулд уулзалт дууссаны дараа аль болох хурдан ярилцлагын протоколыг бэлтгэх хэрэгтэй:
 - Аль болох үнэн зөв протокол бичихийн тулд өөрийн болон ярилцлагад байлцсан аудитын багийн бусад гишүүдийнхээ тэмдэглэлийг ашиглах.

- Ярилцлагын протоколыг сэдэв, сэдвээр нь логиктойгоор эмхэтгэх. Хамгийн чухал материалыг хамгийн эхэнд нь оруулбал сайн. Протоколыг аль болох дэлгэрэнгүй байлгах хэрэгтэй ч, протокол нь ярилцлагын хуулан бичлэг биш гэдгийг санагтун.
 - Протоколд эш татсан бүх баримт бичгийг тулган шалгах.
 - Бүх нээлттэй тэмдэглэл болон хариулагдаагүй асуултуудыг шийдвэрлэх:
 - о Ярилцлага өгөгчийн мэдэгдэлд нөлөөлсөн хам нөхцөл, орчин нөхцөл, ялгаварлал болон бусад хүчин зүйлсийг тайлбарлахад аудиторын тэмдэглэлийг ашиглах.
 - о Бүх товчилсон үгсийг анх ашиглахдаа тодорхойлолтыг нь бичих.
2. Протокол бичихдээ аудитын зорилго() болон асуултуудыг санаж байх хэрэгтэй:
 - Аудитын асуултуудад хариулахад шаардлагатай өгөгдөл цуглуулж буй эсэхээ үнэлэх.
 - Боломжтой үед бүрд мэдээллийг эмх цэгцтэй байлгахын тулд протоколд гарчгууд болон дэд гарчгууд ашиглах.
 - Шаардлагатай үед, ярилцлагын үеэр цуглуулсан аливаа мэдээллээ бататгах хэрэгтэй эсэхийг хянагчаасаа асуух.
 3. Баримт бичгийнхээ үнэн зөв байдлыг ярилцлагад байлцсан аудитын багийн бусад гишүүдээрээ нягтлуулах хэрэгтэй эсэхийг хянагчаасаа асуух.
 4. Ярилцлагын протоколын төслөө нягтлуулахаар хянагчдаа өгөх.

Нэмэлт удирдамж

Ярилцлага бол өгөгдөл цуглуулах ч хэрэгсэл мөн, өгөгдөл шинжлэх ч хэрэгсэл мөн. Ярилцлага хийхдээ та боломжит илрүүлэлтүүдийг дэмжих нотлох зүйлсийг цуглуулж байдаг.

Ярилцлагын өмнө

Асуулт асуухдаа дэс дараалалтай асуух стратеги ашиглах тухай бодолцож үзэх хэрэгтэй. Ярилцлага хийхэд зориулсан дэс дараалалтай асуух тодорхой бүтэц байдаггүй боловч, та ярилцлагын үеэр цуглуулах мэдээллээ хэрхэн ашиглах тухай бодож үзэх нь тустай байж болно. Энэ асуултын хариулт нь танд ярилцлагаа ямар бүтэцтэй байлгахыг шийдэхэд хүргэнэ. Дараах жишээнүүдийг бодолцож үзэх хэрэгтэй.

Нарийсгах дараалал. Хамгийн ерөнхий асуултуудаар эхэлж, улмаар фокусаа нарийсгаж, удаах асуулт бүрд илүү нарийн зүйлийг асуух. Энэ арга нь анх өгсөн ерөнхий хариултыг илүү нарийн, тодорхой мэдээлэл болгодог. Тус арга нь ярилцлага өгч буй хүнийг анхны мэдэгдлээ шинэчилж, илүү үнэн зөв болгоход хүргэж болно.

Өргөсгөх дараалал. Тухайлсан асуултуудаар эхэлж, эцэст нь хамгийн ерөнхий асуултуудаар дүгнэж дуусгах. Энэ арга нь ярилцлага авагчид хэлэлцэгдэж буй тухайлсан асуудлууд болон судалгаанд хэрэгтэй бусад асуудал хоорондын хамаарлыг үүсгэхэд тусалдаг.

Эмзэг чанарын дараалал. Хамгийн бэрх эсвэл эмзэг асуултуудыг ярилцлагын төгсгөлд асуухаар төлөвлөх. Энэ арга нь ярилцлага авагчид аль болох урт хугацаанд чөлөөтэй өрнөх харилцаа үүсгэхэд тусалдаг. Энэ аргыг ашиглахдаа, хэлэлцэх шаардлагатай эмзэг

асуудал байгаа гэдгийг ярилцлагын эхэнд ярилцлага өгөгчид хэлж, түүнийг ярилцлагын эхэнд эсвэл төгсгөлд асуухаа шийдэх байдлаар бас ажиллаж болно.

Цаг хугацааны дараалал. Үйл явцын эхнээс буюу хамрагдах цаг хугацааны эхнээс эхэлж, үйл явдлуудыг өрнөсөн дарааллаар нь асуух. Энэ арга нь ярилцлага авагч суурь мэдээлэл цуглуулж буй үе буюу ажлын даалгаврын эхэнд маш тустай байдаг.

Санамсаргүй дараалал. Бүх асуулт нь адил тэнцүү ач холбогдолтой үед ямар нэгэн тодорхой дараалал шаардлагагүй байж болно.

Ярилцлагын үеэр

Идэвхтэй сонсох хэрэгтэй:

- Саад болох зан үйлээс (хуруугаараа товших, үзгээрээ оролдох, хуруугаа дуугаргах) татгалзах хэрэгтэй.
- Цонхоор гадагш ширтэж, эсвэл ханан дээрх диплом, сертификатуудыг уншиж болохгүй.
- Албан тушаалтныг ярьж байх үед өөрт өгөгдсөн баримт бичгүүдийг уншиж эхэлж болохгүй.
- Хаа нэгтэйгээс авсан ялгаварласан үзэл эсвэл мэдлэгээрээ ярилцлага өгч буй хүний хэлж буй мессежинд саад болж болохгүй. Нээлттэй сэтгэлгээгээ хадгалах хэрэгтэй.
- Яарч дүгнэлт хийж болохгүй. Ярилцлага өгч буй хүнийг сонсох хэрэгтэй. Танд илрүүлэлт бий болгох сэдэл хэчнээн төрсөн ч, ярилцлага өгөгчийн хэлэх үгийг нөлөөлөн чиглүүлж болохгүй.
- Саад болж, эсвэл мэтгэлцэж болохгүй.
- Ярилцлага өгч буй хүний илэрхийлсэн утгыг таамаглан ойлгож болохгүй. Тодруулж асуух хэрэгтэй. Ярилцлагыг эрхшээх эсвэл эцсийн цэгийг хатгах гэж оролдож болохгүй.
- Шаардлагатай үед төлөвлөсөн асуултуудаа өөрчлөн тохируулахад бэлэн байх хэрэгтэй. Гэхдээ, яаран шийдэж болохгүй. Албан тушаалтан тухайн мөчид яг юу ярьж байгааг анхааралтай төвлөрч сонсох хэрэгтэй.
- Ярилцлагын чухал мөчлөгүүдэд, ярилцлага өгөгчийн хэлснийг та юу гэж ойлгосноо өөрийн үгээр хураангуйлж, эргүүлэн хэлэх хэрэгтэй. Албан тушаалтанд танд ойлгогдсоныг залруулах боломж олгох хэрэгтэй.
- Ярилцлага өгч буй хүнд өөрийг нь сонсож байгаа гэдгээ харуулах хэрэгтэй.
- Ярилцлага өгч буй хүнтэй бүрэн харилцахын тулд урамшуулахыг оролдох хэрэгтэй.

Нийтлэг алдаанаас зайлсхийх нь:

- **Ярилцлага авагч нь маш их ярьсан ч, гол зүйлээ хэлэхгүй байх.** Ярилцлага өгөгч нь ямар ч асуулт олж сонсоогүйн улмаас үр нөлөөтэй хариулт өгч чадахгүй байдалд орно.
- **Ярилцлага авагч нь нэг асуултад олон асуулт багтааж асуух.** Ярилцлага өгөгч нь аль асуултад нь хариулахаа мэдэхгүй болно. Бусад тохиолдолд, ярилцлага өгөгч нь асуултуудын зарим хэсэгт хариулаад, үлдсэнийг нь орхигдуулна.
- Нээлттэй хариулттай асуулт асуух нь илүү тохиромжтой үед **ярилцлага авагч нь “тийм/үгүй” гэсэн хариулттай асуулт асуух.**
- **Ярилцлага авагч нь хөтлөн чиглүүлсэн шинжтэй асуулт асуух.** Хүлээж буй хариултаа асуултдаа багтааж, эсвэл хэт сэтгэл хөдлөл шингэсэн үгс ашиглаж асуух.

Ярилцлагын протоколын жишээ

Нэр	Аудитад шалгуулагчтай уулзах
Зорилго	...-н тухай мэдээлэл цуглуулах (аудитын сэдвийн дэлгэрэнгүй)
Холбоо барих арга	Биечлэн
Холбоо барих газар	Биечлэн буюу уулзалтын шуудангийн хаяг
Холбоо барих огноо	(огноог оруулах)
Оролцогчид	Аудитад шалгуулагч этгээдээс: Жэйн Дөү, албан тушаал, утасны дугаар, и-мэйл хаяг Жон Дөү, албан тушаал, утасны дугаар, и-мэйл хаяг Аудитын Дээд Байгууллагаас: Аудитын багийн гишүүний нэр, албан тушаал, утасны дугаар, и-мэйл хаяг Аудитын багийн гишүүний нэр, албан тушаал, утасны дугаар, и-мэйл хаяг
Тайлбар/тэмдэглэл: <p>Бид аудитад шалгуулагч этгээдийн байгууламжид очиж, талбарын ажил хийх явцдаа Жэйн Дөү болон Жон Дөү нараас ярилцлага авлаа. Бид тэднээс аудитад шалгуулагч байгууллагынх нь аудитын сэдэвт оролцох оролцооны талаарх асуултуудыг асуусан.</p> <p>Жэйн Дөү аудитад шалгуулагч этгээд аудитын сэдэвтэй ямар хамааралтайг тайлбарласан юм. Харилцаа нь: ... Тэрээр мөн аудитад шалгуулагч этгээд аудитын сэдэвт хэр удаан оролцож буйг хэлсэн. Хугацаа нь: ... жил/сар. Түүнчлэн, Жэйн Дөү аудитад шалгуулагч этгээд дэх өөрийн үүрэг, хариуцлагыг, мөн аудитын сэдэвтэй холбогдох өөрийн үүрэг, хариуцлагыг бидэнд тайлбарласан. Түүний үүрэг ... бөгөөд хариуцлагууд нь ... болон ... байв. Тэд ... учраас аудитын сэдэвтэй хамааралтай аж. Жон Дөү мөн аудитад шалгуулагч этгээд өөрийн үүрэг, хариуцлагыг аудитын сэдэвтэй холбогдох өөрийн үүрэг, хариуцлагын хамт бидэнд хэлж өгсөн. Түүний үүрэг ... бөгөөд хариуцлагууд нь ... болон ... байлаа. Тэд ... учраас аудитын сэдэвтэй хамааралтай гэв.</p> <p>Жэйн Дөү хэлэхдээ аудитад шалгуулагч этгээд нь аудитын сэдэвт оролцохдоо хэд хэдэн сорилттой тулгарч байсан гэсэн юм. Түүний жагсаан хэлсэн сорилтууд нь:</p> <p>(1) ... ; (2) ... ; мөн (3) ... болно.</p> <p>Жон Дөү ... учраас 2-р сорилтод хамгийн их санаа зовж байгаагаа илэрхийлсэн юм. Жэйн Дөү Жон Дөүгийн үнэлгээтэй санал нийлж буйгаа илэрхийлээд, нэмж ... гэж боддогоо ярилаа.</p>	

Эх сурвалж: АНУ-ын ТХГ.

Хавсралт 9: Шинжилгээний протоколын жишээ

Нэр	А баримт бичгийг Б баримт бичигтэй харьцуулах
Зорилго	Баримт бичгүүдийн харьцуулалт буюу ижил төстэй болон ялгаатай талуудыг баримтжуулах.
Эх сурвалж	А баримт бичиг Б баримт бичиг

Шинжилгээ/хураангуй:

Харьцуулалтын үр дүнгийн хураангуй

Ижил төстэй талууд (А болон Б баримт бичгээс хоёулангаас нь илэрсэн)

1. А болон Б баримт бичиг нь аудитын сэдвийг нэгэн ижил үгээр тайлбарласан байна.
2. А болон Б баримт бичгийн хавсралт хэсэгт байгууллагууд аудитын сэдэвт оруулж буй хувь нэмрээ баримтжуулахад ашиглаж болох маягтууд орсон байна.

Ялгаатай талууд

1. А баримт бичигт байгууллагууд аудитын сэдэвт оролцох явцдаа дагаж мөрдвөл зохих сайн туршлагаудыг тайлбарласан хоёр нүүрнээс бүрдсэн хэсэг оржээ.
2. А баримт бичигт тухайн нэг байгууллага аудитын сэдэвт оролцох явцдаа сайн туршлагыг хэрхэн хэрэгжүүлсэн тухай жишээнүүдийг агуулсан нэмэлт хавсралт оржээ.

Ижил төстэй талууд

Арга зүй: Хоёр баримт бичгийн ижил төстэй талуудыг тодорхойлохын тулд, аудитын баг зэрэгцүүлсэн харьцуулалт хийж, баримт бичиг тус бүрийн гол нэр томъёог цахимаар хайсан.

А болон Б баримт бичиг нь аудитын сэдвийг тодорхойлоход ... болон ...-г ашиглажээ

А баримт бичгийн 3-р нүүрний 3-р догол мөрнөөс аудитын сэдвийн тодорхойлолтыг үзнэ үү. Уг тодорхойлолтод ...-г ашиглажээ.

Б баримт бичгийн 10-р нүүрний 5-р догол мөрнөөс аудитын сэдвийн тодорхойлолтыг үзнэ үү. Уг тодорхойлолтод ...-г ашиглажээ.

А болон Б баримт бичгүүд ижил маягт агуулсан хавсралтуудтай байна.

А баримт бичгийн 28-р нүүрэн дэх 9-р хавсралтыг үзнэ үү. Маягтын өмнөх хураангуйд байгууллагууд энэ маягтыг ашиглан аудитын сэдэвт оруулсан хувь нэмрээ баримтжуулж болно гэж бичжээ. Маягтыг дараагийн хоёр нүүрнээс нь (29-30)үзнэ үү.

Б баримт бичгийн 35-р нүүрэн дэх 10-р хавсралтыг үзнэ үү. Хавсралтын гарчиг нь “Байгууллагууд ...-д оруулсан хувь нэмрээ баримтжуулахад ашиглаж болох маягтын жишээ” гэж бичжээ. Маягтыг 35-36-р нүүрнээс нь үзнэ үү.

А баримт бичгийн 9-р хавсралт болон Б баримт бичгийн 10-р хавсралт дахь маягтууд нь хоорондоо ижил маягтууд байна.

Ялгаатай талууд

Арга зүй: Хоёр баримт бичгийн ялгаатай талуудыг тодорхойлохын тулд, аудитын баг зэрэгцүүлсэн харьцуулалт хийж, баримт бичиг тус бүрийн гол нэр томъёог цахимаар хайсан.

А баримт бичигт сайн туршлагуудыг тайлбарласан нэг хэсэг байна.

А баримт бичгийн 13-14-р нүүрэнд байгууллагууд аудитын сэдэвт оролцох явцдаа дагаж мөрдвөл зохих сайн туршлагуудыг тайлбарласан хэсэг оржээ.

Б баримт бичигт ийм хэсэг байхгүй байна. 2-20-р нүүрнээс “сайн туршлага” гэсэн нэр томъёог хайж үзнэ үү.

Хавсралт 10: Өгөгдлийн найдвартай байдлын үнэлгээний жишээ

Өгөгдлийн найдвартай байдлын үнэлгээний протокол

Гүйцэтгэлийн аудитын хувьд энэ маягыг бөглөнө үү.

- Өгөгдлийн найдвартай байдал бол АДБ-ын ажлын асар чухал хэсэг бөгөөд аудитын үйл ажиллагааны аль болох эхэн үед, болбол төлөвлөлтийн үе шатны эхэн үед авч хэлэлцэх хэрэгтэй. Аудитын баг шинжилгээ хийж, аудитын тайлангийн илрүүлэлтүүдийг боловсруулж эхлэх үед аудитын баг болон дотоод оролцогч талууд нотлох чанартай өгөгдлүүд нь хангалттай найдвартай байгаа эсэхийг тогтоож, өгөгдлийн аливаа хязгаарлалтын мөн чанарыг ойлгож, хийх шаардлагатай өгөгдлийн найдвартай байдлын аливаа нэмэлт ажлын талаар хэлэлцэх шаардлагатай болдог бөгөөд энэ үед мөн өгөгдлийн найдвартай байдлын хэлэлцүүлэг өрнөх ёстой.
- Энэхүү маягт нь үнэлгээ хийх шаардлагатай эсэхийг тогтоосон багийн шийдвэрийг баримтжуулна. Мөн, шаардлагатай үед, өгөгдлийн найдвартай байдлын төлөвлөгөө, уг төлөвлөгөөг хэрэгжүүлэх алхмууд, өгөгдлийг хэрхэн илрүүлэлтүүд болон дүгнэлтүүдийн шинжилгээний суурийн нэг хэсэг болгож ашиглахыг, мөн өгөгдлийн зорилтот ашиглалтад буй аливаа хязгаарлалтуудыг баримтжуулна.

Аудитын нэр:	
Бэлтгэгч:	Техникийн дэмжлэг (хэрэв байгаа бол) үзүүлсэн:

Менежер нь энэхүү маягыг дараах хоёр үйл явдлын аль нэгийг нь төгсгөлд зурна: (1) Өгөгдлийн найдвартай байдлын үнэлгээ хийх шаардлагагүй гэсэн шийдвэр гарч, энэ маягтын 1-р хэсгийг гүйцэтгэсэн үед; эсвэл (2) өгөгдлийн найдвартай байдлын бүх ажил дуусаж, энэ маягтын 1, 2, 3-р хэсгийг гүйцэтгэсэн үед.

Жич: Аудитын баг өгөгдлийн найдвартай байдлын үнэлгээ хийх шаардлагагүй гэж анх дүгнэснийхээ дараа, шаардлагатай гэж дүгнэсэн бол энэ тухайгаа 1-р хэсэгт нэмэлт тайлбараар оруулж, 2, 3-р хэсгийг гүйцэтгээд, ажил дууссаны дараа гарын үсэг болон огноог дахин бичнэ.

Менежерийн зөвшөөрөл

Менежер

Гарын үсэг зурсан огноо

1-р хэсэг: Өгөгдлийн найдвартай байдлын үнэлгээ хийх шаардлагатай юу?

Аудитын багийн ашиглахаар төлөвлөж буй компьютероор боловсруулсан аливаа өгөгдөл нь илрүүлэлт (аудитын асуултуудын хариулт), дүгнэлт, зөвлөмжүүдэд материаллаг байдлаар нөлөөлөх төлөвтэй үед өгөгдлийн найдвартай байдлын үнэлгээг ашиглах хэрэгтэй. Материаллаг байдлыг тогтооход аудитын багийн мэргэжлийн үнэлэмж шаардлагатай.

Аудитын баг шийдвэрээ энэхүү маягт дээр баримтжуулах шаардлагатай боловч, дараах нөхцөлүүдийн аль нэг нь үүссэн үед 2, 3-р хэсэгт орсон өгөгдлийн үнэлгээг хийх шаардлагагүй.

2-р хэсэг: Өгөгдлийн найдвартай байдлын үнэлгээний протокол (үргэлжлэл)

ЭХ СУРВАЛЖ 4: Өгөгдлийн эх сурвалжийн нэр/тайлбар

Энэхүү өгөгдлийн эх сурвалжийн өгөгдлийн найдвартай байдлыг Засгийн Газрын Аудитын Стандарт 6.06-гийн дагуу үнэлэхээр төлөвлөх (төлөвлөгөөгөө тайлбарлах эсвэл баримт бичиг эш татах)

Энэ эх сурвалжийн өгөгдлийг дараах байдлаар эцсийн бүтээгдэхүүнд ашиглахаар төлөвлөж байна:

___ Илрүүлэлт, дүгнэлт, зөвлөмжүүдийн цор ганц дэмжлэг.

___ Илрүүлэлт, дүгнэлт, зөвлөмжүүдийг дэмжих нотлох зүйлсийн олон эх сурвалжийн нэг.

___ Тайлангийн илрүүлэлт, дүгнэлт, зөвлөмжүүдэд материаллаг байдлаар нөлөөлөх төлөвтэй хам нөхцөлийн эсвэл суурь мэдээлэл.

Энэ эх сурвалжаас үнэлсэн өгөгдлийн элементүүдийг тайлбарлах (тайлбар бичиг эсвэл баримт бичиг эш татах)

Доорх хүснэгтээс, энэ эх сурвалжийн өгөгдлийн элементүүд нь найдвартай эсэхийг тогтоохын тулд хийсэн алхмуудыг тэмдэглэж, алхам бүрд эш татах материал оруулна уу. Зарим алхам шаардлагагүй байж болно.

Хийсэн алхмууд	Өгөгдлийн найдвартай байдлыг шалгах алхмууд	Эш татах баримт бичиг(үүд) эсвэл үзэх холбоос(нууд)
	Холбогдох баримт бичгүүдийг нягтлах	
	Аудитад шалгуулагч этгээдийн мэдлэгтэй ажилтнаас ярилцлага авах	
	Дутуу өгөгдөл, алслагдсан утгууд болон илэрхий алдааг илрүүлэх өгөгдлийн тестийг цахим технологиор эсвэл гараар хийх (нийтлэгдсэн мэдээлэлтэй харьцуулах болон логик тест агуулж болно)	
	Холбогдох дотоод хяналтыг нягтлах	
	Эх сурвалжийн баримт бичгүүдээс сонголтод эсвэл санамсаргүй түүвэр авч шалгах	
	Бусад (тайлбарлана уу)	

Жич: Дөрвөөс олон эх сурвалж ашигласан бол, дээрх маягтын хэсгийг хуулан олшруулж, нэмэлт эх сурвалжуудын шаардлагатай мэдээллийг оруулна уу (ЭХ СУРВАЛЖ 5, г.м.).

3-р хэсэг: Өгөгдлийг хэрхэн ашиглаж болох вэ?

Өгөгдлийн эх сурвалж тус бүрээс авсан өгөгдлийн найдвартай байдалд хийсэн үнэлгээний дүнг хураангуйлна. Өгөгдөлд хязгаарлалт байгаа бол түүний тухай мэдээлэл оруулж, уг хязгаарлалт нь өгөгдлийг эцсийн бүтээгдэхүүнд ашиглах байдалд хэрхэн нөлөөлөхийг тайлбарлах (тухайлбал, илрүүлэлт, дүгнэлт, зөвлөмжүүдэд үзүүлэх нөлөө).

Үнэлгээ хийсэн бүх эх сурвалжаас авсан өгөгдлийн найдвартай байдлын дүгнэлт (нэгийг сонгоно уу)

___ Бидний үнэлсэн бүх өгөгдлийн элемент нь энэ үйл ажиллагаанд хангалттай найдвартай байна (хязгаарлалтуудыг, хэрэв байгаа бол, дээр тайлбарласан болно).

___ Бидний үнэлсэн зарим өгөгдлийн элемент хангалттай найдвартай бөгөөд хязгаарлалтуудыг, хэрэв байгаа бол, дээр тайлбарласан болно. Хангалттай найдвартай биш өгөгдлийн элементүүдийг энэ үйл ажиллагаанаас хасав.

___ Ямар ч өгөгдлийн элемент нь энэ үйл ажиллагаанд хангалттай найдвартай биш байсан бөгөөд тэдгээрийг энэ үйл ажиллагаанаас хасав.

___ Тодорхойлоогүй найдвартай байдал, хязгаарлалт болон тэдгээрийн үр нөлөөг дээр тайлбарлав.

___ Бусад (тухайлбал, үндсэн зорилго нь аливаа тогтолцоо эсвэл тогтолцооны нэг хэсгийн найдвартай байдлыг үнэлэхэд оршиж байв).

Жич: Өгөгдлийн найдвартай байдлын үнэлгээ хийх шаардлагатай гэж үзэж 2, 3-р хэсгийг гүйцэтгэсний дараа, менежер нь энэ маягтыг нягталж, 1-р хуудсанд гарын үсэг зурснаар өгөгдлийн найдвартай байдлын үнэлгээг батална.

Эх сурвалж: АНУ-ын ТХГ-ын мэдээллийг эш болгов.

Хавсралт 11: Аудитад шалгагдагч этгээдийн өгөгдлийн найдвартай байдлыг үнэлэх асуултуудын жишээ

1. Өгөгдлийн системийг хэзээ үүсгэсэн бэ, ямар зорилготой вэ?
2. Өгөгдлийн эзэмшигч нь өгөгдлийг хэрхэн ашигладаг вэ?
3. Өгөгдлийн системийн үндсэн хэрэглэгчид хэн бэ?
4. Хэрэглэгчид системд хэрхэн нэвтэрдэг вэ?
5. Системд нэвтэрч, өгөгдөл оруулах эсвэл шинэчлэх эрх хэнд байдаг вэ?
6. Өгөгдөлд хандах эрхийн өөр өөр “түвшин” бий юу?
7. Системийн хэрэглэгчдийг сургалтад хамруулдаг бол ямар сургалтад хамруулдаг вэ?
8. Сургалт нь бүх хэрэглэгчдэд нээлттэй юу?
9. Хүсэлт гаргасан хугацаанд өгөгдлийн нэгэн жигд байдалд нөлөөлөх ямар нэгэн өөрчлөлтийг өгөгдлийн системд оруулсан уу (тухайлбал, системийн томоохон сайжруулалт, шинэ нийлүүлэгчдэд оруулсан өөрчлөлт)?
10. Өгөгдлийг хэрхэн, хаана цуглуулдаг вэ (тухайлбал, өгөгдлийг гараар оруулах, агентлагийн төлөөлөгч нар маягт бөглөх, өгөгдлийн эзэмшигчээс өөр этгээд өгөгдөл оруулах)?
11. Өгөгдөл оруулах ажлыг хэн хариуцдаг вэ?
12. Өгөгдөл нь хэр сүүлийн үеийнх вэ?
13. Өгөгдлийг хэр их давтамжтай оруулдаг вэ?
14. Өгөгдлийн эзэмшигч нь өгөгдөл оруулахад, ялангуяа нээлттэй эсвэл хэрэглэгчийн оруулах орц хувьсан өөрчлөгддөг өгөгдлийн талбарт өгөгдөл оруулахад зориулсан ямар зааварчилгаа өгдөг вэ?
15. Ажилтнууд, оффисүүд болон бусад нэгжүүдийн оруулдаг өгөгдлийн нэгэн жигд байдлын талаар юу мэдэгдэж байгаа вэ?
16. Өгөгдлийг нэгжүүдээр нь (тухайлбал, мужууд, байгууллагууд) багцалж үүсгэдэг бол, уг нэгжүүдийн өгөгдөл цуглуулах эсвэл тооцоолон бодох арга хэлбэрт эцсийн багцалсан өгөгдлийн нэгэн жигд байдлыг алдагдуулж болох ямар нэгэн ялгаатай байдал байна уу?
17. Чанарын нягталгаа эсвэл бусад горимын улмаас өгөгдөл оруулах байдал өөрчлөгдөх үү? Өгөгдөл дэх бүртгэл тус бүр нь шинжилгээний ямар нэгжийг төлөөлөх вэ (тухайлбал, хувь хүн, үйл явдал, айл өрх)?
18. Өгөгдлийн систем ямар бүтэцтэй вэ?
19. Өгөгдлийг “дан файл” хэлбэрээр хадгалдаг уу, эсвэл өгөгдлийн систем нь холбоо хамааралтай/шаталсан эрэмбэтэй юу?
20. Хэрэв өгөгдөл нь холбоо хамааралтай бол, хүснэгтүүдийг холбоход ямар давтагдахгүй түлхүүр (unique identifier) ашигладаг вэ?
21. Энэ өгөгдлийн багц дахь ямар нэгэн өгөгдлийг (бүртгэл эсвэл талбар) өөр бусад өгөгдлийн системээс оруулж ирсэн үү?
22. Өгөгдлийн аль нэгийг нь өөр бусад өгөгдлийн системээс оруулж ирсэн бол өгөгдлийг үнэн зөв, бүрэн уншуулах ямар чанарын хяналтын функц байгаа вэ?
23. Өгөгдлийн системд өгөгдлийн бүх тохиолдол (бүртгэл, ажиглалт) болон бүх өгөгдлийн элементийг нэгэн жигд оруулах ямар горимууд байгаа вэ?
24. Өгөгдөлд давхардсан бүртгэл үүсэхээс сэргийлэх ямар горимууд байгаа вэ?
25. Өгөгдлийн систем нь оруулсан өгөгдлийг үнэн зөв байлгахад туслах ямар нэгэн засварлах шалгалт эсвэл хяналттай юу?
26. Мүжаас (завсраас) гадуур өгөгдөл эсвэл нэгэн жигд биш өгөгдлийг мэдүүлэх алдаа заах мессеж зэрэг цахим хамгаалалт бий юу?
27. Гол талбаруудыг үнэн зөв бөгөөд давхардалгүй байлгахын тулд өгөгдлийг бүхэлд нь эсвэл түүвэрлэн авч нягталдаг хүн бий юу?
28. Өгөгдөлд оруулсан өөрчлөлтүүдийг бүртгэж, хянах үйл явц байгаа бол ямар үйл явц байгаа вэ?
29. Өгөгдлийн систем нь өгөгдөлд оруулсан өөрчлөлтийн түүхийг хадгалдаг уу? Шинэ өгөгдөл оруулах үед хуучин түүхэн мэдээлэл устах уу? Өгөгдлийг программ хангамжийн хүснэгтэд хадгалдаг бол, өгөгдлийг

санамсаргүй өөрчлөх эсвэл устгахаас хамгаалах ямар горим байгаа вэ? Мөн, хүснэгт дэх аливаа томъёоны үнэн зөв байдлыг нягталдаг уу?

30. Алдаа илэрсэн тохиолдолд алдааны мөрөөр судлах ямар горим байдаг вэ? Алдааг залруулах хариуцлагыг хэн хүлээдэг вэ?
31. Холбогдох өгөгдлийн талбаруудад алдаа илрүүлсэн бол, түүний шалтгаанууд нь юу байсан бэ? Уг алдаануудыг залруулсан уу?
32. Системчилсэн нягталгаа эсвэл гүйцэтгэлийн хазайлтын тайлан нь үнэн зөв байдлыг судалж, алдааны түвшнийг толилуулдаг уу? Хэр давтамжтай ингэдэг вэ?
33. Системд судалгаа эсвэл үнэлгээ хийсэн бол, ямар үр дүн гарсан бэ? Илэрсэн аливаа асуудлыг та хэрхэн шийдвэрлэсэн бэ?
34. Хэрэв боломжтой бол, өгөгдлийн гаднын хэрэглэгчид эсвэл дата өгөгдлийн бүртгэлийн судлагч хувь хүмүүс тухайн өгөгдлийн үнэн зөв байдлыг нягталж, саналаа хэлэх боломж олгодог уу?
35. Одоо байгаа хувьсагчуудыг бүртгэх замаар шинэ хувьсагч үүсгэдэг үү? Эсвэл одоо байгаа хувьсагчдын утгад үндэслэн шинэ хувьсагч тооцоолдог уу? (тухайлбал, бүртгэгдсэн өдрүүдийн хооронд орших өдрүүдийг тооцоолох, эсвэл насны мужид (завсарт) үндэслэн шинэ хувьсагч үүсгэх)
36. Өгөгдлийн системийн баримтжуулалтад шинэ хувьсагчуудыг хэрхэн үүсгэсэн эсвэл тооцоолсныг тайлбарладаг уу?
37. Нууцлалыг хамгаалах эсвэл өөр бусад зорилгоор өгөгдлийн утгуудад ямар нэгэн өөрчлөлт оруулсан бол ямар өөрчлөлт оруулсан бэ?
38. Өөр бусад байгууллагаас боловсруулсан ангиллыг ашиглаж буй ямар нэгэн хувьсагч байна уу (тухайлбал, салбарын төрөл эсвэл яс үндсийн ангилал)?
39. Өгөгдлийн хүсэлт гаргасан хугацаанд өгөгдлийн элементийг тодорхойлж, оруулж, хадгалах арга зэрэг аливаа горимд өөрчлөлт оруулсан уу (тухайлбал, хүн ам эсвэл газар зүйн талбарууд, хувьсагчийн тодорхойлолт, хувьсагчийн утга эсвэл ангилал, өгөгдөл оруулах зааварчилгаа, боломжит утгуудын сонголт зэрэгт оруулсан өөрчлөлт)?
40. Өгөгдлийн хүсэлт гаргасан хугацаанд горимуудад өөрчлөлт оруулсан бол өгөгдлийн үнэн зөв байдал болон нэгэн жигд хангах ямар алхмуудыг авч хэрэгжүүлсэн бэ?
41. Өгөгдлийн чанар, ялангуяа бүрэн бүтэн байдал болон үнэн зөв байдлын талаарх таны санал дүгнэлт юу вэ? Ихэвчлэн бүрэн бүс эсвэл буруу байдаг өгөгдлийн элементүүд зэрэг ямар нэгэн өгөгдлийн хязгаарлалтууд бий юу? Эдгээр хязгаарлалтууд өгөгдлийн зорилтот ашиглалтад хэрхэн нөлөөлөх вэ?
42. Өгөгдлийн цаг хугацаатай байдал эсвэл ашиглах боломжийн талаар анхаарах асуудлууд байгаа юу?
43. Өгөгдлийг ашиглах ёсгүй ямар нэгэн зорилго бий юу?
44. Өгөгдлийн чанарыг сайжруулах ямар нэгэн залруулах арга хэмжээ авсан уу?

Эх сурвалж: АНУ-ын ТХГ-ын тайлан, Өгөгдлийн найдвартай байдлыг үнэлэх нь, 2019, ТХГ-20-283.

Хавсралт 12: Өгөгдөл цуглуулах хэрэгслийн жишээ

Энд буй өгөгдөл цуглуулах хэрэгсэл нь (ӨЦХ) хэрэгжилтийн түншүүд/оролцогчидтой хийсэн төрийн байгууллагын тохиролцоог нягталж буй аудитын багт зориулагдсан жишээ болно.

Өгөгдөл цуглуулах хэрэгсэл (ӨЦХ)

ӨЦХ-ийг анх гүйцэтгэсэн: _____

Анх гүйцэтгэсэн огноо: _____

ӨЦХ-ийг нягталсан: _____

Нягталсан огноо: _____

А) Суурь мэдээлэл

1. Баримт бичгийн нэр _____
2. Баримт бичгийн огноо _____
3. Анх үүссэн эх сурвалж _____

Б) Дэлгэрэнгүй

1. Хэрэгжилтийн түнш/оролцогч _____
2. Тохиролцсон он _____
3. Тохиролцооны хугацаа: Нэг жилийн Олон жилийн Тодорхойлох боломжгүй
4. (Олон жилийн тохиролцооны хувьд) Тохиролцооны хамрах жилийн тоо _____

Жич: ӨЦХ зохиохдоо, өгөгдлийн талбарын зохиомж, хэлбэржүүлэлт болон хэмжилтийг харгалзан үзэж, дараахыг оруулна уу:

- *Ажлын баг өгөгдлийн талбар тус бүрийн мэдээллийг ӨЦХ-д хэрхэн нэгтгэх вэ?*
- *Ажлын баг кэйс бүрд нэг нэг ӨЦХ ашиглах уу, эсвэл бүх кэйст нэг ӨЦХ ашиглах уу?*
- *Ажилтнууд болон өгөгдөл цуглуулалтын ямар горимууд шаардлагатай вэ (тухайлбал, талбар дээр тулган баталгаажуулалт хийх, мөн/эсвэл өгөгдөл оруулах ажлыг нягтлах; ӨЦХ-д гарын үсэг зурах эсвэл нэрээ бичих зай үлдээх)?*
- *ӨЦХ дээрх өгөгдлийн талбаруудын дэс дараалал ямар байх вэ (ямар мэдээллийг түрүүлж цуглуулах, ямрыг нь хоёрдугаарт цуглуулах, г.м.)?*
- *ӨЦХ нь баримт бичгийн гарчиг, ажлын баг хуулбарлаж эсвэл тайлбарлаж болохгүй цаасан баримт бичгийн нэмэлт ажиглалт эсвэл талбар дээрх нягталгаа зэрэг нэмэлт болон хүлээгдээгүй мэдээллийг цуглуулахдаа нээлттэй өгөгдлийн талбар ашиглах уу?*
- *Өгөгдлийн талбар тус бүрийн хэлбэр формат нь хүссэн мэдээллийн төрөлтэй хэрхэн харгалзах вэ (чагтлах дөрвөлж, олон сонголтод жагсаалт (тухайлбал, тийм/үгүй), нөхөж бичих хоосон зай, г.м.)?*
- *Талбараас анх мэдээлэл цуглуулахад цаасан маягт ашигласан бол, өгөгдлийг хэрхэн цахим файлд оруулах вэ? Ийм тохиолдолд, цаасан болон цахим маягтын зохиомжийг хэрхэн харгалзуулахыг бодолцож үзэх хэрэгтэй.*

Эх сурвалж: АНУ-ын ТХГ.

Хавсралт 13: Шууд ажиглалтыг баримтжуулах маягтын жишээ

Нэр	Аудитад шалгуулагч этгээдийн албан тушаалтнуудын хийдэг гаалийн үзлэгийг ажиглах ...
Зорилго	Гаалийн үзлэгийн үеэр ажиглалтуудыг баримтжуулах
Ажигласан газар	Нисэх буудал ...
Ажигласан үйл ажиллагаа	Гаалийн үзлэгийн тоо
Ажиглалтын огноо	Огноог энд бичнэ
Оролцогчид	<u>Аудитад шалгуулагч “А” этгээд</u> Албан тушаалтан 1 Албан тушаалтан 2 <u>Аудитын Дээд Байгууллага</u> Аудитор А Аудитор Б

Ажиглалт/тэмдэглэл:

Бид энэ хугацаанд нийт ... удаагийн гаалийн үзлэгийг ажиглалаа. Уг үзлэгүүдийн дэлгэрэнгүй мэдээллийг доороос үзэж болно.

(1) 08:00-08:30 цаг хооронд 1-р ажилтны хийсэн үзлэг:

- 1-р ажилтан байцаагдагчийн гар цүнхийг нээж, үзлэгийг эхлүүллээ. Гар цүнх дэх зүйлсийг бүгдийг нь гаргаж ширээн дээр цэгцтэй байрлуулав. Байрлуулах явцдаа улсын хилээр нэвтрүүлэхийг хориглосон эд зүйлсийн шалгах хуудасны дагуу системтэй шалгаж байлаа. Байцаагдагчийн гар цүнхнээс ямар нэгэн хориотой зүйл илрүүлсэнгүй.
- Дараа нь байцаагдагчийн чемоданыг нээлээ. Чемодан дахь эд зүйлсийг нэг бүрчлэн шалгахдаа нэг тал руу шахан овоолж байв. Гар цүнхийг шалгахдаа ашигласан шалгах хуудсыг мөн ашиглаж байлаа. Энэ үзлэгийн үеэр шалгах хуудсанд орсон нэг зүйлийг илрүүлэв. Түүнийг хажуу тийш нь тавиад, чемоданы үзлэгээ үргэлжлүүллээ. Чемодан дахь үлдсэн зүйлсийг шалгаж дуусгаад, хажуу тийш нь тавьсан хориотой зүйлийн талаар байцаагдагчаас асуув. Хориотой зүйлийн талаар асуухдаа асуултууд агуулсан өөр шалгах хуудас ашиглаж байлаа.

Эх сурвалж: АНУ-ын ТХГ.

Хавсралт 14: Судалгааг хэрхэн хийх вэ?

Судалгааны эх олонлогийг тодорхойлох

Судалгаа хийх эх олонлогоо тодорхойлох хэрэгтэй. Ингэхдээ, олж авна гэж найдаж буй мэдээллийнхээ хамгийн сайн эх сурвалж гэж үзсэн хувь хүмүүс болон байгууллагуудыг хамруулах хэрэгтэй.

Түүнчлэн, хэдэн хувь хүн болон байгууллагаас судалгаа авахаа шийдэх хэрэгтэй. Зарим аудитын хувьд, зорилтот эх олонлог нь жижиг байдаг (тухайлбал, 100 ажилтантай байгууллага) учраас эх олонлогийг бүхэлд нь судлах боломжтой байдаг.

Зорилтот эх олонлог нь маш том байж болно (тухайлбал, төрийн байгууллагаас дэмжлэг хүлээн авдаг нэг сая иргэн). Том зорилтот эх олонлогийн хувьд, та зөвхөн түүвэрлэн авч судалгаа хийх боломжтой байж мэднэ. Ийм тохиолдолд, хүссэн зорилгынхоо төлөө мэдээлэл цуглуулахад тохиромжтой түүвэр үүсгэх хэрэгтэй. Энэ нь нарийн төвөгтэй үйл явц байж болох тул судалгааны экспертээс зөвлөгөө авах хэрэгтэй.

Судалгааны асуумжийг боловсруулах

Судалгааны зөв асуултуудыг боловсруулах нь нотлох зүйл болгон ашиглаж болох чанартай мэдээллийг олж авахад маш чухал. Дараах алхмууд асуумж боловсруулахад тань тусална:

- 1. Аудитын асуулт(ууд)ынхаа аль хэсэгт нь судалгаа ашиглаж хариулахаа шийдэх.** Судалгааг зохиомжлохдоо аудитын асуултуудад хариулахад тань шууд туслах байдлаар зохиомжлох нь чухал. Судалгаа танд үүнийг хийхэд тусалж чадахгүй байвал, өөр арга ашиглах талаар бодолцож үзэх хэрэгтэй.
- 2. Аудитын асуулт(ууд)ын уг хэсгийг задалж, сэдвийн талбаруудын багц үүсгээд сэдвийн талбаруудыг илүү нарийвчлан судлах асуултуудыг боловсруулах (Зураг 14.1-ийг үзнэ үү).** Асуултууд нь таны мэдээллийн хэрэгцээнээс хамаарч нээлттэй хариулттай эсвэл хаалттай хариулттай байж болно. Ямар ч асуулт байсан, дараах шаардлагыг хангасан байвал зохино:
 - Судалгаанд оролцогч нарт хялбархан бөгөөд нэгэн ижил утгаар ойлгогдохуйц байдлаар бичигдсэн байх. Өөрөөр хэлбэл, богино бөгөөд энгийн;
 - Судалгаанд оролцогч нар уг асуултад хариулахад шаардлагатай мэдээлэлд хандах боломжтой байх;
 - Судалгаанд оролцогч нарт хариулахад хэт дарамттай биш; мөн
 - Судалгаанд оролцогчийн хариултыг нэг талыг барьсан болгох байдлаар бичигдээгүй.

Зураг 14.1: Аудитын асуултаас судалгааны асуулт боловсруулах жишээ



Эх сурвалж: АНУ-ын ТХГ.

Судалгааны асуултуудыг урьдчилан тестэлж, үнэлж, сайжруулах нь чухал. Ингэхийн тулд дараахыг хэрэгжүүлнэ үү:

- Судалгааны зорилтот эх олонлогийн (хүн амын) гишүүд дээр судалгааны асуумжаа урьдчилан тестэлж, асуултуудыг ойлгосон эсэх талаар нь эгэх мэдээлэл авах.
- Урьдчилан тестэлсэн судалгааны хариултуудыг үнэлж, таны асуултууд танд хэрэгтэй өгөгдлийг цуглуулж байгаа эсэхийг тогтоох.
- Судалгааны хариултууд нь тайланд орох аудитын асуултуудад хариулах боломжийг танд хэрхэн гаргаж өгөх талаар бодолцож үзэх.
- Судалгааны эх олонлогоос зөв асуулт асууж байгаадаа бүрэн итгэлтэй болох хүртлээ асуултуудаа урьдчилсан тест болон үнэлгээнд үндэслэн сайжруулах.

Судалгааг гүйцэтгэх аргыг сонгох

Биечлэн эсвэл утсаар ярилцах судалгаа, вебд суурилсан судалгаа, шуудангаар авах цаасан судалгаа, и-мэйлээр авах цахим судалгаа, эсвэл оролцогчоор өөрөөр нь биечлэн гүйцэтгүүлж авах судалгаа зэрэг олон аргаар судалгааг явуулж болно.

Эх олонлогийн хэмжээ, танай ажилтны нөөц болон судалгаанд оролцогчидтой хэрхэн холбоо барих вэ гэдэг нь бүгд чухал хүчин зүйлс болно. Дараах асуултуудад анхаарвал зохино:

- Эх олонлог нь интернэт, телефон утас болон шуудангийн үйлчилгээ авдаг уу?
- Зорилтот эх олонлогтойгоо харилцахаар сонгосон аргад тань ашиглагдах холбоо барих үнэн зөв мэдээлэлтэй болсон уу (тухайлбал, утасны дугаар, и-мэйл хаяг, шуудангийн хаяг)?
- Эх олонлогийн гишүүдэд судалгаанд өөр аргаар оролцох чадварт нь нөлөөлж болох унших, харах, сонсох эсвэл хөдлөхтэй холбоотой ямар нэг бэрхшээл бий юу?
- Зорилтот эх олонлог хэр том бэ? Ярилцагчаар гүйцэтгүүлэх сонголтыг харгалзан үзэх хэмжээний хангалттай хүний нөөц танд бий юу?

Зорилтот эх олонлог судалгаанд хялбархан хариулж чадахгүй, эсвэл танд судалгааг төлөвлөсөн ёсоор гүйцэтгүүлэх хүний нөөц байхгүй үед таны сонгосон арга нь судалгааны хариултын хувь хэмжээнд нөлөөлөх болно.

Судалгааны үр дүн болон арга зүйг баримтжуулах

Судалгааг хэрхэн гүйцэтгэснээ, судалгааны хариултуудыг, мөн судалгааны үр дүнд хийсэн аливаа шинжилгээг сайтар баримтжуулах хэрэгтэй. Судалгаагаар олж авсан нотлох зүйлд үндэслэн эцсийн тайланд оруулах бүх мэдэгдлийг дэмжих шаардлагатай болох учраас баримтжуулалт чухал. Түүнчлэн, судалгааны арга зүй, судалгаагаар олж авсан өгөгдлийн чанар, мөн судалгааны давуу болон сул талуудын талаарх мэдээллийг аудитын тайланд оруулах хэрэгтэй. Тэгснээр тайлангийн уншигчид таны хийсэн судалгааны үр дүнг хэрхэн хөрвүүлж ойлгохоо мэддэг болно.

Үр нөлөөтэй судалгаа хийхэд тус гарын авлагад орсноос илүү их удирдамж чиглүүлэг шаардлагатай. Иймд, судалгаа эхлүүлэхийн өмнө экспертүүдийн дэмжлэгийг хүсэхээ мартаж болохгүй.

Хавсралт 15: Агуулгын шинжилгээ


Агуулгын шинжилгээ бол нарийн төвөгтэй чанарын өгөгдлийг бүтэцжүүлж, шинжлэх замаар тоон өгөгдөл болгон хувиргах чанарын арга юм. Үүнийг заримдаа өгөгдлийг багасгах үйл явц гэж нэрлэдэг. Гол зорилго нь өгөгдлийг хязгаарлагдмал тооны сэдвүүд буюу агуулгын ангилалд хураангуйлан оруулахын тулд системтэйгээр ангилж, төвлөрүүлж, хялбаршуулахад оршдог. Агуулгын шинжилгээ хийхэд их цаг хугацаа шаардагддаг тул, зарим АДБ энэ гарын авлагад тайлбарласан бусад төрлийн чанарын аргууд шиг түгээмэл ашигладаггүй байж болно. Гэвч, агуулгын шинжилгээ нь тодорхой нөхцөл байдлуудад хэрэгтэй байж чаддаг.

Агуулгын шинжилгээний эхлэлийн цэг болдог чанарын өгөгдөлд аудитад шалгуулагч этгээдийн бодлогын баримт бичгүүд, ярилцлагуудын тэмдэглэл, сонины нийтлэлүүд, фокус бүлгийн хэлэлцүүлгүүдийн тэмдэглэл, нэхэмжлэлийн файлууд болон тайлангууд зэрэг багтаж болно. Тухайлбал, агуулгын шинжилгээгээр та ярилцлагын үед хэлэгдсэн хариултуудыг ангилж, тоогоор илэрхийлж болно. Эсвэл, нэхэмжлэлийн файлуудад бүртгэгдсэн өөр өөр төрлийн үйл явдлуудын давтамжийг тогтоож болно. Агуулгын шинжилгээ нь мөн судалгааны хариулт зэрэг их хэмжээний боловсруулаагүй өгөгдлийн багцыг ашиглаж болохуйц нотлох зүйл болгож хувиргах шаардлагатай үед хэрэгтэй байдаг. Зураг 15.1-д буй жишээг АДБ-ын асуудалд чиглэсэн гүйцэтгэлийн аудитын үеэр хийсэн судалгааны хариултуудад хийсэн агуулгын шинжилгээг эш болгож боловсрууллаа.

Зураг 15.1: Эмэгтэйчүүдийн эсрэг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх арга хэмжээний гүйцэтгэлийн аудитад ашигласан агуулгын шинжилгээ

Аудиторууд хүчирхийллийн эмэгтэй хохирогчдод дэмжлэг үзүүлдэг цагдаагийн албан хаагчид, сэтгэл зүйчид болон нийгмийн ажилтнууд зэрэг 340 хүнээс судалгаа авсан байна. Уг судалгааны сүүлийн асуулт нь, “Таны бодлоор, хүчирхийллийн эмэгтэй хохирогчдод үзүүлдэг үйлчилгээг сайжруулж, энэ төрлийн хүчирхийллийг улс орондоо бууруулахын тулд юу хийх хэрэгтэй вэ?” байв.

Аудитын баг судалгааны хариултуудад агуулгын шинжилгээ хийж, хариултуудыг ангилсан байна. Хамгийн түгээмэл 6 хариултыг доор үзүүлэв.



Эх сурвалж: Бразил улсын АДБ-ын “Ações de enfrentamento à violência doméstica e familiar contra as mulheres” (Эмэгтэйчүүдийн эсрэг гэр бүлийн болон ойрын хамтрагчийн зүгээс үйлдэгддэг хүчирхийлэлтэй тэмцэх арга хэмжээ) гүйцэтгэлийн аудитын тайланг эш болгов.

Агуулгын шинжилгээнд маш олон боломжит үр өгөөж байдаг. Тухайлбал, агуулгын шинжилгээний дүнд үүссэн ангилал буюу сэдвийн хуваалтыг хураангуйлж, уншигчдад хялбархан ойлгогдох байдлаар тайлагнаж болно.

Найдвартай өгөгдөл үүсгэх агуулгын шинжилгээ нь шинжилгээний нарийн төвөгтэй байдлаас хамаараад асар их хөдөлмөр, цаг хугацаа шаардаж болно. Агуулгын шинжилгээг системтэйгээр хийх нь чухал. Иймд арга зүйчтэй, эсвэл судлах сэдэв/ зүйлээр мэргэшсэн бусад дотоод оролцогч талуудтай ярилцах, эсвэл эрдэм шинжилгээний материалуудыг судалж, шаардлагатай нэмэлт чиглүүлэг олж авах хэрэгтэй.

Хавсралт 16: Хураангуй баримт бичиг боловсруулах маягтын жишээ

Нэр	Гаалийн байцаагчдад зориулсан сургалтын хангалттай байдлын талаарх харах өнцгийн хураангуй
Зорилго	Нотлох зүйлийн зориулалтаар ашиглаж болох хураангуй үүсгэх
Гүйцэтгэсэн ажил	<p>Энэ аудитын үеэр, бид нисэх буудлын гаалийн байцаагчдад зориулсан сургалтын хангалттай байдлын талаар мэдээлэл цуглуулах олон удаагийн ярилцлага хийсэн юм. Тодруулбал, бид дараах хүмүүстэй ярилцлага хийсэн:</p> <ul style="list-style-type: none">• Гаалийн Үзлэгийн Сургалтын Академийн сургалтын хөтөлбөрийн удирдагч нар.• Гаалийн Үзлэгийн Сургалтын Академийн сургалтын багш, зааварлагч нар.• Гаалийн байцаагчдад зориулсан сургалтын хөтөлбөрийг боловсруулсан ажилтнууд.• Гурван нисэх буудлын гаалийн байцаагчид.• Гурван нисэх буудлын гаалийн байцаагчдын хянагчид. <p>Бид дээрх бүлэг тус бүрээс 1) анхны сургалтын урт; 2) анхны сургалтын агуулга; мөн 3) багш нар ажлаа эхэлсний дараа хийх ажлын байран дээрх сургалтын талаарх харах өнцгийг нь асуусан юм. Энэхүү хураангуйд эдгээр аудитын сэдэв тус бүртэй холбогдох ажилтнуудын хариултыг эмхэтгэв.</p>

Хариултуудын хураангуй

(Доорх хүснэгтэд, аудитын баг аудитын сэдвүүдээр албан тушаалтнуудын өгсөн хариултыг эмхэтгэнэ. Доорх жишээнүүдийг үзнэ үү.)

Анхны сургалтын урт	
Удирдагч нар	Гаалийн Үзлэгийн Сургалтын Академийн сургалтын хөтөлбөрийн удирдагч нар сургалтын хөтөлбөр нь байцаагчдад суурь түвшний сургалтын мэдлэг олгоход хангалттай урт гэж хэлсэн. Удирдагч нарын хэлснээр Академид сургалтаа өргөжүүлэхэд хангалттай санхүүжилт байхгүй. <i>(хххх баримт бичгийн 3-р нүүрийг үзнэ үү.)</i>
Багш нар	Гаалийн Үзлэгийн Сургалтын Академийн сургалтын хөтөлбөрийн багш нар анхны сургалтын урт нь хангалттай урт биш гэж хэлсэн. Багш нарын хэлснээр, хамгийн багадаа дахиад 2 долоо хоногээр сунгаж байж илүү их практик дадлага олгож, сурагчдыг шалгах боломж бүрдэнэ. Одоогийн сургалтын хуваарь хэт шахуу байгаа бөгөөд зарим сурагчийн сурлагад хоцрогдол үүсэж байна <i>(хххх баримт бичгийн 2-р нүүрийг үзнэ үү.)</i>
Хөтөлбөр хөгжүүлэгчид	(хариултуудын хураангуйг оруулах)
Гаалийн байцаагчид	(хариултуудын хураангуйг оруулах)
Гаалийн хянагчид	(хариултуудын хураангуйг оруулах)
Анхны сургалтын агуулга	

Удирдагч нар	Гаалийн Үзлэгийн Сургалтын Академийн сургалтын хөтөлбөрийн удирдагч нар анхны сургалтын агуулга нь хангалттай боловч, сайжруулж болох талбарууд байж болно гэж хэлсэн. Үнэндээ, 2021 оны 3-р сараас Академи сургалтын хөтөлбөртөө нягталгаа хийх гэж байгаа. Хоёр жил тутамд сургалтын хөтөлбөртөө нягталгаа хийж, шаардлагатай шинэчлэлийг оруулах зорилготой байдаг ч, үргэлж хэрэгжүүлээд байж чаддаггүй. Сүүлийн нягталгаа болон шинэчлэл 2017 оны 8-р сард хийгдсэн. (xxxx баримт бичгийн 7-р нүүрийг үзнэ үү.)
Багш нар	(хариултуудын хураангуйг оруулах)
Хөтөлбөр хөгжүүлэгчид	(хариултуудын хураангуйг оруулах)
Гаалийн байцаагчид	(хариултуудын хураангуйг оруулах)
Гаалийн хянагчид	(хариултуудын хураангуйг оруулах)
Ажлын байран дээрх сургалт	
Удирдагч нар	Гаалийн Үзлэгийн Сургалтын Академийн сургалтын хөтөлбөрийн удирдагч нар Академийн зүгээс ажлын байран дээрх сургалтын албан ёсны удирдамж гаргаагүй гэж хэлсэн. Тэд хянагчдынхаа тусламжтайгаар байцаагчдад хэрэгтэй байгаа зүйлсийг тодорхойлж, олгодог. (xxxx баримт бичгийн 9-р нүүрийг үзнэ үү.)
Багш нар	(хариултуудын хураангуйг оруулах)
Хөтөлбөр хөгжүүлэгчид	(хариултуудын хураангуйг оруулах)
Гаалийн байцаагчид	(хариултуудын хураангуйг оруулах)
Гаалийн хянагчид	(хариултуудын хураангуйг оруулах)

Эх сурвалж: АДБОУБХС/ГАДХ-ны Хөгжлийн Баг.

Хавсралт 17: Регрессийн шинжилгээний жишээ

Хамгийн энгийн төрлийн регрессийн шинжилгээг ихэнхдээ корреляцийн шинжилгээ гэж нэрлэдэг. Хоёр өөр хувьсагч бие биетэйгээ ямар хамааралтай байгааг, өөрөөр хэлбэл, нэг хувьсагчийн өөрчлөлт нөгөө хувьсагчийн өөрчлөлтөд хэр хэмжээтэй нөлөөлөхийг тодорхойлохыг оролдож байгаа үед энэ төрлийн шинжилгээ хэрэгтэй байж болно.

Корреляцийн шинжилгээг ерөнхийдөө гурван алхмаар хийдэг:

- 1. Тархай диаграмм үүсгэх.** Бие хараат хувьсагч “Y” болон бие даасан (хараат бус) хувьсагч “X”-ийн утгуудыг босоо болон хэвтээ тэнхлэгт тус тус зураглана. Хараат хувьсагч гэдэг нь урьдчилан таамаглагдах буюу тооцоологдож буй хувьсагч бөгөөд бие даасан хувьсагч гэдэг нь тооцооллын суурийг үүсгэж буй хувьсагч юм.
- 2. Корреляцийн коэффициент (r) тооцоолох.** Энэ итгэлцүүр нь хоёр хувьсагч хоорондын харилцан хамаарлыг хэмждэг. Корреляцийн коэффициент 1 эсвэл -1-тэй ойртох тусам, хоёр хувьсагч хоорондоо илүү их харилцан хамааралтай байна гэсэн үг. Төгс эерэг эсвэл сөрөг харилцан хамааралтай үед, тархай диаграмм дээрх бүх цэг шулуун шугамыг үүсгэнэ.
- 3. Детерминацын коэффициент (r²) тооцоолох.** Энэхүү тодорхойлох итгэлцүүр нь хараат хувьсагчийн хувьсацыг бие даасан хувьсагчийн хувьсацаар тайлбарлаж болох хэр хэмжээг хэмждэг.

Дараах жишээг Бутан улсын Аудитын Дээд Байгууллагаас (АДБ) гүйцэтгэсэн аудитыг эш болгон боловсрууллаа. Тус жишээ нь энэ төрлийн шинжилгээний энгийн хэрэглээгээр дамжуулан танд корреляцийн шинжилгээний боломжит хэрэглээнүүдийг ойлгуулах болно.


Жишээ: АДБ-аас эрүүл мэндийн салбарын нярайн эндэгдлийг бууруулах зорилгод үндэслэн хүүхдийн эмчийн тоо болон хүүхдийн эндэгдэл хоорондын хамаарлыг судлах аудит гүйцэтгэсэн юм. Аудитын багийн ашигласан өгөгдөл нь:

Он	2003	2004	2005	2006	2007	2008
Хүүхдийн эмчийн тоо	10	15	20	20	25	30
Хүүхдийн эндэгдэл	300	310	280	251	300	200

Эх сурвалж: Бутан улсын АДБ.

Энэхүү өгөгдлийн багц нь Зураг 17.1-д харуулсан тархай диаграммыг үүсгэж байна.

Зураг 17.1: Тархай диаграмм



Бид энэхүү шугаман чиг хандлагын шугамаас хүүхдийн эндэгдэл болон хүүхдийн эмчийн тоо хооронд тодорхой хэмжээний харилцан хамаарал байгааг харж болно. Гэсэн хэдий ч, энэ хоёр хувьсагч хэр их харилцан хамааралтай вэ гэдгийг ойлгох хэрэгтэй. Ингэхийн тулд, бид “r” буюу корреляцын коэффициентийг тооцоолох ёстой. Ингэхийн тулд хүснэгтэлсэн өгөгдөл боловсруулдаг программ хангамжийн “CORREL” функцийг ашиглаж болно.

“r” утга нь -0.712 байна. Энэ нь хүүхдийн эмчийн тоо болон хүүхдийн эндэгдэл хооронд хүчтэй сөрөг харилцан хамаарал байгааг илтгэж байна. Өөрөөр хэлбэл, хүүхдийн эмчийн тоо эсэх тусам, хүүхдийн эндэгдэл буурна.

Гэхдээ дан ганц хүчтэй харилцан хамаарал байна гэдэг нь учир шалгаан, үр дагаврын холбоо байна гэсэн үг биш. Бид детерминацын коэффициент буюу “r²”-ийг мөн тооцоолох ёстой. Ингэснээр хүүхдийн эндэгдлийн хувьсацын хэр хэсэг нь хүүхдийн эмчийн тоогоор тайлбарлагдаж болохыг тодорхойлно.

Энэ тохиолдолд, $r^2=0.507$ буюу 50.7% байна. Иймд, манай жишээнд, хүүхдийн эндэгдлийн хувьсацын 50.7% нь хүүхдийн эмчийн тоогоор тайлбарлагдаж болохоор байна. Харин хувьсацын 49.3% нь өөр бусад хүчин зүйлсээс шалтгаалсан байна.

Энэ жишээнд харагдаж байгаачлан, хүүхдийн эндэгдэл шиг хараат хувьсагчийн өөрчлөлтөд нөлөөлөх олон хүчин зүйл бий. Хүүхдийн эндэгдэлд нөлөөлж буй хувьсагчуудыг бүрэн ойлгохын тулд аудитын багт бусад хувьсагчуудыг тодорхойлдог буюу хянадаг илүү нарийн төвөгтэй загварчлал болон регрессийн шинжилгээний аргууд шаардлагатай болно.

Хавсралт 18: ТХГ-ын тойм мэдээ (хураангуй тайлан)-ний жишээ

GAO

Тойм мэдээ

ТХГ-20-129-ийн тойм, конгрессын хүсэлт гаргагчдад тайлагнах нь

ТХГ яагаад энэ судалгааг хийсэн бэ?

Холбооны засгийн газар жил бүр МТ-д 90 тэрбум гаруй ам.доллар зарцуулдаг. Ийм том хэмжээний хөрөнгө оруулалт хийсэн ч, төслүүд эрхэм зорилготойгоо холбогдох үр дүнд маш бага хувь нэмэр оруулж, бүтэлгүйтэх, эсвэл зардал хэтэрч, хуваарь нь алдагдах тохиолдол хэт их байдаг. Ажиллах хүчний төлөвлөлтийн үйл ажиллагаануудыг үр нөлөөтэй хэрэгжүүлснээр томоохон худалдан авалтуудыг амжилттай болгож чадна.

ТХГ-т засгийн газрыг бүхэлд нь хамруулсан МТ-ийн ажиллах хүчний төлөвлөлтийн нягталгаа хийлгэх хүсэлт ирсэн. Зорилго нь холбооны агентлагууд МТ-ийн ажиллах хүчний төлөвлөлтийн практикийг үр нөлөөтэй хэрэгжүүлсэн хэр хэмжээг тодорхойлох байв. Ингэхийн тулд, ТХГ 1990 оны Санхүүгийн Гол Ажилтнуудын Актын 24 агентлагийн МТ-ийн ажиллах хүчний бодлого болон холбогдох баримт бичгүүдийг ТХГ-аас гаргасан МТ-ийн ажиллах хүчний төлөвлөлтийн хүрээтэй харьцуулсан юм. ТХГ-аас агентлаг тус бүрийг үйл ажиллагаа бүрээр нь бүрэн, ерөнхийдөө, хэсэгчлэн, хамгийн бага хэмжээнд хэрэгжүүлсэн эсвэл хэрэгжүүлээгүй гэж үнэллээ. ТХГ агентлагуудын баримт бичигт хийсэн нягталгаагаар агентлагуудын албан тушаалтнуудтай хийсэн ярилцлагаар лавшруулсан юм.

ТХГ юу зөвлөх вэ?

ТХГ 24 агентлагийн 18-д нь МТ-ийн гол ажиллах хүчний төлөвлөлтийн 8 үйл ажиллагааг бүрэн хэрэгжүүлэхийг зөвлөж байна. Тус 18 агентлагаас, 13 нь зөвлөмжтэй санал нийлж, 1 нь хэсэгчлэн санал нийлж, 3 санал хэлэхээс түдгэлзэж, 1 нь илрүүлэлтүүдтэй санал нийлээгүй бөгөөд ТХГ-ын зөвлөмжийг сайжруулахад хүргэсэн нотлох зүйлс ирүүлснийг энэ тайланд тусгасан болно. ТХГ үлдсэн бүх зөвлөмжөө хүчин төгөлдөр хэвээр гэж үзэж байна.

ТХГ-20-129-ийг үзнэ үү. Дэлгэрэнгүй мэдээлэл авах хаяг: Carol C. Harris, (202) 512-4456 эсвэл HarrisCC@gao.gov

2019 ОНЫ 10-Р САР

МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИ

Агентлагууд гол ажиллах хүчний төлөвлөлтийн үйл ажиллагаануудаа бүрэн хэрэгжүүлэх шаардлагатай байна

ТХГ юу илрүүлсэн бэ?

Холбооны агентлагууд эрхэм зорилгоо дэмжихэд шаардлагатай ажилтнуудтай байхад нь маш чухал мэдээллийн технологийн (МТ) гол ажиллах хүчний төлөвлөлтийн үйл ажиллагаагаа хэрэгжүүлэх хүчин зүтгэлээрээ ихэд харилцан адилгүй байлаа. Тодруулбал, ТХГ-аас нягталгаа хийсэн 24 агентлагаас багадаа 23 нь чадамж болон хүний нөөц хоорондын зөрүүг үнэлэх зэрэг гурван үйл ажиллагааг хэсэгчлэн хэрэгжүүлсэн, ерөнхийдөө хэрэгжүүлсэн эсвэл бүрэн хэрэгжүүлсэн байна. Гэвч, ихэнх агентлаг нь ажиллах хүчний төлөвлөлтийн бусад таван үйл ажиллагааг хамгийн бага хэмжээнд хэрэгжүүлсэн эсвэл огт хэрэгжүүлээгүй байна (зураг үзнэ үү).


Агентлагуудын Мэдээллийн Технологийн (МТ) гол ажиллах хүчний төлөвлөлтийн үйл ажиллагааны ерөнхий хэрэгжилт

МТ-ийн ажиллах хүчний төлөвлөлтийн стратегийн чиглэлийг тогтоох

Ажиллах хүчний төлөвлөлтийн үйл явцыг бий болгож, хэрэгжүүлэх




Чадамж болон хүний нөөцийн шаардлагуудыг хөгжүүлэх




Ур чадварын зөрүүг тодорхойлохын тулд МТ-ийн ажиллах хүчнийг шинжлэх нь

Чадамж болон хүний нөөцийн хэрэгцээг тогтмол үнэлэх



Чадамж болон хүний нөөцийн зөрүүг үнэлэх



МТ-ийн ур чадварын зөрүүг шийдвэрлэх стратеги боловсруулж, үйл ажиллагаа хэрэгжүүлэх нь

Чадамж болон хүний нөөцийн зөрүүг арилгах стратеги, төлөвлөгөө гаргах



Зөрүүг арилгах үйл ажиллагаануудыг хэрэгжүүлэх




МТ-ийн ур чадварын зөрүүг арилгах ахицыг хянан-шинжилж тайлагнах нь

Зөрүүг арилгах агентлагийн ахицыг хянан-шинжлэх




Зөрүүг арилгах ахицын талаар агентлагийн манлайлалд тайлагнах



0 6 12 18 24

Үйл ажиллагааг хэрэгжүүлж буй агентлагуудын тоо



Эх сурвалж: Агентлагийн мэдээллийн технологийн ажиллах хүчний төлөвлөлтийн бодлого болон баримт бичигт хийсэн ТХГ-ын шинжилгээ. | ТХГ-20-129

Агентлагууд ажиллах хүчний төлөвлөлтийн үйл ажиллагаануудаа хэрэгжүүлэхдээ хязгаарлагдмал ахицтай байсныгаа өрсөлдөгч тэргүүлэх зорилгоос шалтгаалсан (6 агентлаг), нөөц хязгаарлагдмал байсан (3 агентлаг) гэх мэт янз бүрийн шалтгаанаар тайлбарласан юм. Агентлагууд МТ-ийн гол ажиллах хүчний төлөвлөлтийн үйл ажиллагааг тэргүүлэх зорилго болгохгүй бол, хүний нөөцийн өөрчлөгдөж буй хэрэгцээг таамаглаж, хариу арга хэмжээ авах, мөн МТ-ийн хамгийн чухал системүүдийг хөгжүүлж, нэвтрүүлж, ажиллуулах үеийн хүний нөөцийн эрсдэлийг хянахад бэрхшээлтэй тулгарах магадлалтай байна.

Америкийн Нэгдсэн Улсын Төрийн хариуцлагын газар

Хавсралт 19: Европын Аудиторуудын Шүүхийн гүйцэтгэлийн хураангуйн жишээ

Тайлангийн хураангуй

I Хөдөө Аж Ахуйн Түгээмэл Бодлогын Түншлэл (ХААТБТ) нь талбарт суурилсан тусламжийг шалгахдаа эртнээс хиймэл дагуул болон агаарын зураг ашиглаж ирсэн бөгөөд өдгөө ЕХ-ноос ХАА болон хөдөөгийн хөгжилд олгодог санхүүжилтийн бараг 80%-ийг авах болжээ. Энэхүү зураглалын орон зайн нягтаршил маш боловч, 2017 оноос өмнө, ХАА-н газарт жилийн турш өрнөж буй үйл ажиллагаануудыг (ж.нь: ургац хураалт) тулган баталгаажуулах боломж олгох хэмжээний хангалттай давтамжтай биш байсан юм.

II 2017 оны 3-р сараас хойш, ЕХ-ны эзэмшлийн Коперникус Сентинел 1, 2 гэсэн хиймэл дагуулууд ХАА-н үйл ажиллагааг хянан-шинжлэх Дэлхийг ажиглах технологид эрс шинэчлэл авчрах боломжтой байнгын, чөлөөт хүртээмжтэй, өндөр нягтаршилтай зургуудаар хангаж байна. Зургийг үе үе авдаг тул ургацын улирлын турш цаг хугацааны цувааны өгөгдлийг автоматаар боловсруулж, хүний оролцоогүйгээр ургацыг таньж, ХАА-н тодорхой практикуудыг дан дангаар нь (хөрс боловсруулах, хадлан авах гэх мэт) хянан-шинжлэх боломжтой юм. 2018 оноос хойш, төлбөр төлсөн агентлагууд Коперникус Сентинелийн өгөгдлийг талбарын үзлэгт суурилсан уламжлалт шалгалтын оронд ашиглах боломжтой болжээ.

III Комисс болон ХААТБТ-ын оролцогч талуудын үзэж буйгаар, Коперникус Сентинелийн өгөгдөл болон талбарын дэмжлэгийг хянан-шинжлэх бусад технологи нь фермерүүд, захиргааны байгууллагууд болон байгаль орчинд ихээхэн үр өгөөжтэй байх боломжтой юм. Манай аудит комисс эдгээр шинэ технологийн өргөн хүрээтэй ашиглалтыг үр нөлөөтэй дэмжсэн эсэхийг, мөн Гишүүн Орнууд тэдгээрийг нэвтрүүлэх хангалттай арга хэмжээ авсан эсэхийг судаллаа. Бид Коперникус Сентинел хиймэл дагуулын өгөгдөл, дроноор авсан зургууд болон геотэмдэглэгээ хийсэн зургуудыг судалсан юм. Зураглалын шинэ технологийг ашиглахад гарсан ахицын үнэлгээ одоо үед тун хамааралтай болсон байна. Учир нь манай аудитын үр дүнгүүдийг ХААТБТ 2020 оноос хойш ашиглах боломжтой юм.

IV Комисс болон зарим Гишүүн Орнууд шинэ технологиудын боломжит үр өгөөжийг нээх арга хэмжээ авсныг бид илрүүлээ. Комиссоос олон конференц болон воркшопоор дамжуулан шинэ технологиудыг сурталчилж, төлбөр төлөгч олон агентлагт хоёр талт дэмжлэг үзүүлсэн юм. Төлбөр төлөгч 66 агентлагийн 15 нь 2019 онд Коперникус Сентинелийн өгөгдлийг ашиглаж, зарим хөтөлбөр болон зарим үр шим хүртэгч бүлгүүдийн тусламжийн хэрэглээг шалгасан байна (“хяналт-шинжилгээгээр шалгах”). Манай аудит төлбөр төлөгч олон агентлаг шинэ технологиудын өргөн хүрээтэй хэрэглээнд саад бэрхшээл учирсан гэдгийг илрүүлсэн юм.

V Уг бэрхшээлүүдийн заримыг нь арилгах эсвэл бууруулах арга хэмжээг комиссоос авсан боловч, төлбөр төлөгч агентлагууд зөв шийдвэр гаргаж, ирээдүйн санхүүгийн залруулгын эрсдэлийг бууруулахад комиссоос илүү их чиглүүлэг хүлээж байна.

VI Хяналт-шинжилгээгээр шалгах практикийг нэвтрүүлэхэд МТ-ийн системүүд, тодорхой нөөцүүд болон мэргэшилд ихээхэн өөрчлөлт хийх шаардлага тулгарч байна. Комисс Сентинелийн өгөгдөл болон дижитал үүлэн боловсруулалтын үйлчилгээнд хандах үйлдлийг хөнгөвчлөх санаачилгуудыг авч хэрэгжүүлсэн боловч, төлбөр төлөгч агентлагууд үйл ажиллагаандаа үүнийг ашиглах байдал бага хэвээр байна.

VII Хөдөөгийн хөгжлийн төлөвлөгөө болон хамтын нийцлийн (cross-compliance) механизмын хувьд, бид уур амьсгал болон байгаль орчны шаардлагуудын нийцлийн ч, гүйцэтгэлийн ч хяналт-шинжилгээнд шинэ технологиудыг хязгаарлагдмал байдлаар ашиглаж байгааг ажиглалаа. Бид мөн, 2020 оноос хойших ХААТБТ-ийн гүйцэтгэлийн индикаторуудын санал болгосон багц нь Сентинелийн өгөгдлөөр шүүд хянан-шинжлэхэд ихээхэн тохиромжгүй гэж дүгнэлээ.

VIII Бид 2020 оноос хойших ХААТБТ-д хяналт-шинжилгээгээр шалгах практикийг хяналтын гол тогтолцоо болгон ашиглахын тулд Гишүүн Орнуудад урамшуулал дэмжлэг олгох нь зүйтэй гэж комисст зөвлөмж хүргүүлж байна. Түүнчлэн, байгаль орчны болон уур амьсгалын шаардлагуудыг хянан-шинжлэхэд шинэ технологиудыг илүү сайн ашиглахыг комисст зөвлөмж болгож байна.

Хавсралт 20: Гүйцэтгэлийн аудитын тайланд аудитын арга зүйг тайлбарлах нь

Холбооны Нисэхийн Захиргаанаас (ХНЗ) батламжилсан механикч болон засварчдын шинж чанарыг судлахын тулд, бид 2018 оны 12-р сарын байдлаарх ХНЗ-ны нийт мэдээлэлд нас, хүйс зэрэг хүн ам зүйн шинж чанараар шинжилгээ хийсэн юм. Нисэхийн техникийн үйлчилгээний ажилтнуудын цалин хөлс болон ажилгүйдэл зэрэг хөдөлмөр эрхлэлтийн шинж чанарыг судлахын тулд бид 2013-2018 оны хөдөлмөрийн зах зээлийн сонгосон индикаторуудаар Хөдөлмөрийн Статистикийн Товчооны Өнөөгийн Хүн Амын Судалгааны өгөгдлийг шинжиллээ. Мөн, бүх 50 мужийн хамгийн сүүлийн үеийн Ажиллах Хүчний Шинэчлэл болон Боломжийн Актыг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд нягталгаа хийсэн юм.

Оролцогч талуудын дэмжлэгийг тодорхойлж, энэхүү ажиллах хүчнийг хөгжүүлэх оролцогч талуудын хүчин зүтгэлийн зохицуулалтыг үнэлэхийн тулд бид ХНЗ, мөн Хөдөлмөр (ХЯ), Боловсрол (БЯ), Батлан Хамгаалах (БХЯ) болон Ахмад Дайчдын Яамны (АДЯ) агентлагуудын албан тушаалтнуудтай энэхүү ажиллах хүчний холбогдох өгөгдөл, хөтөлбөр болон санхүүжилтийн талаар ярилцлага хийсэн юм. Бид эдгээр агентлагуудыг нисэхийн ажиллах хүчинтэй хамааралтай гэж тодорхойлсон өмнөх тайландаа үндэслэн сонголоо.

Оролцогч талуудын зохицуулалтын жишээг тодорхойлохын тулд, бид мөн оролцогч талуудын зөвлөмж болон бусад хүчин зүйлсэд үндэслэн сонгосон ажилтнууд, Нисэхийн Техникийн Үйлчилгээний Техникчдийн (НТҮТ) Сургуулиуд, эвлэлүүд, салбарын холбоод болон ажиллах хүчний сургалтын байгууллагууд гэсэн 6 оролцогч талаас бүрдсэн ерөнхийлөх боломжгүй түүврээс хагац бүтэцлэгдсэн ярилцлага авч, 2 талбарын ажил хийсэн юм. Бид Колумбын Дүүрэгт үйлчилгээ үзүүлж, томоохон арилжааны нисэхийн компанийн нисэхийн засварын станц болдог НТҮТ-ийн нэг сургууль болон Жоржиа муж дахь мужийн ажиллах хүчний нэг байгууллага дээр талбарын ажил хийлээ. Эдгээр оролцогч талуудыг сонгож, талбарын ажил хийхдээ гүйцэтгэсэн ажлын төрөл болон газар зүйн байрлал зэрэг хүчин зүйлсэд үндэслэсэн олон талт харах өнцгийг олж авахыг зорьсон юм. Түүнчлэн, бид ХНЗ-ны 2019-2022 оны стратегийн төлөвлөгөө болон Нисэхийн Ажиллах Хүчний Удирдах Комиссын үндсэн дүрэм зэрэг агентлагийн холбогдох баримт бичгүүдийг нягталсан юм.

НТҮТ-ийн сургуулиудын сургалтын хөтөлбөрийн шаардлагууд болон механикчдын сертификатын шалгалтын стандартыг шинэчлэхэд ХНЗ ямар ахиц гаргасныг тодорхойлохын тулд, бид холбогдох холбооны хууль, журам, зохицуулалтууд болон ХНЗ-ны баримт бичгүүдэд нягталгаа хийж, ХНЗ-ны албан тушаалтнуудаас ярилцлага авсан юм.

Бид энэхүү гүйцэтгэлийн аудитыг 2019 оны 1-р сараас 2020 оны 2-р сар хүртэл ерөнхийдөө хүлээн зөвшөөрөгдсөн төрийн аудитын стандартын дагуу гүйцэтгэлээ. Уг стандарт нь аудитыг төлөвлөж, гүйцэтгэхдээ аудитын зорилгуудад үндэслэн хангалттай бөгөөд зохистой нотлох зүйлс олж авч, илрүүлэлтүүд болон дүгнэлтүүдээ үндэслэлтэй байлгахыг шаарддаг. Бидний аудитын зорилгууддаа үндэслэн олж авсан нотлох зүйлс нь илрүүлэлтүүд болон дүгнэлтүүдийг маань үндэслэлтэй болгосон гэж бид үзэж байна.

Хавсралт 21: Үйл ажиллагааны төлөвлөгөө болон мөрөөр хяналт тавих үйл ажиллагааны баримт бичгийн нягталгааны маягт¹⁵

Үйл ажиллагааны төлөвлөгөө

Гүйцэтгэлийн аудитын нэр: Эмэгтэйчүүдийн эсрэг ойрын хамтрагчийн зүгээс үйлдэгддэг хүчирхийллийг таслан зогсоох (ЭЭОХЗҮХТЗ) үйл ажиллагааны гүйцэтгэлийн аудит

Аудитад шалгуулагч этгээдийн нэр: Эмэгтэйчүүдийн Бодлогын Газрын Нарийн бичгийн дарга

Огноо: 2017-11-20

Зөвлөмж	Аудитад шалгуулагчийн төлөвлөсөн үйл ажиллагаа	Аудитад шалгуулагчийн хариуцах этгээд	Зөвлөмжийг хэрэгжүүлэх эцсийн хугацаа	Хэрэгжүүлэлтээс хүлээгдэж буй өгөөж (боломжтой бол тоогоор илэрхийлэх)
ЭЭОХЗҮХТЗ-ын ач холбогдлын талаар мэдлэг, ойлголт дээшлүүлэх аян явуулах.	Сошиал медиагаар явагдах аян төлөвлөж, явуулах. Телевизээр явагдах аян төлөвлөж, явуулах.	Хатагтай Ширли Смит. Ноён Хуан Перез.	2018 оны 9-р сар. 2018 оны 12-р сар.	Эмэгтэйчүүдийн эсрэг ойрын хамтрагчийн зүгээс үйлдэгддэг хүчирхийлэл буурах.
Эрэгтэйчүүдэд чиглэсэн ЭЭОХЗҮХТЗ аяныг эрчимжүүлэх	Сошиал медиагаар явагдах аян төлөвлөж, явуулах. Телевизээр явагдах аян төлөвлөж, явуулах. Спортын тэмцээний үеэр явуулах аян төлөвлөж, явуулах.	Хатагтай Ширли Смит. Ноён Хуан Перез. Ноён Абдалла Фарид.	2018 оны 9-р сар. 2018 оны 12-р сар. 2018 оны 12-р сар.	ЭЭХ-ийн талаарх эрэгтэйчүүдийн сэтгэлгээг өөрчлөхөд туслах Эмэгтэйчүүдийн эсрэг ойрын хамтрагчийн зүгээс үйлдэгддэг хүчирхийлэл буурах.
Сургуулийн хөтөлбөрт жендерийн сэдвүүдийг, ялангуяа гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой асуудлуудыг оруулахын тулд Боловсролын Яамтай хамтран ажиллах.	Боловсролын Яаман дахь оролцогч талуудтай холбогдох. БЯ-ны оролцогч талуудтай хамт хичээлийн хөтөлбөрийн өөрчлөлтийг төлөвлөх. Багш нарыг сургалтын хөтөлбөрийн өөрчлөлтийн талаарх сургалтад хамруулах.	Хатагтай Катерина Пиазза. Хатагтай Катерина Пиазза. Ноён Жошуа Перейра.	2018 оны 3-р сар. 2018 оны 9-р сар. 2019 оны 12-р сар.	Эмэгтэйчүүдийн эсрэг ойрын хамтрагчийн зүгээс үйлдэгддэг хүчирхийлэл буурах.
Хохирогчдод үйлчилдэг цагдаагийн албан хаагчдын мэдлэг ойлголтыг дээшлүүлж, сургалтыг эрчимжүүлэхийн тулд Хууль Зүйн Яамтай хамтран ажиллах.	Хууль Зүйн Яаман дахь оролцогч талуудтай холбогдох. Дотоод сошиал медиагаар явуулах аян төлөвлөж, явуулах. Цагдаагийн албан хаагчдыг сургалтад хамруулах.	Ноён Хуан Перез. Хатагтай Ширли Смит. Хатагтай Чимаманда Наи.	2018 оны 3-р сар. 2018 оны 9-р сар. 2019 оны 12-р сар.	Цагдаагийн албан хаагчдын гэр бүлийн хүчирхийллийн хохирогчдод үзүүлэх үйлчилгээ сайжрах.

Эх сурвалж: АДБОУБХС/ГАДХ-ны Хөгжлийн Баг.

¹⁵ Энд буй зөвлөмжүүд нь жишээ болно. Боломжит зөвлөмжүүд нь үүгээр хязгаарлагдахгүй. Жинхэнэ гүйцэтгэлийн аудитад үүнээс олон зөвлөмж агуулагдаж болно.

Мөрөөр хяналт тавих үйл ажиллагааны баримт бичгийн нягталгааны маягт

Эмэгтэйчүүдийн эсрэг ойрын хамтрагчийн зүгээс үйлдэгддэг хүчирхийллийг таслан зогсоох (ЭЭОХЗҮХТЗ) үйл ажиллагааны гүйцэтгэлийн аудитыг ашигласан зураглал

Зөвлөмж	Аудитад шалгуулагчийн хийсэн үйл ажиллагаа (төлөвлөсний дагуу)	Үйл ажиллагааны статус/ахиц	Аудитад шалгуулагч үйл ажиллагаагаа дуусгаагүй шалтгаан	Нөлөөлөл
ЭЭОХЗҮХТЗ-ын ач холбогдлын талаар мэдлэг, ойлголт дээшлүүлэх аян явуулах.	Сошиал медиагаар явагдах аян төлөвлөж, явуулах. Телевизээр явагдах аян төлөвлөж, явуулах.	Бүрэн хэрэгжсэн. Хэрэгжээгүй.	Өртөг нь хэт өндөр. Нарийн бичгийн даргад үүнд зориулсан төсөв байхгүй.	Эмэгтэйчүүдийн Бодлогын Газрын Нарийн бичгийн дарга зөвлөх гэрээгээр ажиллуулж аянуудын нөлөөллийг хэмжүүлж байна. Уг судалгаа 2021 оны 7-р сард дуусна. Нөлөөллийг нь дараагийн мөрөөр хяналт тавих үеэр АДБ-аас тулган баталгаажуулна.
Эрэгтэйчүүдэд чиглэсэн ЭЭОХЗҮХТЗ аяныг эрчимжүүлэх	Сошиал медиагаар явагдах аян төлөвлөж, явуулах. Телевизээр явагдах аян төлөвлөж, явуулах. Спортын тэмцээний үеэр явуулах аян төлөвлөж, явуулах.	Бүрэн хэрэгжсэн. Хэрэгжээгүй. Бүрэн хэрэгжсэн.	Өртөг нь хэт өндөр. Нарийн бичгийн даргад үүнд зориулсан төсөв байхгүй.	Нарийн бичгийн дарга аяныг зохион байгуулсан хэд хэдэн хөл бөмбөг, крикет болон сагсан бөмбөгийн тэмцээний дараа судалгаа хийсэн. Урьдчилсан шинжилгээгээр аян нь оролцогчдын дунд ЭЭОХЗҮХТЗ талаарх мэдлэг, ойлголтыг амжилттай дээшлүүлсэн гэж гарсан.
Сургуулийн хөтөлбөрт жендерийн сэдвүүдийг, ялангуяа гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой асуудлуудыг оруулахын тулд Боловсролын Яамтай хамтран ажиллах.	Боловсролын Яаман дахь оролцогч талуудтай холбогдох. БЯ-ны оролцогч талуудтай хамт хичээлийн хөтөлбөрийн өөрчлөлтийг төлөвлөх. Багш нарыг сургалтад хамруулах.	Бүрэн хэрэгжсэн. Зарим талаараа хэрэгжсэн. Хэрэгжээгүй	Даалгаврыг хариуцсан баг нь өөрчлөлтүүдийг боловсруулж байгаа ч, бусад яаралтай ажлын улмаас сааталтай байна. Хугацаа нь болоогүй байгаа. Дараагийн мөрөөр хяналт тавих үйл ажиллагааны үеэр тулган баталгаажуулна.	Хичээлийн хөтөлбөрт өөрчлөлтүүдийг хараахан оруулаагүй байгаа учраас энэ үйл ажиллагааны нөлөөллийг үнэлэхэд хэт эрт байна.
Хохирогчдод үйлчилдэг цагдаагийн албан хаагчдын мэдлэг ойлголтыг дээшлүүлж, сургалтыг эрчимжүүлэхийн тулд Хууль Зүйн Яамтай хамтран ажиллах.	Хууль Зүйн Яаман дахь оролцогч талуудтай холбогдох. Дотоод сошиал медиагаар явуулах аян төлөвлөж, явуулах. Цагдаагийн албан хаагчдыг сургалтад хамруулах.	Хэрэгжсэн. Хэрэгжсэн. Зарим талаараа хэрэгжсэн.	Зөвхөн улсын томоохон хотуудад ажиллаж буй цагдаагийн албан хаагчдыг сургалтад хамруулсан.	Нарийн бичгийн дарга сургалтад хамрагдсан болон хамрагдаагүй цагдаагийн албан хаагчдын үйлчилгээг харьцуулах судалгаа хийж, сургалт одоогоор үр нөлөөтэй байна гэж дүгнэсэн.

Эх сурвалж: АДБОУБХС/ГАДХ-ны Хөгжлийн Баг.